

Дэн Браун

Албингууд ба сахиусан

ТЭНГЭРҮҮД

Баримт

Дэлхийн хамгийн том эрдэм судлалын хүрээлэн -Швейцарийн Европын цөмийн судалгаан зөвлөл (СЭРН, Conseil European pour la Recherche Nucleaire CERN) саяхан антиматери гэх эсрэг биетийн анхны бөөмсийг гарган авсан юм. Антиматери гэдэг матери буюу энгийн биеттэй яг адил, гагцхүү түүний бөөмсийн бүх цэнэг нь эсрэг байдаг. Антиматерийг хүн төрөлхтний мэдэх хамгийн чадалтай эрчим хүчний эх үүсвэр гэж үздэг агаад ашигт үйлийн коэффициент нь 100 хувь буюу төгс юм. Түүнтэй харьцуулахад цөмийн эрчим хүчний ашигт үйлийн коэффициент нь 1.5 байдаг. Антиматери ямар ч бохирдол, цацраг идэвхгүй бөгөөд нэг дусал нь Нью Йорк хотыг бүхэлд нь бүтэн өдрийн турш эрчим хүчээр хангах чадалтай. Гэхдээ энд нэг асуудал бий. Антиматери маш тогтворгүй. Ямар ч зүйлтэй, бүр агаартай хүртэл шүргэлцмэгцээ оргүй устдаг. Ганц грамм антиматери 20 килотонн цөмийн бөмбөг буюу Хирошима хотыг сүйрүүлсэн бөмбөгийн хүчтэй тэнцэнэ. Саяхныг болтол антиматерийг маш багаар цөөн хэдэн атом гаргаж, богинохон хугацаанд тогтоож байлаа. Харин СЭРН Антипротон сааруулагч гэх байгууламж барьснаараа антиматерийг их хэмжээгээр үйлдвэрлэх боломжтой болжээ. Эцэст нь ... энэ гайхамшигт эрчим хүч хүн төрөлхтнийг аврах уу, эсвэл хамгийн аймшигтай зэвсэг болон хувирч алах уу гэдэг ганц л асуулт үлдэнэ. Зохиогчийн тэмдэглэл Энэ зохиолд гарч байгаа Ром хотын барилга, хоолой, булш, бунхан, урлагийн бүтээл бүгд баримттай, яг энд өгүүлсэн тэр газраа оршин буй агаад өнөөдөр ч тэнд нь харж болно. Гэгээрлийн нөхөрлөл гэдэг бас л баримттай зүйл билээ.

Удиртгал

Хөөрхий физикч Леонардо Ветрад махны хярвас үнэртэв. Өөрийнх нь арьс мах шархийтэл түлэгдэж байгаа нь тэр байлаа. Дээгүүр нүүгэлтэн ирэх том хар дүрсийг айдас дүүрэн ширтэнэ. «Чи яах гээ вэ?» «La chiave» гэж архирах сонсогдоно. «Нууц үгээ хэл!» Нүүгэлтэх мангас дээрээс нь няцартал гишгэж улайссан төмөр тамгаа Ветрагийн цээжин дээр дахин шархийтэл дарлаа. Утаа савсан махных нь хярвас дахин ханхийв. Ветра орь дуу тавин хашхирлаа. «Нууц үг байхгүй шүү дээ!» Ухаан нь балартгал өвдөнө. Нөгөө хар мангас «Ne avevo paura. Би ч бас тэгж бодсон юм аа» гэлээ. Ветра ухаан алдахгүй гэж хичээнэ. Нөгөө хар амьтан дахиад л үсрээд ирэв. Авах гэснээ авч хэзээ ч чадахгүй дээ, чи хэмээн дотроо занана. Гэтэл хормын дараа байдал өөрчлөгдөв. Тэр хурц хутга нүүр рүү нь зангаж, мэс засал хийх гэж байгаа юм шиг болгоомжтой чиглүүлж байлаа. «Бурхан өршөө!» гэж Ветра байдгаараа хашхирлаа. даан ч... оройтсон байв.

Хэсэг 1

Гизагийн их пирамидын дээр залуухан бүсгүй зогсоод инээд алдан залуугаа даллан дуудна. «Хүүе, Роберт, хурдлаач ээ. Би арай залуухан эртэй суудаг байж дээ». Бүсгүй адтай яа хөхрөх аж. Эрийнх нь хөл бул чулуу шиг бадайрч, бүсгүйнхээ алхааг гүйцэх гэж зүдрэн: «Хүлээгээрэй хөө, хүлээ л дээ» хэмээн бувгнана. Дээшээ алхах бүр нүд нь бүрэлзэвч түүнийгээ гүйцэх ёстой шүү хэмээх үг чихэнд нь аянга мэт чанга нүргэлэн лугшина. Тэгээд дээшээ харвал бүсгүй алга болсон байв. Бүсгүйн оронд шүд нь сарайсан хөгшин зогсоод

ганцаардангуй гөлийн, доош ширтэж байлаа. Гэнэт гансарсан дуу ясанд ян хийтэл цөл даяар цуурайтав. Роберт Ландон хар дараад сэргэчихлээ. Орных нь хажууд байх утас дуугарч байна. Унтаагаараа шахуу атлаа утсаа авлаа. «Байна уу?» «Би Роберт Ландонтой ярих гэсэн юм» гэж нэг эрэгтэй хүн хэлэв. Ландон өндийж, орон дээрээ суугаад, сэрэх гэж оролдонгоо «Би байна» гээд цахим цаг руугаа харвал 5.18 болж байна. «Тантай маш яаралтай уулзах хэрэгтэй байна». «Хэн тэр вэ?» «Намайг Максимлиан Колэр гэдэг л дээ. Би эгэл бөөмсийн физикч хүн байна». «Юуны физик гэнэ ээ?» Ландоны ухаан санаа нь сэрж амжаагүй л байв. «Та ингэхэд зөв хүн рүүгээ залгасан биз?» «Та Харвардын их сургуулийн шашны иконологийн багш мөн биз дээ? Та билэг тэмдгийн тухай гурван ч ном бичиж, бас...» «Ингэхэд хэдэн цаг болж байгааг мэдэж байна уу, та?» «Уучлаарай. Танд харуулмаар нэг юм надад байгаа юм л даа. Энэ тухай утсаар яриад байж боломгүй байна.» Ландон унтууцав. Иймэрхүү юм өмнө нь болж л байлаа. Шашны билэг тэмдгийн тухай бичихээр мухар сүсэгтэй солиотой хүмүүс Бурхнаас илгээсэн тэмдэг харсан гэж утастаад байдаг нэг зовлонтой ажээ. Сарын өмнө Оклахомагийн нэг тайчигч бүсгүй өөр рүү нь нисч очоод, орон дээр нь гэнэт тодорсон загалмайн дүрсийг харж, учрыг нь тайлж өгвөл үзээгүй сайхан секс амтлуулна шүү гэжээ. **Тулзагийн бүтээлэг*** гэж Ландон түүнийг шоолон дотроо инээдэг байв. «Та миний дугаарыг яаж олоо вэ» гэж асуухдаа ийм эрт сэрээсэнд нь уурласан ч гэсэн эелдэг байхыг хичээлээ. «Интернэтээр. Таны номын вэбсайтаас». Ландон хөмсгөө зангидав. Номынхоо вебсайтад утасныхаа дугаарыг тавиагүй гэдгээ бат мэдэж байсан тул нөгөө хүн худлаа ярьж байгаа нь илт. «Би тантай уулзах хэрэгтэй байна, танд гомдоохгүй мөнгө өгнө шүү». Ландон одоо үнэнээсээ уурлаж эхлэв. «Уучлаарай, гэхдээ би...» «Та яг одоо гарвал энд» «Би хаашаа ч гарахгүй. Өглөө таван цаг болж байна, хөөе» гээд Ландон утсаа шидээд орон дээрээ унаад өгөв. Нүдээ аниад унтах гэж хичээв. даан ч болсонгүй. Нүдэнд нь юм эрээлжлээд тархи нь амарч чаддаггүй. Дурамжхан босч халаадаа нөмрөөд доошоо буулаа. Массачусетсийн Виктория хатан хааны үеийн загвартай байшиндаа Роберт Ландон хөл нүцгэн гэлдэрч унтаж чаддаггүй өвчнөө Нэстле Күикийн уур савссан халуун шоколадаар даамжруулж сууна. Дөрвөн сарын саран цонхоор гийж, шалан дээр байгаа дорнын хэвтэй хивснээ тусна. Ландоны найзууд нь гэрийг нь гэр биш, антропологийн музей гэж наргидаг ажээ. Энэ тэндгүй шашны эд зүйл хөглөрөх бөгөөд Ганын **экуэба****, Испанийн алтан загалмай, Эгийн тэнгисийн Циклад арлын элдэв зүйлс, тэр бүү хэл залуу дайчны мөнхийн залуу насны билэгдэл болсон Борнео арлын боккус хүртэл байна. Ландон Махаришигийн хүрэл сандалд тавтай яа тухлан, халуун шоколад таатай яа балган суухад цонхны шил түүний дүрсийг тольдон байв. Шилэнд туссан бүдэг дүрс нь яг л сүг шиг харагдана. Хөгшин сүг шиг гэсэн ч цалгиун залуу зүрх сэтгэл нь мөнх бусын дунд оршин байгаадаа хэмээн бодов. Хэдийгээр сонгодог утгаараа сайхан залуу гэдэгт орохгүй боловч дөчин тавтай Ландоныг эмэгтэй найзууд нь «боловсон» төрхтэй гэлцэх агаад саарал сор суусан өтгөн бараан үс, нухацтай харсан цэнхэр нүд, хүнгэнэсэн хоолой, тамирчин маягийн хайнга инээмсэглэлийг нь хэлдэг ажээ. Сургууль, коллежийнхоо шигшээ багийн шумбагч байсан болохоор одоо ч усч хүний биетэй агаад зургаан тохой өндөр Ландон сургуулийнхаа усан санд өдөр бүр сэлсээр байдаг ажээ. Найз нар нь Ландоныг эрин зуунд төөрч төрчихсөн сонин этгээд гэдэг. Заримдаа тэр оюутнуудтайгаа компьютер график, шашны түүхийн талаар ярьж жинс өмсчихсөн явна, харин заримдаа музейн нээлт дээр зургаа татуулж, лекц уншиж бүдүүн нэхээстэй Харрис гэх ноосон пиджак, цэцэг навчин хээтэй жилетээ өмсчихсөн догь гэгч алхана. Хэдийгээр сайн багш, нямбай судлаач боловч Ландон «зөв цэвэр таашаал авах мартагдсан урлаг»-ийг эзэмшсэн хүн юм. Биеийн тамираар хичээллэхдээ бүр халдвартай гэмээр урамтай байдгийг нь оюутан шавь нар

нь хүртэл халуунаар сайшаадаг байв. «Дельфин» гэж түүнийг хочилдог нь усан поло тоглохдоо нэг шумбаад л эсрэг багийнхаа бүх хүнийг сүлжин сэлдэг гайхалтай чадварт нь төдийгүй, эвсэг занд нь өгсөн нэр билээ. Ландон гэртээ ганцаараа харанхуй ширтэн сууж байтал анир чимээгүйг факсын хонх эвдэн дуугарав. Уцаарлахаасаа ч төвөгшөөсөн тэрээр тэр зүг дурамжхан матийлаа. *Хөөрхий бурхны үрс Мессаяагаа хоёр мянган жил хүлээж, одоо ч мятрахгүй хүлээх юм даа, чааваас* гэсэн бодол төрөв. Хоосон аягаа гал тогооныхоо тавиур дээр орхиод царсаар доторлосон ажлынхаа өрөө рүү гэлдэрлээ. Дөнгөж ирсэн факс, факсын машины аман дээр байна. Нэг сайхан санаа алдаад, Ландон тэр факсыг авч харав. Хармагц ... бөөлжис цутгаад явчихлаа. Факс дээр байгаа зураг дээр хүний хүүр байв. Хүүрийг нүцгэлж, шалдалжээ. Хүзүүг нь хугалж, толгойг нь эргүүлээд цааш нь харуулчихсан, цээжин дээр нэг юм түлж бичсэн байв. Талийгаачийг ганц үгээр тамгалжээ. Ландон тэр үгийг мэдэхийн цаагуур мэддэг байсан ч тэр үгийг нүд салгалгүй гайхан ширтлээ. ИЛЛЮМИНАТИ «Иллюминати» хэмээн зогтусан бувтнаж зүрх нь дэлсэж эхлэв. Ийм юм гэж бас байдаг аа???... Ландон зургийг аажуухан, 180 хэм эргүүлж харахдаа, мөн байвал яахаа мэдэлгүй балмагдаж байв. Тэрээр тэр үгийг урвуу харуулан уншлаа. Амьсгал бөглөөд, ачааны машинд мөргүүлчихсэн юм шиг л боллоо. Нүдэндээ итгэж ядан, факсыг дахин эргүүлж, өөд уруу нь харуулан ахин дахин уншлаа. «Иллюминати» хэмээн дуу алдан шивнэв. Ландон алмайрч сандал дээр лаг хийтэл унав. Тэр үнэхээр галзуурсан мэт хэдэн хором суулаа. Түүний нүд факсын машины анивчин буй улаан гэрэлт дээр тусч энэ зургийг илгээсэн тэр этгээд утсаа тавилгүй хүлээж байгааг сая л анзаарав. Ландон тэр анивчих гэрлийг удаан ширтлээ. Тэгээд гэнэт ухаан орсон мэт салганан гүйж утсаа авлаа. * Турины бүтээлэг буюу заримдаа Есүсийн бүтээлэг гэх эртний нэгэн бүтээлэг дээр ямар нэг эрэгтэй хүний дүрс гарсан байдаг агаад түүнийг Есүсийг цовдлуулсны дараа хүүрийг нь ороосон даавуу мөн гэж зарим нь үздэг. Үүнтэй холбоотой олон судалгаа байдаг ч өнөөг хүртэл үнэхээр тэр даавуу мөн эсэхийг нь тодорхойлж чадаагүй, тэр хүний дүрс Есүсийнх мөн эсэх нь ч тодорхойгүй байгаа юм. Энэ зохиолд Турины бүтээлэг гэдэгтэй *Тулзагийн бүтээлэг** гэж зүйрлүүлжээ. Тулза гэдэг нь Оклахомагийн нэгэн хот бөгөөд тайчигч бүсгүйн амьдардаг хот ажээ. ** Африкийн Гана улс, түүний орчимд түгээмэл байдаг үр хүүхэд заяадаг гэх модон хүүхэлдэй.

Хэсэг 2

Таны анхаарлыг татаж чадав уу, би?» гэж Ландоныг утсаа авмагц цаанаас нь нэг хүн асуув. «Тэглээ. Чөтгөр гэж, тэглээ, тэглээ. Та энийг тэгээд надад юу гэж тайлбарлах гээ вэ?» «Би түрүүнээс хойш танд хэлэх гэж оролдоод байна л даа.» Түүний хоолой хяхгнуур, механик байв. «Би физикч хүн, судалгааны газар удирддаг юм. Энд нэг хүн алуулчихлаа. Та цогцыг нь харсан байх.» «Та намайг яаж олоо вэ?» гэж Ландон ухаарч ядан асуув. Ухаан санаа нь факсаар илгээсэн зураг дээр л эргэлдэнэ. «Танд хэлсэн шүү дээ. Интернет гэж. Таны номын вебсайт Иллюминатийн ухаан». Ландон оюун санаагаа төвлөрүүлэх гэж оролдоно. Ном нь жирийн уншигчдад бараг л хүртээлгүй, гэхдээ интернетээр нэлээн өргөн хэлэлцэгдэж байдаг. Гэхдээ л тэр хүний яриад байгаа нь утгагүй байв. «Би веб хуудсандаа нэг ч утасны дугаар тавиагүй шүү дээ?» «Манай лабораторид вебээс хэрэглэгчийнх нь мэдээллийг гаргаж авахдаа их сайн хүмүүс байдаг юм.» Ландон нэг л итгэж өгөхгүй байв. «Танай лаборатори ч их юм мэддэг бололтой шүү». «Тэгэх ёстой юм аа, бид өөрсдөө зохион бүтээсэн юм чинь»

гэж нөгөө хүн арцав. Түүний дууны өнгийг сонсвол тоглоом хийгээгүй шиг бололтой. «Би тантай уулзмаар байна» гэж нөгөө хүн тулгаад «энэ тухай утсаар яриад байж боломгүй байна. Манай хүрээлэн Бостоноос нэг цаг орчим нисэх газар байдаг юм». Ландон ажлын өрөөнийхөө бүдэг гэрэлд гартаа байгаа зургийг дахин шинжив. Зураг дээр хуучин бичиг судлалын өнгөрсөн зууны олдвор, түүний арван жилийн судалгааны үр дүнд нотлохыг оролдсон тэр билэг тэмдэг байлаа. «Яаралтай шүү» гэж утасны цаанаас хэлэв. Ландон зураг дээрх үгээс хараа салгаж чадахгүй байв. Иллюминати хэмээн дахин дахин уншина. Түүний судалгаа ямагт хуучны ном бичиг, түүхэн сураг гэх мэт дээр тулгуурлаж байсан боловч өнөөдөр тэр тэмдэг түүний өмнө гараад ирэв. Өнөө цаг дээр. Амьд динозавр харсан палеонтологич л ийм байдалд орох байсан биз. «Эрх хэмжээнийхээ дагуу би танд онгоцоо явуулсан» гэж хэлээд «Бостонд хорин минутын дараа очих байх» гэлээ. Ландон ёстой ангайж орхив. Цаг ниснэ гэнэ ээ. «Намайг ингэж яаруулж шахсанд өршөөгөөрэй, гэхдээ та надад яг одоо энд хэрэгтэй байна» гэж нөгөө хүн хэлэв. Ландон факс руу дахин харав. Эртний домог цагаан дээр хараар нотлогдлоо. Үр дагавар нь аймаар юм. Тэр цонхоороо юу бодохоо мэдэхгүй гүн харанхуй руу гөлөрч зогсоно. Үүр тэмдэгрэх шинж орж, цагаан гэгээ бүдэг бадаг татаад арын хашааны модон дээр тусч сүглийн харагдана. Айх гайхах давхацсан Ландон зөвшөөрөхөөс аргагүй байв. «За, би очье доо. Би танай онгоц руу чинь яаж очих вэ?» гэлээ.

Хэсэг 3

Мянга мянган бээрийн тэртээ хоёр хүн уулзана. Дундад зууны чулуун хүйтэн харанхуй өрөө. «Benvenuto (За морил.ита)» гэж нэг хүн хэллээ. Тэр хараанд өртөмгүй харанхуй буланд суужээ. «Амжив уу, та?» «Si (тэглээ.ита)» гэж харанхуй дүрс хариулав. «Perfettamente (Төгс гайхалтай.ита)» Үг нь чулуун хана шигээ хүйтэн. «Тэгээд хэн хариуцах нь эргэлзээгүй тодорхой биз?» «Хэн ч хариуцахгүй ээ.» «Болж, болж. Миний захисныг олж чадав уу?» Алуурчны нүд хар нүүрсэнд ойсон гэрэл шиг гялалзаад, хүнд цахим багаж гаргаж ирээд ширээн дээр тавилаа. Харанхуйд суугаа хүн баяртай байгаа бололтой.» «Чи ч сайн байна шүү.» «Ах дүүсийнхээ төлөө үнэн зүтгэнэ ээ» гэж алуурчин хариулав. «Удалгүй хоёр дахь шат эхэлнэ. Жаахан амраад ав. Өнөө шөнө цугаараа дэлхийг өөрчилнө.»

Хэсэг 4

Сааб 900S машинаа унасан Роберт Ландон Каллаханы хонгилоор гарч онгоцны Логан буудлын зүг Бостон боомтын зүүн талаар шунгинана. Машин Нисэхийн замаар ороод зүүнтээ эргэж Ийстэрн Эйрлайны хуучин барилгыг чиглэлээ. Замаас гурван зуун мухар дэлэм (ярд) зайтай нэгэн ангаар харанхуйд бүртийнэ. Дээр нь том гэгч 4-ийн тоо зурсан байв. Ландон зогсоолд хүрч, машинаа тавилаа. Нисэгчийн хөх хувцастай дугуй царайтай залуу байшингийн цаанаас гарч ирээд «Роберт Ландон уу?» гэлээ. Дууных нь өнгө тун найрсаг агаад харь аялгатай ярих ажээ. «Мөн л байна» гээд Ландон машинаа түгжив. «Та цагийг ч төгс барих юм аа. Би дөнгөж газардаад байлаа. Дагаад яваарай» гэж нөгөө залуу хэлэв. Тэр хүнийг дагаж байшин тойрохдоо Ландон жаахан барьц алдаж байлаа. Тэрээр шөнө дөлөөр хачин хүнтэй утсаар нууц юм ярьж, хүнээс далд хүнтэй уулзаж сураагүй нэгэн билээ. Юу хэлэхээ мэдэхгүй тэрээр дэмий л битүү захтай цамц, Харрис пиджакаа татаж янзлав. Өдөр болгон хичээлдээ өмсдөг энэ хувцасныхаа хармаанд хийсэн факс, тэнд байгаа зургийг мартаж чадахгүй л байлаа. Аягүйцээд байгааг нь нисэгч мэдсэн мэт «та нисэхээс айдаггүй биз дээ, эрхэм ээ?» гэлээ. «Яалаа гэж дээ» гээд *нисэхийг ч чадна аа, харин тамгалуулсан хүүр л надад асуудал болоод байна даа, залуу минь* гэж бодов. Залуу Ландоныг ангаарын мухар руу аваачаад нисэх

зурвас руу эргэдэг булан руу очлоо. Гүйлтийн зурвас дээр байгаа онгоцыг хараад Ландон ёстой гацталаа гайхлаа. «Бид үүгээр явах юм уу?» Залуу: «Гоё байгаа биз?» гэлээ. Ландон ширтсэн хэвээр. «Гоё гэж дээ. Энэ чинь юу юм бэ?» гэв. Өмнө нь нүсэр том онгоц байв. Сансрын буухиа хөлөгөрхүү дүрстэй мөртөө дээд үеийг нь хусч аваад мөлгөр хавтгай болгочихсон юм шиг эд байх ажээ. Том сүхний занхгар толгой зам дээр тавьчихсан юм шиг эв хавгүй харагдана. Ландон эхлээд зүүдэлж байна уу даа гэж бодов. Нисдэг гэхээргүй болхи галбиртай эд ажээ. Их бие нь сүүл хэсэгтээ мойногдуу гурвалжин л болохоос далавч гэмээр юм бараг алга. Сүүлэн дээрээ хоёр чиглүүр маягтай юм байх ажээ. Онгоцны бусад хэсэг бүхэлдээ хитэг байх агаад уртаашаа 200 орчим тохой, цонх ч байхгүй. «Хоёр зуун тавин мянган кило түлш бүрэн ачсан» гээд л нисэгч өөрийгөө магтдаг хөндий цээжтэн шиг гайхуулж гарав. «Шингэрүүлсэн ус төрөгчөөр ажилладаг. Гадарга нь силикон карбид утастай титаны матриц. Тийрэлт, жингийн харьцаа 20:1, харин одоогийн дийлэнх онгоц 7:1-ийн харьцаатай байдаг юм. Захирал тантай уулзах гэж ёстой л солиотой юм шиг яарч байна. Түүнээс биш энэн шиг онгоцыг хүн болгон руу явуулаад байдаггүй юм». «Энэ чинь тэгэхээр нисдэг байх нь ээ?» «Тэгэлгүй яах вэ» хэмээн нисэгч инээмсэглэлээ. Нисэх зурвас дамжин Ландон онгоц руу дөхөв. «Эхэлж харахаар цочирддог л юм, гэхдээ дассан нь дээр дээ. Манай лаборатори л эхэлж худалдаж авсан болохоос таван жилийн дотор бүх хүн энэ Өндөр хурдтай иргэний тээвэрлэгч ӨХИТ-өөр л нисдэг болно гэж мэд» хэмээн нисэгч тайлбарлана. *Тэр ч ёстой ёрын лаборатори байна даа* гэж Ландон бодов. «Энэ бол Боинг Х-33 загвар. Өөр бас олон бий. Америкчууд Үндэсний агаар сансрын хөлөг, Оросууд Скрамжет, Британичууд ХОТОЛ гээд л. Ирээдүй гэдэг чинь энэ дээ. Хүмүүсийн түгээмэл хэрэглээ болтол жаахан хугацаа л хэрэгтэй. Тэгээд ер нь ердийн онгоцнуудыг баяртай гэх цаг ирчхээд байна шүү дээ» гээд л нисэгч урсгаж гарлаа. Ландон аягүйцсэн хэвээр онгоц руу хараад «ердийн онгоц нь дээр байх аа» гэж бодлоо. Нисэгч шат руу заагаад «Ландон гуай, ийшээ морил» гэлээ. Хормын дараа гэхэд Ландон эзгүй бүхээгт ганцаараа сууж байв. Нисэгч Ландоныг зорчигчийн суудлын урд эгнээнд суулгаж, бүсээр нь даруулж өгчхөөд өөрөө онгоцны урд хэсэг рүү ороод алга болчхов. Энэ онгоц дотроо бол ердийн онгоцтой адил ажээ. Гэхдээ нэг ч цонхгүй болохоор Ландонд эвгүй байлаа. Ландон багадаа осолд орж байснаа хэзээ ч мартаж чаддаггүй болохоор насаараа кластрофобийн хөнгөн хэлбэрээр зовдог байв. Битүү газар байх дургүй Ландонд энэ онгоц эвгүй санагдаад байлаа. Тэр дандаа битүү газраас зайлсхийдэг ажээ. Ракетбол буюу битүү өрөөнд бөмбөгийг хана руу ойлгон цохидог тоглоомд хүртэл нэг л битүү, бүгчим байдаг болохоор дургүй, эвгүй байдаг байлаа. Хэдийгээр жижиг, цомхон, авсаархан, хямдхан байшин авах боломжтой байсан ч Виктория хатан хааны үеийн уужим, саруул, өндөр таазтай байшингаа илүү үнэ төлөн байж авч билээ. Музейн цэлгэр том танхимууд л түүнийг яваандаа урлагийн ертөнцийг шимтэхэд хүргэсэн байж магадгүй юм. Онгоцны хөдөлгүүр шалан доог хүржгэнэхэд хитэг бүхэлдээ дэржигнэж эхлэв. Ландон шүлсээ залгиад, юу болохыг хүлээн, биеэ дангитал чангаллаа. Тэрээр онгоц чичирхийлэх вий гэж бодлоо. Сайхан кантри хөгжим таазнаас зөөлөн дуугарч эхэлсэн ч холоо гэгч газраас хоолойгоор дамжуулан сонсож байгаа юм шиг хөндий сонсогдоно. Ханын утас хоёронтоо жингэнэхэд Ландон харилцуурыг авлаа. «Байна уу?» «Тухлаж амжив уу, эрхэм ээ?» «Амжаагүй л байна.» «Тайвшир даа. Цагийн дотор л тийшээ оччихно шүү дээ.» Ландон хаашаа явах гэж байгаагаа асуугаагүйгээ санаж «ингэхэд тийшээ гэдэг маань хаашаа билээ» гэв. «Женев. Манай лаборатори Женевт байдаг юм» гэж хөдөлгүүрээ дүнгэнүүлэн нисэгч хариуллаа. Ландон үүнийг сонсоод бага ч болов санаа амрав. «Женев гэж Нью Йорк муж улсын хойд хэсгийн хот уу даа? Манай нэг хамаатны айл Сенека нуурын дэргэд байдаг юм.

Гэхдээ би Женевт физикийн лаборатори байдаг гэж мэдээгүй юм байна». Нисэгч хөхрөн «Нью Йоркийн Женев биш ээ, эрхэм ээ. Швейцарийн Женев!» Ландон нисэгчийн үгийг сайн ухаарсангүй. «Швейцарь?!» Нуруунаас нь бүлээн халуун юм дээшээгээ огшоод явчихав. «Лабориторь чинь эндээс ганц цагийн зайд л байдаг гээ биз дээ?» «Тийм ээ, эрхэм ээ. Онгоц маань арван таван Махын (хэмжүүр) хурдтай нисдэг юм л даа.»

Хэсэг 5

Түм түчигнэсэн европын нэгэн гудамжинд алуурчин олны дотор сүлжин алга болов. Тэр хүчтэй, чадалтай, хорлонтой, зальтай, шаргуу нэгэн байв. Саяхан болсон уулзалтын дараа түүнд бяра амтагдан баяртай явна. Алуурчин «*чи ч сайн байна шүү*» хэмээн бувтнана. Харанхуй сүүдрээс эзнийхээ царайг зүсэлж хараагүй боловч уулзсандаа баяртай байв. *Эзэнтэй холбогдсоноос хойш дөнгөж арван таван өдөр л болж байгаа юм байна шүү дээ.* Алуурчин утсаар анх ярьснаа одоо болтол үг үгээр нь санаж байлаа... «Намайг Янус гэдэг» гэж утасны цаанаас хэлэв.» Бид нэг бүлэглэл ухаантай юм. Мөн та бид нэг дайсантай юм байна. Таныг ур чадвараараа бусдад тусалдаг гэж сонслоо л доо». «Та хэний өмнөөс ярьж байна гэдгээс л шалтгаална даа» гэж алуурчин хэлэв. Утастсан хүн хэллээ. «Та тоглоом хийе гэж бодоо юу?» «Та манай нэрийг мэдэж авлаа шүү дээ» гэж цаад хүн хариулав. «Тэгэлгүй яах вэ. Тэр ч домогт нөхөрлөл шүү.» «Гэхдээ л та биднийг байдаг гэдэгт эргэлзээд байх шиг.» «Таны яриад байгаа нөхөрлөлийг тараад алга болчихсон гэж хүн бүхэн л мэднэ шүү дээ.» «Хуурах арга шүү дээ. Хэн ч айдаггүй дайсан л хамгийн аюултай байдаг юм». Алуурчин итгэлгүй л байлаа. «Танай нөхөрлөл хэвээрээ байгаа юм уу, тэгээд?» «Хэзээ хэзээнээс илүү нууцаар гээч. Гэхдээ бидний нөхөрлөл чиний харж байгаа бүх газарт, тэр бүү хэл манай заналт дайсны хамгийн бат цайзад ч хэрэн нэвтрээд байгаа». «Тэнд нэвгэрнэ гэдэг ч санасны гарз биз дээ». «Манайхны гар ч урт шүү». «Гэхдээ хэнийх ч тийм урт байж чадахгүй». «Удахгүй чи итгэнэ ээ. Манай нөхөрлөл цаглашгүй эрх хүчээ удахгүй гайхууламз. Нэг урвалт, эргэлзээгүй ганц нотолгоо». «Та нар юу хийгээ вэ?» Утсаар залгасан хүн түүнд нэгэн учир хэлж өгөв. Алуурчны нүд нь бүлтрэх шахав. «Бүтэхгүй ажил байна даа». Маргааш нь тэр тухай бүх сонин хэвлэл тэргүүн нүүрэндээ мэдээлсэн байлаа. Алуурчин итгэн дагалаа. Арван таван хоногийн дараа гэхэд алуурчны итгэл ямар ч эргэлзээгүй бат нот болжээ. *Нөхөрлөл одоо ч амьд. Өнөө шөнө манай нөхөрлөл эрч хүчээ гайхуулан гарч ирнэ.* Гудамжаар алхаж явахад нь түүний нүд учир мэдсэн шинжтэй, цогтой гялалзана. Түүхэн дэх хамгийн аймшигт, нууц нөхөрлөл түүнийг дайчин эгнээндээ нэгтгэлээ. *Намайг сонгосон нь зөв болсон шүү* гэж бодогдоно. Алж устгадаг шигээ алга болдог овтой нэгэн билээ. Өнөөг хүртэл тэрээр үнэнч зүтгэлээ. Тэр устгах хүнээ устгаж, авчрах юмаа авчирч Януст гардуулсан. Тэр юмаа товлосон газраа аваачих Янусын ажил л үлдлээ. Товлосон газар... Янус тэрийг яаж аваачих юм бол гэж алуурчин гайхаж байв. Түүнд дотроос нь хүмүүс тусалдаг нь лавтай. Манай нөхөрлөлийн гар ч урт юм аа. *Янус гэдэг мэдээж нууц нэр л байгаа* гэж алуурчин бодно. Ромын хоёр нүүртэй бурхныг билэгдсэн юм болов уу, Сатурны сарыг билэгдсэн юм болов уу. Гэхдээ ялгаагүй юм даа. Тэрээр дийлдэшгүй эрх хүчтэй, түүнийгээ ч эргэлзээгүй нотолсон. Алуурчинд өвөг дээдэс нь тэнгэрээс түүнийг инээвхийлэн ширтэж байх шиг санагдав. Өнөөдөр тэр өвөг дээдсийнхээ зуун зууны тэртээ бүр арван нэгдүгээр зуунд байлдаж явсан дайсантай үзэлцэж байна. Дайсан цэрэглэн ирж газар нутгийг нь эзэрхийлж, хүн ардыг нь хүчирхийлэн, шашин шүтлэгийг нь доромжлон, сүм хийдийг нь түйвээж, бурхныг нь ариун бус хэмээн зүхсэн сэн. Түүний өвөг өөрсдийгөө өмгөөлөн хамгаалахын тулд цомхон, гэхдээ үхлийн бүлэг байгуулжээ. Тэр бүлэг хүй элгэнээ авран хамгаалагч, дайснаа дайралдсан газраа даран

сөнөөдөг дархан баатар хэмээн алдаршсан. Тэд зөвхөн өршөөлгүй устгадгаараа ч бус ялалт болгоноо хар өвс зооглон мансууран тэмдэглэдгээрээ ч цуутай байжээ. Таалан зооглодог тэрхүү чадал зориг суулгах хар өвсийг тэдний хэлээр хашиш гэнэ. Тиймээс ч хашиш дагагч буюу хассассин хэмээх нэрээр цуу алдар нь түгэн дэлгэрчээ. Хожим хассассин гэх үг дэлхийн бараг л бүх хэлэнд үхэл гэдэгтэй нэгэн утгаар орсон байдаг агаад өнөөгийн англи хэлэнд ч амь хөнөөх нэгэн зүйл арга хэмээн орсон байдаг. Гэхдээ үүнийг англиар ассассин буюу аллага үйлдэгч гэдэг.

Хэсэг 6

Газраас хөөрөөд жаран дөрвөн минут болсны дараа нүдэндээ итгэж ядсан, бас дотор нь жаахан эвгүйтсэн Ландон нар ээсэн нисэх буудлын гүйлтийн зурвас дээр хөл тавилаа. Цэнгэг зөөлөн салхи түүний пиджакны захыг нь илбэн байв. Задгай агаарт гарах гайхалтай сайхан байлаа. Цав цагаан оройтой нов ногоон уулын хөндийг нүдээ жирвийлгэн таатай яа харав. Би зүүдлээд байна. Сэрчих вий дээ гэж Ландон бодно. «Швейцарьт тавтай морил» хэмээн нисэгч ард нь хүнгэнэх Х-33-ын HEDM хөдөлгүүрийн хүржигнэх дууг давах гэж оролдон хашхирлаа. Ландон цаг руу харахад өглөөний 7.07 болж байна. «Та цагийн зургаан бүс нэвт нисчихсэн. Одоо энд өдрийн 1 цаг л болж байгаа байх» гэж нисэгч хэлэв. Ландон цагаа таарууллаа. «За, яаж байна даа?» Тэрээр гэдсээ илээд: «Болохгүй юм идчихсэн юм шиг л байна» гэлээ. Нисэгч толгой дохиод: «Өндрийн цочрол. Бид жаран мянган тохой өндөрт байсан гэдэг чинь та газарт байгаа жингээсээ гучин хувь хөнгөн байсан гэсэн үг шүү дээ. Харин ч зөөлөн байлаа. Токио руу ниссэн бол зуун бээр өндрөөс буухгүй юу, тэгсэн бол гэдэс дотор тань урваад гарчих байж л дээ.» Ландон толгой дохиод, өөрийгөө азтайд тооцлоо. Нислэгийн бүх зүйл гайхалтай, ер бусын байв. Яс шархиртал огцом хурдаа авсныг эс тооцвол агаарын хуйлралаас болж бага зэрэг чичрэх, өндөр авахад даралт өөрчлөгдөх зэргээрээ ердийн нислэгээс огт ялгаагүй агаад цагт 11000 бээрийн хурдтай бараг л сансарт гарч ниссэн гэх ямар ч тэмдэггүй шахам байв. Хэдэн техникч нислэгийн зурвасаар Х-33 руу гүйж явна. Нисэгч Ландоныг дагуулан хяналтын цамхгийн дэргэдэх авто зогсоолд зогсох Пюжо маркийн суудлын тэрэг рүү аваачив. Хормын дараа гэхэд тэрээр уулын хөндий дагуулан тавьсан засмал замаар шунгинаж явлаа. Ногоорон харагдах хөндийн тэртээ алсад олон байшингийн орой үзэгдлээ. Хурдны заалт 170 км/цаг буюу 100 бээр/цаг хүрэхийг Ландон итгэж ядан харна. Энэ залуу чинь яачихсан гэхээрээ дандаа ингэж хурдалдаг нөхөр вэ хэмээн гайхан нисэгч рүүгээ харлаа. «Лаборитори хүртэл таван километр. Бид хоёрхон минутын дараа л хүрчихнэ» гэж нисэгч тайлбарлав. Ландон аврах бүсээ тэмтрэн *явах хугацаагаа гурван минут болгоод амьд мэнд очиж болдоггүй юм болов уу* гэж бодлоо. Машин хурдалж гарлаа. «Ребагийн дуунд дуртай юу» гэж нисэгч асуугаад машины хөгжим руу хуурцаг хийлээ. Нэг хүүхэн дуулж эхлэв. «Ганцаараа байх айдаст автан ...» Ганцаараа байхад ч айх юм үгүй шүү гэж Ландон бодно. Хамт ажилладаг хүүхнүүд нь түүнийг гэрийнхээ хоосон зайг дүүргэхийн тулд л музейд тавим сайхан олдвор цуглуулдаг гэх ба уул нь тэр зайг нь эмэгтэй хүн дүүргэх ёстой байжээ. Тэгэхэд нь Ландон хөхөрч, билэг тэмдэг судлал, усан поло, ганц бие амьдрал гэсэн гурван зүйлд хамаг дур сонирхлоо өгчхөөд, дэлхий даяар зугаалж, хүссэнээрээ унтаж, шөнөжин таалагдсан сайхан номоо уншиж өнгөрөөх боломжтой байх нь хамаагүй дээр гэж ярьдаг ажээ. «Манайх жижигхэн л болохоос яг л хот шиг байдаг юм» гэж жолооч хэлж, Ландоныг бодлоос нь салгав. «Зүгээр ч лаборатори биш шүү. Дэлгүүр, эмнэлэг, бүр кино театр хүртэл бий». Ландон толгой дохиод хором бүр нүдэнд нь томрох хотын барааг чимээгүйхэн харж суув. «Манайд дэлхий дээрх хамгийн том машин бий» гэж нисэгч

үргэлжлүүлнэ. «Тийм үү» гээд Ландон ойр тойрноо хайнгуй харлаа. «Эндээс харагдахгүй ээ, эрхэм ээ. Газар дор зургаан давхар доор байдаг юм» гээд нисэгч инээмсэглэв. Ландон дахиж юм асууж амжсангүй. Нисэгч анхааруулалгүй тоормос гишгэж, машин эрчээрээ гүйсээр харуулын байрны урд зөөлөн зогслоо. Хаалган дээр SECURITE. ARRETEZ (Харуул. Зогс.) гэж бичжээ. Ландон хаана яваагаа ухаармагцаа гэнэт балмагдан сандрав. «Бурхан минь! Паспортаа мартчихаж». «Паспорт хэрэггүй ээ. Манайх Швейцарийн засгийн газартай байнгын тусгай гэрээтэй» гэж нисэгч ойшоосон шинжгүй хэлэв. Нисэгч хамгаалалтын залууд үнэмлэхээ үзүүлэхэд нь Ландон алмайрч орхив. Хамгаалагч үнэмлэхийг батламжийн цахим машинд шургуулаад авлаа. Машин ногоон гэрлээр анивчив. «Зорчигчийн нэр?» «Роберт Ландон». «Урьсан?» «Захирал өөрөө». Хамгаалагч хөмсөг агируулан харав. Тэгснээ нэг хэвлэсэн цаас авч, дээр нь байгаа мэдээллийг компьютерын дэлгэц дээрх мэдээлэлтэй тулгаж харлаа. Хэсэг азнаснаа цонх руу эргэж ирээд «Ландон гуай, тавтай морил!» гэлээ. Машин дахиад л сүн гээд алга болов. 200 дэлэм орчим тойрч гол хаалганы дэргэд ирлээ. Тэдний өмнө тэгш өнцөгт, ультра-модерн маягийн шил, гангаар боссон байгууламж байлаа. Ландон энэ байшингийн тув тунгалаг хийцийг гайхаж суув. Архитектур түүний дур сонирхлыг ямагт татдаг байжээ. «Шилэн дуган» гэж дагуул нь тайлбарлав. «Сүм ий?» «Үгүй чиш. Манайд байхгүй юм гэвэл сүм л байна. Энэ хавийн шашин бол физик. Та бурхны тухай яаж ч ярьсан болно, кварк, мезоныг харин муу хэлж болохгүй шүү. Ландон байшинг ширтэж суух зуур жолооч машинаа шуртхийтэл эргүүлээд шинэ байшингийн өмнөх зогсоолд аваачлаа. *Кварк, мезон? Хилийн ямар ч хяналтгүй? 15 Мах хурдан онгоц? Энэ ер нь ямар гээчийн хүмүүс вэ?* Байшингийн өмнөх боржингоор хучсан хэсэгт дээрх асуултын хариулыг бичсэн байв. (СЭРН) *Conseil Europeen pour la Recherche Nucleaire* (Цөмийн судалгааны европ зөвлөл.) «Цөмийн судалгаа?» гэж Ландон уншаад энэ үгийг зөв ойлгосон эсэхдээ тээнэгэлзэв. Жолооч хариулсангүй. Урагшаа тонгойж, машиныхаа хөгжимтэй ноцолдож суув. «Та энд бууна. Захирал таныг үүдэнд хүлээж байгаа». Тэргэнцэр дээр суусан нэг хүн байшингаас гарч ирэхийг Ландон харлаа. Тэр дөнгөж жар гарч байгаа болов уу гэмээр аж. Туранхай, халзан тэр хүн лабораторийн цагаан халаад өмсч, хөлөө тэргэнцрийнхээ гишгүүр дээр бат тавьсан байлаа. Амьгүй юм шиг хоёр нүд нь холоос ч чулуу шиг харагдах ажээ. «Тэр үү?» гэж Ландон асуув. Жолооч толгойгоо өндийлгөөд ёозгүйхэн инээмсэглээд «Чөтгөр л гэж мэд» гэлээ. Ландон яахаа мэдэлгүй дэмий л машинаас гарлаа. Тэргэнцэр дээр суугаа тэр хүн Ландон руу хурдлан ирээд хөлстэй гараа сунгав. «Ландон гуай юу? Би танай утсаар ярьсан хүн байна. Намайг Максимлиан Колэр гэдэг».

Хэсэг 7

СЭРН-ийн ерөнхий захирал Максимлиан Колэрыг хүмүүс Konig - Хан гэнэ. Тэргэнцэр сэнтий дээрээ тухлаад хүмүүсээ удирддагт нь биш, харин айдас төрүүлсэн муухай занд нь өгсөн цол байлаа. Түүнийг хувиараа мэддэг хүн цөөн ч гэсэн хэрхэн тахир дугуу болсон тухай СЭРН даяар аймаар яриа явдаг бөгөөд түүний хахир зан, эрдэмд өгсөн чин сэтгэлийг нь өөлөх хүн ховор. Ландон Колэртэй уулзаад хэдхэн хором болсон ч хүйтэн хөндий хүн гэдгийг нь аль хэдийн мэдсэн байлаа. Колэр цахим тэргэнцрээрээ гол хаалга өөд хөдөлж, аажим хурдаа авахад Ландон хойноос нь шогших шахуу алхав. Ландон хэзээ ч тийм тэрэг хараагүй бөгөөд олон шугамт утас, пэйжирийн систем, компьютерын дэлгэц тэр бүү хэл

угсардаг видео камераар хүртэл төхөөрөмжилсөн цахим тоногтой байлаа. Энэ бол Колэр ханы хөдөлгөөнт командын төв ажээ. СЭРН-ийн гулсдаг хаалгаар Ландон асар том, уужим саруул үүдний танхимд орлоо. *Шилэн дуган* хэмээн Ландон дуу алдан дээшээ харав. Цэнхэр шилэн таазнаас үдийн нар гэрэлтэн, янз бүрийн дүрстэй шилэнд ойсон нарны туяа үүдний танхимыг улам ч аугаа болгоно. Хазгай тусах сүүдэр өнгөлсөн цагаан хана дагаж, чулуун шалан дээр буух ажээ. Ариутгасан, цэвэр агаар үнэртэнэ. Хажуугаар хүн явахад хөлийн чимээ нь уужим саруул танхимд цуурайтан сонсогдох ажээ. «Ландон гуай, ийшээгээ!» Колэрын хоолой бараг л компьютерынх шиг дуугарч байна. Түүний аялга ширүүн тод ажээ. Бүгшиж ханиалгаад, цагаан алчуураар амаа арчиж байхдаа ч Ландоноос хараа салгасангүй. «Түргэлээрэй!» Тэргэнцэр өнгөлсөн шал дээгүүр жирийгээд алга болов. Үүдний өрөөнөөс үргэлжилсэн хонгил дуусашгүй мэт санагдана. Хонгил бүрт янз бүрийн судалгаа, туршилт хийж байх ажээ. Судлаачид нь Колэрыг гайхсан байртай харах бөгөөд дараа нь Ландоныг яагаад түүнийг даган шадарлаж явааг таах гэсэн шиг сониучирхан мэлэрнэ. Ландон яриа өдөх санаатай «Эрхэм ээ! Үнэндээ би СЭРН-ийн тухай ер сонсоогүй юм байна». «Гайхах юмгүй ээ» гэж Колэр хэлэхэд хариу нь тун хатуу, төгсгөлөг байлаа. «Ихэнх америкчууд европыг дэлхийд эрдмийн хувьд тэргүүлдэг гэж боддоггүй юм. Европыг хуучны эдлэл зардаг дэлгүүр шиг л боддог. Эйнштейн, Галилео, Ньютон нарыг төрүүлсэн газрыг тэгж төсөөлдөг нь бас сонин юм шүү». Ландон юу гэж хариулахаа мэдсэнгүй. Тэр хармаанаасаа нөгөө факсаа гаргаж ирээд «Энэ зураг дээр байгаа хүн, та...» гэтэл Колэр гараа саван түүнийг үгийг таслав. «Гуйя. Энд болохгүй. Хоёулаа тийшээ л явж байна шүү дээ» гээд Ландоны гарыг татаж «Би наадахыг чинь түр авч байвал дээр байх» гэлээ. Ландон факсаа гарт нь өгөөд араас нь чимээгүйхэн дагав. Колэр зүүн огцом эргээд шагнал, дурсгалын зүйлээр дүүрсэн уужим хонгилоор явав. Нэг том хүрэл пайз тэр хонгилын хойморт байлаа. Ландон явуут дундаа тэр пайзыг уншив. ЦАХИМ УР ШАГНАЛЫГ Тоон эрин дэх Соёлын санаачлалынх тулд Тим Бэрнэрс Ли болон СЭРН-д WORLDWIDE WEB-ыг зохион бүтээснийх нь төлөө олгов. *Золиг гэж! Энэ нөхөр тоглоом хийгээгүй байж шүү.* Ландон вэб гэдгийг америкчууд зохиосон л гэж боддог байлаа. Түүний мэдлэг бичдэг ном, Лувр, Эл Прадогийн музейгээр хуучин Макинтош компьютерээрээ хааяа нэг хэсүүчлэх төдийгөөр л хязгаарлагдаж байдгийг ухаарав. «Вэб гэдэг чинь энэ байшинд байгаа компьютерүүдийг хооронд нь нитгэж үүссэн юм шүү дээ» гээд Колэр бүгшин ханиаж, амаа арчсаныхаа дараа «Ингэж нитгэснээр өөр өөр секторт ажилладаг судлаачид өөр хоорондоо мэдээлэл, өгөгдөхүүнээ өдөр болгон хуваалцах боломжтой болсон юм. Гэхдээ мэдээж, бүх дэлхий вебийг АНУ-ын технологи гэж боддог юм л даа». Ландон хонгилын үзүүр хүртэл дагалдан явна. «Яагаад тэгээд энэ амжилтаа тэмдэглүүлээгүй юм бэ?» Колэр мөрөө хавчаад ойшоосонгүй. «Аар саар технологийн тухай аар саар эндүүрэл. СЭРН бол хоорондоо холбоотой баахан компьютероос хамаагүй илүү эд. Манай судлаачид бараг л өдөр бүр гайхамшиг бүтээдэг». Ландон Колэр рүү асуусан байртай харав. Гайхамшиг аа? «Гайхамшиг» гэдэг үгийг лав л Харвардын Фэйрчильдийн Шинжлэх ухааны байранд хэрэглэдэггүй ажээ. Энэ үг зөвхөн Ариун номын сургуульд л үлдсэн байлаа. «Та гайхсан харагдаж байх чинь» гэж Колэр хэлэв. «Би таныг шашны билэг тэмдэг судлаач гэж бодсон юм сан. Та гайхамшигт итгэдэггүй хэрэг үү?» Ландон «Итгэх эсэхээ шийдээгүй гэх үү дээ» гэв. *Тухайлан шинжилгээний лабораторид гардаг гайхамшигт шүү.* «Би буруу үг хэрэглэсэн байх л даа. Би зүгээр л танай хэлээр ярих гэж оролдсон юм». Ландон нэг л аягүйцээд явчихлаа. «Манай хэл ээ?» «Эрхэм ээ, таныг үгүйсгэх гээгүй юм шүү. Би шашны билэг тэмдгийг судалдаг л даа. Гэхдээ би эрдмийн хүн, шашны гэлэн биш шүү дээ». Колэр жаахан удааширч, эргэж харахад нь харц нь арай зөөлөрсөн байв. «Тэгэлгүй яах вэ. Би дутуу

боджээ. Шинж тэмдгийг нь судлахын тулд заавал хорт хавдар тусах албагүй шүү дээ». Ландон хүн ингэж ярьж байхыг ерөөсөө сонсож байсангүй. Колэр зөвшөөнгүй толгой дохиод, тэд цааш хөдлөв. «Хоёулаа бие биенээ сайн ойлгох байх гэж би бодож байгаа шүү, Ландон гуай!» Ландон харин үүнд жаахан эргэлзэж байв. Колэрыг даган явж байх зуур гүн бөглүү чимээ урд гарч байхыг Ландон сонсов. Урагш алхах бүр улам тодорч хана чичирнэ. Чиглэн яваа хонгилын үзүүрээс тэр чимээ гараад байх шиг байлаа. «Энэ юу вэ?» гэж Ландон асуув. Яг л оргилж буй галт уул руу дөхөж явах шиг санагдана. «Чөлөөт уналтын хоолой» гэж Колэр хариулахад хахир дуу нь агаарт ян хийтэл сонсогдов. Түүнийгээ нэмж тайлбарласангүй. Ландон ч асуусангүй. Яриа өдөх гэсээр цөхөрчээ. Максимилиан Колэр эелдэг, найрсаг байх гэж хичээсэнгүй. Тэгээд яах гэж энд байгаагаа эргэн саналаа. Иллюминати. Энэ асар том байгууламжийн хаа нэгтээ 3000 бээрийн цаанаас үзэх гэж зорьж ирсэн тэр тэмдгээр тамгалуулсан нэгэн хүүр байгаа билээ. Хонгилын үзүүрт хүрч ирэхэд чичрэх чимээ дүлийртэл чангарлаа. Тэд бөхийж баруун талд байсан гэгээвч рүү шагайн харав. Шумбагч онгоцны гэгээвч шиг дөрвөн жижиг цонх ханан дээр байлаа. Ландон зогсоод нэгээр нь шагайж харав. Роберт Ландон энэ насандаа сонин зүйл бишгүй олон харж байсан ч хамгийн жигтэй нь энэ байлаа. Хий юм хараагүй байгаадаа гэсэндээ бүр хэд хэдэн удаа нүдээ цавчиж үзэв. Маш том дугуй өрөө. Тэр өрөөнд жингүй юм шиг хүмүүс хөвж явав. Гурвуулаа байна. Нэг нь түүн рүү гараараа даллаад агаарт бүтэн нэг эргэв. *Ээ, бурхан минь. Би лав ид шидийн ертөнцөд байх шиг байна.* Өрөөний шал нь тахиа зумласан юм шиг шарга, шоон хээтэй. Доор нь том гэгч моторын металл дүрс үзэгдэнэ. «Чөлөөт уналтын хоолой» гэж Колэр зогсосхийн Ландоныг хүлээн хэлэв. «Жингүйдэлт. Стресс тайлах арга л даа. Босоо салхин хоолой». Ландон амаа ангайн гайхжээ. Хөвж явсан хүмүүсээс нэг махлаг авгай цонх руу дөхөж ирэв. Агаарын хүчтэй урсгалаас болж далбаганах тэр авгай найрсгаар инээмсэглэхэд нүүрнийх нь арьс үелзэн татганана. Тэр эмэгтэй Ландон руу хараад эрхий хуруугаа гозойлгов. Ландон муухан инээмсэглээд хариу зангахдаа эрхий хуруугаа гозойлгох нь эр хүний бэлэг эрхтний чалхыг бэлгэдсэн эртний дохио гэдгийг энэ авгай мэдэхгүй дээ гэж бодлоо. Тэр бандгар авгай дээрээ шүхэр маягийн зүйл өмссөн цорын ганц хүн байхыг Ландон анзаарав. Дөрвөлжин даавуун зүйл түүнийг яг л өлгөсөн тоглоом шиг тогтоох ажээ. «Тэр жижигхэн шүхэр юм уу, юу юм бэ?» гэж Ландоныг асуухад Колэр: «Диаметр нь нэг дэлмээс илүү байж болдоггүй юм» гэлээ. «Үлээхэд биеийн жинг нь хөнгөлж өгнө». Тэгээд хонгил руу харцаа шилжүүлэнгээ «Нэг дэлэм ам дөрвөлжин талбай унаж яваа биеийн хурдыг хорь шахуу хувиар удаашруулдаг юм». Ландон тоомсоргүйхэн толгой дохив. Энэ шөнө, хэдэн зуун бээрийн цаана, Колэрын дөнгөж сая ярьсан зүйл амийг нь аврах юм чинээ санахгүй явдлаа.

Хэсэг 8

Тэр хоёр СЭРН-ийн гол байраас гарч Швейцарийн цэнгэг агаар, хурц нарны гэрэлд гарч ирмэгц Ландонд гэртээ ирсэн мэт санагдлаа. Өмнө байгаа бүх юм хуучны их сургуулиудын байдаг л нэг төрх байлаа. Дөв дөрвөлжин буттай цэв цэвэрхэн зассан нов ногоон зүлэг уулын бэл даган бууж сургуулийн дотуур байр, явган хүний замыг эмжинэ. Ухаалаг царайтай баахан хүн том том ном тэврэн гадуур доторгүй холхино. Урт үстэй хоёр хиппи залуу дотуур байрны цонхноос эгшиглэх Малерийн дөрөвдүгээр симфонийг сонсонгоо хуванцар таваг хоорондоо шидэлцэн тоглох нь эрдмийн уурхай гэж ийм л байдаг болов уу гэмээр амгалан ажээ. «Энэ манай судлаачдын дотуур байр» гэж Колэр тайлбарлангаа тэр байшингийн зүг сандлаа эргүүлээд хурдаа нэмэн уруудав. «Энд гурван мянга орчим физикч байдаг юм. Дэлхий дээр эгэл бөөмс судалдаг бүх физикчийн тал илүү нь энд СЭРН-д ажилладаг. Герман, Япон,

Итали, Нидерланд гээд л бүх орны нэртэй сайн эрдэмтэн болгон энд бий. Нийтдээ жаран орны, таван зуун их сургуулиас ирсэн хүмүүс дээ». Ландон алмайрсан хэвээрээ. «Тэд тэгээд яаж хэл амаа ололцдог юм бэ?» «Мэдээж англиар л байхгүй юу. Эрдмийн нийтлэг хэл шүү дээ». Ландон математикийг л эрдмийн нийтлэг хэл гэж ойлгодог байлаа, гэхдээ үг сөрсөнгүй, Колэрыг дуулгавартай яа дагана. Бэл рүү буух зам дунд орж явтал нэг залуу өөдөөс гүйж явна. Түүний футболк дээр «ЕО-гүй бол ЦУУ үгүй» гэсэн бичигтэй байлаа. Ландон түүнийг дагуулж харангаа «ЕО-гүй бол гэнэ ээ. Манай цэргийнхний зүдэрч чардайхгүй бол алдар цуу олдохгүй гэдэг уриа энд бас байдаг байх нь ээ?» гэж асуув. «Биш ээ. ЕО гэдэг нь Ерөнхий онол, Орны ерөнхий (нэгдсэн) онолыг хэлж байгаа юм» гэж Колэр бувтнаад «Юм болгоныг тайлбарладаг онол гэсэн үг» гэв. «Аа» гэж Ландон юу ч бодолгүй толгой дохив. «Та эгэл бөөмсийн физик гэж мэдэх үү, Ландон гуай?» Ландон мөрөө хавчин «Би ерөнхий физик гэж л арай чүү сонссон. Биеийн чөлөөт уналт энэ тэр гээд л». Олон жил усанд шумбасны хувьд гравитацийн акселлерацийн асар их хүчийг биеэрээ мэдэрч гайхдаг төдий л байлаа. «Эгэл бөөмсийн физик гэж атом судлалыг хэлж байна уу, үгүй юу?» Колэр толгой сэгсэрлээ. «Манай судалж байгаа юмтай харьцуулахад атом гэдэг чинь гариг ертөнц л гэсэн үг. Бид атомын цөмийг судалдаг. Бүхэл атомаасаа бүр арван мянга дахин жижиг эд л дээ». Дахиад л бүгшин ханиана, бие нь хариугүй дорой байгаа бололтой. «СЭРН-д байгаа хүн бүр түүхийн турш хүмүүсийн сонирхсоор ирсэн тэр л асуултад хариулах гэж оролддог юм. Бид хэрхэн үүсэв, биднийг юугаар хийв гээд л». «Энэ асуултын хариултыг тэгээд физикийн лабораторьт хайдаг гэж үү?» «Гайхсан сонсогдож байх чинь». «Харин тийм. Энэ чинь нэг л шашны маягийн асуулт байна л даа». «Ландон гуай, бүх асуулт нэгэн цагт шашных байсан юм. Эрдэм тайлбарлаж чадахгүй байгаа орон зайд л шашин, шүтлэг оршиж ирсэн юм шүү дээ. Нар мандах, шингэхийг эрт үед нарны бурхан гал тэргээрээ зугаацаж явна гэдэг байлаа. Газар хөдлөх, далайн татлага, түрлэгийг Посейдоны хийж байгаа ажил гэдэг байлаа. Харин эрдэм хүчээ авч, тэр бурхан гэдэг нь худал домог төдий юм гэдгийг баталж өгсөн. Удахгүй бүх бурхныг худал гэж баталж дуусна даа. Эрдэм өнөөдөр хүний асууж болох бараг бүх асуултад хариулаад байна. Хэдхэн асуулт л үлдээд байгаа, тэгээд тэр нь дандаа эсоретик асуулт. Бид хаанаас үүсэв, бид энд юу хийж байгаа юм бэ, амьдрал, орчлон хорвоогийн утга учир юунд орших вэ гэх мэт». Ландон толгой эргэж орхив. «СЭРН тэгээд ийм асуултад хариулах гээд байгаа юм уу?» «Байзаарай. Бид энэ асуултад хариулж байгаа юм». Дотуур байр тойрон эргэх үед Ландон дуугаа хураалаа. Хуванцар таваг толгой дээгүүр нь нисч ирээд чанх өмнө нь унав. Колэр тоосонгүй. Араас нэг хүн «S'il vous plait (фра. Ажаам уу)» хэмээн талбайн цаанаас хашхирах сонстов. Ландон эргэж харав. Хоолойтой ноосон цамц өмссөн буурал хүн түүн рүү даллаж байлаа. Ландон хуванцар тавгийг шүүрч аваад их л сурмаг эргүүлж шидэв. Тэр хүн тавгаа шүүрч аваад, гартаа эргүүлж байснаа мөрөө давуулан нөгөө хүн рүүгээ шидлээ. Тэгээд Merci (фра. Баярлалаа) гэж Ландон руу хэлэв. Ландоныг Колэр рүү эргэхэд «Баяр хүргэе. Та дөнгөж сая multiwire proportional chamber зохион бүтээж Нобелийн шагнал хүртсэн Жорж Шарпактай тоглочихлоо» гэлээ. Ландон толгой дохив. *Азтай л байгаа юм шиг байна даа.* Ландон, Колэр хоёр цаашаагаа гурав орчим минут яваад зорьсон газраа очив. Цэцэрлэгт том гэгч байр байлаа. Бусад дотуур байртай харьцуулахад энэ байр арай л тансаг харагдана. Байшингийн өмнө сийлсэн чулуун дээр С БАЙР гэжээ. *Сүрхий хийсвэрлэсэн нэр шив дээ* гэж Ландон үл ойшоон харлаа. Ландон архитектурын консерватив, бат бөх хэв маягт дуртай болохоор энэ энгийн нэртэй байшин таалагдлаа. Улаан тоосгон нүүртэй, шатны хигээс нь хүртэл сийлбэртэй, суурийн хөвөө нь ч бас хээтэй байв. Тэр хоёр үүд рүү чиглэн чулуун шатаар өгсөөд боржин чулуун баганатай дааман хаалгаар орлоо. Тэр хаалган дээр наадаг

цаасан дээр ЭНЭ БОЛ ИОН БАГАНА гэсэн байв. *Физикчид бас ханан дээр эрээчдэг байх нь* ээ хэмээн Ландон тэр бичгийг уншин мушилзаад «Хамгийн ухаалаг физикчид ч бас алдаа хийдэг юм байна шүү» гэлээ. Колэр толгойгоо өндийлгөн: «Юу гэнэ ээ» гэв. «Тэрэн дээр буруу бичээд наачхаж. Энэ бол ион багана биш, ион багана өргөн шулуун байдаг юм. Гэтэл энэ чинь дээшээгээ нарийссан байгаа биз? Энийг уул нь Дори гэдэг юм: Ионы загварын Грек хувилбар л даа. Гэхдээ энэ хоёрыг хүмүүс дандаа л хольж сольдог юм». Колэр инээвхийлсэн ч үгүй. «Тэрийг бичсэн хүн тоглоом хийх гэж л оролдсон юм шиг байна, Ландон гуай! Ион гэдэг нь цахилгаан цэнэгтэй эгэл бөөмсийг хэлж байгаа юм. Бараг л бүх биет ион агуулдаг юм» гэв. Ландон багана руу эргэж хараад, хоолойгоо засав. Ландон С байрын дээд давхарт гарч, лифтнээс буухдаа ч юу болоод байгааг гүйцэд ухаараагүй л байлаа. Тэр тансаг хонгилоор Колэрыг дагаж явав. Хонгилыг хүрэн буйдан, шаазан ваар, модон сийлбэрээр чимсэн нь колонийн үеийн франц хэв маягтай болгожээ. «Манайхан энд байгаа хэдэн физикчээ тохитой байлгах гэж их л хичээдэг юм» гэж Колэр тайлбарлана. *Үнэн юм аа* гэж Ландон бодов. «Факс дээр байсан хүн энд суудаг байсан юм уу? Тэгэхээр танай их л чухал хүмүүсийн нэг байж дээ?» «Аяар гэм» гэж Колэр хэлээд «Тэр уул нь өнөө өглөө надтай уулзах ёстой байсан, гэхдээ ирээгүй, бас пэйжирдэхэд хариу өгөхгүй байсан юм. Би уулзах гээд энд иртэл зочны өрөөндөө алуулсан байхыг нь оллоо л доо». Ландон үхсэн хүн харах гэж байгаагаа ухаармагц сэрвээ нь огшоод явчихлаа. Дотор нь бэлбэлзээд, эвгүй болчхов. Оюутан ахуйдаа Леонардо да Винчи хүүр өвчиж, булчинг нь зүсэж байж хүний биеийн бүтцийг судалж мэдсэн тухай анх сонсох үед бас ингэж билээ. Колэр хонгилын үзүүр рүү Ландоныг дагуулан явлаа. Тэнд ганцхан хаалга байв. Духандаа чийхарсан хөлсөө арчингаа «Дээврийн хонгил шиг байна уу» хэмээн асуув. Ландон өмнөө байгаа царсан хаалгыг харвал дээр нь ЛЕОНАРДО ВЕТРА гэж бичжээ. «Зайлуул, Леонардо Ветра дараа долоо хоногт тавин найм хүрэх байсан юм. Тэр маань энэ цагийг эзэлсэн их физикчдийн нэг байлаа. Ингэж хальсан нь юутай их гарз билээ» хэмээн Колэр халаглана. Ландон Колэрын сэтгэл хөдлөхийг түүний зэвхий царайнаас нь олж харав. Гэхдээ сэтгэл хөдлөлийн тэр илрэл гэнэт илэрсэн шигээ мөн л эгшин зуур ул мөргүй алга боллоо. Колэр түлхүүр хайн халаасаа ухангаа хаалганы цоож руу дөхөв. Нэг ч хүн энэ байшинд байхгүй байгааг Ландон гэнэт анзаарав. Буг шүглээд энэ байшингийн хүмүүсийг хөөчихсөн юм шиг л хоосон, хүйтэн. «Эндхийн хүмүүс нь хаачсан юм бэ?» Хүн амины хэргийн газарт амьтан бужигнахгүй байгаа нь нэг л жигтэй. «Хүмүүс лабораторид байгаа» гэж Колэр хэлэнгээ түлхүүрээ олов бололтой. «Үгүй, би цагдаа нар гэж хэлэх гэсэн юм л даа» гэж Ландон тайлбарлав. «Цагдаа нар ирээд явчихсан юм уу?» Колэр түлхүүрээ гаргаж цоож руу чиглүүлэн өргөнгөө тоомжиргүйхэн «Цагдаа нар уу?» гэв. Ландон Колэрын нүд рүү нь ширтэн «Цагдаа, цагдаа! Та над руу хүн амины хэргийн зураг явуулсан биз дээ. Цагдаа дуудсан байх ёстой шүү дээ». «Үгүй, дуудаагүй». «Юу гэнэ ээ?» Колэрын зэвхий нүд нь жартайж «Байдал их төвөгтэй байна, Ландон гуай!» гэв. Ландоны дотор оволзоод явчихлаа. «Гэхдээ .. та хэн нэгэнд энэ тухай мэдэгдээ биз дээ?» «Тэгсэн. Леонардо нэг өргөмөл охинтой, тэр нь бас физикч: энд СЭРН-д байдаг юм. Аавтайгаа хамт нэг лабориторьт ажилладаг юм л даа. Эцэг охин хоёр гэхээс гадна бас цуг ажиллагсад гэх үү дээ. Ветра авхай энэ долоо хоногт хээрийн судалгаанд гарчихсан. Бид түүнд аав нь нас барсан тухай хэлсэн, бид хоёрыг ингээд ярьж байх зуур ирж яваа даа». «Гэхдээ энд хүн алуулчихаад...» «Албан ёсоор мөрдөлт мэдээж явагдана» гэж Колэр бат нот хэлээд: «Тэгвэл мэдээж аав охин хоёр тас нууцлаад байдаг тэр ажлынх нь лабориторьт үзлэг хийж л таарна. Тиймээс Ветра авхайг иртэл хүлээх хэрэгтэй. Оруулах эсэхийг тэр өөрөө шийдсэн нь дээр байлгүй!» Колэр түлхүүрээ эргүүлэв. Хаалга онгойход өрөөнөөс мөс шиг хүйтэн агаар хонгил руу цутгаж

Ландоны нүүрийг сэвхийтэл үлээлээ. Тэр огт танил биш орчны заагт зогсоод хэлмэн ширтэнэ. Өрөөнд хүйтэн цайвар униар суунаглан, тавилга дашинга хооронд хурган тогтоод бүх юмыг бүүдийлгэн харагдуулна. «Энэ чинь юу вэ?» гэж Ландон дуу алдав. «Фреон хөргөлтийн систем» гэж Колэр хэлээд «Би хүүрийг илжрүүлэхгүйн тулд энэ байрыг хөргөсөн юм». Ландон пиджакныхаа товчоо товчлоод *Би гайхамшигийн оронд байна, гэхдээ шидэт шаахайгаа мартчихаж* гэж бодлоо.

Хэсэг 9

Ландоны өмнө шалан хэвтээ хүүр аймаар байв. Леонардо Ветраг нүцгэлж шалдлаад нуруугаар нь хэвгүүлсэн байх агаад арьс нь хөхөрч сааралтжээ. Хүзүүг нь нуга дарж, хугарсан газраар нь эргүүлээд чанх арагш цааш нь харуулсан байв. Нүүр нь шал руу харжээ. Тэр хүн хөлдсөн шээсэн дээрээ хэвтэж, бэлэг эрхтнийх нь үс царцан сэгсийсэн байлаа. Ландон жихүүрхэн, арай л бөөлжиж орхисонгүй: хохирогчийн цээж рүү хараагаа шилжүүллээ. Цээжин дээр нь түлж сийлсэн тэгш хэмтэй тэр бичгийг факс дээр байн байн харж байсан ч яг жинхэнээр нь харахад нүд дальдрам байв. Үсэг бүрийн зураасыг тэв тэгш ховил гарган зүсч арьс махыг нь нямбай гэгч түлжээ. Хөргөлтийн системээс болсон уу, харж байгаа зүйлийнхээ үр дагаврыг төсөөлснөөс болсон уу сэрвээг нь даган хүйт даав. ИЛЛЮМИНАТИ Тэр хүүрийг тойрч харан бичгийг өөд уруу харуулан уншиж, тэгш хэмийг нь гайхна. Энэ бэлгэдэл тийм ч нууцлаг биш санагдлаа. «Ландон гуай?» Ландон анзаарсангүй. Тэр өөрийнхөө ертөнцөд: махбод, түүх, домог, бодит явдал холилдсон тэр ертөнцөд бүх мэдрэмжээ огшоон орчихсон байв. «Ландон гуай!» гэж Колэрын нүд шаардангүй байдлаар гялалзан дуудав. Ландон эргэж харалгүй, анхаарлаа бүрэн төвлөрүүлсэн байлаа. «Та хэр их юм мэдэж авав даа?» «Вэбсайтаас чинь л жаахан юм уншлаа. Иллюминати гэдэг нь «гэгээрэгч» гэсэн үг. Эртний нэг нөхөрлөлийн нэр юм гэв үү дээ». Ландон толгой дохилоо. «Та энэ нэрийг өмнө нь сонсож байсан уу?» «Ветра эрхмийг тамгалсан байхыг хараад л анх удаа сонслоо». «Тэгээд та интернетээр хайлт хийсэн юм биз дээ?» «Тийм ээ.» «Тэгвэл энэ үгэнд зуу зуун утга олдсон байж таарна даа». «Мянга мянга» гэж Колэр хэлээд «Гэхдээ ганц таных л Харвард, Оксфорд мэт нэр хүндтэй нийтлэгчдийн жагсаалтыг ардаа хавсаргасан байсан. Судлаачийн хувьд би ийм эх сурвалжийг магадтайд тооцсон юм. Таны иш татсаныг харвал илүү бодитой санагдаад.» Ландоны нүд хүүрээс салж чадахгүй байлаа. Колэр дахиж юм хэлсэнгүй. Тэр зүгээр л Ландоныг тоймтой юм хэлж магадгүй гээд хүлээж суув. Ландон толгойгоо өндийлгөөд царцсан байрыг тойруулж хараад «Хоёулаа арай дулаахан газар ярилцсан нь дээргүй юү?» гэлээ. «Энд зүгээр шүү дээ» гэж Колэр хүйтнийг үл ажран хэлээд «Хоёулаа эндээ ярилцъя» гэлээ. Ландоны царай нь барайн *Иллюминатигийн тухай энд ярилцвал ч би дуусахаасаа өмнө хөлдөөд үхчих байх даа* гэж бодов. Энэ тийм ч амархан ярьчих түүх биш ажээ. Гэсэн ч түлж сийлсэн аймшигт бичиг рүү зэрвэс хараад ухаан санаагаа сэргээн ярьж эхэллээ. Орчин үеийн бэлгэдэл судлалд Иллюминатигийн эмблем домог болсон боловч нэг ч судлаач түүнийг өнөө хэр хараагүй байлаа. Эртний сударт энэ үгийг амбиграмм (амби-хоёр тал) буюу хоёр талаасаа уншигддаг гэж дурдсан байдаг ажээ. Хас, арга билэг загас, Ховройн од, загалмай гээд л ийм амбиграмм бэлгэдэл олон байдаг: гэхдээ, бүтэн үгийг амбиграмм болгож бичнэ гэдэг үнэндээ боломжгүй юм. Бэлгэдэл судлаачид иллюминати гэдэг үгийг төгс хэмтэй бичих гэж олон жил оролдсон ч бүтэлтэй болоогүй билээ. Тиймээс

ихэнх судлаач тийм бэлгэдэл байсан гэдэг нь зүгээр л нэг домог гэж үздэг болжээ. «За тэгээд тэр Иллюминати гэдэг чинь хэн юм бэ дээ?» гэж Колэр асуув. *Харин л дээ, нээрэн, хэн юм бол* хэмээн Ландон дотроо гайхна. Тэгээд тэрээр үлгэрээ ярьж эхлэв. «Бүр эртнээсээ эрдэм, шашин хоёрын хооронд том гэгч ангал оршин байв. Жиордано Бруно гэх мэт гайхамшигт судлаачид» гэж Ландоныг эхэлмэгц «алагдсан юм» гэж Колэр таслав. «Сүм хийд тэднийг эрдмийн үнэнийг олж хэлсний төлөө цаазалсан. Шашин ямагт эрдмийг шүүн цээрлүүлж байсан». «Тиймээ. Гэхдээ 1500-аад оны үед Ромын хэсэг эрдэмтэн сүм хийдийн эсрэг тэмцэж эхэлсэн юм. Италийн хамгийн гэгээрсэн хүмүүс: физикч, математикч, одон орон судлаач нар нууцаар уулзаж, шашны буруу номлолын талаар ярилцдаг байжээ. Шашин «үнэн»-ийг өмчилж байгаа нь эрдэм дэлхий даяар түгэн тархахад саад болж байна гэж үзжээ. Тэгээд эрдмийн хүрээлэг үүсгэж, түүнийгээ «гэгээрсэн хүмүүс» гэж нэрлэсэн юм.» «Иллюминати гэж үү?» «Ухайс даа» гэж Ландон дэмжээд: «Европын хамгийн эрдэмт хүмүүс ... эрдмийн үнэнийг хайхын төлөө амьдралаа зориулсан хүмүүс». Колэр чимээгүй байв. «Тэгтэл Католик сүм хийд иллюминатийг ангуучилж эхэлсэн байна. Тиймээс онц нууц байж байж л тэд амгалан байж болох байв. Эрдмийн хүрээнийхний дунд цуу тархаж, иллюминати бүх Европ даяар эгнээгээ өргөжүүлж эхэлжээ. Тэдгээр эрдэмтэн Ромд байдаг Гэгээрлийн сүм гэх газар маш нууц байдалд тогтмол уулздаг байжээ.» Колэр бүгшин ханиагаад, сандал дээрээ суудлаа засан суув. «Иллюминатигийн олон гишүүн шашны худал хуурмагийн эсрэг хүч хэрэглэн тэмцье гэдэг байсан ч хамгийн эрхэм гишүүн нь тийм санааг дэмжилгүй, намжаадаг байсан юм. Тэр энхийг эрхэмлэгч, түүхэн дэх хамгийн алдартай эрдэмтэн хүн байлаа» гэж Ландон үргэлжлүүлнэ. Ландон тэр хүний нэрийг Колэр мэднэ гэдэгт огт эргэлзэхгүй байлаа. Нар дэлхийг биш, харин дэлхий нарыг тойрдог гэж нотолсныхоо төлөө шашныханд алуулчих шахсан тэр одон орончийг бүр эрдэмтэн биш эгэл хүн ч таних билээ. Нотолгоог нь няцаах арга байхгүй ч гэсэн бурхан хүнийг ертөнцийн төвд бус, өөр хаа нэгтээ аваачаад суулгачихсан гэх санаа гаргасныхаа төлөө хэрцгий эрүү шүүлт амссан нэгэн билээ. «Түүнийг Галилео Галилей гэдэг байлаа» гэж Ландон хэлэв. Колэрын нүд нь онийн «Галилей юу?» хэмээн асуув. «Тийм. Галилей иллюминтус байсан юм. Тэр мөн чин сүсэгт католик хүн байлаа. Тиймээс эрдэм бурхан байдгийг үгүйсгэдэггүй, харин ч нотолдог хэмээн тайлбарлаж эрдмийн талаарх шашныхны байр суурийг зөөллөх гэж оролдсон юм. Нэг удаа дурангаараа гариг эрхсийг харж байхад нь бурхны дуу хоолой хөгжим болон эргэлдэн сонсогдож байв гэж хүртэл бичиж байжээ. Тэр эрдэм, шашин хоёр дайсан бус, харин холбоотнууд агаад тэгш хэм, тэнцэл, тэнгэр газар, өдөр шөнө, халуун хүйтэн, бурхан чөтгөр гэх мэтийн тухай нэг л үлгэрийг өөр өөрөөр тайлбарлаж байдаг гэж нотлох гэж хичээжээ. Эрдэм, шашин хоёулаа бурхны тэгш хэмийг бишрэн, гэрэл гэгээ, харанхуй сүүдэр хоёрын эцэс төгсгөлгүй тэмцлийг дуулдаг» гэж ярихдаа Ландон хөлөө дулаацуулах гэж дороо дэвсчиж байлаа. Колэр тэргэнцэр дээрээ суугаад гөлөрнө. «Харамсалтай нь» гэж Ландон үргэлжлүүлэн «эрдэм, шашин хоёрыг зохируульа гэж сүм хийд хүсээгүй юм». «Мэдээж, тэгэхгүй л дээ» гэж Колэр Ландоны үгийг таслан өгүүлэв. «Тэр хоёр зохирчихсон бол шашин - бурханд хүрэх цор ганц зам гэдэг тэдний номлол үгүй болчих байлаа. Тиймээс шашныхан Галилеог тэрс номтон хэмээн зарлаж, буруутган, байнгын гэрийн хорионд түгжиж орхисон юм, Ландон гуай. Гэхдээ энэ бол хэд хэдэн зууны өмнө болсон явдал шүү дээ. Леонардо Ветрад ямар хамаатай юм бэ?» Сая долларын үнэтэй асуулт байна даа. Ландон цааш нь үргэлжлүүлэв. «Галилеог хорионд хиймэгц иллюминати эсэргүүцэж байж алдаа гаргаад, шашныхан дөрвөн гишүүнийг нь баривчлаад, байцаажээ. Гэхдээ тэднийг яргалсан ч гэсэн тэд юу ч хэлээгүй юм.» «Яргалсан гэнэ ээ?» Ландон толгой дохив. «Тэднийг амьдаар нь тамгалсан юм. Цээжин дээр нь

загалмай сийлчихсэн гэдэг». Колэрын нүд нь бүлтийж, Ветрагийн хүүр рүү жихүүрхэн харав. «Дараа нь тэр дөрвийг алаад Ромын гудамжинд хүүрийг нь хаяж, өөр нэгэн иллюминатид элсүүзэй хэмээн сануулга болгожээ. Шашны мөрдөлт чангармагц иллюминатигийн бусад гишүүн Италиас дүрвэн гарчээ». Ландон ингэж хэлээд зогсосхийв. Тэр Колэрын нүд рүү ширтэж байлаа. Тэгээд «иллюминати бүр ч нууцлаг болж, католик сүм хийдэд хавчигдсан алхимич, хар домч, ислам, жүүд гэх мэт бусад бүлэгтэй холилдож эхэлсэн юм. Гэхдээ жил ирэх тусам иллюминати шинэ гишүүдээр өргөжиж байлаа. Ингээд шинэ Иллюминати гарч ирсэн юм. Нүгэлт, анти-христ Иллюминати. Маш хүчтэй, тайлагдашгүй зан үйл, үхлийн нууцтай, нэг л өдөр эргэн ирж католик сүм хийдээс хонзонгоо авна хэмээн занатаг болжээ. Тэд хүчирхэгжсээр бүр католик сүм хийд тэднийг дэлхий дээрх хамгийн аюулгүй анти-христ хар хүч хэмээн нэрийдэх хэмжээнд хүрчээ. Ватикан энэ нөхөрлөлийг Шайтан гэж зарласан юм». «Шайтан аа?» «Энэ исламынх л даа. Зүгээр л «дайсан» ... бурхны дайсан гэсэн үг. Шашныхан ислам нэр томъёог заваан гэж үздэг байсан болохоор тэгж нэрлэсэн хэрэг» гэж Ландон тайлбарлаад «Шайтан гэдэг нь англи хэлээр бол Сатаан гэсэн үг л дээ». Колэр янз муутай байгааг Ландон анзаарав. Ландоны дуу чанга нот байв. «Колэр гуай, би энэ тэмдэг энэ хүний цээжинд хэрхэн, мөн яагаад тавигдсаныг үнэндээ мэдэхгүй байна. Гэхдээ та энд дэлхий дээрх хамгийн эртний, хамгийн хүчирхэг Сатаанлаг шүтлэгийн ор тас мартагдсан гэгдэж байсан тэр тэмдгийг харж байна даа» гэлээ.

Хэсэг 10

Эзгүй нарийн гудмаар хассассин хурдан гэгч алхалж, хар нүдэнд нь итгэлийн цог гэрэлтэнэ. Хүрэх газраа дөхөх тусам Янусын үгс тархинд нь ян хийтэл дахин давтан сонсогдоно. Удалгүй хоёр дахь шат эхэлнэ. Жаахан амраад ав. Хассассин мушилзав. Тэр шөнөжин унтаагүй боловч унтах тухай бодох ч үгүй байлаа. Зөвхөн дорой амьтад л унтдаг. Тэр эцэг өвгөдийнхөө адил дайчин хүн бөгөөд өвөг дээдэс нь тулаан эхэлмэгц дуусан дуустал нь унтдаггүй байлаа. Тулаан ямартай ч эхэлчихсэн, дайсны цусыг түрүүлж урсгасан гавьяа түүнийх. Эргээд ажилдаа ортол, ялалтын алдраа тэмдэглэх хоёр цагийн хугацаа түүнд байлаа. Унтах аа? Түүнээс илүү амрах сайхан арга бас бий шүү... Таашаалдаа хөтлөгдөх хэдонистик занг өвөг дээдсээсээ уламжилсан байлаа. Өвөг нь хашиш зажилж таашаал авдаг байсан бол тэр арай өөр. Түүний эр бие торниун, үхлийн машин - энэ биеэ хар тамхиар хордуулахыг тэвчдэггүй байв. Тэр тамхи мамхиас илүү таашаалтай, эрүүл сайхан зүйлд татагдана. Амсах таашаалаа төсөөлөн шүлсээ залгилсаар гудамжны үзүүр рүү яарна. Явсаар нэг хаяггүй хаалган дээр ирээд хонх цохив. Хаалганы шагайвч тас хийтэл нээгдэж, хоёр бор нүд түүнийг цоо ширтлээ. Удалгүй хаалга онгойв. «За, морил, морил!» гэж аятайхан хувцастай хүүхэн урив. Хүүхэн түүнийг гэрэл муутай даруухан тавилгатай хүлээлгийн өрөөнд орууллаа. Агаарт тансаг үнэртэн ханхална. «Бэлэн болмогцоо хэлээрэй» гээд хүүхэн фото зургийн том цомог гарт нь өглөө. «Сонгочихоод хонхоо дарж дуудаарай» гээд хүүхэн гунхалзан алга болов. Хассассин инээвхийлэн мушилзана. Өргөн буйдан дээр сууж, өвөр дээрээ цомгоо тавилаа. Өлөн араатан шиг л байв. Үндэс угсаагаараа зул сар тэмдэглэдэггүй боловч тэр өөрийгөө христ шашинт хүү бэлгээ аваад дотроос нь ямар гоё юм гарах бол хэмээн задлах гэж хөгжиж байгаа юм шиг л төсөөлнө. Цомгоо нээгээд зураг бүрийг нь сонжив. Хурьцлын садар амт амталсан нүд цомгийн зургаас түүнийг ширтэх ажээ. Мариса. Итали дагина. Халуухан. Залуухан л болохоос Софиа Лорэн л гэсэн үг. Сачико. Япон гэйша. Урин янаг. Чадварлаг гэдэг нь эргэлзээгүй. Канара. Гялалзсан хар. Шөрмөслөг. Экзотик. Тэр цомгоо хоёронтаа үзээд сонголтоо хийв. Ширээн дээрх товчоо дарлаа. Хормын дараа хаалга нээж өгсөн нөгөө хүүхэн

хүрч ирэв. Тэр хэнийг сонгосноо харуулбал хүүхэн инээмсэглээд «Дагаад яваарай» гэв. Залууг төлбөрөө хийсний дараа хүүхэн утас цохилоо. Хэсэг азнаснаа дагуулан тансаг зассан хонгил руу боржин шатаар өгсөж гараад «Үзүүрт байгаа шар хаалга» гэж зааснаа «Та ч үнэтэй сонголт хийдэг юм байна» гэв. *Тэгэх ч ёстой юм, би ч мэргэжлийн шүү* гэж бодлоо. Өлөн үчимбэр анд гэтэх шиг хассассин хонгилын үзүүр рүү сэм сэм алхана. Дөхөж очоод дотроо инээмсэглэв. Хаалганы завсраас түүнийг хуял тачаал даллана. Хаалгаа түлхэхэд аниргүйхэн онгойв. Сонгосон хүүхнээ харж, зөв шийдсэнээ мэдлээ. Яг л хүссэнээр нь ... хүүхний гарыг орны толгойноос нарийн утсаар хүлж, шалдлаад, нуруугаар нь хэвтүүлсэн байлаа. Өрөөнд орж, орны хажууд суув. Том бараан хуруугаа хүүхний ангир цагаан цээжнээс хөнгөхөн уруудуулсаар хүйсэн дээр нь зөөлөн аваачлаа. *Би урд шөнө дайснаа устгасан, харин чи миний шан!*

Хэсэг 11

Сатаанлаг гэнэ ээ!» гэж Колэр уруулаа арчин, тавгүй асуув. «Энэ тэгээд чөтгөрийн тэмдэг юм уу?» Ландон хүйтэн өрөөнд дулаацах гэж холхино. «Иллюминати сатаанлаг байсан юм. Гэхдээ энэ нь өнөөгийн утгаар биш.» Сатаанлаг гэдгийг олон хүн чөтгөрт мөргөдөг дайсан гэдэг ойлгодог, харин тэр үед сатаанлаг гэж зүгээр л шашныхныг эсэргүүцсэн нэгнийг хэлдэг байсан тухай тайлбарлав. Шайтан. Сатаанлаг хар дом, амьтнаар өргөл барих ёс, таван хошуу зэрэг бол шашныхан дайсныхаа эсрэг явуулсан цуурхал төдий зүйл. Цаг хугацаа алслах тусам шашныг эсрэг үзэлтнүүд Иллюминатийг дуурайх гэж оролдохдоо тэр цуурхлыг баримтлан дагасан байна. Ингэж л орчин үеийн Сатаанизм үүсжээ. Колэр ундуцангуй «Энэ ч яахав, эртний түүх л байна. Харин энэ тэмдэг яаж яваад энд гараад ирдэг билээ?» Ландон гүнзгий амьсгаа авлаа. «Энэ тэмдгийг арван зургадугаар зууны нэгэн Иллюминати урлаач Галилеог тэгш хэмд дуртайг нь санагалзан, нөхөрлөлийнхөө ариун тэмдэг болгон зохиосон юм. Нөхөрлөл энэ тэмдгийг нууцалсан: хангалттай хүч хуримтлуулж, газар дэлхийд дахин ил гарч, гол зорилгоо биелүүлэх цагтаа л ил гаргана гэдэг домогтой юм». Колэр бас л аягүйрхэн хараад «Тэгэхээр нөхөрлөл ил гарах цаг болсон гэдгийг энэ тэмдэг хэлж байгаа хэрэг үү?» Ландон мөрөө хавчин: «Уул нь тэгмэээргүй л юм даа. Иллюминатигийн түүхэнд миний ухаарч чадаагүй зүйл үлдээгүй гэж бодсон юм сан». Колэрын дуу эргээд чангарав. «Гэгээрүүлж хайрла, намайг!» Ландон алгаа үрж, Иллюминатигийн тухай уншсан олон зуун ном, судраа толгойдоо эмхэллээ. «Иллюминатигаас амь үлдсэн хүмүүс Ромоос оргон зайлж, Европ даяар тарж, дахин нэгдэх таатай газар орон хайн хэсүүчилсэн юм. Тэгээд бас нэг нууц нийгэмлэгтэй хамссан нь Баварийн баян чулуучдын Чөлөөт масон гэх нөхөрлөл байлаа». Колэр гайхасхийн «Масонууд уу?» гэв. Колэр энэ нөхөрлөлийн тухай сонссон байсанд Ландон нэг их гайхсангүй, толгой л дохилоо. Масон* нөхөрлөл өнөөдөр таван сая гаруй гишүүнтэй, үүнээс АНУ-д тал нь, харин нэг сая орчим нь Европт байдаг. «Гэхдээ масонууд чинь сатаанлаг биш гэдэг биз дээ?» гэж Колэр тээнэгэлзсэнгүй асуулаа. «Мэдээж үгүй. Масонууд зүгээр л сайхан сэтгэлийнхээ золиос болчихсон юм. Тэд 1700-аад оны үед хавчилтаас дүрвэсэн эрдэмтдийг орогнуулаад өөрсдөө тэднийхээ бамбай болчхож л дээ. Иллюминати зэрэг дэвийнх нь дагуу өссөөр бүр хамгийн том ложийг нь (Масон ёсны удирдах зөвлөл) хүртэл эзэлжээ. Тэгээд Масонуудын дотор өөрийнхөө бүлгэмийг байгуулж, нууц нийгэмлэг доторх нууц нийгэмлэг болжээ. Цаашлаад Иллюминати Масонуудын даян дэлхийг хамарсан сүлжээг ашиглан эрх нөлөөгөө тогтоож эхэлсэн юм.» Ландон нэг том амьсгаа аваад цааш нь үргэлжлүүлэв. «Католицизмийг үгүй хийх нь Иллюминатигийн үндсэн зорилго. Шашин бол мухар сүсгээр хүн төрөлхтнийг

хордуулж байгаа хамгийн том дайсан нь. Шашин хоосон номлолоо бодит гэж хүмүүст үнэмшүүлбэл эрдмийн дэвшил саатаж, хүн төрөлхтөн ухаан мадаггүй шашны дайнд умбах болно гэж тэд үздэг.» «Өнөөдөр яг л тэгээд байна шүү дээ». Ландон хөмсгөө өргөн гайхасхийв. Гэхдээ Колэрын зөв байлаа. Ариун дайн гэдэг сонин болгоны тэргүүн нүүрэнд тавигддаг. Миний бурхан чиний бурхнаас дээр. Итгэгчид олон болох тусам хэлмэгдэгсэд олон болно. Колэр «Цааш нь» гэв. Ландон оюунаа хөвчлөөд цааш нь үргэлжлүүлэв. «Иллюминати Европт хүчирхэгжээд, Америк руу тэлжээ. Жорж Вашингтон, Бэнжамин Франклин гээд л бүгд бурхны үнэн сүжигтэн, Масоны нөхөрлөл дотор нь Иллюминати оршиж байгааг гадарлах ч үгүй байлаа. Иллюминати нэвчих тусмаа давуулаг болж банк, их сургууль, аж үйлдвэрүүдийг туйлын зорилгоо гүйцэлдүүлэх зэвсэг, болгох гэж байгуулж байлаа» гээд Ландон зогсосхийгээд «Дэлхийн нэгдсэн нэг гүрэн - шашингүй Дэлхийн шинэ журмыг тогтоохыг оролдож байв». Колэр хөдөлсөн ч үгүй. «Дэлхийн шинэ журам» гэж Ландон давтаад «Эрдмийн гэгээрэл дээр тогтох юм. Үүнийг тэд Люциферийн номлол гэдэг. Шашныхан Люциферыг чөтгөрийн хаантай** холбодог бол Иллюминати энэ үгийг ориг Латин утгаар нь буюу гэрэл түгээгч буюу гэгээрэгч гэж тайлбарладаг». Колэр нэг санаа алдаад, гэнэт их л догь дуугаар «Ландон гуай, та сууж морил» гэв. Ландон хүйт даасан сандал дээр хөнгөн суув. Колэр тэргэнцэртэйгээ дөхөж ирээд «Би сая таны ярьсныг бүрэн ойлгосон эсэхээ мэдэхгүй байна. Леонардо Ветра бол СЭРН-ий гайхамшиг байсан хүн. Бас миний дотнын анд. Та надад Иллюминатийг олж өгч туслаач» гэв. Ландон юу гэхээ мэдсэнгүй. «Иллюминатийг олох оо? Тоглоогүй байгаа даа!» гэж бодоод «Эрхэм ээ, гэхдээ энэ боломжгүй болов уу гэж эмээнэм». Колэр хөмсгөө атируулав. «Та юу гэнэ ээ? Та...» «Колэр гуай» гэж Ландон яриаг нь таслаад хэлэх гэж байгаагаа хэрхэн ойлгуулахаа мэдэхгүй, Колэрт аминчлан ойртлоо. «Би яриагаа арай дуусгаагүй байна. Энд Иллюминатигийн тамгыг сийлчихсэн ч гэсэн Иллюминатигийнхан өөрөө сийлсэн гэж би бодохгүй байна. Сүүлийн хагас зуун жилийн турш тэд оршоор байгаа гэсэн ямар ч сэжиг, тэмдэг гараагүй тул дийлэнх эрдэмтэн Иллюминати тарж алга болоод олон жил болж байгаа гэж үздэг юм шүү дээ.» Өрөөнд чимээгүй болчхов. Колэр Ландоныг эргэлзэх, уурлах хоёрын дундуур унтууцан чимээгүй харж байснаа «Энэ хүний цээжин дээр тамгаа дарчхаад байхад та тийм хүмүүс байдаггүй юм гэж яаж хэлж байна аа?» Ландон өглөөнөөс хойш өөрөөсөө ингэж асууж байлаа. Иллюминатигийн амбиграмм тэмдэг ингэж гарч ирсэн нь тун жигтэй байв. Дэлхийн бүх бэлгэдэл судлаач ч бас л гайхах байсан биз. Гэхдээ энэ тэмдэг гарч ирсэн нь Иллюминатиг оршин буй гэдгийг шууд нот батлах зүйл бас биш билээ. Тэгээд Ландон «Тэмдэг гарч илэрлээ гэдэг чинь түүнийг эзэмшдэг этгээд оршин байгаа гэсэн үг биш шүү дээ» гэлээ. «Тэгвэл тэгээд юу гэсэн үг юм бэ?» «Энэ юу гэсэн үг вэ гэхээр энэ тэмдгийг хэрэглэдэг байсан философичдын бүлгэм тарж алга болсон ч гэсэн тэмдэг нь үлдэх агаад тэр тэмдгийг өөр хэн ч хэрэглэж болно гэсэн үг. Үүнийг трансференц буюу шилжих гэдэг юм. Бэлгэдэлд энэ их түгээмэл. Нацистууд Хинду шашнаас хас тэмдгийг шилжүүлэн авсан, харин Христ шашинтнууд Египетчүүдээс загалмайг өвлөсөн байдаг юм, мөн ...» «Өнөө өглөө ...» гэж Колэр үгийг нь таслаад «... би Иллюминати гэж бичээд интернетээр хайлт хийхэд мянга мянган шинэ мэдээ олдож байсан. Тэгэхээр маш олон хүн энэ нөхөрлөлийг оршоор байгаа гэж боддог юм билээ шүү дээ». «Цуурхал төдий юм байхгүй юу даа» гэж Ландон хариулав. Орчин үеийн поп соёлд чихэнд чийр болтол нуршдаг хэрэгтэй, хэрэггүй цуу яриа, сэжиг таамагт тэр ямагт унтууцдаг байлаа. Шар хэвлэлүүд дэлхий сөнөх гэж байгаа тухай, хоёр зууны зааг дахь сүйрлийн тухай, Иллюминати оршин тогтносоор Дэлхийн шинэ журмаа тогтоох гэж байгаа тухай шал дэмий зүйлийг өлгөж аваад л цуурдаг. Нью Йорк Таймс-ын

сүүлийн нэгэн дугаарт Артур Конан Дойл ихэмсэг, Кэнтийн бэйл, Петер Сэллерс, Ирвин Бэрлин, Филипп хунтайж, Луй Армстронг гээд л орчин үеийн нэртэй төртэй олон бизнесмен, банкны эздийг хамарсан Масоны том гэгч бүлгийг илрүүлсэн байлаа. Колэр ууртай яа Ветрагийн хүүрийг заан байж «Энэ баримтыг үндэслэвэл тэр цуурхал чинь үнэн байж магадгүй бололтой байна шүү» гэлээ. Ландон чадах ядахаараа дипломат зан гаргах гэж оролдон «Минийхээр бол, ямар нэг өөр нийгэмлэг Иллюминатигийн энэ тэмдгийг олж аваад зорилгодоо ашиглаж байна гэвэл илүү бодитой тайлбар болох болов уу» гэв. «Тэгээд ямар зорилгын төлөө тэр вэ? Энэ аллага юуг нотлох ёстой юм бэ?» *Зөв асуулт шүү* гэж Ландон бодлоо. Тэрээр хэн Иллюминатигийн энэ тэмдгийг 400 жилийн дараа олж авчхаад хэрэглэж явдаг билээ гэж гайхаад байлаа. «Иллюминати өнөө хэр оршоор байгаа гэж үзсэн ч гэсэн, гэхдээ би тэгж болохгүй байна, тэд Леонардо Ветрагийн аллагад оролцох хүмүүс биш гэж л би танд хэлмээр байна». «Юу?» «Иллюминати Христийн шашныг үгүй хийх гэж зорьдог. Зорилгоо террорист замаар бус, харин улс төр, эдийн засгийн аргаар гүйцээх гэж оролддог юм. Түүнээс гадна, тэд хэнийг дайсан гэж үзэх вэ гэсэн ёс зүйн чанга дүрэмтэй. Эрдэмтэн хүнийг их дээдэлдэг. Тиймээс Леонардо Ветра шиг ийм эрдэмтэн хүний амийг хорлох ямар ч шалтгаан байхгүй». Колэрын нүд зэвхийгээд явчхав. «Би Леонардо Ветра зүгээр нэг эрдэмтэн байгаагүй гэдгийг хэлээгүй бололтой». Ландон амьсгаа аваад их л эелдгээр «Колэр гуай, би Леонардо Ветра олон талаараа гайхалтай хүн байсныг ойлгож байна л даа, гэхдээ асуудал...» Колэр юу ч хэлэлгүй тэргэнцрээ эргүүлээд зочны өрөөнөөс гарч одов. Хүйтэн униар түүний урьд ярагдан ард нь дулаан амьсгал үлдэвч төдөлгүй хөрч замхарна. *Бурхан өршөө* гэж Ландон бувтнан босоод араас нь явлаа. Колэр үүдний жижиг гонхонд хүлээж байв. «Энэ Леонардогийн судалгаа байгаа юм» гээд Колэр гулсдаг хаалга руу зүглэв. «Та энийг харвал асуудал арай өөр болох байх». Колэр жигтэй хачин түлхэж, хаалга гулсан онгойв. Ландон тэр өрөөнд Колэртэй зэрэгцэн ороод зогтусан алмайраад «*Ээ, Есүсийг төрүүлсэн ариун эх минь ээ*» хэмээн дуу алдлаа. * Масон гэдэг нь чулуучид, барилгачдын шашинлаг нөхөрлөл юм. Хүлэг баатар-рыцарийн ордныг үлгэр болгосон, зохион байгуулалттай энэ нөхөрлөл - харц барлаг гаралтай хүмүүсийг нэгтгэж байснаараа онцлог байжээ. Харин тэр барлаг гаралтай хүмүүс олон зууны турш шургуу хөдөлмөрлөснийхөө үр дүнд, өнөөдрийн том том корпорац, эрдмийн хүрээлэн, их сургуулийг үндэслэсэн хөрөнгөлөг ангийн үндсийг тавьжээ. ** Библид өгүүлснээр Люцифер буюу Гэгээ түгээгч гэх нэртэй ангель өөрийгөө бурхан болсон мэт эндүүрэн, эл эзнийхээ эсрэг тэмцсэнд бурхан түүнийг газрын гав руу илгээж, чөтгөр болгоод нэрийг нь Сатаан хэмээн сольсон гэдэг.

Хэсэг 12

Өөр нэг улсад залуухан харуул өмнөө байгаа эрээлжилсэн олон зурагтын дэлгэцийг хянуур гэгч ажиглана. Энд тэндгүй байрлуулж хэрсэн зуу зуун камеруудаас ирүүлж буй дүрс нэг бүрийг гаргах олон дэлгэцийг ширтэнэ. Дэлгэц бүр дээр дүрс болгон солигдох нь дуусашгүй мэт. Сийлбэрт гудам. Хувийн ажлын өрөө. Үйлдвэр шиг том гал тогоо. Дүрс бүр жирэлзэн өнгөрч, харах тусам заримдаа зүүдэлж байгаа ч юм шиг санагдана. Харуул солигдох мөч дөхөж байсан ч тэр дэлгэц дэлгэц дээр гарч буй дүрс бүрийг няхуур ажиглана. Зүтгэл бол алдар. Нэг л өдөр шагналаа хүртэх нь гарцаагүй. Бодолдоо төөрөн сууж байсан түүний нүдэнд нэг дэлгэц дээрх дүрс гэнэт түгшүүр төрүүлэв. Гар нь өөрийн эрхгүй эгшин зуур

сунаж хяналтын самбар дахь товчийг дарлаа. Түгшүүр төрүүлсэн нөгөө дүрс түүний өмнө солигдолгүй зогсов. Тэр оюунаа хөвчлөн байж дэлгэцээ сайтар харах гэж тонгойлоо. Энэ дүрс гол гудмыг харуулах ёстой #86 дугаар камераас ирж байлаа. Гэхдээ тэр яавч гол гудам биш байлаа.

Хэсэг 13

Ландон судалгааны өрөөг хараад мэл гайхав. «Энэ чинь юун өрөө вэ?» Тасалгааны дулаан агаар нүүр рүү нь пүн хийтэл үлээнэ, гэхдээ тэр анзаарсан ч үгүй. Колэр дуугүй араас нь оров. Ландон өрөөг тойруулж хараад Ветра энд юу хийдэг байсныг огт ойлгосонгүй. Энд маш онцгой эд өлгийн зүйл цуглажээ. Арван зургадугаар зууны Испанийнх болов уу гэмээр аугаа том модон загалмайг өрөөний хойморт залжээ. Тэр загалмайн дээрээс нарны аймгийн гариг эрхсийг тойрог замтай нь дүрсэлсэн автоматаар эргэдэг болов уу гэмээр зүйлийг таазнаас өлгөсөн байв. Зүүн талд Онгон Мариагийн тосон будгаар зурсан хөрөг, хажууд нь гялгар цаасаар бүрсэн Менделеевийн үелэх систем өлгөжээ. Эсрэг талын хананд хүрэл загалмайг Альберт Эйнштейний хөрөгтэй хамт өлгөөд хажууд нь Эйнштейний хамгийн алдарт үгийг БУРХАН ШОО ОРХИЖ ХОРВООТОЙ НААДДАГГҮЙ ЮМ гэж томоор бичжээ. Ландон өрөөнд ороод, орчноо мэлрэн харна. Ветрагийн ширээн дээр ширэн хавгастай Библи, атомын бүтцийг үзүүлсэн Борын хуванцар загвар, Мекланжелогийн барьсан Мошагийн баримлын жижиг хуулбар байв. Эклектицизм хэмээн Ландон шивнэв. Тасалгааны дулаан агаар нэн таатай, гэхдээ өрөөний засал жихүүцэм ажээ. Философийн хоёр урсгалын мөргөлдөөн, эсрэг хүчний уусал мэдрэгдэнэ. Тавиур байгаа номын нэрийг зэрвэс гарчиглав. *Бурханлаг бөөмс. Физикийн Даосизм. Бурхан: Гэрчлэл* Нэг номын сүүлд нь Жинхэнэ ЭРДЭМ гэдэг энд тэндгүй Бурхан байгааг л ухаарч нээдэг -ХИ ПИЮС ПАП гэсэн ишлэл хавчуулжээ. «Леонардо католик гэлэн байсан юм» гэж Колэр хэллээ. Ландон эргэж хараад «Гэлэн аа? Та чинь түүнийг физикч байсан гээгүй билүү?» «Физикч ч байсан, гэлэн ч байсан юм. Түүхэнд шашин, эрдэм хоёрыг хосолсон хүн байгаагүй л дээ. Гэхдээ л Леонардо тийм хүн байсан. Физикийг «Бурхны тогтоосон ертөнцийн жам» гэдэг байлаа. Хүрээлэн буй бүх юмс үзэгдэл, жам ёс бол бурхны бүтээл, ур юм гэдэг сэн. Бурхан байдаг гэдгийг мунхаг олонд эрдмийн замаар таниулж, нотолж болно гэж боддог байсан юм. Тэгээд өөрийгөө тео-физикч гэдэг байлаа, зайлуул.» *Тео - физикч ээ?* Тео (бурхан), физик гэдэг хоёр үг яавч нийцтэй сонсогдохгүй байлаа. «Эгэл бөөмсийн физик саяхан нэг аугаа нээлт хийсэн юм. Гэхдээ үр дагавар нь шашинд тун нөлөөтэй. Леонардо үүнд их үүрэг гүйцэтгэсэн юм л даа» гэж Колэр хэллээ. Ландон СЭРН-ий захирлыг гайхан ажиж, энд байгаа зүйлсийн учрыг олох гэж хичээнэ. «Сүсэг, физик хоёр уу?» Ландон шашны түүхийг судалсан бүх амьдралынхаа туршид огт нийцгүй хоёр зүйл аль вэ гэвэл шашин, эрдэм хоёр гэдэг байлаа. Энэ хоёр бүр анхнаасаа л ус тос хоёр шиг хэзээ ч холилдоогүй эд байв. Колэр өгүүллрүүн: «Ветра эгэл бөөмсийн физикийг шинэ шатанд гаргах гэж байлаа. Тэр эрдэм, шашин хоёр тун санамсаргүй байдлаар холбогддог, хоорондоо нийцтэй гэдгийг батлах гэж байсан юм. Үүнийгээ *Шинэ физик* гэж хүртэл нэрлээд амжсан байсан юм» гэлээ. Колэр тавиур дээрээс нэг ном аваад Ландонд өгөв. Хавтсыг нь харвал «Бурхан, Гайхамшиг, Шинэ физик, зохиогч Леонардо Ветра» гэсэн байв. Колэр цааш нь «Энэ шинэ салбар болохоор одоохондоо хүрээ нь их бага. Гэхдээ орчлонгийн үүсэл, бид бүхнийг холбож байдаг хүчийн талаар жигтэй шинэ хариулт өгсөн юм. Леонардо судалгаагаа олон сая хүнийг сүсэгтэй болгож чадна гэж найдаж байсан сан. Өнгөрсөн жил бид бүхнийг нэгтгэдэг эрчим хүч гэж байдгийг зарчмын хувьд шууд нотолсон юм. Тэгээд бид бүгд бие махбодоороо холбоотой... таны биед байгаа молекул миний биед байгаа молекултой

харилцан ихэрлэсэн байдаг., тиймээс бид бүхний дунд нэг том хүч гүйж байдаг гэж л баталсан юм шүү дээ.» Ландоны бодол нь төөрчихсөн байв. *Бурхны хүч биднийг нэгтгэнэ.* «Ветра гуай тэр эгэл бөөмсүүдийн холбоог нотлох аргаа олсон юм уу, тэгээд?» «Бүр мөсөн нотолсон юм. Эрдмийн америк сэтгүүлд бүр шинэ физик бол шашнаас илүү бурханд хүрэх найдвартай гарц мөн гэж хүртэл бичсэн юм даа». Колэрын ярьсан учиртай байв. Ландон дандаа Иллюминатийг шашны эсрэг гэдэг талаас нь бодоод байдаг байснаа гэнэт ухаарав. Одоо л тэр боломжгүй зүйл бодитой байж болохыг тун оюунлаг байдлаар нотолсныг зөвшөөрөх хэрэгтэй боллоо. Хэрэв Иллюминати идэвхтэй хэвээр байсан сан бол энэ шашинлаг санааг олонд түгээхийг зогсоох гэж Леонардог алах байсан уу? Ландон энэ бодлоо өөрөө сэгсрээд хаячхав. *Иллюминати бол хуучны түүх! Бүх эрдэмтэн мэднэ шүү дээ!* «Эрдмийн хүрээлэлдээ Ветра олон дайсантай байсан» гэж Колэр үргэлжлүүлэн «Олон эрдэмтэн түүнийг үгүйсгэдэг байлаа. Бүр СЭРН дотор шүү дээ. Аналитик физик ашиглан шашны зарчмыг нотолно гэдэг эрдмээс урвасан хэрэг гэж хүртэл үздэг юм даа». «Гэхдээ өнөөгийн эрдэмтэд шашнаас тийм их айдаг гэж үү?» Колэр тээршаангуй яраглаад: «Яагаад үгүй гэж? Шашин эрдэмтдийг амьдаар нь тарчлаахаа больсон байж магадгүй. Гэхдээ зайгаа тавьж өгөөгүй л байна. Яагаад танай дунд сургуульд хувьслын онолыг зааж болдоггүй юм бэ? Яагаад АНУ-ын Христийн эвсэл дэлхий нийтийн эрдмийн дэвшилд гай болж, лобби хийгээд байгаа юм бэ? Шашин, эрдэм хоёрын дайн одоо ч үргэлжилсээр байна, эрхэм ээ. Тулаан дайны талбараас удирдах зөвлөлийн ширээ рүү шилжсэн, дайсагнал хэвээрээ л байгаа». Колэрын зөв байлаа. Харвардын Ариун номын сургуулийнхан Биологийн факультетын байрны өмнө жагсаал хийж магистрантур, докторантурын хөтөлбөрт генийн инженерчлэл багтаж байгааг эсэргүүцсэн удаатай. Тэгэхэд нь, Биологийн факультетын декан нэрт орнитологч Ричард Аарониан эгдүүцсэндээ том гэгч далбаа цонхноосоо өлгөж жагсагчдыг угтсан байлаа. Далбаан дээр христ загасны хэлбэрийг өөрчлөн Африкийн уушгит загас болгож доор нь дөрвөн жижиг хөл зурсан байв. Энэ загас анх удаа хуурай газарт дасан зохицсон амьтны хувьд хувьслын онолыг бүхэлд нь төлөөлж чадна гэж Аарониан үзжээ. Дотор нь Есүс гэдэг үгийн оронд Дарвин гэж бичсэн байлаа.



Гэнэт чанга гэгч час хийсэн дохио хадлаа. Колэр тэргэнцрийнхээ гар руу хажуулдасхийн

тонгойж сандлынхаа гарны цахим удирдлагын тагийг гулсуулан нээж, шинэхэн мэдээг уншлаа. «Леонардогийн охин нь ирчихжээ. Ветра авхай буудлын тойрог дээр яг одоо газардаж байна. Хоёулаа тийшээ очиж, угтъя. Тэр ийшээ ирээд аавыгаа ийм байдалтай байгааг харах хэрэггүй биз» гэлээ. Ландон зөвшөөрөв. Үр хүүхдэд нь ийм юм үзүүлшгүй билээ. «Би Ветра авхайгаас аавтайгаа хамт ажиллаж байсан төслийн талаар ярьж өгөөч гэж гуйя... тэгвэл яагаад алагдсан нь тодорхой болж магадгүй.» «Та Ветраг ажиллаж байсан төслөөсөө болж алагдсан гэж бодоо юу?» «Тун магадгүй. Леонардо нэг жигтэй зүйл дээр ажиллаж байгаа гэж хэлсэн юм. Өөр юм хэлээгүй. Тэгээд лабораториосоо ч гарахгүй, төслөө нуугаад байсан. Тэр тусдаа, нууцхан газар хувь лабораторитой: би гайхалтай хүн болохоор нь дургүйцэлгүй гаргаж өгсөн юм. Сүүлийн үед лаборатори нь асар их эрчим хүч хэрэглэх болсон. Би итгэдэг, хүндэлдэг болохоороо юу хийгээд байгааг нь асуугаагүй л дээ» гээд Колэр тэргэнцрээ эргүүлэн үүд рүү чиглэв. «Эндээс гарахын өмнө би танд бас нэг юм хэлье.» Ландон юу хэлэх гэж байгаа, тэр хэлэх гэж байгааг нь сонсвол дээр үү, үгүй юу гэдгийг мэдэхгүй байв. «Ветраг алсан хүн нэг юм хулгайлсан байна лээ». «Юуг тэр вэ?» «Нааш ир дээ». Захирал гуай нөгөө униар татсан хүйтэн өрөөнд ороод алга болов. Ландонд араас нь дагахаас өөр арга байсангүй. Колэр Ветрагийн хүүрийн яг дэргэд нь очиж зогсоод Ландоныг хүрээд ир гэлээ. Ландон түүний дэргэд ихрүүдэхийн очиход хамар сад тавьтал хөлдүү шээс үнэртэж байв. «Нүүрийг нь хар даа». *Нүүрийг нь харах аа?* Ландон зэвхий даав.

Та нэг юмыг нь хулгайлчихсан байсан гээ биз дээ. Ландон дурамжхан сөхөрч суулаа. Тэгээд Ветрагийн нүүрийг дарах гэж тонгойсон ч хүзүүг нь нуга дараад 180 хэм эргүүлчихсэн тул нүүр нь хивс рүү ***** байв. Тахир дутуу Колэр зүтгэсээр байгаад доошоо болж Ветрагийн хөлдүү толгойг эргүүллээ. Хугарсан хүзүү хярхийн дуугаран нүүрийг нь харуулахад бузар улай гэгч тэр байлаа. Колэр нүүрийг нь Ландонд түр харуулаад буцааж тавив. «Ээ, Ариун Есүс минь» гэж Ландон агзаганан дуу алдаад арагш ухасхийж лаг хийтэл суун тусав. Ветрагийн нүүр нэлдээ цусанд будагджээ. Ганц үхмэл нүд л гөлөрнө. Нөгөө нүднийх нь ухархай хоосон онгойж харлана. «Нүдийг нь ухаад аваад явчихсан юм уу?» гэлээ.

Хэсэг 14

Ландон Ветрагийнхыг орхин С байрнаас задгай агаарт гарч ирэхэд дотор арай жаахан уужрав. Гэрэлт наран нүдийг нь ухсан хоосон ухархайн тухай бодлоос түүнийг салгалаа. «Ийшээ морил!» хэмээн Колэр хэлээд шулуун зам руу эргэлээ. Цахим тэргэнцэр яах ийхийн зуургүй хурдлав. «Ветра авхай айсуй яваа шүү». Ландон араас нь даган жирийв. Колэр: «Та тэгээд Иллюминати оролцсон гэдэгт эргэлзсээр л байна уу?» Ландон юу бодохоо мэдэхгүй байв. Ветрагийн шашинлаг байдал мэдээж сэжигтэй гэхдээ л олон жил хийсэн эрдмийн ажлынхаа дүгнэлтийг зүгээр л ингээд хаячхаж чадахгүй байлаа. Түүнээс гадна, бас нүд ... «Би Иллюминати энэ аллагад буруугүй л гэж бодоод байна» хэмээн Ландон урьдынхаасаа ч бат нот өгүүлээд «Тэр алга болсон нүд батална» гэлээ. «Юу?» «Иллюминати зүгээр л нэг хүн эрэмдэглээд явдаггүй юм» гэж Ландон хэлээд «Шүтлэг судлаачид туршлага муутай этгээдүүд хөөрөлд авган санамсаргүй террорист аллага хийдэг гэдэг, гэхдээ Иллюминати илүү догь хүмүүс байдаг юм шүү». «Догь гэнэ ээ? Хүний нүдний алимыг мэс заслын нарийвчлалтай ухааж авах чинь догь биш байгаа нь тэр үү?» «Гэхдээ тэглээ гээд ямар ч утгагүй байна шүү дээ. Ямар ч ариун дээд зорилго агуулаагүй.» Колэр тэргэнцрээ толгодын дээр зогсоогоод эргэж харан: «Ландон гуай! Тэр алга болсон нүдийг үнэхээр ариун дээд зорилгод, бүр ариунаас ариун дээд зорилгод хэрэглэх байх шүү» гэлээ. Тэр хоёрыг ногоон толгод руу өгсөн гарч ирэх үед өрнө зүгээс нисдэг тэрэг хүржингнэн, сэнсээрээ салхи зүсэн нүргэлэх чимээ улам чангарна. Удалгүй бараа нь тодорч, наашаагаа айсуй. Тэгээд хурдаа хасан хассаар зүлгэн дээр будаж тэмдэглэсэн буудлын тойргийн дээр ирээд дүүжигнэв. Ландоны оюун бодол нэг л бүүдийгээд, нисдэг тэрэгний сэнс хүржигнэх хэмнэлээр бүрэлзэж байв. «Бүтэн нойртой хоносон бол ингэхгүй байх байсан болов уу? Үгүй л байх даа» гэж бодно. Нисдэг тэрэгний цан газар шүргэмэгц нисэгч үсэрч буугаад ачаагаа буулгаж эхлэв. Баг, нойтон резин цүнх, хүчилтөрөгчийн баллон, өндөр технологийн шумбах хэрэгсэл бололтой олон зүйлсийг буулгаж байна. Ландон гайхасхийн «Эд нар чинь тэгээд Ветра авхайн багажууд уу?» гэж сэнсний хүржигнэх чимээг давах гэж байдгаараа хашхирлаа. Колэр толгойгоо дохиод «Baliatic тэнгист судалгаа хийж байсан юм аа» гэж хариу хашхирлаа. «Та чинь түүнийг физикч гээ биз дээ?» «Тэгсэн. Bio Entanglement Physicist юм аа. Амьд системийн харилцан уялдааг судалдаг гэх үү дээ. Ажил нь аавынх нь хийж байсан эгэл бөөмсийн физикийн судалгаатай тун нягт холбоотой байдаг юм. Тэр саяхан сүрэг туна загасыг автоматаар синхронжуулсан камераар ажиглаж байгаад Эйнштейний нэг суурь онолыг няцаасан юм даа.» Ландон түүний царайг ажвал тоглоом шоглоом хийсэн нэг ч атугай шинж олж харсангүй. *Эйнштейн, туна загас гэнэ үү? Х-33 гэгч тэр онгоц намайг ер нь өөр гариг дээр авчирчхаагүй байгаа? Удалгүй Виттория Ветра нисдэг тэрэгний бүхээгээс гарч ирлээ. Роберт Ландон өнөөдөр гайхаад дуусахгүй гэдгээ ойлгов. Бор шарга шорттой, ханцуйгүй цамц өмссөн Виттория нисдэг тэрэгнээс үсрэн бууж байхыг харвал ном тэвэрсэн унжгар физикч*

хүүхэн гэж төсөөлж байснаас нь шал өөр байлаа. Тэр самар шиг хүрэн бор арьстай, өндөр шаавай бүсгүй байв. Үс нь нисдэг тэрэгний сэнсний салхинд нүүр рүү нь намирна. Яах аргагүй Итали төрхтэй царай нь хөөрхөн гэхээргүй ч аятайхан, хөрслөг эрэмгий төрхтэй ажээ. Салхи бүрэн товчилсон хувцсыг нь биед нь чивчиртэл наан үлээхэд хувцасных нь цаанаас жижиг хөх, эвлэг цээж нь тодорч байлаа. Ландон эмэгтэйг хараад нүд алдсаныг мэдсэн юм шиг «Ветра авхай хүчтэй бүсгүй дээ» гэж Колэр хэлээд «Тэр экологийн аюултай орчинд олон сараар ажилладаг юм, бас ч үгүй манай энд СЭРН-д хатха иогийн багш гэж байгаа.» *Хатха иог гэнэ ээ.* Католик гэлэнийн физикч охинд Буддын сунгалтын дасгалтай бясалгал нэг л эрээвэр хураавар санагдана. Витториа ирж явааг Ландон харлаа. Их уйлж, нүд нь бүлцийжээ. Гүн цэнхэр нүдэнд хурсан гуниг гоо үзэсгэлэнд нь нэг л зохимжгүй харагдана. Гэхдээ цоглог, шийдэмгий алхлан тэдэн рүү ойртож байлаа. Гар хөл нь урт, хүчтэй агаад Газар дундын тэнгисийн наранд дандаа шарагдаж байсан бололтой хөрслөг байлаа. Колэр өөдөөс нь «Витториа» гэсээр дөхөж очив. «Эмгэнэлтэй еэ, хөөрхий. Эрдэмд ... энд СЭРН-д байгаа бүхэнд том гарз гарлаа». Витториа талархан толгой дохив. Тэгээд хүнгэнэсэн жигд хоолойгоороо «Хэн ингэснийг нь та мэдэж амжив уу?» хэмээн англи хэлээр жаахан харь аялгатай хэлэв. «Бид оролдож л байна». Тэр эргэж хараад Ландон руу нарийхан гараа сунган «Намайг Витториа Ветра гэдэг. Та, бодвол, Интерполынх уу?» Ландон гарыг нь атгаснаа түгдчин байж «Роберт Ландон» гэлээ. Өөр юу гэхээ мэдэхгүй байв. «Ландон гуай албаны хүн биш ээ. Тэр АНУ-аас ирсэн шинжээч. Энэ явдалд хэн буруутайг тогтооход туслах гэж байгаа юм» гэж Колэр дундуур нь орж тайлбарлалаа. Витториа гайхасхийн «Тэгээд цагдаагийнхан ..?» Колэр санаа алдаад юм хэлсэнгүй. «Хүүр нь хаана байна?» гэж эмэгтэй чангахан асуув. «Тэнд хүн байгаа.» Колэр Витториаг хуурч байгаад Ландон гайхна. «Би хармаар байна» «Витториа» гэж Ландон арцан «Эцгийг тань харахын эцэсгүй аймшигтай хөнөөжээ. Та түүнийг ямар байсан, түүгээр нь санаж явсан нь дээр биз дээ.» Витториа юм хэлэх гэтэл дундуур нь таслав. «Хүүе, Витториа ! Гэртээ тавтай морил» гэж алсаас дуудав. Эргэж харвал нисэх буудлын тойргийн хажуугаар явсан хэсэг эрдэмтэн түүн рүү даллан инээгээд өнгөрөв. «Эйнштэйний дахиад нэг онолыг няцаагаад ирэв үү?» гэж нэг нь хашхирлаа. Нэг нь бүр «Аав чинь ч баярлана даа» гэлээ. Витториа тэдэн рүү хааш яаш даллаад Колэр рүү эргэж харахад нүд нь гайхаж цөхөрсөн харцтай байв. «Хэн ч мэдээгүй байгаа юм уу?» «Би чанд нууцлахыг эрхэмлэсэн юм». «Та аавыг маань алуулчхаад байхад хэнд ч хэлээгүй байгаа хэрэг үү?» гэж Витториа ууртай яа хэлэв. Колэрын дуу ч мөн чангараад явчихлаа. «Ветра авхай, та мартаагүй сэн бол би энэ хэргийн талаар мэдээлмэгц энд СЭРН-д мөрдөлт явагдана. Тэгээд танай лабораторийг ч нэгд нэгэнгүй нэгжинэ. Би аавын чинь хувь нууцыг ямагт эрхэмлэж ирсэн. Аав чинь ажиллаж байгаа төслийнхөө тухай надад хоёр л зүйл цухуйлгасан. Нэгд, түүний төсөл СЭРН-д дараагийн арван жилд сая сая франкийн төсөл авчирч магадгүй гэж, хоёрт, одоохондоо энэ технологи эрсдэлтэй байгаа болохоор нийтэд мэдээлж арай болохгүй байгаа гэж. Тэгж хэлснийг нь бодохоор гаднын хүмүүс танай лабораториор хэсээд танай ажлыг хулгайлах ч юм уу, эсвэл тавьтаргүйтэж байгаад үхэж орхивол СЭРН л хариуцлага хүлээж үлдэнэ шүү дээ. Ойлгов уу, намайг?» Витториа юу ч хэлж чадахгүй мэлэрдэ. Колэрын хэлсэн хүйтэн боловч үнэн байлаа Колэр цааш нь «Албаны хүмүүст мэдэгдэхийнхээ өмнө би та хоёр юун дээр ажиллаж байсныг мэдмээр байна. Та биднийг лаборатори руугаа аваачина уу». «Лаборитор хамаагүй ээ» гэж Витториа хэлээд «Аав бид хоёр юу хийж байсныг хэн ч мэдэхгүй. Туршилт маань аавын үхэлд ямар ч хамаагүй». Колэр их л зовуурилан чичирч амьсгаа аваад «Гэхдээ баримт үгүй гээд байна». «Баримт аа? Ямар баримт?» Ландон бас гайхаж орхив. Колэр амаа арчаад «Та надад зүгээр л итгэ» гэлээ. Витториагийн харцыг ажвал

итгэхгүй байгаа нь илт байв.

Хэсэг 15

Ландон - Витториа, Колэр хоёрын араас түүний анх ирсэн шилэн дуганы зүг чимээгүйхэн алхаж явлаа. Витториагийн хөл төрөлхийн уян төдийгүй хатха иогоор хичээллэдэг болохоор олимпын аварга шиг л шуурхай алхалж байв. Ландон гүн гүнзгий харууслыг нь сонсох гэсэн шиг бүсгүйн жигд, аяархан амьсгалахыг чагнаж байлаа. Ландон сэтгэлийг нь засах аятайхан юм хэлмээр л байв. Тэр ч мөн тун санаандгүй эцгээ алджээ. Аавыгаа оршуулсан тэр өдөр бороотой, бүрхэг саарал өдөр байв. Арван хоёр насных нь төрсөн өдрөөс хойш хоёр хоног өнгөрчээ. Гарыг нь өвдтөл хүчтэй атгасан саарал хувцастай албаны хүмүүс гэрт нь пиг дүүрсэн байлаа. Тэд *зүрхний, стресс* гэж л бувтнана. Ээж нь нулимстай нүдээр харж аавынх нь гарыг атгангаа судасны цохилтыг нь тоолоход биржийн мэдээг бүхэлд нь хянаж чаддаг байсан юм гэж тоглоом шоглоом хийж байжээ. Аав нь амьд байх үед нэг удаа ээж нь аавд нь «Зогсоод, сарнай үнэрлэ л дээ» гэж гуйхыг сонсож билээ. Тэр жил Ландон хүрэн өнгөтэй шилэн сарнай авч аавдаа зул сарын баяраар бэлэглэжээ. Нарны туяа тэр сарнай дээр тусаад солонгорон ойх нь Ландонд энэ насандаа үзсэн хамгийн гоё зүйл шиг санагддаг байв. Тэгэхэд аав нь Ландоны духан дээр үнсэж «Гоё юм аа» гэж билээ. «Хаана тавьчихвал аятайхан байх бол?» гээд аав нь зочны өрөөний хамгийн харанхуй буланд тоосонд дарагдсан тавиур дээр тавьсан сан. Хэдэн өдрийн дараа Ландон сандал дээр гараад сарнайгаа аваад дэлгүүрт нь буцааж өгчээ. Харин аав нь үүнийг анзаараагүй юм даг. Цахилгаан шатны дуу Ландоныг бодлоос нь салгав. Витториа, Колэр хоёр урагш алхаж цахилгаан шат руу орлоо. Ландон орох эсэхээ мэдэлгүй зогтусжээ. «Яасан?» гэж Колэр гайхахаасаа илүү адгаж асуув. «Зүгээр» гэж Ландон хэлээд цахилгаан шатны сараалжин бүхээгт орлоо. Битүү юмнаас эвгүйдэг зангаараа тэр цахилгаан шатанд суудаггүй, харин саруул уужим болохоор нь шатаар өгсөхийг илүүд таашаадаг байв. «Ветра докторын лаборатори газар доор байдаг юм» гэж Колэр тайлбарлав. «Гайхалтай» гэж Ландон бодон шатны бүхээгт орвол, шатны хонгилоос зэврүүн салхи үлээнэ. Хаалга хаагдан, шат бууж эхэллээ. «Зургаан давхарт» гэж Колэр яг л механик юм шиг өгүүлэв. Ландоны нүдэнд доор нь байгаа гүнзгий хонгил төсөөлөгдөөд аягүй байв. Тэгэхээр нь явж байгаа давхрынхаа тоог илтгэдэг шатны самбар руу харж сатаарахыг бодлоо. Гэтэл тэнд ердөө хоёрхон давхрыг тэмдэглэсэн байв. **ГАЗРЫН ТӨВШИН, АХАБ.** «Энэ АХАБ гэж юу гэсэн үг юм бэ?» гэж Ландон сандарснаа мэдэгдэхгүйг хичээн асуув. «Аварга Хадрон Бутлуур» гэж Колэр хэлээд «бөөмсийн хурдасгуур» гэж тайлбарлалаа. Бөөмсийн хурдасгуур? Ландон энэ тухай сонсож байсан санагдана. Кембрижийн Данстер хауст ажлынхаа хэдтэй оройн зоог барьж байхдаа энэ тухай анх сонсжээ. Тэдний физикч найз Боб Браунэл нэг орой тэр тухай ярьж байлаа. «Новшнууд цуцалж орхилоо» гэж Браунэл хараав. «Юуг тэр вэ?» гэж бүгд гайхлаа. «ССБ-г» «Юуг гэнэ ээ?» «Супердамжуулагч Супер Бутлуур!» Нэг нь мөрөө хавчаад «Харвард тийм юм барьж байгаа гэж дуулаагүй л юм байна» гэв. «Харвард биш ээ» гэж тэр өгүүлээд «АНУ! Уул нь дэлхийн хамгийн хүчтэй бөөмсийн хурдасгуур болох байсан юм! Энэ зууны хамгийн чухал эрдмийн төсөл! Хоёр тэр бум доллар хэрэгтэй байсан чинь Сенат баталсангүй. Чөтгөрийн библи шүтсэн лоббичид гэж». Браунэл тайвшраад бөөмсийн хурдасгуур гэдэг нь атомоос жижиг бөөмсийг хурдасгадаг тойрог хэлбэртэй урт том хоолой юм гэж тайлбарлажээ.

Соронзон орныг байн байн эгшин зуур асааж унтраамагц бөөмс тойрон эргэлдэж эргэлдэж асар их хурд авдаг байна. Бүрэн хурдассан бөөмс секундэд 180 000 бээрийн хурдтай хоолойгоор эргэлддэг байна. «Энэ чинь бараг л гэрлийн хурд байна шүү дээ» гэж нэг профессор хэлэхэд «Тийм шүү, чөтгөр гэж» гэж Браунэл хэлээд цааш нь тайлбарлав. Хоёр бөөмсийг эсрэг чиглэлд хурдасган мөргөлдүүлбэл бөөмс бутарч байгалийн хамгийн жижиг бүтцийг олж нээж болох байлаа. «Бөөмсийн хурдасгуур эрдмийн дэвшилд зайлшгүй хэрэгтэй. Бөөмсийг мөргөлдүүлж хорвоо ертөнц тогтсон хамгийн жижиг зүйлийг судлах боломжтой болох юм.» Харвардад Байнга оршин суугаа шүлэгч гэх Чарльз Прагт нэг их гайхширсангүй. «Балар эртний бүдүүлэг арга шиг сонсогдож байна шүү. Цаг дотор юу байгааг харах гэж юм мөргүүлж эвдээд задлах гэж байгаа юм шиг». Броунэл уурлаад сэрээгээ ширээ рүү шидчихээд шууран гарч одож билээ. *Тэгэхээр СЭРН бөөмсийн хурдасгууртай байх нь ээ?* гэж Ландон бодож зогстол цахилгаан шат түгхийн зогсов. *Бөөмсийг мөргөлдүүлж бутаргадаг тойрог хоолой.* Тэгээд энийгээ яагаад газар дор барьсан юм бол гэж бодогдоно. Цахилгаан шат зогсмогц Ландонд унаж байгаа юм шиг санагдахаа больж, хөл доороо бат бөх газар таатай яа мэдрэв. Гэвч хаалга онгоймогц таатай байдал ор мөргүй алга болов. Түүнд дахиад л шал өөр ертөнцөд байгаа юм шиг санагдаад явчихлаа. Урт гэгч гудам хоолой даган баруун зүүн хоёр тийшээ үзүүр нь харагдахгүй сунаж оджээ. Арван найман хасаг тэрэг өлхөн багтахуйц том, толигор цементэн хонгил байлаа. Тэдний зогсож байсан газар арай цагаан гэгээтэй, харин хоёр тал руугаа цаашлах тусам хав харанхуйлна. Алс харанхуйгаас зэврүүн салхи үлээж, газрын гүнд байгааг нь зэвүүн сануулна. Ландон толгой дээрээ байгаа шороо чулууны хүнд жинг мэдрэх шиг болов. Есөн настайдаа осолд орж, түнэр харанхуйд өөрийн эрхгүй сорогдон орсон эвгүй дурсамж одоо ч байнга санагдана. Алгаа хавсран нуга хийлгээд тэр бодлоо зайлуулах гэж оролдлоо. Витториа аягүйцсэн шинжгүй цахилгаан шатнаас гарч тэднийг ч хүлээлгүй харанхуй руу ганцаараа алхлав. Дээр нь флуоресцент цэгээн гэгээ анивчин асч замыг нь гэрэлтүүллээ. Хонгил Витториагийн алхааг хараад байгаа юм шиг л дагаж гэрэлтэнэ. Ландон, Колэр хоёр араас нь зайдуухан дагалаа. Гэрэл тэдний яг ард автоматаар унтарна. «Тэр бөөмсийн хурдасгуур чинь» гэж Ландон Колэр рүү тонгойж «Энэ хавьд байгаа юу?» гэж шивнэн асуув. Колэр зүүншээ зааж хонгилын дагуу татаж өнгөлсөн хромон хоолой руу дохиод «Тэр байна» гэв. Ландон тэр хоолойг хараад «Нөгөө хурдасгуур чинь тэгээд энэ юм уу?» хэмээн мэл гайхав. Тэр хоолой түүний төсөөлж байснаас шал өөр юм байлаа. Шув шулуун тэр хоолой диаметрээрээ гурван тохой орчим, хонгилыг эмжин сунаж, үзүүр нь харанхуй руу харваж одсон байлаа. *Өндөр технологийн сантехникийн хоолой шиг л юм* гэж Ландон хошигнон бодов. «Би бөөмсийн хурдасгуур гэдэг чинь тойрог хэлбэртэй байдаг гэж бодсон юм сан.» «Энэ чинь тойрог шүү дээ» гэж Колэр хэлээд «Энэ шулуун санагдаад байгаа бол оптик иллюзи. Хонгилын тойргийн диаметр асар их, тиймээс мурийлт нь мэдрэгдэхгүй байгаа юм. Яг л дэлхийн бөмбөрцөг шиг» хэмээн тайлбарлав Ландон мэл гайхаж, цэл хөхрөв. *Энэ чинь тэгээд тойрог юм уу?* «Тэгвэл энэ чинь аймаар том эд байх нь ээ?» Ландоныг хүргэж ирсэн жолооч газар доор байдаг аугаа том машины тухай ярьж байсныг гэнэт санав. Гэхдээ л... «Энэ хонгилын диаметр найм гаруй километр, уртаашаа хорин долоон километр». Ландонд төсөөлшгүй санагдана. «Хорин долоон километр!» Тэр Колэр рүү нэг хараад, урдаа төгсгөлгүй мэт үргэлжлэх урт хонгил руу нэг харав. «Энэ хонгил хорин долоон километр урт гэж үү? Энэ чинь бараг л арван зургаан бээр шүү дээ» Колэр зөвшөөрөнгүй дохив. «Бүтэн тойрог гэж байгаа. Тойргийн урд үзүүр нь бараг л Франц хүрээд эргэдэг юм. Гүйцэд хурдасгасан бөөмс мөргөлдөхийнхөө өмнө энэ хоолойг нэг секундэд арван мянган удаа тойрно.» Ландон доошоогоо хонгилын шатыг харав. Алмайж гиюүрсэн

түүний хөл резин шиг гуйвсхийв. «Та тэгээд СЭРН өчүүхэн бичил бөөмсийг мөргөлдүүлэх гэж сая сая тонн шороо ухсан гээд байгаа юм уу?» Колэр мөрөө хавчаад «Үнэнийг хайхын тулд заримдаа уулыг ч эргүүлэх хэрэгтэй болно шүү дээ» гэв.

Хэсэг 16

СЭРН-ээс зуу зуун бээрийн холд гар холбоо шажигнах чимээ сонстов. «За, за би нөгөө гудманд ирчихлээ». Видео дэлгэцийг хянаж байсан техникч дамжуулагчийнхаа товчийг дарав. «Чи #86 камерыг хай даа. Уул нь наад гудмын чинь цаад буланд байх ёстой юм». Гар холбоо нэлээн удаан чимээгүй болчхов. Эцэст нь холбоо дахин шажигналаа. «Тэнд чинь камер байхгүй байна шүү дээ» гэлээ. «Гэхдээ хаа нэг газар асаалттай л байна даа. Нэг нь наадахыг чинь өөр газар тавьхаж дээ». Техникч хүндээр амьсгаа аваад «Баярлалаа. Түр хүлээгээрэй, тэгэх үү?» Тэр санаа алдаад хяналтын олон дэлгэц рүүгээ эргэж ширтэв. Энэ байгууламжийн дийлэнх хэсэг нийтэд ил байдаг ажээ. Өмнө нь дурсгал болгож авах гэсэн жуулчид нэг бус удаа камерыг нь аваад явчихдаг байлаа. Байгууламжийн хананаас дөнгөж гармагц, долгион барих зайнаас холдож, дэлгэц шууд унтардаг байв. Гайхширсан техникч дэмий л дэлгэц рүү ширтэнэ. #86 камераас ирүүлж буй тов тод дүрс өмнө жирэлзэх ч үгүй гарна. *Тэр камер алдагдсан юм бол яагаад дүрс дамжуулсан хэвээр байгаа юм бол гэж мэлийн сууна. Мэдээж үүнд ганцхан л хариулт байлаа. Тэр камер байгууламж дотор байж байгаа, харин нэг хүн түүнийг мулталж аваад өөр газар тавьжээ. Гэхдээ хэн яах гэж тэгээ вэ?* Тэр дэлгэж рүү их л хянуур харлаа. Тэгээд гар холбоогоо шүүрч «Тэр гудманд чинь шүүгээ ч юм уу, нэг тиймэрхүү зүйл байна уу? Тавиур юм уу, эсвэл харанхуй булан ч юм уу?» Цаад хүн нь учраа олохгүй байгаа бололтой «Үгүй, яасан?» гэв. Техникч барайсан хэвээрээ: «За, за, зүгээр, гялайлаа» гэлээ. Гар холбоогоо унтраагаад, хөмхийгөө зуун бодлогоширно. Жижиг оврын, бас тэгээд утасгүй болохоор #86 камер хагас бээрийн радиустай гучин хоёр байшин, эргэн тойрон зүү орох зайгүй хамгаалсан энэ цогцолборын аль ч хэсэгт байж болох ажээ. Тэр камер харанхуй газар байгаа гэдэг нь л ойлгомжтой байв. Гэхдээ энд харанхуй газар үй олон бий: хувцасны агуулах, дулааны шугам, цэцэрлэгийн зоорь, унтлагын өрөөний шүүгээ, тэр бүү хэл газар доорх сүлжилдсэн хонгил хүртэл бий. Тэгэхээр #86-г хайх гэж бүтэн долоо хоног гаруй болно. *Гэхдээ энэ ч бас асуудал биш байна аа гэж техникч бодов.* Тэр камерыг хаана байгааг нь олохоос илүү том аягүй асуудал бас байв. Алга болсон камерын дамжуулж байгаа дүрсийг анхааралтай ажвал ямар нэг суурин объект байх. Бас өмнө нь хэзээ ч харж байгаагүй орчин үеийн хийцтэй төхөөрөмж байв. Сууринд нь цахим дэлгэц анивчина. Онцгой дарамттай нөхцөлд ажиллах дасгал зөндөө хийсэн ч харуулын даралт нь ихсээд ирэв. Сандрах хэрэггүй гэж өөртөө шивнэнэ. Ямар нэг тайлбар байж л таарна. Объект ноцтой аюул учруулж чадахааргүй жижиг ч гэсэн тийм юм байгаа нь өөрөө түгшүүртэй байв. *Тун түгшүүртэй. Очиж очиж өнөөдөр шүү гэж бодно.* Дарга нь аюулгүй байдал бол хамгийн чухал зүйл гэж ямагт үзсээр ирсэн агаад өнөөдөр сүүлийн арван хоёр жил өнгөрөөсөн бүх өдрөөс бүр ч илүү чухал байлаа. Техникч тэр зүйл рүү удаан ширтсэний эцэст аажимдаа үнэхээр түгшиж эхлэв. Тэгээд дарга руугаа утастлаа.

Хэсэг 17

Тийм ч олон хүүхэд аавтайгаа анх хэрхэн учирснаа санадаггүй байх, харин Витториа тод санадаг ажээ. Тэр аав ээжийгээ огт мэдэхгүй, найман настайдаа Флоренцын хажууханд орших Orfanotrofito di Siena (ита. Сиенагийн өнчин хүүхдийн асрах газар) хэмээн католик асрамжийн газар суудаг байв. Тэр өдөр бороо орж байлаа. Асрагч эх нь оройн хоолоо ид гэж

хоёр удаа дуудав. Витториа зөрүүдэлж, хашаандаа хэвтгээд, борооны дусал бие дээр нь унахыг мэдэрч, дараагийнх нь хаана унах бол хэмээн бодсоор, бөнжигнөн орох усан дуслыг ширтэж байлаа. Асрагч эх ахин дуудаад, ийм анзааргагүй бол орчин тойрондоо анхаарал тавьдаггүй зөрүүд хүүхэд болно шүү гэв. «Чамайг сонсохгүй байна аа» хэмээн Витториа дотроо хэрэлдэнэ. Хаалга онгойн, асрагч эх нь биш, харин нэг залуухан гэлэн гараад ирлээ. Танихгүй шинэ хүн байв. Намайг дотогшоо оруулах байх даа гэж Витториа төвөгшөөнө. Гэтэл тэр тэгсэнгүй, тэр бүү хэл, хувцсаа норгон байж хажууд нь ирээд хэвтчихэв. Тэр: «Чамайг олон юм асуудаг гэгцгээх юм» гэлээ. Витториа хөмсгөө зангидан: «Юм асууж болдоггүй юм уу?» гэв. Тэр хүн хөхрөөд: «Хөөх, тэд үнэн хэлсэн байна шүү» гэв. «Та энд юу хийж байгаа юм бэ?» «Чамтай л адил ... дээшээ харж хэвтгээд бороон дусал яагаад доошоо унадаг юм бол гэж гайхаад л сууж байна». «Би гайхаагүй ээ... яагаад унадгийг нь мэдэх юм чинь». Гэлэн их гайхсан байдалтай хараад: «Чи юу?» гэв. «Франсиска эгч: борооны дусал бидний нүглийг ариусгах гэсэн ангелийн нулимс байгаа юм, гэсэн». Гэлэн: «Аа, тийм үү?» гэж гайхан өгүүлэв. «Ийм учиртай юм бий вий?» «Үгүй шүү» гэж охин эрс хэлээд: «Юм болгон доошоогоо унадаг болохоор л бороон дусал бас доошоогоо унадаг юм. Бүх юм унадаг! Ганц бороо ч биш» гэв. Гэлэн толгойгоо маажгаад: «Залуу авхай минь, чиний зөв шүү. Бүх юм унадаг. Энэ чинь дэлхийн татах хүч байхгүй юу». «Юу гэнэ ээ?» Гэлэн охин руу гайхан харлаа. «Чи *дэлхийн татах хүч* гэж сонсоогүй юм уу?» «Үгүй». Гэлэн санаагаар унасан байдалтай мөрөө хавчив. «Муу л байна. Дэлхийн татах хүч гэдэг олон асуултад хариулт өгдөг юм.» Витториа өндийж суугаад: «Тэр татах хүч гэдэг чинь тэггээд юу юм бэ? Хэлээд өг л дөө» гэв. Гэлэн нэг хөмсгөө өргөн охиныг дүрлийн харснаа: «Хоёулаа хоолоо идэж байхдаа чамд ярьж өгөх үү?» гэлээ. Тэр залуу гэлэн Леонардо Ветра байлаа. Их сургуульд байхдаа физикийн аварга оюутан байсан ч зүрх сэтгэлээ чагнан сүмд очдог байв. Леонардо, Витториа хоёр ганц биеэр туулах ёстой сүмийн амьдралд зохихгүй хүмүүс байлаа. Витториа түүнийг инээлгэж, харин Леонардо охиныг нөмөртөө авч: гол мөрөн, солонго борооны тухай өөр өөр сонин хачин тайлбар байдгийг ярьж өгдөг байжээ. Гэрэл, гариг эрхэс, од гээд л байгаль бүхэлдээ бурхны хийгээд эрдмийн нүдээр хэрхэн харагддагийг бяцхан охинд таниулжээ. Витториа хурц оюун, дуусашгүй дур сонирхолтой болохоороо сайн ч сурчээ. Леонардо түүнийг охин шигээ хайрладаг байв. Витториад ч бас сайхан байлаа. Аавтай байхын жаргалыг өмнө нь хэзээ ч амсаагүй билээ. Бүх хүн асуултад нь хэг ёг гээд л хариулчихдаг бол Леонардо түүнд ном үзүүлэн, олон цагаар ярилцан суудаг байв. Бүр Витториаг юу гэж бодож байгааг нь асуудаг байлаа. Леонардо дандаа надтай хамт байгаасай гэж Витториа залбирдаг байжээ. Нэг л өдөр, түүнд хамгийн аймаар санагдсан явдал болов. Леонардо гэлэн асрах газраас явах болжээ. «Би Швейцар явлаа» гэж Леонардо хэлээд: «Тэнд Женевийн их сургуульд физик судлах төсөл авсан юм» гэж хэлэв. «Физик үү?» гэж Витториа дуу алдаад: «Би таныг бурханд зүтгэдэг гэж бодсон шүү дээ». «Тэгэлгүй яах вэ. Тийм л болохоороо би түүний бүтээсэн ариун тогтцыг судлах гэж байгаа юм шүү дээ. Физикийн хууль гэдэг чинь бурхны урласан гайхамшигт бүтээлийн зотон даавууных нь нэхээс байхгүй юу.» Витториа гэлэнг ийм юм ярихад нь жаахан гайхаж, хамгийн гол нь түүний явах гэж байгаад их л гомдонгуй байв. Тэр мөчид Леонардо бас өөр нэг мэдээ дуулгав. Дээд дарга нартайгаа яриад, хэрэв охиныг зөвшөөрвөл Леонардо үрчилж авч болно гэсэн хариу авчээ. «Би чамайг өргөөд авчих уу?» гэж Леонардо асуув. «Өргөж авах гэж юу гэсэн үг вэ?» гэж Витториа хариу асуужээ. Леонардо тайлбарлаж өглөө. Витториа түүн рүү учир зүггүй гүйн очиж хүзүүдэж аваад: «Тэгэлгүй яах вэ, тэгэлгүй яах вэ дээ, аав минь» хэмээн шивнэхэд, хоолой нь зангиран, баярын нулимс дусалж билээ. Леонардо одоо яваад, Швейцарт шинэ орон гэрээ төвхнүүлээд,

зургаан сарын дотор охиноо эргээд авна аа гэж амлажээ. Харин энэ зургаан сар - Витториагийн хамгийн удаан хүлээлт байлаа. Эцсийн эцэст, Леонардо амалсандаа хүрч, Витториа есөн нас хүрэхэд тав хоног дутуу байхдаа Женев рүү нүүжээ. Тэр Женевийн олон улсын сургуульд өдөртөө сурч, оройдоо харин ааваасаа суралцдаг байлаа. Гурван жилийн дараа, Леонардо Ветра СЭРН-д ажиллах болж, тэр хоёр дахиад л нүүжээ. Гэхдээ шинэ нутаг нь жаахан охинд гайхалтай таалагдав. Түүний хэзээ ч төсөөлж байгаагүй тийм сайхан газар байлаа. Витториа хонгилоор алхаж явахдаа өөрийгөө хий үзэгдэл болчих юм шиг санана. Сүүмэлзэх сүүдэр нь харанхуй дунд чимээгүй дагаж, аав чинь үгүй болсон шүү гэж үглэн сануулах шиг. Уул нь энэ хонгил гэр шиг нь танил дотно, дотуур нь чөлөөтэй, амгалан алхалдаг байлаа. Харин одоо хүнийрхүү хөндий, үхмэл зэврүүн болжээ. Гурван цагийн өмнө аавыгаа өнгөрснийг сонссоноос хойш энэ хорвоод цор ганцаараа үлдсэнээ мэдмэгц, бүх юм өнгөө алдаад, нэг л жихүүн санагдана. Колэрыг утастахад Балеарийн тэнгист өглөө 10 цаг болж байлаа. *Аавыг чинь алчихлаа. Түргэн хүрээд ир.* Шумбагчийн төмөр гадарга наранд халаад байсан ч, энэ үгийг сонсоод, Витториагийн голоор хүйт дааж, зүрх нь зогсох шиг болов. Колэрын сэтгэл хөдлөлгүй хөндий дуу хоолой, дуулгасан мэдээ шигээ хүйтэн зэвүүн байжээ. Одоо тэр гэртээ ирчихсэн байв. Гэхдээ хэний гэр билээ? Бүр арван хоёртойгоосоо СЭРН-ийг гэрээ гэж бодох болсон ч өнөөдөр бүх юм гэнэт харь хөндий болчхов. Гэрийг нь гэр болгож байсан аав нь халин оджээ. *Гүнзгий амьсгал* гэж өөртөө давтан давтан хэлсэн ч тайтгарч чадахгүй байв. Баахан асуулт толгойд нь эргэлдэнэ. Хэн аавыг минь алчхав? Яах гэж ингэв? Энэ америк «мэргэжилтэн» гээд байгаа хүн ер нь хэн юм бэ? Колэр яагаад лабораторийг нь үзэх гээд зүтгээд байна вэ? Аавыг маань бид хоёрын ажиллаж байсан төслөөс болж алсан байж магадгүй баримт бий гэж Колэр хэлсэн. *Тэр нь юу юм бол? Бид хоёр юун дээр ажиллаж байгааг хэн ч мэдээгүй шүү дээ. Мэдсэн ч гэсэн түүнээс болж аавыг алах ямар ч учир байхгүйсэн.* ЛНС-ын хонгилоор лаборатори руугаа алхаж явахдаа, Витториа аавыгаа эзгүйд аавынхаа нээсэн хамгийн том нээлтийг задлах гэж байгаагаа гэнэт ухаарав. Ингэж нээх эгшинг тэр их л өөрөөр төсөөлдөг байсан сан. Аав нь СЭРН-ийн толгой судлаачдыг лабориторьтоо урьж, хийсэн ажлаа танилцуулан гайхуулж, ангайж мэлэрсэн царайг нь харна даа гэж тэр боддог байжээ. Тэгээд аав нь эцэг хүний ёсоор охиноороо бахархан, нээлтээ бодит байдал болгох явдал Витториагийн санаа байсныг тайлбарлан, охин нь энэ аугаа нээлтийн нэг чухал хэсэг байсныг хүмүүст их л хөөр бахтай дуулгаж, талархах байсан биз... Витториагийн хоолой нь зангирав. *Нээлтээ зарлах энэ эгшинд аав бид хоёр хамт байх ёстой байсан юм.* Гэвч одоо ганцаараа. Хэн ч байхгүй. Нэг ч баяр бахтай царай үгүй. Нэг хачин америк залуу, Максимилиан Колэр хоёр. *Максимилиан Колэр. Хан!* Витториа хүүхэд байхаасаа л энэ хүнд дургүй байлаа. Хожим түүний сүрхий чадалтайг нь хүндэтгэх болсон ч зэвхий чөтгөр шиг хүйтэн царай нь аавынх нь элгэмсэг дулаан байдлаас шал ондоо санагддаг байсан. Колэр эрдмийг хүйтэн логик гэж хардаг бол аав нь гайхамшиг гэж үздэг байв. Тэгээд бүр гайхалтай нь, эсрэг тэсрэг зан авиртай энэ хоёр хүн бие биеэ дуугүйхэн боловч их л хүндлэх бөлгөө. *Суутнууд нэг нь нөгөөгөө ямар ч болзолгүй хүндэлдэг* гэлцдэг. *Суутан ... Аав минь, үгүй болчих гэж!* Леонардо Ветрагийн лаборторьт орох үүд маш урт, ариутгасан, бүхэлд нь цагаан шохойгоор зассан гудам байлаа. Ландонд газар доорх хоргодох байр руу орж яваа юм шиг солиотой санагдаж байв. Тэр гудмын хананд хар цагаанаар зурсан дүрс жаазанд хийж өлгөжээ. Ландон дүрс судлалаар ажиллаж байсан ч тийм дүрс огт хараагүй байлаа. Зүгээр л зураас, спиралийн замбараагүй эрээлэл гэлтэй. *Модерн урлаг?* *Жак Поллок амфетамин хүртэж солиорчхоод, зурсан юм байлгүй.* «Няцарсан мөр» гэж Витториа, Ландоны бодлыг унших мэт тайлбарлав. «Эгэл бөөмс мөргөлдөн няцрах явцыг

компьютероор хянаж, зурсан юм. Энэ нь Z бөөмсийнх» гээд алмайрсан хүнд ажиглагдахгүй шахам бүрхэг дүрсийг заан хэлэв. «Аав таван жилийн өмнө энийг нээсэн юм. Цэвэр энерги-ямар ч массгүй. Ертөнцийг үүсгэсэн хамгийн жижиг нэгж байж магадгүй дээ, энэ. Матери бол түгжигдмэл энерги шүү дээ, өөр юу ч биш.» *Матери энерги гэж үү? Зэн буддизм шиг л сонсогдож байна шүү* гэж Ландон болов. Тэр, ханан дээрх жижиг зурааснуудыг харангаа хагас, бүтэн сайны турш бөөмсийн хурдасгуур дотор, Z бөөмсийн няцарсан мөрийг харж суулаа гэвэл Харвардын физикийн факультетын найзууд нь юу гэх бол гэж бодлоо. Лабораторийн ган хаалга руу дөхөх зуур Колэр: «Витториа! Би аавыг чинь хайж өнөө өглөө энд ирснээ чамд дуулгах хэрэгтэй байх» гэлээ. Витториа гайхан: «Та юу?» гэв. «Тийм ээ. Тэгээд танай аав СЭРН-ийн аюулгүйн стандарт түлхүүрийг өөр юмаар сольчихсон байхаар нь гайхаж орхисон шүү» гээд Колэр хаалганы хажууд байгаа цахим зүйл рүү заав. Витториа: «Өршөөгөөрэй! Гэхдээ та түүнийг ажлаа ямар их нууцалдаг байсныг мэднэ шүү дээ. Ийшээ зөвхөн аав бид хоёр л орж гарч байгаасай тэр хүссэн юм.» Колэр зөвшөөнгүй: «Тийм дээ. За, за, хаалгаа нээ!» гэв. Витториа, нэлээн хэдэн хором зогсож байснаа, гүн амьсгаа аваад хананд суулгасан тэр механизм руу очлоо. Ландон юу болох, яах ийхээ ч мэдэхгүй алмайна. Витториа багаж руу дөхөж очоод, дуран мэт линзтэй зүйлийн харалдаа эгцлэн, баруун нүдээ байрлуулан, тонгойв. Тэгснээ, нэг товч дарлаа. Тэр механизм дотор нэг юм жиг гэж дуугарав. Зурвас улаан гэрэл гарч, дээш доош гүйн, Витториагийн нүдийг яг л канон шиг сканердав. «Ретина скайн» гэж Витториа тайлбарлаад: «Найдвартай баталгаа даа. Ретина дүрсээр таньдаг юм. Аав бид хоёрынхыг л гэсэн шүү дээ». Ландон сая л ухаарч хиртхийв. Леонардо Ветрагийн там болсон хүүр нүднийх нь өмнө нэгд нэгэнгүй харагдлаа. Цусанд будагдсан нүүр, гөлийн ширтэх ганц үхмэл нүд, нүдний онгорхой ухархай. Үгүй байлгүй дээ гэж бодсон ч тэр механизмын чанх доор, цагаан шохойгоор будсан шалан дээр гарсан хар толбыг харахад итгэхээс өөр аргагүй! Цусны хатсан толбо байлаа. Аз болж, Витториа анзаарсангүй. Төмөр хаалга гулсан онгойж, хүүхэн ч ороод явчихлаа. Колэр хүрч ирээд, толбо харж гөлөрсөн Ландоны харцны өмнүүр сүүтгэнэн, нүд рүү нь харж дохив. *Тэр алга болсон нүдийг үнэхээр ариун дээд зорилгод, бүр ариунаас ариун дээд зорилгод хэрэглэх байх шүү.*

Хэсэг 18

Хүүхний гар нь хүлээстэй, тийчилснээсээ болоод бугуй нь хөхөрчээ. Саарал арьстай хассассин хүүхний дэргэд хэвтэн шан харамжаа авсан хүний нүдээр таатай яа харна. Тэр үнэхээр өвдөөд ингээд байгаа юм уу, эсвэл өөрт нь дургүйцэхдээ ингээд маяглаад байгаа юм уу хэмээн бодно. За тэгээд, яасан ч ямар хамаатай юм бэ. Сайхан л таашаал авлаа. Бие сэтгэл нь цадсан тэр, орон дээрээ өндийн суулаа. Түүний эх оронд эмэгтэй хүн бол өмч байдаг. Сул дорой. Наадан цэнгэх хэрэгсэл. Тэднийг адуу мал шиг л наймаалцана. Тэд ч хэрээ мэднэ. Гэхдээ энд, Европт эмэгтэйчүүд хүчтэй, бие даасан байдаг нь гайхалтай. Тэр муу сайн хүүхнүүдийг эр биеэрээ бахтай яа эдлэн эрэлхэхсэн. Бэлгийн зөнгөө цатгасан түүнд, удалгүй өөр нэгэн дур тачаал нь оргилон ирэхийг мэдрэв. Урд шөнө хүн алсан, алахаар барахгүй бахтай сайхан тарчлаасан..., алан хядах дон гэдэг яг л мансуурах дон шиг шүтэлдэг бөгөөд нэг аллагаас таашаал аван мансуураад, мансууралдаа цадаад хэсэг хугацааны дараа дахин тачаадаж, хүн алж таашаал хүртэхгүй бол байж суухын эцэсгүй болно. Өмнөх аллагын таашаал шингэж, шинэ аллагаар өлсөж эхлэв. Хажуудаа унтаа хүүхнийг эргэж харав.

Хүчирхэг гараа хүүхний хүзүүнээс нь доошлуулан халуун биеийг нь илэх агшинд амийг нь эгшин зуур тасалж орхих дадал сэрэл нь хөдөлж эхэллээ. Хүний оронцог! Таашаал авах хэрэгсэл төдий! Том хүнд савраа хүүхний хоолойн дээр тавихад, судасных нь эрүүл жигд хэмнэл мэдрэгдэнэ. Тэр гэнэт тачаалаа хураан, гараа татав. Ард бас ажил байна. Тачаалаас илүү ариун дээд үйлс хүлээж байна. Орноосоо үсрэн босмогцоо, өмнөө байгаа даалгаврыг гүйцэтгэвэл дуурсах алдрынхаа тухай бодолхийлэв. Янус гэх тэр эр, түүний толгойлсон нөхөрлөлийн сүр нөлөөг тэр өнөө хэр хэмжээлж чадахгүй байлаа. Энэ нөхөрлөл чухам түүнийг олж сонгосон. Тэд ямар нэг аргаар түүний ур чадварыг олж мэдээд, үнэлж дагуулжээ. Яаж гэдгийг нь хэн ч мэдэхгүй. Тэдний эрх сүр ч хэтийдсэн юм аа. Өнөөдөр нөхөрлөл түүнд нэр төрийн хэрэг даалгажээ. Тэр нөхөрлөлийнхөө гар хөл, дуу хоолой нь боллоо. Тэдний цэрэг, тэдний элч. Ийм хүндтэй хүнийг хүн зон нь Malk al-haq - Үнэний ангель гэдэг.

Хэсэг 19

Ветрагийн лаборатори ирээдүйн зөгнөл болсон эд байв. Гялбам цагаан ханатай, бүх талдаа төрөл бүрийн компьютер, цахим төхөөрөмжөөр битүү тоногдсон, яг л цахим удирдлагын өрөө шиг ажээ. Хүний нүдийг ухаж аваад нэвтэрч ормоор ямар сүрхий нууц энэ өрөөнд байдаг юм бол хэмээн Ландон бодож зогсов. Колэрын нүд ийш тийш түгшүүртэй еэ гөлөн гөлөн хийж, алуурчин орж ирсэн ямар нэг шинж байх вий хэмээн дотор нь байгаа юм болгоныг их л хянуур харж байв. Лаборатори хоосон байв. Аав нь байхгүй болохоор танихгүй газар болчихсон юм шиг Виттория ч бас удаан, зөөлөн хөдөлж байлаа. Ландоны нүд өрөөний голд босгосон намхан баганууд дээр өөрийн эрхгүй тусав. Стоунхэнжийн чулуу шиг арван хоёр орчим өнгөлсөн төмөр багана өрөөний дунд хэсэгт байлаа. Тэдгээр багана гурван тохой орчим өндөр, асар өндөр үнэтэй үнэт чулуун гоёл тавьдаг музейн үзмэр шиг харагдана. Гэхдээ тэр багануудад ямар ч үнэт чулуу байсангүй, харин ч теннисний бөмбөгний сав шиг өргөнтэй тунгалаг канистер байх агаад дотроо хов хоосон бололтой байлаа. Колэр толгойд нь эргэлдэх асуудалд хариулт өгчхөөр ямар нэг сэжим хайсан бололтой, тэр канистеруудыг хянуур ажиглаад, юм олсонгүй бололтой орхив. Тэгээд Витториад хандан: «Ямар нэг юм алга болоогүй биз?» гэж асуулаа. «Алга болох оо? Яаж?» «Ретина скайныг зөвхөн бид хоёр л оруулна шүү дээ» гэж Виттория арцав. «Зүгээр л юм хумаа нэг бүртгээдэх дээ». Виттория санаа алдаад, орчин тойрноо хэсэг зуур гүйлгэн харлаа. Тэгснээ мөрөө хавчив. «Бүх юм л байрандаа байх шиг байна. Аав юмаа нэг иймэрхүү байдалтай л орхидог юм. Цэгцтэй хаос гэх үү дээ». Колэр, Витториад хэр их юм хэлэх вэ, яажшуухан аль болох их юм яриулчих билээ гэж цэгнэж суугааг Ландон ажиглав. Тэгээд одоохондоо юм хэлээд хэрэггүй гэж бодсон бололтой. Тэргэнцрээ эргүүлэн, өрөөний төвд байгаа хуванцар багана руу очоод ажиглан зогсов. Тэгээд: «Нууц гэдгийг баттай хадгалах аргагүй болжээ» гэлээ. Виттория зөвшөөнгүй толгой дохьсноо, гэнэт нэг таагүй юм санасан бололтой сэтгэл нь ихэд хөдлөх шиг болоод явчхав. *Виттория одоо л юм хэлэх нь дээ* гэж Ландон бодлоо. Гэвч тэр яг л юм хэлэх гэж байснаа гараараа нүүрээ даран гүн амьсгаа аваад чимээгүй болов. Дахиад хоёронтаа удаан гэгч гүн амьсгаа авлаа... Ландон түүнийг харж зогссоноо гэнэт санаа нь зовж эхлэв. Тэр гайгүй байгаа даа? Тэгээд Колэр рүү харвал гайхсан шинжгүй байх, Витториаг ингэхийг өмнө нь харж байсан бололтой ажээ. Арваад секундйн дараа Виттория нүдээ нээв. Виттория тэгж өөрчлөгдөнө чинээ Ландон санаагүй болохоор бүр мэлэрч орхилоо. Уруул нь суларч, мөр нь унжаад, нүд нь зөөлөрчээ. Тэр цөхрөнгөө бараад, уй гашуугаа дараад, бүх оюун санаа, булчин шөрмөсөө сулласан мэт. Гал цог, уур хилэн нь сэтгэлийнх нь алс хол мухар руу алга

болсон байв. «Хаанаас эхэлж ярьдаг билээ дээ?» гэж түүнийг хэлэхэд, дуу нь цаашаагаа ороод, харь аялга нь улам ч тод болжээ. «Бүр эхнээс нь» гэж Колэр шавдуулан: «Аав чинь ямар туршилт хийж байсан юм бэ?» гэв. «Эрдмийг шашны үүднээс засварлана гэдэг аавын маань энэ насны мөрөөс байсан юм» гэж Виттория хэлээд: «Шашин, эрдэм хоёр харилцан нийцтэй бөгөөд нэг үнэнийг олох гэсэн хоёр өөр зам юм хэмээн үздэг байсан юм» гэлээ. Тэгснээ дуугаа түр хураахыг харвал хэлэх гэж байгаа зүйлдээ өөрөө ч итгэх эсэхээ мэдэхгүй байгаа бололтой. «Тэгээд саяхан аав тэгж батлах аргаа олсон юм» гэлээ. Колэр юм хэлсэнгүй. «Шашин, эрдэм хоёрын хамгийн халуун маргааныг нэг тийш нь болгож магадгүй гэсэн нэг туршилтыг тэр бодож олсон юм». Ландон ямар маргааныг тэр вэ гэж гайхаж байв. Тийм маргаан үй олон билээ. «Бүтээлийн тухай» гэж Виттория хэлээд: «Ертөнц хэрхэн бий болсон тухай маргаан» гэлээ. *Өөх, нөгөө алдарт маргаан!* гэж Ландон бодно. Виттория: «Библийн ёсоор бол бурхан ертөнцийг бүтээжээ. Бурхан: «Гэрэл бий бол» гэмэгц бидний харж байгаа бүх юм оргүй хоосноос бий болжээ гэдэг. Гэтэл физикийн хамгийн суурь онолд, матери оргүй хоосноос үүсэж болохгүй гэдэг.» Ландон өмнө нь энэ тухай сонсож байлаа. Бурхан «хов хоосноос юм бий болгосон» тухай санаа орчин үеийн физикийн хуультай зөрчилддөг, тиймээс физикчид Библи судрын Үүтгэл (Genesis) бүлгийг хоосон домог гэлцдэг. «Ландон гуай» гэж Виттория хандан: «Та их тэсрэлтийн онолыг мэдэх үү?» гэв. Ландон мөрөө хавчаад: «Бага сага гадарлана» гэлээ. Их тэсрэлтийн онол бол эрдэмтдийн дунд хамгийн их зөвшөөрөгдсөн ертөнцийн үүслийн тухай эрдмийн тайлбар загвар юм. Яагаад гэдгийг нь Ландон сайн ойлгодоггүй боловч хэт их энерги хуралдсан нэг цэг аймшигтай яа тэсэрч орчлонг үүсгэн, тэлж байгаа гэдэг. Нэг иймэрхүү юмны тухай онол билээ. «Католик сүм хийд Их тэсрэлтийн онолыг 1927 онд гаргаж тавихад...» гэж Витторияг үргэлжлүүлэв. «Уучлаарай!» гэж Ландон өөрөө ч мэдэлгүй үгийг нь таслаад: «Та Их тэсрэлтийн онолыг Католик сүм хийд гаргасан гэгчхэв үү дээ?» гэж асуув. Асуултыг нь сонсоод, Виттория гайхсан байдалтай түүн рүү мэлрэв. «Тэгсэн. Жорж Лемэтрэ гэдэг католик лам 1927 онд гаргасан юм». «Гэхдээ... юу л даа. Харвардын одон оронч Эдвин Хаббл Их тэсрэлтийн онолыг гаргасан гэж сонссон юм л даа» гэж Ландон хэллээ. Колэр ундууцангуй: «Бас л эрдмийн тухай америк хийрхэл. Хаббл хоёр жилийн дараа 1929 онд анх энэ тухай нийтэлсэн юм» гэлээ. Ландон зөрж: *Сансрын дуранг хүртэл Хаббл телескоп гэж нэрлээд байгаа шүү дээ, Лемэтрэ дуран гэж л лав сонсогдоогүй юм байна* хэмээн бодолдоо арцав. «Колэр гуайн зөв шүү!» гэж Виттория хэлээд: «Их тэсрэлтийн онол - Лемэтрэгийн санаа байсан юм. Харин Хаббл зүгээр л нотолгоо цуглуулж, энэ онолыг шинжлэх ухааны хувьд баталж болохыг харуулсан юм» гэв. «Аа, зөв, зөв» гэж Ландон хэлээд, Харвардын Одон орны факультетынхан, Хабблыг шүтэгсэд лекцдээ Лемэтрэгийн нэрийг дурсдаг эсэхт эргэлзэж суув. «Лемэтрэг анх Их тэсрэлтийн онолыг гаргаж байхад, эрдэмтэд шоолж байсан юм» гэж Виттория үргэлжлүүлэв. «Матерь оргүй хоосноос үүсэх боломжгүй. Хаббл Их тэсрэлтийн онол үнэн гэдгийг эрдмийн зүгээс нотлоход, католик шашин ялалт байгуулсан мэт эрэмшиж, тэр нотолгоог нь Библи эрдмийн хувьд үнэн гэдгийн нотолгоо мөн хэмээн тайлбарласан юм. Ариун үнэн гэж». Ландон тэр ярианд хамаг анхаарлаа хандуулан, толгой дохиж суув. «Мэдээж, эрдэмтэд яалаа гэж судалгааных нь үр дүнг сүм хийд шашныхаа зорилгод ашиглаад байхыг зүгээр харж суух вэ дээ. Тэгээд, тэд Их тэсрэлтийн онолыг дор нь математикчилж, шашны өнгөтэй бүх тайлбарыг нь авч хаяад, эрдэм шинжилгээний нээлт гэж сурталчилсан юм. Харамсалтай нь, тэр тэнцэтгэлд нь нэг ноцтой дутагдал байдаг, шашныхан тэр дутагдлыг нь дандаа хөндөж байдаг юм.» Колэр хоолойгоо засаад: «Сингуляр» гэв. Яг л ялын тогтоол сонсож байгаа юм шиг, тэр үгийг их л аягүйцэн хэлэв. Виттория тосч аваад: «Яг зөв.

Сингуляр. Тэсрэлт гарсан тэр эгшин. Цаг хугацааны эхлэл болсон тэг цагийн тухай юм» гэв. Тэгээд, Ландон руу хандан үргэлжлүүлэв. «Өнөөг хүртэл эрдэмтэд тэг цагийг тодорхойлж чадаагүй. Математик загвар манай нэлээн эртний ертөнцийн тухай алдаагүй гэмээр тайлбарладаг ч тэг цаг руу дөхөх тусам бүх тэгшитгэл задарч, бүх утга нь алга болчихдог.» «Тийм шүү» гэж их л хахир зэвүүнээр Колэр зөвшөөрөв. «Тэр дутагдлыг бурхан оршин, гайхамшиг бүтээсэн мөч гэхээс өөрөөр тачлбарлах аргагүй гэж шашныхан хэлдэг. Одоо, гол асуудалдаа ор доо!» «Аав бурхныг Их тэсрэлтийн онолд холбогдоно гэдэгт бат итгэдэг байсан. Эрдэм ертөнцийг үүтгэсэн тэр эгшинг ухаарч чадахгүй байгаа ч нэг л өдөр үүнийг нотлох болно гэж боддог байсан юм.» Виттория аавынхаа ажлын байрны хавьд өлгөсөн, лазер принтерээр хэвлэсэн тэмдэглэлийн хуудсыг эмгэнэн заагаад: «Намайг эргэлзэх тоолонд, тэр миний эргэлзээг хийсгэж орхидог байлаа» гэв. Ландон тэмдэглэл дээр бичснийг уншив.

ЭРДЭМ, ШАШИН ХОЁР ЭСРЭГ ХҮЧ БИШ. ЭРДЭМ, ЗҮГЭЭР Л, ЮМНЫ УЧИР ОЛОХ БОЛООГҮЙ БАЛЧИР БАЙГАА ЮМ. «Аав эрдмийг - бурхныг нотлох хэмжээнд, илүү өндөр хөгжүүлэх гэж зорьж байсан юм» гэж Виттория хэлэв. Тэгээд гараараа үсээ илэн санаашрав. «Тэр өмнө нь ямар ч эрдэмтэн зориглож байгаагүй зүйл хийхээр шийдсэн юм. Хэн ч ашиглаж байгаагүй технологи-оор хийхийг зориглосон юм.» Хэсэг дуугаа хураав. Дараагийнхаа үгийг цэнэж байгаа бололтой. «Тэр Үүтгэл үнэн байсныг нотлох туршилт хийсэн юм». *Үүтгэл үнэн гэж нотлох оо?* Ландон мэл гайхаж, цэл хөхрөв. *Гэрэл гарга? Оргүй хоосноос матери үүсэв?* Колэрын үхээнц нүд сааралтан эргэлдээд :«Уучлаарай, та юу гэв ээ?» гэв. «Аав оргүй хоосноос... ертөнцийг үүсгэсэн юм». Колэр толгойгоо гилжийлгэн: «Юу ... уу?» гэж дахин лавлав. «Тэр Их тэсрэлтийг дахин бүтээсэн юм». Колэр хөл дээрээ босоод зогсчих вий дээ гэлтэй гайхан харж байлаа. Ландоны толгой нь эргээд, бодол нь төөрч орхив. *Ертөнцийг бүтээх ээ? Их тэсрэлтийг бүтээх ээ?* «Мэдээж тун бичил хэмжээтэйг шүү дээ» гэж Виттория засав. Яриа нь алгуур түргэсч эхэллээ. «Процесс нь бол тун энгийн. Хоёр ультра-нимгэн бөөмсийг хурдасгуурын хоолой дотор эсрэг чигт хурдасгасан юм. Хоёр бөөмс асар хурдтай мөргөлдөж хоёр талын эрчинд бүх энерги нь нэг цэгт хуралдана. Ингэж энергийн хэт нягтралыг бий болгосон юм.» Тэр баахан нэр томъёо, тоо хэмжээ урсгаж эхлэхэд, Колэр захирлын нүд бүр галзуу юм шиг болж эхлэв. Ландон тэр яриаг нь ойлгох гэж хичээнэ. *Тэгэхээр, Леонардо Ветра энергийн хэт хуралдсан цэг үүсгэж, тэндээс ертөнц үүснэ гэж тооцож загварчилжээ.* «Үр дүн нь мэдээж аугаа гайхалтай байлаа. Нийтлүүлсэн бол өнөөгийн физикийн хамгийн суурь хуулиудыг ч ганхуулж магадгүй байсан юм» гэж Ветра хэлэв. Хэлэх гэж байгаа зүйлдээ өргөлт өгөхөөр шийдсэн бололтой аажим өгүүлж эхэллээ. «Хурдасгуурын хоолой дотор энерги хэт төвлөрсөн цэгээс материйн эгэл бөөмс оргүй хоосноос үүсч эхэлсэн юм». Колэр ямар ч реакц үзүүлсэнгүй. Зүгээр л мэлэрнэ. Виттория цааш нь: «Матерь оргүй хоосноос дэлгэрч байсан. Атомаас жижиг бөөмсүүдийн галт наадам гэмээр л байсан шүү. Жижигхэн ертөнц амь орох шиг. Тэр зөвхөн матери оргүй хоосноос үүсч болно гэдгийг төдийгүй Их тэсрэлт, Үүтгэл хоёр аугаа их энергийн хуралдал хурдасган үүссэн гэж тайлбарлаж болно гэдгийг нээсэн юм л даа.» Колэр: «Тэгвэл бурхан гэдэг чинь ..?» гэж асуув. «Бурхан, Будда, Ертөнцийн санаа, Яхва, сингуляр, нэгдсэн цэг энэ тэр гээд л юу ч гэж нэрлэсэн бай, үр дүн нь нэг л юм. Шашин, эрдэм хоёр нэг л зүйлийг - ертөнцийн бүтээгч бол цэвэр энерги юм гэж л нотолж байна». Колэр эцэст нь их л төв байдлаар дуугарав. «Виттория, чиний яриа миний толгойг эргүүлчихлээ. Аав чинь материйг ... оргүй хоосноос гаргаж авсан гэж чи хэлээд байна уу даа?» гэж асуув. «Тийм» гэж Виттория хариулаад канистер руу зааж: «Тэнд нотолгоо нь байна. Аавын гаргаж авсан материйн бөөмс нь тэнд, тэр канистеруудад байгаа» гэв. Колэр ханиасаар, тэргэнцрээ

жолоодон, нэг юм биш байгааг мэдэрсэн зэрлэг амьтан аятай, их л хянамгайлан канистер руу ойртов. Тэгснээ: «Нэг юм болохгүй байна даа» гэв. Энэ канистерт аавын чинь гаргаж авсан бөөмс байгаа гэдэгт хүн итгэнэ гэж чи яаж бодов оо? Энэ бөөмсүүдийг хаанаас ч гаргаж авч болно шүү дээ.» «Уул нь, болохгүй л дээ» гэж Витториа хариулаад: «Эдгээр бөөм тун онцгой, газар дэлхий дээр хаана ч байдаггүй матери байгаа юм... тэгэхээр бүтээсэн байж л таарна шүү дээ» гэв. Колэрын царай нь барайгаад: «Витториа, онцгой гэдэг нь яг юу гэсэн үг юм бэ? Ганц л төрлийн матери байдаг шүү дээ... тэгээд» гэснээ чимээгүй болчхов. Витториа ялгуусан дүр гарган тайлбарлав. «Та өөртөө л тэгж лекцэлдэг шүү дээ, захирал минь! Ертөнц дээр хоёр төрлийн матери байдаг. Эрдмийн баримт шүү!» гээд Ландон руу хандан: «Ландон гуай, Библи Бүтээлийн тухай юу гэдэг билээ? Бурхан юуг бүтээв гэдэг билээ?» Ландон, тэр Библи ер нь энд ямар хамаатай юм бол хэмээн учрыг огт олохгүй, тун аягүй байв. «Бурхан гэрэл, сүүдэр, тэнгэр, тамыг ... гээд л бүтээсэн юм гэдэг шүү дээ». «Яг зөв!» гэж Витториа хэлээд: «Бурхан бүх юмыг эсрэг тэсрэг бүтээсэн юм. Хэм тэгш, төгс тэнцэл.» Тэгээд Колэр рүү эргэж: «Захирал аа! Эрдэм шашинтай адил, нэг л юм ярьдаг. Их тэсрэлт энэ ертөнцөд бүх юмыг эсрэг тэсрэг харьцаанд бүтээсэн гэж» гэв. Колэр: «Материйг ч бас» гэж өөртөө хэлэх мэт шивнэв. Витториа толгой дохиод: «Аав маань энэ туршилтыг хийхэд, мэдээж хэрэг, хоёр төрлийн матери бий болсон юм» гэлээ. Ландон мэлэрсэн хэвээрээ. *Леонардо Ветра эсрэг биет - антиматери бүтээлээ гэж үү?* Колэр ууртай харагдана. «Таны яриад байгаа бодис чинь энэ ертөнцийн хаа нэгтээ оршиж байгаа л даа. Гэхдээ, дэлхий дээр биш. Тэр бүү хэл манай галактикт ч биш» гэв. «Яг зүйтэй» гэж Витториа хэлээд: «Чухам наадах чинь л энэ канистерт байгаа эдийг гаргаж авсан гэдгийг нотлоод байгаа юм» гэлээ. Колэрын царай хиртхийв. «Витториа! Чи, тэгээд, тэрийг энэ канистерт байгаа гэх гээд байгаа юм уу?» «Тийм шүү». Тэр канистер рүү бахтай харж байв. «Захирал аа, та энд энэ дэлхийн хамгийн анхны антиматерийг харж байна» гэлээ. Хэсэг *20 Хоёр дахь шат* хэмээн Хассассин бодон харанхуй хонгилоор шуурч явлаа. Гарт нь дүрэлзэх бамбар сүртэй ажээ. Үүнийг ч тэр мэдэж байв. Бамбар сүр үзүүлэхийн тулд билээ. Гэхдээ сүр үзүүлнэ гэдэг хамгийн чухал нь юм. Айдас түүний хамгийн сайн анд. Зөвхөн айдас л дайсныг дайн эхлэхээс өмнө даран устгаж өгдөг. Өөрийнхөө хэр сүртэй харагдаж байгааг зэрвэс ч атугай харчхаар толь хонгилд даан ч байхгүй ажээ. Гэхдээ, ард нь сүүдэр цувуулах дээлийнхээ хормойн дэрвэлзэхийг хараад, аймшигтай харагдаж байгаагаа мэдэрнэ. Ингэж сүр үзүүлэх нь төлөвлөгөөний нэг чухал хэсэг байлаа. Тэр хамгийн зэрлэг мөрөөдөлдөө ч ийм чухал ажлын ийм чухал хэсэгт нь гар бие оролцоно гэж төсөөлөөгүй билээ. Хоёр долоо хоногийн өмнө, энэ хонгилын цаад үзүүрт гүйцэтгэх ёстой ажлаа ямар ч боломжгүй зүйл гэж бодож байв. Тэр үед, энэ бол амь золих хэрэг, арслангийн аманд биеэ тушааж байгаа явдал байлаа. Гэхдээ, Янус боломжгүй зүйлийг боломжтой болгожээ. Янус түүнтэй сүүлийн хоёр долоо хоногийн турш маш олон нууцыг задлан ярьсан: энэ хонгил зөвхөн нэг нь л байлаа. Хонгил их л эртний эд боловч зорчиж болохуйц хэвээрээ байв. Хассассин дайснуудынхаа зүрх рүү дөхөх тусам гүйцэтгэх ёстой үүрэг нь Янусын хэлсэн шиг амархан байх болов уу, үгүй юу гэж гайхасхийж явлаа. Янус түүнд, дотор нь байгаа нэг хүн тусална гэсэн билээ. Дотор нь байгаа хүн. Үнэмшмээргүй юм. Энэ тухай бодох тусам хүүхдийн тоглоом шиг амархан санагдана. *Вахад... тинтэйн ... талата ... арбаа* хэмээн тэр өөртөө арабаар хэлж, хонгилын үзүүр рүү дөхөж явав. *Нэг .. хоёр... гурав... дөрөв...*

Та антиматери гэж сонссон байлгүй дээ, Ландон гуай?» хэмээн Витториа шинжингүй ажиглахад, хөрслөг бор арьс нь лабораторийн цагаан ханан дээр тод ялгаран харагдана. Ландон уруулаа цорвойлгон, санаа алдаад: «Тийм ээ, сонссон байх аа». Бүсгүйн нүүрэнд шоолонгуй инээвхийлэл зурвас илрээд алга болчхов. «Та Стар Трэк гэж кино үзсэн үү?» Ландон барьц алдсанаа: «Манай оюутнууд дуртай л даа» гэв. Тэгснээ, нэг юм санасан бололтой толгойгоо өндийлгөөд: «Антиматерь гэдэг чинь нөгөө АНУ Интерпрайс хөлгийн гол түлш бил үү?» гэв. Витториа толгой дохилоо. «Сайн зөгнөлт ном - эрдмийн сайн үндэстэй байдаг юм» гэв. «Тэгээд антиматери гэдэг чинь бодитой юм уу?» «Байгалийн жам. Бүх юм эсрэг тэсрэг. Позитрон электрон хоёр. Дээд, доод кварк. Атомоос жижиг хэсгээс тогтсон сөрөг ертөнц гэж бас бий. Матери арга бол антиматери билэг. Ингэж л физикийн тэнцэтгэл - тэнцэтгэл болж байгаа юм.» Ландон, Галилео хосолмол харьцааг шүтдэг байсныг санав. Витториа үргэлжлүүлэн: «Бүр 1918 оноос хойш, эрдэмтэд Их тэсрэлт хоёр төрлийн матери үүсгэсэн гэж мэддэг байсан. Нэг төрлийн матери нь дэлхий дээр хад, чулуу, мод, хүн болж бидэнд харагдаж байна. Нөгөөх нь яг эсрэгээр - уул нь бүх талаараа бидний мэдэж байгаатай яг адилхан, гэхдээ зөвхөн цэнэг нь л өөр». Колэрын нүд манан дундаас сүүмэлзэх шиг. Дуу хоолой нь тээнэгэлзсэн бололтой. «Гэхдээ антиматерийг хадгална гэдэг технологийн хувьд аугаа бэрх даваа шүү дээ. Яаж саармагжуулсан юм бэ?» «Аав маань сөрөг туйлтай вакуум бүтээж антиматерийн позитроныг устахаас нь өмнө хурдасгуур дотроос сугалж авсан юм». Колэр хүйтэн царайтай хэвээр: «Гэхдээ тэр вакуум чинь бас материйг хамт татчихдаггүй юм уу? Тэр хоёрыг салгах ямар ч арга байхгүй шүү дээ». «Соронзон талбай үүсгэчихгүй юу. Тэгээд материйг баруун талд нь, антиматерийг зүүн талд нь татчихсан. Эсрэг туйлд нь татаад л боллоо.» Витториаг тэгж хэлмэгц Колэрын эргэлзээ нуран уналаа. Тэр Витториаг бишрэн мэлэрснээ гэнэт тасралтгүй ханиалгаж эхлэв. «Биш ... эрмээр . . . юм ... аа» гээд амаа арчаад: «Гэхдээ л ...» гэв. Бас л итгэж өгөхгүй, нөгөө хүйтэн логик нь зөвшөөрч өгөхгүй байгаа бололтой. «Гэхдээ л вакуум ажилласан ч гэсэн, энэ канистерууд бас л матери шүү дээ. Антиматери ханатай нь эгшин зуур харилцан үйлчлээд...» «Бөөмс хананд хүрэхгүй» гэж Витториа тэгж асуухыг нь мэдэж байсан юм шиг эрс хариулав. «Антиматерь тэнд хий тэлэгдчихсэн байгаа. Энэ канистерыг «антиматерийн хавх» гэдэг, үнэхээр ч антиматерийг татаад канистерын төв хэсэгт, үзүүр, хананаас нь хөндий тэлчихсэн байгаа юм.» «Тэлчихсэн? Яаж тэр вэ?» «Солбисон хоёр соронзон орны огтлолцсон цэг дээр. Хар даа!» Витториа өрөөн дотуур алхалж, том цахим аппаратын дэргэд очив. Тэр төхөөрөмж яг л хүүхэлдэйн кинонд гардаг цацрагийн буу шиг - гол төмөр шиг өргөн хоолойн дээр овоо хараа шиг юмтай, доор нь хөл шиг тулгууртай ажээ. Бүсгүй түүнийг нэг канистер руу нь чиглүүлж, шагайвчаар нь онилж байгаад нэг товчийг нь дарав. Тэгээд тэндээсээ холдож Колэрыг харахыг урив. Колэр гайхширсан байртай: «Та нар харагдахуйц хэмжээгээр цуглуулсан гэж үү?» «Таван зуун нанограм» гэж Витториа хариулав. «Шингэн плазм сая сая позитрон агуулж байгаа юм». «Сая сая гэнэ ээ? Дөнгөж хэдэн ширхэг бөөмийг л хэн нэг нь хаа нэгтээ гаргаж чадсан байдаг шүү дээ.» «Аав ксенон тийрэлтээр эгэл бөөмсийг хурдасгаж, электронуудыг нь үлээгээд, яг зэрэгцүүлээд түүхий электронууд зэрэг шахчихсан юм. Уул нь энэ процессоо их л нууцалж байсан сан, зайлуул» гэж Витториа ярилаа. Ландон ойлгосонгүй. Ер нь тэд англиар ярьж байгаа эсэх нь ойлгомжгүй байв. Колэр чимээгүй суусаар, хөмсгийнх нь үрчлээ гүнзгийрнэ. Гэнэт эхэр татаж, яг л буудуулчих шиг харагдав. «Тэгвэл, техникийн хувьд нэлээн олон...» Витториа толгой дохиод: «Тийм шүү, бүр маш олныг» гэлээ. Колэр эргээд канистер рүү ойртов. Сандал дээрээ өндийж, эргэлзсэн нүдээрээ шагайвч руу ойртон, харлаа. Юу ч хэлэлгүй, удаан гэгч дурандана. Арай гэж шагайж дуусаад, сандлынхаа

түшлэгийг налан гэдийхэд, нүүрэн дээр нь хөлс бурзайжээ. Духных нь үрчлээ тэнийчихсэн байв. Тэгээд, бараг л шивнэх шахам: «Бурхан минь, та нар чадсан байна шүү» гэлээ. Витториа зөвшөөн: «Аав маань чадсан юм» гэлээ. «Би ... би юу хэлэхээ ч мэдэхгүй байна». Витториа, Ландон руу эргээд: «Та хармаар байна уу?» гэж нөгөө дуран руу зангав. Ландон яахаа ч мэдэхгүй, шууд л урагш алхлаа. Хоёр тохой зайнаас, канистер хоосон харагдана. Тэнд юу ч байлаа гэсэн, их л бичил байх нь эргэлзээгүй. Ландон нүдээ шагайвч руу ойртуулан, онилов. Түүний нүдний өмнө байгаа зүйл тодорч харагдталаа бас хэсэг зуур болов. Тэгээд, тэр харлаа. Түүний төсөөлж байсан шиг ёроолд нь биш, харин төв хэсэгт нь, яг л мөнгөн ус шиг шингэн дусал хөвж байлаа. Тэр дусал шидийн мэт хүчээр агаарт тогтоно. Дусал дундуур металл зурвас үелзэн урсаж байв. Ландон жингүйдлийн нөхцөлд буюу G тэг байх нөхцөлд усан дусал ингэж харагддаг гэсэн видео бичлэг үзэж байснаа саналаа. Дусал, мэдээж, бичил хэмжээтэй байсан ч тэнд үелзэн буй бүх судлыг нэгд нэгэнгүй харж болох ажээ. Тэр бишрэнгүй дуу алдаад: «Энэ ... хөвж байна» гэв. Витториа: «Тэгвэл л сайн. Антиматери тун тогтворгүй. Энергийн хувьд гэвэл антиматери, материйн эсрэг хэлбэр учир шүргэлцэх л юм бол бие биеэ саармагжуулж устана. Тэгэхээр, антиматерийг материас саланги байлгана гэдэг том даваа шүү. Яагаад гэвэл, энэ дэлхий дээр байгаа юм бүхэн матери шүү дээ. Эдгээрийг, тэгэхээр, юм болгоноос тусад нь, бүр агаараас хүртэл тусад нь байлгах хэрэгтэй болно шүү дээ». Ландон мэлэрнэ. *Тэгэхээр, вакуум орчинд ажиллана гэсэн үг.* «Энэ антиматерийн хавхыг чинь» хэмээн Колэр үгийг нь таслан орж ирээд, мойног хуруугаараа канистерын суурь руу заан: «Аав чинь хийсэн үү?» гэлээ. «Энэ нь ч миний санаа л даа» хэмээн Витториа хариулав. Колэр түүн рүү ширтэнэ. Витториа түүнийг анзаарсан ч үгүй: «Аав уул нь анх антиматерийг гаргасан боловч хэрхэн тогтворжуулахаа мэдэхгүй байсан юм. Тэгээд, би энийг санаачилсан юм л даа. Хоёр талдаа цахилгаан соронзон туйлтай, агаар үл нэвтрүүлэх нано-хуванцар хоолой» гэлээ. «Аавынхаа суут санааг улам ч бишрэм болгожээ» «Үгүй дээ. Би байгаль эхээсээ л санаа авсан хэрэг. Португалийн дайнч-эр загас ангуучлахдаа хоёр сахлынхаа хооронд нематосистик цэнэг гарган барьдаг юм. Энэ л зарчмыг би ашигласан. Канистерын хоёр үзүүрт цахилгаан соронзон хоёр талбайтай. Хоёр талаас эсрэг туйлууд таталцаж, соронзон талбай үүсгэхдээ, туйлууд нь хоёр үзүүртээ солбисон байх учраас дундаа огтлолцоно. Яг тэнд л антиматерийг гацааж, барьж байгаа юм.» Ландон канистер руу дахин харав. Антиматери вакуум дотор хөвж, аль ч талаараа юу ч шүргэхгүй байлаа. Колэр үүнийг суут бүтээл гэж зөв үнэлжээ. «Цахилгаан соронзоны тэжээл нь хаана байгаа юм бэ?» гэж Колэр асуулаа. Витториа: «Хавхны доор байгаа шонд. Канистерыг сууринд нь эрэгдэж бэхэлсэн юм. Тиймээс цэнэг унахгүй - соронзон орон байнга л байж байна гэсэн үг» гээд заав. «Соронзон орон унавал яах вэ?» «Мэдээж тэгвэл, антиматери унаж, хавхны ёроолд хүрмэгц аннигиляц болно доо». Ландонд «аннигиляц» гэдгийг сонсоод хирдхийв. Бүр мөсөн устаж, ор мөргүй болно гэсэн тэр үг нэг л аягүй сонсогдоно. Витториа түүнийг нь анзаарсан ч үгүй. «Тийм шүү. Хэрэв антиматери, матери хоёр шүргэлцвэл хоёулаа эгшин зуур устаж үгүй болно. Физикт ийм үзэгдлийг аннигиляц гэдэг юм» гэлээ. Ландон: «Аа, зөв, зөв» гэхээс өөр хэлэх юм олдсонгүй. «Энэ бол байгалийн хамгийн энгийн харилцан үйлчлэл шүү дээ. Антиматерийн бөөмс, материйн бөөмс хоёр нийлж фотон гэдэг хоёр шинэ бөөмс үүсгэдэг. Фотон гэдгийг гэрлийн ширхэг гэмээр юм уу даа.» Ландон, фотон буюу гэрлийн бөөмс бол энергийн цэвэр хэлбэр хэмээн уншиж байснаа саналаа. Ахмад Кирк, Клингонсийн эсрэг фотон торпедо харваж байсныг асуух гэснээ болив. «Тэгээд антиматери унах юм бол жижигхэн гэрлийн ширхэг болно гэсэн үг үү?» Витториа мөрөө хавчаад: «Жижигхэн гэдгийг яаж ойлгохоос л хамаарна даа. Би нэг юм харуулах уу?» гэлээ. Тэгээд, нэг канистер руу нь

очоод эрэгдэн, сууриас нь салгаж эхлэв. Колэр нүд ирмэхийн зуур Витториагийн дэргэд очоод, гарыг нь сандран татаж: «Витториа, чи чинь солиороо юу?» гэж салганан хашхирлаа.

Хэсэг 22

Колэр сандарсандаа, хоёр хөл дээрээ хэсэг зуур чичрэн босоод ирснээ, эргээд лаг хийтэл сандал дээрээ уналаа. Царай нь цаас шиг зэвхий даажээ. «Витториа, чи энэ хавхыг салгаж болохгүй шүү дээ». Колэр захирал тэгтлээ тэвдэн сандарсан нь Ландонд жигтэй санагдана. «Таван зуун нанограмм шүү дээ! Сууриас нь салгачих юм бол...» «Захирал аа!» гэж Витториа эргэж хараад: «Зүв зүгээр. Бүх хавхны доор сууриасаа салсан үед шууд ажиллах зай байдаг юм. Сууриас нь салгасан ч гэсэн энэ бөөмс хөвсөн хэвээрээ л байна» гэлээ. Колэр жигтэй харснаа хойшилж, санаа нь уужирсан бололтой, сандлынхаа түшлэгийг налав. «Хавхыг сууриас нь салгамагц зай нь автоматаар ажиллана» гэж Витториа тайлбарлана. «Зай нь хорин дөрвөн цагийн турш барина. Яг л бензиний нөөц сав шиг». Тэгээд, Ландон эвгүйцээд байгааг мэдэрсэн бололтой, түүн рүү эргэж харав. «Ландон гуай! Антиматери аймшигтай үр дагаварт хүргэж магадгүй шүү. Арван миллиграмм буюу элсний ширхэг шиг хэмжээтэй антиматери ердийн пуужингийн түлшний дайтай энерги ялгаруулна гэсэн таамаглал байдаг юм». Дахиад л, Ландоны тархи тэр үгийг нь ухаарах гэж ачааллаа нэмэв. «Энэ чинь ирээдүйн энергийн эх үүсвэр байгаа юм даа. Цөмийн энергиэс мянга мянга дахин хүчтэй. Зуун хувийн ашигт үйлийн коэффициенттой. Ямар ч сөрөг нөлөө байхгүй. Ямар ч цацраг идэвх байхгүй. Ямар ч бохирдолгүй. Хэдхэн грамм нь том том хотыг долоо хоногийн турш эрчим хүчээр хангаж чадна». *Грамм нь уу?* гэж Ландон канистераас болгоомжлонгуй холдохдоо асуулаа.

Витториа: «Айх хэрэггүй. Энд граммыг сая хуваасантай тэнцэх бага хэмжээтэй байгаа. Арай аюул бага». Тэгээд, канистер руу дахин очоод сууриас нь салгав. Колэр болиулах гэж зангаснаа болив. Хавхыг сууриас салгах эгшинд хурц гэрэл анивчаад, доор нь байх шингэн дэлгэц аслаа. Улаан өнгийн тоо хорин дөрвөн цагаас эхлэн, урвуу тоолж эхлэв. 24:00:00... 23:59:59... 23:59:58... Ландон урвуу тоолох тэр цагийг харвал, хавх яг л цагтай бөмбөг шиг санагдана. «Зай дуустлаа хорин дөрвөн цаг бүрэн барина. Сууринд нь буцаагаад суулгахад дахин цэнэглэгдэнэ. Уул нь, хөдөлмөр хамгааллын үүднээс ингэж бүтээсэн ч ийш тийш зөөхөд бас амар байдаг юм» гэлээ. «Зөөх өө?» гэж Колэр мэгдэн асуув. «Та хоёр энийг бас лабораториос гадагш нь зөөж явж байсан хэрэг үү?» «Үгүй, яалаа гэж дээ? Гэхдээ судлахын тулд хөдөлгөх хэрэг бас гарна шүү дээ» гэж Витториа хариуллаа. Бүсгүй - Ландон, Колэр хоёрыг өрөөний алс мухар руу дагууллаа. Нэг хөшиг татвал цонхны цаана том гэгч өрөө байх ажээ. Хана туурга, шал, таазыг бүхэлд нь ган хавтангаар бүржээ. Яг л газрын тос зөөдөг, ачааны том усан онгоцны ёнкос шиг байлаа. Тэр ханта судлах гэж Папуа Шинэ Гвиней рүү явж байхдаа нэг удаа ийм онгоцоор аялжээ. «Энэ аннигиляцын өрөө байгаа юм» гэж Витториа тайлбарлав. Колэр өнгийгөөд: «Та хоёр бас аннигиляц хийж туршсан юм уу?» гэлээ. «Аав Их тэсрэлтийн физикийг сонирхон: яаж материйн жижигхэн хэсгээс асар их энерги ялгарсныг гайхаж: учрыг нь олох гэдэг байсан юм». Витториа цонхон доор байсан шургуулгыг татаж, хавхаа дотор нь хийгээд эргүүлж хаав. Тэгээд, шургуулгын хөшүүргийг татлаа. Удалгүй, антиматерийн хавх цонхны цаана үзэгдэнэ. Хавх төмөр шалан дээгүүр явсаар, цаад өрөөний голд байх том өргөн нум руу очоод зогсов. «За, та бүхэн антиматери, материйн аннигиляцыг амьдралдаа анх удаа харах гэж байна. Граммыг сая хуваасантай тэнцэх тун яльгүй хэмжээтэйг шүү» гэж Витториа хэлээд жуумалзахад, нүүрэнд нь мишээл тодроод алга боллоо. Антиматерийн хавх том гэгч төмөр өрөөний голд ганцаараа бөртийнө. Ландоныг цонх руу харахад, Колэр ч бас, юу бодохоо мэдэлгүй, цонх руу ширтэж байлаа.

Витториа: «Ер нь бол зай нь дуустал хорин дөрвөн цаг хүлээх хэрэгтэй л дээ. Харин энэ өрөө шалан доороо соронзтой: тэр нь хавханд байгаа соронзоос хүчтэй болохоор, хөвж байгаа антиматерийг доош нь татна. Тэгээд антиматери, матери хоёр ...» гээд л тайлбарлав. «Аннигиляц болно» гэж Колэр шивнэх шахам хэлэв. «Бас нэг юм байна» гэж Витториа хэлээд: «Антиматерь цэвэр энерги ялгаруулдаг. Масс зуун хувь фотон болон хувирна. Тиймээс тийшээ битгий зүгээр хар, нүдээ халхлаарай» гэв. Ландон яриаг нь шимтэн сонсож байсан ч, энэ удаа Витториа арай л хэтрүүлж байх шиг байлаа. *Тийшээ битгий зүгээр хараарай!* Хавх плексиглассаар бүрхсэн, ультра зузаан шилэн ханын цаана, гуч гаруй дэлэм зайтай байлаа. Түүнээс гадна, антиматери тун бага, микроскопоор л харахгүй бол үзэгдэхээргүй бага хэмжээтэй. *Нүдээ халхлаарай гэнэ шүү. Энэ жаахан дээж хэр энерги гаргав гэж дээ...* Витториа товчоо дарав. Ландон сохорчих шиг болов. Канистерт оч гялбаад, хурц цэгээн гэрэл мэлсхийтэл цацраад, шилэн хананы цаадах төмөр өрөө чичирч нүргэлэн дэлбэрлээ. Хана доргиход, Ландон арагш дэнхэлзэн ухрав. Гялбам цэгээн гэрэл хөвөх мэт хэсэг тогсоод: гэнэт эргэж хураагдан, жижигхэн хар цэг болмогцоо, ор мөргүй алга болчхов. Нүд нь нэлгэр цэгээн гэрэлд гялбасан хэвээр. Хэдэн хормын дараа, аяндаа юм харахтайгаа боллоо. Ландон аннигиляцын өрөөг зэрвэс харлаа. Канистер замхарчихсан юм шиг оргүй болжээ. Ямар ч ул мөргүй. «Ээ, бурхан минь!» хэмээн Ландон өөрийн өрхгүй бувтнав. Витториа эргэж хараад: «Аав бас ингэж х элж билээ» гэхэд, харцанд нь сэтгэлийн гансрал үзэгдлээ.

Хэсэг 23

Колэр аннигиляцын өрөө рүү ширсээр, сая харснаа бахдаж дуусахгүй, хөөрч суулаа. Роберт Ландон таг мэлэрнэ. «Би аавыгаа хармаар байна» гэж Витториа хэлэв. «Би танд лабораторио үзүүллээ. Одоо би аавыгаа хармаар байна» . Колэр сонсоогүй юм шиг аажим эргэж: «Та нар яагаад ийм удаан хүлээгээ вэ, Витториа? Та хоёр энэ нээлтийнхээ тухай надад тэр даруйд нь мэдэгдэх ёстой байсан шүү дээ» гэлээ. *Танд тэгээд хэдэн удаа тайлбарлах юм бэ* гэсэн байртай Витториа түүн рүү төвөгшөөн ширтэнэ. «Захирал аа! Энэ тухай хоёулаа дараа ярья. Харин одоо би аавыгаа хармаар байна.» «Энэ технологи юунд хүргэж болохыг мэдэж байна уу?» «Тэгэлгүй яах вэ дээ» гэж Витториа хилэгнэн: «СЭРН-д уул овоо шиг мөнгө авчирна. Гэхдээ би одоо аавыгаа ..» «Энэнээс л айгаад байсан хэрэг үү, та хоёр?» гэж Колэр шавдуулан: «Удирдах зөвлөл эсвэл намайг энэ технологийг лицензлэх байх гэж айгаа юу?» «Лицензлэх ч ёстой» гэж Витториа уцаарлаад, тайлбарлахгүй бол болохгүй нь гэсэн боллоотой ярилаа. «Антиматерь бол чухал технологи. Гэхдээ бас аюултай. Аав бид хоёр баяжуулах аргыг нь сайжруулж, илүү аюулгүй болгох гэж байсан юм.» «Өөрөөр хэлбэл, удирдах зөвлөлийг, эрдмийг мөнгөний шуналаасаа илүүд үзэж чадахгүй гэж бодсон юм биз дээ?» Колэр дууныхаа өнгийг өөрчлөлгүй ингэж хэлсэнд Витториа гайхав. «Өөр асуудал бас бий» гэж бүсгүй арцан: «Аав даг нь ирэхээр антиматерийг танилцуулна гэдэг байсан юм». «Тэр чинь юу гэсэн үг вэ?» *Юу гэсэн үг гэж гэдэг чинь юу гэсэн үг вэ?* «Энергээс матери гаргаж авлаа шүү дээ? Оргүй хоосноос бодит юм гаргалаа шүү дээ. Энэ чинь, Үүтгэл эрдмийн хувьд бодитой гэдгийг харуулж байна биш үү?» «Тэгэхээр, нээлтийнх нь шашинлаг үр нөлөөг бизнесийн хэрэгсэл болгочих вий гэхээс эмээсэн хэрэг үү?» «Тийм гэх үү дээ?» «Харин таны хувьд?» Витториагийн зовнил арай өөр байлаа. Бизнесийн хэрэгсэл болчихвол уул нь энергийн шинэ эх үүсвэртэй болж, түгэхэд тустай юм. Антиматери технологи үр

ашигтай, бохирдолгүй энергийн эх үүсвэр мөн боловч: улс төр, нэр алдрын хэрэг болгоод, цөмийн болон нарны эрчим хүчний нэр хүндийг унагачихсан шиг юм болж магадгүй гэж болгоомжилжээ. Цөмийн эрчим хүчийг аюулгүй болгохоос нь өмнө дэлгэснээс болж, олон олон осол гарсан. Нарны эрчим хүчийг үр ашигтай болгохоос нь өмнө дэлгэснээс болж, олон бизнес дампуурсан. Өнөөдөр энэ хоёр технологи хоёулаа хүмүүсийн дунд муу нэртэй болжээ. «Миний сонирхол бол» гэж Витториа хэлээд :«Шашин, эрдэм хоёрыг нэгтгэхээс арай наагуур л даа» гэлээ. «Байгаль орчин уу?» гэж Колэр шавдуулна. «Хязгааргүй энерги. Ямар ч уурхай байхгүй, ямар ч бохирдол байхгүй, ямар ч цацраг идэвх байхгүй. Антиматери технологи энэ дэлхийг аврах гарц». «Эсвэл устгах хүч» гэж Колэр засав. «Хэн, юуны тулд хэрхэн ашиглахаас л хамаарна шүү дээ». Колэрын зэвхий царайг хараад, Витториагийн нуруугаар хүйт оргилоо. «Энэ тухай өөр хэн мэдэж байсан бэ?» «Хэн ч мэдээгүй гэж би хэлсэн шүү дээ». «Тэгвэл, аав чинь яагаад алагдсан байх вэ?» Витториа, илэрхий уурласан ч, биеэ барих гэж оролдон, нэлээн унтууцсан байдалтай: «Би яаж мэдэх юм бэ? СЭРН-д хүртэл тэрний дайсан зөндөө л байсан, та мэднэ шүү дээ. Гэхдээ, энэ антиматеритай ямар ч хамаагүй. Бид хоёр бэлэн болтлоо дахиад хэдэн сар энэ тухай хэнд ч ам алдахгүй гээд тангараглачихсан байсан юм.» «Аав чинь тангаргаа сахисан гэж бодож байна уу?» Витториа одоо бие барихаа больж эхлэв бололтой, дэлбэртлээ уурлалаа. «Аав үүнээс илүү нууц хадгалж чадаад байсан юм даа.» «Чи бас хэнд ч юу ч хэлээгүй юу?» «Мэдээж хэлээгүй». Колэр урт гэгч амьсгаа авлаа. Тэгээд үгээ цэнэн байж хэлэв. «Өөр хэн нэгэн энэ тухай мэдчихжээ гэж бодъё. Тэгээд энэ лабораторид нэвтрэх боломжтой болжээ гэж бодъё. Тэгвэл, тэр орж ирээд юу хийх байсан бэ? Аавын чинь тэмдэглэл юм хум энд бүрэн байна уу? Туршилтын явцын баримтжуулалт ч юм уу?» «Захирал аа! Би тэвчээртэй байх гэж хичээж байна шүү. Та надад ядаж зарим зүйлээ тайлбарлах хэрэгтэй байна. Дандаа нэвтрэх боломжийн тухай яриад байх юм, ретина скайныг хараа биз дээ? Аав маань аюулгүй байдал, нууцлалын тухайд чанд хүн байсан юм шүү». «Тоглоод байгаа юм уу даа?» гэж Колэр тоомжиргүй хэлээд: «Юм алга болж уу?» гэж тулгаж асуув. «Ёстой мэдэх юм алга» гээд Витториа эргэн тойрноо хилэнтэй еэ харлаа. Антиматерийн бүх канистер бүрэн байв. Аавынх нь ажлын байр байдаг л чигээрээ. «Ийшээ хэн ч орж ирээгүй байна» гэж тэр хэлээд: «Энэ давхарт л лав бүх юм хэвээрээ байна» гэлээ. Колэр няхуур гэгч: «Энэ давхарт гэнэ ээ?» гэв. Витториа санамсаргүй ингэж хэлжээ. «Тийм. Дээд давхрын энэ лаборатори л лав зүгээр байна». «Тэгвэл доод лабораторийг та нар бас ашигладаг байсан юм уу?» «Агуулах төдий л». Колэр ханиалгасаар түүн рүү дөхөж: « Та нар, тэгээд, Naz-Mat өрөөг бас агуулах болгочихсон юм уу? Юу хадгалж байгаа юм бэ? «Аюултай материал л байхгүй юу. Өөр юу байдаг юм бэ?» гэж Витториа тэсвэр алдан хашхирав. «Антиматерийг!» Колэр тэргэнцрийнхээ гар дээр түшин, өндийж: «Антиматерийн өөр дээж бас байгаа юм уу? Яагаад надад хэлэхгүй байсан юм бэ?» «Хэлж байгаа юм биш үү?» гэж Витториа арцав. «Тэгээд ч, та надад юм хэлэх бололцоо олгосон юм уу?» «Цөмөөрөө одоо тэр дээжсийг очиж шалгая» гэж Колэр хэллээ. «Дээжийг гээч!» гэж Витториа засч хэлээд: «Ганц тоон дээр! Тэгээд ч, зүгээр байгаа даа. Хэн ч тийшээ ...» «Ганц ширхэг юм уу? Яагаад энд хадгалахгүй байгаа юм бэ?» гэж Колэр яриаг нь таслан асуулаа. «Аав аюулгүй байлгах гэж л, хадан доогуур тавьсан нь дээр гэсэн юм. Тэр нь эд нарыг бодоход том л доо». Колэр, Ландон хоёрын нүдэнд айдас тодроод явчхыг Витториа ажиглав. Колэр түүн рүү дөхөж очоод: «Та хоёр таван зуун нанограммаас илүү дээж гаргаж авсан юм уу?» Витториа: «Шаардлагатай байсан болоод л» гэлээ. «Хөрөнгө, олзворлолт хоёрын харьцаа нь ашигтай гэдгийг батлах гэсэн юм.» Энергийн шинэ эх үүсвэрийг хэрэглээнд нэвтрүүлэхэд ямагт гардаг нэг асуудал бол хөрөнгө, олзворлолтын харьцаа: энерги үйлдвэрлэхэд хэр хэмжээний хөрөнгө

оруулалт хэрэгтэй вэ гэдэг юм. Ганц баррель газрын тос гаргах гэж бүтэн цамхаг баривал дампуурна. Гэтэл тэр цамхагт нэмж жаахан хөрөнгө оруулаад, сая сая баррелийг ч олзворлож магад: тэгвэл, энэ бизнес амжилт оллоо гэсэн үг. Антиматери ч бас л адил. Арван зургаан бээр урт цахилгаан соронзонг шатааж орхиод, гаргаж авсан антиматерийнхаа гаргаж чадах боломжит энергиэс илүүг зарвал ашиггүй билээ. Тиймээс антиматерийг үр ашигтай, найдвартай гэдгийг нотлохын тулд боломжтой хэмжээгээр гаргаж нотлох ёстой билээ. Аав нь их л дурамжхан байсан ч, Виттория шахсаар байгаад, нэлээд их хэмжээтэй антиматери гаргажээ. Виттория хүмүүсийн анхаарлыг антиматерид татахын тулд хоёр зүйл заавал хийх хэрэгтэй: нэгд, хангалттай их антиматерийг хямд өртгөөр үйлдвэрлэж болно гэдгийг нотлох: хоёрт, гаргасан дээжийг аюулгүй хадгалж болно гэдгийг нотлох ёстой гэж эцгээ сэнхрүүлжээ. Эцэст нь тэр санаснаараа болгож, аав нь шийдвэрээсээ татгалзжээ. Гэхдээ нууцлах, нэвтрэх хатуу журам тогтоох болзол тулгажээ. Аавынх нь хэлснээр, антиматерийг Naz-Mat буюу ахиад далан таван тохой доор орших жижигхэн боржин өрөөнд хадгалья гэжээ. Тэр дээжийг чанд нууцлах ёстой, аав охин хоёр л нэвтрэх эрхтэй байхаар болсон юм санжээ. «Виттория! Та аавтайгаа хэр их хэмжээтэй антиматери гаргаж авсан юм бэ?» гэж Колэр их л түгшин асуув. Витториягийн дотор ид хав оволзон, гайхуулмаар санагдана. Хэлэх гэж байгаа тоо хэмжээ нь аугаа их Максимилиан Колэрыг ч алмайруулна гэдгийг мэдэж байлаа. Виттория доор байгаа антиматерийг дүрслэн, гайхалтай зүйлс ярьж эхлэв. Хавхан дотор ердийн нүдээр харж болох хэмжээний том талбай үүсгэнэ. Тэр нь ВВ-ын хэмжээтэй том учраас микроскопоор ч харах шаардлагагүй. Виттория гүнзгий амьсгаа аваад: «Грамын дөрөвний нэгийн хэмжээтэй» гэв. Колэр цонхийж, нүүрнийх нь арьснаас хамаг цус нь алга болчих шиг болов. «Юу..?» гээд юм хэлэх гэснээ, бүгшин ханиалгана. «Грамын дөрөвний нэг гэнэ ээ..? Энэ чинь бараг л таван килотонн шүү дээ!» *Килотонн*. Виттория энэ үгэнд дургүй ажээ. Аав охин хоёр энэ үгийг хэрэглэх дургүй байлаа. Нэг килотонн 1 000 метр тонн TNT-тай тэнцэнэ. Килотонн гэдгийг зэвсгийн чадлыг хэмжихэд л хэрэглэдэг билээ. Цэнэгийн хэмжээ. Устгах хүч. Харин тэр хоёр вольт, жюль гэх мэт энергийн бүтээлч хэмжээний тухай л ярина. «Тийм их антиматери хагас бээрийн радиуст байгаа бүхнийг үнсэн товрог болгоно шүү дээ» гэж Колэр хэллээ. «Бүгдийг нь нэг зэрэг аннигиляц хийвэл ч тэгнэ л дээ. Гэхдээ хэн тэгэх вэ дээ?» гэж Виттория зөрүүдлэв. «Юу ч мэдэхгүй нэг нь тэгж магадгүй юм. Эсвэл зай нь дуусдаг ч юм уу» хэмээн хэлэхдээ, Колэр цахилгаан шат руу зүглэж явав. «Тийм л учраас аав маань тэрийг чинь Naz-Mat-ын доор унтрахгүй эрчим хүчинд холбож, дэндүү их нууцлалтай системээр тоногчихоод, хадгалж байсан юм». Колэр найдангуй эргэж харлаа. «Naz-Mat -д дахиад нэмэлт аюулгүйн систем тавьсан юм уу?» «Тийм. Ретина скайнаар тоногдсон». Колэр хоёрхон л үг хэлэв. «Доошоогоо, хурдлаарай!» Ачааны цахилгаан шат, унаж яваа чулуу шиг хурдан доошилно. Газрын гүн рүү дахиад далан таван тохой бууж явна. Цахилгаан шат доошлох тусам хажуудах хоёрынх нь айдас нэмэгдэхийг Виттория мэдэрнэ. Колэрын ямар ч хувиралгүй зэвхий царай хүртэл барайсан байлаа. Виттория *дээж үнэндээ хэт их хэмжээтэй, гэхдээ бидний авсан аюулгүйн арга хэмжээ...* хэмээн бодож дуусаагүй байтал, шат газар тулав. Цахилгаан шат онгойж, Виттория бүүдгэр гэрэлтэй гудмаар тэр хоёрыг дагуулан алхав. Гудмын үзүүрт том төмөр хаалга байна. HAZ-MAT. Хаалганы хажууд байх ретина скайн дээд давхрынхтай ижил ажээ. Виттория дөхөж очоод, нүдээ линз рүү аяархан дөхүүлэв. Тэгснээ, огло үсрэн холдов. Бүртийх ч тоосгүй байдаг линзийг нэг юмаар нялгачихжээ... Цус мэт? Бүсгүй хэлмэн цочиж, нөгөө хоёр руугаа эргэн хартал Колэр, Ландон хоёрын царай нь зэвхийчихсэн, бүсгүйн зогсож байгаа газар руу доошоо харж байв. Виттория тэдний харж байгаа зүг ... доошоо... хөл доорхоо харлаа. «Битгий!» гэж Ландон хашхираад, бүсгүйг сатааруулах гэсэн ч,

оройтсон байлаа. Витториагийн харц шалан дээр хэвтэх юман дээр мэлэрчээ. Тэр хүнийрхэж агзайм, гэхдээ танил дотно зүйл байлаа. Бүсгүй танилаа. Сүнс нь сэврээгээр нь хүйт огшоон, гараад явчих шит болов. Бүсгүй тэр юмыг танилаа. Хог шиг хөсөр хаягдаад, түүн рүү гөлийх тэр юм - нүд байлаа. Тэр нүдний харцыг бүсгүй хаана ч байсан таних билээ.

Хэсэг 24

Аюулгүйн техникч урт гэгч амьсгаа авч, захирагч нь түүний мөрөн дээр гараа тавьж, хоёул өмнөө байгаа хяналтын олон дэлгэцийг хянуур ажиглана. Минут хэртэй өнгөрөв. Захирагч юм хэлж чадахгүй байв, тэгэх ч болов уу гэж техникч боджээ. Энэ захирагч дэг хатуу барьдаг хүн аж. Эхэлж хашхираад, дараа нь боддоггүй учраас л тэр энэ дэлхийн хамгийн мундаг аюулгүйн албаны захирагч болтлоо дэвшсэн билээ. *Тэр юу бодож байгаа бол?* Дэлгэц дээр байгаа тэр зүйл - канистер маягийн юм байлаа. Гэхдээ-бүх тал нь тунгалаг ажээ. Энэ ч яах вэ, тодорхой. Харин бусад нь огт ойлгомжгүй байлаа. Тэр канистер дотор, шингэн металл дусал мэт зүйл агаарт хөвж байв. Канистерын суурьт байгаа шингэн дэлгэц дээр, цахим цаг урвуу тоолно. Секунд секундээр хорогдон, робот шиг улаан гэрэл анивчих бүрт нөгөө дусал хяналтын дэлгэц дээр нэг гараад, нэг алга болоод л байв. Цаг хором хормоор хорогдох тусам техникч байж сууж ядна. «Гэрлийн ялгарлыг нь тодосгож болох уу?» гэж захирагч асуув. Техникч хэлсэн ёсоор нь болговол, дэлгэц дээрх дүрс овоо тодорлоо. Захирагч дэлгэц рүү байдгаараа тонгойн, канистерын суурь хэсэгт сая л харагдахуйц болж байгаа зүйлийг ажиглав. Техникч, захирагчийн харж байгаа зүйл рүү бас харцаа шилжүүлэв. Шингэн дэлгэцийн хажууд бүдэгхэн боловч товчилсон үг байхыг харлаа. Анивчих гэрлийн зуур дөрвөн том үсэг нэг гэрэлтэж, нэг алга болно. «Эндээ байж бай!» гэж захирагч хэлэв. Тэгснээ: «Юу ч битгий хэлээрэй. Би аргыг нь олъё» гэлээ.

Хэсэг 25

Naz-Mat. Газар дор тавин метр гүн. Витториагийн нүд харанхуйлж, ретина скайныг мөргөн алдаад ухаан балартав. Америк эр гүйн ирж, түүнийг тэврэн, биеийг нь түшээд авахыг дэн дун мэдэрлээ. Хөл доор, шалан дээр аавынх нь нэг нүд мэлэрнэ. Уушгинд нь байсан агаар царцчих шиг амьсгал тасалдан, ухаан бүрэлзэнэ. Нүдийг нь ухчхаж, зайлуул! Бүсгүй юм хэлж чадахгүй, үгээ сунгаж зажилна. Колэр ард нь үглэн, холхино. Ландон өөрийг нь түшиж явна. Өөрөө ретина скайн руу харна. Скайнер ажиллаад, часхийтэл дуугарна. Бүх юм яг л зүүдэлж байгаа юм шиг дэн дун. Хаалга гулсан онгойв. Аавынх нь шалан дээр унасан нүд бүсгүйн сэтгэл рүү өнгийх шиг аймаар санагдлаа. Дахиад бүр ч аймаар юм өрөөн дотор хүлээж байгаа совин татна. Дотор нь арай уужирч, нүд бүрэлзэхээ болимогц, совин үнэн байжээ гэдгийг ухаарлаа. Канистерын цэнэглэгч суурь хоосон байв. Канистер алга болжээ. Тэрийг л хулгайлах гэж аавынх нь нүдийг ухжээ. Үр дагаврыг нь төсөөлөх ч аргагүй. Бүх юм буруугаар эргэчихлээ. Антиматери бол аюулгүй, найдвартай энергийн эх үүсвэр гэдгийг нотлох гэж байсан дээж алдагджээ. Гэхдээ, ийм дээж байгаа гэж хэн ч мэдээгүй шүү дээ. Гэхдээ л, үнэн болж байгаа юмыг яалтай ч билээ. Нэг хүн л мэдэж байж дээ. Хэн гэдгийг нь, харин, Витториа төсөөлж ч чадахгүй байв. СЭРН-д болж байгаа бүх юмыг мэддэг гэдэг Колэр хүртэл юу ч мэдээгүй нь илт байлаа. Аавыг нь гоц авьяасаас нь болж хөнөөжээ. Бүсгүйн зүрх эмгэнэн эмтрэх тэр эгшинд, өөр нэг гансрал сэтгэлийг нь эзэмдэв. Бүр янхийж, яс сийгтэл эзэмдэв. Өөрийгөө зүхэх өршөөлгүй гансралд авган, бүсгүй арчаагүй сулбайн уналаа. Зүхсэн, ялласан, гэмшсэн зэм! Витториа өөрөө л аавыгаа ийм дээж гаргаж авья гэж ятгасан билээ. Аав нь үгүй гээд байхад, зөрүүдэлсээр байгаад шүү. Тэрнээс болоод аавыг

минь алчхаж. *Граммын дөрөвний нэг*. Гал, дарь, дотоод шаталтын хөдөлгүүр гэх мэт буруу гарт очсон бүх технологи шиг антиматери үхлийн аюултай. Антиматери бол сүйрлийн зэвсэг юм. Хүчирхэг, сөрөх аргагүй зэвсэг. СЭРН-д байсан сууриасаа салсан болохоор канистер цагтай бөмбөг болжээ. Цаг нь ч урсаад эхэлчихсэн. Цаг дуусмагц... Гялбасан цэгээн гэрэл. Аяндын нүргэлээ. Эгшин зуур галав юүлнэ. Ганц гялс гээд л хар нүх үлдэнэ. Бүр том гэгч хар нүх шүү. Аавынх нь сод билгийг сүйрлийн хэрэгсэл болгох вий гэх айдас бүсгүйн цусанд хор мэт гүйнэ. Антиматери бол террористуудын мөрөөдлийн зэвсэг болно. Металл биш болохоор металл илрүүлэгчид өртөхгүй, химийн элемент үгүй болохоор сургуультай нохойд баригдахгүй, цэрэг цагдаагийнхан олсон ч гэсэн унтраах боломжгүй. Тэгээд одоо цаг тоолоод эхэлчихсэн... Ландон юу хийхээ мэдэхгүй балмагдана. Энгэрийнхээ алчуураа гарган Леонардо Ветрагийн нүдийг хучлаа. Витториа Naz-Mat-ын хоосон өрөөний үүдэнд зогсоод эмгэнэл, айдас хоёртоо авгчихсан зэрзийж байв. Ландон аясан түүн рүү очих гэтэл Колэр болиуллаа. «Ландон гуай!» Колэрын царай ямар ч хувиралгүй хэвээр. Тэр чихэнд нь шивнэ гэж байгаа бололтой, өөр рүүгээ дохив. Ландон дурамжхан тонгойж, Витториа ард нь зэрзийсэн хэвээр үлдлээ. Колэр: «Та бол мэргэжилтэн нь шүү дээ. Тэр Иллюминатигийн новшнууд антиматериар юу хийх гээд байгааг мэдмээр байна» гэж шивнэв. Ландон оюунаа хөвчлөх гэж хичээнэ. Эргэн тойрон солиотой юм болж байсан ч гэсэн, хамгийн эхний реакц нь тун логиктой байлаа. Академик няцаалт. Колэр өөрийнхөө бодолтой зууралдсаар л. Гэхдээ огт боломжгүй бодол. «Иллюминати гэж байхгүй, Колэр гуай! Би батална. Хэн ч энэ хэргийг хийсэн байж магадгүй, бүр СЭРН-ий нэг ажилтан Ветра гуайн нээлтийг олж мэдээд, энэ төсөл үргэлжилбэл аюултай гэж бодсондоо ч хийсэн байж магад шүү дээ». Колэр нүүрээ нүүрэнд нь тулгаж хараад: «Та үүнийг ухамсартай хүний хийсэн хэрэг гэж бодоо юу? Эндүүрэл биз дээ! Леонардог алсан этгээд ганц антиматерийг л авах гэж зорьсон байна. Түүгээр нэг юм хийх гэж байгаа нь илт». «Террорист ажиллагаа юу?» «Хэт хөнгөмсөг тайлбар байна». «Гэхдээ, Иллюминати террорист байгаагүй юм шүү». «Наадахаа Леонардо Ветрад хэл!» Энэ хорон үг үнэний ортой билээ. Леонардо Ветраг Иллюминатигийн тэмдгээр тамгалсан. Тэр хаанаас гарч ирсэн тэмдэг вэ? Хэн нэгэн энэ ариун тэмдгийг ашиглан хийсэн хэргийнхээ мөрийг бусад руу чиглүүлэх гэсэн гэж бодоход хэтэрхий төвөгтэй байлаа. Өөр нэг учир байх л ёстой. Ландон боломжгүй гэлгүй байдлыг харгалзан тааварлахыг оролдов.

Иллюминати идэвхтэй хэвээр юм бол, тэд антиматерийг хулгайлсан юм бол, түүгээр юу хийх гэж байж болох вэ? Онилох бай нь юу байж болох вэ? Тархинд нь ганц хариулт шууд орж ирсэн ч, Ландон түүнийг даруй няцаав. Иллюминати цор ганц өстөн дайсантай байсан. Гэхдээ, түүнийхээ эсрэг өргөн далайцтай террорист ажиллагаа явуулах боломж огт үгүй. Огт төсөөлшгүй байлаа. Иллюминати хүний амь хөнөөж байсан, гэхдээ тун няхуур сонгосон хувь хүнийг! Үй олноор хөнөөнө гэдэг тэдний зан арай л биш байв. Ландон зогтусав. Тэгээд дахин бодвол энэ тухай хоосон шидийн санаа л эргэлдэнэ - антиматери, эрдмийн энэ аугаа ололтыг хөнөөн устгахын тулд хэрэглэнэ гэдэг.

Ландон дэмий боломжгүй бодлоо хөөхийг оролдоно. «Энд терроризмоос илүү логик хариулт байгаа» гэж гэнэт хэлэв. Колэр цааш ярихыг нь хүлээн түүн рүү харлаа. Ландон бодлоо цэгцлэхийг оролдов. Иллюминати санхүүгээр дамжуулан асар их эрх сүр олж авсан юм. Тэд банкнуудыг хянадаг байсан. Цул алтан гулдмай ч өмчилдөг байсан. Тэр бүү хэл, дэлхий дээр цор ганц байдаг Иллюминатигийн очир гэгдэх ямар ч сэвгүй асар том очир эрдэнэ хүртэл байдаг гэсэн цуу яриа бий. Ландон «Мөнгө. Антиматерийг иймэрхүү зорилгоор хулгайлсан байх» гэв. Колэр үл итгэн ширтэнэ. «Санхүүгийн ашиг олох гэж үү? Ганц дусал антиматерийг хэнд зарах вэ дээ?» «Дээжийг нь биш» гэж Ландон үргэлжлүүлэн: «Харин технологийг нь. Антиматерийн технологи их үнэд хүрнэ. Магадгүй хэн нэгэн дээжийг хулгайлж, шинжлэх гэж байгаа байх». «Үйлдвэрлэлийн тагнуул гэж үү? Гэхдээ тэр канистерын зай нь дуустал хорин дөрөвхөн цаг л байна шүү дээ. Ямар нэг юм олж мэдэхээсээ өмнө, тэд чинь дэлбэрээд үхчихнэ гэж мэд». «Дэлбэрэхээс нь өмнө цэнэглэх ч юм билүү. Энд СЭРН-Д байгаа шиг цэнэглэгч суурь хийчхэж болно шүү дээ». «Хорин дөрөвхөн цагийн дотор уу?» гэж Колэр тавлангуй хэлээд: «Бүр схемийг нь хамт хулгайлсан байсан ч гэсэн, тийм суурь хийхэд цагаар биш бүр бүтэн сар сараар ажиллах хэрэгтэй болно доо.» «Тийм шүү!» гэж Витториа их л сулхан шивнэв. Хоёул эргэж харлаа. Витториа тэр хоёр руу арай чүү алхан аядаж байв. «Тийм шүү. Тэр канистерт урвуу инженерчлэл хийгээд, цагтаа бэлэн болгож чадахгүй. Дэлгэцийг нь хийе гэхэд л долоо хононо. Хувьсах шүүлтүүр, сэвс-шураг, эрчим хүчний кондиционерийн хайлц, бүгд тодорхой энергийн төвшинд зохицсон байх учиртай.» Ландон барайв. Боломжгүй байх нь! Антиматерийн хавх гэдэг, зүгээр л ханын залгуурт залгачихдаг эд биш ажээ. СЭРН-ээс л гарсан бол тэр канистер эргэж ирэхгүй устах замдаа орж, хорин дөрөвхөн цаг үлджээ. Их л аягүй цорын ганц дүгнэлт үлдлээ. «Интерпол руу утастах хэрэгтэй» гэж Витториа хэлэв. Өөрт нь хүртэл дуу нь хүнийрхүү сонсогдов. «Бид зохих албаны хүмүүсийг яаралтай дуудах хэрэгтэй». Колэр толгойгоо сэгсрээд: «Үгүй шүү!» гэв. Бүсгүй гайхан: «Яагаад? Юу гэсэн үг вэ?» «Таны аав, та хоёр намайг их л хүнд байдалд орууллаа даа». «Захирал аа! Тусламж хэрэгтэй шүү дээ. Тэр хавхыг олоод, хүн амьтан хөнөөхөөс нь өмнө, СЭРН-д авчрах хэрэгтэй байна. Энэ бол бидний хариуцлага». «Бидний хариуцлага бол бодох» гэж Колэр зандрангуй өнгөөр нот хэлэв.» Энэ байдал СЭРН-д тун аюултай байж магадгүй байна». «Та чинь СЭРН-ий нэр хүндийн тухай л бодоод байгаа юм уу? Тэр канистер том хотод дэлбэрвэл яахыг мэдэж байна уу? Хагас бээрийн радиуст юу ч үгүй болно. Том хотын есөн хороолол шүү дээ!» «Таны аав, та хоёр тэр дээжийг бий болгохоосоо өмнө энэ тухай бодох хэрэгтэй байсан байх шүү!» Энэ үг Витториаг цохиод авах шиг болов. «Гэхдээ бид болгоомжловол зохих бүх арга хэмжээг авсан шүү дээ». «Харамсалтай нь хангалттай биш байж!» «Гэхдээ хэн ч антиматерийн тухай мэдээгүй шүү дээ». Энэ үг, харин, утгагүй сонсогдож байв. Мэдээж, хэн нэгэн мэдэж байжээ. Тэр нь хэн бэ гэдгийг л олох хэрэгтэй байв. Витториа хэнд ч хэлээгүй ажээ. Тиймээс хоёрхон боломж л байлаа. Юун түрүүнд, аав нь хэн нэгэнд энэ нууцыг охиндоо мэдэгдэлгүй задалсан: гэхдээ энэ боломжгүй, учир нь чухам аав нь л өөрөө нууц хадгална гэж тангараг өргөхийг санаачилсан ажээ. Эсвэл аав охин хоёрыг хянаж байсан байж таарна. Гар утсаар хянаж болох л доо. Витториаг аялан явах зуур, хэд хэдэн удаа гар утсаар ярьсан. Тийм их юм гар утсаар ярьж орхисон гэж үү? Үгүй байлтай. Цахим-шуудан байж болно. Гэхдээ тэр ч бас нууцлалтай шүү дээ. СЭРН-ий аюулгүйн систем? Тэдэнд мэдэгдэлгүй хянаж байсан байж болох уу? Хэн ч тэгж чадахгүй гэдгийг бүсгүй сайн мэдэж байлаа. Гэхдээ л, болсон юм болдгоороо болжээ. *Аавыг минь хөнөөчихжээ.* Тэр бодол бүсгүйг шийдмэг алхам хийхэд түлхэв. Тэр шортныхоо хармаанаас гар утсаа шүүрэн авлаа. Колэр бүсгүй рүү хурдалж, хүчтэй гэгч ханиалгасаар

очиход, нүд нь ууртай яа эргэлдэж байв.»Хэн рүүгээ утастаад байгаа юм бэ?» «СЭРН-ийн оператор руу. Тэндээс Интерпол руу ярьж болох байх». «Бодоод үзээч!» гэж Колэр хахаж цацан, түүнийг болиулахаар сарвалзана. «Чи ийм гэнэн юм уу? Тэр канистер энэ дэлхийн хаана ч байж магадгүй. Ямар ч мундаг тагнуулын газар хүчээ бүрэн дайчлаад тэртэй, тэргүй цагт нь олж чадахгүй». «Тэгээд юу ч хийхгүй суугаад байх уу?» гэж Витториа утсаа өгөхгүйг хичээн Колэрын гартай зууралдав. Ийм бие муутай хүнтэй тэмцэлдэж байгаадаа зовниж байвч, захирлын ярьж, хийж байгаа нь хэрээс хэтэрчээ. «Бид ухаантай алхам хийх ёстой. Тэртэй тэргүй тусалж чадахгүй албаны хүмүүсийг дуудаж СЭРН-ий нэр хүндийг сэвтгээгээд яах вэ дээ. Ядаж одоо биш. Бодож байж больё» гэж Колэр сарвалзан зүтгэнэ. Колэр уул нь зөв юм яриад байлаа. Гэхдээ иймэрхүү зөв яриа уулаасаа ёс суртахуунгүй байдгийг Витториа гадарлах билээ. Аав нь хянуур, хариуцлагатай эрдэм, хүний дотоод сайн сайханд итгэсэн ёс суртахууны хариуцлагын төлөө амьдарсан билээ. Витториа үүнд нь бас л гүн бат итгэдэг байсан ч арай өөр өнцгөөр карма-гийн үүднээс хардаг байв. Бүсгүй Колэроос нүүр буруулан гар утсаа онгойлгов. Колэр: «Ингэж болохгүй ээ» гэлээ. «Болиулах гээд оролд л доо». Колэр хөдөлсөнгүй. Витториа, Колэр яагаад хөдлөөгүйн нь учрыг төдөлгүй ойлгов. Газрын ийм гүнд гар утасны сүлжээ барихгүй байх нь аргагүй билээ. Хм! гээд Витториа цахилгаан шат руу зүглэв.

Хэсэг 26

Хассассин чулуун хонгилын үзүүрт зогсоно. Гартаа барьсан бамбар нь дүрэлзсэн хэвээр, агаарт хярвас, үхширсэн хөвд, тоос холилдон үнэртэнэ. Эргэн тойрон аниргүй. Хонгилтойгоо чацуу настай зэвэрсэн төмөр хаалга өмнө нь бат хөндөлдөнө. Хаалганы цаадах хүнд нот итгэсэн хассассин түнэр харанхуйн дунд хүлээсээр. Цаг бараг л дөхөж байлаа. Нэг хүн дотроос нь тэр хаалгыг онгойлгож өгнө гэж Янус хэлсэн сэн. Хассассин түүнийг дайснаа дотроос нь тэгж урвуулж чадсаныг бишрэвч барахгүй ажээ. Даалгавраа гүйцэтгэхийн тулд тэр хаалга онгойхыг шөнөжингөө хүлээхэд бэлэн байсан тэр яагаад ч юм бэ хаалга удахгүй нээгдэхийг мэдэж байлаа. Тэр итгэл төгс хүнд зүтгэж байгаа билээ. Минутын дараа, яг цагтаа, хаалганы цаанаас хүнд түлхүүр түрхийн шургах чимээ чанга гэгч сонсогдов. Төмөр төмөртэйгөө хяхтнан хавирч, зэвэрсэн шураг гийнан тачигнана. Төдөлгүй хаалгыг дарж бэхэлсэн гурван төмөр эрэг нэг нэгээрээ тайлагдаж эхлэв. Түлхүүр эргэх тоолон зуу зуун жил барьцалдсан шураг эргэн дотроо гол зурам гийнан эргэнэ. Төд удалгүй бүх эрэг тайлагдан унав. Тэгээд хэсэг үхээрийн аниргүй боллоо. Хассассин түүний хэлсэн ёсоор яг таван минут амьсгаа даран хүлээв. Цаг боллоо. Хамаг биеэр цахилгаан гүйх шиг болоод хүчээ хуралдуулан түлхлээ. Хүнд төмөр хаалга цэлийтэл нээгдэв.

Хэсэг 27

"Витториа, би чамайг ингүүлэхгүй шүү» гэж Колэр амьсгаадан хэлэв. Цахилгаан шат Naz-Mat-аас өгсөх бүр тэр улам түргэн амьсгаадна. Витториа түүний замыг хаан зогсжээ. Гэр шиг нь санагддаг байсан энэ лаборатори одоо харь хөндий мэт санагдах тул амгалан байж болох нөмөр хайх шиг л харагдана. Гэхдээ одоо эмгэнэл цөхрөлөө мартан, хөдлөх хэрэгтэй байлаа. Утас барих газарт л хүрэх хэрэгтэй. Роберт Ландон түүний хажууд чимээгүй байдгаараа л байж байв. Витториа энэ эр хэн юм бол гэж гайхаж явлаа. *Мэргээжилтэн?* Колэр үүнээс илүү тодорхой хэлж болохгүй байсан юм байх даа? *Ландон гуай, аавыг чинь*

хөнөөсөн этгээдийг олоход тусална. Ландон яаж ч тусалж чадахгүй байв. Найрсаг, уриалагхан нь сайхан ч гэсэн, ямар нэг юм нуугаад байх шиг. Энэ хоёр хоёулаа нуугаад байна. Колэр дахиад л түүн рүү дөхөж очив. «СЭРН-ийн захирлын хувиар би эрдмийн ирээдүйн өмнө хариуцлага хүлээдэг юм. Хэрэв чи энэ хэргийг олон улсын дуулиан болгон хувиргавал СЭРН ...» «Эрдмийн ирээдүй ий?» гэснээ Витториа түүн рүү эргэж харав. «Та тэгээд тэр антиматери СЭРН-ээс алдагдсан гэж хүлээн зөвшөөрөхгүй, хариуцлагаас мултрах гээ юу? Бид өөрсдөө үй олон хүний амь насанд аюул учруулчихаад, дараа нь ойшоохгүй бултах уу?» «Бид биш» гэж Колэр арцан: « Та. Танай аав, та хоёр.» Витториа ширэв татав. «Амь насны тухайд бол, чухам түүнийг чинь л би яриад байна» хэмээн Колэр үргэлжлүүлэн: «Антиматерь технологи энэ ертөнцийн амьдралд чухал нөлөө үзүүлнэ. Гэтэл СЭРН нэг муу хэл амнаас болж дампуурвал, бүгдээрээ хохирно. Хүн төрөлхтний ирээдүй маргааш тулгарах асуудлыг өнөөдөр шийдэж буй СЭРН шиг газар, тан шиг, танай аав шиг эрдэмтдийн гарт байгаа шүү дээ». Витториа, Колэрын «Эрдэм бол бурхан мөн!» гэдэг лекцийг өмнө нь сонсож байсан ч, санал нийлдэггүй байлаа. Өнөөгийн амьдралын бүх асуудлын талыг нь эрдэм өөрөө бий болгосон билээ. «Дэвшил» гэдэг Байгаль эхийн даажигнал гэлтэй. Колэр: «Эрдмийн хөгжил эрсдэл дагуулдаг нь зүй. Дандаа л ийм байсан. Сансрын хөтөлбөр, генетик судалгаа, анагаах ухаан: - бүгд л алдаа хийдэг. Эрдэм алдааныхаа уршгийг ямар ч үнээр хамаагүй даван туулах ёстой. Бүх хүний тусын тулд шүү дээ» гээд л тасралтгүй үглэнэ. Витториа - Колэрын ёс суртахууныг эрдэмтэй хэрхэн холбон ярьдаг авьяасыг гайхаж байв. Хүйтэн логик сэтгэлгээ - сэтгэл зүрхийг нь үхүүлчихсэн учраас л суу билэгтэй болчихсон юм болов уу гэж харагддаг. «Та СЭРН хүн төрөлхтний ирээдүйд амин чухал газар учраас ёс суртахууны асуудал огт падгүй гэх гээд байна уу?» «Надтай ёс суртахуун битгий ярь. Та тэр дээжийг гаргаж авч байхдаа л ёс суртахууныхаа хэм хэмжээг аль хэдийн даваад арилчихсан - одоо энэ байгууллагыг аюулд учруулчихаад байна. Харин би энд ажиллаж байгаа гурван мянган физикчийн ажлын байрыг төдийгүй, аавын чинь нэр хүндийг аврах гэж оролдож байна. Аавынхаа тухай бодооч. Аавыг чинь - хүнийг үй олноор хөнөөх зэвсгийг зохион бүтээгч гэж дурсах ёсгүй шүү дээ.» Энэ үг Витториагийн зүрхийг шимшрүүлэв. *Би л аавыгаа ийм юм хий гэж ятгасан шүү дээ. Би л буруутай.* Хаалга онгойход Колэр ярьсаар л байв. Витториа цахилгаан шатнаас гараад, утсаа гаргаж, дахин залгав. Сүлжээ байхгүй л байлаа. Чөтгөр гэж! Тэр гарах хаалга руу зүглэв. «Витториа зогс!» Хойноос нь хурдалж яваа захирлын дуу таглаарх гэж байгаа юм шиг сонсогдоно. «Зогсооч! Хоёулаа ярих хэрэгтэй байна.» «Basta di parlare! (ита. Ярих хэрэгтэй байна)» «Аавыгаа сана! Тэр юу хийх байсан бол гэж бодооч!» гэж Колэр мэтгэнэ. Бүсгүй алхалсаар л. «Витториа, би чамд бүх үнэнээ хэлээгүй нь үнэн л дээ». Витториагийн хөл нь удаашраад явчихлаа. «Би юу бодохоо мэдэхгүй байсан юм. Би чамайг л хамгаалах гэсэн юм. Чи яамаар байгаагаа л хэлчих! Хоёулаа энэ асуудлыг хамтдаа шийдэхээс өөр замгүй шүү дээ» гэж Колэр хэлэв. Лабораторийн яг голд нь хүрээд Витториа зогслоо, гэхдээ эргэж харсангүй. «Би антиматерийг олмоор байна. Аавыг минь хэн алсныг мэдмээр байна» гээд гээд цааш нь дуу нь гарсангүй. Колэр санаа алдаад: «Витториа, хэн аавыг чинь алсныг бид мэднэ ээ. Уучлаарай!» гэв. Витториа эргэж харав. Нүд нь гайхсан шинжтэй атлаа, уур хилэнгээр дүрэлзэж байв. «Юу гэнэ ээ?» «Би чамд яаж хэлэхээ мэдэхгүй байсан юм. Энэ их төвөгтэй л дээ...» «Аавыг минь хэн алсныг та мэдэж байсан гэв үү?» «Бидэнд тун магадтай таамаг байгаа. Алуурчин бараг л нэрийнхээ хуудсыг үлдээсэн байсан. Тэгээд л, би Ландон гуайг дуудсан юм. Нэг бүлэглэл энэ хэргийг хийсэн гээд байгаа юм». «Бүлэглэл ээ? Террористууд юм уу?» «Витториа! Тэд л граммын дөрөвний нэг антиматерийг аваад явсан шүү дээ.» Витториа өрөөний нөгөө талд зогсоо Ландон руу харав. Бүх юмыг ухаарч эхлэх

шиг. Энэ ч бас зарим зүйлийг тайлбарлаж байна шүү. Яагаад энэ тухайгаа өмнө нь хэлээгүй юм бэ гэж Витториа гайхав. Колэр уул нь албаны хүмүүс рүү утастсан юм байж. Тэр ч тодорхой. Роберт Ландон гэх энэ америк хүн тэвхгэр, консерватив, хараажийн хурд эр байна. Өөр хэн ч байх билээ дээ? Витториа анхнаасаа л тааварлах ёстой байж. Бүсгүй түүн рүү найдлага төрсөн байртай харав. «Ландон гуай! Аавыг минь хэн алсныг мэдмээр байна. Танай агентлаг антимаатерийг олж чадах эсэхийг бас мэдмээр байна». Ландон тулгамдан: «Манай агентлаг уу?» гэв. «Та АНУ-ын тагнуулын газраас яваа юу?» «Үнэндээ бол ... үгүй л дээ». Колэр дундуур нь орж: «Ландон гуай - Харвардын их сургуулийн урлагийн түүхийн багш хүн байгаа юм» гэв. Витториагийн нүүр рүү нь хүйтэн ус цацчих шиг болчхов. «Урлагийн түүхийн багш аа?» «Энэ хүн бол шашны бэлгэдлийн мэргэжилтэн» гээд Колэр санаа алдав. «Витториа! Аавыг чинь нэг сатаанлаг бүлэг алсан бололтой байгаа юм» гэлээ. Витториа юу хэлснийг сонссон боловч ойлгож чадсангүй болов. Сатаанлаг бүлэг ээ? «Тэр бүлгийг Иллюминати гэдэг юм». Витториа Колэр рүү нэг, Ландон руу нэг харж, тоглоом шоглоом хийгээд байгаа юм болов уу ч гэж бодов. «Иллюминати юу? Баварийн Иллюминати юу?» Колэр дуу алдан: «Та тэр тухай сонссон юм уу?» Витториа уурласандаа, нулимс нь цэлэлзэхийг мэдрэв. «*Баварийн Иллюминати: Дэлхийн шинэ журам*. Стив Жаксоны компьютер тоглоом. Энд байгаа техникчдийн тал нь л лав интернетээр энэ тоглоомоор тоглодог.» Дуу нь харгиад явчхав. «Гэхдээ би ойлгосонгүй...» Колэр тээнэгэлзэн, Ландон руу харав. Ландон толгой дохиод: «Их түгсэн тоглоом шүү. Эртний нөхөрлөл дэлхийг эзэлж байна гэж тоглодог юм. Түүхчилсэн гэх үү дээ. Гэхдээ, би тэрийг Европт тоглодог гэж мэдээгүй юм байна». «Та нар юу яриад байгаа юм бэ? Иллюминати ч гэх шиг. Компьютер тоглоом ч гэх шиг?» гээд л Витториа цамнаж эхлэв. «Витториа! Иллюминати гэж бүлэг л аавыг чинь алсны хариуцлагыг хүлээх бололтой дог оо» гэж Колэр хэллээ. Витториа, нүдэндээ цийлгэнэх нулимсаа унахгүй барих гэж тэвчээртэй еэ хичээнэ. Сэтгэлээ барьж, байдлыг логик дүгнэх гэж оролдоно. Гэвч хичээх тусам, ойлгож чадахгүй байв. Аавыг нь хөнөөчихсөн байдаг. СЭРН-ийн аюулгүйн системийг нэвтэрчихсэн байдаг. Түүний бүтээсэн бөмбөг хаа нэгтээ дэлбэрэх гээд, цаг урсаад байдаг. Захирал гуай сатаан шүтлэгтэй эртний нөхөрлөлийг олох гээд, нэг урлагийн түүхийн багшийг авчирчихсан байдаг. Витториа гаслантай яа ганцаардан гансрав. Тэр явах гээд эргэтэл, Колэр урдуур нь орж таслав. Тэгээд, хармаандаа ямар нэг юм тэмтчин байснаа, факсын үнгэчсэн цаас гаргаж ирээд, бүсгүйд өгөв. Витториа цаасан дээрх зургийг хараад, айдаст автан сэрвээгээр нь сийгээд явчихлаа. «Тэд тамгалж орхисон юм. Цээжийг нь тамгалчхаад явчихсан юм» гэж Колэр хэлэв.

Хэсэг 28

Силвий Боделок гэх нарийн бичиг хүүхэн мэгдэн сандарчээ. Тэр захирлынхаа өрөөний үүдээр эргэлдэнэ. *Чөтгөр чинь хааччихдаг байна аа? Яалтай билээ?* Энэ өдөр нэг л жигтэй. Колэртэй ажиллахад, хэзээ ч ийм жигтэй байж магадгүй ч, өнөөдөр Колэр бүр онцгой хачин байлаа. «Леонардо Ветраг олоод ир!» гэж Силвийг өглөө ирмэгц дууджээ. Силвий ч түүн рүү нь хариуцлагатай нь аргагүй пэйжердээд, утастаад, бүр е-мэйлдээд байдаг, хариу байдаггүй. Бүр таг чиг. Колэр янцаглан өрөөнөөсөө гараад, Ветраг өөрөө хайхаар явав бололтой. Хэдэн цагийн дараа, Колэр эргэж ирэхдээ, зэвхий даачихсан байлаа. Тэр уулаасаа л бие муутай, зэвхий царайтай боловч тэр удаа бүр жигтэйхэн зэвхийчихсэн байжээ. Тэгээд, өрөөндөө ормогцоо дотроос нь тас түгжлээ. Дотор нь модем нь дуугарч, утастаж, факсдаж, хүнтэй яриад байгаа нь сонсогдож байв. Удалгүй, Колэр дахиад л өрөөнөөсөө гараад явлаа. Тэгээд ирсэнгүй. Колэрыг дахиад л хачин авирлаа биз гээд Силвий тоохгүй орхих гэж үзсэн боловч,

ээлжит эмчилгээндээ амжиж, тогтсон цагтаа ирээгүй болохоор зовниж эхлэв. Колэрын бие муу болохоор, өдөр болгон цагийн тариа хийлгэдэг, бага ч атугай оройтож орхивол амьсгалын цочролд орж, тасралтгүй ханиалган, дээрээс нь муухай авир нь дэндээд, солиотой юм шиг болчихдог байжээ. Заримдаа Максимлиан Колэр үхэх гээд л тэгээд байдаг байх гэж Силвий бодно. Бүсгүй пэйжирдэж сануулъя юу гэж бодсон ч, Колэр дандаа юм мартдаггүй ой тогтоолтоороо гайхуулдаг болохоор нь, больжээ. Өнгөрсөн долоо хоногт, Колэр өөрийг нь өрөвдсөн нэг эрдэмтэнд галзууртлаа хилэгнэн, хатангир хөл дээрээ босч ирээд, компьютерынхоо гарыг толгой руу нь шидэж орхисон билээ. Колэр хан өрөвдүүлэх тун дургүй нэгэн билээ. Силвий энэ удаа захирлынхаа эрүүл мэндэд зовнихоос өөр, бас нэг тулгамдсан асуудал гараад байлаа. СЭРН-ийн оператор таван минутын өмнө утастаад, захиралтай нэг жигтэй газраас ярих гээд байна гэжээ. «Тэр одоогоор байхгүй байна даа» гэж Силвий хэлжээ. СЭРН-ийн оператор хэн утастсан тухай түүнд хэлэв. Тэгэхэд нь, Силвий хөхрөх аядаад: «Тоглоом хийгээд байгаарай, чи!» гэжээ. Тэгснээ итгэж чадалгүй нүүр нь барайгаад: «Таны утасны ID -г чинь харвал» гэснээ хувьс хийв. «Аа, мэдлээ, мэдлээ. Та болвол ...» Бүсгүй санаа алдан: «Үгүй ээ, зүгээр зүгээр. Түр барьж байгаарай гээд хэлчихгүй юу. Би захирлыг бушуухан олоодохье. Тэгье. Ойлгож байна аа, тэгэлгүй яах вэ. Удахгүй ээ.» Гэхдээ, Силвий захирлаа олж чадахгүй байв. Гурвантаа утастсан боловч удаа бүр: «Таны залгасан дугаар сүлжээний тойргоос гарсан байна» гэж өөдөөс хэлээд болдоггүй. Сүлжээний тойргоос гарсан ий? Уул нь хэр хол яваа аж дээ? Силвий Колэрын пэйжир рүү залгаж үзэв. Дахин залгав. Хариу байдаггүй. Нэг л жигтэй. Сүүлдээ бүр зөөврийн компьютер рүү нь э-мэйлдэж үзлээ. Таг чиг. Тэр хүн яг л газар дэлхийгээс оргүй алга болчихсон юм шиг байлаа. Яалтай билээ хэмээн тэр хавчигнана. СЭРН-ий бүх байгууламжийг нэгжиж гүйлтээ биш гэхэд, хаана ч байсан захирлын анхаарлыг татаж чадах нэг арга байгааг Силвий ухаарав. Мэдээж Колэр таашаахгүй нь лав: гэхдээ утсан дээр байгаа хүнийг хүлээлгээд байж болохгүй байлаа. Бас тэр хүнд, захирал алга байна гэж хэлэлтэй биш. Силвий шийдвэр гаргав: гэхдээ ийм зоримог шийдвэр гаргасандаа өөрөө ч гайхаж байлаа. Колэрын өрөө рүү явж ороод, ширээнийх нь ард байдаг төмөр хайрцаг руу дөхөв. Тагийг нь онгойлгоод, хяналтын самбарыг нь харж байснаа, зөв товчоо олов бололтой. Гүнзгий гэгч амьсгалаад, микрофон авлаа.

Хэсэг 29

Витториа яаж цахилгаан шатанд орсноо мэдсэнгүй: гэхдээ л, тэнд зогсоод дээшилж явав. Колэр ард нь байх агаад хүнд гэгч амьсгаадна. Ландон зовнисон байдалтай, түүн рүү нэвг ширтэх ажээ. Тэр гараас нь нөгөө факсыг авч эвхээд, пиджакнийхаа энгэрийн халаас руу, нүднээс нь далд хийчхэв. Гэхдээ л, нөгөө дүрс нүдэнд нь үзэгдээд байлаа. Цахилгаан шат өгссөөр, Витториа харин түнэр харанхуй руу шумбасаар. Рара! (ита. Аав аа!) Бүсгүй сэтгэлдээ аавтайгаа уулзах шиг. Дурсамжийнхаа баян бүрдэд, эгшин зуур тэр аавтайгаа хамт байлаа. Витториа есөн настай байх агаад Швейцарийн цэлмэг тэнгэр дор, уулын уруу цагаан уул цэцгэн дундуур өнхөрнө. Рара! Рара! Леонардо Ветра хажууд нь инээн зогсоод: «Яасан бэ, ангель минь?» гэв. «Аав аа!» гээд л тэр аавынхаа дэргэд дэвхэцнэ. «Юу юм бэ гээ дээ!» «Юу ч болоогүй л байна шүү дээ, эрх минь! Тэгж асууж яах юм бэ?» «Асуу л даа.» Аав нь мөрөө хавчаад: «За, за. Юу юм бэ?» Охин, тэгмэгц цалгитал инээд алдаад: «Юу юм бэ гэвэл байна шүү дээ, юм бүхэн матери л юм даа. Хад, мод, атом, бүр шоргоолж идэштэн хүртэл! Юм бүхэн матери!» Аав нь хөхрөв. «Чи үүнийг мэдчихээ юү?» «Ухаантай байна уу?» «Бяцхан Эйнштейн минь дээ». Охин урвайснаа: «Тэр чинь шал муухай үстэй. Би зургийг нь харсан». «Гэхдээ, их ухаантай хүн шүү. Би тэр хүн юу хийсэн тухай чамд ярьсан биз дээ?» Охины нүд

нь бүлтийснээ: «Үгүй шүү, аав аа! Та гэхдээ ярьж өгнө гэж амласан шүү дээ!» «E=MC2!» Аав нь өхөөрдөнгүй жуумалзаад: «E=MC2!» гэв. «Тоогоор биш ээ! Би танд хэлсэн шүү дээ. Би тоонд дургүй!» «Тоонд дургүй чинь ямар сайн хэрэг вэ? Яагаад гэвэл охидыг тоо бодуулж болдоггүй юм». Витториа гайхаад: «Болдоггүй ээ?» «Мэдээж болохгүй. Бүгд л мэднэ шүү дээ. Охид хүүхэлдэйгээр тоглодог байхгүй юу. Харин хөвгүүд тоо боддог юм. Тоо охидын ажил биш. Жаахан охидод тоо заана гэвэл би л лав зөвшөөрөхгүй.» «Юу? Тэгвэл шударга биш байна шүү». «Дүрэм бол дүрэм. Жаахан охидод тоо заахгүй». Витториа айсан бололтой. «Гэхдээ, хүүхэлдэй чинь уйтгартай шүү дээ». Аав нь: «За яах вэ, би чамд тоо зааж өгч болох л юм, гэхдээ би баригдчихвал ...» гээд, эргэн тойрноо их л айсан байртай харлаа. Витториа аавыгаа дагаж харснаа: «За, за. Тэгвэл, та надад чимээгүй заагаад өгчих, тэгэх үү» гэж шивнэн гуйлаа. Цахилгаан шатны түчигнэн, Витториа сэргэв. Аав нь алга болжээ. Нүдээ нээв. Бодит байдал түүнийг хүрээлэн авч, бүх бие нь хүйт даах шиг боллоо. Бүсгүй Ландон руу харав. Зовнил тодорсон нүд нь дулаахан, ялангуяа, хажууд хүйтэн егзэр Колэр байхад, бүр ангель шиг харагдана. Удалгүй, нэгэн аймшигт бодол толгойд нь цахилан орж ирэв. *Антиматери хааччихав?* Хариулт нь хэдхэн эгшний дараа тодорхой болов.

Хэсэг 30

Максимлиан Колэр. Та өрөөндөө яаралтай ирнэ үү! Цахилгаан шатны хаалга гол танхимд онгоймогц, нарны хурц гэрэлд Ландоны нүд гялбав. Цагаан хоолойгоор зарласан дуу цуурайтаж дуусаагүй байтал, Колэрын тэргэнцрийн бараг л бүх цахим тоноглол дор бүрээ жингэнэж эхлэв. Пэйжир, утас, е-мэйл гээд л бүгд л анивчин, жонгиноно. Колэр тонгойж, тэр бүхэнтэйгээ сандчин ноцолдох ажээ. Захирал сүлжээний тойрогт тодрон гарч ирлээ. *Колэр захирал аа! Өрөө рүүгээ утастаарай!* Цагаан хоолойгоор Колэрын нэрийг дуудахад, тэр бараг л татвага хийх шахав. Дээшээ их л ууртай харж, илэрхий зовнисон шинжтэй болчихлоо. Дараа нь Ландон, Витториа хоёр руу харав. Тэр гурав хэсэг зогтусахад, хооронд нь байсан хурц маргаан алга болчихсон, ямар нэг юмыг зэрэг мэдэрсэн харагдана. Колэр гэнэт тэргэнцрийнхээ гараас утсаа татвасхийн авлаа. Тэгээд, дотоод шугам руугаа залгаснаа, бүгшин ханиаж эхлэв. Витториа, Ландон хоёр түүнийг хүлээнэ. Утас нь залгагдав бололтой: «Колэр захирал байна» гэлээ. Тэгснээ: «Өө, тийм үү..? Би газар доогуур, сүлжээний тойргоос гадна байсан юм аа» гэв. Тэгээд цаад хүнээ хэсэг чагнаж байснаа, гөлийсөн нүд нь бүлтийгээд ирлээ. «Хэн гэнэ ээ? За, за. Намайг холбоодох доо». Тэгээд хэсэг чимээгүй болов. «Сайн байна уу? Намайг Максимлиан Колэр гэдэг. Би СЭРН-ийн захирал байна. Та хэн билээ?» Колэрыг утсаар ярих зуур Витториа, Ландон хоёр чимээгүй харж зогсов. «Энэ тухай утсаар ярих нь ухаангүй хэрэг шүү. Би одоохон очлоо» гэж гэнэт хэлснээ бүгшиж эхлэв. «Намайг Леонардо да Винчи нисэх буудал дээр хүлээж байгаарай. Дөчин минутын дараа шүү». Колэрын амьсгаа тасалдаж эхлэв. Тэгснээ, эхэр татан бүгшиж, сүүлийн үгээ арай л гэж хэллээ. «Канистерыг түргэн олоорой... Би одоо очлоо» гээд утсаа таслав. Витториа, Колэр рүү сандран очиход, юм ярих тэнхээгүй болчихсон байлаа. Бүсгүй утсыг нь шүүрч аваад, СЭРН-ийн эмнэлгийн түргэн дуудав. Ландон, шуурганд өртөх гэж байгаа завь шиг түгших мөртөө, юу ч хийж чадахгүй зогслоо. *Намайг Леонардо да Винчи нисэх буудал дээр хүлээж байгаарай* гэх Колэрын дуу цуурайтна. Ландон өглөөнөөс хойш ухааныг нь олохгүй мухардаад байсан юм энэ эгшинд гэнэт тодорхой боллоо. Оюун нь нэг л саруул болчих шиг, ямар нэг шидийн хүч тайлагдахгүй байсан оньсогын хариуг хэлээд өгөх шиг. *Амбиграмм. Алагдсан гэлэн эрдэмтэн. Антиматери. Одоо тэгээд ...* бай! Леонардо да Винчи нисэх буудал гэдэг ганц л зүйлийг хэлж байна. Ийнхүү Ландон ганц л эгшинд болоод байгаа

зүйлийн бүх учгийг тайлж, итгэлээ. *Таван килотонн. Гэрэл үүсгээ!* Цагаан халаадтай хоёр сувилагч гол үүдний танхимаас, тэдэн рүү чиглэн айсуй. Колэрын дэргэд ирмэгцээ тонгойн, хүчилтөрөгчийн хошуувч өмсгөв. Түүгээр явж байсан эрдэмтэд тэдэнд зай тавьж өгнө. Колэр хоёронтоо гүнзгий амьсгаа авмагцаа, хошуувчаа суга татан аваад амьсгалын дутагдалд орсон хэвээрээ, уухилан байж, Витториа, Ландон хоёр руу хандан «Ром ... Ром» гэлээ. Витториа гайхан: «Ром оо? Антиматери Ромд байгаа юм уу? Хэн танд тэгж хэлээ вэ?» гэв. Колэрын царай цонхийн, нүд нь цийлгэнэнэ. «Швейцарийн ...» гэж хэлж амжаагүй байтал, сувилагч хүчилтөрөгчийн хошуувчийг нь углаадавав. Түүнийг авч явахаар зэхэх зуур, Колэр салганан байж Ландоны гарыг атгалаа. Ландон толгой дохив. Тэр юу хийхээ мэдэж байлаа. «Яваарай, очоод над руу яриарай» гэж Колэр хошуувчны цаанаас сулхан хэлэх эгшинд, сувилагч нар түүнийг яаралтай нь аргагүй түрж одов. Витториа холдон одох Колэрыг харан, балмагдан зогсоно. Тэгээд, Ландон руу эргэж «Ром оо? Тэгээд бас юун ... Швейцар билээ?» гэв. Ландон гараа мөрөн дээр нь тавиад, бараг л шивнэх шахам «Швейцарь жард. Ватиканы үнэнч албатууд» гэлээ.

Хэсэг 31

Х-33 хэмээх агаар сансрын хөлөг тэнгэрт халин, Ромын зүг шунгинан одов. Бүхээгт Ландон чимээгүй сууна. Сүүлийн арван таван минутыг арай чүү санах ажээ. Тэр Витториад Иллюминатигийн тухай ярьж, заналт дайсан Ватиканых нь тухай дурдан, өрнөн буй явдал үүнтэй холбоотойг хэлжээ. Энд би юу хийж явна вэ гэж Ландон бодлоо. Боломж гарсан дээр нь би гэртээ харьдаг байж дээ. Гэхдээ л, тийм боломж гараагүй билээ. Эрүүл ухаан нь түүнийг Бостон руугаа харих нь дээр гэх авч, эрдмийн сонирхол нь өөр зүг рүү хөтлөөд байв. Иллюминати тарж замхарсан хэмээн итгэж байсан бүхэн нь ердөө л нэг сайн тооцсон цуурхал төдий байсныг гэнэт сэхээрэв. Бүр зарим нэг нь бат нотлогдлоо. Энд бас хүн чанарын асуудал байна. Колэр өвчтэй, Витториа өнчирсэн болохоор, хэрэв Ландоны мэдсэн судалсан нь хэрэг болж чадах л юм бол энд хамт байх нь ёс суртахууны үүрэг байлаа. Өөр бас олон шалтгаан бий. Хүлээн зөвшөөрөхөд жаахан ичгэвтэр ч гэлээ, антиматери Ромд байгааг мэдээд зөвхөн Ватикан хотын хүн амын амь насанд төдийгүй, өөр бас нэг юманд их л зовнисон билээ. Тэр бол урлаг байлаа. Дэлхийн урлагийн сор болсон бүтээл, хамгийн том цуглуулга одоо цагтай бөмбөг дор байв. Микланжело, Винчи, Бернини, Боттичелли гээд л суут хүмүүсийн урлагийн үнэлж баршгүй 60 000 орчим бүтээлийг Ватиканы музей 1407 гаруй танхимд хадгалдаг билээ. Шаардлагатай гарвал, энэ бүх бүтээлийг нүүлгэж чадах болов уу гэж Ландон гайхна. Ийм боломж бараг л байхгүй. Эдгээр бүтээлийн олонхи нь тонн тонн жинтэй. Түүнчлэн, Систин цогчин, Гэгээн Петерийн ордон, Брамантегийн хийсэн Ватиканы музей рүү өгсдөг эрүүлгэн шат гэх мэт барилга байшин нь өөрөө хүний бүтээлч оюуны дээжис болсон эд билээ. Канистер дэлбэрэхэд хэдий хэр хугацаа үлдсэн бол гэж Ландон бодож явлаа. Витториа намуухан дуугаар: «Ирсэнд баярлалаа» гэлээ. Ландон гүн бодлоосоо сэрлээ. Витториа бүхээгийн хажуу эгнээний харалдаа суужээ. Флорес-цент гэрлийн бүдэг туяанд бие галбир нь бараг л гэрэлтэж байх шиг, дотоод сэтгэлийнх нь аура цацарч байх шиг. Амьсгал нь гүн, жигд хэмнэлтэй болжээ, гэхдээ нүд нь өөрийгөө хадгалах гэсэн оч шударга ёс, гомдол нэхэн, эцгээ үгүйлсэн охины хайраар гялалзаж байв Витториад шорт, ханцуйгүй цамцаа солих завдал гараагүй тул түүний хөрслөг бор хөл нь онгоцны

хүйтэн бүхээгт даарсан бололтой. Ландон юу ч бодолгүй пиджакаа тайлж бүсгүйд өглөө. «Америк хөлөг баатар уу даа» гээд талархсан харц түүнд шагнав. Агаарын хуйлралаас болж онгоц багахан донслоход, Ландоны зүрх нь амаар гарчих шиг болов. Цонхгүй битүү бүхээгт тэр эвгүйтэн, өөрийгөө уужим саруул газар байна гэж төсөөлөхийг хичээнэ. Осолд орохдоо, тэр уужим саруул газар байснаа санав. Түнэр харанхуй. Тэр дурсамжаа бодлоосоо хөөх гэж оролдлоо. Өнгөрсөн явдал шүү дээ. Витториа түүнийг харан сууснаа: «Та бурханд итгэдэг үү, Ландон гуай?» гэв. Ингэж асуухад нь Ландон цочиж орхив. Бүсгүй зүгээр л байцаах гэхээсээ илүү үнэн голоосоо асуусанд тэр бүр балмагдчихав. Би бурханд итгэдэг билүү? Энэ урт нислэгийг давахын тулд тэр арай илүү дээгүүр төвшний яриа гарах болов уу гэж бодож байлаа. Мухар сүсгийн төөрүүлэгч. Найзууд маань намайг ингэж дууддаг юм даа. Ландон шашны тухай маш олон жил судалсан боловч тэр сүсэгтэй хүн биш байв. Сүсэг бишрэлийн чадал, сүм хийдийн буян, шашин олон хүнд хүч өгдгийг хүндэлдэг ... гэхдээ эрдмийн хүний хувьд «үл итгэх» ёстой бөгөөд үнэхээр бурханд итгэдэг хүний хувьд энэ үл итгэл хамгийн том саад болдог гэдэг билээ. Би итгэмээр л байдаг юм гэж өөртөө хэлэх шиг болов. Витториа шүүмжилсэн ч үгүй, өөлсөн ч үгүй, зүгээр л: «Тэгээд, яагаад та итгэдэггүй юм бэ?» гэлээ. Ландон нуг нуг хөхрөнгөө: «Энэ тийм ч амар биш л дээ. Сүсэгтэй байна гэдэг сүсгээ дагахыг шаардана: ариун ивээл зэрэг гайхамшиг байдаг гэдэгт сэтгэлээсээ үнэмших хэрэгтэй болно. Тэгээд, бас ариун сахил гэж байна. Библи, Коран, Бурхны шашин бүгд л нэг адил шаардлага, нэг адил залхаалтын тухай номлодог. Бүгдээрээ л намайг тодорхой сахилыг сахихгүй бол тамд унана гэдэг. Бурхан байдаг бол ертөнцөд тийм журам тогтооно гэдэгт би л лав итгэхгүй дэг» гэв. «Та оюутнууддаа ийм юм ярьж хуурдаггүй байлгүй дээ». Ландон тэгж хэлэхийг нь сонсоод, барьц алдан: «Юу гэнэ ээ?» гэв. «Ландон гуай, би таныг, хүмүүс бурхны тухай ярьдаг юманд итгэдэг үү гэж асуугаагүй. Харин таныг бурханд итгэдэг үү гэж асуусан. Энэ хоёр чинь өөр шүү дээ. Ариун судар, түүх, шастир, үлгэр, домог бол хүн амьдралын утга учрыг олох гэсэн эрэл төдий. Би таныг тэр үлгэр домгийг юу гэж боддог вэ гээгүй. Таныг бурханд итгэдэг үү гэж л асуусан. Та одот тэнгэрийг ширтэн хэвтэхдээ ариун зүйл мэдэрдэг үү? Танд бурхны бүтээлийг харж байна гэж санагддаг уу?» Ландон нэлээд бодлогошров. «Би зүгээр л сонирхсон юм аа» гэж Витториа уучлал эрэв. «Зүгээр ээ, би ...» «Та хичээл дээрээ сүсэг бишрэлийн тухай маргадаг л биз дээ?» «Маргаж ч дуусахгүй дээ». «Та тэгээд дандаа л өөнтөгч чөтгөр болоод маргааныг нь дэвэргэнэ биз?» Ландон инээвхийлэн: «Та ч гэсэн багш болмоор юм байна шүү» «Үгүй ээ, гэхдээ жинхэнэ багш хүн намайг сургасан юм. Аав минь Мёбиус хуйлаасны хоёр талд мэтгэдэг хүн байсан юм». Ландон Мёбиус хуйлаасыг санаандаа дүрслэн инээв. Мёбиус хуйлаас гэж зэрвэс харвал хуйлсан цаасны зураг: харин сайн харвал цаас дандаа нэг талаараа харагдаж, нөгөө тал гэж огт байхгүй санагдана. Анх тэр зургийн М. С. Эшэрийн бүтээлээс үзсэн билээ. «Би юм асууя, тэгэх үү, Ветра авхай?» «Зүгээр л Витториа гэл дээ. Ветра авхай гэхээр эмгэн болчихсон юм шиг санагдаад байдаг юм». Ландон гэнэт өөрийнхөө насыг бодсоноо дотроо санаа алдав. «Витториа. Намайг Роберт гэдэг». «Юм асууя гэл үү?» «Тийм. Эрдэмтэн хүний хувьд, бас католик гэлэнгийн охины хувьд чи шашныг юу гэж боддог вэ?» Витториа нүднийхээ урдуур унжсан үсийг илж хойшлуулснаа: «Шашин бол хэл шиг, эсвэл хувцас шиг эд л дээ. Бид өсч бойжсон туршлагадаа татагддаг. Гэхдээ эцэст нь, бид нэг л юмыг ойлгодог. Амьдрал утга учиртай гэж. Тиймд нь ч, биднийг бүтээсэн тэр хүчинд бид талархдаг шүү дээ». Ландонд сонин байлаа. «Тэгвэл христийн буюу лалын шашинтай байх эсэх нь зүгээр л хаана төрснөөс л шалтгаалдаг гэсэн үг үү?» «Мэдээж биш байна гэж үү дээ? Дэлхий дээрх энэ бүх шашин дандаа ижил юм номлодгийг хар л даа». «Тэгэхээр сүсэг бол тохиолдлын чанартай гэсэн үг үү?» «Үгүй ээ.

Сүсэг бол түгээмэл зүйл. Харин сүсгээ ухамсарлаж байгаа арга нь өөр өөр гэх үү дээ. Зарим нь Есүст залбирч, зарим нь Мекка руу бадарчилж, зарим нь атомоос жижиг бөөмс судалж байна. Эцсийн дүндээ бид өөрсдөөсөө ч илүү чухал тийм л үнэнийг эрэлхийлж байгаа шүү дээ.» Оюутнууд маань ийм тодорхой ярьдаг байгаасай гэж Ландон бодов. Би ч гэсэн өөрийгөө ийм тодорхой илэрхийлж чаддаг ч болоосой. «Бурхны тухайд? Чи бурханд итгэдэг үү?» Витториа хэсэг чимээгүй сууснаа: «Эрдэм - бурхан байдаг гэж хэлээд байгаа юм. Харин миний сэтгэл намайг бурхныг ухаарч чадахгүй гэдэг. Зүрх минь намайг ухаарах гээд хэрэггүй гэдэг». Ямар товч тодорхой хэлчхэв ээ гэж Ландон бодов. «Тэгэхээр та бурхан байдагт итгэдэг, гэхдээ бид тэр бурхан гэгч эрийг огт ойлгож чадахгүй гэсэн үг үү?» «Тэр эмийг гээч» гэж бүсгүй инээвхийлэн хэлээд: «Танай уугуул Америкчууд чинь харин зөв дууддаг байсан юм шүү». Ландон хөхрөн: «Хөрст дэлхий эх гэж үү?» «Гэйа гэж. Энэ ертөнц бүхэлдээ нэг организм. Бид бол зүгээр л өөр өөр зорилготой эс төдий. Гэхдээ, бүгдээрээ хоорондоо холбоотой. Бие бие руугаа зүтгэнэ. Бүгд зорилгодоо ч зүтгэнэ». Витториа руу харж байснаа түүнд олон жил мартагдсан мэдрэмж төрөн, сэтгэл нь хөдлөв. Бүсгүй гялалзсан сайхан хар нүдтэй . . . шингэн цээл хоолойтой ажээ. «Ландон гуай! Танаас дахиад нэг юм асууя». «Роберт гээч!» Ландон гуай гэхээр өвгөн болчихсон юм шиг санагддаг юм. Гэхдээ би ч өвгөрч л байна даа. «Дургүйцэхгүй бол, та яаж яваад Иллюминатитай орооцолдчихсон юм бэ?» Ландон урьд болсон явдлыг эргэн дурсав. «Үнэндээ бол, мөнгөнөөс болсон юм». Витториа цочин: «Мөнгө өө? Зөвлөгөө өгдөг байсан юм уу?» Ландон буруу ярьснаа мэдэж, хөхөрч гарав. «Үгүй дээ. Мөнгө гэж дэвсгэрт л байхгүй юу даа.» Тэгээд өмднийхөө халаасыг уудалж хэдэн мөнгө гаргалаа. Нэг долларын дэвсгэрт олов. «Би АНУ-ын долларын дэвсгэрт бүхэлдээ Иллюминатигийн бэлгэдлээр дүүрснийг мэдээд л, шашин судлалыг сонирхож эхэлсэн юм». Витториа хэлсэнд нь үнэмших эсэхээ мэдэхгүй нүдээ жирвийлгэн харав. Ландон түүнд мөнгөн дэвсгэрт гардууллаа. «Ар талыг нь хар даа. Зүүн талд нь байгаа Төрийн их тамгыг үз дээ.» Витториа дэвсгэртийг эргүүлж харснаа: «Пирамид уу?» гэв. «Яг үнэн. Пирамид АНУ-ын түүхэнд ямар хамаатайг мэдэх үү?» Витториа мөрөө хавчлаа. «Яг зүйтэй» гэж Ландон хэлээд: «Ямар ч хамаагүй шүү дээ». Витториа инээх гэсэн шиг мушилзсанаа: «Тэгээд яагаад танай төрийн их тамга дээр энэ дүрс бүр төв хэсэгт нь байдаг юм бэ?» «Жигтэй түүх байгаа юм даа. Пирамид бол Иллюминатигийн эх туйл руу өсөн дэвжихийн бэлгэдэл юм. Дээр нь юу байгааг хар даа». Витториа дэвсгэртийг харж байснаа: «Гурвалжин дотор нүд байна». «Энийг чинь *тринакриа* гэдэг юм. Гурвалжин дотор нүд байхыг өөр хаа нэгтээ харсан уу?» Витториа хэсэг чимээгүй сууснаа: «Харсан байх аа. Гэхдээ сайн санахгүй байна». «Дэлхий даяар Масоны ложид энэ тэмдгийг ашигладаг юм» «Энэ чинь Масоны тэмдэг юм уу?» «Уул нь биш. Иллюминатигийнх. «Гялбах дельта» гэдэг юм. Гэгээрэн өөрчлөхийн уриа. Нүд нь Иллюминатигийн хаа сайгүй нэвтэрч, юм бүхнийг тольдох чадварыг бэлгэдэж байгаа мэлмий юм. Гялбах гурвалжин нь гэгээрэл гэсэн үг. Гурвалжин чинь бас Грекийн дельта үсэг шүү дээ. Үүгээр математикт...» «Өөрчлөлт, шилжилтийг тэмдэглэдэг» гэж Витториа өгүүлэв. Ландон мишээж: «Би эрдэмтэн хүнтэй ярьж байгаагаа мартчихаж» гэв. «Тэгэхээр та АНУ-ын төрийн их тамга гэгээрсэн, бүхнийг тольдсон өөрчлөлтийг уриалж байгаа юм биз дээ?» «Зарим наадахыг чинь Дэлхийн шинэ журам гэдэг юм». Витториа цочих шиг болов. Тэгээд дэвсгэрт рүү дахин харлаа. «Пирамидын доор байгаа бичиг дээр . . . *Novus... Ordo...* » «*Novus Ordo Seclorum* » гэж Ландон таслаад: «Дэлхийн секулярь шинэ журам гэж байгаа юм» гэлээ. «Секулярь гэдэг нь шашингүй гэсэн үг биз?» «Тийм, шашингүй гэсэн үг. Энэ уриа Иллюминатигийн гол зорилгыг тодорхой илтгэж байгаа юм, гэхдээ хажууд нь бичсэн үгтэй шал өөр агуулгатай байгаа биз? Бид бурханд итгэнэ». Витториа төөрөлдөж эхлэв бололтой:

«Тэгээд, энэ бүх бэлгэдэл чинь яаж яваад дэлхийн хамгийн хүчирхэг мөнгөн дэвсгэрт дээр гарчихдаг билээ?» гэв. «Дийлэнх эрдэмтэн Дэд ерөнхийлөгч Хэнри Уаллас наадахыг чинь хийсэн гэдэг юм. Тэр Масоны дээд зиндааны хүн байсан. Бас Иллюминатитай холбоотой байсан, гэхдээ гишүүн нь байсан уу, эсвэл зүгээр л хүчтэй нөлөөнд нь байсан уу гэдгийг мэддэггүй юм. Гэхдээ Уаллас л энэ тамганы дүрсийг ерөнхийлөгчид өргөсөн байдаг». «Яаж тэр вэ? Ерөнхийлөгч нь яагаад энийг тэгээд зөвшөөрчихсэн юм бэ?» «Тэр ерөнхийлөгч нь Франклин Делано Рузвельт байсан юм. Уаллас түүнд Novus Ordo Seclorum гэдэг нь Шинэ үйл (New Deal) гэсэн үг гээд л хэлчихсэн юм.» Витториа нэг л үл итгэнгүй байдлаар: «Рузвельт энэ тэмдгийг Эрдэнэсийн департаментад өгч хэвлүүлэхээсээ өмнө өөр хүнд үзүүлээгүй юм уу?» «Хэрэггүй байсан юм аа. Уаллас тэр хоёр чинь анд нар байсан юм». «Анд аа?» Ландон инээвхийлэн: «Түүхийн номоо хааяа сөхөж байх хэрэгтэй шүү. Франклин Д. Рузвельт чинь өөрөө алдартай масон байсан юм» гэлээ.



Мёбиус хуйлаас

Хэсэг 32

Х-33 онгоц Леонардо да Винчи нисэх буудлын дээгүүр нэг эргээд, доошлож эхлэхэд, Ландон гүнзгий амьсгаа авлаа. Витториа хажууд нь нүдээ аниад, байдлыг ухаарах гэсэн шиг сууж байна. Онгоц газардмагцаа, хувийн ангаар руу жирийлгэв. Нисэгч хитгээс гарч ирмэгцээ: «Удаан ниссэнд уучлаарай. Олон хүнтэй хотын дээгүүр нисэх шуугианы дүрэм гэж нэг юм бий л дээ». Ландон цаг руугаа харав. Тэд ердөө гучин долоон минут л ниссэн байлаа. Нисэгч гарах хаалгыг нээгээд: «Юу болоод байгааг хэлээд өгөх хүн байна уу?» гэв. Витториа, Ландон хоёрын хэн нь ч дуугарсангүй. «За за» гэж тэр хэлэнгээ суниаж зогсоно. «Би бүхээгтээ сэрүүцүүлэх сэнс, хөгжим хоёртойгоо байж байя. Зөвхөн Гарт бид хоёр...» гэлээ. Ангаараас гарахад халуун наран шарж байлаа. Үд хэвийжээ. Ландон пиджакаа тайлж, мөрөн дээгүүрээ давуулан үүрлээ. Харин Витториа нар руу харан гүнзгий амьсгаа аваад, нарны туяа түүнд ямар нэг увдист эрчим өгч өгч байгаа юм шиг таатай яа ээв. *Газар дундын тэнгис ээ гэж* гэж Ландон хэлэхдээ, хэдийн хөлөрчихсэн байлаа. Витториа нүдээ аньсан хэвээр: «Хүүхэлдэйн кино үзэхэд арай хөгшдөх юм биш үү» гэлээ. «Юу гэнэ ээ?» «Бугуйн цагийг

чинь хараад л. Онгоцон дотор анзаарсан юм». «Аа, энэ үү?» Хүмүүс цагийг нь гоочилдогт тэр аль хэдийн дасчихсан байлаа. Аав ээж хоёр нь энэ цуглуулгад зориулсан Микки Маустай цагийг авч бэлэглэж билээ. Миккигийн татваганасан царай, цаг заасан гар нь тэнэг юм шиг боловч Ландон энэ насандаа үүнээс өөр цаг зүүж үзээгүй ажээ. Ус нэвтгэрдэггүй, харанхуйд гэрэлтдэг энэ цаг усанд сэлэхэд ч, их сургуулийн харанхуй чулуун гудмаар явахад ч хэрэгтэй байдаг байжээ. Оюутнууд нь түүнийг яагаад ийм цаг зүүдэг юм бэ гэхэд нь зүрх сэтгэлдээ ямагт залуу байх ёстойгоо цагаа харах тоолон санадаг юм гэж хариулдаг байлаа. «Зургаа болж байна» гэж Ландон хэлэв. Витториа нүдээ аньсан хэвээрээ толгой дохиод: «Манай унаа ирж явах шиг байна даа» гэлээ. Ландон алсаас хүрчигнэх чимээ сонсож, дээшээ унтууцан харав. Хойд зүгээс жижигхэн зэгзгэр нисдэг тэрэг гүйлтийн зам руу дөхөж явлаа. Ландон Андийн нурууны Палпа хөндийд Назка гэх элсний зургийг дээрээс ажиглах гэж нэг удаа нисдэг тэргээр нисч байсан, тэгэхэд нэг их таалагдаагүй билээ. *Нисдэг хайрцаг.* Сансрын хөлгөөр өглөөжин ниссэн тэр Ватиканаас машин ирж угтах байх гэж бодож байжээ. Даанч тэгсэнгүй. Нөгөө нисдэг тэрэг хурдаа саасаар агаарт хэсэг дэнжигнэн байснаа чанх доошилж эгц урд нь газардав. Тэр тэрэг цагаан өнгөтэй, бөөрөн дээр нь бамбай дэвсгэр дээр хоёр сэрзийсэн түлхүүр загалмайлан зөрүүлсэн Ромын Папын титэмтэй сүлдийг дүрсэлжээ. Ландон энэ сүлдийн бэлгэдлийг сайн мэддэг байлаа. Энэ бол Ватиканы уламжлалт сүлд - *Ариун ширээт* буюу ариун сэнтий - Гэгээн Петерийн эртний сэнтийн билэгдэл байлаа. *Гэгээн зэгзээхэй минь дээ* хэмээн нисдэг тэрэг газардах агшинд Ландон бодолхийлэв. Тэр Ватиканд ийм зэгзгэр тэрэг ганц байдаг, түүгээрээ Ромын Папыг нисэх буудал, хурал чуулган, Гандольфо дахь зуны өргөө рүү нь хүргэдгийг мартчихсан байжээ. Гэхдээ л, Ландон машинаар явахыг илүүд үзэх байлаа. Нисэгч бүхээгээсээ үсэрч буугаад, тэр хоёрыг чиглэн ирэв. Витториа түүнийг хараад: «Энэ тэгээд манай нисэгч юм уу?» хэмээн нэг л аягүй болчхов. Ландон бас яг тэгж бодож байсан болохоор: «Нисэх, эс нисэх. Асуудал ийм л байна» гэв. Нисэгч яг л Шекспирийн жүжигт тоглох гэж байгаа мэт хувцаслажээ. Хөх ягаан, шар өнгийн өргөн тууш хээтэй хөвгөр цамц, шарваар өмд өмсөж, яг тийм хээтэй оймсон тойговч гутлынхаа гадуур татжээ. Хөлдөө харин углааш шиг санагдах шаахай тийрч, хар цэмбэн берет малгай тавьсан байв. «Швейцар жардын уламжлалт хувдас» хэмээн Ландон тайлбарлаад: «Микланжелло өөрөө загварыг нь гаргасан гэж байгаа, гэхдээ нэг их сайн бүтээл болоогүй юм шиг байгаа юм» гэж нисэгч ойртох эгшинд шивнэв. Тэр эрийн нүүрэнд жигтэй хувцаснаас илүү ажил хэрэг чухал байгаа нь илт байв. Тэр яг л АНУ-ын тэнгисийн явган цэрэг шиг эрэлхэг нот алхална. Швейцар жардын шилдэг цэрэг болохын тулд ямар сүрхий хатуу хүтүүг туулах хэрэгтэй болдог тухай Ландон хэзээ нэгтээ уншиж байжээ. Швейцарын дөрвөн мужаас энэ албанд татаж, харуул болохын тулд арван есөөс гучин насны, таван тохой зургаан хуруугаас доошгүй өндөртэй, Швейцарийн армид алба хаасан, гэрлээгүй Швейцар залуу байх ёстой ажээ. Эзнийхээ аюулгүйг чандлан хангах энэ цэрэг шуурхай, чадалтайгаараа дэлхийд алдартай хүчин байлаа. Харуул тэр хоёрын дэргэд ирмэгцээ: «Та бүхэн СЭРН-ээс морилж явна уу?» гэж чанга хүнгэнэсэн хоолойгоор асуулаа.: «Тийм, эрхэм ээ!» гэж Ландон хариулав. «Та нар цагаа гайхалтай барьлаа» гэнгээ тэр Х-33 руу гайхасхийн харснаа, Витториа руу эргэн: «Авхай! Танд өөр хувцас байхгүй юу?» гэлээ. «Уучлаарай, юу гэнэ ээ?» Харуул хөл рүү нь зааснаа: «Ватиканд шорт өмсөхийг хориглодог юм» гэлээ. Ландон Витториа руу харснаа гэмших шиг болов. Ватиканд эр эмгүй өвдгөөсөө дээгүүр хөлөө ил гаргах хориотой гэдгийг мартчихсан байв. Бурхныг хүндэтгэх үүднээс ийм журам тогтоожээ. «Надад байгаа нь энэ шүү дээ, яаруулсан болохоор санасангүй л дээ» гэлээ. Харуул дургүйхэн толгойгоо дохиод Ландон руу харж: «Танд ямар нэг зэвсэг байхгүй биз?» гэв. *Зэвсэг ээ?* гэж Ландон бодов. *Би*

дотуур хувцсаа ч сольчихоор юм аваагүй шүү дээ! Толгойгоо сэгсрэв. Харуул доошоо суугаад Ландоныг оймсноос нь эхлэн нэгжив. *Итгэлтэй хүн шүү* гэж Ландон бодлоо. Харуулын хүнд гар хөлөөс нь эхлэн, өмдийг нь дарж үзэн дээшилсээр, гуя цавь руу нь дөхөхөд эвгүй санагдав. Ашгүй удалгүй цээж, мөр рүү нь нэгжиж дууслаа. Ландоныг аюулгүй эсэхийг шалгаад, Витториа руу эргэж, түүнийг хөлөөс нь цээж рүү нь дагуулан харав. Витториа өөдөөс нь болгоомжлонгүй харснаа: «За ёстой, ингэж нэгжүүлэхгүй шүү!» гэлээ. Харуул бүсгүй рүү шийдсэн байртай ширтэнэ. Гэсэн ч Витториа цочирдсонгүй. «Наадах чинь юу юм бэ?» гэж шортных нь урд хармаанд төвийх дөрвөлжин зүйлийг заав. Витториа хармаанаасаа нимгэхэн гар утсаа авч өглөө. Харуул тэрийг нь аваад онгойлгох, товчийг нь дарах зэргээр шалгаж, гарт нь байгаа зүйл гар утаснаас өөр юу ч биш гэдгийг тодорхойлоод, буцааж өгөв. Бүсгүй аваад, буцаагаад хармаандаа хийлээ. Тэгээд, харуул: «Эргэ дээ» гэв. Витториа гараа өргөн, 360 хэм бүтэн эргэлээ. Харуул хянуур гэгч ажна. Ландон, Витториаг харвал биеийг нь барьсан шорт, цамцанд овойх төвийх юм алга байлаа. Харуул залуу ажиглаж дуусав бололтой. Тэгээд: «Баярлалаа танд, ийшээ морил!» хэмээн зам удирдав. Ландон, Витториа хоёр Швейцар жардын нисдэг тэрэг рүү дөхөв. Витториа дээр нь эргэлдэх сэнсэн доогуур бараг л бөхийлгүй бүхээг рүү эхэлж яваад орчхов. Ландон зогсосхийснээ: «Машин байж болоогүй юм уу?» хэмээн хошигносон, хошигноогүй хоёрын хооронд, нисэгчийн бүхээг рүү суух гэж байсан Швейцар эр рүү хэлэв. Харуул хариулсангүй. Ромын солиотой юм шиг машин барьдаг жолооч нарыг мэддэг болохоор нисэх нь хамаагүй аюулгүй юм даа гэж Ландон бодоод, нэгэнтээ гүнзгий амьсгаа аваад хүржгэнэн эргэлдэх сэнсэн доогуур болгоомжтой ёо бөхийсхийгээд, бүхээг рүү орлоо. Харуул залуу мотороо асаах зуур, Витториа араас нь: «Та нар канистераа олов уу» гэж хашхиран асуув. Харуул мөрөн дээгүүрээ гайхсан байртай харснаа: «Юугаа гэнэ ээ?» гэв. «Канистер аа. Та нар СЭРН руу канистер гэж утагтсан шүү дээ». Харуул мөрөө хавчаад: «Таны яриад байгааг мэдэхгүй байна аа. Бид өнөөдөр их завгүй байсан. Захирагч маань та нарыг аваад ир гэсэн юм. Тэгээд л тэр». Витториа Ландон руу гайхан харав. «Бүсээ бүслээрэй!» гэж нисэгч хэлэхэд хөдөлгүүр хүржгэнэж эхэллээ. Ландон суудал руугаа эргэж, бүсээ татахад, нисдэг тэрэгний умгар бүхээг түүнийг тэврээд авах шиг болов. Хөдөлгүүр хүржгэнэсээр, умар зүг Ромыг чиглэн нисч одлоо. *Ром... Caput mundi (ума. Дэлхийн нийслэл).* Энд Цезарь хаанчилж, Гэгээн Петерийг загалмайд хадсан сан. Орчин үеийн иргэншлийн өлгий. Яг төвд нь харин ... цагтай бөмбөг бий.

Хэсэг 33

Ромыг дээрээс нь харахад толгой эргэм ажээ. Байшин барилга, усан оргилуур, нуранги балгас тойрсон эртний зам талбайнуудын учир нь олодохгүй санагдана. Ватиканы зэгзгэр нисдэг тэрэг нам өндөрт, баруун хойд зүгийг барин, доороос олгойдох шингэн утаан давхарга дундуур ниснэ. Ландон Ром хотыг дээрээс нь ажиглан: мопед, жуулчны задгай автобус, Фиат маркийн үй олон машин зүг бүрт зүү орох зайгүй бүчжээ. Коянискаци буюу «тэнцвэр алдсан амьдрал» гэж Хопи нарын хэлдэг, яг тэр чигээрээ доор харагдаж байв. Витториа хажууд нь дуугүй сууна. Нисдэг тэрэг хүчтэй донслов. Дотор нь муухай оргиход Ландон алсыг харж, тайвшрах гэж оролдов. Нүдэнд нь Коллизеумийн нуранги өртөв. Тэр Коллизеумыг түүхийн ээдрээт хувь тавилангийн толь хэмээн боддог байжээ. Хүн төрөлхтний гайхамшигт бүтээн байгуулалтын бэлгэдэл болсон энэ цэнгэлдэхэд, хамгийн балмад аймшгийг баяр хөөр болгон үзүүлж, өлөн барс хоригдол ялтныг сэг зэм болгон тастаж,

боолууд амь гарахын төлөө бие биеэ хядалцан хүүрэн овоо босгож, алс газраас олзлон ирсэн экзотик санагдсан хүүхнийг бүлэглэн хүчиндэж, олны нүдэн дээр ялтныг цаазаар авахыг харуулдаг байлаа. Яг л энэ коллизеум шиг, Харвардын цэрэг эрсийн талбарт Харвард, Йелийн их сургуулийн америк хөл бөмбөгийн багууд солиорсон дэмжигчдийнхээ дунд цусаа урсган тэмцэж, эртний балмад заншлыг амилуулах шиг болдгийг Ландон бас дурсав. Нисдэг тэрэг хойшоо нисэх зуур Ландон Роман форум буюу Христээс өмнөх үеийн Ромын туурийг ажиж байв. Сүндэрлэн харагдах эртний багана булшны чулуу санагдуулж: эргэн тойрон түчигнэн буй их хотын хөл үймээнд залгиулчхалгүй, яажшуухан үлдээ юм бол гэмээр ажээ. Баруун талд Тибер мөрөн урсах агаад хот дотор том том нумран мушгирчээ. Ландон тэр дээрээс, энэ мөрөн хэр гүн эсэхийг мэдэхгүй байв. Бороо орсноос хөөс, лаг шавраар дүүрсэн усны урсгал бараан харагдана. «Урагшаа!» гэж нисэгч хэлээд өндөр авлаа. Ландон, Витториа хоёр харцаа шилжүүлэн, униар дундаас уулын толгод торойн, асар том бөмбөгөр дээвэр тодрон гарахыг үзвэл Гэгээн Петерийн ордон байлаа. Ландон Витториа руу тонгойн: «Харин тэрийг бол Микланжелло гайхалтай сайн хийсэн юм шүү» гэлээ. Ландон Гэгээн Петерийн ордонг хэзээ ч агаараас харж байгаагүй ажээ. Барилгын гантиг нүүр үдийн наранд дүрэлзэх гал шиг харагдаж байв. Гэгээнтэн, гэлэн, ангель нарын зуун дөч гаруй гайхалтай баримал бүхий Херкулесийн ордон, хөл бөмбөгийн хоёр талбай нийлүүлсэн шиг өргөн, бүр зургааг нийлүүлсэн шиг урт билээ. Ордон дотроо мөргөлчдөд зориулсан 60 000 гаруй өрөөтэй, энэ нь дэлхийн хамгийн жижигхэн улс Ватиканы ариун ширээт улсын нийт хүн амаас зуу дахин олон ажээ. Бүр гайхалтай нь, энэ цайзын аугаа сүр бараа нь хүртэл өмнөө байгаа талбайг сүүдэрлэж чадахгүй ажээ. Нил боржингоор шалласан Гэгээн Петерийн талбай, түчигнэн чихцэлдсэн Ром хотын дундах амьсгал авах уужим саруул чөлөө мэт байлаа. Ордны өмнө аугаа том зууван талбайг 284 баганатай, дөрвөн аварга нуман хаалга хүрээлэн, талбайн үлгэрлэшгүй тансгийг илтгэн зогсоно. Ойртон буй аугаа том сүмийг хараад, Гэгээн Петер энийг өөрөө харсан бол яах байсан бол хэмээн Ландон бодов. Чухам яг энэ газар түүнийг загалмайд уруу харуулан хадаж, аймшигтай яа хороосон билээ. Харин одоо, түүний шарил сүмийн бөмбөгөр оройн чанх доор, газрын гүнд таван давхар доошоо, хамгийн ариун бунханд амарлин буй. «Ватикан хийд» хэмээн нисэгч тэдэн рүү гайхалтай уриалагхан хэлэв. Ландон өмнөө нэвтэршгүй мэт сүндэрлэх бат чулуун цайз - . . . , эрх сүр, ид шид, адал нууцлагийн нөгөө ертөнцийг хамгаалдаг гэх газар дэлхийд шороо чулуугаар босгосон тэр хэрмийг харан байлаа. «Хар даа» гэж гэнэт Витториа Ландоны гарыг татан, яг доороо байгаа Гэгээн Петерийн талбай руу чанх доошоо заалаа. Ландон нисдэг тэрэгний цонх руу нүүрээ наан, харав. «Тийшээ» гэж бүсгүй дахин дахин чичлэн заалаа. Ландон харвал, доор, Гэгээн Петерийн талбайн захад баахан том жижиг машин шавж, яг л машины зогсоол болчихсон юм шиг үзэгдэнэ. Машин болгоны орой дээр сансрын таваган антен зоогоостой, тэр нь бүгдээрээ тэнгэр рүү чиглээстэй байна. Таваган антен болгон дээр: TELEVISOR EUROPEA VIDEO ITALIA BBC UNITED PRESS INTERNATIONAL гэх мэт олон танил нэр тавьжээ. Ландон антматерийн тухай мэдээ аль хэдийн тарж орхисон юм болов уу гэж хэсэг гайхлаа. Витториа бүр илүү сандран: «Яагаад ийм олон хэвлэлийнхэн цуглачхаа вэ? Юу болоод байгаа юм бэ?» гэж асуув. Нисэгч бүсгүй рүү мөрөн дээгүүрээ гайхсан байртай хараад: «Юу болоод байгаа юм бэ гэнэ ээ? Та нар мэдээгүй байгаа юм уу?» гэв. «Үгүй» гэж Витториа хэлэхэд, дуу нь хатуу чанга болчихсон байлаа. «*Il Conclave (uma. Цуурган)*» гэж нисэгч хэлээд: «Одоо цагийн дараа тэднийг гаднаас нь түгжинэ дээ. Бүх дэлхий тэднийг харж байна» гэж тайлбарлав. *Il Conclave*. Энэ үг Ландоны чихэнд удаан жингэснээ, толгой руу нь түс хийж манартал цохиод авах шиг болов. *Il Conclave, Цуурган. Ватиканы цуурган*. Би яаж

мартаж чадав аа? Саяхан, бүр мэдээгээр гарч байсан шүү дээ. Арван хоёр жилийн алдарт хаанчлалынхаа дараа, Ромын Пап арван таван хоногийн өмнө нас барсан байлаа. Паптан унтаж байхдаа, гэнэт зүрхний шигдээсээр нас барсан тухай дэлхийн даяараа мэдээлж, хэний ч санаагүй байхад ингэж өөд болсныг нь сэжигтэй хэмээн шуугилдаж байв. Харин өнөөдөр, ариун уламжлалын дагуу Папыг нас барснаас хойш арван таван хоногийн дараа Христийн ертөнцийн хамгийн хүчирхэг хүмүүс, зуун жаран таван кардинал дэлхийн өнцөг булан бүрээс Цуурган гэх хамгийн ариун ёслол үйлдэхээр, Ватикан хийдэд цуглан, шинэ Папыг сонгох гэж байлаа. Нисдэг тэрэг Гэгээн Петерийн ордон дээгүүр өнгөрөх үед, Ландон энэ дэлхийн бүх кардинал энд цуглажээ хэмээн ухаарав. Ватиканы хэрмэн доторх дотоод ертөнц доогуур нь жирэлзэн өнгөрнө. *Ромын Католик сүмийн хамгийн хүчирхэг удирдлага цагтай бөмбөг дээр сууж байх гэж.*

Хэсэг 34

Мортати кардинал Систин цогчны тансаг чимэгтэй таазыг ширтэн, оюун санаагаа бага ч атугай төвлөрүүлэн төвшитгөхийг оролдоно. Зураг, зүмбэрээр дүүрсэн дуганы хананд газар газраас ирсэн кардиналуудын дуу хоолой цуурайтна. Тэнд суугаа хүмүүс лааны бүдэг гэрэлд бие бие рүүгээ тонгойж, англи, итали, испани голдуу есөн зүйлийн хэлээр хоорондоо дүнгэцгээж байлаа. Ердийн үед энэ танхимд, жаргах нарны гэрэл харанхуйг зүсэн туяарах нь эгээ л бурхнаас гийх мэт тэнгэрлэг харагддаг ажээ. Гэхдээ өнөөдөр өөр байлаа. Нууц хадгалах уламжлалыг сахин, энэ дуганы бүх цонхийг хар хөшгөөр хаасан байв. Ингэж, өрөөнд байгаа хүнийг гадаад ертөнцтэй холбогдон, дохио илгээх боломжийг тас хаадаг ажээ. Тийм болохоор, танхим түнэр харанхуй үлдэж, лааны өчүүхэн өнчин гэрэл туссан бүхнээ ариусгах мэт туяаран, тэнд байгаа хүн бүрийг бурхан ч юм шиг, буг ч юм шиг харагдуулна. *Энэ ариун ёслолыг удирдах нь ямар таатай завшаан билээ* хэмээн Мортати бодно. Наяас дээш настай кардиналыг энэ хэрэгт хэт хөгшиднө хэмээн эл ариун ёслолд оруулдаггүй, харин далан есөн настай Мортати хурсан олныхоо дотор хамгийн ахмад нь болж таарч, ёслолыг биечлэн удирдахаар болжээ. Кардиналууд уламжлал ёсоор цуурган эхлэхээс хоёр цагийн өмнө дуглаж, найз нөхөдтэйгөө уулзан, түгжүүлэхээсээ өмнө яриа дэлгэж амжихаа бодно. Орой 7 цагт, сүүлийн Папын гарын даа ирж, цуурган эхлэх мөргөл хийгээд, гарч одох болно. Тэгээд Швейцар жард хаалга дарж, кардиналуудыг тэнд нь түгжинэ. Ийнхүү дэлхийн хамгийн эртний, хамгийн нууцлаг төрийн ёслол эхэлдэг. Кардиналуудаас хэнийг нь ч шинэ Папыг сонгон сонготол тэндээс гаргахгүй. Цуурган. Нэр нь хүртэл нууцлаг. *«Con clave (uma. Цуурга бүхий)»* гэдэг нь үг бүрчлэн «цуургаар түгжигдсэн» гэсэн утгатай юм. Кардиналууд юу ч болж байсан гадаад ертөнцтэй харилцаж болохгүй, тас хориотой. Утастахгүй. Мэссэждэхгүй. Хаалганы цаанаас шивнэхгүй. Цуурган бол гадаад ертөнцөөс яаж ч нөлөөлж чадахааргүй вакуум хорио байлаа. Энэ бүхний учир нь кардиналуудыг *Solum Deum prae oculis (латин)* ... Гагцхүү бурхныг мэлмийдээ тольдон байгаа гэж нотлохын тулд билээ. Харин сүмийн хэрмийн гадна талд, хэвлэлийнхэн пиг шаваастай, хэн дараагийн Пап болж даян дэлхийн нэг тэрбум католик шашинтныг хаанчлах вэ хэмээн таавар уралдуулна. Цуурганы дотор улс төржсөн, тулгамдсан уур амьсгал ямагт үүсдэг байжээ. Кардиналууд ариун хананы дотор, зуу зуун жилийн турш бие биедээ хор өгч, зодолдож, бүр алалдаж хүртэл байлаа. Тиймээс цуурган үхлийн аюултай хуралдаан байдаг байжээ. *Гэхдээ энэ бол эрт үед болж өнгөрсөн явдал, харин өнөө шөнийн цуурган эетэй, нигүүлсэнгүй, хамгийн гол нь хурдан болж өнгөрнө дөө* гэж Мортати бодно. Тэр тэгж л төсөөлж байв. Гэхдээ цуурган эхлэхийн өмнө санаандгүй юм болж эхэллээ. Дөрвөн кардинал жигтэй еэ алга болжээ. Ватикан хийдийн бүх хаалгыг

хааж, харуул тавьсан болохоор, тэр дөрөв холдоогүй байгаа гэж Мортати мэдэж байлаа: гэхдээ л, цуурган эхлэх мөргөл хийхэд цаг хүрэхгүй хугацаа үлдээд байгаа болохоор, түгшүүртэй байв. Хамгийн гол нь тэр алга болсон дөрөв жирийн кардиналууд биш байв. Тэд бол онцгой нэгэн байлаа. Шилмэл дөрөв. Цуурганыг удирдагчийн хувьд Мортати дөрвөн кардинал алга болсон тухай Швейцар жардад зохих шугамаар аль хэдийн мэдэгджээ. Хариу чимээ ирээгүй л байлаа. Бусад кардинал ч тэднийг алга байгааг анзаарсан бололтой, их л унтууцан шивнэлдэнэ. Бүх кардинал дундаас энэ дөрвөн кардинал л яг цагтаа ирсэн байх учиртай. Мортати кардинал энэ шөнө их л урт болох вий хэмээн эмээж эхлэв. Мэдэх юм алга даа.

Хэсэг 35

Ватиканы нисдэг тэрэг буух тойрог аюулгүй, бас чимээ шуугиангүй байх үүднээс Ватикан хийдийн алс баруун хойно, Гэгээн Петерийн ордноос хол байдаг ажээ. «Terra firma (ита. Газар хатуу)» хэмээн нисэгч, нисдэг тэрэг газардах тэр эгшинд хэллээ. Тэгээд гарч, Ландон, Витториа хоёрт гулсдаг хаалгаа нээж өгөв. Ландон бумагцаа Витториад туслахаар эргэтэл, бүсгүй ямар ч төвөггүй аль хэдийн газар буучихсан байлаа. Бүсгүйн бүх булчин шөрмөс, антиматерийг аймшигт уршиг тарихаас нь өмнө олох гээд, хөвчирчихсэн байх шиг санагдана. Бүхээгийнхээ салхины шилийг гялгар бэрзээнтээр хучсаныхаа дараа, нисэгч тэр хоёрыг дагуулан, нисэх тойргийн хажууд хүлээх гольфийн талбайд явдаг томхон шиг цахилгаан тэрэг рүү дагуулан очив. Тэрэг Ватиканы хилийн шугамыг тодорхойлсон, танкаар дайрсан ч ажрахааргүй тавин тохой өндөр цементэн хананы дагуу аниргүйхэн гүйнэ. Хананы дагуу дотор, тавь тавин метрийн зайтай Швейцар жард зогсон, дотор гадаргүй хянуур ажна. Тэрэг гэнэт огцом эргэж Одон орны гудмаар жирийлгэв. Тэнд: **ЗАСГИЙН ОРДОН ЭТИОПЫН КОЛЛЕЖ ГЭГЭЭН ПЕТЕРИЙН ОРДОН СИСТИН ЦОГЧИН** гэх мэт зам заах тэмдэг жирэлзэн өнгөрнө. Тэд хурдлан явсаар, **ВАТИКАНЫ РАДИО** гэсэн жижиг байшинг өнгөрлөө. Энэ бол Ватиканы радио гэх, бурхны үгийг сая сая сүсэгтэн олонд түгээдэг, дэлхийн хамгийн олон сонсогчтой радио программ явуулдаг газар билээ. «Attenzione (ита. Анхаараарай)» гэж нисэгч хэлээд, тойрог замаар огцом эргэлээ. Цахилгаан тэрэг даялах эгшинд Ландон нүдэндээ үзэгдэх зүйлд бараг л итгэсэнгүй. **Giardini Vaticani** (ита. Ватиканы цэцэрлэг). Ватикан хийдийн хамгийн зүрх болсон газар. Чанх өмнө нь Гэгээн Петерийн ордон араасаа сүндэрлэн харагдах агаад хүн болгонд энэ талаас нь харах завшаан гардаггүй билээ. Баруун гаршаа Хурлын ордон байх ба Папын баян тансгаараа алдартай энэ өргөөтэй, зөвхөн Версалийн ордон л өрсөлдөж магадгүй гэлцэх бөлгөө. Говернаторато буюу Ватиканы засгийн газар байрлах өргөө ард үлджээ. Зүүн урд Ватиканы музейн асар том гурвалжин шилтгээн байх ажээ. Энэ удаа, тэр музейг үзэх зав даан ч гарахгүй дээ хэмээн Ландон бодлоо. «Хүмүүс хаачаа вэ?» гэж Витториа эзгүй зөрөг, замуудыг ажиглан асуулаа. Харуул тас хар өнгөтэй, цэргийн тусгай зориулалтын цагаа хөвгөр ханцуйнхаа доороос сөхөж харлаа. Тэр цаг, цамц хоёр эрт эдүгээг харшуулах мэт жигтэй харагдана. «Бүх кардинал одоо Систин цогчинд хурсан байгаа. Цаг хүрэхгүйн дараа цуурган эхэлнэ». Кардиналууд цуурганаас хоёр цагийн өмнө Систин цогчинд хурж, дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн нөхөдтэйгөө чимээгүйхэн уулзаж, ярилцдаг заншилтайг Ландон санаж, толгойгоо дохив. Энэ хугацаа бол кардиналууд хоорондоо нөхөрлөж, ингэснээрээ сонгуулийн явцыг хурцатгахгүй байхад чиглэдэг ажээ. «Тэгвэл бусад нь хаачсан хэрэг вэ?» «Цуурганыг дуустал аюулгүйн болон нууцлалын шалтгаанаар хийдээс гаргасан байгаа». «Тэгээд энэ нь хэзээ дуусах юм бэ?» Харуул мөрөө хавчив. «Бурхан л мэднэ дээ». Жигтэй ч, үнэн үг шүү. Гэгээн Петерийн ордны

арын зүлгийн дэргэд цахилгаан тэрэг зогсож, харуул - Ландон, Витториа хоёрыг дагуулан ордны арын чулуун зөрөг, гантиг талбайгаар дагуулан явав. Талбайг өнгөрөөд, тэд гурвалжин хэлбэртэй цэцэрлэгээр дамжин, Виа Бэлведерэ гудмаар яваад, бөөрийг нь нийлүүлэн барьсан хэд хэдэн байшин өнгөрлөө. Ландон урлагийн түүх үзэх явцад, итали хэлний чамгүй мэдлэгтэй болсон бөгөөд Ватиканы хэвлэл, Эртний өлгийг сэргээн засварлах лаборатори, Шуудангийн алба, Гэгээн Аннагийн сүм гэх мэтчилэн хажуугаар өнгөрөх байшингийн хаягийг уншиж чадахгайгаа болжээ. Тэр гурав дахин нэг жижиг талбай гараад, зорьсон газраа ирэв. Швейцар жардын алба Ил Корпо ди Вижиланзатай хаяа дэрлэн, Гэгээн Петерийн ордны баруун хойшхон нь байдаг ажээ. Энэ алба жижиг, чулуун байшинд байрлана. Хоёр талдаа хаалгатай, хоёуланд дээр нь хоёр хоёр харуул чулуун хөшөө шиг зогсох ажээ. Тэр харуулууд тийм ч шоолоод байхаар харагдахгүй байлаа. Хэдийгээр нөгөө л хөх ягаан, шар өнгийн хувцсаа өмссөн ч бүгд найман тохой урт, хялгас эсгэм хурц иртэй «Ватиканы морин жад» барьжээ. Энэ харуулууд тэр морин жадаараа арван тавдугаар зууны үед Христ хөлөг баатрыг хамгаалан, үй олон лал шашинтны толгойг хяргасан гэдэг билээ. Ландон, Витториа хоёрыг үүд рүү дөхөхөд хоёр харуул урагш алхан морин жадаа зөрүүлэн замыг нь хаалаа. Нэг нь нисэгч рүү гайхан хараад: «Il pantalonì (ита. Өмд нь)» гээд Витториагийн шорт руу заав. Нисэгч тэднийг болиулан: «Il commondante vuole vederi subito (ума. Захирагч яаралтай уулзана гэсэн юм)» гэлээ. Харуулууд илэрхий дурамжхан, гэдрэг ухрав. Дотор талд агаар хүйтэн байлаа. Энэ байшинг харуул албаны захиргаа гэж хэлэхээргүй ажээ. Чимэг, зүмбэр нь гайхалтай, гол гудамд нь өлгөсөн зураг бүрийг дэлхийн аль ч музей үнэ хаян авах сан билээ. Нисэгч өргөн том шат руу зааж: «Ийшээ буугаарай!» гэлээ. Ландон, Витториа хоёр хажуугаараа, нүцгэн эрчүүдийн цагаан шавар хөшөө бүхий цагаан гантиг шатаар аажуухан буулаа. Хөшөө болгоны бэлэг эрхтний оронд навч наасан нь бусад хэсгээ бодоход арай цайвар харагдана. *Их агтлал* гэж Ландон бодолхийлэв. Их агтлал гэдэг Сэргэн мандлын үеийн гайхамшигт бүтээлийг сүйтгэсэн хамгийн том эмгэнэлийн нэг билээ. 1857 онд, IX Пьюс Пап, эдгээр хөшөөнд эр бэлэг эрхтнийг тодорхой дүрсэлсэн нь Ватиканы дотоодод янаг тачаал үүсгэж магадгүй гэж болгоомжилжээ. Тэгээд алх, хусуур авч хөшөө нэг бүрийн эрхтэнг хусч хаяжээ. Тэр Микланжелло, Браманте, Бернини нарын сонгодог бүтээлийг ийнхүү сүйтгэсэн байна. Ингэж сүйтгэсэн ороо навчаар нааж халхалсан юм гэнэ. Гэхдээ тэр чулуун бэлэг эрхтнүүдийг хураасан газар хаа нэгтээ байдаг болов уу гэж Ландон дандаа гайхдаг байлаа. «Ийшээ!» гэж харуул хэллээ. Тэд шатаар буугаад төмөр хаалганы дэргэд ирлээ. Харуул нэвтрэх нууц үгээ оруулахад, хаалга гулсан нээгдэж, Ландон, Витториа хоёр алхан оров. Босго давж ормогцоо, тэр хоёр мэл гайхаж, цэл хөхөрлөө.

Хэсэг 36 Швейцар жардын алба. Ландон үүдний дэргэд зогсоод, эрт, эдүгээ хоёр холилдчихсоныг ажиглаж байв. Холион бантан. Тэр өрөө Сэргэн мандлын үеийн номын сан байсан болтой: хуучны номын тавиур, дорнын хивс, эрээн мяраан сүлжмэл эдлэл гэх мэт хуучин эд өлөг бүрэн байх авч . . . хамгийн сүүлийн үеийн өндөр технологи анивчин, багц компьютер, факс, Ватикан цогцолборын электрон газрын зураг ханан дээр гэрэлтэн, бас том шингэн дэлгэцтэй телевиз дээр CNN суваг гарч байлаа. Хөх, шар шарваартай залуус галзуу юм шиг компьютер дээр юм шивж, ирээдүйн технологи байлгүй гэмээр чихэвч зүүсэн байх ажээ. «Энд хүлээж байгаарай!» гэж харуул хэлээд, явж одов. Тэр залуу танхимаар шувт алхаад,

гүн хөх цэрэг хувцастай өндөр гэгч хүн рүү чиглэн одлоо. Тэр хүн гар утсаараа ярьж байх агаад цэх зогсож байгаа нь арай л хэтэрхий гэдийчихсэн юм уу гэлтэй. Харуул тэр хүнд юм хэлэхэд, тэр Ландон, Витториа хоёр руу хяламхийв. Тэгээд толгойгоо дохьсноо, нуруугаараа эргэж харан утсаараа үргэлжлүүлэн ярилаа. Харуул эргэж ирээд: «Оливетти захирагч удахгүй та нартай уулзана аа» гэлээ. «Баярлалаа.» Тэгээд харуул буцаад, нөгөө хаалгаараа гарч явлаа. Ландон өрөөний нөгөө талд байгаа Оливеттийг анхааралтай харж, тэр хүн энэ улсын бүх цэргийн жанжин болохыг ухаарав. Нүдний өмнө өрнөж буй бүхнийг ажин Ландон, Витториа хоёр үүдэнд зогсоно. Цайвар хувцастай нэг харуул Италиар тушаал дамжуулан байв. «Continua cercando (ита. Эрлээ үргэлжлүүл)» гэж нэг нь утсаар хашхична. «Probasti il museo (Музейг үзэх үү)?» гэж нэг нь асууна. Аюулгүйн энэ алба бүх чадлаараа хайлт хийж байгааг ухаарахад ямар ч орчуулга хэрэггүй байлаа. Энэ бол сайн л хэрэг, гэхдээ тэд антимаатерийг олоогүй байгаа нь муу байлаа. «Дажгүй юу, хэ?» гэж Ландон Витториагаас асуув. Бүсгүй мөрөө хавчаад, ядрангуй мишээв. Захирагч гуай арай гэж утсаа таслаад, чанх тэдэн рүү дөхөхөд алхах бүрдээ томрох шиг санагдаж байв. Ландон чамгүй өндөр, хүмүүстэй дээшээ харж ярьдаггүй ч, энэ удаа тэгэхээс өөр аргагүй болжээ. Ширүүн төмөр царайг нь харвал, тийм ч аятайхан ааштай хүн биш санагдлаа. Үсээ цэрэг маягаар тачир тайруулсан түүний нүдэнд, олон жилийн цуцашгүй дасгалын үр дүн болсон шийдэмгий чанар илт байв. Цэгц алхлан ирэх түүнийг, чихнийхээ ард сонсох төхөөрөмж зүүснийг харвал, Швейцар жард гэхээс илүү АНУ-ын нууц албаны ажилтан гэмээр ажээ. Захирагч тэдэнтэй их л харь аялгатай англиар мэндлэхэд ийм том хүнд баймааргүй аяархан, бараг л шивнэсэн дуутай байлаа. Гэхдээ тун товч, цэргийн хүн шиг ярина. «Үдийн мэнд, эрхмүүдээ! Намайг Оливетти захирагч гэдэг-Швейцар жардын тэргүүн захирагч. Би танай захирал руу чинь ярьсан юм» гэлээ. Витториа дээшээ өлийн: «Гялайлаа, эрхэм ээ» гэв. Захирагч хариулсангүй, харин тэднийг дагаад яв хэмээн дохив. Тэгээд баахан цахим төхөөрөмж анивчих газраар өнгөрч, өрөөний хажуу ханан дахь хаалга руу дөхөв. Тэгээд, хаалгаа онгойлгоод: «Морил!» гэлээ. Ландон, Витториа хоёр орвол, тэнд хана дүүрэн хар цагаан дүрстэй олон дэлгэц байх агаад Ватиканы өнцөг булан бүрийг хянан, залхуутай яа цэлэлзсэн харанхуй өрөө байв. Нэг залуу харуул тэр дэлгэцүүд рүү их л анхааралтай яа харж сууна. «Fuogi (ита. орхиё)» гэж Оливетти хэллээ. Харуул хийж байснаа бушуухан дуусгаад, гарч одов. Оливетти тэр олон дэлгэцийн нэгийг нь заасаар дэргэд нь очоод, тэдэн рүү эргэн: «Энэ дүрсийг Ватикан хийдийн хаа нэгтээ байгаа камераас ирүүлж байгаа юм. Та бүхэн надад тайлбарлаж өгнө үү». Ландон, Витториа хоёр дэлгэц рүү ширтэн, зэрэг дуу алдав. Дүрс тов тодорхой байлаа. Ямар ч эргэлзээгүй. Тэнд СЭРН-ийн антимаатерийн канистер байлаа. Дотор нь металл өнгөтэй нэгэн дусал агаарт хөвж, шингэн дэлгэц дээрх тоо анивчих тоолон, гэрэлтэн үзэгдэнэ. Гайхалтай нь, канистерын ойр орчин тас харанхуй байх агаад шүүгээнд юм уу, харанхуй өрөөнд байгаа бололтой. Дэлгэцийн дээр хэсэгт : ШУУД НЭВТРҮҮЛЭГ - КАМЕР#86 гэсэн бичиг байв. Витториа канистерын доорх цаг руу хараад: «Зургаа хүрэхгүй цаг үлдэж шүү дээ» гэж Ландонд мэгдэн хэлэв. Ландон цаг руу харан: «Тэгвэл бидэнд ...» гээд тооцох гэж оролдов. Дахиад л түүний дотор нь эвгүй оргилоо. «Шөнө дунд хүртэл цаг байна» гэж Витториа үргэлжлүүлэв. Шөнө дунд гэж Ландон өөртөө шивнэв. Өрнүүн сайхан зохиомжилжээ. Урьд шөнө үүнийг хулгайлсан этгээд цагаа яс барьжээ. Оливетти энэ удаа шивнэх биш, исгэрэх мэт болж: «Энэ объект танай эд үү?» гэж асуулаа. Витториа толгой дохиод: «Тийм, эрхэм ээ. Өчигдөр манайхаас хулгайлчихсан юм. Энэ бол антимаатери гэдэг онц шатамхай бодис байгаа юм» гэлээ. Оливетти хөдөлсөнгүй. «Би шатамхай бодистой их ажилласан хүн л дээ, Ветра авхай. Гэхдээ антимаатери гэж л лав сонсоогүй юм байна» гэлээ. «Энэ шинэ технологи л доо. Бид үүнийг одоо даруй олох

хэрэгтэй, эсвэл Ватиканыг нүүлгэх хэрэгтэй болно.» Оливетти нүдээ аниад, аажуухан нээхдээ, Витториаг дөнгөж сая хэлснээ өөрчлөх болов уу гэж бодсон бололтой. «Нүүлгэх ээ? Өнөө орой энд юу болоод байгааг та ер нь гадарлаж байна уу?» «Тийм ээ, эрхэм ээ. Танай кардиналуудын чинь амь нас хутганы ирэн дээр байна. Одоо бидэнд зургаан цаг л байгаа. Та нар энийг олох талаар ямар нэг ахиц гаргав уу, үгүй юү?» Оливетти толгойгоо сэгсрээд: «Бид хайж эхлээ ч үгүй байна л даа.» Витториа эхэр татан цочоод: «Юу уу? Гэхдээ танай харуулууд хоорондоо юм эрж байгаа гэж яриад байсан шүү дээ». «Эрж байгаа нь үнэн, гэхдээ танай канистерыг биш. Манай хүмүүс та нарт хамаагүй юм хайж байгаа юм» гэж Оливетти хэлэв. Витториагийн хоолой хачин хахир болж: «Та нар тэр канистерыг хайж эхлээ ч үгүй байгаа юм уу?» гэлээ. Оливеттигийн найрсаг зан хийсчих шиг болов. Тэр тэсвэр алдсан бололтой, хорхой шиг годгонон, нүдээ жартайлган байж: «Ветра авхай! Танд зарим нэг юм ярьж өгье. Танай захирал чинь намайг энэ зүйлийг ол гэхээс өөр, ямар нэг илүү зүйл утсаар ярьж, мэдээлэл өгөхийг хүсээгүй юм. Бид маш завгүй байна, тиймээс зарим нэг шаардлагатай үнэн зөв мэдээлэл авахаас нааш, яг одоо өөр хэрэг дээр ажиллаж байгаа амин чухал хүн хүчээ танай юмыг эрхэд зориулж үнэндээ чадахгүй нь» гэлээ. «Энд хэрэгтэй гэх ганц л үнэн байна, эрхэм ээ. Зургаан цагийн дараа энэ төхөөрөмж Ватикан хийдийг чинь газартай нь самрах гээд байна» гэж Витториа арцав. Оливетти хөдөлгөөнгүй зогсоод: «Ветра авхай, та нэг юм ойлгох хэрэгтэй» гэлээ. Дуу нь хатуу болсон байв. «Хэдийгээр Ватикан хийд балар эртний мэт харагдаж байгаа ч нийтийн, хувийн гарц нэг бүрийг хүний ертөнцийн хамгийн сүүлийн үеийн мэдрэгчээр тоногдсон байгаа. Хэн ч атугай шатамхай, тэсрэмтгий бодис яаж ийгээд орууллаа гэхэд тэр дороо илэрнэ. АНУ-ын Хар тамхи мөрдөх агентлагийн бүтээсэн цацраг идэвхит изотоп, үнэр шүүлтүүр гээд шатамхай, хорт бодисын хими сигнатурийг нь илрүүлж чадах бүх багаж бидэнд бий. Хамгийн сүүлийн үеийн металл илрүүлэгч, рентген скайнер ч бий.» Витториа: «Үнэхээр сүрхий юм» гэж арцахдаа, яг л Оливеттигийнх шиг төмөр нүүртэй болчихсон байв. «даан ч антиматери бол цацраг идэвхгүй, химийн сигнатурь нь ус төрөгч шиг, тэгээд бас канистер нь хуванцар юм. Тэр төхөөрөмжүүдийн чинь аль нь ч илрүүлж чадахгүй» гэлээ. «Гэхдээ энэ чинь тэжээлийн эх үүсвэртэй л байна шүү дээ» гэж Оливетти анивчин буй шингэн дэлгэц рүү заан: «Бидэнд никел-кадмумын бага ч атугай мөрийг...» гэлээ. «Зай нь бас хуванцар юм аа». Оливеттигийн тэвчээр барагдаж буй бололтой. «Хувандар зай гэнэ ээ?» «Тэфтонтой нийлэг тослог электролит юм». Оливетти бүх биеэрээ дараад авах гэж байгаа юм шиг цээжээрээ бүсгүй рүү тонгойн: «Сеньорина, Ватикан сар бүр тэсрэх бөмбөгийн арав гаруй халдлага, заналхийлэлтэй тулгардаг юм. Би Швейцар жардыг тэсрэх бөмбөгийн хамгийн сүүлийн үеийн технологид биечлэн сургадаг. Тэгэхээр, цөмийн цэнэгтэй бэйсболын бөмбөг шиг хэмжээтэй түлшний голыг л хэлээгүй юм бол, таны яриад байгаа шиг тийм хүчтэй тэсрэх бодис одоогоор энэ дэлхий дээр байхгүйг би гадарлана шүү.» Витториа түүнийг хүйтэн төмрөөр хайрах мэт ширтэн байж: «Байгальд нууцаа дэлгээгүй юм олон байдаг юм шүү» гэлээ. Оливетти бүр нүүрээ наах шахан бүсгүй рүү ойртон, тонгойгоод: «Ингэхэд таныг хэн гэдгийг мэдэж болох сон болов уу? Та СЭРН-д ямар алба хашдаг билээ?» гэв. «Би эрдэм шинжилгээний ахлах ажилтан. Энэ онц байдлыг шийдэхээр СЭРН-ийг Ватикан хийдтэй холбон ажиллах хүн байна» гэлээ. «Бүдүүлэг сонсогдвол уучилна биз, гэхдээ хэрэв энэ үнэхээр онц байдал юм бол би танай захиралтай ярихгүй, тантай юу хийж байгаа хэрэг билээ? Та ингэхэд Ватикан хийдийг үл хүндэтгэн, шорттой ирдэг хэн гуай билээ?» Ландон хувьсхийн гайхав. Ийм тулгамдуу нөхцөлд энэ хүн арай ч хувцасны сахилыг сахиулах гэж оролдохгүй байлгүй дээ. Гэхдээ чулуун бэлэг эрхтэн Ватиканы оршин суугчдад янаг тачаал өдөөж магадгүй юм бол, шорт өмссөн Витториа Ветра бүсгүй яах ч аргагүй

үндэсний аюулгүй байдалд нь заналхийлж байлаа. «Оливетти захирагч аа!» гэж Ландон тэсрэх бөмбөг шиг болтлоо улайрсан хоёрыг сатааруулах гэж дундуур нь ороод: «Намайг Роберт Ландон гэдэг. АНУ-д шашны түүх заадаг багш хүн л дээ, СЭРН-д ямар ч хамаагүй. Гэхдээ би антиматерийн туршилтыг нүдээрээ үзсэний хувьд, Ветра авхай ер бусын аюулын тухай яриад байгаа нь үнэн юм шүү гэмээр байна. Танай шашны эсрэг байдаг хүмүүс цуурганыг тасалдуулах зорилгоор энэ зүйлийг Ватиканы дотуур хүрээнд тавьсан гэж үзэх үндэслэл байгаа юм» гэлээ. Оливетти Ландон руу давшилж: «Энд нэг богино өмдтэй хүүхэн нэг шингэний жижигхэн дусал Ватикан хийдийг газартай нь самрах гээд байна гэх, бас нэг Америк багш гуай биднийг шашны эсрэг бүлэг дайрах гээд байна гэх. Та нар надаар яг яалгах гээд байгаа юм бэ?» гэв. «Тэр канистерыг яг одоо олоодох доо» гэж Витториа хэллээ. «Ямар ч боломжгүй. Тэр чинь хаана ч байж магадгүй, гэтэл Ватикан хийд чинь асар том шүү дээ». «Танай камеруудад чинь GPS байхгүй юм уу?» «Камеруудыг нэг их хулгайлаад байдаггүй юм. Гэхдээ, энийг олох гэж хэдэн өдөр болно шүү дээ.» Витториа мэгдэн: «Цаг хугацаа өдрөөр биш цагаар тоологдож байна. Бидэнд зургаахан цаг л байна» гэлээ. «Юунд зургаахан цаг гэж?» гэж Оливеттигийн дуу улам хатуу ширүүн болов. Тэгээд дэлгэц дээр байгаа дүрс рүү заан: «Энэ тоо тоолж дуустал уу? Ватикан хийд газрын хөрснөөс арчигдтал уу? Манай аюулгүйн системийг басамжлаад байгаа хүмүүст би эелдэг байж чаддаггүй юм шүү. Энэ хананы дотор орж ирсэн ямар нэг ид шидийн механик төхөөрөмжид ч дургүй. Би зовниж байна. Ингэж зовних нь миний ажил үүрэг. Гэхдээ та нарын дөнгөж сая ярьсан юмыг огт зөвшөөрөмгүй байна». Ландон хэлээ хазаж чадалгүй, бодож байснаа хэлчхэв. «Та Иллюминати гэж сонссон уу?» Захирагчийн хүйтэн байдал бүр ч цэвдэг болчихлоо. Нүд нь цагаараад, олз руугаа үсрэх гэж байгаа араатан шиг болчхов. «Танд сануулъя. Надад ийм юманд үрэх цаг алга». «Тэгэхээр та Иллюминати гэж сонссон байх нь ээ?» Оливетти нүдээрээ сүлбэх мэт харна. «Би бол католик шашны тангарагтан цэрэг. Би мэдээж Иллюминати гэж сонссон. Тэр чинь алга болчихоод хэдэн арван жил болж байгаа шүү дээ.» Ландон халаасаа ухаж, Леонардо Ветрагийн тамгалуулсан хүүрийн зурагтай факсыг гаргаж ирээд, Оливеттид өгөв. Тэр зургийг үзэх зуур: «Би Иллюминатийг судалдаг юм» гэж Ландон хэлэв. «Би Иллюминати одоо хүртэл ажиллаж байдаг гэдэгт итгэж чадахгүй байсан юм. Гэхдээ энэ тэмдэг наана чинь гарсан, Иллюминати Ватикан хийдийн эсрэг хонзонтой зэргийг бодоод итгэхээс өөр аргагүй болоод байна л даа». Оливетти нөгөө зургийг: «Компьютерээр зурсан эвлүүлэг шив» гэснээ Ландонд буцааж өгөв. Ландон түүний тоомжиргүйг хараад мэл гайхав. «Эвлүүлэг ээ? Та тэр тэгш хэмийг нь хар л даа. Хүн хүнээс та үүний бодитой гэдгийг ...» «Чухам бодитой гэдэг чинь л алга байна. СЭРН Ватиканы бодлогыг хэдэн арван жилийн турш шүүмжилж ирснийг Ветра авхай танд дуулгахаа мартсан юм шиг байна. Тэд Бүтээлийн онолоос татгалзах, Галилео, Коперникоос албан ёсоор уучлал гуйх, ёс суртахуунгүй, аюултай судалгаа хийж байна гэж шүүмжилдгээ боль гэж манайх руу ямагт заргалддаг байсан юм. Тэгэхээр, энийг юу гэж үзэх вэ? Дөрвөн зуун жилийн өмнөх сатаанлаг шүтлэгтнүүд үй олноор устгах өндөр технологийн зэвсэг барьчихсан, дахиж гарч ирж байна гэж үнэмших үү, эсвэл СЭРН-ийн нэг хэнээтэн ирээд, сайхан зохиосон худал юм ярьж, Ватиканы ариун ёслолыг тасалдуулах гэж байна гэх үү? Би алинд нь үнэмшвэл дээр вэ?» гэлээ. «Наад зураг дээр чинь аав минь байгаа юм. *Алуулчихсан*. Та намайг тоглоом хийж байна гэж бодоод байгаа юм уу?» гэж Витториа оргилж байгаа галт уул шиг болчихсон, асуув. «Мэдэхгүй юм даа, Ветра авхай. Мэдэж байгаа юм гэвэл, ямар нэг учир замбараатай хариулт сонсохоос нааш, түгшүүр зарлах хэрэг надад байхгүй гэдэг л байна. Нягт, чанд байна гэдэг миний үүрэг... шашны зан үйл энд саруул оюунаар шийдэгдэж байгаасай гэж тэр. Тэр

тусмаа өнөөдөр». Ландон: «Ядаж цуурганыг хойшлуул л даа» гэв. «Хойшлуулах аа?» гэж Оливетти дуу алдаад: «Ямар их мунхаглал вэ? Цуурган гэдэг чинь бороо орохоор хойшлуулдаг Америк бэйсбол биш. Энэ бол чанд журамтай ариун явдал. Шинэ удирдагчаа хүлээж байгаа даян дэлхийн нэг тэрбум католикуудыг тооцоо больё, гадаа байгаа дэлхийн олон олон хэвлэл мэдээллийг больё гэсэн ч энэ зан үйлийн журам нь ариун - ямар нэг засварлах зүйл байж ч болохгүй. 1179 оноос хойш цуурган газар хөдлөлт, өлсгөлөн, тэр бүү хэл тахлыг даваад гарсан юм. Энэ бол алагдсан эрдэмтэн, юу болох нь мэдэгдэхгүй усан дуслаас болж хойшлуулаад байдаг эд биш». Витториа: «Намайг удирдаж байгаа хүн дээрээ аваачаадах» гэж шаардав. Оливетти гэнэт зогтусаад: «Би л байна шүү дээ» гэлээ. «Үгүй ээ, шашны албанаас» гэлээ. Оливеттигийн судас нь гүрдийгээд явчхав. «Бүх алба явчихсан. Швейцар жардыг тооцохгүй бол энэ Ватикан хийдэд байгаа хүмүүс бол Кардиналын чуулган. Тэд одоо Систин цогчинд байгаа». «Гарын даа яагаа вэ?» гэж Ландон пал хийтэл асуув. «Хэн ээ?» «Сүүлчийн Папын гарын даа» гэж Ландон буруу санаагүй байгаа даа гэсэндээ өөрийгөө зоригжуулан давтлаа. Папыг нас барсны дараа Ватиканы эрх мэдлийг түр хадгалах тухай нарийн зохицуулсан журам байдгийг уншсан санагдана. Шинэ хуучин хоёр Папын хооронд бүх эрх мэдэл сүүлчийн Папын хувийн туслах - гарын даад шилждэг агаад тэр л цуурганы явцыг шинэ Гэгээн эцгийг сонгогдтол хянадаг ажээ. «Миний санахаар одоо гарын даа бүх асуудлыг хариуцаж байгаа байлгүй дээ». «Il camerlingo (ита. Гарын даа)» гэж Оливетти хэлэв. «Камерлинго (ита. гарын даа) энд байгаа цорын ганц гэлэн. Сүүлийн Папын гарын хүн байгаа юм». «Гэхдээ тэр энд байгаа. Та түүнд захирагдах ёстой биз, тийм үү?» Оливетти элгээ эвхэн: «Ландон гуай. Ватиканы хууль ёсоор камерлинго цуурганы үеэр гүйцэтгэх эрх мэдлийг авдаг нь үнэн, учир нь тэр хүн уулаасаа Папад сонгогдох эрхгүй тул сонгуулийг голч байлгаж магадгүй болохоор л тэр юм. Танай ерөнхийлөгч нас барвал туслахуудынх нь нэг нь бүрэн эрхийг нь орлож, зууван танхимд суудагтай л адилхан шүү дээ. Камерлинго залуухан хүн, аюулгүй байдал, харуул хамгаалалттай холбоотой мэдлэг нь маруухан. Тиймээс аливаа чухаг бүхний нэрийн өмнөөс би энд бүхнийг хариуцаж байна даа» гэлээ. Витториа: «Түүнтэй л уулзмаар байна» гэлээ. «Болохгүй ээ. Цуурган дөчин минутын дараа эхэлнэ. Тэгэхээр камерлинго Папын албан өрөөнд бэлтгэл хийж байгаа байх. Тиймээс аюулгүйн асуудлаар түүнийг сагааруулаад хэрэггүй биз дээ». Витториа юм хэлэх гэсэн боловч, хаалга тогших чимээ хэлэх гэж байсныг тасалчхав. Оливетти хаалга онгойлголоо. Бүрэн зэвсэгтэй харуул цаана нь үзэгдэж, цагаа заагаад: «E l'ora commandante (ита. Цаг боллоо, захирагч аа)» гэлээ. Ландон өөрийнхөө цагийг харж, толгой дохив. Тэгснээ Ландон, Витториа хоёр руу эргэж хараад хувь заяаг нь шийдэх гэж байгаа шүүгч шиг тэвхийн зогсов. «Намайг дагаад явна уу» гэж тэр хэлээд, тэр хоёрыг хяналтын өрөөн дундуур авч явж, цаад хананд нь байгаа шилэн хорго шиг битүү өрөөнд аваачив. «Энэ миний өрөө байгаа юм» гээд оруулав. Тэнд онцгой юм юу ч байсангүй, цаас овоорсон ширээ, хавтас хийх шургуулга, эвхдэг сандал, ус хөргөгч л байлаа. «Би арваад минутын дараа ирнэ. Энэ хооронд та нар юу хийхээ бодно биз» гэв. Витториа огцом эргэж: «Та зүгээр л ингээд явчхаж болохгүй, тэр канистер чинь ...» гэтэл Оливетти: «Надад наадахад чинь үрэх цаг алга. Тэгэхээр би та нарыг цуурган дуусаж завтай болтлоо түр хорьсон нь дээр байх» гэлээ. «Сениорь, spazzare di capella (ита. Хийдийг цэвэрлэх)» гэж харуул залуу цагаа заан, Оливеттиг шавдуулав. Оливетти толгой дохиод, явахаар завдав. «Spazzare di capella? Та нар хийдийг цэвэрлэх гэж байгаа юм уу?» гэж Витториа асуув. Оливетти залхсан байдалтай хараад: «Бид хийдийг чагнах төхөөрөмжөөс цэвэрлэх гэж байгаа юм, Ветра авхай. Энэ аюулгүй байдалтай холбоотой ажил, гэхдээ та ч ойлгохгүй биз дээ» гэж шалдан хөл рүү нь дохиж, тохуурхан дайруулав. Тэгээд шил нь сугарч

хяхартал, хаалгаа тас хийлгэн хаагаад, нүд ирмэхийн зуур түлхүүр гаргаж ирээд түгжчихэв. Хүнд оньс тархийтэл хаагдлаа. «Хөөе, чи муу тэнэг, ингэж болохгүй шүү дээ» гэж Витториа цамнан хашхичив.

Ландон шилэн хаалганы цаана Оливетти харуул руу тонгойн нэг юм хэлэхэд, цаадах нь толгой дохихыг харав. Тэгээд түүнийг явахад харуул эргэж, цонхны цаанаас тэдэн рүү харж, элгээ эвхэн зогсоход ташаандаа зүүсэн гар буу нь ил харагдана. *Гайхалтай зөв, даан ч цагаа олсонгүй* гэж Ландон бодлоо.

Витториа хаалганы цаана байгаа харуул руу ширтэнэ. Харуул ч өнгөлөг сайхан хувцастайгаа муу ёр зөгнөх шиг шийдэмгий гэгч, өөдөөс нь нүд цавчихгүй тайван ширтэнэ. *Che fiasco (ита. Юу болоод байна даа). Ингээд шарваар өмссөн зэвсэгт этгээдийн барьцаанд үлдчих нь энэ үү* гэж Витториа бодлоо. Витториа Ландоныг чимээгүй зогсохыг хараад, Харвардад үнэ хүрдэг тэр гайхалтай ухаалаг тархиндаа эндээс хэрхэн гарах тухайгаа бодож байгаа болов уу гэж найдав. Гэхдээ царай нь юм бодож байгаа гэхээсээ илүү мэгдэн сандарсан байдалтай харагдахад, түүнийг энэ хэрэгт дэмий хутгаж дээ гэж харамсав. Витториа эхлээд гар утсаараа Колэр рүү ярьдаг юм уу гэж бодсон ч, удалгүй дэмий санагдав. Нэгд, харуул орж ирээд гар утсыг нь булаагаад авчих нь лавтай. Хоёрт, Колэртэй ярилаа гэхэд, өвчин нь гайгүй болсон ч гэсэн ямар нэг юм хийх сөхөөгүй байгаа байж магадгүй билээ. Тэгээд ч Оливетти яг одоо хэнийг ч ярьсан авч хэлэлцэхээргүй байгаа нь тодорхой байлаа. *Санаарай, санаарай! Энэ дасгалын хариуг санаарай* гэж Витториа амандаа шивнэнэ. Санана гэдэг Буддист гүн ухааны арга байлаа. Витториа ямар ч боломжгүй асуудлын шийдлийг асууж, тархиа зовоохын оронд зүгээр л тархиндаа эргэж санахыг хичээдэг ажээ. Санана гэж бодохоор, хариултыг нь хэзээ нэгэнтээ мэддэг байсан юм шиг санагдана ... тиймээс ямар ч айх явдалгүй, хариулт нь бэлэн байгааг мэдэрч, харин санах л хэрэгтэй байдаг ажээ. Витториа энэ аргаа урьд нь ихэнх хүн боломжгүй гэж боддог байсан асуудлыг шийдэхэд олонтаа ашиглаж байлаа. Харамсалтай нь, одоохондоо тэр арга нь огт үр дүнгүй байв. Тэгээд Витториа байгаа боломжуудаа үнэллээ. Тэр хэн нэгнийг анхааруулах хэрэгтэй байв. Ватиканд байгаа хэн нэгэн түүнийг анхааралтай яа сонсох хэрэгтэй байлаа. Гэхдээ хэн тэр вэ? Камерлинго юу? Тэгээд яаж мэдэгдэх вэ? Өөрөө ганцхан хаалгатай шилэн хоргонд түгжээтэй сууж байх. *Хэрэгсэл! Хэрэглэчихмээр юм энд тэндгүй ямагт олдоно.* Витториа ойр тойронд байгаа юмаа хянуур ажив. Бүсгүй зөнгөөрөө мөрөө буулгаж, харцаа хураан, гурвантаа гүн гэгч амьсгаа уушгиндаа хураалаа. Зүрхний цохилт нь удааширч, булчин шөрмөс нь сулрав. Тэгээд, тархинд эргэлдэх элдэв сандрал ариллаа. *За, одоо оюун ухаанаа цэвэрлэе. Явал энэ муу байдлыг нааштай болгож болох вэ? Хэрэглэчихмээр юм надад юу байгаа билээ?* Ветрагийн задлан шинжлэх чадвар ямагт түүний хамгийн хүчирхэг зэвсэг байдаг байлаа. Хормын дотор, ингэж хоригдсон нь эндээс гарах хамгийн таатай завшаан болохыг ухаарав. «Би утсаар ярьлаа» гэж бүсгүй гэнэт шийдэмгий хэлэв. Ландон дээшээ хараад: «Би чамайг Колэр рүү утаст гэж хэлэх гэж байсан юм, гэхдээ ...» гэв. Витториа яриаг нь таслан: «Колэр рүү биш ээ. Өөр хүн рүү.» «Хэн рүү гэж?» «Камерлинго руу!» Ландон гайхан мэлрэв. «Чи камерлинго руу утастах гэж үү? Яаж?» «Оливетти камерлингог Папын албан өрөөнд байгаа гэсэн». «Тийм л дээ. Гэхдээ чи Папын өрөөнийх нь дугаарыг мэдэх юм уу?» «Үгүй ээ. Гэхдээ өөрийнхөө утаснаас ярихгүй» гээд бүсгүй Оливеттигийн өндөр технологийн холбооны хэрэгслээр тоногдсон ширээ рүү дохив. Тэнд шууд холбогдох олон олон товч байлаа.»Харуулын албаны даргад Папын өрөө рүү шууд залгадаг товч байж л таараа» гэв. «Гэхдээ.., бид хоёроос зургаахан тохой зайд, буу зүүсэн мангас шиг залуу зогсож байгаа шүү дээ». «Гэхдээ бид хоёрыг цоожилчихсон шүү дээ». «Би ч мэдээд л байгаа л даа». «Үгүй ээ, би харуул ч гэсэн бас цоожлуулчихсан гээд байна шүү дээ. Энэ чинь Оливеттигийн хувийн өрөө. Өөр хүнд түлхүүр нь байгаа гэж бодохгүй л байна шүү». Ландон харуул руу харав. «Энэ шил нимгэн, харин тэр буу бол гайгүй том юм байна шүү дээ». «Тэр яав л гэж. Утсаар ярилаа гэж буудах юм уу?» «Хэн мэдэх вэ дээ. Энэ чинь шал өөр газар, юм бүхэн шал өөр шүү дээ». «Тэгээд, хоёулаа сүүлчийнхээ таван цаг дөчин найман минутыг Ватиканы шоронд сууж

өнгөрөөх үү? Антиматери яаж дэлбэрэхийг их ойрхноос харах азтай юм даа, чи бид хоёр?» Ландон гацчихав. «Гэхдээ чамайг утас авмагц, харуул Оливетти рүү гүйнэ. Тэгээд ч, энд бараг хорь гаруй товч байна шүү дээ. Ямар ч тэмдэг байхгүй шүү. Бүгд рүү нь залгаж азаа үзэх юм уу?» Витториа утас руу алхах зуураа: «Үгүй шүү. Ганцхан л товч дарна». Тэгээд харилцуурыг авч хамгийн түрүүний товчийг дарав. «Дугаар нэг. Би хармаанд чинь байгаа Иллюминатигийн зурсан америк долларуудын чинь нэгээр нь энэ бол Папын өрөөний дугаар мөн гээд мөрийцчих үү? Швейцар жардын ахлагчид өөр юу тийм их чухал байх билээ?» Ландон хариулж ч амжсангүй. Харуул бууныхаа бөгсөөр хаалганы шил рүү нүдэж эхлэв. Бүсгүй рүү утсаа тавь гэж дохиж байлаа. Витториа даапаалан, түүн рүү нүдээ ирмэхэд, харуул уурласандаа галзуурах гэж байх шиг харагдана. Ландон хаалганаас холдож, Витториа руу эргэлээ. «Чиний зөв бололтой шүү. Харуул нэг их баясахгүй шинжгүй харагдаад байна». «Чөтгөр гэж. Дуу хурааж байна» гэж харилцуурыг чагнангаа цаадах нь хэлэв. «Дуу хураах аа? Пап автомат хариулагчтай байх нь ээ?» гэж Ландон асуулаа. «Папын өрөө биш байна аа. Ватиканы хоолны газрын долоо хоногийн цэс байна, золиг гэж» гэснээ Витториа харилцуураа тавилаа. Ландон сулхан инээвхийлээд, шилэн хаалганы цаана уурлан цовхчиж, Оливетти руу холбоогоор хашхичиж байгаа харуул залуу руу харлаа.

Хэсэг 38

Ватиканы залгагч Ватиканы шуудангийн архан талд, Холбооны албанд байрладаг ажээ. Энэ бол 141 хянах самбар бүхий Корелкогийн найман шугамтай давчуухан өрөө байлаа. Энэ алба өдөрт 2000 гаруй яриаг холбож, дийлэнхийг нь автомат мэдээллийн системд бичдэг байна. Өнөө шөнө ганцхан оператор ажил дээрээ жижүүрлэн, кофеинтой цай амтархан оочилж суув. Тэр энэ шөнө Ватикан хийдэд үлдэхийг зөвшөөрсөн цөөхөн хүний нэг болсондоо баяртай байлаа. Гэхдээ л Швейцар жардынхан хаалганых нь гадна холхиод байхад тийм ч сайхан биш ажээ. *Жорлонд хүртэл дагаж орох нь л дээ. Ариун цуурганы төлөө доромжлол хүртэл амсах юм даа* гэж унтууцан бодолхийлэв. Аз болж, өнөө орой утасны дуудлага цөөн байв. Гэхдээ энэ аз уу, эз үү гэдгийг хэлж мэдэхгүй. Сүүлийн хэдэн жил хүмүүс Ватиканд болж байгаа үйл явдлыг сонирхох нь илт багассан билээ. Хэвлэлийнхний утастах нь цөөрч, бүр солиотой хүмүүс хүртэл өмнөх шигээ байнга утастахаа больжээ. Хэвлэлийн алба өнөө орой олон хүн энэ үйл явдлыг сонирхон цуглах байх гэж хөөрчихсөн байлаа. Гэвч харамсалтай нь Гэгээн Петерийн талбай дээр байгаа хэвлэл мэдээллийнхний машиныг харвал дийлэнх нь нөгөө л Италийн юм уу, Европынх байх... дэлхий даяар үйл ажиллагаа явуулдаг зарим нэг хэвлэлийн нэрс үзэгдэв ч тэд мэдээж *giornalisti secondarii* (ита. Хоёрдугаар зэрэглэлийн сэтгүүлчид)-ээ явуулсан байгаа. Оператор аягаа алгандаа хавчуулан, түшлэгээ налан суухдаа, энэ шөнө хэр урт байх бол хэмээн бодов. *Шөнө дунд, эсвэл жаахан илүү л болно биз.* Өнөөдөр Ватиканы шадар хүмүүсийн дунд цуурган эхлэхээс хамаагүй өмнө хэн Пап болох нь тодорхой болчихсон байдаг, тиймээс цуурган сонгууль гэхээсээ гурав дөрвөн цаг үргэлжлэх ёслол маягтай болжээ. Мэдээж, зарим нэг эсрэг санал цуурганыг үүр гэгээртэл юм уу, өглөө болтол сунжруулж болох л юм. 1831 оны цуурган тавин өдөр үргэлжилжээ. *Гэхдээ өнөөдөр л лав биш.* Өнөөдрийн цуурган тамхи татахын зуур болж өнгөрнө гэж хүмүүс ярьж байсныг сонссоноо тэр санав. Хянах самбарын дотоод шугамын хэсэгт гэрэл асах агшинд операторын бодол замхарч орхилоо. Тэр толгойгоо маажлан тэр

гэрлийг харангаа *Жигтэй юм даа. Тэг шугамаас дуудаж байх юм. Өнөө шөнө дотор байгаа хэн нь оператор руу утасдаг байна аа? Ер нь хэн өнөө шөнө энэ дотор байдаг билээ?* «Citta del Vaticano, prego (итал. Ватикан хийд байна)» гэж тэр утсаа авмагцаа хэлэв. Нэг хүн хурдан гэгч Италиар шулганаж байна. Оператор түүний яриаг чагнан франц, Швейцар өнгөтэй ч Италиар ус цас ярьж байгаа Швейцар жардынхны дунд түгээмэл байдаг хачин аялгыг танив. Гэхдээ утассан хүн ямартай ч Швейцар жард биш байлаа. Эмэгтэй хүний хоолой сонссон оператор гайхсандаа цайгаа асгах шахав. Тэр хянах самбар руу харав. Ямар ч эргэлзээгүй дотоод шугамаар ярьж байв. *Үгүй байлгүй дээ, ийм юм баймгүй юм* гэж тэр бодлоо. *Эмэгтэй хүн Ватикан хийдэд байна гэнэ ээ? Бүр өнөө шөнө шүү!* Бүсгүй тун түргэн, их л шамдангуй ярьж байлаа. Тэр олон жил утсаар ярьсан хүний хувьд мэдрэл муутай хүнийг ялгагдаг болсон байлаа. Гэхдээ, энэ хүүхэн галзуу биш ажээ. Тэр яаруу, гэхдээ ухаалаг байв. Тайван, гэхдээ үр нөлөөтэй байв. Тэр бүсгүйн хүсэлтийг сонсоод мэлэрч орхив. «Il camerlingo?» гэж тэр гайхан асуухдаа дуудлага хаанаас ирснийг тодорхойлох гэж алмайн зогсоно. «Би таныг залгаж өгч чадахгүй байх аа... тийм тийм, тэр Папын өрөөнд байгаа нь лавтай юм... та ингэхэд хэн билээ?... та түүнд анхааруулах гэсэн юм уу? Тэр сонсох тусмаа улам гайхна. *Бид бүгдийн амь насанд аюул учраад байна аа? Яаж тэр вэ? Ингэхэд та хаанаас утастаад байгаа юм бэ?* Би таныг Швейцар жард руу холбож өгвөл дээр юм уу. Оператор гайхсандаа зогтусав. Та хаана байна гэнэ ээ? Хаана аа? Тэр цочирдсон ч шийдвэр гаргалаа. «Хүлээгээрэй» гэж хэлмэгцээ хүүхнийг дуугарахаас өмнө нь утсыг нь хүлээлгээд, Оливетти захирагчийн өрөө руу шууд холбох товчийг залгав. *Тэр хүүхэн яавч тэр өрөөнд баймгүй дээ. Утсыг шууд л авлаа.* «Per l'amore di Dio (Бурхны минь авралаар ... ита.)» гэж нөгөө эмэгтэй хэлээд: «Намайг холбоод өгөөч, золиг минь» гэж шавдууллаа. Швейцар жардын аюулгүйн албаны өрөөний хаалга тасхийн онгойв. Оливетти харуулуудын дундуур зүсэн, нисэх мэт орж ирлээ. Тэгээд буланд байгаа өрөө рүүгээ эргэхдээ, Оливетти харуул залуу холбоогоор ярьсан нь үнэн байсан эсэхийг нүдээрээ шалгав: Витториа Ветра ширээнийх нь дэргэд утсыг нь барьчихсан зогсоно. *Che coglioni che ha questa! Энэ утсан дээр бүжиглэх гээ юм болов уу* гэж Оливетти бодов. Тэр өрөө рүүгээ шулуухан алхлан ирж, түлхүүрээ цоож руу шургуулав. Тэгээд хаалгаа түлхэн онгойлгомгоцоо: «Та чинь юу хийгээд байгаа юм бэ» хэмээн зандарлаа. Витториа тоосон ч үгүй. «Тийм шүү. Би танд энэ тухай л анхааруулах гэж...» хэмээн бүсгүй харилцуураар ярьж зогсов. Оливетти харилцуурыг шүүрч аваад чихэндээ дөхүүлэн: «Хэн гэж золиг вэ, чи?» хэмээн хашхирлаа. Тэгснээ, эгшин зуур түүний хөшүүн гөжүүд байдал замхран алга болов. «Мэдлээ, камерлинго... зөв өө, зөв... гэхдээ аюулгүй байдлын асуудлыг... мэдээж үгүй... би түүнийг эндээ л хорьж ... тэгэлгүй яах вэ... гэхдээ» хэмээн тэр ярина. Эцэст нь: «Мэдлээ, эрхэм ээ. Би одоохон тэднийг дээш нь аваад очъё» гэлээ.

Хэсэг 39

Систин цогчны дэргэдэх Апостолийн ордон гэдэг Ватикан хийдийн зүүн хойд буланд орших олон барилгын цогц байлаа. Гэгээн Петерийн талбай руу харсан энэ байшинд Папын хувийн өргөө, Папын бичгийн өргөө хоёр байрладаг ажээ. Ландон, Витториа хоёр Оливетти захирагчийг чимээгүйхэн даган, урт тансаг гудмаар доошилж явахад, захирагчийн булчин нь чинэрэн татганаж байлаа. Гурван шатаар өгссөний дараа тэд өргөн, зөөлөн гэрэлтэй гудам руу орлоо. Ландон хананд өлгөөтэй урлагийн бүтээлүүдийг бахдан гайхаж явав. Зэс хөөмөл, нэхмэл, сүлжмэл гэх мэт зуу зуун мянган долларын үнэтэй гайхамшгууд тэнд байлаа. Гудмын гуравны хоёрыг өнгөрч явахдаа, гайхамшигт усан оргилуурын хажуугаар дайрлаа. Жижиг ховилын түүгээр Оливетти зүүншээ эргээд, том хаалга руу шудран алхав. Ландон тийм том

хаалга амьдралдаа хэзээ ч харж байсангүй. *Ufficio di Papa (ита. Папын бичгийн өргөө)* гэж Оливетти Витториа руу ширүүн гэгч хяламхийн өгүүлэв. Бүсгүй дальдарсан ч үгүй. Оливетти хаалганы дэргэд очиж, чанга тогшив. Папын бичгийн өргөө гэж! Ландон дэлхийн хамгийн том шашны нэгийнх нь хамгийн ариун өрөөний өмнө зогсож байгаадаа бахдан байв. *Avanti (ита. морил)* хэмээн дотроос нь хэлэх сонстов. Хаалга онгойход Ландон нүдээ халхлав. Өрөөнд туссан нарны гэрэлд нүд дальдрам хурц байлаа. Удалгүй нүд нь дасч, юм харахтайгаа болов. Папын бичгийн өрөө бичгийн гэхээсээ цэнгүүний тэнхим гэлтэй ажээ. Улаан гантиг шал, бүрэн зүмбэртэй хана руу урсан нийлжээ. Уран чамин цэцэг дэн таазан дээр өлгөөтэй, цаана байх аварга том нуман цонхоор Гэгээн Петерийн талбай бүхэлдээ харагдана. *Бурхан минь, ямар сайхан алсын бараатай өрөө вэ* гэж Ландон бодлоо. Өрөөний алс буланд, сийлбэртэй модон ширээн дээр, нэг хүн их л шамдангуй юм бичиж харагдана. *Avante* гэж тэр хүн дахин хэлээд, үзгээ тавин гараараа даллав. Оливетти түрүүлэн, цэрэг тэвхгэр алхаагаар орж очлоо. «Сениорь, *No ho potuto*» хэмээн их л гэмшингүй өгүүлнэ. Нөгөө эр түүний өгүүлэхийг таслаад, хоёр гийчнийг тайван ажиглав. Камерлинго Ландоны бодсон шиг Ватиканд холхин явдаг ерийн нэг настай, турьхан хүн огт биш байлаа. Тэр эрхи ч, унжлага ч зүүгээгүй, хүнд ямбаны дээл ч жагсаагаагүй байлаа. Харин зүгээр л хар бариу дээл өмссөн нь түүний тэвхгэр биеийг тодруулжээ. Дөч арай хүрээгүй болов уу гэмээр нас нь Ватиканд бол хүүхдээрээ гэж тоологдох байлаа. Тэр царайлаг, буржгардуу, гэрэлтсэн ногоон нүдтэй, тэр нүд нь ертөнцийн элдэв ид шидээр дүүрсэн юм шиг харагдана. Харин түүнийг ойртон ирэхэд Ландон нүд нь туйлдсан байдалтай байхыг мэдлээ. Амьдралынхаа хамгийн бэрх арван таван өдрийг арай гэж туулж, аврал гуйсан сүнс мэт байлаа. «Карло Вентреска» гэж тэр цэвэр англиар хэллээ. «Талийгаач Папын камерлинго» гэж өөрийгөө танилцуулахад дуу нь эелдэг, гэхдээ ялимгүй итали аялгатай байлаа. Бүсгүй: «Витториа Ветра» гэж өөрийгөө танилцуулаад, урагш алхан, гараа сунгаж: «биднийг авч уулзсанд гялайлаа» гэв. Камерлинго Витториагийн гарыг атгахад, Оливетти агзасхийх шиг болов. «Энэ хүн бол Роберт Ландон. Харвардын их сургуулийн шашны түүхч» гэж Витториа Ландоныг танилцууллаа. «Padre (ита. Эцэг минь)» хэмээн тэрээр байдгаараа акцентгүй хэлэх гэж хичээлээ. Тэгээд, камерлингогийн сунгасан гарыг үнсэхээр бөхийв. Тэгэхэд нь, камерлинго цочих мэт гараа суга татаад: «Үгүй ээ, боль, боль» хэмээн Ландон өндийлгөв. «Дээрхийн гэгээнийг түр орлож байгаа маань намайг Дээрхийн гэгээн болгохгүй шүү дээ. Би зүгээр л нэг гэлэн - камерлинго, хийх ёстой юмаа хийх ёстой цагт нь хийж яваа эгэл хүн». Ландон цэхлэн босов. Камерлинго эелэн: «Сууж тавлацгаа!» хэмээлээ. Ширээний өмнө байгаа хэдэн сандал руу заахад Витториа, Ландон хоёр сууж, харин Оливетти суулгүй зогссон хэвээр үлдэв. Камерлинго ширээнийхээ ард сууж, гараа салаавчлан, санаа алдаад, гийчдээ харав. Оливетти: «Сениорь. Бүсгүйн хувцас бол миний алдаа юм шүү...» гэлээ. Камерлинго ядарсан байртайгаар үгийг нь таслаад: «Бүсгүйн хувцасны тухайд би зовнихгүй байна. Цуурган эхлүүлэхээс хагас цагийн өмнө оператор над руу залгаж, таны албан өрөөнөөс нэг бүсгүй та нарын надад огт дуулгаагүй аюулын талаар анхааруулахаар утастаж байна гэсэн билээ. Үүнд л би зовниж байна» гэлээ. Оливетти тушаал хүлээж байгаа цэрэг шиг арагшаа гэдийн номхон зогсоно. Ландон камерлингог хараад ховстуулсан мэт болов. Тэр залуу, царайлаг агаад эелэг төрх, эрх мэдлээ цацруулсан шидэт баатар мэт санагдана. «Сениорь, та аюулгүйн асуудлаар оюунаа чилээх хэрэггүй шүү дээ. Та бол хүнд хариуцлагатай өөр ажилтай хүн» хэмээн Оливетти их эвлэг, гэхдээ шамдангуй өгүүлэв. «Би үүргээ гүнээ ухамсарлаж байна, Оливетти. *Direttore interme-diatoro* (ита. түр захирагч) -ийн хувьд би эл цуурганд байгаа хүн нэг бүрийг аюулгүй, амгалан байлгах үүрэгтэй билээ. Энд тэгээд юу гэгч нь болоод байгаа юм бэ?»

«Байдлыг би хянаж байгаа, эрхэм ээ». «Үгүй л юм шиг байх юм». Ландон тэдний яриаг таслан: «Эцэг минь, тольдож ажаам уу» хэмээн факсаа гаргаж камерлингод өгөв. Оливетти захирагч саад хийх санаатай урагш алхан: »Эцэг минь, та ийм зүйлд санаагаа чилээх хэрэггүй биз» гэлээ. Камерлинго зургийг аваад Оливеттийг ч анзааралгүй удаан гэгч харав. Тэрээр Леонардо Ветрагийн алуулсан зургийг хараад цочих шиг боллоо. «Энэ юу вэ?» «Аав минь байгаа юм» гэж хэлэхдээ Витториагийн хоолой зангираад явчхав. Тэгснээ: «Тэр маань шашны гэлэн, бас эрдмийн хүн байсан юм. Урьд шөнө түүнийг минь алчихаж» гэлээ. Камерлингогийн царай нь зөөлөрч, өрөвдөнгүй байдалтай бүсгүй рүү хараад: «Охин минь, эмгэнэлтэй юм болжээ, зайлуул!» гэлээ. Тэгээд загалмайлан залбираад, сүнс зайлсан юм шиг харцаар факс руу дахин харав. «Хэн ингэж... цээжийг нь түлж... сийлдэг байна?» Камерлинго түгдчээд зураг руу хараад таг болчхов. Ландон: «Наана чинь Иллюминати гэж байгаа юм. Та мэдээж энэ юу болохыг нь мэднэ биз дээ» гэв. Камерлингогийн царай эргэлзэнгүй хувьсхийж: «Энэ нэрийг сонсож байсан юм байна аа. Гэхдээ энэ чинь ... юу л даа...» «Иллюминати шинэ технологи хулгайлахын тулд Леонардо Ветраг хөнөөгөөд...» Оливетти дундуур нь таслан: «Дээдэс ээ! Энэ бол солиотой хүний ажил. Юун Иллюминати вэ? Наадах чинь яах аргагүй зүгээр л нэг цуу сэжиг шүү дээ». Оливеттигийн энэ үг байдаа тусав бололтой. Камерлинго эргэж, Ландон руу хараад, сэтгэл нь амарлисан байдалтай гүнзгий амьсгаа авч: «Ландон гуай, би насаараа Католик сүмд суусан хүн. Иллюминатигийн тухай, тэдний алдарт тамгын тухай домгийг мэдээж сонссон. Гэхдээ бид өнөө үед амьдарч байгааг танд сануулмаар байна. Хуучны буг чөтгөрийг сэрээхгүй байсан ч Христийн шашинд өнөөдөр дайсан мундахгүй байна» гэлээ. «Бэлгэдэл нь тохироод байгаа юм» гэж Ландон тэрцсэн байртай хэлээд, түүн рүү дөхөж, зургийг эргүүлээд өгөв. Камерлинго тэр бичээс тэгш хэмтэй байхыг үзээд бас л дуугаа хураачхав. «Бүр орчин үеийн компьютер хүртэл энэ үгийг семитр, амбиграмм бичих гэж тооцоолоод чадаагүй юм шүү дээ» гэж Ландон ятган сэнхрүүлнэ. Камерлинго алгаа хавсран, дуугаа хураан хэсэг зогсов. Тэгээд: «Иллюминати устсан шүү дээ. Бүр олон жилийн өмнө шүү. Энэ бол факт» гэлээ. Ландон толгой дохингоо: «Өчигдөр бол, би тийм л гэхээр байлаа» гэв. «Өчигдөр өө?» «Өнөөдөр болоод байгаа зүйлийг мэдлээ. Иллюминати эртний хонзонгоо өвөртлөн гараад ирчихсэн юм шиг байна». «Өршөөгөөрэй. Сайн ухсангүй. Ямар хонзонг тэр билээ?» «Ватикан хийдийг устгах!» Камерлинго гайхсангүй, харин төөрөлдөж орхив. «Гэхдээ тэгэх боломжгүй шүү дээ»: Витториа толгой сэгсрэн: «Бас өөр хэдэн таагүй мэдээ дуулгамаар байна» гэлээ.

Хэсэг 40

«Энэ үнэн үү?» гэж камерлинго Витториагаас Оливетти рүү эргэн асуув. «Сениорь, ямар нэг төхөөрөмж байгаад байгааг би зөвшөөрнө. Гэхдээ манай хяналтын камер дээр байгаа дүрсийг харвал тэр их жижигхэн, Ветра авхайн хэлээд байгаа шиг тийм их хөнөөл учруулж чадахааргүй байгаа юм» гэж Оливетти хариулна. «Азнаарай! Та нар тэрийг нь харсан юм уу?» гэж камерлинго асуулаа. «Тэгсээн, сениорь. Камер #86-аар харсан». Камерлинго уурсангуй: «Тэгээд тэрийгээ очоод авчихгүй яагаад байгаа юм бэ?» гэлээ. Оливетти цэх зогссон хэвээр: «Сениорь, тэр ч амаргүй л байна л даа» гээд байдал ямархуу байгаа тухай тайлбарлав. Камерлинго түүний ярихыг сонсох тусам түгшиж эхлэхийг Витториа гадарлав. «Та нар яагаад тэрийг Ватикан хийдийн дотор байгаа гээд байгаа юм бэ? Тэр камерыг авч яваад, өөр газраас дамжуулаад байгаа юм биш биз?» «Тэгэх боломжгүй. Манайх дотоод харилцаагаа хамгаалахын тулд гадаад хэрмээсээ дотогш цахим халхтай байдаг юм. Тэгэхээр, дохио дотроос л ирж байгаа, үгүй бол бид хүлээж авахгүй» гэж Оливетти хариуллаа. «Тэгвэл,

та ядаж одоо бүх хүчээ дайчлан алдсан камераа хайж байгаа биз дээ?» Оливетти толгойгоо сэгсэрнэ. «Үгүй ээ, сениорь. Тэрийг хайхад зуу зуун хүн бас цаг шаардана. Аюулгүйн асуудлаар санаа тавих өөр олон зүйл байна. Ветра авхайг ойлгож байгаа ч, тэр яриад байгаа дусал нь хэтэрхий жижигхэн, тийм их хөнөөлтэй байж чадахааргүй байгаа юм.» Витториа тэвчээр алдав. «Тэр дусал чинь Ватикан хийдийг газрын хөрстэй тэгшилчих чадалтай юм шүү. Та ер нь миний яриад байгааг сонссон уу, үгүй юү?» «Авхай! Би олон жил тэсрэх бодистой ажилласан туршлагатай хүн шүү» гэж Оливетти хүйтэн дуугаар хариу барилаа. Витториа мөчөөгөө өгөлгүй: «Таны туршлага даан ч тус багатай юм. Миний хувцас таны санааг зовоож байгаа бол, харин би атомын бөөмс судлалаар дэлхийд тэргүүлдэг олон улсын хүрээлэнгийн ахлах судлаач хүн шүү. Тэр дусал төдий дээжийг аннигиляц болохоос сэргийлж буй антиматерийн хавхыг би өөрөө зохиосон юм. Хэрвээ танай харуулууд зургаан цагийн дотор тэр канистерыг олж чадахгүй бол, дараагийн зуунд та нарт газрын гавт суусан том хар нүхнээс өөр хамгаалах юмгүй хоцорно шүү гэж сануулаад байна» гэлээ. Оливетти жоомон нүдээ жартайлган ширэв татсанаа, камерлингод хандан: «Сениорь, одоо ингэж маргаж суух цаг биш байх. Таны цагийг дэмий үрээд яах вэ? Иллюминати ч гэх шиг, бид бүгдийг устгах чадалтай ганц дусал ч гэх шиг» гэв. Basta! гэж камерлинго хэллээ. Тэр энэ үгээ их л намуухан хэлсэн, ч бараг л өрөө даяар цуурайтан сонсогдов. Тэгснээ, өрөөнд хэсэг аниргүй боллоо. Тэр бараг л шивнэх шахуу: «Аюултай ч бай, үгүй ч бай, иллюминати ч бай, биш ч бай, ер нь юу ч байсан, тийм юм лав л одоо энд, Ватикан хийдэд, цуурган болж байгаа энэ мөчид байх ёсгүй ... Тэрийг олоод, зайлуул! Даруй эрэл зохион байгуул!» гэлээ. Оливетти бас л тайлбар тавина. «Сениорь, бид бүх хүчээ дайчилсан ч гэсэн энэ цогцолборыг нэгд нэгэнгүй нэгжихэд хэд хэдэн өдөр хэрэгтэй. Ветра авхайтай ярьсныхаа дараа би харуулуудынхаа нэгийг, манай хамгийн сайн галт зэвсгийн шинжээчтэй тэр антиматери гэгчийнх нь тухай зөвлөлд гэсэн юм. Тэр тухай ямар ч мэдээ байхгүй байсан.» *Тэнэг төгцөг, Галт зэвсгийн шинжээч гэнэ ээ. Энциклопед сөхөж харсан гээсэй! А үсгээс нь эхлээд шүүрдэж харсан гээч!* гэж Витториа тэрцэн бодов. Оливетти ярьсан хэвээр: «Сениорь, таныг харуулыг маань Ватикан хийдийг нэгд нэгэнгүй нэгж гэвэл, би таны тушаалыг эсэргүүцмээр байна» гэлээ. «Захирагч аа!» Камерлинго хилэнтэй еэ дуугарав. «Одоогоор та надтай ярихдаа, надтай биш, харин энэ албан тушаалтай ярьж байгаа гэдгийг тань сануулчихъя. Та намайг тоохгүй байгааг ойлгож байна, гэхдээ хуулиар, яг одоо, би энэ тушаалыг хашиж байгаа шүү. Би эндүүрээгүй бол кардиналууд одоо Систин цогчинд аюулгүй байгаа, тэгэхээр та цуурган тартал ямар нэг онц асуудалгүй байгаа биз. Та яагаад энэ төхөөрөмжийг хайхаас цааргалаад байгааг ойлгохгүй байна. Таныг мэддэггүй сэн бол, би таныг энэ цуурганы явцад санаатайгаар саад болж байна гэмээр байна шүү». Оливетти хилэгнэж эхлэв. «Та яаж ингэж чадаж байна аа? Би танай Папад арван хоёр жил зүтгэсэн. Өмнөх Папад арван хоёр жил. 1438 оноос хойш Швейцар жард ...» Яриаг нь таслан, Оливеттигийн бүсэнд байсан холбоо чанга гэгч паржигнаад, түүнийг дуудан «Захирагч аа, захирагч аа!» гэлээ. Оливетти бүснээсээ холбоогоо сугалаад, товчин дээр дарж «Sono occupato! Cosa vox! (uma. Завгүй байна,)» «Scusi» хэмээн холбоон дээр байсан Швейцар жард хэллээ. «Мэдээ байна. Тэсрэх бөмбөг нуусан гэж заналхийлж байгаа тухай мэдээ аваад, танд дуулгах гэсэн юм». Оливетти нэг их сонирхсон янзгүй: «Тэгээд яах вэ дээ? Журмаараа л явуулаа ч дээ. Бичээд ав». «Тэгсэн эрхэм ээ! Гэхдээ таныг судал гээд байсан нөгөө антиматерийн тухай яриагүй бол, би тан руу залгахгүй байлаа л даа». Өрөөнд байсан хүмүүс бие бие рүүгээ түгшин харав. Оливетти: «Юу гэнэ ээ?» гэж хашхирав. «Антиматерь, эрхэм ээ. Бид таныг судал гээд байсан болохоор, жаахан нэмэлт судалгаа хийж зарим нэг зүйл оллоо.

Антиматерийн тухай мэдээллийг үзвэл ... тэр чинь ер нь нэлээн аягүй эд бололтой шүү». «Чи өөрөө зэвсгийн шинжээч тэр тухай юу ч мэдэхгүй байна гээ биз дээ?» «Би интернетээр хайсан юм аа». *Ашгүй дээ* гэж Витториа бодов. «Тэр бодис их сүрхий тэсэрдэг эд юм байна. Энэ мэдээлэл хэр үнэн эсэхийг мэдэхгүй, гэхдээ нэг фунт антиматери цөмийн цэнэгээс зуу зуу дахин илүү тэсрэх чадалтай гэнэ ээ» гэж харуул хэллээ. Уул нурж байгаа юм шиг л, Оливеттигийн нүсэр чанга бие сулбайгаад ялхийчихав. Витториа эрдсэн царайтай байснаа, камерлинго зэвхий даахыг хараад, дагаад барайчхав. «Чи шугамыг нь мөшгөв үү?» гэж Оливетти асуув. «Чадсангүй ээ. Гар утасныхаа сүлжээг чанд нууцалчхаж. SAT хиймэл дагуулын солбицлыг төөрүүлчихсэн, тэгэхээр гурамсан солбицол үүсгэх боломжгүй болчхож. IF мөрийг хайвал, Ром хотын хаа нэгтэйгээс утастсан гэж байна, гэхдээ яг хаана гэдгийг тодорхойлох арга алга». Оливеттигийн дуу нь зөөлөрчихсөн: «Ямар нэг шаардлага тавив уу?» «Үгүй ээ, эрхэм ээ! Зүгээр л антиматерийг энэ хийдэд нуусан байгаа гэсэн. Намайг мэдээгүй байхыг сонсоод, гайхах шиг болсон шүү. Намайг өөрөө харсан эсэхийг хүртэл лавласан. Тэгээд, таныг антиматерийн тухай асуугаад байсан болохоор би мэдэгдсэн нь дээр гэж бодсон юм». «Чи зөв хийжээ. Би удахгүй доошиллоо. Дахиж утаствал шууд дуулгарай» гэж Оливетти хэллээ. Тэгээд, холбоон дээр хэсэг аниргүй байснаа: «Тэр утсаа тавиагүй хэвээрээ байгаа юм байна шүү дээ, эрхэм ээ» гэлээ. Оливетти тогонд цохиулсан юм шиг болсноо: «Шугам нээлттэй байна уу?» гэв. «Нээлттэй, эрхэм ээ. Бид шугамыг нь мөшгөх гэж арван минут оролдоод чадахгүй байна. Биднийг чадахгүй гэдгийг ч мэдээд байгаа бололтой камерлинготой ярихаас нааш тавихгүй гээд утсаа бариад байж л байна.» «Нааш нь холбоодох, даруйхан шиг!» гэж камерлинго тушаав. Оливетти сандран: «Хэрэггүй ээ, ариун эцэг минь. Швейцар жардын мэргэшсэн хүн энэ асуудлаар ажиллавал дээр» гэлээ. Камерлинго тоосонгүй: «Залгаадах!» гэв. Оливетти тушаалыг цааш нь дамжууллаа. Удалгүй, Вентреска камерлингогийн ширээ дээрх утас жингэнэн дуугарав. Тэр утасныхаа чанга яригч товчийг дарлаа. «Бурхны өмнө та өөрийгөө хэн гэж бодоо вэ?»

Хэсэг 41

Камерлингогийн ширээн дээрх утасны цаанаас гарах дуу төмөр шиг, хүйтэн, бардам байлаа. Өрөөн дотор байсан хүн болгон сонсож суув. Ландон англиар ярих, харь аялгыг нь таах гэж оролдоно. Ойрх дорнодынх юм уу даа. «Би эртний нөхөрлөлийн, та нарын зуу зуун жилийн турш яллаж байсан тэр нөхөрлөлийн элч байна. Би Иллюминатигийн элч байна» хэмээн танхим даяар цуурайтав. Ландоны хамаг булчин нь сулраад, хамгийн сүүлчийн эргэлзээ нь замхарлаа. Бах тав, нэр алдар, үхлийн айдас гурав холилдсон нэгэн мэдрэмж гэнэт төрсөн нь их л танил агаад өнөө өглөө факсаар авсан зураг дээрээс нөгөө амбиграаммыг харах үед төрсөн яг тэр мэдрэмж байлаа. «Та юу хүсээ вэ?» гэж камерлинго асуув. «Би эрдмийн хүмүүсийг төлөөлөн ярьж байна. Асуултад хариу хайн тантай л адил бэдэрч явдаг хүмүүсийг... Хүний хувь заяа, зорилго, бүтээгчийн тухай асуулт ...» Камерлинго: «Та хэн ч байсан хамаагүй, би...» «Silenzio (ита. Чимээгүй бай) Сонсож байсан чинь өлзийтэй байх шүү. Хоёр мянганы турш танай шашин үнэний эрлийг өмчиллөө. Өөрөөр ярьсан хүн болгоныг худал үг, муу ёрын заналаараа няц дарж байлаа. Үнэнийг өөрийнхөө зорилгод гуйвуулж, танай хорон бодлогын чинь эсрэг нээлт хийсэн бүхнийг хөнөөж байлаа. Та, тэгээд, энэ дэлхийн гэгээрсэн хүмүүсийн бай болоод байгаадаа гайхаад байгаа юм уу?» «Гэгээрсэн

хүн алс үйлсийнхээ төлөө барьцаалдаггүй юм даа». «Барьцаалах гэнэ ээ?» Утасны цаана инээх сонстов. «Барьцаалаагүй ээ. Би ямар нэг юм нэхээгүй. Ватиканыг устгана гэдэг нөхцөл тавиад больдог зүйл биш. Дөрвөн зуун жилийн турш, бид энэ шөнийг хүлээлээ. Яг шөнө дунд болоход танай хийдийг устгана. Та нар юу ч хийж чадахгүй». Оливетти утас руу ухасхийж: «Энэ хийдэд нэвтрэх боломжгүй. Та нар тэсрэх бөмбөг энд тавьсан байх учиргүй» гэлээ. «Та ч Швейцар жардын хайхрамжгүй төрхөөр ярьж байх чинь. Офицер юм уу даа? Иллюминати зуу зуун жилийн турш энэ дэлхийн хамгийн элит гэгддэг байгууллагуудад нэвтэрчихсэн байсныг та мэдэх байлгүй яв гэж. Тэгээд яагаад Ватиканыг тэднээс өөр, халдашгүй гэж бодоо вэ?» *Есүс минь. Энэ дотор бас хэн нэгэн байгаа юм байж дээ* гэж Ландон бодов. Нууцаар шургална гэдэг үнэндээ Иллюминатгийн гаршсан ганц ажил байлаа. Тэд Масон нийгэмлэгт, томоохон банк, бүр засгийн газарт ч шургалчихсан байжээ. Хэрэв Иллюминати Английн парламентад нэвчиж орхисон шиг Английн тагнуулууд Нацистуудын гүнд шургалж чадсан сан бол дайн ганц сарын дотор л дуусах санж гэж бүр Черчилль хүртэл нэг удаа сурвалжлагчид ярьж байсан ажээ. Оливетти шазав татан, эгдүүцэж: «Бүр ичихгүй худлаа ярьж байх шив. Та нар тэгж чадахгүй л дээ». «Яагаад чадахгүй гэж? Танай Швейцар жард хянамгай болохоор гэж үү? Швейцар жард танай өчүүхэн ертөнцийн мухар булан болгоныг хардаг болохоор гэж үү? Ингэхэд, танай Швейцар жардын дотор шургалж яагаад болохгүй гэж? Тэд ч бас хүн шүү дээ. Танай харуулууд усан дээр явж чаддаг хүний тухай үлгэрт итгэсэндээ, амиа золино гэж та нээрэн итгээд байгаа юм уу? Тэр канистер танайх руу өөрөөр яаж яваад, орж орхисон юм бол? Танай нөгөө аминаасаа эрхэмлэх дөрөв яаж яваад алга болчихсон юм бол?» Оливетти: «Ямар дөрөв гэж? Юу яриад байгаа юм бэ?» гэлээ. «Нэг, хоёр, гурав, дөрөв. Та нар тэр дөрвөө алга болгочхоогүй байгаа юм уу?» Оливетти: «Чи ямар чөтгөрөө яриад байгаа юм бэ?» хэмээн хашхичихдаа, яг л элэгдүүлчихсэн юм шиг, нүд нь хорсолтой ёо эргэлдэж, хөмхийгөө зуусан байлаа. «Тайвшир даа. Би нэрийг нь уншаад өгөх үү?» гэж утасны цаанаас тавлалаа. «Юу болоод байгаа юм бэ?» гэж камерлинго уурсан хэлэв. Утасны цаанаас баясан хөхрөх сонстоно. «Таны албатууд танд сонордуулаагүй байсан юм уу? Нүгэлтэй юм. Гэхдээ гайхмаар ч эд биш юм аа. Ямар ч бардам юм бэ? Тэр амь шигээ хамгаална гэж андгайлсан дөрвөн кардиналаа алдсан гэж үнэнээ чамд хэлэхэд, царай чинь яаж хувьсхийхийг төсөөлсөн чинь ... ха ха ха.» Оливетти хилэгнэн дүрэлзэж: «Чи энэ мэдээллийг яаж олж аваа вэ?» гэлээ. Утасны цаанаас хорыг нь малтсан шинжтэй: «Камерлинго! Та захирагчаасаа танай бүх кардинал Систин цогчинд бүрэн байгаа юу гэж нэг асуу даа» гэв. Камерлинго Оливетти рүү эргэж, асуусан байдлаар хилэнтэй еэ харав. Захирагч камерлинго руу ойртон, чихэнд нь аядуу дуугаар: «Сениорь, манай дөрвөн кардинал одоохондоо Систин цогчинд ирээгүй байгаа нь үнэн: гэхдээ үүнд зовних хэрэггүй. Тэр дөрөв дөрвүүлээ өнөө өглөө байрандаа байсан, тэгэхээр, одоо Ватикан хийд дотор аюулгүй байгаа нь лавтай. Дөнгөж цагийн өмнө, та өөрөө тэдэнд цай барьсан шүү дээ. Тэр дөрөв зүгээр л цуурган эхлэх цагаас жаахан хоцроод байх шиг байна. Бид тэднийг хайж байгаа, гэхдээ тэд зүгээр л цагийнхаа баримжааг алдаад, хэрмэн дотуур зугаацаж яваа байх гэж бодож байна» гэж шивнэв. «Дотуур зугаацаж яваа гэнэ ээ?» гэж камерлинго хэлэхэд дуу нь сааралтсан сонстов. «Тэр дөрөв аль цагийн өмнө Систин цогчинд оччихсон байх ёстой шүү дээ». Ландон Витториа руу хөмсгөө мушилзуулан харав. *Кардиналууд алга болсон гэнэ ээ? Харуулууд доор тэднийг л хайгаад байсан юм байна л даа.* «Манай чадлыг та нар гайхах байх шүү, сонсоорой» гэж утасны цаанаас дуугараад: «Парисын кардинал Ламассэ, Барселоны кардинал Гвидэра, Франкфуртын кардинал Эбнэр...» Тэр нэрийг дуудах бүр аварга том биетэй Оливетти улам бүр жижигрэх шиг болно. Утасны цаана байгаа этгээд хэсэг

зогсосхийгээд сүүлийнхээ нэрийг их л таашаалтай яа уншив. «. . . бас Италийн кардинал Баггиа» гэлээ. Камерлинго, салхигүй тэнгис дэх онгоцны дарвуул сул унжих шиг шолхойж орхилоо. Дээлийнх нь хормой газар шүргэмэгц, тэр сандал дээр лаг хийтэл унан тусав. «I prefeti» гэж тэр амандаа бувтна. «Дөрвөн дэвшигч... Баггиа кардинал хүртэл шүү. Бүр Дээрхийн гэгээн болж хамгийн магадгүй байсан нэр дэвшигч шүү. Яаж тэгдэг байна аа?» Ландон Папыг сонгох орчин үеийн журмын тухай нэлээдгүй мэдэх болохоор камерлингогийн царай барсхийн зэвхийсний учрыг ойлгож байлаа. Хэдийгээр ная хүрээгүй ямар ч кардинал Пап болж сонгогдож болох ч гэсэн цөөхөн хэдэн хүн л нийт саналын гуравны хоёрын саналыг авахуйц нэр нөлөөтэй байдаг ажээ. Тэднийг дэвшигчид гэнэ. Тэгээд тэр дэвшигчид нь алга болчихжээ. Камерлингогийн хөмсгөнд нь хөлс чийхарч: «Та тэднийг маань яах гэж байна даа?» гэв. «Та намайг тэр дөрвийг яана гэж бодоо вэ? Би чинь Хассассины удам шүү дээ». Ландон агзасхийв. Тэр энэ нэрийг сайн мэднэ. Энэ шашин түүхийнхээ турш Хассассин, Темпларь баатад гээд л, чамгүй олон заналт дайсантай өс зангидсан бөгөөд Ватикан заримыг нь хядаж, заримаас нь урваж байсан билээ. «Кардиналуудыг тавьчих!» гэж камерлинго хэлээд: «Бурхны хийдийг устгана гэж заналхийлэх чинь хангалттай биш үү?» гэлээ. «Кардиналуудаа март даа. Тэднийгээ та алдсан. Харин тэдний нэр алдар нь сая сая хүнд дурсагдаж байгаасай л гэж залбир. Бүх золигийн хүсдэг зүйл шүү дээ. Би тэднийг хэвлэлийн баатар болгоно доо. Нэг нэгээр нь. Шөнө дунд гэхэд, Иллюминати хүн бүхний анхаарлын төвд байх болно. Дэлхий ертөнцийн нүднээс гадуур хүн хороогоод яах вэ дээ. Хүмүүсийг нүд үзтэл аллага үйлдэх нь тэднийг аймшиг руу хөтлөхгүй гэж үү? Та нар тэгдэг гэдгийг нь аль хэдийн нотлоод, үзүүлчихсэн шүү дээ, Темпларийн баатад, Загалмайтнууд . . .» гэснээ хэсэг чимээгүй болсноо: «Бас la purga (ита. хэлмэгдүүлэлт)» гэлээ. Камерлинго чимээгүй л суув. Утасны цаанаас: «Та la purge гэж мэдэх үү? Арга байж уу дээ, гэлэн нар ер нь түүх муу мэддэг. Шашных нь түүх тэдэнд шившигтэй санагддаг байлгүй» гэв. «La purge гэдэг чинь» гэж Ландон өгүүлэн: «Мянга зургаан зуун жаран найман он. Шашныхан Иллюминатигийн дөрвөн эрдэмтний цээжин дээр загалмай сийлж тамгалсан юм. Нүглийг нь наманчлуулах гэж шүү дээ» гэлээ. «Хэн тэнд яриад байна вэ?» гэж утасны цаанаас зовнисон гэхээсээ шохоорхсон байдалтай дуугараад: «Энд, өөр бас хэн байгаа юм бэ?» гэлээ. Ландон чичрэх шиг болов. «Танд миний нэр сонин биш биз дээ» хэмээн зүрх алдсанаа мэдэгдэхгүйг хичээн, төв байдалтай хэлэв. Амьд Иллюминатустай ярина гэдэг түүхч хүний хувьд жигтэй хачин . . . яг л Жорж Вашингтонтой ярьж байгаа юм шиг. «Би зүгээр л танай нөхөрлөлийн түүхийг судалдаг номын хүн л дээ» гэлээ. «Таатай сонстож байна» гэж тэр хүн хэлээд: «Бидний эсрэг үйлдсэн гэмт хэргийг санаж явдаг амьд хүн байгаа нь сайхан байна шүү» гэв. «Гэхдээ, бидний дийлэнх нь танай нөхөрлөлийг устсан гэж боддог юм шүү» «Бид наад домгийг чинь хүмүүст үнэмшүүлэх гэж их чармайсан юм. La purge-ийн тухай өөр юм мэдэх вэ дээ?»

Ландон түгдэрсхийв. Өөр юу мэдэх вэ гэж үү? Энэ болоод байгаа юм хэтэрхий хурдан байна гэдгийг л мэдэж байна даа. «Тамгалсныхаа дараа, тэр эрдэмтдийг хөнөөгөөд, хүүрийг нь Ром хотын талбай дээр, олны нүдэн дээр бусад эрдэмтнийг Иллюминатитай нэгдүүзэй гэж сэрэмжлүүлэн хаяж орхисон юм». «Тийм шүү. Тэгэхээр бид ч бас тэгнэ. Quid pro quo (лат. Юуг вэ, тэрээр буюу нүдийг нүдээр) Анд нарынхаа өрийг авсан гээд л тооцчих. Танай кардиналууд найман цагаас эхлээд, цаг тутам нэг нэгээрээ талийна даа. Харин яг шөнө дунд, энэ дэлхий гайхан алмайрах болно». Ландон утас руу дөхөөд: «Та тэр дөрвөн кардиналыг тамгалаад хөнөөх гэж байгаа юм уу?» гэлээ. «Түүх давтагддаг шүү дээ, тийм биз дээ? Гэхдээ мэдээж, шашныхныг бодоход илүү эвлэг, чанд байх болно. Шашныхан манайхныг нэг нэгээр нь сэмхэн хороочоод, дараа нь хүүрийг нь өлгөсөн байсан шүү дээ, хулчгар байгаа биз?» «Та

юу гэв ээ?» гэж Ландон асуув. «Та нар тэднийг олны өмнө тамгалж, хөнөөх юм уу?» «Сайн байна шүү. Гэхдээ мэдээж, олны өмнө гэдэгт юуг ойлгох вэ гэдэг ч асуудалтай л даа. Одоо тэртээ тэргүй нэг их олон хүн сүм рүү яваад байдаггүй шүү дээ». Ландон бүр лавшруулан асуув. «Тэгээд та нар тэднийг бүр сүмд хөнөөх гэж байгаа юм уу?» «Саймширал гэх үү дээ. Сүнсийг нь танай бурхан чинь хурдан татаад аваасай гэсэн дээ л. Зөв биз дээ? Мэдээж, бас хэвлэлийнхэн энийг их л олзуурхах байх л даа». Оливетти: «Чи худлаа ярьж байна» гэж хүйтэн дуугаар хэлэв. «Та нар хүнийг сүмд хөнөөгөөд, гарч чадахгүй шүү дээ». «Худлаа гэнэ ээ? Бид танай Швейцар жардын дунд сүг сүнс шиг шургалаад, танай хэрмээс чинь дөрвөн кардинал хулгайлчхаад, бас болоогүй, хамгийн нандин шүтээний чинь доор үхлийн аюултай бөмбөг нуучхаад байхад та биднийг худлаа яриад байна гээд байгаа юм уу? Хөнөөчхөөд, хүүрийг нь олсны дараа хэвлэлийнхэн ч ёстой шавааралдах байх даа. Харин яг шөнө дунд хүн бүр Иллюминатийн их үйлсийг ухаарах болно». «Бүх сүмд харуулаа зогсоочихвол яах юм бэ, та нар?» гэж Оливетти хэлэв. Утасны цаанаас хүйтэн гэгч хөхрөв. «Танай шашны ажил хэрэгч байдал нээрэн тэгж магадгүй шүү, бүр айлгачихлаа байна. Та нар ингэхэд сүүлийн үед сүмээ тоолж үзсэн юм уу? Ромд дөрвөн зуу гаруй католик сүм байдаг юм шүү дээ. Сүм, дуган, хийд, зуу гээд л ... » Оливеттигийн царай барайсаар. «Ерэн минутын дараа эхэлнэ» гэж утасны цаанаас ярьж дууссан бололтой хэллээ. «Цаг тутам шүү. Үхлийн математик прогресс. За одоо би явах боллоо». «Хүлээгээрэй» гэж Ландон хэлснээ: «Та нар юугаар тамгалах гэж байгаагаа хэлж болох уу?» гэлээ. Алуурчин гайхаж орхив бололтой. «Ямар тамга байх вэ гэдгийг та аль хэдийн мэдчихсэн юм биш үү. Эсвэл та өөртөө итгэхгүй байгаа юм уу? Гэхдээ яах вэ, та тэртээ тэргүй удахгүй харна аа. Эртний домог үнэн гэдгийг харуулна даа». Ландон тэнэг юм асуучихсанаа гэнэт ойлгов. Тэр хүн юу хэлж байгааг Ландон маш сайн мэдэж байлаа. Тэр өөрийнхөө нүдээр Леонардо Ветрагийн цээжин дээрх тамгыг харсан билээ. Иллюминатигийн домог нийтдээ таван тамгын тухай ярьдаг ажээ. Ландон *дөрвөн кардинал болгонд зориулсан дөрвөн тамга үлджээ* гэж ойлгов. Камерлинго гэнэт: «Би өнөө шөнө шинэ Папыг сонгоно гэж бурхны нэрээр андгайлсан билээ» гэв. «Камерлинго!» гэж утасны цаанаас дуудаад: «Энэ дэлхийд шинэ Пап хэрэггүй. Тэр тэргүй шөнө дунд гэхэд тэрэнд чинь үнс нурмаас өөр засаглаад байх юм үлдэх ч үгүй. Католик шашны эрин өнгөрч, газрын хөрснөөс оргүй алга болно доо». Хэсэг аниргүй болов. Тэгснээ камерлинго ийн өгүүлэв. «Та нар эндүүрч байна. Сүм хийд гэдэг чинь чулуун хана төдий зүйл биш. Та нар хоёр мянган жилийн турш амьд байсан сүсгийг . . . ер нь ямар ч сүсгийг зүгээр л арччихаж чадахгүй шүү дээ. Та нар биетэй харагдах зүйлийг нь устгачхаад, сүсгийг нь устгачихлаа гэж болохгүй. Католик шашин Ватикантай, Ватикангүй оршсоор л байх болно.» «Сонсголонтой сайхан худлаа ярилаа. Гэхдээ худал гэдэг худал л байна шүү дээ. Бид хоёр хоёулаа үнэнийг мэднэ. Тэгвэл яагаад Ватикан хийдийг тойроод чулуун хэрэм байдаг юм бэ?» «Бурхны шавь нар аюултай ертөнцөд амьдарч байна шүү дээ» гэж камерлинго хариулав. «Та хэр залуу хүн бэ? Католик сүмийн эд баялгийн тал нь - ховор зураг, баримал, үнэт эрдэнэс, чухаг ном гэх мэт цөмөөрөө Ватиканд байдаг болохоор чулуун хэрмээр хүрээлсэн байдаг юм. Алтан гулууз, үл хөдлөх хөрөнгийн баримтууд бүгд Ватиканы банкны сангайд бий. Тэр болгоныг багцаагаар бодоход л 48.5 тэр бум ам.долларын хөрөнгө Ватикан хийдэд байгаа. Алтан өндгөн дээр сууж байгаа биз, та нар тэгэхээр? Гэхдээ маргааш гэхэд л наадах чинь үнсэн товрого болно. Та нар дампуурна. Хэн ч байсан та нарт үнэгүй ажиллахгүй шүү дээ». Хөрөнгийнх нь дүнг яг олж хэлсэн нь Оливетти, камерлинго хоёрын нүүрээс илт харагдаж байв. Ландон мэлэрч орхилоо. Ингэхдээ католик сүмийн хөрөнгийг гайхаа юу, эсвэл Иллюминати тэрийг нь тодорхой мэдэж байгааг гайхаа юу, ямар ч л байсан мэлэрч орхив. «Мөнгө биш, харин сүсэг л шашны

гол нуруу юм шүү дээ» гэж камерлинго санаа алдан учирлав. «Дахиад л худлаа. Өнгөрсөн жил та нар дэлхийн өнцөг булан бүрт байгаа дампуурахдаа тулсан диочесууддаа (католик сүмийн нутаг дэвсгэрийн хуваарь) 183 сая ам.долларын татаас өгч торгоогоо биз дээ? Сүмд явдаг хүний тоо улам бүр буурсаар, сүүлийн арван жилд л гэхэд дөчин зургаан хувь хорогдсон. Өргөл барьцын хэмжээ долоон жилийн өмнөхтэй харьцуулахад талд нь арай гэж хүрэхтэй үгүйтэй болсон. Семинарт улам л цөөн хүн хамрагдах боллоо. Хүлээн зөвшөөрмөөргүй байгаа ч гэсэн, шашин чинь мөхөж байна. Харин ч, бид та нарт хорвоог дуулиантай орхих боломж өгч байна шүү». Оливетти урагш алхлаа. Тэр шууд тэрсэлдсэн янзгүй байгаа нь өмнөө нүүрлэсэн байдлыг ухаарсан аястай байв. «Тэгвэл алтан гулдмайн зарим нь танай зорилгыг санхүүжүүлэхэд орвол яах вэ?» «Чи намайг төдийгүй өөрийгөө ч доромжлоод эхэллээ шүү дээ». «Гэхдээ бид мөнгөтэй шүү дээ». «Бид ч гэсэн. Бүр танайхаас их шүү». Ландоны бодолд Иллюминатигийн эрдэнэсийн тухай домог харван ирэв. Баварийн чулуун масоны хөмрөг, Ротшильд, Билдербэргэр, домогт Иллюминатигийн очир... «I prefereti» гэж камерлинго царайчлан: «Тэднийг өршөөчих. Тэд чинь настай хүмүүс шүү дээ» гэж ярианы сэдэв өөрчлөн гуйв. Утасны цаанаас хөхрөн: «Тэр чинь ариун онгон тахил маань юм шүү. Ингэхэд та тэднийг нээрэн онгоноороо байгаа гэж боддог уу, хэл дээ? Тэр бяцхан хэдэн хурганы амийг таслахад чарлах болов уу? *Sacrifici vergini nell'altare di scienza (uma. Шинжлэх ухааны тахилын өмнөх ариун онгон өргөл.)*» Камерлинго дуугаа хураан удаан суув. Тэгээд: «Тэд ариун сүсэгтэн билээ. Үхлээс айхгүй биз ээ» гэлээ. Цаад хүн харгин: «Леонардо Ветра бас л ариун сүсэгтэн байсан, гэхдээ л урьд шөнө намайг хөнөөж байхад нүдэнд нь айдас сүүмийж байсан юм даа. Тэр айдсыг нь би л дуусгасан даа, зайлуул». Энэ бүх хугацаанд огт дуугараагүй Виттория гэнэт улангасан цамнаж: «Asino (ита. Алуурчин)! Тэр хүн аав минь байсан юм» гэж хашхичив. Харилцуур чахраад цаанаас нь гайхсан бололтой: «Аав гэнэ ээ? Юу вэ, энэ чинь? Ветра охинтой байсан юм уу? Аав чинь эцэслэхдээ хүүхэд шиг гингэнэж байсан шүү. Өрөвдмөөр байж билээ, солиотой амьтан чинь» гэв. Виттория яг тэр үгэнд цохиулчихсан юм шиг, сулдаа унамагц, Ландон яаран түшлээ. Тэр сэргэж, тэнцвэрээ олоод, утас руу гүн хар нүдээрээ цоо ширтэв. «Би чамайг энэ шөнө өнгөрөхөөс өмнө олно гэж амь насаараа андгайлъя» гэж тэр хурц тод хэлэв. «Тэгээд ...» Хөхин инээх дуу утасны цаанаас сонсогдоно. «Эршүүд хүүхэн байна. Тачаал төрөм гээч. Магадгүй би чамайг энэ шөнө өнгөрөхөөс өмнө олоод, тэгээд...» Сүүлд хэлсэн үг нь илдээр шивэх шиг зарсхийлгэв. Тэгээд тэр утсаа тавилаа.

Хэсэг 42

Мортати кардинал ямбаны хар хувцастайгаа хөлрөн зогсоно. Систин цогчин саун шиг бүгчим, гэхдээ гол нь цуурган хорин минутын дараа эхлэх гэж байхад алга болсон кардиналууд сураггүй л байлаа. Тэд байхгүй болохоор, эхэндээ дүнгэнэн шивнэлдэж байсан кардиналууд одоо бүр илэрхий түгшингүй чанга чанга ярилцаж эхлэв. Дуулгаваргүй тэд хаачсаныг Мортати ухаарч чадахгүй байлаа. Камерлинготай байгаа байх. Камерлинго ёс гүйцээн тэр дөрвөн дэвшигчтэй үдээс хойш цай ууж суусан боловч түүнээс хойш хэдэн цаг өнгөрсөн байв. Өвдсөн юм болов уу? Болохгүй юм идчихээ юм болов уу? Гэхдээ Мортати тэгээгүй гэж мэдэж байлаа. Үхэх гэж байсан ч гэсэн дэвшигчид цуурганд ирэх ёстой байв. Кардинал хүн Дээд Пап болно гэдэг энэ насанд нэг л заяах, бүр заяах ч үгүй завшаан бөгөөд Ватиканы хууль ёсоор санал хурааж байх үед тэр кардиналууд Систин цогчны дотор байж байх ёстой ажээ. Үгүй бөгөөс зохисгүй этгээд тэднийг үзнэ. Хэдийгээр дөрвөн дэвшигч байсан ч цөөхөн кардиналаас бусад нь дараагийн Пап хэн болохыг тодорхой мэдэж байлаа.

Сүүлийн арван тав хоног дараагийн нэр дэвшигчийн талаар мөн ч олон факс илгээж, мөн ч олон утсаар ярьсан билээ. Гэхдээ заншил ёсоор дөрвөн дэвшигч шилж, дөрвүүлээ Пап болох шалгуурыг чимээгүйхэн давсан байлаа. *Итали, Испани, Англи хэлээр чөлөөтэй ярьдаг. Шүүгээндээ араг яс хадгалаагүй. Жаран таваас наян насны хооронд.* Гэхдээ тэр дөрвөөс сонговол зохих нэгэн илэрхий тодордог байлаа. Энэ удаа тэр хүн бол Миланы кардинал Алдо Баггиа байлаа. Түүний сэвгүй зүтгэл, хэлний хосгүй авьяас, шашны амин чухал асуудлаар чин үнэн харьцдаг нь түүнийг эргэлзээгүй ялах дэвшигч болгож байв. *Тэр чөтгөр чинь хаачдаг байна аа?* Мортати цөхөрч эхлэв. Энэ цуурганыг ахлах үүрэг өөрт нь ногдсон болохоор, Мортати алга болсон кардиналуудын хойноос чин сэтгэлээсээ түгшиж байлаа. Долоо хоногийн өмнө Кардиналын чуулган түүнийг цуурганы дотоод жаягийг мөрдүүлэх үүрэгтэй Их сонгогч болгон нэгэн дуугаар сонгожээ. Хэдийгээр хийдийн дотоод хэргийг камерлинг ахлан гүйцэтгэж байсан авч, тэр дөнгөж гэлэн зэрэгтэй байсан бөгөөд сонгуулийн дотоод нарийн жаягийг мэдэхгүй нэгэн байсан тул кардиналууд Систин цогчин дотроосоо нэгнийгээ эл жаягийг мөрдүүлэхээр сонгожээ. Их сонгогч болно гэдэг Христ шашны дотор хамгийн азгүй эрхэмлэл хэмээн кардиналууд хошигнодог ажээ. Энэ тушаалд сонгогдсон хүн Папад нэр дэвших эрхгүй болоод зогсохгүй цуурган болохоос хэд хоногийн өмнөөс эхлэн *Universi Dominici Gregi* судрыг эргүүлэн сонгуулийг амжилттай явуулахын тулд нарийн ширийнийг ухан, шарласан хуудсыг элээн суух хэрэгтэй болдог байна. Мортати гэхдээ гомдоллосонгүй. Тэр энэ тушаалд буухаа ч мэдэж байв. Кардиналууд дундаа хамгийн ахмад нь, бас сүүлийн Папын итгэлт хүн байлаа. Хэдийгээр хуулийн дагуу Папад сонгогдох эрхтэй хэдий ч бусадтайгаа хүчтэй өрсөлдье гэхэд арай л хөгшдөнө. Далан есөн настай түүнд ямар ч кардинал Папын ажлын хүнд, завгүй хөдөлмөрийн пянг даах эрүүл мэндтэй гэж найдан саналаа өгөхгүй билээ. Пап долоо хоногийн долоон өдөр, өдөрт арван дөрвөн цаг ажиллаж, цуцаж туйлдсандаа дунджаар 6.3 жилийн дараа өөд болно. Пап болно гэдгийг «тэнгэр рүү хурдан очих зам» ч гэж хатуухан хошигнодог байна. Мортатиг хэтэрхий уужим сэтгэлтэй биш байсан сан бол арай залуу байхдаа Пап болчих байсан юм гэж олон хүн боддог байлаа. Пап болохын тулд гурван зарчмыг хатуу барих ёстой, тэдгээр нь консервативизм, консервативизм бас дахин консервативизм ажгуу. Мортати сүүлийн Папыг, бурхны авралаар, албаа авсныхаа дараа гайхмаар либерал байсныг нь санан олзуурхдаг байлаа. Орчин үеийн дэвшил шашнаас алслан одож байгааг мэдэрснээс тэр үү, Дээрхийн гэгээнтэн эрдмийн тухай дахь шашны байр суурийг зоримог зөөллөн, зарим нэг судалгаа шинжилгээг хүртэл санхүүжүүлжээ. Үүнийх нь төлөө түүнийг, консерватив католикууд «зөнөг» гэж, харин эрдмийн пуристууд шашны нөлөөг байх ёсгүй газар нь халдварлуулах гэж оролдлоо хэмээн үзэж чаддаггүй байжээ. «Тэд хаачиж орхив доо?» Мортати бодолдоо умбасан хэвээр. Зарим кардинал хүрч ирээд, мөрөн дээр нь алгадан: «Тэднийг хаачсаныг нь та эрх биш мэдэж байгаа биз дээ, тийм ээ?» гэж хүртэл асууна. «Камерлинготай хамт байгаа биз дээ» гэж Мортати санаа зовнисноо нуух гэж оролдон хэлэв. «Одоо хүртэл үү? Энэ чинь нэг л хэвийн бус юм биш үү?» Тэр кардинал Мортати руу үл итгэсэн байртай хараад: «Камерлинготон цагийн баримжаа алдсан байх аа» гэлээ. Мортати тэгж бодохгүй байсан ч өөр юм хэлж чадсангүй. Дийлэнх кардинал камерлингог тоодоггүй, Папад тийм ойр ажиллахад хэт залуудах хүн гэдэг байлаа. Дийлэнхдээ, зүгээр л атаархал төдий ажээ. Мортати тэр шижигнэсэн залууг бахдаж, Паптан гарын даагаа болгосныг дотроо сайшаадаг байв. Камерлинг итгэл төгс харагддаг, бусад кардиналыг бодоход шашин, сүсэг хоёрыг ойр зуурын улс төрийн хов живээс илүүд үзэн зүтгэж чаддаг нэгэн байв. Үнэхээр л бурханлаг хүн ажгуу. Гарын даа хийж байхдаа, камерлингогийн гаргасан гавьяа зүтгэл домог болсон байлаа. Олон хүн үүнийг бага насанд

нь тохиосон явдалтай холбон үздэг бөгөөд ... тэр явдал ямар ч хүний зүрхэнд гүн сэтгэгдэл үлдээх бөлгөө. Гайхамшиг. Тийм чин сүсэг илрэх гайхалтай мөч өөрийнх нь хүүхэд насанд тохиогоогүйд Мортати гонсойдог байлаа. Гэхдээ, камерлинго хөгшин болсон хойноо ч Пап болох хувьгүй гэдгийг Мортати мэдэж байлаа. Пап болохын хувьд улс төрийн хүчтэй амбиц хэрэгтэй, тийм амбиц даан ч алга байв. Сүүлчийн Паптан түүнийг захиргааны дээгүүр тушаалд тавья гэж удаа дараа санал тавьж байсан ч: шашинт эгэл хүний хувиар зүтгэмээр байна хэмээн, тухай бүр татгалзаж байжээ. «Одоо яах вэ?» гэж нөгөө кардинал Мортатигийн мөрөн дээр гараа тавин асуув. Мортати толгойгоо өндийлгөн: «Юу гэнэ ээ?» гэв. «Тэд хоцроод байна. Тэгэхээр, бид яах ёстой юм бэ?» «Бид юу хийх вэ дээ. Хүлээе, бас сүсэглээ» гэлээ. Мортатигийн хэлсэн үг сэтгэлд нь нийцээгүй бололтой, кардинал мөрөө хавчаад олны дунд уусан алга болов. Мортати оюунаа хөвчлөн, ухаанаа саруулсгах гэж хэсэг зогсов. Нээрэн, одоо яадаг хэрэг вэ? Тэрээр хоймрын шүтээний дээр байх Микланжелогийн урласан «Эцсийн шүүлт» хэмээх зургийг ширтэнэ. Тэр зураг дээр цухалдлыг нь тайтгаруулах юу ч байсангүй. Харин ч аймшиг төрүүлэм: тавин тохой өндөр Есүс Христос хүн төрөлхтнийг буянтан, нүгэлтэн хэмээн ялгаж, нүгэлтнийг нь там руу илгээх ажээ. Арьсыг нь өвчиж, махыг нь шарж, бүр Микланжелогийн нэг өстөн нь тамын гал дээр суусан харагдана. Гай дэ Мопаса нэгэнтээ энэ зургийг мах худалдах мухлагт зориулж, хэнэггүй галч зурсан юм шиг гэж хүртэл бичжээ. Мортати кардинал: «Тийм ч юм уу» гэж бодлоо.

Хэсэг 43

Ландон Папын өрөөний сум нэвтгэрдэггүй цонхны дэргэд зогсоод, доошоогоо Гэгээн Петерийн талбай дээр бужигнах хэвлэлийн мухлаг тэргүүд рүү ширтэнэ. Дөнгөж сая утсаар ярьсан хачин ярианыхаа дараа, нэг л эвгүй сэтгэгдэлтэй үлдсэн байлаа. Иллюминати ингэж гэнэт гарч ирсэн нь, эртний үлэг гүрвэл гэнэт мөлхөж ирээд ангаа тойрон хоргоох шиг л санагдана. Ямар ч шаардлага тавихгүй, ямар ч хэлэлцээ хийхгүй. Гагцхүү хонзонгоо авна. Энгийн, муу ёрын. 400 жилийн өс. Зуун зууны турш яллагдсан эрдэм эргэж ирээд, боргож байгаа юм шиг. Камерлинго ширээнийхээ дэргэд зогсоод, утас руугаа ширтэнэ. Гэтэл Оливетти чимээ аниргүйг эвдэн дуугарав. «Карло» гэж цэрэг нь биш, харин анд нөхөр нь дуудаж байгаа юм шиг камерлингог нэрээр нь дуудаад: «Би хорин зургаан жил энэ газрыг амиараа хамгаална гэж тангараглан, алба хаасан юм сан. Харин өнөөдөр өөрийгөө шившиглэчихлээ» гэв. Камерлинго толгойгоо сэгсрээд: «Та бид хоёр өөр өөрийнхөө замаар бурханд зүтгэж байгаа. Зүтгэл ямагт алдар авчирдаг» гэлээ. «Энэ явдал ... яаж яваад ийм болчхов оо ... энэ нөхцөлд» гэж гонгинон, Оливетти өөрийгөө хянаж чадахаа болив бололтой. «Бид ганцхан л юм хийх ёстой. Би кардиналын чуулганыг аюулгүй байлгах үүрэгтэй». «Наадахь чинь миний үүрэг шүү дээ, сениорь» гэж Оливетти хэлэв. «Тэгвэл чи хүмүүстэйгээ хамт даруй нүүлгэн шилжих явцыг удирд». «Сениорь?» «Бусдыг нь дараа хийж болно. Тэр төхөөрөмжийг олох, алга болсон кардинал, барьцаалсан этгээдүүдийг хайх гэх мэт. Гэхдээ хамгийн гол нь кардиналууд аюулгүй байх ёстой. Хүний амь гэдэг хамгийн чухал. Тэр хүмүүс бол энэ шашны суурь шүү дээ». «Та цуурганыг цуцлах гэж байгаа юм уу?» «Өөр арга байгаа юм уу?» «Шинэ Паптаныг сонгоход туслах ёстой таны үүрэг яах билээ?» Гарын даа санаа алдан цонх руу эргээд, тэртээ доор шавааран бужигнах Ром хотыг ширтэнэ. «Дээрхийн гэгээн надад айлдахдаа, Пап гэдэг бодит болоод ариун ертөнцийн дунд тэлэгдсэн хүн юм. Бодит ертөнцийн сорилтыг тоомсорлоогүй ямар ч шашин, ариун ертөнцөд үлдэж чадахгүй гэж

айлдаж билээ» гэв. Залуу хүн гэхэд их л цэцэн мэргэн ярьж байлаа. «Бодит ертөнцтэй бид нүүр тулаад байна. Тоомсорлохгүй бол бид өөрсдөө сүйрнэ. Хэдий бардам ч гэсэн учир шалтгааныг анхаарах чухалтай» гэлээ. Оливетти толгой дохин: «Би таныг дутуу үнэлж байжээ, сениорь» гэв. Камерлинг сонсоогүй юм шиг, цонхоор алсыг ширтэн зогсоно. «Илэн далангүй ярихыг зөвшөөрнө үү, сениорь. Бодит ертөнц гэдэг миний ертөнц. Би өдөр бүр ийм заваан юмтай нооролдож, бусад хүн сайхан гэж хардаггүй юм хийдэг. Үүссэн цагийн байдлын тухайд, танд зөвлөхийг болгооно уу. Би үүнд л дадлагажсан хүн. Таны хэлснийг хүндэтгэж байгаа боловч ... яг одоо бол сүйрэлд хүргэх аюултай юм». Камерлинг эргэж харав. Оливетти санаа алдаад: «Кардиналын чуулганыг Систин цогчноос нүүлгэнэ гэдэг байж болох хамгийн муу арга» гэлээ. Камерлинг доромжлуулсандаа биш, харин гайхсандаа: «Та, тэгээд, яамаар байгаа юм бэ?» гэв. «Кардиналуудад юу ч битгий хэл. Цуурганыг түгж. Тэгвэл бид бусад боломжоо ашиглах цаг гарна». Камерлинг санаа зовсон шинжтэй: «Та намайг кардиналын чуулганыг бүхэлд нь цэнэгтэй бөмбөгөн дээр суулгаж бай гээд байгаа юм уу?» «Тийм, гэхдээ түр. Шаардлага гарвал, дараа нь бид нүүлгэж болно». Камерлинг толгой сэгсрээд: «Цуурганыг эхлэхээс нь өмнө л хойшлуулж болно. Хэрэв нэг түгжчихвэл, юу ч үймүүлж болохгүй. Цуурганы явцад ...» «Бодит ертөнц, эрхэм ээ. Өнөө шөнө тэр чинь нүүрлэхээд байна. Сонс доо» гээд Оливетти дайны талбарт байгаа офицер хүний шуурхай хэллэгээр ярьж эхлэв. «Зуун тавин зургаан кардиналыг ямар ч бэлтгэлгүй, ямар ч хамгаалалтгүй Ромын гудамжаар авч явна гэдэг бол сүйрэл. Хөөрхий хөгшид тэвдэж, сандарна. Үнэнийг хэлэхэд, нэг хөгшин зүрхний шигдээсээр өөд болсон нь хангалттай шүү дээ». Зүрхний шигдээс. Захирагчийн үг Ландон Харвардын сургуулийн оюутнуудтайгаа оройн зоог барьж байх зуураа уншсан сонины гарчгийг санагдуулав: ПАПТАН ЗҮРХНИЙ ШИГДЭЭС ТУСЧ, НОЙРСОЖ БАЙХДАА ӨӨД БОЛЖЭЭ. «Түүнээс гадна» гэж Оливетти үргэлжлүүлэн: «Систин цогчин бол цайз. Байдал эгзэгтэй байгаа ч гэсэн энэ цайзыг бат бэхэлсэн, багахан пуужингаар буудсан ч ажрахгүй. Өнөөдөр үдээс хойш цуурганд бэлтгэх гэж бид шалгаж, ямар нэг дамжуулах хэрэгсэл, төхөөрөмж байх вий гэж ямх бүрийг нэгжиж үзсэн. Дуган цэвэрхэн, аюулгүй. Ямартай ч антиматери тэнд байхгүй гэж би бат нот хэлнэ. Одоохондоо, кардиналуудад тэрнээс өөр аюулгүй газар байхгүй. Шаардлага гарвал, нүүлгэх тухай ярьж амжина» гэлээ. Ландон Оливеттиг бахдав. Түүний хүйтэн, алдаагүй логик яг л Колэр шиг байлаа. «Захирагч аа!» гэж Витториа сандрангуй хэлээд: «Санаа зовних юм мундахгүй шүү. Хэн ч өмнө нь ийм их антиматери гаргаж байгаагүй юм. Тиймээс дэлбэрэлтийн радиусыг зөвхөн багцаалж л болно. Ром хотын ойр орчмын газар ч аюулд өртөж болзошгүй. Канистер тэр төв хэсэгт байгаа байшингуудад юм уу, эсвэл газар доор байвал дэлбэрэлтийн хүрээ бага байж магадгүй, гэхдээ гадагшаа ойрхон, хэрмийн дэргэд, жишээ нь энэ байшинд ч юм уу байвал ...» гэснээ, Гэгээн Петерийн талбай дээр хурсан олон руу харлаа. «Би гадаад ертөнцийг хамгаалах үүрэгтэйгээ ухамсарлаж байна, гэхдээ энэ байдлыг улам ч дордуулна» хэмээн Оливетти хариулав. «Би хорин жилийн турш энэ цогцолборыг хамгаалах үүрэг хүлээсэн. Тиймээс би тэрийг дэлбэлүүлчихмээргүй байна шүү». Вентреска камерлинг түүн рүү эгцэлж хараад: «Та олж чадна гэж бодож байна уу?» «Эхлээд би ажиглалтын мэргэжилтнүүдтэйгээ зөвлөх хэрэгтэй байна. Хэрвээ Ватикан хийдийн цахилгааныг таслаад RF суурийг арилгаж, цэвэр орчин үүсгэж чадвал, канистерын соронзон талбайг илрүүлж болох юм». «Та Ватиканыг таг харанхуй болгох гээ юу?» гэж Витториа дуу алдан гайхав. «Магадгүй. Гэхдээ ингэж болох эсэхийг би тодорхой мэдэхгүй байна. Гэхдээ л үүнийг судлах хэрэгтэй». «Гэхдээ, тэгэх юм бол, кардиналууд юу болоод байгаа юм бэ гэж гайхна биз дээ» гэж Витториа асуув. Оливетти толгой сэгсрээд:

«Цуурганыг лааны гэрэлд хийдэг юм. Кардиналууд юу ч мэдэхгүй. Тэднийг түгжсэнийхээ дараа, бид хийдийн харуулд хэдэн хүнээ үлдээгээд, үлдсэнийг нь эрэлд дайчилна. Зуун хүн таван цагийн дотор овоо гайгүй талбайг самначихна» гэлээ. «Дөрвөн цаг» гэж Витториа хэлээд: «Канистерыг олоод би СЭРН рүү эргээд нисэх ёстой. Цэнэглэхгүй бол тэсрэх нь гарцаагүй» гэв. «Энд цэнэглэх арга байхгүй юм уу?» Витториа толгойгоо сэгсрээд: «Суурь их төвөгтэй механизм. Болдог байсан бол би энд аваад ирэхгүй юу» гэв. «За яах вэ, тэгвэл дөрвөн цаг» гэж Оливетти барайн хэлээд: «Гэхдээ л цаг хангалттай. Сандраад нэмэргүй. Сениорь, танд арван минут байна. Очоод цуурганыг түгжчих. Хүмүүст маань ажлаа хийх цаг хэрэгтэй. Цаг дуусах дөхөөд ирэхээр, хамгийн эрсдэлтэй шийдвэрээ гаргая» гэлээ. Ландон Оливеттиг шийдвэрээ өөрчилтөл: «цаг дуусах дөхөх» гэж хэдий хэр хугацааг хэлээд байгааг сайн ойлгосонгүй. Камерлинго түгшингүй харагдана. «Гэхдээ кардиналууд надаас дэвшигчид... ялангуяа, Баггиа хаачив гэж асууна шүү дээ». «Та нэг юм бодоод л хэлчихгүй юу дээ, сениорь. Та цай уух зуураа юм яриад, ойлголцож чадалгүй салсан гэхгүй юу». Камерлинго гайхан асуув. «Систин цогчны хоймрын шүтээний өмнө зогсоод, кардиналуудын чуулганд худал хэлэх хэрэг үү?» «Тэдний л аюулгүй байдлын төлөө шүү дээ. Una bugia venial Цайлган хуурах. Таны ажил бол энх амгаланг хадгалах». Оливетти хаалга руу эргэн: «Та бүхнийг болгоовол, би одоо явж, даруй эхлэх хэрэгтэй байна» гэлээ. Камерлинго: «Захирагч аа, бид алга болсон кардиналуудыг ингээд хаячхаж болохгүй шүү дээ». Оливетти хаалганы дэргэд зогсоод: «Баггиа тэр хэд, яг одоо, манай нөлөөлж чадах хүрээний гадуур байна. Бид тэднийг орхихоос өөр аргагүй ... бусдынх нь тусын тулд шүү дээ. Цэргийнхэн үүнийг triage (ита. Гарах ёстой хохирол) гэдэг юм». «Та хаях гээд байна уу?» Оливеттигийн дуу чангараад: «Сениорь, хэрэв тэр дөрвийг олох ямар нэг арга байгаа бол би амиа ч өгөхөд бэлэн байна. Гэхдээ харамсалтай нь,» гэж зогтусан, Ромын тоолж томшгүй олон байшингийн дээвэр дээр ойх оройн нарны алтрах туяа цацрах цонх руу чичлэн зааж: «Таван сая хүнтэй хотыг самнана гэдэг миний барах ажил биш. Би хором бүр нь үнэтэй байгаа цагаа биелэхэд хэцүү зорилтод зарцуулмааргүй байна. Өршөөгөөрэй!» гэлээ. Витториа гэнэт: «Хэрэв бид алуурчныг барьчихвал түүнийг яриулж чадах уу?» гэв. Оливетти түүн рүү хувьсхийн хараад: «Цэрэг хүн гэгээн байдаггүй юм, Ветра авхай. Би тэр хүнийг барих гэсэн таныг санааг ойлгож байна» гэлээ. «Зөвхөн хувийн шалтгаан байгаа юм биш» гэж хариулаад: «Хэрэв бид алуурчныг баривал, тэр антматери хаана байгаа, алга болсон кардиналууд хаана байгааг мэднэ. Яаж ийгээд барьчихвал шүү дээ». «Үгүй дээ» гэж Оливетти хэлээд: «Зуу зуун сүмийг нэгжихийн тулд Ватикан хийдийн бүх хамгаалалтыг буулгана. Аягүй бол, энийг л Иллюминати анаж байгаа биз. Цаг алдана, хүн хүч алдана. Тэгээд, бас Ватиканы банкиг, үлдсэн кардиналуудтай нь хамт хамгаалалтгүй үлдээнэ гэсэн үг» гэлээ. Тэр яг онож хэлжээ. «Ромын цагдаагийн газрыг дуудах юм уу?» гэж камерлинго санал болгов. «Бид цагдааг дайчилбал хот даяар харуултай болно гэсэн үг. Тэднийг, кардиналыг барьцаалсан этгээдийг олоход туслаач гэж болно шүү дээ.» «Бас л болохгүй» гэж Оливетти хариуллаа.» Та Ромын Карбинерууд бидний тухай юу гэдгийг мэднэ шүү дээ. Бид хэдэн хүн олж, тэд нь бидэнд туслах гэж мэрийхгүй, харин ч энэ үйл явдлыг дэлхий даяар цацчихна. Дайснууд маань энийг хүлээж байгаа шүү дээ. Бид бас хэвлэлийнхэнтэй учир зүйгээ даруй ололцох ёстой болно.» *Танай кардиналуудаар хэвлэлийг шуугиулна даа гэж хэлсэн нь бодогдов. Эхний кардиналын хүүрийг найман цагт олно. Ингээд цаг тутам нэгийг олно. Хэвлэлийнхэн ч дуртай байх болно доо.* Камерлинго уурсангүй аястай дахин өгүүлэв. «Захирагч аа, бид алга болсон кардиналуудын тухайд юу ч хийхгүй байж болохгүй шүү дээ». Оливетти камерлинго руу үхсэн юм шиг зэвхий нүдээр гөлрөв. «Гэгээн Франсисийн мөргөлийг санаач, сениорь». Залуу гэлэн

хоолойдоо зовнил тодруулан нэг мөр цээжээр хэллээ. «Бурхан минь, өөрчилж дийлэхгүй бүхнээ хүлээн авах чадал надад хайрлаач!» «Надад итгэж үз. Энэ мөргөл үүний л тухай юм шүү дээ» гэж Оливетти хэлээд гарч одов.

Хэсэг 44

Британийн өргөн нэвтрүүлгийн корпорацын (BBC) төв алба Лондон хотноо Пикадилли тойргийн яг баруухнаа оршино. Хянах самбар дахь утас жингэнэн дуугарахад, дугаарын туслах редактор харилцуураа авлаа. «BBC сонсож байна» гэж бүсгүй хэлээд, Данхиль янжуурынхаа үнсийг унагааж сууна. Утасны цаадах хүн хахир дуутай, Ойрх дорнод аялгаар ярих. «Танайх сонирхож магадгүй шуурхай мэдээ надад байна». Редактор стандарт Мэдээ бүртгэлийн маягтаа аваад, харандаагаа зэхээд: «Юун тухай юм бол?» гэлээ. «Папын сонгуулийн тухай». Бүсгүйн сонирхол буучхав. BBC өчигдөр урьдчилсан байдлаар танилцуулах мэдээ явуулсан, олон нийт Ватикан хийдэд өрнөн буй явдлыг төдий сонирхохгүй байгаа болтой байв. «Аль талаас нь мэдээлэх юм бэ дээ?» «Энэ сонгуулийг ажиглахаар танайх ТВ сурвалжлагчаа Ром руу илгээсэн биз дээ?» «Тэгсэн байх аа». «Түүнтэй л шууд яримаар байна». «Уучлаарай, ямар нэг урьдчилсан мэдээлэлгүйгээр, би танд тэр дугаарыг өгч болохгүй шүү дээ ...» «Цуурганд аюул учраад байна гэж л танд хэлье дээ». Редактор тэмдэглээд авлаа. «Таны алдар?» «Миний нэрийг мэдээд хэрэггүй». Редактор гайхсандаа: «Таны саяын хэлсэнд чинь нотолгоо байгаа юм уу?» «Бий.» «Би таны мэдээллийг дуртай яа авмаар байна. Гэхдээ, газар дээр байгаа сурвалжлагчийнхаа утасны дугаарыг өгдөггүй журамтай юм л даа». «За мэдлээ. Тэгвэл би өөр газар руу утастъя даа. Цаг гаргасанд баярлалаа, баяртай...» «Байзаарай, түр байзнаарай. Та утсаа барьж байхгүй юу» гэж бүсгүй хэллээ. Редактор утсаа хүлээлэг дээр тавиад, хүзүүгээ шилгээн суниав. Утасны дуудлагыг сорих тийм ч нарийн ухаан биш боловч, энэ хүн дөнгөж сая утсаар ирэх мэдээг сорих BBC-ийн хоёр нарийн сорилтыг давж орхив. Тэр нэрээ хэлэхээ татгалзаад, утсаа тавихад бэлэн байлаа. Хэг ёг хийх, хэнэггүй царайлах нь үнэмшилтэйд тооцогддог ажээ. Аз болоход, сурвалжлагч бүр шуугиан тарих мэдээнээс хоцорчих вий гэсэн айдастай амьдардаг болохоор солиотой хоосон мэдээний хойноос гүйлгэлээ гэж редактортаа унтууцах хүн байдаггүй байлаа. Сурвалжлагчийн таван минутыг дэмий юманд үрж болно. Харин дуулиант хэргийг бол болохгүй. Бүсгүй залхуутай яа нэг эвшээгээд, дэлгэц рүүгээ ширтэн компьютерийнхаа гар дээгүүр хуруугаа сурмаг гэгч гүйлгэн: «Ватикан хийд» хэмээн түлхүүр үгээ шивэв. Папын сонгуулийг ажиглаж байгаа сурвалжлагчийн нэр төдөлгүй гараад ирлээ, түүнийг уншмагцаа «хн...» гэж ёжтой ёо, бас хайхрамжгүйхэн дуу алдав. Тэр сурвалжлагч BBC-д шинээр орсон залуу байсан агаад Лондоны новш шиг шар сонинцруудын нэгээс татаж аваад, хамгийн уйтгартай үйл явдлыг ажиглуулахаар илгээчихсэн байв. Редакцынхан, тэр залууг бүр шавар хутгахаас эхлүүлэх гэсэн бололтой. Тэр залуу аравхан секундйн сурвалжлага хийх гэж бүхэл шөнөжингөө хөшиж үхтлээ сууж байгаа даа. Шуурхай мэдээгээр зурвасхан гарах нь түүний хувьд аз заяа байлтай. BBC-ийн дугаарын эрхлэгч - сурвалжлагч залуугийн Ватикан хийд дэх утасны өргөтгөлийг хуулж, дахин нэг тамхи асаан гүнзгий гэгч сороод, санаа алдан байж утсаа аваад, сурвалжлагч залуугийн утасны дугаарыг хэлж өгөв.

Хэсэг 45

Тэгж болохгүй» гэж Витториа Папын өрөөнд алхлан камерлингогийн нүүр рүү ширтэн хэлэв. «Цвейцарь жард цахим долгионыг барьсан ч гэсэн тэгж барьтлаа канистерын яг дээр нь байсаар л байх болно. Тэгээд дээрээс нь, хэрэв канистерыг ямар нэг саадын ард юм уу,

юман дотор хийгээгүй бол шүү дээ. Газар доогуур төмөр хайрцагт хийчихсэн байвал яах вэ? Эсвэл тэр хайрцгийг нь долгион ойлгодог гялгар цаасанд ороочихсон бол яах вэ? Тэгвэл ёстой яаж ч оролдоод, долгион барьж чадахгүй. Ингэхэд ер нь, Швейцар жардад тэднийг нэвтрээгүй гэж хэн батлах юм бэ? Тэгвэл хайсан ч гэсэн, олигтой хайж чадахгүй шүү дээ». Камерлинго цөхөрсөн байртай хараад: «Ветра авхай! Танд, тэгээд, арай илүү санаа байна уу?» гэлээ. Ветра түр гацасхийв. Мэдээж байхгүй л байна. Тэгснээ: «Би таныг болгоомжлох үүднээс өөр арга хэмжээ даруй аваач ээ гэж байна. Захирагчийн хайлт амжилттай болно гэх ямар ч найдлага байхгүй: гэхдээ найдахаас өөр замгүй. Бас нэг асуудал бий. Тэр цонхоор хар даа. Тэр хүмүүсийг хар. Тэр байшингуудыг хар. Тэр хэвлэлийнхний мухлаг тэрэгнүүдийг хар. Жуулчдыг хар. Тэд бараг л дэлбэрэлтэд өртөж таарна. Тиймээс одоо даруй нэг юм хийх хэрэгтэй байна» гэлээ. Камерлинго толгой дохиж суув. Ветра эгдүүцэн зогсоно. Оливетти өрөөнд байгаа хүмүүст цаг байгаа гэж итгүүлчхээд, гараад явчихсан байв. Хэрэв энэ тухай мэдээ Ватиканаас гадагш алдагдчихвал, Гэгээн Петерийн талбай хормын дотор л сониуч хүмүүсээр дүүрэх байлаа. Швейцарийн парламентын байшинд бөмбөг тавьж, хүн барьцаалсан гэх мэдээгээр, юу болохыг нь харах гэсэн мянга мянган сониуч хүн гадна цуглаж байсныг Ветра саналаа. Цагдаагийнхан аюултай гэдгийг сануулсаар байсан ч, хурсан олон парламентын байшин руу алхам алхмаар ойртож байжээ. Хүний мууд дурлахаас өөр сонин юм энэ хорвоод үгүй гэлтэй. Витториа улам шаргуу мэтгэнэ. «Сениорь! Аавыг минь хөнөөсөн хүн тэнд, хаа нэгтээ байгаа. Би гүйж гараад тэр хүнийг олж, намнахыг бүх эд эс, ширхэг нэг бүрээрээ тэмүүлж байна. Гэхдээ, би ингээд таны албан өргөөнд ... таны өмнө хариуцлага хүлээх ёстой учраас зогсож л байна. Таны өмнө, бүх хүний өмнө. Хүмүүсийн амь нас хутганы ирэн дээр байна. Та ер нь намайг сонсож байна уу?» Камерлинго дуугүй сууна. Зүрхний цохилт нь Витториагийн чихэнд сонстож байв. *Яагаад Швейцар жард тэр новишийн утсыг нь мөшгөж илрүүлж чадсангүй вэ? Иллюминатигийн алуурчин чинь л гол сээжим юм биш үү? Тэр л антимагери хаана байгааг хэлж чадна, тэр л кардиналууд хаана байгааг хэлнэ шүү дээ. Алуурчныг барь, тэгээд л боллоо.* Витториа жолоогүй уурлаж эхлэв. Тэр бүр багадаа, асрах газар байхдаа л биеэ барьж чадалгүй, ингэтлээ уурлаж байснаа бүүр түүр санана. *Нэг арга байгаа, нэг арга байж л таарна* гэж өөртөө шивнэв. Гэсэн ч тус болсонгүй. Оюун санаа нь хүнийсээд, тогтоож барихад бэрх болжээ. Витториа судлаач, асуудлыг шийддэг хүн байв. даан ч энэ асуудалд ямар ч шийдэл байсангүй. *Ямар өгөгдөл надад хэрэгтэй билээ? Би яах гээд байгаа билээ?* Гүнзгий амьсгаа авах хэрэгтэй гэж өөртөө хэлсэн ч, амьдралдаа анх удаа тэгж чадсангүй, харин ч бүр амьсгаа авах гэж бөглөрөхөө шахав. Ландоны толгой нь өвдөнө. Бодол нь тархиных нь ирмэгээр гулсаад, гүнзгий тогтож чадахгүй байх шиг. Витториа, камерлинго хоёр өмнө нь байсан ч, нүдэнд нь дэлбэрч байгаа атомын бөмбөг, хүмүүсийн шуугиан, камерын бичлэг, тамгалсан дөрвөн хүн сүүмийн үзэгдэнэ. *Шайтан ... Люцифер ... Гэгээ авчрагч ... Сатаан ...* Тэр муу ёр зөгнөсөн бодлоо хөөх гэж оролдоно. Сэтгэх санаа олох гэж: *Нарийн төлөвлөсөн террорист ажиллагаа гэж амандаа бувтнана. Самуун өдөөх гэсэн төлөвлөгөө.* Радклиффийн терроризмын тухай семинарт нэг удаа сууж байснаа саналаа. Түүнээс хойш тэр терроризм гэдгийг огт өөрөөр төсөөлөх болжээ. Лекц уншиж байсан багш: «Терроризм ганц л зорилготой байдаг. Тэр нь юу гэж та нар бодож байна даа?» «Гэм зэмгүй олныг хөнөөх» гэж нэг оюутан таав. «Буруу байна. Хүний амь хөнөөнө гэдэг терроризмын дайвар бүтээгдэхүүн юм шүү дээ». «Хүч чадлаа гайхуулах». «Үгүй ээ. Тэд дорой биш гэдэг нь уулаасаа ойлгомжтой.» «Террорт автуулах, айлгах» «Яг зөв. Тун амархан. Терроризмын гол зорилго бол айлгах юм. Айдас хүмүүсийн итгэлийг эвддэг, төр засаг, шашин шүтлэгт бишрэх тэр сүсгийг сарниулдаг. Айдас, ингэж,

дайсны дотоод эвийг сарниулж доройтуулдаг. За бичээд ав. Терроризм бол бухимдлын илрэл биш, харин улс төрийн зэвсэг. Засгийн газрын ялагдашгүй гэдэг багийг нь авч хаяхын тулд хүмүүсийнх нь итгэлийг үгүй хий.» *Итгэлийг үгүй хийх...* Энд л гол учир нь байгаа юм биш үү? Дөрвөн кардинал зэрэмдэглэсэн нохой шиг болчхоод үхсэн хэвтээг харвал, даян дэлхийн христ шашинтнууд яах бол гэж Ландон бодов. Гэлэнгийнх нь сүсэг өөрийг нь Сатаанаас аварч чадахгүй байхад, үлдсэн бид нь яах болж байна? Ландоны толгой бөмбөр нүдэж байгаа юм шиг лугшиж эхлэв. *Сүсэг та нарыг аврахгүй. Эм тан, суудлын даруулга та нарыг аварна. Бурхан та нарыг аврахгүй, харин оюун ухаан аварна. Гэгээр! Бодит үр дүнд гарч байгаа юманд сүсэглэ. Усан дээр явдаг хүний тухай домог хэдэн мянган жил үргэлжлэв? Тэр гайхамшиг чинь орчин үеийн эрдэм:... компьютер, вакцин, сансрын станц ... тэр бүү хэл бүтээлийг хүртэл ... лабораторийн нөхцөлд оргүй хоосноос матери гаргаж авлаа. Бурхан хэнд хэрэгтэй юм бэ? Хэнд ч хэрэггүй. Тэр бурхан гэдэг чинь эрдэм юм.* Алуурчны дуу Ландоны чихэнд хадна. *Шөнө дунд ... Үхлийн математик прогресс... sacrifice vergini n' ll altari di scienza.* Буу тасхийхэд, шуугисан хүмүүс чив чимээгүй болдог шиг, толгойд нь лугшсан бүх бодол гэнэт арилж одоод: бүх юмны учир ил болоод, цэлмээд явчхав. Роберт Ландон мэлрэн бослоо. Сандал нь арагшаа унаж, гантиг шалан дээр тас хийв. Витториа, камерлинго хоёр давхийн цочиж, эргэн харлаа. «Би анзаараагүй байна. Бүр нүдний минь өмнө байж шүү дээ» гэж Ландон өөртэйгөө хүүрнэх мэт шивнэнэ. «Юу тэр вэ?» гэж Витториа асуулаа. Ландон камерлинго руу харан: «Эцэг минь. Би Ватиканы архивд орох зөвшөөрөл гурван жилийн турш хүсч, миний өргөдлийг долоон удаа татгалзсан юм.» «Ландон гуай. Уучлаарай. Гэхдээ таны гомдлыг авч хэлэлцэх таатай мөч биш шиг байна». «Надад одоо зөвшөөрөл өгчих. Дөрвөн кардиналыг яг хаана хөнөөхийг би олоод мэдчих боломж гарч магадгүй». Витториа юу яриад байгааг нь огт ухаарсан шинжгүй мэлэрнэ. Камерлинго уурсангуй, хорон үгээр ёжлох гэж байгаа мэт харна. «Та тэгээд энэ тухай мэдээлэл манай архивд байгаа гэх гээд байна уу?» «Цагтаа багтааж олно гэж амлах бэрх л дээ, гэхдээ таныг зөвшөөрвөл би ...» «Ландон гуай. Би дөрвөн минутын дараа Систин цогчин руу явах хэрэгтэй байна. Ватиканы архив харин эсрэг зүгт байгаа». «Чи нээрэнгээсээ яриад байна уу» гэж Витториа асуухдаа, Ландоныг үнэн хэлж байгаа эсэхийг мэдэх гэсэн шиг нүд рүү нь цоо ширтэж байв. Тоглоом хийх цаг ч биш шиг л байна» гэж Ландон хариуллаа. Витториа камерлинго руу эргэн: «Эцэг минь. Энэ дөрвөн аллага хаана болохыг нь мэдэх бага ч гэсэн боломж байвал бид оролдоод үзэхээс өөр замгүй шүү дээ» гэлээ. «Гэхдээ архивд уудаа? Яаж тэнд байх юм бэ?» гэж камерлинго асуув. «Тайлбарлая гэвэл, таны цаг ч багадаа байх даа» гэж Ландон хэлээд: «Тэнд байгаа мэдээлэл Хассассиныг барихад тусалж магадгүй юм» гэлээ. Камерлинго итгэмээр байгаа ч чадахгүй байв. «Христ шашны хамгийн нандин судрууд тэнд бий. Би хүртэл тэнд орох эрхгүй шүү дээ». «Мэднэ ээ, эцэг минь». «Зөвхөн кураторын бичгээр өгсөн зөвшөөрөл, эсвэл Ватиканы номын сангийн зөвлөлийн шийдвэрээр л ...» «Эсвэл» гэж Ландон таслаад: «Папын эрх олгосноор. Танай кураторын татгалзсан захиа болгонд ингэж бичсэн байдаг юм» гэлээ. Камерлинго толгой дохив. «Бүдүүлэг баймааргүй байна, гэхдээ энэ өрөөнөөс л эрх олгодог шүү дээ» гэж Ландон мэтгэв. «Харин өнөө шөнийн хувьд та тэр эрхийг эдэлж байгаа. Байдлыг дүгнэн үзвэл ...» Камерлинго урт хар дээлийнхээ хармаанаас цагаа гаргаж ирээд харлаа. «Ландон гуай. Энэ шашныг аврахын төлөө өнөө шөнө би амиа өгсөн ч чадах байна» гэлээ. Түүний нүд рүү харвал, энэ үг огт эргэлзээгүй үнэн ажээ. «Тэр бичиг чинь энд байгаа гэдгийг та үнэхээр мэдэж байна уу? Тэр дөрвөн сүмийг олоход тусалж үнэхээр чадах уу?» гэж камерлинго асуув. «Хэрвээ би тэгж бодоогүй бол дахин дахин хүсэлт гаргахгүй байсан юм. Багшийн цалингаар амьдардаг хүний хувьд Итали гэдэг

байн байн нисэж ирээд байх газар биш шүү дээ. Энд байгаа бичиг бол эртний ...»
Камерлинг яриаг нь тасалж: «Өршөөгөөрэй. Миний тархи одоо ажиллах чадалгүй болчихоод, нарийн ширийн мэдээлэл боловсруулж дийлэхгүй нь. Нууц архив хаана байдгийг мэднэ биз дээ?» Ландоны дотор баяр хөөр ундрал. «Санта Анагийн хаалганы яг ард нь». «Гайхалтай. Олон эрдэмтэн тийшээ Гэгээн Петерийн сэнтийн ард байдаг, нууц хаалгаар нэвтэрдэг гэдэг юм шүү дээ». «Үгүй дээ. Тэр чинь *Archivia della Reverenda di Fabrico di St. Pietro* шүү дээ. Байдаг л нэг төөрөгдөл». «Номын сангийн доцентууд орж байгаа хүн бүртэй хамт ордог юм. Гэхдээ өнөө шөнө нэг ч доцент байхгүй байгаа. Таны хүсч байгаа нэвтрэх эрхийг цагаан хуудасны эрх (*carte blanche*) гэдэг. Бүр манай кардиналууд хүртэл ганцаараа ордоггүй юм шүү дээ». «Би танай эрдэнэтэй туйлын нягт нямбай хандана аа. Танай номын сангийнхан намайг тэнд байсан гэсэн ямар ч ул мөр олохгүй». Гэгээн Петерийн талбайн хонх дүнгэнэлээ. Камерлинг цагаа хараад: «За, би явья даа» гэв. Тэгснээ, Ландон руу эгцлэн хараад: «Таныг архивын үүдэнд Швейцар харуул угтана. Би танд итгэлээ шүү, Ландон гуай! За одоо хөдөл» гэлээ. Ландон дуугарсангүй. Камерлинг нэг л эвгүй зогсоод, мөрөн дээр нь гайхалтай чанга гараа тавилаа. «Та хайснаа ол. Харин түргэн олж үзээрэй» гэв.

Хэсэг 46

Ватиканы нууц архив Белведэрэ гудамжны мухарт, Санта Анагийн хаалганаас дээшээ, толгод өөдөө байдаг ажээ. Тэнд 20 000 орчим номтой гэх агаад Леонардо да Винчигийн алга болсон өдрийн тэмдэглэлээс эхлээд Библийн олонд нийтлээгүй зарим бүлэг ч байдаг гэх бөлгөө. Ландон Фондамента гудмаар архив өөд өгсөхөд, тэнд хүн амьтан огт үл үзэгдэнэ. Тэрээр архив руу нэвтрэх эрх олж авсандаа итгэж ядан байв. Ветра өмнө нь шийдмэг алхална. Сайхан үнэртэй үс нь салхинд зөөлөн намирч, Ландонд үнэртэнэ. Харин бодол нь дэвэн дэлхийгээр хэсүүчлэн, өнгөрсөн он жилүүд рүү эргүүлж татах шиг. «Юу хайхаа чи надад хэлэхгүй юм уу?» гэж Витториа асуув. «Галилео гэдэг залуугийн бичсэн нэг жижигхэн номыг». Бүсгүй: «Битгий тойруулаад бай л даа. Тэнд тэгээд юу биччихсэн байгаа юм бэ?» гэв. «Тэнд *il segno* (тэмдэг) гэсэн юмны тухай бичсэн байх учиртай юм». «Тэмдэг үү?» «Тэмдэг, дохио, заавар ... юу орчуулж байгаагаас хамаарна даа». «Юуны тэмдэг юм бэ?» Ландон алхаагаа нийлүүлээд: «Нууц байрных нь. Галилеогийн Иллюминатигийнхан Ватиканы хавчлагаас зулбаж явахдаа, энэ Ромд маш нууц уулздаг газартай байсан юм. Түүнийгээ Гэгээрлийн сүм гэдэг юм.» «Сатааны ичээг сүм гэдэг - бөх зүрхтэй юм гээч». Ландон толгойгоо сэгсрэв. «Галилеогийн Иллюминати сатаанлаг биш байсан. Тэд чинь зүгээр л гэгээрэх гэсэн эрдэмтэд шүү дээ. Тэр сүм нь зүгээр л цуглаад, хориотой сэдвээр ярилцдаг аюулгүй газар юм. Тийм нууц газар байдгийг мэддэг ч гэсэн өнөөг хүртэл хэн ч тэрийг нь олоогүй юм». «Иллюминати нууцаа яаж хадгалахаа мэддэг бололтой шүү». «Тэгэлгүй яах вэ? Үнэхээр ч, тэгж нууцаар уулздаг байсан газраа нөхөрлөлийнхнөөсөө өөр хэнд л задлаагүй юм. Өөрсдийгөө хамгаалахын тулд ингэх л хэрэгтэй, гэхдээ ингээд нууцлаад байхаар шинэ гишүүн элсүүлэхэд их хэцүү байж л дээ». «Үзэл санаагаа дэлгэрүүлэхгүй бол тэлэхгүй л дээ» гэж Витториа хэлэхэд санаа бодол нь алхаа гишгээтэйгээ зэрэгцэх шиг. «Яг зөв. Галилеогийн нөхөрлөлийн тухай сураг 1630-аад онд их л түгж, эрдэмтэд Ромд ирж Иллюминатид элсэн... Галилеогийн нөгөө алдартай телескопоор харж, яриаг нь сонсох санаатай ирдэг байжээ. Гэхдээ Иллюминати их нууц байсан болохоор Ромд ирсэн эрдэмтэд

хаашаа явж, хэнтэй уулзахаа мэддэггүй байжээ. Иллюминати харин цусаа сэлбэх гэсэн ч хаана байгаага мэдэгдэж, нууцаа алдахаас зүрхшээдэг байжээ.» Витториа барайсан хэвээр. «*Situazione sense soluzione* (гарах замгүй газар) шиг л сонсогдож байх чинь». «Тийм шүү.» «Тэгээд яасан бэ?» «Тэд чинь эрдэмтэд шүү дээ. Асуудлаа шинжлээд, хариуг нь гаргачихгүй юу. Гэхдээ, тун сайн шийдэл шүү. Иллюминати эрдэмтдийг уулзах газар руугаа хөтөлсөн нэг ёсны замын зураг хийсэн юм». Витториа гайхаж хараад, алхаагаа удаашрууллаа. «Замын зураг аа? Болгоомжгүй юм. Өөр хүн нэг хувийг нь олоод авчихвал...» «Тэгж чадахгүй л дээ» гэж Ландон хэлэв. «Уулаасаа нэг ч хувь байхгүй юм чинь. Цаасан дээр ч багтахгүй. Гол нь хот даяар тавьсан тэмдгүүдийг дагаж явах ёстой юм.» Витториагийн алхаа бүр удаашрав. «Зам дээр тавьсан сумыг дагаад л алхаад байх хэрэг үү?» «Ер нь бол тийм, гэхдээ илүү нууц. Тэр зураг нь энэ хотын олон хүн цугладаг газар тавьсан бэлгэдлүүдийг заадаг юм. Нэг тэмдэг нь нөгөө тэмдэг рүүгээ хөтөлнө, тэгж явсаар Иллюминатигийн ичээ рүү нь авчирна даа». Витториа хяламхийн: «Эрдэнэсийн эрэл шиг үү». Ландон хөхрөн: «Тийм шүү. Иллюминати тэр тэмдэгтүүдээ «Гэгээрлийн мөр» гэдэг, нөхөрлөлд нь элсэх хүн болгон дагаж явсаар очих ёстой байлаа. Нэг бодлын сорил гэх үү дээ». «Тэгвэл Ватикан яагаад Иллюминатийг олохын тулд тэр тэмдэгтүүдийг нь дагаж явсаар бариад аваагүй юм бэ?» гэж Витториа асуув. «Үгүй дээ. Тэр зам чинь нууц. Зөвхөн тодорхой төрлийн хүмүүс тэмдгийг олж, хаана Гэгээрлийн сүм байгааг олж мэдэх ёстой оньсон тоглоом шиг эд, угаасаа тэгж хийсэн юм. Иллюминати үүнийг зүгээр нэг аюулгүйн байдлаа хангах арга зам болгоод зогсоогүй зөвхөн хамгийн гарамгай хүмүүс ирээсэй гэсэндээ эхний шатны шалгуур болгосон юм.» «Гэхдээ л биш байна даа. 1600-аад оны үед чинь хамгийн боловсролтой хүмүүс гэдэг сүмийн бичээчид л байсан биз дээ. Тэр тэмдэгтүүд нь олны хөлийн газар байсан юм бол Ватиканд тэрийг нь тайлаад унших нэгэн олдох л байлгүй дээ». «Тэгэлгүй яах вэ?» гэж Ландон зөвшөөрөв. «Гэхдээ, тийм тэмдэг байдаг гэж мэдвэл шүү дээ. Харин тэд мэддэггүй байсан юм. Иллюминати тэр тэмдгүүдээ тухайлан тэр бичээчид хараад юу вэ гэдгийг нь шууд ухаарахааргүй байдлаар анхнаас нь хийжээ. Өөрөөр хэлбэл, *dissimulation* (адилтгал) гэдэг арга л даа.» «Өнгөлөн далдлалт». Ландон: «Чи энийг мэддэг юм уу?» «*Dissimulazione* гэдэг чинь байгалийн хамгийн гайхалтай урлаг шүү дээ» гэж бүсгүй хэлэв. «Дээшээ хөвж яваа бүрээ загасыг далайн ёроолын ургамлаас ялгах ч хэцүү шүү». «За, за» гэж Ландон зөвшөөрөөд: «Иллюминати ч бас яг тэгж аргалсан юм. Тэд тэмдгүүдээ эртний Ромын нуранги дотор далдалсан гэдэг. Тэд амбиграм, шинжлэх ухааны нэг ч тэмдэг ашиглаагүй, мэдээж, тэгсэн бол хүн болгон таних илэрхий байх байж л дээ. Тэгээд Иллюминати нэг урлаачийг, нөгөө «Иллюминати» гэдэг амбиграммыг зохиодог хүн шүү дээ, түүнийг урьж авчраад дөрвөн баримал бариач гэсэн юм.» «Иллюминати баримал аа?» «Тийм. Гэхдээ хоёр удирдамжийг хатуу барьж ажиллахыг шаарджээ. Юун түрүүнд, тэр баримлууд Ромын бусад баримлаас ялгарахааргүй байх ёстой... Өөрөөр хэлбэл Ватиканыхан хараад тэднийг Иллюминатигийнх гэж хэзээ ч ялгахаргүй байх ёстой.» «Шашны баримал байх гэсэн үг үү?» Ландон толгойгоо дохингоо их л догдлонгуй улам хурдан ярьж эхлэв. «Хоёр дахь нь баримал нэг бүр нэг тодорхой сэдэвтэй байх ёстой байсан юм. Өөрөөр хэлбэл, баримал болгон дөрвөн элементийн нэгэнд нь зориулагдсан байх ёстой байсан юм л даа». «Дөрвөн элемент ээ? Элемент чинь зуу гаруй байдаг шүү дээ» гэж Витториа асуув. «1600 онд бол өөр шүү» гэж Ландон сануулаад: «Тэр үед бидний одоо махбод гэдгийг элемент гэдэг байсан юм. Дээр үед алхимичид орчлон хорвоо ердөө л дөрвөн махбод дээр үндэслэсэн гэдэг байсан юм. Шороо, хий, гал, ус шүү дээ» гэв. Эрт үедээ, загалмай ч бас шороо, хий, гал, ус гэсэн дөрвөн махбодын холбоог илэрхийлдэг байжээ. Түүхийн турш энэ дөрвөн махбодын холбооны өөр

янз бүрийн хослол гарч байлаа. Пифагорын амьдралын хүрд, Хятадын арга билэг, Жүүдийн эр эм үүтгэл, зодиакийн дөрвөлж, тэр бүү хэл Ислам шашинтнууд хүртэл «талбай, үүл, аянга, давалгаа» гэж нэрлэн, мөн л тэр дөрвөн махбодыг шүтэж ирсэн байдаг. Ландоны хувьд сүүлийн үеийн Масоны Туйлын эхлэл хүртэл шороо, хий, гал, ус гэсэн дөрвөн шаттай байдгийг санахад хүйт оргидог байлаа.

Витториа одоо төөрөлдөж орхих шиг харагдана. «За тэгвэл, Иллюминатигийн урлаач шашны юм шиг харагдах дөрвөн баримал барьжээ. Тэгээд тэр шороо, хий, гал, усаа яг хаана тахисан хэрэг вэ?» «Зүйтэй» гэж Ландон хэлээд Via Sentinel (Харуулын жим)-ээр эргэн архивыг чиглэн алхав. «Тэр баримлуудыг Ромын далай шиг их шашинлаг баримлуудын дунд далдалсан юм. Барималч нь сайн дураараа тэр баримлаа тодорхой нэг сүмд хандивлаад, тэр сүмийнхээ хүчийг ашиглан Ромын тодорхой нэг газар байрлуулдаг байж л дээ. Баримал болгон чиг заагч бөгөөд ... дараагийнхаа чиг заагчийн зүг ... хөтөлдөг байжээ. Яг л шашны баримал шиг харагдах замын тэмдэг гэлтэй. Иллюминатид элсэхийг хүссэн хүн эхлээд эхний сүмийг олж, шороо тэмдгийг олж чадвал тэр нь дараагийн ... хий рүү чиглүүлж..., тэндээсээ ... агаар руу ... тэгээд ус руу ... эцэс нь Гэгээрлийн сүм рүү аваачна». Витториа улам л ойлгохоо больж байв. «Тэгээд энэ чинь Иллюминатгийн алуурчныг олоход ямар нэмэртэй юм бэ?» Ландон их л бахтай яа: «Өө нэмэртэй байлгүй яах вэ? Иллюминатигийнхан тэр дөрвөн сүмийг их л онцлог нэрлэдэг байсан юм. Юу гээч? Altare di scienza (Эрдмийн тахил.ита)» гэлээ. Витториа баргар хэвээр өгүүлрүүн: «Уучлаарай, гэхдээ энэ чинь тэгээд ямар хамаатай юм ... «гэснээ зогтусав. «Өө, Valtare di scienza!» хэмээн гайхан дуу алдлаа. «Хассассин. Дөрвөн кардинал эрдмийн тахилын өмнө онгон өргөл болно шүү гэсэн шүү дээ». Ландон инээвхийлэн: «Дөрвөн кардинал^. Дөрвөн сүм. Эрдмийн дөрвөн тахил» гэлээ. Бүсгүй цочирдон: «Та тэгээд тэр дөрвөн кардиналаар өргөл барих дөрвөн сүмийг Гэгээрлийн мөр заасан дөрвөн сүм мөн гэж бодоо юу?» «Тэгж л бодож байна» гэж Ландон хэлэв. «Алуурчин яах гэж бидэнд тэгээд энэ тухайгаа хэлсэн юм бэ?» «Яагаад болохгүй гэж? Цөөхөн түүхч тэр баримлын тухай мэддэг. Бүр цөөхөн нь тэднийг үнэхээр байдаг гэж боддог юм. Байршил нь дөрвөн зууны турш нууц хэвээр байсан, тэгэхээр тэртээ тэргүй дахиад таван цаг энэ нууцаа хадгалж дөнгөнө гэж бодож байгаа биз. Тэгээд ч тэр Гэгээрлийн мөр нь Иллюминатид одоо хэрэггүй болно. Ер нь, тэр ичээ нь одоо байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Одоо чинь орчин үе. Тэд одоо банкны удирдах зөвлөл дээр, ресторанд зоог барьж байхдаа, эсвэл хувийн гольфийнхоо талбайд уулзаж байгаа. Өнөө шөнө тэд нууцаа задлах гэж байгаа. Энэ бол тэдний мөч, гайхамшигтай мөч шүү дээ». Гэхдээ, Ландон Иллюминати дахиад нэг аймшигт тэгш хэмээ гаргах вий гэхээс айж байсан ч, түүнийгээ хэлсэнгүй. *Дөрвөн тэмдэг.* Кардинал болгоныг өөр өөр тэмдгээр тамгална гэж алуурчин андгайлаад байсан сан. *Эртний домог үнэн гэдгийг харуулна даа.* Дөрвөн амбиграмм тамганы тухай домог Иллюминатитай адил эртнийх бөгөөд шороо, хий, гал, ус гэсэн үгийг төгс хэм тэгш бичсэн байдаг гэдэг. Яг л Иллюминати гэдэг үг шиг. Кардинал болгон эрдмийн дөрвөн махбодоор тамгалуулна. Тэр тамгын үг нь Италиар биш, Англиар байдаг гэдэг агаад энэ нь судлаачдын дунд маргааны сэдэв болдог байлаа. Төрөлх хэлээ биш, Англи хэлийг сонгосон нь санамсаргүй мэт санагдавч... Иллюминати санамсаргүй зүйл огт хийдэггүй билээ. Ландон архивын байшингийн өмнөх тоосгон гудмаар алхална. Бодолд нь, янз бүрийн аймшгийн дүрс үзэгдэнэ. Иллюминатигийн хорон төлөвлөгөө агуу сүрийг үзүүлэн, илрэн гарах гэж байв. Нөхөрлөл шаардлагатай гэсэн хугацаагаараа чимээгүй нуугдаж, айх аюулгүй болтлоо хүчтэй, нөлөөтэй болсон тул өнөөдөр өдрийн гэрэлд нуух юмгүй тэмцэнэ. Иллюминати нуугдах хэрэггүй болжээ. Тэд чадлаа гайхуулан, нууц хуйвалдаан үнэн болохыг нотлох гэж байлаа. Өнөө шөнө даян дэлхийд гайхуулах мөч байв. «За, дагуул маань ирж явах шив» гэж Витториа хэллээ. Ландон толгой өргөж, хаалганы урд талын зүлгэн эмжин, гүйж яваа Швейцар жардыг харав. Харуул тэр хоёрыг хармагцаа, яг тэндээ гэнэт зогсчхов. Тэр хий юм үзэж байна уу гэлтэй тэднийг мэлэрнэ. Тэгснээ юм хэлэлгүй эргэж хараад, гар холбоогоороо хүнтэй ярина. Залуу цаад хүнээсээ маш яаралтай юм асуух агаад асууж байгаа юм нь гайхалтай мэдээжийн

байлаа. Хариу нь ч бас л тодорхой, цаанаас нь уурсан хашхичих сонсогдов. Харуул толгой дохиод, холбоогоо буцаагаад бүсэндээ зүүнгээ, эргэж тэдэн рүү их л мэгдэн харлаа. Харуул юу ч хэлэлгүй тэр хоёрыг байшин руу дагуулан оров. Хоёр нууц үгтэй цоожтой дөрвөн төмөр хаалга өнгөрч, доошоогоо өргөн шатаар буугаад хос нууц түлхүүртэй хоёр хаалгаар орлоо. Хэд хэдэн цахим хаалга өнгөрөөд урт гудамны мухарт царсан хавтаст хаалган дээр ирэв. Харуул зогсож, тэр хоёр руу дахиж нэг хараад, амандаа юм бувгнасаар хаалган дээрх төмөр хайрцаг руу дөхөв. Тэр хайрцгийг онгойлгоод, дотор нь код оруулав. Түлхүүрийн боолт салж байгаа нь сонсогдоод, хүн хаалга чахран онгойлоо. Харуул эргэж хараад, анх удаа ам нээв. «Архив энэ дотор байгаа. Би та хоёрыг энэ хүртэл дагалдаад, өөр ажилтай болохоор эргээд явах ёстой» гэлээ. «Та явах гэж байгаа юм уу?» гэж Витториа асуув. «Швейцарь жард Нууц архивд орох эрхгүй байдаг юм. Манай захирагч камерлингогоос шууд тушаал авсан болохоор л та нарыг энд авчирлаа» гэлээ. «Тэгээд бид хоёр яаж буцаж гарах юм бэ?» «Зөвхөн гадна талаасаа орох л хориотой. Харин дотроосоо бол зүгээр онгойдог юм.» Ингээд яриа дуусч, харуул эргэж хараад, явж одов. Витториа юм хэлээд байх шиг байсан ч Ландон сонссонгүй. Ухаан санаа нь өмнөө байгаа хавтаст хаалга дээр төвлөрөөд цаана нь ямар гайхамшиг нуугдаж байгаа бол хэмээн бодож байлаа.

Хэсэг 47

Цаг бага гэж мэдэж байсан ч Карло Вентреско камерлинго удаан алхаж явав. Нээх залбирлын өмнө, оюун санаагаа төвлөрүүлэхийн тулд ганцаараа хэсэг байх хэрэгтэй байлаа. Эрээлжилсэн олон юм ар араасаа болж байх. Умар жигүүр руу уруудан, ганцаараа чимээгүйхэн бууж явахдаа, өнгөрсөн арван таван хоногт ясанд нь тултал дарсан ачааллын тухай бодолхийлж явав. Тэр ариун үүргээ үг үсэгчлэн биелүүлжээ. Ватиканы уламжлал ёсоор камерлинго Паптань гүрээний судас дээр хуруугаараа дарж, амьсгалыг нь тоолоод, дараа нь Папыг нэрээр нь гурвантаа дуудаж, нас барсныг нь биечлэн баталжээ. Тэгээд унтлагын өрөөг нь түгжиж, *papal fisherman's ring* -ийг эвдээд, тамганд хэрэглэдэг лацыг нь хагалаад оршуулгын ёслолд зэхжээ. Оршуулга дууссаны дараа, цуурганд бэлджээ. *Цуурган. Сүүлийн даваа* хэмээн бодно. Энэ бол Христ ёсны хамгийн эртний заншлын нэг байлаа. Орчин үед цуурганы дүнд, хэн Пап болох нь тэртээ тэргүй тодорхой байдаг болсон тул үүнийг сонгууль гэхээсээ ёс төдий зүйл хэмээн шүүмжлэх болсон билээ. Гэхдээ, энэ шүүмжлэл учир бага гадарлах хүмүүсийн яриа гэдгийг камерлинго мэднэ. Цуурган бол сонгууль биш. Харин засгийг шилжүүлэх эртний нууцлаг ёслол байлаа. Шилжилт цагийн хязгааргүй... нууцлаг, нугалсан цаас, саналын хуудсыг шатаах, химийн бодисыг холих, утаан дохио ... Камерлинго Георгиас XIII-ын Loggias руу дөхөж явахдаа Мортати кардинал сандраагүй байгаа гэж бодлоо. Мортати, мэдээж, дэвшигчид алга болсныг мэдсэн байж таарна. Тэднийг байхгүй бол санал хураалт шөнөжингөө үргэлжилж ч магад. Мортатийг Их сонгогч болсон нь сайн хэрэг болсон юм хэмээн камерлинго бодно. Мортати бол чөлөөтэй сэтгэдэг, бодсоноо хэлдэг хүн ажээ. Цуурганд яг ийм л хүн өнөө шөнө хэзээ хэзээнээсээ илүү хэрэгтэй байлаа. Камерлинго Хаан шатны доод гишгүүрт ирмэгц, амьдралынх хамгийн чухал эгшин тулж ирсэн мэт санагдав. Энэ доор хүртэл Систин цогчинд байгаа 165 кардинал түгшингүй ярилцах нь сонсогдож байлаа. Нэг зуун жаран нэгэн кардинал шүү дээ гэж тэр бодлоо засан шивнэв. Эгшин зуур, камерлинго тамын ангал руу унаж, нүцгэн бие нь хярвас үнэртүүлэн шатаж, доор хүмүүс чарлаж, дээрээс чулуу, цус садран асгарах шиг санагдлаа. Гэнэт, огт аниргүй болчхов. Хүү сэрлээ. Тэр диваажинд байв. Эргэн тойрон цав цагаан. Гэрэл нүд сохлом хурц, бас цэвэр. Зарим хүн аравхан настай хүү диваажин гэж мэдэхгүй гэдэг ч Карло Вентреска мэдэхийн

цаагуур мэддэг байлаа. Хүү өөр хаана байх билээ дээ. Амьдралынхаа аравхан жилд хүү бурхны суу чадлыг биширдэг болсон байжээ. Чихэнд нь нүргэлэх цуурт органы аялгуу, зулайг нь өнгийх сүмийн өндөр дээвэр, мөргөлийн өндөр царгих дуун, шилэн чимэгт цонх, жингэнэх хүрэл, алт... Карлогийн эх Мариа хүүгээ өдөр болгон цуглаанд авчирдаг байлаа. Тиймээс ч сүм гэдэг Карлогийн гэр байжээ. «Хоёулаа яагаад өдөр болгон цуглаанд очдог юм бэ?» гэж хүү ээжээсээ огт юу ч бодолгүй асуужээ. Ээж нь: «Би тэгнэ гэж бурханд амлачихсан болохоор л тэгдэг юм» гэж хариулна. «Бурханд өгсөн ам бол хамгийн чухал андгай байдаг юм. Бурханд өгсөн андгайгаа хэзээ ч зөрчиж болохгүй шүү». Карло бурханд өргөсөн андгайгаа хэзээ ч зөрчихгүй гэж ээждээ амлажээ. Тэр ээждээ энэ дэлхийн юунаас ч илүү хайртай байлаа. Ээж нь түүний ангель байв. Тэр заримдаа ээжийгээ *Maria benedetta* (ита.) буюу Буянт Мариа гэдэг ч, ээж нь тэгж дуудуулах дургүй байжээ. Хүү ээжтэйгээ хамт сөхрөн сууж, ээжийгээ эрхээ эргүүлэн, залбирлаа уншихад нь дүнгэнэх хоолойг нь сонсон, ариухан үнэрийг нь үнэрлэж суудаг байлаа. *Гэгээн Мариа минь... Бурхны гэгээн эх минь ... одоо ч тэр, биднийг үхэх тэр мөчид ч тэр ... нүгэлт биднийгээ авралдаа багтаан соёрх.* Аав нь хүүг төрөхөөс өмнө нас барчихсан гэдгийг мэддэг атлаа Карло: «Аав хаана байгаа юм бэ» гэж асуудаг байв. «Бурхан чиний эцэг юм шүү, хүү минь. Чи чинь сүмийн хүү шүү дээ» гэж ээж нь хариулна. Карло тэгж хэлэхэд нь дуртай байлаа. Ээж нь: «Чи айх болгондоо бурхан миний эцэг юм шүү гэж бодож яв. Тэр чамайг дандаа харж, хамгаалж явна. Бурхан чамайг учиртай заяасан юм, Карло» гэж сургана. Ээжийнхээ зөв гэдгийг хүү мэдэж байлаа. Тэр бурхныг эд эс, цусандаа хүртэл мэдэрдэг байв. Цус. *Тэнгэрээс садран асгарах цус!* Аниргүй. Тэгээд л диваажин. Хурц гэрэл унтармагц, хүү Палермо хотын Гэгээн Клара эмнэлгийн Сэхээн амьдруулах тасагт байгаагаа мэдлээ. Ээжтэйгээ хамт цуглаанд очоод байхад нь террорист халдлага болж, бөмбөг дэлбэрэн, сүм бүхэлдээ нуранги болох үед хүү гав ганцаараа амь гарчээ. Ээжтэй нь хамт гучин долоон хүн үрэгдсэн байв. Хүү амьд гарсныг орон нутгийн хэвлэл Гэгээн Франсисийн гайхамшиг хэмээн шуугина. Дэлбэрэлт болохын яг өмнөхөн Карло ээжийнхээ дэргэдээс босч, Гэгээн Франсисийн домгийг дүрсэлсэн зургийг сонирхон нэг жижигхэн мухар руу очжээ. *Бурхан намайг тэнд дууджээ. Тэр намайг аварсан* гэж хүү бодох болжээ. Карло өвдсөндөө дэмийрч байв. Тэр ээжийгээ сөхрөөд залбирч суухыг, өөрийг нь үнсэж байхыг харж байтал удалгүй чанга чимээ гарч, ээжийнх нь сайхан дүр сарнин алга боллоо. Хүний хорон санаа гашуун ажээ. Тэнгэрээс цус садарна. Ээжийнх нь цус. Буянт Мариа! *Бурхан чамайг дандаа харж, хамгаалж явна* гэж ээж нь хэлнэ. *Гэтэл тэгэхэд, бурхан хаана байсан юм бэ?* Яг тэр эгшинд, ээжийнх нь хэлж байсан шиг сүмийн нэгэн хэргэмтэн хүү дээр ирэв. Тэр жирийн нэгэн бус, харин бошго байлаа. Бошго Карлогийн дэргэд, Гэгээн Франсисийн гайхамшигийн дэргэд ирж залбирав. Карлог эдгээд гарахад, тэр бошго өөрийнхөө яамладаг хийдийн ойролцоо жижиг сүмд суулгажээ. Хүү тэнд лам нартай амьдарч, сурч байв. Удалгүй бошгынхоо тахилгач хүү болжээ. Бошго хүүг улсын сургуульд сургая гэсэн ч Карло үгүй гээд шинэ гэрээсээ өөр газар сайхан байж чадахгүй гэжээ. Ингээд л тэр бурхны гэрт амьдрах болжээ. Карло шөнө болгон ээжийнхээ төлөө залбирна. *Бурхан намайг аварсан нь учиртай. Харин ямар учиртай юм бол доо?* Карло арван зургаа хүрмэгц Италийн хуулийн дагуу хоёр жил цэргийн дайчилгааны нөөцөд алба хаах хэрэгтэй болжээ. Бошго түүнийг семинарт ор, тэгвэл цэргийн албаас чөлөөлөгдөж болно гэсэн ч хүү семинарт орохдоо л орно, гэхдээ эхлээд нүгэл гэж юу болохыг мэдье гэжээ. Бошго ойлгосонгүй. Бүх амьдралаа сүмд сууж, нүглийн эсрэг тэмцэж өнгөрөөх гэж байгаа юм бол, эхлээд түүнийгээ ухаарч мэдэх хэрэгтэй шүү дээ гэж Карло хэлжээ. Зэвсэгт хүчнээс өөр нүглийг жинхэнээр нь нүдээрээ харах газар үнэхээр байсангүй. Цэргүүд буудаж, бөмбөгдөнө. Тийм л бөмбөгөөр

Буянт Мариаг минь хөнөөсөн сөн. Бошго түүнийг ятгаж оролдсон ч Карло шийдчихсэн байлаа. «Сэрэмжтэй яваарай, хүү минь. Эргээд ирэхэд чинь сүм чамайг хүлээж байгаа шүү, санаж яваарай» гэж Бошго захъжээ. Карлогийн цэрэгт өнгөрөөсөн хоёр жил там байлаа. Хүү бага насаа ажин түжин, амар төвшин өнгөрөөсөн сөн. Гэтэл цэрэгт ажин түжин байх нэг ч хором алга байв. Пижгэнээд л байна, пижгэнээд л байна, дуусахгүй. Том том машинууд нүргэлнэ. Амсхийх чөлөөгүй. Цэргүүд долоо хоногтоо нэг удаа хуаран дотроо цуглаанд очдог ч хамт байгаа нөхдийнх дунд бурханлаг нэгэн огт байсангүй. Толгой тархи нь бурхныг олж харахгүй болтлоо эргэчихсэн байлаа. Карло шинэ амьдралаа үзэн ядаж, гэртээ харимаар л байв. Гэхдээ нэгэнт л үзнэ гээд шийдчихсэн болохоор буцах зам байсангүй. Нүглийг ухаараагүй л байлаа. Тэр буугаар буудахгүй гэсэн болохоор эмнэлгийн нисдэг тэрэг жолоодохыг сурчээ. Карло нисдэг тэрэгний шуугиан, үнэрийг нь тэсч чаддаггүй байсан ч тэнгэрт хөөрөхдөө бурханд, ээждээ ойртож яваагаа мэдэрдэг байлаа. Нисдэг тэрэг жолоодох дадлагад, шүхрээр буух бас ордог байсныг Карло мэдээд үхтлээ айжээ. Гэхдээ яаж ч чадсангүй. Бурхан намайг хамгаална хэмээн өөртөө шивнэнэ. Карло шүхрээр анх үсрээд амьдралдаа байгаагүй ихээр догдолжээ. Яг л бурхантай хамт нисч яваа юм шиг санагдана. Газар руу алгуурхан бууж явахдаа тэр аниргүй сайхныг... нисэхийн сайхныг... үүлэн дээр тодрох ээжийнхээ царайн сайхныг харж, мэдэрч явлаа. Бурхан чамайг учиртай заяасан юм, Карло. Цэргээс халагдаад Карло семинарт оржээ. Энэ явдал хорин гурван жилийн өмнө болж өнгөрчээ. Карло Вентреска камерлинго Хаан шатны доор зогсон, ийм эвгүй байдалд орчихсон үйл явдлын учир шалтгааныг тэнсэн зогсоно. Айдсаа дараад энэ шөнийг бурханд өргө гэж өөрийгөө зоригжуулан шивнэв. Систин цогчны том хүрэл хаалга, үүдэнд нь бат нот зогсох тангараг^тан дөрвөн харуулыг харлаа. Харуулууд цоожийг онгойлгож, хаалгыг нээв. Дотор нь байсан хүн болгон толгойгоо эргүүлж, түүн рүү харна. Камерлинго ч бас тэр хар дээл, улаан шаш туузтай хүмүүс рүү ширтэнэ. Бурхан түүнийг ямар учиртай заяасныг сая л ухаарлаа. Энэ шашны хувь заяа гарт нь байв. Камерлинго загалмайж мөргөөд, босго даван оров.

Хэсэг 48

ВВС-ийн сурвалжлагч Гунтер Глик мэдээнийхээ мухлаг машиныг Гэгээн Петерийн талбайн зүүн өнцөгт зогсоогоод, хөлсөө гоожуулан, түүнийг томилсон редакторыг зүхэж суув. Ажилд орсон эхний сарынх нь сурвалжлагыг - баттай сурвалжтай, хурц, содон - хэмээн үнэлсэн ч тэр өнөөдөр Ватикан хийдэд «Папыг анах» үүрэгтэй сууж байв. ВВС-д сурвалжлага хийнэ гэдэг Британи хов сэтгүүлд ажиллахаас илүү бат нот баримт цуглуулна гэсэн үг шүү гэж түүнд сануулсан ч, энэ бол түүний ажилладаг арга даан ч биш байлаа. Гликийн ажил амархан байв. Доромж гэмээр амархан. Тэр өмхий хэдэн хөгшин дундаасаа нэг өмхий хөгшнөө дараагийнхаа даргаа болгож сонгохыг хүлээж суугаад, дараа нь Ватикан хийдийг дэвсгэр болгон арван таван секундйн «шууд» мэдээ хийгээд л боллоо. *Гайхалтай.* ВВС ийм дэмий юм сурвалжлуулах гэж баг илгээдэг гэдэгт Глик итгэж өгөхгүй байв. *Энэ шөнө Америк сурвалжлагч энд олж харахгүй дээ.* Яагаад гэвэл тэд л хийх ёстой юмаа хийдэг. Тэд «шууд» сурвалжилгаа цэнхэр өнгийн дэлгэц дээр аваад ард нь Ватикан сүмийн видео бичлэг оруулж дэвсгэр хийгээд л болчихно. MSNBC бүр салхилуур, борооны машин ашиглан студи дотроо яг амьд болж байгаа юм шиг эффект гаргана. Үзэгч үнэнийг биш,

харин зугаа үзэхийг хүсдэг болсон юм чинь. Глик машиныхаа урд цонхоор уйтгарлан, уйтгарлах тусмаа уур нь хүрэн сууна. Хаан дов дээр сүндэрлэх Ватикан хийд хүмүүс санаа бодол нийлвэл ямар гайхамшиг бүтээдгийг харуулах сурталчилгааны хуучин хуудас мэт сүглийнэ. «Би энэ амьдралдаа юу бүтээв?» гэж уурсангуй чанга хашхирснаа: «Юу ч бүтээсэнгүй» гэлээ. «Тэгвэл бугаад өгчхөөч дээ» гэж ард нь эм хүний хоолой жингэнэв. Глик давхийн цочив. Ганцаараа байгаа биш гэдгээ бараг л мартчихсан байжээ. Тэр мөрөн дээгүүрээ залхуутай яа эргэж, зураглаач Чинита Макри нүднийхээ шилийг арчин, чимээгүй суухыг харлаа. Чинита өөрийгөө африкан америк гэдэг махлаг, сэргэлэн хар хүүхэн байлаа. Хэг ёг ааштай боловч Глик хамт ажиллах дуртай билээ. «Чи яачхаа вэ?» гэж Чинита асуув. «Хоёулаа энд үхсэн үлийгээ хийж байгаа юм бэ?» Бүсгүй шилээ зүлгэнгээ: «Гайхалтай үйл явдлыг сурвалжлах гээд л анаж сууна». «Хэдэн хөгшин харанхуй өрөөнд түгжээтэй сууж байгаа нь, тэгээд, гайхалтай хэрэг үү?» «Чи тамд унана гэдгээ мэддэг үү?» «Өө, тэнд чинь аль хэдийн оччихоод сууж байгаа минь энэ биш үү?» «Яагаад тэр вэ? Ярь л даа» гэх нь яг л ээж шиг нь сонсогдов. «Би нэг шуугиулсан юм бичих юм сан». «Чи тэрийгээ *Британи хов* - доо биччихээгүй юм уу?» «Бичиж байсан л даа. Гэхдээ шуугиулчхаар олигтой юм байгаагүй». «За боль доо. Хатан хаан, харь гаргийнхантай нууцаар янагласан гэж шуугиан тарьсан өгүүлэл бичээ л биз дээ». «Баярлалаа». «За за, өөдрөг бай. Өнөө шөнө чи амьдралынхаа анхны арван таван секундийн теле-сурвалжилга хийх гэж байж». Глик: «хн...» гээд унтууцав. Редактор: «Баярлалаа, Гунтер, сайхан сурвалжиллаа» гэж хэлэхийг нь сонсох шиг болов. Тэгээд, нүдээ эргэлдүүлээд, цаг агаарын мэдээ гаргана даа. «Би нэг редактор болж үздэг юм уу?» Макри тас хийтэл инээв. «Туршлагагүй, бас сахал тавиагүй байж уу? Боль, боль». Глик алгаараа хацар эрүүгээ дагуулан илээд: «Сахалтай бол ч ухаантай юм шиг харагдах байх аа» гэв. Машин дотор гар утас дуугаран, Гликийн хэлэх гэж байсан юмыг тасалж орхив. «Энэ редактор байх аа. Яг одоо юу болж байгааг шууд нэвтрүүлээдэх гээгүй байлтай» хэмээн горьдонгуй өгүүлэв. «Одоо болж байгааг уу?» гэж Макри хөхрөн: «Сэрүүн зүүднээсээ сэрг үз, хүү минь!» гэв. Глик утсаа аваад жинхэнэ хөтлөгч хоолойгоор: «Гунтер Глик, ВВС, Ватикан хийд» гэлээ. Утасны цаанаас илэрхий араб аялгатай хүн ярив. «Сонсож бай. Би амьдралыг чинь өөрчлөх гэж байна».

Хэсэг 49

Ландон, Витториа хоёр хавтаст хаалганы цаана байх Нууц архивын босгон дээр зогсоно. Тэр гудмын гантиг шалан дээр нэг хананаасаа нөгөө ханаа хүртэл уртааш нь дэвссэн эртний уран гоё хивс, тэр хоёр руу тансаг сийлбэрт хананаас гилжийн ширтэх камертайгаа огт авцалдахгүй, чимэглэл гэж хэлэхээргүй, зохилдохгүй байлаа. Ёстой л эрэмдэг чимэг гэлтэй. Нуман хаалганы дээр жижиг хүрэл пайзан дээр: ВАТИКАНЫ АРХИВ Эрхлэгч Жакуй Томазо эцэг гэжээ. *Жакуй Томазо эцэг*. Гэрт нь байгаа бичгийн ширээн дээр нь хэвтэж байгаа Ватиканы архивд оруулахыг таггалзсан олон захидал дээрээс нэрийг нь Ландон зөндөө уншиж, эчнээ танил болсон байв. *Эрхэм Ландон гуай, Таны хүсэлтийг ёсоор болгож чадахгүйдээ гүнээ хүлцэл өчин энэ захидлыг тэрлэн суухдаа ...* Хүлцэл гэнэ ээ. Жакуй Томазог энэ архивын эрхлэгч болсноос хойш лав л Ландоны мэдэхээр католик биш л бол нэг ч Америк эрдэмтэн энэ архивд орох эрх олж аваагүй юм. Түүхчид *түүнийг il guardiano (uma. Харгалзагч)* хэмээн хочилдог байлаа. Жакуй Томазо энэ дэлхийн ямар ч номын сангийн эрхлэгчээс хамгийн хатуу харамч нь байлаа. Ландон хаалга нээн, босго даван орох тэрхэн агшинд Жакуй Томазо цаана нь цэрэг эрээн хувцас, хуяг дуулгаа өмсөөд, гартаа пулемёт барьчихсан зогсож байх вий гэхээс бараг л үнэнээсээ айн гирвэшиж байлаа. Гэхдээ аз

болоход, тэнд хэн ч байсангүй. Чив чимээгүй. Цийлгэнэсэн бүдэг гэрэл. *Ватиканы архив*. Орж үзэх сэн гэж насаараа мөрөөдсөн газар. Ландон архив дотор ормогцоо, хамгийн түрүүнд ямар их гэнэн романтик байснаа ухаарч, ичих шиг болов. Энэ газрын тухай өдий олон жил төсөөлж байсан нь арай ч ийм хол зөрүүтэй баймааргүй сэн. Тоосонд дарагдсан номын тавиурууд, дээр нь хавгас нь навсайсан боть боть ном, тэр дунд шашны гэлэн нар суучихсан, шигтгэмэл цонх, лааны гэрэлд каталог хийгээд л, хажуугаар нь лам нар хөлхөөд л ... Огт өөр байлаа. Эхэлж харахад онгоцны ангаар шиг том танхимд шоо шиг, шоо шиг теннисний талбайг шилээр бариад тусгаарлачихсан юм шиг байв. Ландон, мэдээж, шилэн ханатай тусгаар өрөө байна гэж мэдэж байлаа. Тийм өрөө эртний судар, номыг хадгалахын тулд хэрэгтэй гэсэн чийгшил, дулааны хэмжээг тохируулахад шаардлагатай байдаг. Ландон ийм газар өмнө нь байж байсан, ийм газар орох болгондоо л номын санч хүчилтөрөгчийг нь зоргоороо тааруулдаг ямар нэг агаар үл нэвтрэх саван дотор ороод ирчихсэн юм шиг санагддаг байлаа. Тасалгаанууд бүгээн, бүр сүг сүнс орогносон юм шиг зэвүүн харанхуй, тавиур болгоны цаанаас бүгээн гэрэл суунаглан харагдана. Тасалгаа болгонд түүх өгүүлсэн том том нүсэр тавиур сүндэрлэн байлаа. Түүхийн үлэмж том уурхай. Виттория ч бас гайхан зогсоод, тунгалаг тасалгаануудыг чимээгүй харж байлаа. Цаг бага болохоор, Ландон гэлэндын өрсөн номын тавиуруудыг бүгээн гэрэлд ширтэн зогсоод байсангүй. Тэртээд нүүгэлтэх газар компьютер байгаа бололтой цох шиг гэрэл анивлазана. «Хар даа. Библионоор номын сангаа каталогжуулсан бололтой». «Тэгвэл ч хамаагүй хурдалж болох байх шүү» гэж Виттория найдлага тодрон хэллээ. Ландон уул нь түүний найдлагыг хуваалцмаар л байлаа, гэхдээ дотор нь нэг айдас байв. Компьютер рүү очоод, гаран дээр нь юм шивлээ. Айдас нь үнэн боллоо. «Хуучин аргаа л хэрэглэхээс дээ, тэр нь найдвартай юм шиг байна». «Яагаад?» «Яагаад гэвэл жинхэнэ номд нууц үг байдаггүй юм. Физикч гэдэг чинь компьютерын хакерууд биш шүү дээ?» гээд компьютерын ширээнээс холдов. Виттория толгой сэгсрэн: «Гэхдээ би хясаа онгойлгоод идчихэж чадна шүү» гэлээ. Ландон гүнзгий амьсгаа аваад том том тавиурыг эргүүлэн харлаа. Тэгээд ойрын нэг тасалгаа руу очоод шилний цаанаас бүгээн гэрлийг ширтэн зогсов. Энгийн нэг номын тавиурууд, номын хяз, уншилгын ширээ. Тавиур болгоны эцэст урт цухуйсан товъёог байлаа. Ямар ч номын санд тийм товъёог тэр тавиурт байгаа номын ерөнхий утгыг заадаг билээ. Ландон шилэн хананы цаанаас тавиур болгоны товъёогийг уншиж байв. Pietro l'eremita., Le Crociate... Urbano II ... Levant... «Номоо толгойлчихсон юм байна» гэж дагуулж явангаа хэллээ. «Гэхдээ цагаан толгойн дараалал биш байна» гэв. Үүнд харин гайхсангүй. Олон номын зохиогч нь тодорхойгүй байдаг болохоор хуучны номын сангууд номоо цагаан толгойн дарааллаар толгойлдоггүй байлаа. Номын нэрээр ч толгойлдоггүй, дийлэнх ном бас л нэр, гарчиггүй байдаг ажээ. Тиймээс ихэнх номын сан он цагийн дарааллаар нь өрдөг байлаа. Гэхдээ энд бас л он цагийн дарааллаар өрөгдөөгүй байв. Цаг нь урсаад байгаа юм шиг санагдана. «Ватикан өөрийн гэсэн дараалалтай юм шиг байна». «Тэр нь л дутаж гэнэ дээ». Тэр товъёогуудыг дахин харлаа. Тэнд байгаа ном зуун зуун дамжин тархсан байв, гэхдээ бүх түлхүүр үг нь холбоотой харагдаад байлаа. «Энэ чинь сэдэвчилсэн юм шиг байна». «Сэдэвчилсэн гэнэ ээ, үгүй байлгүй дээ» гэж Виттория хэлэв. «Тэгвэл ч үр дүнтэй арга биш л байна даа». «Гэхдээ, миний харсан хамгийн мундаг товъёог энэ байна даа» гэлээ. Ландон оюутнуудаа бүтээл, огнооны тухайд төөрөлдөхөөсөө илүү тэр үеийн шалтгаан, сэдлийг нь ухаарах хэрэгтэй гэдэг байв. Ватиканы архив ч тэр л зарчмаар каталогжсон байлаа. Өргөн зураас. Ландон унших тусмаа урамшин: «Энэ тавиурт байгаа ном, зуун зуун дамнасан материал Загалмайтны аян дайнтай холбоотой юм байна. Энэ чинь л сэдэв нь юм байна»

гэлээ. Ландон учрыг нь сая л олов. *Түүхийн ойллого, захидал, урлагийн бүтээл, нийгэм-улс төрийн байдал, орчин үеийн шинжилгээ. Бүгд нэг дор байлаа. Нэг асуудлыг илүү гүнзгий ойлгох боломж олгоно. Гайхалтай.* Витториа гайхав. «Гэхдээ энэ өгөгдөхүүн нэг зэрэг олон сэдэв рүү хальж болох юм байна». «Харин тийм болохоор л ийм дагавар товъёог хийсэн юм байна шүү дээ» гээд Ландон баримт бүрийн завсар хавчуулсан өнгөт хавчуургуудыг шилэн хоргоны цаанаас заалаа. »Тэр хавчуурга хаа нэгтээ анхдагч сэдвээ дагаж орсон хоёрдогч баримтыг зааж байгаа юм байна.» Бүсгүй: «Нээрэн, тийм юм шиг байна» гэж их л урамтай яа дэмжив. Тэгээд хуруугаараа уруулаа оролдон номын сангийн асар уужим танхимыг тойруулан хараад, Ландон руу эргэж: «Ингэхэд, профессор гуай, бид хоёрын эрээд байгаа тэр Галилеогийн номын чинь нэр нь юу билээ дээ?» гэв. Ландон чимээгүйхэн инээвхийллээ. Тэр энэ номын санд байгаа гэдэгтээ бас л итгэж өгөхгүй хөөрчихсөн байв. Энд л байгаа даа. *Энэ харанхуйд, хаа нэгтээ байх ёстой.* «Тийшээ явъя» гээд Ландон бүсгүйг дагуулан хоёр ханынхаа эхний эгнээний тавиурыг хянуур ширтэн алхлав. «Гэгээрлийн мөрийн тухай миний ярьсныг санаарай! Бас Иллюминатигийнхан шинэ гишүүн элсүүлэхдээ ямар овжин шалгадаг байсныг санаарай!» «Эрдэнэсийн эрэлд яваа юм шиг байх шив дээ?» хэмээн Витториа араас нь бувтнан дагалаа. «Иллюминатигийнхан тэмдгүүдээ байрлуулж дууссаны дараа, ийм тэмдгүүд байгаа шүү гэдгийг эрдмийн хүрээнийхэндээ ямар нэг байдлаар дуулгах хэрэгтэй болсон юм. Тэгж дуулгах үнэхээр бэрх даваа байжээ». «Аргагүй л дээ» гэж Витториа хэлэв. «Тэгж дуулгахгүй бол хэн ч хайж очихгүй шүү дээ». «Яг үнэн. Тэгээд тийм зам мөр байгаа гэдгийг мэддэг байсан ч гэсэн хаанаас тэр мөр эхэлж байгааг нь олох ямар ч аргагүй шүү дээ. Ром чинь том хот.» «Тийм шүү». Ландон дараагийн эгнээ рүү алхан товъёог, хавчууруудыг хянуур ширтэнэ. «Арван тав орчим жилийн өмнө би Сорбоны их сургуулийн хэдэн түүхчтэй хамт segno-ийн тухай бичсэн Иллюминатигийн хэдэн захидал олсон юм». «Тэмдэг үү? Тэгээд, тэнд чинь зам хаанаас эхэлж байгааг заасан байсан юм уу?» «Тийм. Дараа нь, надаас өгсүүлээд Иллюминатиг судалдаг эрдэмтэд segno-ийн тухай хэд хэдэн баримт олоод байгаа юм. Одоо бол тийм тэмдэг байдаг, тэмдэг эхлэх газрыг заасан байдаг, Галилео тэр тухай Ватиканд мэдэгдэлгүй эрдмийн хүрээнийхэнд тараасан гэдэг нь нийтээр зөвшөөсөн онол болчихоод байгаа.» «Яаж тэгж чадаа вэ?» «Мэдэхгүй, гэхдээ хэвлэмэл материалаар дамжсан байх илүү магадтай. Галилео маш олон ном, бүтээл хэвлэсэн хүн шүү дээ.» «Тэр бүрийг нь Ватикан хянаж л байсан байж таарна шүү дээ. Аюултай биш үү?» «Тийм л дээ. Гэхдээ л тарааж дөнгөсөн байгаа юм». «Гэхдээ хэн ч тэр номыг нь одоогоор олоогүй байгаа юм байна, тийм үү?» «Үгүй дээ. Масон ч тэр, эртний эрдмийн сэтгүүлд ч тэр, Иллюминати ч тэр, ямар нэг байдлаар segno-ийн тухай битүүхэн өгүүлсэн бүх зүйл дандаа л нэг тодорхой тоогоор илэрхийлсэн байдаг юм». «666 ?» Ландон инээвхийлэн «Үгүй дээ, 503». «Юу гэж байгаа юм бэ?» «Юу гэж байгааг нь одоогоор хэн ч мэдэхгүй байгаа. Би тэр 503-аар чинь бараг л өвчилж гүйцээд нумерлоги, зураг зүй, өргөрөг гээд л байж болох бүх байдлаар эргүүлж, тойруулж үзсэн дэг. Учиг нь ердөө олдохгүй байгаа юм». Ландон тэгж ярингаа нэг гудмыг харуулдаг гүйцээд, булан тойрч, дараагийн гудам руу орж, дараа дараагийн товъёог, хавчуургыг яарангуй гүйлгэн харна. «Энэ бүх жилийн турш ганцхан учиг байгаа нь энэ тоо таваар буюу Иллюминатигийн ариун гэж тооцдог тоогоор эхэлсэн явдал л юм» гээд зогсосхийв. «Чи түүнийх нь учрыг олчихоод л энд баталгаагаа хайгаад байгаа юм шиг байх юм, тийм үү?» гэж Витториа инээвхийлэн асуулаа. «Тийм шүү» гэж Ландон хэлэхдээ ажлынхаа үр дүнд тун сэтгэл дүүрэн байгаа байртай байлаа. Ийм мөч тун ч ховор билээ. «Чи Галилеогийн Dialogo гэх номыг нь мэдэх үү?» «Мэдээж. Эрдэмтдийн дунд эрдмээс урвасан бүтээл гэгддэг шүү дээ». Урвах гэдэг үг Ландонд арай л хатуу сонсогдов, гэхдээ тэр Витториаг ойлгож байлаа.

Галилео 1630 оны эхээр нарны аймгийн тухай Коперникийн нар төвт (heliocentric) загварыг нотолсон бүтээл хэвлүүлье гэсэн ч Ватикан үүнийг нь зөвшөөрөхгүй, шашны дэлхий төвт (geocentric) адил хүчинтэй еэ нотлохоос нааш номыг нь хэвлэхгүй гэдгийг сайтар мэдэж байлаа. Уул нь, тэр Ватиканы төсөөллийг дотроо буруушааж байсан ч, гэхдээ номоо хэвлүүлэхийн тулд дэлхий төвт загварын тухай бичихээс өөр аргагүй байж: эцэст нь, зөв буруу хоёр загварыг хоёуланг нь зөв гэж нотолсон бүтээл болжээ. «Гэхдээ Галилео буулт хийсэн ч гэсэн Dialogo-г тэрслүү ном гэж үзээд, гэрийн хорионд хийчихсэн шүү дээ. Чи үүнийг юу эс андах билээ» гэж Ландон хэлэв. «Буруу юм хийсэн бол зэм хүртэлгүй яах вэ дээ». Ландон инээмсэглэн: «За, тийм дээ. Гэхдээ л, Галилео шантраагүй юм. Гэрийн хориондоо байхдаа, Discorsi гэдэг ном бичсэн нь нэг их алдаршаагүй боловч эрдэмтэд дандаа Dialogo-той нь андуураад байдаг юм. Витториа толгой дохив. «Сонссон л юм байна. *Далайн татлагын тухай ойллого (Discourses on the Tides)*». Ландон зогтусан, нэрд гараагүй, цөөхөн хүн мэддэг бүтээлийн тухай Витториа мэддэг төдийгүй гариг эрхсийн хөдөлгөөн далайн татлагад нөлөөлдөг тухай бичсэнийг ч сонссон байхыг гайхав. Бүсгүй ч анзаарсан бололтой: «Хүүе! Аав нь Галилеог шүтдэг байсан, далайн физик судалдаг итали физикчтэй ярьж байгаа шүү, та» гээд инээвхийлнэ. Ландон ч инээв. Гэхдээ тэдний хайж байгаа ном бол Discorsi биш ажээ. Галилео гэрийн хорионд байхдаа түүнээс гадна хэд хэдэн ном бичжээ. Тэдгээр номын нэг нь бас л цуу багатай Diagramma байлаа. *Diagramma del Verita* гэж Ландон хэлэв. *Үнэний диаграмм*. «Огт сонсоогүй эд байна». «Магадгүй ээ. Диаграмма гэдэг нь Галилеогийн үнэн гэж боддог ч, бусадтай хуваалцаж болохгүй байсан эрдмийн фактын товчоо юм шиг байгаа юм. Хамгийн нууц бүтээл нь гэдэг. Галилеогийн номыг найз нөхөд нь Ромоос нууцаар авч гараад, Голландад хэвлүүлдэг байжээ. Тэр номыг ч бас л тэгж хэвлэжээ. Гэхдээ, тэр ном тэр үеийн Европын нууц ажилладаг байсан эрдэмтдийн дунд цууд гарсан юм. Яваандаа, Ватикан тэр номын тухай олж мэдээд, түүнийг шатаах кампанит ажил явуулсан байдаг». Витториа түүнийг их л эргэлзэнгүй харав. «Чи тэгээд тэр Диаграмма-д учиг нь байгаа гэж бодоо юу? Нөгөө тэмдгүүдийн учиг нь, Гэгээрлийн мөрийн тухай мэдээг тэр номоос олж болно гэж үү?» «Диаграмма-гаар Галилео хэлэх гэсэн юмаа хэлсэн юм. Энэ бол харин үнэн шүү». Ландон нэг гудмыг дуусгаад, дараагийн гудмаар орж, эгнээ тус бүр дэх товъёогийг ажиглан алхана. «Архивчид Галилеогийн тэр номыг он удаан хайж байгаа юм. даан ч заримыг нь Ватикан шатаагаад, үлдсэнийх нь *permanence rating* цаас нь элэгдээд, энэ ном одоо огт олдохгүй болчихсон». «*Permanence rating?*» «Хадгалагдах хугацаа гэсэн үг л дээ. Архивчид баримт бичгийн хадгалагдах чанарыг нэгээс арав хүртэл тоогоор үнэлдэг юм. Диаграмма-г *sedge raryus* дээр хэвлэсэн. Тэр нь яг л уудаг цаас шиг, сарампай цаас л даа. Дээд тал нь, зуун жил л хадгалж болох байх». «Яагаад арай илүү бөх цаасан дээр хэвлээгүй юм бол?» «Галилеогийн заль. Шавь нараа хамгаалах гэсэн арга л даа. Хэрэв хэн нэгэн эрдэмтэн энэ номыг авч яваад баригдах юм бол, усанд хаячихад л уусаад алга болчихно. Нотлох баримт устгах гайхалтай сайн арга, гэхдээ архивчдад бол эмгэнэл гэсэн үг. Гэхдээ XVIII зуунаас хойш Диаграмма-гийн цорын ганц хувь л хадгалагдаж үлдсэн гэдэг.» «Ганц аа?» гэж Витториа асуухад нь нүдэнд нь оч цахилах шиг болоод, эргэн тойрноо гэнэт их л хянамгай ажиглав. «Тэгээд тэр нь энд байгаа юм уу?» «Галилеог нас барсных нь дараа, Ватикан Голландаас хурааж авсан юм. Би тэрийг л олж үзэх санаатай, энд ирэх гэж өргөдөл гаргасаар удаж байна. Тэрийг энд байгаа гэдгийг мэдсэнээсээ хойш л хөөцөлдөж байгаа юм». Ландоны юу бодож байгааг нь уншсан юм шиг Витториа гэнэт хөдөлж, шилэн хоргоны цаанаас номын тавиур руу ширтэн, баримтын товъёогуудыг уншиж эхлэв. Ландон: «Баярлалаа. Галилео, эрдэм, эрдэмтэд гэх мэт товъёог хайгаарай. Чи хармагцаа л танина даа» гэлээ. «За. Гэхдээ чи яагаад

заавал Диаграмма -д тэр учиг байх ёстой гэж бодоод байгаа юм бэ? Иллюминатигийн захидлуудад тэр тухай дурдсан юм уу, эсвэл тэр 503-т учир байна уу?» Ландон инээвхийлнэ. «Тийм шүү. Би нэлээн удаж байж 503 гэдэг хялбаршуулсан код юм гэдгийг ухаарсан юм. Энэ чинь шууд л Диаграмма гэсэн үг байна лээ». Хоромхон зуур, Ландон энэ ухаарлыг олсон өдрөө буюу 8 дугаар сарын 6-ны өдрийг эргэн санах. Хоёр жилийн өмнө юм сан. Найзынхаа хүүгийн хуримын ёслолд оролцоод, жижиг цөөрмийн эрэг дээр зогсож байлаа. Цоорт аргон эгшиглэн, хос хоёр цөөрмийн голоос гатлага сал хөлөглөн орж ирж байв. Тэр салыг цэцгэн эрхээр дүүртэл чимсэн болохоор, жижигхэн цэцгэн арал хос хоёрыг авчирч байгаа юм шиг харагдана. Тэр гаталга салын хитэг дээр ром тоогоор DCII гэж бичсэн байв. Тэр тоог нь хараад, Ландон гайхасхийн бэрийн эцгээс нь: «602 гэж юу гэж байгаа юм бэ?» гэж асуужээ. «602 оо?» Ландон салын хитэг рүү заагаад: «DCII гэдэг чинь 602 гэсэн ром тоо биз дээ?» гэлээ. Тэр эр тас тас хийтэл инээгээд: «Тэр чинь ром тоо биш ээ. Салын нэр нь байхгүй юу» гэлээ. «DCII гэж үү?» Тэр эр инээсэн хэвээр: «Дик, Коний 2 гэдгийг товчилсон юм (Dick and Connie 2, DCII)» гэлээ. Ландонд ичмээр санагджээ. Дик, Коний гэдэг нь хуримлаж буй хосын нэрс байлаа. Мэдээж салыг тэр хоёрын нэрээр нэрлэжээ. «Тэгвэл DC 1 нь хаачсан юм бэ?» Нөгөө эр хоолойгоо засаад: «Өчигдөр хуримын ёслолыг сургуулилж байх үед живчихсэн юм» гэж билээ. Ландон хөхрөөд: «Уучлаарай, тоогүй юм болжээ» гэв. Тэр гаталга сал руу эргэн харлаа. DCII гэж яг л QEII гэдэг шиг хэмээн бодов. Дараа нь гэнэтийн нээлт тархинд харван орж иржээ. Ландон Виттория руу эргэж: «503 гэдэг чинь код юм. Иллюминати үүнийг ром тоотой эндүүрэхүйц болгох гэж л дээ. 503 гэдэг чинь ром тоогоор бол...» «DIII...» Ландон Витторияг үгийг нь шууд таслахад гайхан хараад: «Хурдан хувиргаж байна шүү. Чи өөрийгөө Иллюмината* гэж л битгий хэлээрэй дээ!» Бүсгүй инээд алдаад: «Би пелагийн хүрээг ром тоогоор дугаарладаг юм» гэлээ. Нээрэн тийм л дээ, гэж Ландон бодлоо. Виттория цааш нь: «Тэгээд DIII гэдэг чинь юу гэсэн үг юм бэ?» гэв. «DI, DII, DIII гэдэг их эгэл бус товчлол байгаа юм. Эртний эрдэмтэд хоорондоо дандаа эндүүрэгдээд байдаг Галилеогийн гурван номыг тэгж ялгадаг байж л дээ.» Виттория гүнзгий амьсгаа аваад: «Dialogo, Discorsi, Diagramma» гэлээ. «D нэг, D хоёр, D гурав гэж. Бүгд эрдмийн бүтээл. Бүгд маргаан тарьсан. Тэгэхээр 503 гэдэг бол DIII, Диаграмма юм. Гурав дахь ном нь». Виттория эргэлзэнгүй харагдана. «Гэхдээ нэг юмыг ойлгосонгүй. Хэрвээ энэ segno, тэмдэг, Гэгээрлийн мөрийн тэмдэг нь Галилеогийн Диаграмма-д, үнэхээр байсан юм бол Ватикан бүх хэвлэлийг нь хурааж авсныхаа дараа яагаад олж хараагүй юм бол?» «Харсан ч гэсэн анзаараагүй байж болно шүү дээ. Иллюминатигийн тэмдгүүдийг бод л доо. Юмыг ердийн юм шиг нуух. Диссимуляц. Segno-г яг л тийм аргаар ердийн юм шиг нууцалсан байгаа. Хайгаагүй хүнд олдохооргүй энгийн. Бас ойлгоогүй хүнд олдохгүй энгийн.» «Юу гэсэн үг вэ?» «Галилео сайн нуусан гэсэн үг. Түүхэнд өгүүлснээр бол Иллюминати segno-гоо lingua pura (цэвэр хэл) дээр бичиж үлдээсэн гэдэг.» «Цэвэр хэлээр үү?» «Тийм». «Математикаар уу?» «Би бас тэгж л тааж байна. Гэхдээ хэтэрхий энгийн санагдаад байгаа юм. Галилео эрдэмтэн хүн байсан, тэгээд эрдэмтэн хүндээ бичиж байсныг санах хэрэгтэй. Тиймээс математик бол хамгийн логиклог сонголт болох нь эргэлзээгүй. Номыг Диаграмма гэдэг байсан, математикийн диаграмм бас ямар нэг код байж болох л юм.» Виттория эргэлзэхээ больж байгаа бололтой. «Тэгвэл Галилео шашныханд мэдэгдэхгүй ямар нэг математик код зохиосон байх». «Чи миний санааг бараг л зөвшөөрчихсөн бололтой байх чинь» хэмээн Ландон тавиурын эгнээ хоорондуур явангаа хэллээ. «Үгүй дээ. Гол нь чи өөрөө эргэлзээд байгаа болохоор. Хэрэв чи DIII -ийн тухайд итгэл төгс байсан бол яагаад хэвлээгүй юм бэ? Тэгээд бас, Ватиканы архивд нэвтрэх эрхтэй нэгэн хүрч ирээд, тэр Диаграмма-г чинь аль хэдийн шалгачихгүй яасан юм

бэ?» «Би хэвлэх гэж яараагүй юм» гэж Ландон хэлэв. «Би мэдээлэл олох гэж их зүтгэл гаргасан юм шүү» гэж хэлснээ, зогтусан чимээгүй болчхов. Өөрийгөө магтчихсанаа гэнэт мэдрээд ичих шиг боллоо. «Алдар цуу хүсээ юм биз дээ?» Ландон ичсэндээ улайж орхив. «Тэгж хэлж болох л юм. Гэхдээ энэ зөвхөн ... «За юундаа ичингүйрээд байгаа юм бэ? Би бас эрдэмтэн хүн, чамайг ойлголгүй яах вэ? Хэвлэ, эсвэл үх гэдэг. СЭРН-д бид энэ тухай «нийтлүүл, эсвэл ниргүүл» гэдэг юм.» «Гэхдээ, би энэ тухай анх хэвлэсэн хүн болох гэж зүтгэхдээ бас гол биш. Гол нь хэн нэгэн буруу гарын нөхөр энэ тухай мэдчихвэл, Диаграмма-т олж аваад, алга болгочих вий гэж бас эмээсэн юм». «Буруу гарын нөхөр гэдэг нь Ватикан уу?» «Яг ч шууд утгаараа биш л дээ, гэхдээ Ватикан дандаа л Иллюминатигийн аюулыг арай бага үнэлээд байдаг юм. 1900-аад оны эхээр Иллюминати гэж хүмүүсийн айдсандаа автсан хийрхэл төдий зүйл гэж хүртэл мэдэгдэж байсан. Хүчирхэг том анти-христ бүлэглэл, шашны бүх банк санхүү, улс төр, их сургуулиудад нь хэрж нэвччихсэн гэдгийг шашныхан мэдэхийг ч хүсэхгүй биз.» *Энэ өгүүлбэрийг одоо цаг дээр хэлэх хэрэгтэй юм байна даа гэж Ландон бодлоо. Шашны банк санхүү, улс төр, их сургуулиудад нь хэрч нэвччихсэн хүчирхэг том анти-христ бүлэглэл ОРШИН буй шүү дээ.* «Тэгэхээр, Иллюминатигийн заналхийлсэн бүх үйлдлийг шашныхан огт анзаарахыг хүсэхгүй өнгөрөөгөөд байсан гэсэн үг үү?» «Тун магадгүй дээ. Төсөөлсөн ч бай, бодитой ч бай, ямарваа заналхийлэл шашны эрх сүрийг унагана шүү дээ». Витториа хоромхон зуур зогсохийснээ: «Дахиад нэг юм асууя. Чи нээрэн яриад байна уу?» гэж асуулаа. Ландон зогссоноо: «Юу гэнэ ээ?» гэв. «Чи нээрэн ингэж бодоод л байдлыг аврах гэж яваа хүн үү?» Бүсгүйн нүдэнд бахдал, айдсын аль нь тодроод байгааг Ландон ухаарсангүй мэлрэв. «Диаграмма-тийн тухайд уу?» «Харин тийм. Диаграмма-т олоод, дөрвөн зуун жилийн настай segno-т ухаж төнхөөд, математик кодыг нь тайлж уншаад, зөвхөн түүхэнд суу алдар нь түгсэн эрдэмтдийн тайлж уншаад мөшгөн явсан тэр нууцлаг чиг заагчийг дагаж яваад л... тэгээд ердөө дөрөвхөн цагийн дотор шүү» Ландон мөрөө хавчаад: «Өөр олигтой санал байвал сонсмоор л байна шүү» гэлээ. *Иллюмината буюу Illuminata гэдэг нь латин хэлээр гэгээрэгч гэдэг үгийг эм хүйс дээр хувилгасан үг юм. Ветра авхай эмэгтэй хүн тул тийн хэлжээ. Харин Иллюминатигийн гишүүн эр хүнийг Иллюминатус хэмээнэ.

Хэсэг 50

Роберт Ландон 9-р хоргын дэргэд зогсоод тавиурууд дээрх товъёогийг уншлаа. Брах ... Клавиус ... Коперник ... Кэплер ... Ньютон Ландон тэр нэрсийг дахин дахин уншаад учрыг нь нэг л ухахгүй байв. *Энд дандаа эрдэмтэд байх юм. Гэхдээ яагаад Галилео байхгүй байгаа юм бол?* Тэр Витториа руу эргэн харвал бүсгүй хажуугийн тавиурын товъёогийг уншина. «Би зөв тавиураа олчих шиг боллоо. Гэхдээ Галилео байхгүй байх юм..?» «Тэнд ч байхгүй л дээ» гэж бүсгүй хэлэнгээ дараагийн тавиур руу дөхөв. Тэгээд «Яагаад гэвэл тэр чинь тэнд байна. Чамайг нүдний шилээ авчирсан гэж найдъя. Учир нь бүхэл бүтэн хана тэр чигтээ Галилеогийнх байна» гэлээ. Ландон яаран очив. Витториа зөв хэлжээ. Бүтэн хана дүүрэн ном байх ба түлхүүр үг нь бүгд л II. PROCESSO GALILEANO гэсэн байв. Галилеогийн бүтээл бүтэн хана дүүрэн байгааг хараад, яагаад 9-р хоргод түүний бүтээл байгаагүйг ухааран, Ландон дуу алдах шахлаа. Нүд нь шилнийхээ араас жартайн, харанхуйд сүүмийх тавиурыг өрөмдөн ширтэнэ. «Ватиканы түүхэн дэх хамгийн урт, хамгийн үнэтэй шүүлт. Арван дөрвөн

жил, зургаан зуун сая лир. Бүх материал нь энд байгаа шүү дээ». «Бага зэрэг хууль, шүүхийн баримт бичиг л байгаа нь энэ» гэж Витториа хана дүүрэн тавиурын хаанаас нь эхлэхээ мэдэхгүй хошигнов. «Зуун зууны турш, нэг ч хуульч ийшээ зүглээгүй бололтой». Ландон хоргын дэргэдэх шар товчлуур руу дөхөж, дарахад цувсан олон жижиг бүдэг гэрэл хорго дотор бүүдийн асав. Гэрэл час улаан - шоо дөрвөлжин хоргыг аньсны өнгөтэй болгож, тааз тулам өндөр тавиурын тэртээ дээрээс сүүмийнэ. «Бурхан минь!» хэмээн бүсгүй дуу алдаад: «Бид хоёр ажиллах гэж байна уу, шарлага хийлгэх гэж байна уу?» гэв. «Илгэн цаас, бас гялгар цаас гэрэлд элэгддэг юм. Тийм болохоор номын хоргын гэрэлтүүлэг ямагт бүдэг байх ёстой». «Энэ бүдэг улаан гэрэлд удвал галзуурах байх аа». Бүр долоон дор гээч гэж Ландон дотроо үглээд, хорго руу нэвтрэх үүд рүү дөхлөө. «Сануулах юм байна. Хүчилтөрөгч бол исэлдүүлэгч бодис, тиймээс битүү шилэн хоргод бага байх ёстой юм. Тэгэхээр энэ дотор бараг л вакуум байгаа гэсэн үг. Амьсгал давчдаж магадгүй шүү». «Нөгөө хэдэн хөгшин кардинал тэсч чадвал ч яах вэ, болж л байна.» Тэр ч тийм шүү гэж Ландон бодов. *Бид ч бас ялгаагүй амь гарч чадвал ...* Хоргын үүд нь дөрвөн хавтастай эргэдэг хаалга байв. Хавтас болгондоо нэг нэг, нийт дөрвөн товчлууртай ажээ. Товчлуурыг дармагц хаалганы гол хагас эргэж, үүдийг нээмэгцээ хаах бөгөөд ингэж хоргын доторх атмосферийг нь хадгалдаг ажээ. «Намайг орсны дараа» гэж Ландон сануулан: «Зүгээр л энэ товчийг нь дараад ороод ирээрэй. Энэ дотор ердөө л найман хувийн чийглэгтэй болохоор ороход чинь хэт хуурай байх байх шүү» гэлээ. Ландон хаалганы хавтас дотор орж зогсоод, товчийг нь дарвал хаалганы гол тарчигнан дуугарсаар эргэлээ. Битүү хоргон дотор бүгчим, хуурай байдаг болохоор дөнгөж ормогц хэдэн хором бие эвгүйцдэг, Ландон үүнийг мэдэх тул хаалганы нээгдэж буй хавтсыг даган алхах зуур биеэ бэлтгэн зэхэж байлаа. Ийм битүү хоргод орно гэдэг далайн төвшнөөс шууд л 20 000 тохой өндөр рүү эгшин зуур гарахтай адил, тиймээс толгой эргэж, дотор давчиддаг нь олонтаа ажээ. Давхар хар, давхар хэмээн номын санчдын байнга давтдаг, үгийг өөртөө сануулан орлоо. Агаар исгэрэн орох сонсогдоод хаалганы хавтас хаагдав. Орчихлоо. Дотор нь байсан агаар бодож байснаас ч бага ажээ. Ватиканы албатууд архив хадгалалтдаа их л нухацтай ханддаг бололтой. Бие нь цочирч, уушгины судас нь огцом ачаалалд орж, дасан ядаж байгааг мэдэрлээ. Дельфин минь шумбаарай гэж өөртөө хэлнэ. Өдөр бүр усанд сэлдгийнхээ ачаар цочролыг дажгүй давчихлаа. Одоо л арай дөнгүүр амьсгалах болж, орчин тойрноо эргүүлэн харлаа. Хоргын хана тунгалаг ч гэсэн нөгөө л эвгүйцэл төрж байв. *Би хайрцаган дотор зогсч байна. Цусан улаан өнгөтэй хайрцаг шүү.* Ард нь хаалга тарчигнан дуугарахад, Ландон эргэж, орж ирж яваа Витториа руу харлаа. Орж ирмэгцээ л нүд нь цийлгэнээд, амьсгал нь бахардаж эхлэв. «Жаахан азна!» гэж Ландон хэлээд: «Цочролд орж байгаа юм. Жаахан бөхийгөөд амьсгал» гэж зөвлөлөө. «Би яг л ...» гэж Витториа үгээ зөөн: «... усанд шумбаж... байгаа юм шиг... гэхдээ ... буруу усандаа л ... орчих шиг боллоо. . . доо» гэлээ. Ландон Витториаг гайгүй болохыг хүлээн азнав. Бүсгүй энэ цочролыг дажгүй давчихна гэж мэдэж байлаа. Витториа харваас тамирчин маягийн шаавай хүүхэн байлаа. Ландон өмнө нь Радклифийн нэг төгсөгч авгайтай хамт Уайденэр номын сангийн битүү хоргод нэг удаа хамт орж байсан бөгөөд нөгөө авгай ухаан алдаж унаад, тэгээд ам руу нь хиймэл амьсгаа хийж хэрэгтэй болж, тэр үед хөөрхий авгай бас хиймэл шүдэндээ хахаж үхэх шахсаныг санаж зогслоо. «Дажгүй юу?» Витторий толгой дохив. «Чи намайг аймшгийн хурдтай сансрын хөлгөөр нисгэж толгой эргүүлж, дотор муухай оргиулаа биз дээ? Одоо миний ээлж шүү» гэлээ. Бүсгүй мушилзасхийн инээвхийлээд: «Тэгвэл одоо адилдаа адил, годилдоо годил боллоо шүү» гэв. Ландон хаалганы дэргэд байх нэг жижиг сав руу очиж, товчийг нь дарвал цагаан бээлий гарч ирэв. «Албаны өмсгөл юм уу?» гэж Витториа асуув. «Хуруу хамгаалдаг

юм. Өмсөхгүйгээр энэ бичгүүдтэй ажиллаж болохгүй. Чи ч гэсэн нэгийг өмссөн нь дээр дээ» гэлээ. Витториа гартаа бээлий өмсөөд: «Цаг юу болж байна?» гэв. Ландон Микки Маустай цагаа харснаа: «Долоо л өнгөрч байна» гэлээ. «Хоёулаа тэрийг чинь нэг цагийн дотор олох ёстой юм байна шүү дээ». «Гэхдээ бид хоёрт тийм хугацаа байхгүй» гэж Ландон хэлээд таазны сараалжийг заав. «Уул нь битүү хоргонд хүн орвол, номын санч байн байн агааржуулагч ажиллуулах ёстой юм. даан ч өнөөдөр тэгэхгүй. Тиймээс хорин минутын дараа хоёулаа бүтэж үхэхдээ тулна шүү» гэлээ. Витториа улаавтар өнгөтэй туяан дунд толгой дохиж харагдлаа. Ландон инээвхийлээд, бээлийгээ өмсөнгөө: «Ветра авхай минь, бүтээ эсвэл бүтэж үх гэдэг чинь болж байна даа. Микки маань цаг тоолж эхэллээ шүү».

Хэсэг 51

ВВС-ийн сурвалжлагч Гунтер Глик алмайн гацчихав. Гар утсаа өмнө нь огт харж байгаагүй юм шиг арваад хором гөлөрч байснаа, эргүүлж халаасандаа хийв. Чинита Макри түүнийг араас нь машин дотроос харж байснаа: «Яасан бэ? Хэн яриа вэ?» гэж асуулаа. Глик эргэж харахад, яг л авахгүй байх гэсэн бэлгээ авсан хүүхэд шиг нүд нь гялалзаж байв. «Би нэг сонин юм сонслоо. Ватикан дотор нэг юм болоод байна даа». «Тэрийг чинь цуурган гэдэг юм» гэж Чинита хэлээд: «Сонин юм аа ч олж дээ, чи» гэв. «Биш ээ. Өөр юм болоод байна». *Өөр юм болоод байна. Сая утастсан хүн үнэн ярьсан байгаа даа гэж Глик итгэж ядан байлаа. Үнэн байгаасай гэж хүсч байгаадаа, тэр бараг л өөрийгөө гайхна.* «Дөрвөн кардиналыг хулгайлчихсан, тэгээд өнөө шөнө өөр өөр газар тэр дөрвийн бодийг хөтөлнө гэвэл чи яах вэ?» «Нэг муу хийх юмаа олж ядсан амьтан чамайг хуурч байна л гэнэ дээ». «Эхний аллага болох газрын хаягийг чи бид хоёрт удахгүй хэлнэ гэсэн бол чи яах вэ?» «Чамтай бас ямар амьтан нь юу гээд ярьчихсаныг л мэдмээр байна даа». «Мэдэхгүй. Надад хэлээгүй». «Тэгвэл нэг овилгогүй амьтан л байхгүй юу даа». Макри ая зан муутай байх янзтайг Глик гадарлалаа. Гэхдээ Британи хов сонинд арван жил ажиллахдаа худал, хуурмаг цуу яриа л түүний хөөцөлдөх ёстой зүйл мөн болохыг тэр сурсан билээ. Утастсан хүн аль нь ч биш байлаа. Тэр хүн эрүүл хүйтэн ухаанаар асуудалд хандаж байв. *Би чам руу найм болохоос өмнөхөн ярьж, эхний аллага хаана болохыг хэлнэ. Чи тэрийг нэвтрүүлж чадвал ч алдартай болно доо.* Глик тэр хүнийг яагаад ийм мэдээ түүнд өгөөд байгааг асуухад түүний хоолой, Ойрх дорнод аялга нь цэл хүйтэн болж хувираад *яагаад гэвэл хэвлэл мэдээлэл бол нийгмийг үймээн бусниулах хамгийн оновчтой зэвсэг шүү дээ* гэсэн билээ. «Тэр бас өөр юм ярьсан» гэж Глик хэлэв. «Юу гэж? Элвис Прэслийг Пап болчихлоо гэж үү?» «ВВС-ийн датабааз руу залга даа» гэж Глик агдганав. «Энэ нөхдийн тухай ямар ямар мэдээ цацагдаж байсныг би мэдмээр байна.» «Ямар нөхөд?» «Тоглоод байгаа юм уу, надаар?» Макри санаа алдаад, утсаа авч ВВС-ийн мэдээллийн сан руу залгав. «Хэдэн минут хүлээх хэрэгтэй болох байх даа». Глик хамаг оюунаа дайчлан, ямар нэг юмны учрыг олох гэж мэрийнэ. «Тэр хүн намайг зураглаачаа заавал авчир гээд байсан шүү». «Оператор аа гээч». «Тэгээд бас шууд дамжуулж чадах уу гээд байсан». «Нэг мянганы таван зуун долоон мегагерц гэнэ үү? Энэ чинь юу гэсэн үг юм бэ?» Мэдээллийн сан дин дин хэмээн дохио өгөв. «За за, бид хоёр ингээд мэдээллийн сан руу нэвгэрчихлээ. Ингэхэд, чи хэний тухай мэдээ хайгаад байгаа юм бэ?» Глик түүнд түлхүүр үг хэлж өгөв. Макри компьютер рүүгээ эргэж хараад, гар дээгүүр нь тачигнуулан бичив. Тэгээд дараа нь: «Чи надаар тоглож байгаа байлгүй дээ» гэлээ.

Хэсэг 52

10 дугаар хорго дотор Ландоны бодсон шиг зохион байгуулалттай байсангүй, Диаграмма

ч Галилеогийн бүтээлүүд дотор байхгүй байх шиг санагдана. Компьютерт хийсэн Библионгүй, мөн номын каталоггүй болохоор Ландон, Витториа хоёр гацаж «Диagramма нээрэн энд байгаа гэж үү?» гэж Витториа асуув. «Баталгаатай. Энэ тухай олон сурвалж нотолсон. *Ufficio della Propoganda delle Fede*» «За за. Чи л мэдэж байгаа бол барав.» Ландон баруунш, бүсгүй зүүнш эргэлээ. Ландон хайлт хийж эхлэв. Тэр бүх товъёог унших гэж оролдон, хажуугаараа гарсан бүх баримтыг харах гэж оролдож байв. Тэнд гайхамшигтай материалууд байлаа. *Ассаер ... Одот элч . . . Наран толбо өгүүлэл . . . Христина бэйж авхайд бичсэн захидал . . . Apologia pro Galileo...* гээд л. Нэлээн удаан хайсны эцэст Витториа хоргын сүүл хэсэгт хайснаа олов. *Diagramma della Verita*. Ландон суунагласан улаан гэрэл дундаас үсрэн ирэв. «Хаана байна?» Витториа олсон бичиг рүүгээ заахад, Ландон түүнийг яагаад шууд олчхож чадаагүйгээ ухаарав. Ном бусдын адил тавиур дээр байсангүй, харин тусдаа хавтгай царан дээр байлаа. Хавтаслаагүй цаасыг хадгалахдаа, тийм цар ашигладаг байв. Тэр царын гадна талд байсан гарчиг дотор нь юу байгааг эргэлзээгүй хэлээд өгч байлаа. ҮНЭНИЙ ДИАГРАММ Галилео Галилей, 1639 Ландоны зүрх нь дэлссээр өвдөг дээрээ сөхөрч орхилоо. Диagramма. Тэр бүр тэсгэлгүй хөхөрч байлаа. «Сайхан шүү. Энийг татаж гаргахад туслаач» гэлээ. Витториа хажууд нь суугаад хамт өргөлцөв. Номыг хадгалсан металл цар гүйдэг замаар шурхийн гарч ирлээ. Татахад зүгээр л гараад ирэхээр нь Витториа гайхан: «Цоожгүй юм уу даа» гэв. «Байхгүй, байх ч ёсгүй юм. Зарим үед энэ бичиг баримтуудыг цөмийг нь маш яаралтай нүүлгэх хэрэгтэй болно шүү дээ. Гал гарах ч юм уу, усанд автах ч юм уу?» «Онгойлго доо». Ландон дахиж хэлүүлсэнгүй. Судлаач болсон цагаасаа үзье гэж мөрөөдсөн баримт нь түүний өмнө байлаа. Дээрээс нь агаар багасч байв. Янцаглаж ядах ямар ч шалтгаан байсангүй. Царын түгжээг нь шууд мултлаад тагийг нь өргөв. Хайрцгийн дотор хар уут байлаа. Тийм уут дотор нь байгаа цаасыг хадгалахад туйлын чухал ажээ. Уутыг хэвтгээгээр нь болгоомжтой ёо өргөн, хоёр гараараа барьж хайрцгаас гаргалаа. «Би эрдэнэсийн сав байх болов уу гэж бодсон юм» гэж Витториа хэлээд: «Тэгсэн чинь дэр шиг юм байх юм» гэлээ. «Нааш ир!» хэмээн Ландон тэр уутыг тахил өргөж байгаа аятай нандигнан өргөсөөр хоргын голд байх шилэн тавцантай уншилгын ширээ рүү явав. Ихэнх архивд уншилгын ширээг аль ч тавиураас ойрыг бодож хоргын гол хэсэгт байрлуулдаг. Бүх гайхамшигт нээлтийг ийм л жирийн ширээнээс хийсэн байдаг агаад судлаач нар нарийн нандин бичиг баримтаа үзэж суухад нь өрсөлдөгч нь шилэн хоргын цаанаас хараад байгаасай гэж хүсдэггүй болохоор ширээ тойрсон тэр тавиуруудад дуртай байдаг ажээ. Ландон уутыг ширээн дээр болгоомжтой ёо тавиад амыг нь нээлээ. Витториа хажууд нь зогсоно. Ширээн дээр өрсөн архивын хэрэгслээс Ландон *finger cymbals* гэж архивчдын нэрлэдэг хоёр үзүүртээ хавтгай дугуй бүхий урт гэгч хямсаа авлаа. Тэр баярласандаа их л яараад, Кембрижийн их сургуульд, оюутнуудынхаа шалгалтын дүнг засах гээд аймшгийн их цаасан дундаа сэрж орхих вий хэмээн айж байлаа. Гүнзгий амьсгаа аваад, тэр уутыг онгойлгов. Бээлий дотор гар нь чичирч байгааг хямсаагаа авахад нь харж болох байв. «Тайвшир даа. Энэ чинь цаас болохоос плутони биш» гэж Витториа хэллээ. Ландон хямсаагаа ууган дотор томбойх бичгийн хажуугаар оруулж, хуудсанд аль болох жигд даралт үзүүлэхүйц байдлаар бүхэлд нь зөөлөн хавчив. Тэгээд, цааснуудыг зүгээр л татаад гаргачхын оронд, тэр чигт нь хавчиж байгаад уугаа зөөлөн гулгуулж татлаа. Энэ бол эх хувь дээр нь ором үлдээхгүйн тулд архивчдын түгээмэл хэрэглэдэг арга билээ. Цааснуудыг уутнаас гаргаж тавиад, ширээний гэрлээ асаан асаатал Ландон амьсгаа авсангүй. Шилэн ширээний доороос нэвт гэрэлтэх бүдэг гэрэл нүүрэн дээр нь тусахад Витториа яг хий үзэгдэл шиг харагдана. «Хөөх, ямар жижигхэн хуудас вэ?» Ландон толгой дохив. Урд нь байгаа ном хямдхан цаасан дээр хэвлэсэн номын урагдсан

хуудас шиг харагдана. Тэргүүн хуудас дээр Галилей өөрөө өнгийн бэхээр урлан бичиж, номын нэр, огноо, нэрээ тавьсан байлаа. Энэ эгшинд, Ландон ядарсан зүдэрснээ бүү хэл, энд ирэх болсон аймшигт үйл явдлынхаа тухай ч ор тас мартаж орхисон байв. Тэр зүгээр л баярлан мэлэрч зогслоо. Түүх гэгчтэй ингэж нүүр тулах тоолон, Ландон дандаа ийнхүү бишрэн мэлэрдэг агаад Мона Лиза зураг дээрээс Леонардо да Винчигийн өөрийнх нь үлдээсэн бийрийн зураасыг ажиглах шиг гайхал, бахархал төгс эгшин байдаг билээ. Эрж байсан нөгөө ном нь шарласан илгэн цаастайгаа бүрэн эхээрээ ямар ч эргэлзээгүй өмнө нь байлаа. Хадгалагдсан он цагтай нь харьцуулахад гайхамшигтай хадгалжээ. *Пигмент жаахан урсах хандлага оржээ. Цаас нь бага зэрэг шарлаж, элэгдсэн байна. Гэхдээ л ерөнхийдөө бол . . . гайхалтай сайн хадгалжээ.* Зурж чимэглэсэн хавтсыг нандигнан эргүүлэх тэр зуур, хоргон доторх хуурайшлаас болоод нүд нь харанхуйллаа. Витториа чимээгүй зогсоно. «Чимхүү өгөөдөх дөө!» Ландон ширээн дээрх архивын хэрэгсэл өрсөн тавиур руу зангав. Витториа тэрийг нь түргэн дөхүүллээ. Тун сайн эд ажээ. Ландон нэг гартаа чимхүүрээ атгаад, нөгөө гараараа номын хуудсанд хүрэлгүй хөнгөн шүргэн арчиж хуралдсан байж магадгүй статик цэнэгийг арилгав. Тэгээд, чимхүүрээ хуудсан завсар аажуухан шургуулаад, нөгөө үзүүрээр нь хавчиж хуудсыг нямбай гэгч эргүүлэв. Эхний хуудсыг чимэглэх гэсэндээ гараа өргөж бичсэн бололтой, угалзлуулан бичсэнийг нь бараг л унших аргагүй байлаа. Номд Ландоны бодож байсан шиг диаграмм, тоо байсангүй, харин энэ бол үргэлжилсэн үгийн зохиол байлаа. «Дэлхий-төвт онол» хэмээн Витториа эхний царан дээрх хуудсын гарчгийг уншин орчуулав. Бүсгүй бичвэрийг бүхэлд нь гүйлгэн уншжээ. «Галилео дэлхий-төвт загварыг магтсан байна шүү дээ. Эртний итали хэлээр боловч орчуулахдаа алдаа гаргаагүй гэдэгт минь итгээрэй дээ». «Энэ яах вэ дээ. Бид хоёр тоо хайж байгаа шүү. Цэвэр хэл!» гэж Ландон хариулав. Чимхүүрээрээ хавчаад дараагийнх нь хуудсыг эргүүллээ. Дахиад л бичиг. Ямар ч тоо, диаграмм байсангүй. Ландоны гар нь бээлий дотроо хөлөрч эхлэв. «Гариг эрхсийн хөдөлгөөн гэж байна шүү дээ» гэж Витториа гарчгийг нь гайхан уншина. Ландон барайж эхлэв. Өөр үед байсан бол Ландон тэр бичвэрийг уулга алдан унших л байлаа. NASA-ийн хүчирхэг дуран авай ашиглан гаргасан бүх зураг Галилеогийн төсөөлж байсантай яг адилхан байдаг билээ. Витториа ч бас толгой сэгсрэн: «Тоо алга аа. Ямар нэг ухрах хөдөлгөөн, зууван тойрог зам энэ тэр гээд л юм бичээд байна» гэв. Зууван. Галилео гариг эрхсийн хөдөлгөөний тойрог зам зууван байдаг гэж бичээд буруудаж шүүхэд дуудагдаж байсныг Ландон саналаа. Ватикан тойрог бол төгс хэлбэр гэж үздэг байсан агаад гариг эрхсийн хөдөлгөөний тойрог зам бас тойрог байх ёстой гэж үзэл бодлоо тулгаж байжээ. Харин Галилеогийн Иллюминати зууван ч бас төгс хэлбэр мөн гэж математикийн *twin foci* -гийн *duality*-г үндэслэн нотолж байв. Тэр зууванг эрхэмлэх явдал өнөөдөр ч хэвээр агаад өнөөгийн масоны уламжлалд ширээ, хөлийн дэвсэг нь зууван байдаг ажээ. «Дараагийнхыг нь» гэж Витториа шавдуулав. Ландон хуудсаа эргүүллээ. «Сарны үечлэл, хавирган сар» гэж Ландон орчуулаад: «Ямар ч тоо, диаграмм алга» гэлээ. Хуудсаа дахин эргүүлэв. Юу ч алга. Хэд хэдэн хуудас дараалан эргүүлсэн боловч юу ч алга. Витториа гайхахдаа: «Би энэ хүнийг чинь математикч байсан гэж бодсон юм сан. Гэтэл дандаа л бичвэр байна шүү дээ» гэв. Ландоны уушгин дахь агаар багасахын хэрээр найдвар нь ч бас нимгэрч байлаа. Горьдлого тасрахдаа туллаа. «Юу ч алга даа» гэж Витториа хэлээд: «Ямар ч тоо алга. Хэд хэдэн өдөр сар, хэдэн ширхэг стандарт тоо л байна, өөр юм үгүй шив дээ. Санаа авчхаар юм ч алга даа» гээд шүүрс алдав. Ландон сүүлийнх нь хуудсыг эргүүллээ. Тэнд бичвэр дуусаад гарын үсгээ тавьжээ. «Жижигхэн ном юм аа» гэж хэлэхдээ Витториа барайж орхисон байв. Ландон хөмсгөө зангидан толгой дохилоо. «Ромд энийг чинь Merda («чөтгөр гэж») гэдэг юм даа». Чөтгөр гэж гэж Ландон бувтнан давтлаа. Түүний дүрс

хоргын шилэн хананд ойж, өөрийг нь хараад байгаа юм шиг сүүмийнэ. Өнөө өглөө гэртээ сууж байхад цонхонд нь туссан дүрс нь бас тэгж байсныг саналаа. Хөгшин сүг! «Энд хаа нэгтээ байх л ёстой доо» гэж хэлэхдээ их л дориун тод хэлсэндээ өөрөө ч гайхлаа. «Энд хаа нэгтээ segno байх л учиртай. Би мэдээд байна». «Эсвэл чи DIII гэж буруу тайлсан юм болов уу?» Ландон бүсгүй рүү эргэж хараад хэсэг ширтэв. «За за., DIII гэдэг ч ойлгогдож л байна л даа. Эсвэл дохиогоо математикаар илэрхийлээгүй байх.» «Lingua pura гэж өөр юу байх юм бэ?» «Урлаг?» «Гэхдээ нэг ч зураг, диаграмм, өнгө будаг энд чинь алга л байна шүү дээ». «Lingua pura гэж ямар ч байсан итали хэл биш байна. Математик байвал уул нь логиктой л юм.» «Харин тийм ээ». Ландон ийм хурдан няцаагдчих юм гэж бодсонгүй. «Тоог бичгээр бичиж болно. Тэгшитгэлийг үгээр бичиж ч болно шүү дээ». «Тэгэхээр бүх хуудсыг нь унших хэрэгтэй гэсэн үг шүү дээ, цаг нэлээн авах нь дээ». «Гэтэл бидэнд цаг байдаггүй. Хоёулаа хуудсаа хувааж аваад уншъя» гэж Ландон гээд чимхүүрээрээ бүх хуудсыг эргүүлж тавилаа. «Би Италиар тоог бол ялгаад унших байлгүй дээ». Тэгээд яг л хөзөр хувааж байгаа юм шиг чимхүүрээрээ эхний хэсгийг нь бөөнд нь таслаад Витториагийн өмнө тавилаа. «Энэ хавьд л байгаа. Нээрэн шүү». Витториа өмнөө байгаа хуудсууд руу хараад, хуруугаа эхний хуудас руу нь явууллаа. «Чимхүүрээр!» гэж Ландон анхааруулаад, багажны тавиураас нэгийг авч Витториад бариулав. «Би бээлийтэй байгаа биз дээ. Би энийг яачхав л гэж дээ». «Зүгээр л наадахаа хэрэглэ.» Витториа чимхүүрийг нь атгаад: «Чи миний мэдэрч байгааг мэдэрч байна уу?» «Нервтэж байна уу гэж үү?» «Үгүй ээ. Амьсгал давхцах шинжтэй болж байна». Ландон мэдээж мэдэрч байлаа. Агаар санаснаас хамаагүй хурдан багасч байв. Яарах хэрэгтэй байлаа. Архивын журам, түүний хувьд, шинэ зүйл биш байсан ч гэсэн ердийн үед бол арай тавиу хугацаанд баримт бичигтэйгээ ажилладаг байв. Гэхдээ, тэр юу ч хэлэлгүй, доошоо тонгойж, өөртөө ногдсон хуудаснаас эхний хуудсыг нь гүйлгэж эхэллээ. *Өөрийгөө үзүүлэх цаг ирлээ шүү.*

Хэсэг 53

Ромын хаа нэгтээ нэг хүний бараан дүрс бүртэлзэн, газар доорх хонгилоор чулуун зам даган алхална. Эртний энэ нууц хонгилыг зөвхөн бадамлан асах бамбар л гэрэлтүүлэх агаад агаарыг улам ч халуун хуурай болгоно. Чанх урд, шаналан зүдэрсэн хүний дуу сонстох агаад хоосон хонгил даяар ёнгинон цуурайтах ажээ. Булан тойрч эргээд, айж бэмбийсэн, цээжин дээрээ дөрвөн өөр тамга даруулсан дөрвөн өвгөнийг яаж орхисон, яг тэр чигээрээ хэвтэж байхыг харлаа. «Quis etes-vous? (Та чинь хэн юм бэ? фра.)» хэмээн нэг нь Францаар асуув. «Бид дөрвөөр яах гээд байгаа юм бэ?» «Hilfe! (Туслаарай!)» гэж нэг нь Германаар орилов. «Биднийг тавьчих л даа». «Биднийг хэн гэдгийг та мэдэж байна уу?» гэж нэг нь англиар асуусан ч акцент нь испани байлаа. «Амаа татацгаа!» гэж тэр архиран хашхирахад хонгил чив чимээгүй болов. Дөрөв дэх нь итали хүн агаад чимээгүй сууж, хашхичин буй этгээд рүү бодлогошрон харж, албин чөтгөр гэгчтэй нүүр тулнаа ухаарч байлаа. Бурхан биднийг өршөөх болтугай хэмээн тэр залбирна. Алуурчин цагаа харснаа, эргэж хоригдон буй хөгшчүүл рүү ширтэн: «За, одоо, хэнээс нь эхлэх билээ?» гэлээ.

Хэсэг 54

10-р хоргон дотор Роберт Ландон уран бичгээр угалзруулан бичсэн итали тоог уншин ядна. *Mille . . . centi ... uno, duo, tre ... cinguant* (мянга, зуу, нэг, хоёр, гурав, арван тав., ита.) *Надад ямар ч хамаагүй тоо л хэрэгтэй байна, чөтгөр гэж.* Эхний хуудасныхаа эцэст нь хүрээд, чимхүүрээрээ дараагийнх нь хуудсыг эргүүлэв. Хуудсаа нээгээд, багажаа зэрэгцүүлэн тавихдаа чимхүүрээ чанга барьж чадахгүй алдчихав. Хэдэн минутын дараа, хуудсаа бүр гараараа эргүүлэн уншиж байлаа. Мэрийсэндээ, бас агаарын дутагдалд орсноосоо болоод үүнийгээ ч анзаарах сөхөөгүй байсан тэр гэнэт гэмт хэрэг хийчихсэн юм шиг санагдлаа. *Би ч архивчдын тамд л шарагдах нь шиг байна даа.* Ландоныг хуудсаа гараараа эргүүлэхийг анзаарсан Витториа: «Энэ цагийг, чөтгөр гэж» гэлээ. Тэгээд бас л чимхүүрээ тавиад, гараараа эргүүлж эхлэв. «Амжилттай юу?» Витториа толгойгоо сэгсрэв. «Цэвэр математикийн гэгчхмээр юм харагдахгүй л байна. Би гүйлгэж уншаад л байна, гэхдээ санаа авахаар юм алга даа». Ландонд орчуулж уншина гэдэг улам л хүнд болж байлаа. Итали хэл нь уулаасаа сайн биш, дээрээс нь угалзалж бичсэн эртний өгүүлбэрийг ойлгох бүр хэцүү байв. Витториа Ландоноос өмнө өмнөө байсан хэсгийг гүйлгэж уншиж дуусаад, сүүлийнхээ хуудсыг урам хугарсан байртай эргүүлээ. Тэгээд илүү идэвхийлэн уншиж эхлэв. Ландон сүүлийнхээ хуудсыг дуусгаад, амьсгаадан байж нэг хараал хэлчхээд, Витториа руу харав. Бүсгүй өмнөө байгаа нэг хуудсыг эргүүлж тойруулан үзнэ. «Юу вэ, наадах чинь?». Витториа дээшээ ч харсангүй: «Чиний хуудас дотор чинь ишлэл, зүүлт татсан юм байна уу?» «Анзаарсангүй. Яасан?» «Энэ хуудсанд нэг зүүлт байна. даан ч нугалаа таараад баларчихжээ». Ландон бүсгүйн хараад байгаа зүйлийг харах гэж оролдсон боловч баруун дээд буланд нь тавьсан хуудасны дугаараас өөр юм харсангүй. Хуудас 5 гэжээ. Энэ тооны ач холбогдлыг ухах гэж хэдэн хором болсон боловч утга нь нэг л бүрхэг байлаа. *Хуудас 5. Тав. Пифагор, пентаграмм, иллюминати.* Иллюминати нууц замаа заахдаа тавдугаар хуудсыг сонгосон гэж үү?. Суунаглан сүүмийх улаан гэрэл дунд, Ландоны сэтгэлд найдварын бяцхан оч гялсхийв. «Наад зүүлт чинь тэгээд тоо юм уу?» Витториа толгой сэгсрээд: «Үгүй. Бичиг. Ганц мөр юм. Их л жижиг бичсэн юм байна. Бараг л уншигдахгүй юм» гэв. Найдвар нь замхарчихав. «Тоо байх ёстой шүү дээ. *Lingua puga*». «Тийм л дээ. Гэхдээ, чи энийг сонссон нь дээр байх» гэж бүсгүй хэлэв. Түүний хоолойд бахдах өнгө тодрохыг Ландон анзаарлаа. «За тэгээд, юу гэж байна?» Витториа мэрийн байж тэр мөрийг уншив. «*Ариун тэнслийн зүг гэрлийн мөр зурайж*». Ландон ийм үг сонсоно гэж огт бодоогүй байлаа. «Уучлаарай. Юу гэнэ ээ?» Витториа дахин уншив. «*Ариун тэнслийн зүг гэрлийн мөр зурайж*». «Гэрлийн мөр өө?» Ландон ширээ түшээд хөшчихсөн байснаа, энэ үгийг сонсоод босоод ирэв. «Харин тэгээд л биччихсэн байна. Гэрлийн мөр». Энэ үг аянга цахилах мэт эгшин зуур Ландоны оюун бодлыг нь цэлмээж орхив. *Ариун тэнслийн зүг гэрлийн мөр зурайж.* Энэ үг яагаад ч юм бэ бүү мэд, түүнд Гэгээрлийн мөрийг заах дохио мэт санагдана. *Гэрлийн мөр. Ариун тэнсэл.* Муу шатахуун хийчихсэн мотор хүржигнэж байгаа юм шиг, тархи нь бодлоо цэгцлэх гэсэн шиг хөвчилнө. «Чи зөв орчуулсан биз?» Витториа мөрөө хавчаад: «Ер нь бол . . . техникийн хувьд би орчуулсангүй. Энэ мөрийг англи хэлээр биччихсэн байна» гээд нөгөө хачин хуудас руу харлаа. Ландон чих шуугиж, хоргон доторх дуу авианы замхарлаас болоод буруу сонсчхов уу гэж бодлоо. «Англи хэлээрээ?» Витториа хуудсыг өмнө нь түлхэж тавиад, Ландон хуудасны доор бичсэн иржийсэн жижиг мөрийг уншив. *Ариун тэнслийн зүг гэрлийн мөр зурайж.* Англи хэл. Англи хэл энэ итали ном дотор юу хийж яваа хэрэг вэ? Витториа мөрөө хавчив. Бүсгүй ч бас жигтэй гайхсан шинжтэй харагдана. «Англи хэлийг *lingua puga* гэсэн юм болов уу? Энэ чинь олон улсын хэл шүү дээ. СЭРН-д бид англиар л ярьдаг». «Гэхдээ энэ чинь 1600-аад он шүү дээ. Италид хэн ч англиар ярьдаггүй байсан юм. Тэр бүү

хэл . . . « гэж Ландон их дуугаар сөргөж хэлснээ зогтусан дуу нь намсаж: «Тэр бүү хэл шашны мяндагтнууд хүртэл ярьдаггүй байсан юм» гэлээ. Ландоны тархи нь хүчээ шавхан эргэлдэж, сурсан мэдсэн бүхнээ эргэцүүлэн хөвчилж, бүр ч хурдан ярьж эхлэв. «1600-аад оны үед Ватикан англи хэлийг хэрэглэдэггүй байсан юм. Тэд итали, латин, герман, испани, Францаар ярьдаг байсан, гэхдээ англиар огт ярьдаггүй байсан юм. Англи хэлийг бохирдсон, бүдүүлэг Шосэ, Шекспир мэтийн урт дурын этгээдүүд ярьдаг хэл гэж тооцдог байсан». Гэнэт Иллюминатигийн Шороо, Хий, Гал, Ус гэдэг дөрвөн алдарт тамгыг англи хэлээр бичсэн байдаг гэх домог санаанд нь харван орж ирмэгц, энэ бүхэн хоорондоо ямар нэг шүтэлцээтэй гэдэг нь тодорхой боллоо. «Чи тэгэхээр Ватиканыхан англи хэлийг оролдоогүй болохоор Галилео энэ хэлийг la lingua pura гэж тооцсон гэж хэлэх гээ юү?» «Тийм шүү. Эсвэл зүгээр л англиар биччихээр Ватиканыхан уншсан ч ойлгохгүй болохоор албаар тэгсэн байж болох юм». «Гэхдээ энэ чинь ямар нэг дохио, санаа авахаар юм хэлэхгүй байна шүү дээ» гэж Витториа арцав. «*Ариун тэнслийн зүг гэрлийн мөр зурайж. Энэ тэгээд юу гэж байгаа юм бэ?*» Энэ ч зөв шүү гэж Ландон бодлоо. Энэ мөр тэртээ тэргүй нэг их тус болсонгүй. Тэр дахин дахин энэ мөрийг амандаа бувтнан, ямар нэгэн юм хайна. Энэ ямар сонин үг вэ. Юу гэсэн утгатай юм бол? «Хоёулаа эндээс гарсан нь дээр юм шиг байна» гэж Витториа амьсгаадан хэлэв. Ландон түүнийг анзаарсангүй. *Ариун тэнслийн зүг гэрлийн мөр зурайж.* Энэ ямбын таван үет мөр байна хэмээн хэлээд, үеийг нь тоолов. «Өргөлттэй, өргөлтгүй хоёр хоёроороо таван хос». «Ямбын юу гэнэ ээ?» Тэр эгшинд, Ландоны оюун бодол Филипс Эксэтэрийн академийн бямба гарагийн Англи хэлний хичээлд сууж байсан руу эргэн оджээ. Сургуулийн бэйсболын од Петер Грээр Шекспирийн жүжиг дэх ямбын таван үетийн нэг мөрд байх ёстой хос үеийн тоог санах гэж түгдэрч зогсов. Биссель багш гэж сургуулийнхаа эрхлэгч байсан багш ширээнийх нь өмнө очиж, мэхийн ёслоод «Таван үе, Грээр минь. Бод л доо. Пента метер гэдэг чинь таван үе гэсэн үг шүү дээ. Пентагон гэдэг чинь таван өнцөгт гэсэн үг. Тав, тав, тав шүү дээ» гэж байсныг санав. Таван хос хэмээн Ландон бодно. Хос бүр тодорхойлолт ёсоор хоёр үетэй байх ёстой. Ямбын таван үет мөр гэдэг Иллюминатигийн ариун тоо 5, 2 хоёрын хослол байсныг огт анзааралгүй явсаар, өнөөдөр ухаарч байгаадаа итгэж чадахгүй байв. Чи ч агуу юм аа гэж Ландон өөртөө шивнээд, энэ бодлоо үргээж дахин төвлөрөх гэж оролдов. *Зүгээр л тохиолдол юм болов уу. Тав буюу пента гэдэг язгуур Пифагорт ч, пентагонд ч орж байна. Харин хоёр гэдэг бол бүх юм хоёр талтай байдгийн математик бэлгэдэл.* Хормын дараа, Ландон бас нэг нотолгоог эргэн санасан нь бүр гайхалтай байлаа. Ямбын таван үеийг энгийн болохоор нь «цэвэр үет» гэж нэрлэдэг билээ. Lingua pura. Тэгэхээр үүнийг л, Иллюминати цэвэр хэл гэж яриад байсан ажээ. *Ариун тэнслийн зүг гэрлийн мөр зурайж.* «Өө, хөөрхий!» гэж Витториа дуу алдав. Ландон түүнийг нөгөө хуудсаа тойруулан үзэж байхыг харлаа. *Арай энэ мөрөө амбиграмм болгож бичсэн юм биш биз дээ. Үгүй байлгүй дээ.* «Үгүй. Энэ мөр ч амбиграмм биш л дээ... гэхдээ...» гээд бүсгүй хуудсыг 90 хэм хажуулдуулж, тойруулан уншина. «Тэгээд юу гэж?» Витториа толгойгоо өргөн: «Ганц мөр ч биш юм байна аа» гэв. «Дахиад бас байгаа юм уу?» «Тал бүрт нь өөр өөр мөр байна. Дээр, доор, баруун, зүүн талд нь. Энэ чинь шүлэг юм шиг байна» гэв. «Дөрвөн мөрт үү?» гэж Ландон гайхан дуу алдлаа. *Галилео шүлэгч байсан гэж үү?* «Алив, хараадахья даа». Витториа хуудсаа өгсөнгүй, тал бүрээр нь хажуулдуулан, уншсаар байв. «Би мөрийг нь уншиж чадахгүй байна. Яг ирмэг дээр нь биччихжээ» гэв. Тэгснээ, толгой нь сүүлийнх нь мөр дээр тогтоод: «Хөөх, юу гээч! Галилей энийг бичээгүй юм байна» гэв. «Юу гэнэ ээ?» «Жон Милтон гээд гарын үсгээ зурчихжээ». «Жон Минтон уу?» Энэ хүн Алдагдсан диваажин-г бичсэн Галилейтэй нэгэн үед амьдарч асан английн нэрт шүлэгч агаад зарим онолчид

түүнийг Иллюминатигийн томоохон гишүүдийн нэг байсан хэмээн үздэг билээ. Минтоныг Галилейн Иллюминатитай холбоотой байсан гэдэгт домогт Ландон итгэдэггүй байлаа. Минтон 1638 онд «гэгээрсэн хүмүүстэй уулзах гэж» Ромд очсон тухай дэлгэрэнгүй баримт байдаг төдийгүй, бүр Галилейтай гэрийн хорионд байхад нь уулзаж байсан гэдэг агаад Сэргэн мандлын үеийн алдарт зураач Аннибал Гаттигийн зурсан Галилей Минтон хоёр гэдэг алдарт зураг одоо ч Флоренцын IMMS музейд байдаг билээ. «Минтон Галилейг таньдаг байжээ, тийм үү?» гэж Витториа асуугаад нөгөө хуудсаа Ландон руу түлхэв. «Тэгээд, түүнд тус болж, ийм шүлэг бичиж өгсөн юм болов уу?» Ландон хуудсыг ширээн дээр цэвэрхэн дэлгэхдээ, шүдээ зуусан байв. Тэгээд, цэвэрхэн дэлгэсэн хуудасныхаа дээд талын ирмэг дагасан мөрийг уншлаа. Дараа нь, 90 хэмээр хажуулдуулж, баруун талынхыг нь уншив. Дахин эргүүлж хамгийн доод мөрийг үзлээ. Эцэст нь зүүн ирмэг дагуулан уншлаа. Ингээд бүтэн тойруулан харж дууслаа. Нийт дөрвөн мөр байна. Анх Витториагийн харсан мөр бол дөрвөн мөртийн гурав дахь мөр нь ажээ. Ландон дахин цагийн зүүний дагуу дээд, баруун, доод, зүүн ирмэгийг нь их л хянуур уншлаа. Тэгээд уртаар санаа алдав. Ямар эргэлзээ алга. «Ветра авхай, та олчихжээ!» Бүсгүй зөөлөн инээмсэглээд: «Сайн л биз. Тэгээд одоо хоёулаа эндээс гарвал яасан юм бэ?» гэлээ. «Би үүнийг хуулж бичээдэхье. Харандаа цаас байна уу?» Витториа толгой сэгсрэн: «Больж үз дээ, профессор минь. Юм бичиж байх цаг алга. Микки чинь дохио өгөөд байна.» Бүсгүй нөгөө хуудсыг авангуутаа хаалга руу алхав. Ландон ширээ түшсэн байснаа босоод: «Хүүе, чи авч гарч болохгүй шүү дээ. Энэ чинь ...». Витториа гараад явчхав.

Хэсэг 55

Ландон, Витториа хоёр Нууц архивын цэцэрлэгт амьсгаадан байна. Ландоны уушги цэнгэг агаарыг, яг л донтсон нэгэн хар тамхи сорж байгаа юм шиг татаж байлаа. Бүрэлзээд байсан нүд нь одоо л зүгээр боллоо. Гэхдээ, гэм хийсэн сэтгэл нь тэгсэнгүй. Тэр дөнгөж сая дэлхий дээрх хамгийн хатуу нууцалсан архиваас асар үнэтэй баримт бичиг хулгайлчхаад зогсож байлаа. Гэтэл хөөрхий камерлинго би танд итгэлээ өглөө шүү гэж анхааруулж байсан билээ. Витториа: «Түргэлээрэй» гэнгүүтээ гартаа нөгөө хуудсаа атгасан чигээрээ Белведерэ гудмаар Оливеттигийн байрны зүг гүйхээрээ алхлав. «Хэрэв наадахад чинь ус хүрэх л юм бол» «Тайвшир л даа. Хоёулаа энийг тайлж уншсаныхаа дараа тэр бичиг рүү нь буцаагаад хийчихье». Ландон хойноос нь гүйцэх санаатай матирна. Гэмт хэрэгтэн болчихсон юм шиг санагдахаас гадна, энэ бичиг юу нотлоод байгааг дахин дахин шүүн бодно. *Жон Минтон иллюминатус байжээ. Тэгээд Галилейд шүлэг бичиж өгч, тав дахь хуудсанд нь хэвлүүлсэн байна. Ватиканаас далдуур.* Цэцэрлэг өнгөрмөгц, Витториа нөгөө хуудсаа сарвайж: «Чи энийг тайлж чадах уу? Эсвэл түүнд зориулах тархиныхаа эсийг өөр юманд зарах уу?» Ландон хуудсыг болгоомжтой ёо авлаа. Тэгээд, бүдүүн нэхээст пиджакныхаа энгэрийнх нь хармаанд шургуулж нарны гэрэл, агаарын чийгшлээс хамгаалав. «Би аль хэдийн тайлчихсан». Витториа «Юу гэнэ ээ?» хэмээн зогтусан харав. Ландон алхсаар явна. Витториа түүнийг гүйцэх гэж гүйсхийгээд: «Чи ганц л удаа уншсан шүү дээ. Энийг тайлж унших хэцүү байх гэж бодсон юм сан». Түүний зөв байлаа, гэхдээ л Ландон энд байгаа segno-г тайлаад уншчихсан байв. Ямбын таван үет бадаг шүлэг, эрдмийн онгон тахил хоёр нийлэхээрээ утга санаагаа гайхалтай тод илэрхийлсэн байлаа. Гэхдээ, утгыг нь ийм амархан тайлчихсандаа итгэж чадахгүй, болгоомжилж байв. Ландон өөрөө пуритан ёсоор хүмүүжсэн нэгэн билээ. Бага байхад аав нь *хэрвээ чи ямар нэг юмыг огт зоволгүй амархан хийчихвэл буруу хийсэн л байж таарна* гэж сургадаг байжээ. Тийм биш байгаасай л гэж залбирч явав. «Би энийг тайлаад уншчихсан» гэж

тэр явуут дундаа хэлээд: «Эхний аллага хаана болохыг би мэдчих шиг боллоо. Оливеттийг очиж анхааруулах хэрэгтэй байна» гэлээ. Виттория ойртож очоод: «Чи яаж ийм амархан мэдчихэв ээ? Би дахиад нэг хараадахья даа». Тэр турьхан гараа, боксчин шиг уран шийдэмгий оруулж ирээд, энгэрийн хармаанаас нь нөгөө хуудсыг авчхав. «Аяар гэм» гэж Ландон хэлээд: «Урчихвал яах ...» Виттория түүний хэлэхийг тоосонгүй. Бүсгүй шингэх нарны улаан туяанд гартаа барьсан нөгөө хуудасныхаа ирмэгийг хянуур гэгч уншин, дэргэд нь явна. Ландон очоод, тэр хуудсаа шүүрч авах гэсэн боловч Виттория шүлгийг гайхалтай тод, зөв хэмнэлээр чанга дуудан уншмагц, ховстуулсан мэт болоод, больж орхив. Тэр эгшинд, Ландон өөрийгөө Галилейн үед очсон мэт төсөөлөөд, . . . Ром даяар хэрсэн дөрвөн нууц тэмдгийн тухай . . . эрдмийн дөрвөн тахилын байрыг заасан газрын зураг, тэмдэг гэдгийг ухааран . . . энэ шүлгийг анх удаа сонсож байгаа эрдэмтэн хэмээн төсөөлөв. Витториагийн уруулаас ундрах шүлэг яг л аялгуу төгс дуу шиг сонсогдоно. *Чөтгөрийн цооногт Сантигийн шороон булнаас эхлээд Ромыг хэрэн шидэт махбодиуд хүрээлжээ Ариун тэнслийн зүг гэрлийн мөр зурайж Ангель бүр ариун эрлийг чинь чиглүүлнэ* Виттория энэ шүлгийг хоёронтоо уншаад, эртний шүлгэнд уярах мэт чимээгүй болчхов. *Сантигийн шороон були* хэмээн Ландон амандаа бувгнана. Мөр Сантигийн булнаас эхэлнэ гэдэг нь тов тодорхой байлаа. Тэндээс, Ром даяар элдэв тэмдэг тархан байрласан бий. *Чөтгөрийн цооногт Сантигийн шороон булнаас эхлээд Ромыг хэрэн шидэт махбодиуд хүрээлжээ Шидэт махбод.* Бас л тодорхой. *Шороо, Хий, Гал, Ус.* Иллюминатигийн дөрвөн махбодыг шашны баримал маягтай байрлуулсан байгаа. Виттория: «Эхний тэмдэг нь Сантигийн булш юм шиг байх юм» гэлээ. Ландон: «Тийм хэцүү биш юм байна гэж хэлээ биз дээ» гээд инээвхийлэв. «Тэр Санти чинь тэгээд хэн юм бэ? Булш нь хаана байгаа юм бэ?» гэж их л хачирхан асуулаа. Ландон бараг л хөхрөх шахав. Сэргэн мандлын үеийн тэр алдарт уран бүтээлчийн овгийг хүмүүс ерөөсөө мэддэггүйг тэр дандаа л гайхдаг байлаа. Түүний жинхэнэ нэр буюу хүүхэд ахуйд нь өхөөрддөг байсан нэрээрээ дэлхий нийтэд алдаршсан ажээ. Хорин тавхан насандаа, Ромын Пап II Юлиусийн захиалгаар бүтээл туурвиж, гучин наймхан насандаа өөд болсон боловч түүхэнд байгаагүй гайхалтай баримал, уран бүтээлийг өв болгон үлдээсэн билээ. Санти урлагийн ертөнцийн од - Наполеон, Галилей, Есүс нар шиг зөвхөн жинхэнэ нэрээрээ түүхэнд үлдсэн гайхалтай хүмүүсийн нэг юм. Мэдээж, Харвардын оюутны дотуур байраас сонсдог жинхэнэ нэрээрээ өөрийгөө домог болгох гэж оролддог Стинг, Мадонна, Жьювел, бүр Принц гэж алдаршиж байгаад нэрээ гэсэн тэмдэг болгон өөрчилж: «Манин Анхыг хэрсэн Тау үсэг» хочтой хуурмаг ододтой зүйрлэшгүй нэгэн байлаа. «Санти гэдэг чинь Сэргэн мандлын үеийн алдарт зураач Рафаэлийн нэр овог байхгүй юу» гэж Ландон хэлэв. Виттория гайхан дуу алдав. «Рафаэль уу? Нөгөө Рафаэль үү?» «Тэрнээс өөр хэн байх вэ дээ». Ландон Оливеттигийн байр руу улам хурдлан зүтгэлээ. «Тэгэхээр Рафаэлийн булнаас мөр эхлэх нь ээ?» «Энэ чинь тун нарийн учиртай эд шүү» гэж Ландон явуут дундаа хэллээ. «Иллюминати алдартай зураач, барималч болгоныг дандаа гэгээрсэн анд хэмээн тооцдог байсан юм. Тиймээс, Рафаэлийн булшийг хүндэтгэн үзсэн байх тал бий». Рафаэлийг бусад олон алдартай уран бүтээлчдийн адил бурхангүй үзэлтэн гэж сэжиглэж байсан тухай Ландон бас дуулж мэдсэн байлаа. Виттория нөгөө хуудсаа Ландоны хармаа руу болгоомжтой ёо хийгээд: «Тэгээд булш бунхан нь хаана байгаа юм бэ?» гэв. Ландон гүнзгий амьсгаа аваад: «Итгэнэ үү, байна уу өөр мэд. Рафаэлийг Пантеон дотор оршуулсан юм» гэв. Виттория үл итгэх аястай: «Пантеонд уу?» гэж асуув. «Тэр Рафаэлийг Пантеонд л оршуулсан юм даа» гэж Ландон цохон тэмдэглэв. Гэхдээ, Ландон Пантеонд анхны тэмдгийг тавьсан гэж эхэндээ бодоогүй билээ. Эрдмийн анхны тахил сүм рүү хөлхөх хүний хөлөөс зайдуу, бөглүүдүү газар байх болов уу

гэж анх тааж байлаа. Бүр 1600-аад онд ч том гэгч цоорхой өрхтэй Пантеон Ромын хамгийн алдартай газрын нэг байжээ. «Ингэхэд, Пантеон чинь ер нь сүм мөн юм уу?» гэж Витториа лавлав. «Ромд байгаа хамгийн эртний католик сүм юм шүү дээ». Витториа толгойгоо сэгсрээд: «Эхний кардиналыг Пантеон дотор цаазална гэж чи нээрэн бодоод байна уу? Тэр чинь Ром хотын хамгийн олон жуулчин цугладаг газрын нэг шүү дээ». Ландон мөрөө хавчив. «Иллюминатигийнхан дэлхий нийтэд үзүүлнэ гээ биз дээ? Кардиналыг Пантеон дотор цааш нь харуулна гэдэг олон хүний нүдийг хужирлана шүү». «Тэгээд яаж тэд кардиналыг Пантеон дотор хөнөөчхөөд хүнд мэдэгдэлгүй сэм одох вэ дээ. Боломжгүй шүү дээ». «Ватикан хийдээс дөрвөн кардиналыг хулгайлах боломжтой байсан гэж үү? Дээрээс нь энэ шүлэг тодорхой хэлсэн байна шүү дээ». «Чи бас Рафаэлийг Пантеон дотор оршуулсан гэдэгт итгэлтэй байгаа, тийм үү?» «Би тэр булшийг нь олон удаа харсан шүү». Витториа түгшсэн байртай толгой дохино. «Цаг хэд болж байна?» Ландон цагаа хараад: «Долоо гуч» гэв. «Пантеон эндээс хол билүү?» «Ганц бээр л байх. Цаг бас байна аа.» «Шүлэг дээр *Сантигийн шороон були* гэсэн байгаа. Энэ ямар учиртай гэж бодно вэ?»

Ландон Харуулын цэцэрлэгээр хөндлөн гулд алхах зуур «Шороон гэж үү? Пантеоноос илүү шороон гэмээр газар Ромд өөр байхгүй л болов уу. Уул нь энэ сүм чинь Ромын олон бурхдад зориулсан, тэр дундаа Хөрст дэлхий эхэд зориулсан сүм байсан юм. Тийм болохоор л уул нь, Пантеон гэж нэрлэсэн юм шүү дээ». Архитектурыг сонирхдог байсны хувьд, Ландон Пантеоны уужим гол танхимын хэмжээ нь Гэяа буюу Хөрст дэлхий эхэд зориулагдсан гэдгийг бахдан уншиж байсан удаатай. Дотор нь том гэгч хөрст бөмбөрцөг хананаасаа миллиметрээс бага зайтай багтахаар тооцож хийсэн гэдэг. «За, за» гэж Витториа одоо арай илүү итгэлтэй болж байгаа бололтой өгүүлэв. «*Чөтгөрийн цооног* -ийн тухайд юу гэх вэ? *Чөтгөрийн цооногт Сантигийн шороон булинаас эхлээд* гээ биз дээ?» Ландон энэ тухайд тийм ч бат нот байж чадахгүй байв. «Чөтгөрийн цооног гэдэг нь өрх байх аа» хэмээн логик таамаг дэвшүүлэхээс өөр арга олдсонгүй. «Пантеоны дээвэрт байдаг нөгөө алдартай том дугуй өрх» гэлээ. «Энэ чинь сүм шүү дээ» гэж Витториа бөөрөнд нь наалдан хурдан хурдан алхлах зуураа хэлээд: «Яагаад сүмд чөтгөрийн цооног байх ёстой юм бэ?» гэж асуув. Яг энэ асуултад Ландон өөрөө гайхасхийгээд байлаа. Тэр өрхийг «чөтгөрийн цооног» гэж нэрлэж байхыг хэзээ ч сонсож байсангүй, гэхдээ тэртээ зургадугаар зууны үед Пантеоныг шүүмжилж байсан нэгэн шүүмж санамсартай, санамсаргүй нийцээд байсан нь гайхмаар байв. Эрхэмсэг Бэдэ нэг удаа, IV Бонифас Пантеоныг адисалсны дараа, тэнд байсан чөтгөрүүд зугтан зайлахдаа, дээврийнх нь тэр нүхийг өрөмдсөн гэж тэмдэглэж байжээ. «Гэхдээ л, Иллюминати Рафаэлийг хүндэлдэг байсан юм бол яагаад Санти гэдэг нэрээр нь тэмдэглэсэн юм бол доо» хэмээн Витториа харуулын байрны өмнөх цэцэрлэг рүү эргэхдээ асуулаа. «Чи олон юм асуух юм аа». «Аав минь бас ингэж хэлдэг байж билээ». «Хоёр шалтгаан байж магадгүй. Нэгд, Рафаэль гэдэг үг хэтэрхий олон үетэй байна. Тэгэхээр ямбын таван үет мөрийг эвдчих гээд байсан байх». «Нэг л үнэмшилтэй болсонгүй». Ландон үүнийг зөвшөөрч байв. «За яах вэ. Тэгвэл «Санти» гэдэг нэрийг хэрэглэж тэмдгээ далдлах гэж оролдсон байх талтай. Зөвхөн сайн мэддэг гэгээрсэн хүн л энэ бол Рафаэль гэж мэдэх ёстой юм». Витториад энэ шалтгаан бас л үнэмшилтэй санагдаагүй бололтой. «Рафаэлийг амьд байх тэр үед овгийг нь нийтээрээ мэддэг байсан байх аа». «Гайхалтай нь үгүй шүү. Ганц нэрээрээ тодорно гэдэг алдар хүндийн хэрэг байсан юм. Рафаэль өнөөдрийн поп одод шиг овгоо хэрэглэдэггүй байсан. Мадонна шиг гэх үү дээ, Сикконэ гэдэг овгоо огт хэрэглэдэггүй шүү дээ». Витториа Ландон руу хараад гайхан дуу алдаж: «Чи Мадоннагийн овгийг мэддэг юм уу?» гэв. Ландон ийм жишээ татсандаа санаа зовов. Гэхдээ л 10 000 гаруй өсвөр насныхантай ажиллаж байгаа түүний хувьд, тэднээс халдаад, санааны мухарт хоцорсон хог шиг хэрэггүй мэдээллийн нэг байжээ. Витториа тэр хоёр Швейцар жардын албаны зүг явсаар, сүүлийнхээ хаалганд хүрлээ. «Para!» хэмээн ар нуруунаас хашхирав. Эргээд харвал, бууны ам тэднийг чиглэсэн байх ажээ. «Attento! (Болгоомжтой гэм. Ита.)» гэж Витториа хашхираад арагш үсрэн «Болгоомжтой бай л даа, наад...» Харуулын цэрэг «Non sportarti! (Бүү эсэргүүц. Ита.)» гэж зандраад, буугаараа зангав. Цэцэрлэгийн цаанаас: «Soldato! (Хөөе, цэрэг ээ. Ита.)» гэж нэг хүн хашхирлаа. Удалгүй Оливетти харуулын цэгээс гарч ирснээ: «Наадуулаа оруул!» гэлээ. Харуулын нүд хилэгнэн эргэлдээд: «Ma, signore, e ipa donna (эрхмээ, энэ авхай...)» «Оруул!» гэж Оливетти харуул руу дахин хашхичив. «Signore, non posso - (эрхэм ээ, болохгүй шүү дээ)» «Оруул гэм, наадуул аа! Чамд тушаал өгч байна. Рошер занги хоёр минутын дараа та нарт үүрэг тавина. Одоо бид хайгуул хийх гэж байгаа». Нүд нь хилэнтэй еэ эргэлдсэн харуул тушаал даган, харуулын төв байр руу гүйж одов. Оливетти Ландон руу шийдэмгий хүнд алхаагаар дөхөн ирээд: «Манай хамгийн нууц архивд юу хийсэн тухайгаа тайлбарлахыг би танаас шаардаж байна» гэлээ. Ландон: «Сайн мэдээтэй яваа шүү» гэв. Оливетти нүдээ жартайлган: «Сайн

Хэсэг 56

Огт дугаар, тэмдэг байхгүй дөрвөн Альфа Ромео 155 Т-Спаркс хэмээх машин Коронари гудамж өгсөн, яг л хөөрөх талбай дээр гүйж байгаа тийрэлтэт онгоц шиг шунгинан одов. Черчи-Пардини загварын хагас автомат, ухаан алдуулах хийтэй бортого, алс тусгалтай урт буу агсаж энгийн хувцас өмссөн Швейцар жардын арван хоёр залуу энэ машиныг хөлөглөн явлаа. Гурван мэргэн бууч лазерын овоо хараатай буу мөрлөсөн байв. Урд талын машины урд суудалд суусан Оливетти арагшаа Ландон, Ветра хоёр руу эргэж харжээ. Нүд нь хилэнтэй еэ дүрлэглэнэ. «Та хоёр намайг үнэмшүүлж чадсан, тэгээд л бид ийм юм хийж явна шүү!» гэлээ. Ландон жижиг машинд байдгаараа агшчихсан сууж байв. «Таны байдлыг ч би ойлгож байна л даа...» «Үгүй, хэн ч ойлгохгүй» гэж Оливетти үгийг нь таслав. Тэр дуугаа өндөрсгөөгүй боловч өмнөхөөсөө гурав дахин хурдан ярьж байлаа. «Би яг цуурганы өмнө хамгийн шилдэг арван хоёр залуугаа аваад, Ватикан хийдээ орхиод явж байна. Насандаа огт харж байгаагүй нэг америк нөхөр хүрч ирээд, дөрвөн зуун жилийн өмнө бичсэн дөрвөн мөрт шүлгийн утгыг үнэн худал ярьж тайлж өгсөн болохоор нь би Пантеоны өмнө гозойтлоо зогсох гэж хамгийн чухал үүргээ орхиод явж байна шүү дээ. Тэгээд болоогүй антиматерийг хайх даалгаврыг хоёрдугаар зэргийн тушаалтанд даалгачхаад шүү». Ландонд нөгөө тавдугаар хуудсаа хармаанаасаа аваад, Оливеттигийн нүүрэн дээр барьж байгаад уншуулмаар санагдлаа. «Бидний олсон мэдээ Рафаэлийн булшийг зааж байгаа, харин Рафаэлийн булш Пантеонд байдаг шүү дээ». Жолоо барьж байсан офицер залуу толгой дохингоо: «Тэр ч тийм шүү, захирагч аа! Авгай бид хоёр нэг удаа ...» «Дуугүй л жолоогоо барь!» гэж Оливетти тасхийтэл зандрав. Тэгээд Ландон руу хандан эргээд: «Ямар амьтан тийм олон хүнтэй газар хүн хөнөөчхөөд мэдэгдэлгүй гарч чадах вэ дээ» гэлээ. «Би яаж мэдэх вэ дээ» гэж Ландон хариулаад: «Гэхдээ Иллюминати гайхалтай ажиллаж байна шүү дээ. Тэд СЭРН-д ч, Ватиканд ч нэвтэрч орхилоо. Бид эхний аллага хаана болохыг ёстой азтай тохиолоор л мэдэж авлаа. Танд тэр алуурчдыг барих тохиол Пантеонд л гарч магадгүй байна шүү дээ». «Та дахиад л өмнө ярьснаа үгүйсгээд байна» гэж Оливетти хэлэв. «Та чинь нэг тийм зам маягийн юм байдаг энэ тэр гээгүй билүү? Тэмдэг дохионууд. Хэрэв тэр Пантеон чинь зөв газар мөн л юм бол бусад тэмдгийг нь дагаад мөшгөж болно. Тэгэхээр тэднийг барих дөрвөн тохиол наад зах нь байгаа юм биш үү?» «Тэгж л найдахаас» гэж Ландон хэлээд: «Гэхдээ хэд хэдэн зууны өмнө бол ... болох л байх байсан байх». Пантеон эхлэх цаг байсан явдалд Ландонд сайхан, бас аягүй санагдаж байлаа. Түүх заримдаа өөрийг нь мөшгөн судалсан хүнээр төөрч самууртал нь буруу замаар дагуулж тоглон, ааш гаргадаг билээ. Гэгээрлийн мөр өнөөг хүртэл яг хэвээрээ, бүх хөшөө тэмдэг нь тэр чигээрээ оршин байгаа гэж найдах бас л хэцүү, гэхдээ л Ландоны дотор сэтгэлд нэг зүйл Гэгээрлийн мөрөөр мухарт нь хүртэл явж, Иллюминатигийн үүр ноохойд очих болно хэмээн шивнээд байлаа. Гэвч тэгж найдах бэрх. «Ватикан 1600-аад оны сүүлээр Пантеонд хуучин байсан бүх хөшөө баримлыг гаргаад устгачихсан юм». Витториагийн нүд нь томрон: «Яагаад?» гэж гайхан асуув. «Тэр хөшөөнүүд нь эртний Олимпын бурхад байсан юм. Тиймээс харамсалтай нь, түүнтэй хамт анхны тэмдгүүд бас устсан байж магадгүй, хэрэв тэгвэл...» «Тэр анхны тэмдгээс өөр нэмэлт тэмдэг энэ тэндээс олж болохгүй юм болов уу?» гэж Витториа асуулаа. Ландон толгой сэгсрэн: «Пантеон л ганц

боломж. Тэнд л чадахгүй бол замын мөрийг алдана» гэлээ. Оливетти тэр хоёр руу хэсэг харснаа эргээд урагшаа харав. Тэгснээ: «Зогс!» гэж жолооч руу архиран хашхичив. Машин замын хажуу руу огцом шахаж, тоормослон зогсов. Арын гурван машин ч ар араасаа гулган ирж тоормослов. Швейцар жардын машинууд цуваа үүсгэн гудамж дагуу зогсчихлоо. «Та чинь яаж байна аа?» хэмээн Витториа асуув. «Ажлаа хийж байна» гэж Оливетти эргэж харж суунгаа хүйтэн дуугаар хариуллаа. «Ландон гуай, байдлыг замдаа тайлбарлаж өгье гэхээр чинь би Пантеонд очихдоо, манай хүмүүс юу хийх ёстой тухай тов тодорхой ойлголттой байсан юм байх гэж ойлгосон юм. Гэтэл тийм биш байжээ. Би энд сууж байх зуур гүйцэтгэх ёстой хамгийн чухал үүргээ хойш тавьчихсан байгаа, дээрээс таны яриад байгаа тэр ариун тахил, эртний шүлэг хоёрын тухай онол чинь утга учир багатай байгааг олж мэдсэнээс хойш, дахиад ингээд яваад байх шалтгаан олж харахгүй байна. Тиймээс би энэ даалгаврыг орхиж байна» гэлээ. Тэгээд, холбоогоо сугалж аваад, харилцах товчлуурыг дарав. Витториа урагш тэмүүлэн түүний гарыг нь шүүрч атгаад: «Та ингэж болохгүй» гэлээ. Оливетти гараа доош буулгаж, Витториа руу улангассан догшин нүдээр цоргитол хараад: «Та ер нь Пантеон руу орж үзсэн үү?» «Үгүй л дээ, гэхдээ ...» «Тэгвэл би танд ярьж өгье. Пантеон гэдэг бол ганц ханхай өрөө. Чулуу, цементээр цутгасан юм. Ганцхан үүдтэй. Ямар ч цонхгүй. Ганцхан давчуухан үүдтэй. Тэгээд тэр үүдэн дээр нь дөрвөн зэвсэгт цагдаа урлагийн бүтээл хулгайлагч, антихрист террорист, сэм гартай жуулчдаас тэр сүмийг хамгаалан хорин дөрвөн цагаар зогсч байдаг юм». «Тэгээд юу гэж?» гэж Витториа хүйтэн царай гарган асуув. «Тэгээд үү?» гэж Оливетти суудлаа чахруулан түнтэгнэснээ: «Юу гэвэл та хоёрын ярьсан юм тохиолдоно гэдэг огт бололцоогүй. Та нар кардиналыг Пантеон дотор егүүтгэх ганц ч атугай боломжийн тавил хэлээд өгөхгүй юу? Юун түрүүнд, эхлээд золионьхоо хүнийг цагдаагийнханд мэдэгдэлгүй хэрхэн авч орох вэ? Тэгээд яаж дотор нь хөнөөчхөөд эргэж гарах вэ?» гэлээ. Оливетти суудлынхаа түшлэг дээгүүр давах шахан түнтэгнэхэд, амьсгал нь Ландоны нүүрэн дээр ирж, кофе үнэртэж байв. «Ландон гуай минь, ядаж ганц боломж хэлээд өгөөч». Жижигхэн машин Ландоныг тойроод хумигдчих шиг болов. *Би яаж мэдэх юм бэ? Би алуурчин биш. Би яаж хүн хөнөөхийг нь мэдэхгүй байна. Би зөвхөн ...* «Ганц боломж гэв үү?» гэж Витториа хахир дуугаар асуугаад: «Ингэвэл ямар вэ? Алуурчин нисдэг тэргээр ирж, хүмүүс рүү хашхираад, тамгалж тамласан кардиналыг хаяна. Хөөрхий кардинал доошоо нисч, боржин чулуун шал мөргөж үхнэ дээ.» Машинд байсан бүх хүн Витториа руу мэлэрч орхив. Ландон юу хэлэхээ мэдэхгүй байлаа. *Авхай минь, та ч төсөөлөн сэтгэхдээ тун ч адтай юм, тэгээд хурдан ч юм.* Оливеттигийн дуу нь намсаад: «Боломжийн юм, зөвшөөрч байна. Гэхдээ юу л бол?» «Эсвэл алуурчин кардиналыг мансууруулчихна» гэж Витториа үргэлжлүүлэн: «Тэгээд хөлгүй хүний тэргэн дээр суулгаад, хөгшин настай жуулчин шиг түрээд орчихно. Тэнд нь сэмхэн хоолойг нь хэрччихээд, гараад явчихна даа» гэв. Энэ үг Оливеттийг цочоох шиг болов. *Муугүй шүү* гэж Ландон бодлоо. «Эсвэл алуурчин ...» гээд л Витториа амьсгаа аван үргэлжлүүлэх гэтэл Оливетти тасалж орхив. «Сонслоо. Хангалттай» гэж Оливетти хэлээд, гүнзгий гэгч амьсгаа аваад, тургиж байгаа юм шиг дуутай яа гаргалаа. Гэтэл цонхны цаанаас нэг юм сүүтгэнэхэд, бүгд цочин харлаа. Арын машинаас нэг цэрэг хүрээд иржээ. Оливетти цонхоо буулгав. «Зүгээр үү, захирагч аа?» гэж нөгөө залуу хэллээ. Тэр жирийн нэг цамц өмсч, олон функцтэй цэрэг цагаа гарган, ханцуйгаа шамласан байлаа. «Долоо дөч болж байна, захирагч аа. Бид яаралтай очиж, байрлалаа эзлэх хэрэгтэй байх аа». Оливетти толгойгоо дохисхийгээд, хэсэг юм хэлэлгүй суулаа. Их л бодлогоширч, хүүхэд шиг, машины урд тавцан дээрх тоосыг хуруугаараа оролдон, нааш цааш зурна. Хажуугийнхаа толинд Ландоныг ажиглах бөгөөд Ландонд харин өөрийг нь хэмжиж, жинлэж орхих шиг

санагдана. Эцэст нь Оливетти харуул залуу руугаа эргэж харлаа. Их л дурамжхан ярих сонсогдоно. «Өөр өөр замаар дөхөж очъё. Ротунда талбай, Орфани гудамж, Гэгээн Игначо талбай, Гэгээн Истачо талбайн чиглэлээр тус тус орно. Хоёр гудамжнаас дотогшоо ойртохгүй шүү. Очиж байрлалаа эзлээд, миний дохиог хүлээ. Гурван минутын дотор. Гүйцэтгэ». «Гүйцэтгэе, эрхэм ээ» гэж цэрэг хэлээд, машин руугаа эргэв. Ландон Витториа руу харж талархан толгой дохьсонд, бүсгүй мөн өөдөөс нь инээмсэглэн дохилоо. Энэ мөчид Ландон гайхамшигтай нандин холбоо тэр хоёрын дунд үүсэхийг гэнэт мэдэрлээ. Оливетти суудлаа чахруулан эргэж хараад: «Ландон гуай, бидний нүүрэн дээр л битгий дэлбэрээсэй билээ, тийм ээ?» гэлээ. Ландон инээмсэглэсэн болоод т *эгэхгүй байлгүй дээ* гэлээ.

Хэсэг 57

СЭРН-ийн захирал Максимлиан Колэр цусанд нь юүлсэн хромолин, лекотриний хүчинд хоолой, уушгины судас нь тэлэхийг мэдрэн, хүйтэн нүдээ нээлээ. Тэр дахин хэвийн амьсгалж байлаа. СЭРН дэх эмнэлгийн орон дээр хэвтэж байх агаад тэргэнцэр нь орны хажууд байна. Түүнд эмнэлгийн цаасан даавуугаар хийсэн халаад өмсгөжээ. Хувцсыг нь эвхээд орны хажууд байх сандал дээр тавьсан байв. Хаалганы гадна сувилагч нар шивнэлдэн юм ярина. Тэдний яриаг сонсон, нэлээн удаан хэвтэв. Тэгээд, аль болох чимээ гаргалгүй зүтгэсээр, хувцсаа татаж авлаа. Үхэжсэн хөлтэйгөө түнтэгнэн байж, арай гэж хувцсаа өмсөв. Дараа нь, тэргэнцэр рүүгээ хүнд биеэ зөөж тавилаа. Чимээ гаргалгүй ханиах гэж бүгшсээр хаалга руу дөхлөө. Тэр мотороо асаалгүй, гараараа дугуйгаа эргүүлж явав. Хаалганд тулж ирээд, түлхэн онгойлготол тэнд хэн ч байсангүй. Максимлиан Колэр ийнхүү чимээгүйхэн эмнэлгээс оргон одлоо.

Хэсэг 58

Долоо дөчин зургаа, гучин . . . тэмдэглэ». Холбоогоор ярихдаа хүртэл Оливеттигийн хоолой шивнэх төдий сонстох ажээ. Пантеоноос гурван гудамжны наана Конкорд талбай дээр зогсох машин Альфа Ромео машины арын суудал дээр Ландон ноосон пиджак дотроо хөлрөн, сууж байв. Витториа хажууд нь, сүүлийнхээ тушаалыг өгч байгаа Оливеттийг харж сууна. «Найман тал үүсгэн, байраа эзэл. Үүдийг бүрэн периметрээр нь ажигла. Бай та нарыг таньж магадгүй болохоор, ил харагдаж болохгүй. Хүч хэрэглэхдээ үхэлд хүргэж болохгүй. Нэг нь дээврийг ажиглаж бай. Байг анхаараарай. Хэрэгсэл чухал биш». Бурхан минь, хэмээн Ландон бодлоо. Оливеттигийн дөнгөж сая дамжуулсан тушаалын ямар түргэн шуурхай хийгээд өөрийнхөө хүмүүст шаардлагатай бол кардиналыг золиосолж болох тухай хэлэхэд нь сэрвээнийх нь үс босох шиг боллоо. Хэрэгсэл чухал биш. «Давгъя. Хүч хэрэглэхдээ үхэлд хүргэж болохгүй. Дайсан амьдаараа бидэнд хэрэгтэй. За хөдөл!» гэж Оливетти холбоогоор зандран тушаав. «Захирагч аа, дотогш нь хүн илгээхгүй юм уу?» гэж Витториа гайхангуй, бараг л уурлангуй асуув. Оливетти эргэж хараад: «Дотогш нь уу?» гэлээ. «Пантеон дотор. Тэнд л болж магадгүй гээд байгаа биз дээ?» «Attento» гэж Оливетти хэлэхэд, нүд нь бас л дүрлэгнэнэ. «Хэрэв миний хүмүүс дотор нь орох юм бол хамгийн түрүүнд танигдана. Танай найз чинь дөнгөж сая байг барих цор ганц боломж бол энэ гэж хэлсэн шүү дээ. Хүмүүсээ дотогш нь оруулаад, хэн нэгийг үргээж орхих вий л гэж эмээж байна шүү». «Алуурчин аль хэдийн дотор байвал яах юм бэ?» Оливетти цагаа хараад: «Бай тов тодорхой хэлсэн. Найман цагт гэж. Бидэнд бас арван таван минут байна» гэлээ. «Тэр чинь кардиналыг яг найман цагт хөнөөнө гэсэн шүү дээ. Гэхдээ, тэр хохирогчоо аваад, аль хэдийн дотор нь орчихсон явж байж магадгүй. Бай чинь гараад ирдэг, танай хүмүүс хэн байсан гэдгийг нь мэдэхгүй

өнгөрөөчихвөл яах вэ? Дотор цэвэрхэн байгаа эсэхийг яаж ийгээд нягтлах хэрэгтэй шүү дээ». «Яг одоо бол хэтэрхий эрсдэлтэй байна». «Танихгүй хүн орвол эрсдэл бага шүү дээ». «Ажиллагааг өөрчилнө гэдэг цаг үрсэн ажил болох гээд байна ...» «Би яваад орьё л доо» гэж Витториа хэллээ. Ландон бүсгүй рүү эргэн харж, гайхан мэлрэв. Оливетти толгойгоо сэгсрэн: «Тэгж огт болохгүй» гэв. «Тэр чинь аавыг минь алсан шүү дээ». «Тийм учраас, таныг хэн бэ гэдгийг мэдэж байж магадгүй». «Та сонсоо биз дээ. Тэр Леонардо Ветра охинтой байсан гэж огт мэдээгүй байсан шүү дээ. Тэгэхээр, намайг ямар төрхтэйг гадарлах ч үгүй. Би жуулчин шиг л ороод явчихна. Тэгээд, ямар нэг сэжигтэй юм ажиглагдвал, гарч ирээд дохио өгье, та хүмүүсээ оруулаарай» гэлээ. «Өршөөгөөрэй, би тэгж чадахгүй нь». «Захирагч аа?» гэж Оливеттигийн холбоо чахрав. «Хойд талд асуудал гарлаа. Усан оргилуур Пантеоны үүдийг хаагаад харагдахгүй болгоод байна. Бид талбай дээр ил гарахгүй л бол ажиглаж чадахгүй нь. Та юу гэмээр байна? Харахгүй суух уу, эвсэл ил гарах уу?» Витториа сууж тэвчихээ болилоо. «За тэр. Би ерөөсөө гарлаа». Тэр хаалгаа нээгээд гарч одов. Оливетти холбоогоо орхиод, машинаас үсрэн гарч, Витториагийн замыг хөндөлдөв. Ландон бас араас нь гарлаа. Энэ хүүхэн чинь юу хийх гээд байна вэ? Оливетти Витториаг хөндөлдөөд: «Ветра авхай, та сайхан санаа гаргалаа. Гэхдээ, би энгийн хүмүүсийг ажиллагаанд оруулж чадахгүй нь». «Оруулах аа? Та нар юу ч харж чадахгүй байна шүү дээ. Би туслах гэж л байна». «Дотроос ажиглалт хийвэл сайхан л байна, даан ч ...» «Даан ч юу гэж? даан ч би эмэгтэй юм гэж үү?» гэж Витториа тулгав. Оливетти дуугарсангүй. «Та үүнээс дээр санаа гаргаж чадахгүй байна шүү дээ, захирагч аа. Яагаад гэвэл, миний санаа зөв гэдгийг та сайн мэднэ. Тэгсэн атлаа нэг эртний хүчирхэг зан гаргах гээд л ...» «Бид ажлаа л хийе л дээ». «Би тусалъя л даа». «Хэтэрхий аюултай шүү дээ. Бид хоорондоо холбоо барих боломж байхгүй. Би танд ямар холбоогоо өгчихөлтэй биш, тэгвэл хүн болгон таныг анзаарна». Витториа цамцныхаа халааснаас гар утсаа гаргаж ирээд: «Гэхдээ, олон жуулчин гар утастай яваа шүү дээ». Оливетти барайж орхив. Витториа утсаа дэлгээд, утсаараа ярьж байгаа юм шиг дүр эсгэн «Сайн уу, хонгор минь. Би Пантеон дотор байна. Чи үүнийг үзэх хэрэгтэй юм байна даа» гэв. Тэгээд, утсаа хаагаад, Оливетти руу ширтэв. «Хэн мэдэх юм бэ? Ямар ч эрсдэл байхгүй шүү дээ. Би таны нүд чинь больё гээд байна». Тэгээд, Оливеттигийн бүсэн дэх гар утас руу зааж: «Наадахын чинь дугаар нь хэд юм бэ?» гэлээ. Оливетти хариулсангүй. Жолооч тэднийг ажиглан зогссоноо гарч ирээд, Оливеттигийн дэргэд ирлээ. Түүнд ямар нэг санаа төрсөн бололтой, арван секунд орчим хоорондоо хар хур хийн ярилцав. Тэгснээ, Оливетти толгой дохиод, эргэж ирснээ: «Миний дугаарыг бичээд ав» гээд хэлж өглөө. Витториа дугаарыг нь утсандаа сануулав. «За одоо, залгаадаа даа». Витториа залгалаа. Оливеттигийн бүсэн дэх утас жингэнэв. Тэр утсаа аваад: «За, за, тийшээгээ оч, Ветра авхай. Ороод, орчин тойрноо ажигла, гарч ирээд юу харснаа утастаж мэдэгд» гэлээ. Витториа утсаа хаагаад: «Баярлалаа, эрхэм ээ» гэлээ. Ландон, эр амьтны хамгаалагч зөнгөөрөө, гэнэт: «Хүлээгээрэй» гэхчлээ. Тэгээд, Оливеттид хандан: «Та нар чинь энэ хүүхнийг тийш нь ганцааранг нь явуулчхаж байгаа юм уу?» гэлээ. Витториа түүн рүү хөмсөг зангидан, хараад: «Роберт, би зүгээр дээ» гэв. Жолооч дахиад л Оливеттитай ярилцлаа. Ландон: «Энэ чинь аюултай шүү дээ» гэж Витториад хэлэв. «Зөв шүү» гэж Оливетти хэлээд: «Миний хамгийн шилдэг дайчин хүртэл ганцаараа ажилладаггүй юм. Дэслэгч маань, та хоёрыг хамтдаа явбал ямар ч сэжиг татах зүйлгүй, бүр ч энгийн бас найдвартай болох юм байна гэлээ л дээ» гэв. *Бид хоёр уу?* гэж Ландон зогтусав. *Уул нь би...* «Та хоёр хоёулаа тийшээ ор» гэж Оливетти хэлээд: «Та хоёр яг л зугаалж яваа амрагууд шиг харагдана. Тэгээд ч бие биеэ хамгаална. Тэгвэл, надад илүү дээр санагдаад байна» гэлээ. Витториа мөрөө хавчаад: «Болж л байна. Гэхдээ хоёулаа бушуулахгүй бол

горьгүй нь» гэлээ. Ландон зогтуссан хэвээр. *Сайхан санаа байлаа шүү, ковбой минь.* Оливетти гудамжны өнцөг рүү зааж: «Эхэлж таарах тэр гудамж бол Орфани гудамж. Түүгээр зүүнш эргэ. Тэгээд, шууд Пантеон руу яваад орчихно. Удлаа гэхэд, хоёр минут л алхана. Би эндээ үлдэж, хүмүүсээ удирдаад, та хоёроос утас хүлээж байна. Та хоёрт өөрийгөө хамгаалах зэвсэг хэрэг болж магадгүй» гэснээ өврөөсөө гар буугаа сугалж ирээд: «Та хоёр буу яаж хэрэглэхийг мэдэх үү?» гэж асуулаа. Ландоны зүрх нь оволзоод ирэв. Бид хоёрт буу хэрэггүй ээ. Витториа гар бууг нь шууд аваад: «Би дайвалзаж байгаа онгоцноос сэлж яваа далайн гахайг дөчин метрийн зайнаас буудаж, им тавьдаг юм» гэв. «Сайн байна» гээд Оливетти буугаа Витториад өгөөд: «Харин наадахаа далд хийвэл зүгээр юм даа» гэлээ. Витториа шорт руугаа нэг харснаа, Ландон руу харав. *Өө, үгүй шүү* гэж бодож ч амжаагүй байтал Витториа пиджакийнх нь өврийг нээгээд, энгэрийнх нь халаас руу хийчхэв. Тэгэхэд, өвөрт нь хүнд чулуу хийчих шиг болчихлоо. Аз болж, Диаграмма-аас авсан хуудас нөгөө хармаанд байв. «Бид гэмгүй харагдаж байгаа биз дээ» гэж Витториа асуугаад: «За за, бид хоёр явлаа» гэлээ. Тэгээд, Ландоны гараас татаад, шууд л гудамж уруудан алхлав. Жолооч тэндээс: «Гараас нь татаж болж л байна. Гэхдээ та хоёр чинь жуулчин, тэгээд шинэхэн гэрлэсэн хос шүү дээ. Сугадалцаад явбал дээргүй юу?» гэлээ. Тэр хоёр булан тойрох тэр агшинд, Ландон Витториагийн нүүрэнд нууцхан мишээл тодрохыг анзаарав.

Хэсэг 59

Швейцар жардын «тоглолтын өрөө» гэгч Корпи ди Вигиланзагийн хажууд орших бөгөөд тэнд ихэнхдээ Папыг олны өмнө гарах юм уу, Ватиканы хүлээн авалт зэрэг үед хамгаалалтын асуудлыг төлөвлөдөг байлаа. Гэхдээ, энэ өрөөг энэ үдэш огт өөр зорилгоор ашиглаж байв. Хамтарсан ажиллагааг энэ удаад Швейцар жардын шаталсан удирдлагад хоёр дахь хүн нь болох Элиас Рошер захирч байлаа. Рошер торх шиг том цээжтэй, уян хатан болов уу гэмээр биетэй хүн байлаа. Уламжлалт цэнхэр хувцсаа өмсөж, улаан берет малгайгаа хажуулдуулан тавьж дэгжирхжээ. Ийм лагс хүнд огт баймааргүй цээл хоолойтой, ярихад нь хөгжмийн аялгуу шиг тод сонсогдоно. Рошерийн нүд шөнийн амьдралтай амьтных шиг сүүмгэр ажээ. Нөхөд нь түүнийг *orso* буюу өтөг баавгай гэнэ. Заримдаа түүнийг «могойн сүүдэрт алхах өтөг» гэх бөлгөө. Оливетти захирагчаа тэд могой гэх ажээ. Рошер могой шиг аюултай байж чадах боловч, ядаж л ирж явааг нь бараалж болох билээ. Рошерийн цэргүүд огт хөдлөлгүй, бараг л булчин шөрмөс нь чичрэлгүй зогсох боловч үнэндээ дөнгөж сая өгсөн мэдээлэл тэдний цусны даралтыг нэлээн хэдэн хэмээр нэмж, анхаарлыг нь хөвчиртөл чангалсан нь мэдээж байлаа. Дэслэгч Шартрон өрөөний хана даган номхон зогсох бөгөөд энэ даалгаврыг гүйцэтгэхэд тэнцэхгүй 99 хувийн нэг нь байгаасай хэмээн залбирна. Хорин настай Шартрон Швейцар жардын дотор хамгийн залуу нь байлаа. Тэр Ватиканд ирээд, дөнгөж гурван сар болж байв. Бусдын л адил Швейцарийн цэрэгт алба хааж, дараа нь Берн хотын ойролцоо хоёр жилийн турш нэмэлт *Ausbildung* (боловсрол. Герм.) аваад, дараа нь Ромын гадна орших нууц хуаранд Ватиканд алба хаах бэрх *prova* (сорилт. ита) давж энд иржээ. Гэхдээ, ийм нөхцөлд яах ёстойг ямар ч сургалт зааж өгсөнгүй. Үүрэг тавьж эхлэх үед, Шартрон үүнийг ямар нэг хачин жигтэй сургалт гэж бодож байлаа. *Ирээдүйн технологиор бүтсэн зэвсэг ч гэх шиг. Эртний нөхөрлөл ч гэх шиг. Хулгайлагдсан кардинал ч гэх шиг.* Дараа нь, Рошер тэдэнд олох ёстой зэвсгийнх оршин байгааг харуулсан камерын бичлэгийг үзүүлжээ. Энэ тоглоом, тэр бүү хэл сургалт ч биш байлаа. «Зарим газрын цахилгааны хангамжийг таслана». гэж Рошер хэлээд, цааш нь: «Энэ маань соронзон долгион илрүүлэх зорилготой юм. Дөрөв дөрвөөрөө баг болж ажиллана. Бүгд инфра-улаан туяаны шил зүүнэ. Хайлтыг ердийн металл

илрүүлэгчийг тэг гурван Омын долгион дээр тавьж гүйцэтгэнэ. Асуулт байна уу?» Алга байлаа. Шартроны толгойд олон бодол эргэлдэнэ. «Хэрэв цагаас нь өмнө олж илрүүлж амжихгүй бол яана аа?» гэж асуух гэснээ, тэр даруйдаа болив. Улаан беретийнхээ доороос өтөг түүнийг ширүүн харж байв. Тэгээд хүмүүсээ цогтой ёо ёслон: «Бурхан өршөөг, та нарыг минь!» гээд тараав.

Хэсэг 60

Пантеоноос хоёр гудамжны наана Ландон, Витториа хоёр такси зогсоол өнгөрөн, зорьсон газар руугаа дөхөж явлаа. Такси дотроо жолооч нь унтаж байх бөгөөд эртний Испаниас гаралтай үдийн үеэр дуг хийх энэ уламжлалыг олон нийт ягштал энд тэндгүй сахина. Ийнхүү, дугхийх цагаа зүй ёсоор бага зэрэг хэтрүүлж, ингэсээр, энэ мөнхийн хотод хаа нэгтээ хэн нэгэн ажил дээрээ заавал унтаж байх бүлгээ. Ландон оюунаа төвлөрүүлэх гэж оролдох ч үүсээд байгаа нөхцөлд юмыг ухамсартай хүлээж авахад тун ч хүнд байлаа. Зургаахан цагийн өмнө, тэр Кембриждээ тавтай яа унтаж байлаа. Гэтэл, одоо тэр Европт, хармаандаа хагас автомат буу хийчихсэн, дөнгөж танилцсан хүүхэнтэйгээ хөтөлцөөд, эртний шашны догшин нийгэмлэгүүдийн хоорондох өршөөлгүй тулааны талбарт гол үүрэг гүйцэтгээд явж байлаа. Витториа руу харав. Зориг төгс явна. Гарт нь эрч хүч мэдрэгдэж, бие даасан, итгэл төгс хүүхэн байлаа. Ландон бүсгүйн гарыг зөөлөн атгахад таатай, аятай санагдана. Бүсгүйд улам бүр татагдах шиг. *Бодитой ханд л даа* гэж тэр өөртөө шивнэв. Витториа түүний дотор тавгүй байгааг мэдрэв бололтой. «Тайван, тайван» гэж, бүсгүй толгойгоо эргүүлэлгүй шивнэнэ. «Бид хоёр шинэ гэрлэсэн хос шиг байх ёстой шүү дээ». «Би тайван байна». «Гэхдээ, чи гарыг минь няцлах нь байна шүү дээ». Ландон атгалтаа сулруулав. «Нүдээрээ амьсгал!» гэж бүсгүй хэллээ. «Уучлаарай, юу гэххэв ээ?» «Булчин шөрмөсийг сулруулдаг юм. Пранаяама гэдэг юм.» «Пиранха...?» «Загас биш ээ. Пранаяама тээч». Тэр хоёр Ротунда талбайг тойрон эргэхэд, Пантеон сүрлэг сайхнаар тодрон харагдана. Ландон энэ барилгыг харах тоолон гайхан бахаддаг ажээ. *Пантеон. Бүх бурхны сүм. Эртний бурхад. Байгаль, Хөрст дэлхийн бурхад.* Пантеон бодож байснаас нь илүү дөрвөлжин харагдах шиг. Босоо багана, гурвалжин *pronous* хоёр л ардаа байгаа асар том бөмбөгөр оройг халхлах ажээ. Үүдэн дээр бичсэн том үсэг, давлиун утгатай үгийг уншвал, яг зөв газар руугаа явж байгаа дахин нотлох шиг санагдана. *M Agrippa l f cos tertium fecit.* Ландон энэ үгийг ямагт бахдалтай яа орчуулдаг билээ. *Үүнийг гурвантаа консулоор сонгогдсон Маркус Агриппа бариулав. Яасан ч чийглэг юм бэ дээ* гэж бодон, Ландон ойр тойрноо харав. Видео камер барьсан жуулчид ойр орчныг бахдан явна. Зарим нь *La Tazza di Oro* хэмээх задгай кафед суун, Ромын хамгийн сайхан кофег амтархан тухална. Пантеоны өмнө, Ромын дөрвөн зэвсэгт цагдаа зогсоод, яг л Оливеттигийн сануулж байсан шиг хянуур ажиглана. «Ямар амгалан сайхан харагдана вэ?» гэж Витториа хэлэв. Ландон толгой дохьсон ч сэтгэл нь түгшүүрт автаад, живж байлаа. Энд биеэрээ зогсоод талбайг ажиглавал бүх юм жигтэй санагдана. Хэдийгээр Витториа зөв гэдэгт нь бат илтгэлтэй байсан ч, бүхэл бүтэн армийг энд аваад ирсэн хүн нь Ландон болж таарна. Иллюминатигийн шүлэг санаанд орлоо. *Чөтгөрийн цооногт Сантигийн бушинаас эхлээд. ТИЙМЭЭ, ЗӨВ* гэж өөртөө шивнэв. Энэ бол зөв газар. Сантигийн булш. Тэр энд Пантеоны өрхийн дор олонтаа ирж, аугаа Рафаэлийн бунхны өмнө ч олонтаа зогсож байсан билээ. «Цаг хэд болж байна?» гэж Витториа асуув. Ландон цагаа

хараад: «Долоо тавь. Шоу эхэлтэл арван минут байна». «Энэ залуусыг сайн л гэж найдахаас» хэмээн Пантеон руу орж яваа жуулчдыг харан Витториа хэллээ. «Хэрэв тэр бөмбөгөр дээвэр дор ямар нэг юм болбол, бид бүгд хайчин галд өртөнө шүү дээ» гэлээ. Үүдээр орох үедээ, Ландон гүнзгий гэгч амьсгаа авав. Хармаанд байгаа буу нь хүндрээд байгаа санагдана. Хэрэв үүдэнд байгаа цагдаа түүнийг нэгжээд, бууг нь олчихвол юу болох бол гэж бодсон ч, тэд хүний урманд түүнийг харсан ч үгүй оруулчхав. Ямар ч юм болсон боломжийн санагдана. Ландон Витториа руу тонгойн: «Чи ингэхэд хийн буунаас өөр юмаар буудаж үзсэн үү?» гэж асуув. «Чи надад итгэхгүй байгаа юм уу?» «Итгэх ээ? Би чамайг дөнгөж л таньдаг болоод байгаа төдий шүү дээ». Витториа түүн рүү урвайн, хошуугаа цорвойлгоод: «Гэхдээ энд бол бид хоёр чинь дөнгөж гэрлэсэн хос шүү дээ» гэлээ.

Хэсэг 61

Пантеон дотор хүйтэн, хүнд агаар - түүх хүүрнэх мэт угтав. 141 тохой өндөрт жингүй мэт нумарсан ханхай, хүнхэр энэ дээвэр Гэгээн Петерийн ордны бөмбөгөр дээврээс ч том ажээ. Энэ том харанхуй өрөөнд орж ирэхдээ, Ландон, яагаад ч юм бэ, дандаа жихүүцдэг ажээ. Пантеон - инженерчлэл, урлаг хоёрын гайхалтай хослол байлаа. Алдарт дугуй өрх тэртээ дээр онгойн, шингэх нарны улаан туяа түүгээр ташуулдан тусна. *Нөгөө алдарт өрх*, хэмээн Ландон бодов. *Чөтгөрийн цооног*. Тэр хоёр яваад орлоо. Хүнхэр дээвэр хоёр хажуу руугаа уруудан, баганат ханаа тулан тогтож, доороос нь өнгөлсөн гантиг чулуун шал бат дэвсэг болох ажээ. Хүмүүсийн алхлах чимээ, жуулчдын шивнэлдэх шуугиан асар том энэ өрөөнд цуурайтна. Ландон, үүгээр түүгээр алхах хэд хэдэн жуулчныг ажиглаад авав. Тэд энэ аугаа танхимын дотор сэлгүүцэн тайван алхах ажээ. *Чи энд ирчихсэн үү, үгүй* гэж Ландон бодов. «Ямар сайхан амгалан санагдах юм бэ?» хэмээн Витториа гарыг нь атгасан хэвээр өгүүлэв. Ландон толгой дохин зөвшөөв. «Тэгээд, Рафаэлийн булш хаана байгаа юм бэ?» Ландон эргэн тойрноо зэрвэс тойруулан ажиглав. Чулуун авс. Тахил. Багана. танхимын эсрэг талд, тухайлан чимэглэсэн нэгэн чулуун авс руу Ландон зааж: «Тэр Рафаэлийнх байх аа» гэлээ. Витториа аугаа том танхимыг тойруулан ажиглаад: «Энд кардиналыг алах гэж байгаа бололтой нэг ч хүн харагдахгүй байна даа. Орчноо дахиад нэг ажиглах юм уу?» гэв. Ландон толгой дохиод: «Энд хүн нуугдаж болох ганц л газар бий. Хоёулаа *reintranze*-г шалгах хэрэгтэй байх». «Хүнхэг үү?» «Тийм» гэж Ландон хэлээд: «Ханаа дагасан хүнхэг байгаа» гэлээ. Хана дагуулан хэд хэдэн нумарсан хөндий байдаг ажээ. Хүнхэг тийм том биш ч гэсэн сүүдэрт нь хүн нуугдаж болохоор юм. Уул нь тэнд эртний Ромын Олимпын бурхдын хөшөө байдаг байсан ч: харамсалтай нь, Ватикан Пантеоныг христийн сүм болгох үедээ, буруу номын бурхад гээд устгаж орхисон ажээ. Ландон эрдмийн тахилын эхнийхийг нь олсон ч, тэр тэмдгийг устгачихсан байвал яана гэж бодмогц унтууцал төрнө. Ямар хөшөө, хаашаа заагаад байж байх бол хэмээн бас бахдан бодно. Тэр Иллюминатигийн тэмдэг болсон хөшөө Гэгээрлийн мөрийг заан зогсож байхыг харвал сонирхолтой боловч гайхахааргүй байлаа. Дараа нь, тэр хөшөөг босгосон Иллюминатигийн нууцлаг урлаач хэн байсан бол хэмээн дотроо гайхав. «Би зүүн хагасыг нь үзье» гээд Витториа зүүнш заалаа. «Харин чи барууншаа яв. Тэгээд зуун наян хэм тойроод уулзая» гэв. Витториаг алслан одоход, Ландоныг айдас хучин авлаа. Баруунш эргэн алхах үед нь алуурчны хүйтэн чанга дуу ар нуруунаас нь сонстох шиг болов. *Найман цагт. Эрдмийн тахилын өмнөх ариун онгон өргөл. Үхлийн математик прогресс. Найм, ес, арав, арван нэг ... тэгээд яг шөнө дунд.* Ландон цагаа харвал 7:52 болж байна. Найман минут. Ландон эхний хүнхэг рүү өнгийн харахдаа, Италийн нэгэн католик ханы булшийг өнгөрлөө. Чулуун авсыг нь хана руу хэлтгий тавьчихсан - их л содон гаж

харагдана. Хэсэг жуулчин тэр хэлтгий байрлуулсан авсыг гайхан зогсоно. Ландонд тайлбарлаж байх зав байсангүй. Христийн шашинтны булш дорно зүг хандсан байх ёстой болохоор, өмнө нь баригдсан Ромын үеийн барилга дотор дандаа гажуу далий тавигдахаас өөр аргагүй болдог байжээ. Эртний энэ мухар сүсгийн тухай Ландон Бэлгэдэл 212 ангидаа өнгөрсөн сар ярилцаж байсан билээ. Ландон дорнош хандсан булшийн тухай ярьж дуусахад: «Ямар ч утгагүй юм байна шүү дээ» гэж нэгэн оюутан эмэгтэй хэлж байжээ. «Яагаад христийн шашинтнууд булшаа дорнош, ургах нар руу хандуулах билээ дээ. Тэд чинь христийн шашин, нарны шүтлэг биш шүү дээ» гэж билээ. Ландон самбарынхаа өмнө гарч зогсоод, гартаа барьсан алимаа нэг хазаад :«Хицрот гуай» гэж дуудав. Арын ширээнд үүрэглэн сууж байсан нэг залуу бөндгөсхийн цочсоноо: «Юу? Би юу?» гэв. Ландон хананд өлгөсөн Сэргэн мандлын үеийн нэг зургийн хуулбарыг зааж: «Тэр бурхны өмнө сөгдөөд байгаа хүн хэн бэ?» гэж асуув. «Хн . . . нэг гэгээнтэн л байх». «Сайн байна. Тэгээд, чи гэгээнтэн гэдгийг нь яаж мэдээд байгаа юм бэ?» «Толгой дээр нь гэрэлт цагираг байгаа болохоор». «Зөв шүү. Тэгээд, тэр алтан цагираг чамд юу санагдуулж байна вэ?» Хицрот инээмсэглэн: «Тийм шүү. Нөгөө урд хичээл дээр үзээд байсан, Египетийн бурхдын ард байдаг дугуй юмыг . . . юу билээ... нөгөө нар!» «Сайн байна, Хицрот. Одоо унт, унт» гэснээ, Ландон танхим руугаа эргэн «Гэрэлт цагираг гэдэг бол христийн шашин Египетийн нарны шүтлэгээс өвлөн авсан олон бэлгэдлийн нэг юм. Христийн шашин нарны шүтлэгийн жишээгээр дүүрэн бий». «Уучлаарай» гэж урд сууж байсан нэг охин хэлээд: «Би дандаа сүм рүү явдаг. Гэхдээ, тэнд нарны шүтлэгийн тухайд ямар нэг юм огт анзаараагүй юм байна». «Нээрэн үү? Арван хоёр сарын хорин таванд та нар юу тэмдэглэдэг вэ?» «Зул сарын баяр. Христийн мэндэлсэн өдрийг». «Гэхдээ, Библид бичсэнээр бол Христ гурван сард мэндэлсэн гэдэг шүү дээ. Тэгсэн мөртөө, бид арван хоёр сард юу тэмдэглэдэг юм бэ?» Танхим чимээгүй болчхов. Ландон инээвхийлээд: »Хүүхдүүд минь дээ, Арван хоёр сарын хорин таван гэдэг чинь эртний нарны шүтлэгийн баяр - Sol invictus - Ялгуусан нарны баяр юм шүү дээ. Энэ өдрөөс л нар эргэж, өдөр уртасдаг шүү дээ» гэж билээ. Ландон алимаа дахин нэг хазлаа. «Шинэ шашин хуучин шашнаа шахан зайлуулахдаа, хуучин шашныхаа баяр ёслолыг өвлөн авч, хүмүүсийг төдийлөн зовлонгүй өөртөө дасгаж ээнэгшүүлдэг юм. Үүнийг трансмутац гэдэг. Тэгж хүмүүс шинэ шашныг өөрийнхөө дассан сурснаараа хүлээн авдаг байна. Сүсэгтнүүд хуучин газраа, хуучин баяраа тэмдэглэж, хуучин бэлгэдлээ харж баясдаг боловч харин нь бурхан нь л солигдчихсон байдаг юм.» Урд эгнээнд суусан нөгөө охин нэлээн эгдүүцсэн байртай: «Та тэгээд христийн шашин бол зүгээр л өөрөөр будаад янзалчихсан нарны шүтлэг юм гэж та хэлээд байна уу?». «Үгүй, үгүй. Христийн шашин дандаа ганцхан нарны шүтлэгээс өвлөж аваад байсан юм биш. «Бурхан бүтээх» ёс эртний Эгемэрүүдээс гаралтай, харин «бурхан идэх» ёс буюу Ариун нийгэмлэгийг бол эртний Ацтекуудаас өвлөсөн юм. Бүр бусдын нүглийг ариусгах үүднээс өөрийн биеэр өргөл өргөх заншил ч өөрөө Христийнх биш, ард түмнийхээ өмнөөс биеэ золиосолсон залуугийн тухай Квацалкотлийн уламжлал юм шүү дээ». Нөгөө охин гайхасхийн: «Тэгээд яг христийн гэгчхээр ориг юм байгаа юм уу?» «Одоогийн ямар ч шашинд өөрийн гэх юм тун бага. Шашин гэдэг хоосон юмнаас үүсдэггүй юм. Харин ч хуучныхаа уламжлалаас өвлөсөөр цогцолж бий болдог. Орчин үеийн шашин бол түүхийн туршид хүмүүсийн бий болгосон бурханлаг мөрөөдлийн олон олон уламжлалын цогц юм шүү дээ» гэлээ. «Би ингэж бодоод байна» гэж нөгөө Хицрот нойр нь аль хэдийн сэргэчихсэн бололтой өндөлзөн: «Христийн шашинд ориг юм нэг байна. Христийн өөрийн нь дүр. Христийн шашинд бурхныг нарны шүтлэг шиг шонхороор дүрсэлдэггүй, Ацтекууд ч юм уу, эсвэл бусад шүтлэг шиг өөр ямар нэг юмаар дүрсэлдэггүй шүү дээ. Бурхан гэж дандаа л нэг цагаан

сахалтай өвөгжөөр хүн байдаг. Тэгэхээр бурхны дүр өөрөө ориг юм биш үү?» гэлээ. Ландон зальтай яа инээвхийлэн: «Эртний Ром, Гэрэг, Митраик энэ тэр гээд олон овог аймаг Христийн шашинд орохдоо, мэдээж, тэдний Христ бурхан нь ямархуу харагддаг вэ гэдэг асуулт тавьсан л байж таарч байгаа юм. Тэгэхэд нь, сүм хийд тун овжиноор бүх түүхэн шүтлэг дотроос хамгийн өөриймсөг, танил, догшин дүрийг сонгож өгсөн байдаг юм.» Хицрот нэг л үл итгэн харлаа. «Урт цагаан сахалтай өвөгжөөр хүн үү?» Ландон Гэрэгийн бурхдын шатлалыг танилцуулсан ханын зураг дээр хамгийн дээр нь байгаа цагаан сахалтай, өвөгжөөр хүний дүрийг зааж «Зевсийн царай танил биш байна гэж үү?» гэлээ. Яг энэ мөчид хичээл завсарлажээ. «Оройн мэнд!» хэмээн нэг хүн ар нуруунаас мэндлэв. Ландон давхийн цочиж, эргэн харав. Тэр саяхь бодлоосоо дөнгөж салаад, Пантеонд эргэн ирлээ. Энгэртээ загалмай зүүсэн, цэнхэр хувцастай өвөгжөөр хүн ард нь зогсч байв. Инээмсэглэхэд нь, уруулынх нь завсар саарал өнгөтэй шүд нь цухуйх ажээ. «Та англи хүн үү?» гэж хүчтэй Тускон аялгаар асууж байна. Ландон түгдэрч, ээрснээ: «Үгүй ээ, америк хүн л дээ». Тэр хүн санаа нь зовсон байртай: «Өөх, бурхныг бодож өршөөгөөрэй. Та их зөв аятайхан хувцасласан болохоор нь, би зүгээр л ... Өршөөгөөрэй» гэлээ. «Би яаж танд туслах вэ?» Ландон асуулаа. «Үгүй дээ. Уул нь би танд тусалдаг юм уу л гэсэн юм. Би эндхийн тайлбарлагч юм л даа» гээд хотын захиргаанаас өгсөн тэмдгээ үзүүлээд: «Ромд ирсэн жуулчдыг аянаа сонирхолтой өнгөрөөхөд нь тусалдаг юм» гэлээ. Сонирхолтой гэнэ ээ. Ландон энэ удаад, Ромд ирээд, тун сонирхолтой аялж байгаа шүү гэж дотроо бодлоо. «Та их боловсролтой хүн шиг харагдаж байна» гээд хөтөч: «Урлаг соёлд шимтдэг хүн гэдэг нь илэрхий байна шүү. Магадгүй, би энэ гайхалтай барилгын талаар илүү сонин түүх ярьж өгч болох юм» гэлээ. Ландон эелдэг инээмсэглээд: «Та найрсаг хүн юм, гэхдээ би өөрөө урлагийн түүх судалдаг хүн л дээ, тэгэхээр ...» «Хөөх, гайхалтай!» гэж нөгөө хүн үгийг нь таслав. Мөрийтэй тоглоомд хожсон хүн шиг нүдэнд нь цог бадамлаад явчихлаа. «Тэгвэл энэ газрыг хараад танд хязгааргүй бахдал төрж байгаад эргэлзэх хэрэггүй юм байна даа». «Надад туслалцаа... ер нь бол... хэрэггүй» «Пантеоныг манай эриний өмнөх 27 онд Маркус Агриппа бариулсан юм шүү дээ» хэмээн нөгөө хүн цээжилсэн танилцуулгаа урсгаж эхэллээ. «Тийм, тийм. Тэгээд бас, Хадрианы үед, манай эриний 119 онд их засвар хийсэн юм» хэмээн Ландон дундуур нь таслав. «Энэ 1960 онд Нью Орлеанд Супердом гэх том танхимыг барьтал хамгийн том бөмбөрцөг дээвэрт байшин байсан юм». Ландон унтууцаж эхлэв. Тэр хүнийг зогсоох аргаа олохгүй байлаа. «Тавдугаар зууны шашин судлаачид Пантеоныг Чөтгөрийн байшин гэдэг байсан нь тэр дээврийн задгай өрхийг чөтгөрийн үүд гэж нэрлэснээс болсон байгаа юм.» Ландон тэр хүнийг сонсолгүй, өөрийнхөө бодолд алслан одов. Тэр - задгай өрхийг харан, Витториагийн яс янгинатал ярьсныг санан, цээжин дээрээ тамгалуулсан нэгэн кардинал тэр өрхөөр нисэн орж ирээд, боржин чулуун шал мөргөж байгааг төсөөлөн зогсов. *Тэгвэл ч шар хэвлэлийн шуугиан болно доо.* Ландон Пантеон дотор сурвалжлагч байгаа эсэхийг харуулдан ажиглав. Алга байлаа. Санаа жаахан уужирч, амьсгаа авав. Шал дэмий санаа байлаа. Мэдээж, тийм юм хийх гэж тусгайлан сурвалжлагч нарыг энд авчирна гэдэг хэний ч бодсон инээдтэй хэрэг билээ. Ландон булан тохойгоо үргэлжлүүлэн нэгжиж эхэллээ, харин тайлбарлагч түүнийг эзэндээ эрхлэх гөлөг шиг даган гүйнэ. Урлагийн түүх судлаач үүнийг бас танилцуулга цээжилсэн хөтчөөр тайлбарлуулна гэнэ ээ хэмээн төвөгшөөн бодов. Танхимын нөгөө талд, Витториа өөрт ногдсон хэсгээ шалмаг хянаж дуусгав. Аав нь өнгөрсөн тухай мэдээ дуулснаас хойш, анх удаа гав ганцаараа үлдэж байгаа нь энэ бөгөөд өнгөрсөн найман цагт үзэж амссан бүх аймшиг түүнийг орхилгүй тойрсоор байгааг анзаарлаа. Аавыг нь зэрлэгээр хөнөөсөнд эмгэнэн хорсох сэтгэл шинээрээ байлаа. Мөн аавынх нь бүтээсэн гайхамшигийг террорист

зэвсэг болгон, хүмүүс ашиглаад явж байгаа нь аавыг нь хөнөөсөнтэй адил эмгэнэн хорсох сэтгэл төрүүлж байв. Үүнд, Витториа өөрийгөө ч бас буруутгаж байв. Антиматерийг Витториагийн өөрийнх нь зохион бүтээсэн саванд хийж авч яваад, өнөөдөр өөрийнх нь зохиосон сав Ватиканд дэлбэрэх цагаа тоолон хүлээж байлаа. Аавынхаа жирийн үнэний төлөө хийсэн эрэлд дөхөм үзүүлсэн охины хөдөлмөр . . . олон нийтийг үймүүлэх том үйл явдлын нэг хэсэг болчихсон байв. Амьдралын яг энэ мөчид байгаа хамгийн аятайхан зүйл бол огт танихгүй Роберт Ландон түүнтэй хамт байгаа явдал байв. Ландоны нүд тайтгарч, тайвшрах нөмөр нь болж байлаа. Өнөө өглөөг хүртэл, зөвхөн далай л түүнд тийм тайван сайхан сэтгэл төрүүлдэг байсан билээ. Тэр залуу түүнтэй хамт байгаад баяртай байв. Ландон эрч хүчний эх булаг болоод зогсохгүй, аавыг нь хөнөөсөн этгээдийг барих ганц боломжийг бас олгож байлаа. Витториа гүнзгий амьсгалан, ногдсон хэсгээ нэгд нэгэнгүй шалгана. Өмнө нь хэзээ ч ингэж өшөө авах сэтгэлээр дүүрэн байгаагүй, харин өнөөдөр хатуу харш ийм сэтгэл түүнийг өдөржин эзэмдэж байлаа. Амьдрал, амь хороохыг үзэн яддаг тэр бүсгүй аавыг нь хөнөөсөн хүнийг үхээсэй гэж хүсч байв. Ямар ч сайн карма түүнийг энэ бодлоос нь өнөөдөртөө л лав салгаж чадахааргүй ажээ. Цочирдож, хилэгнэсэн бүсгүйн Итали цусаар ямар нэг хараал шингэсэн зүхэл урсаж байгааг анзаарах бөгөөд урьд нь ийм зүйл хэзээ ч мэдэрч байсангүй. Өрхийнхөө нэр төрийг харгис хэрцгийгээр ч хамаагүй хамгаалдаг байсан Сицил өвөг дээдэс өшөө авахыг сануулан шивнэх шиг. Хонзон гэдгийг бүх биеэрээ мэдэрч байв. Рафаэлийн бунхан руу дөхөв. Харваас, тэр онцгой нэгэн байсан бололтой. Авс нь бусдаасаа өөр, плексглассаар гадуур нь хамгаалж, ханын хүнхэг рүү цэвэрхэн оруулсан байв. Шилний цаанаас авсны урд хэсэг харагдана. РАФАЭЛЬ САНТИ 1483-1520 Витториа булшийг хянамгай ажиглан, гадна нь тавьсан тайлбарыг уншина. Тэгснээ... дахиад уншив. ... Дахин нэг уншлаа. Хормын дараа, аймшигт автсан нүдээр эргэн тойрноо харлаа. «Роберт, Роберт!»

Хэсэг 62

Ландон өөрт ногдсон Пантеоныхаа хэсгийг хянан явсаар, түүнд нь өсгий даган гишгэх нөгөө тайлбарлагч төвөг болсоор байв. Хөтөч зогсолтгүй ярьсаар, Ландон ч сүүлийнхээ ханан хүнхэг рүү дөхөж явна. «Та тэр хүнхэгийг сонирхоод байх шиг байна аа даа» гэж хөтөч хэлээд, их л баяртайгаар: «Хана нь зузаан болохоор л энэ том дээвэр жингүй юм шиг тогтож байгаа юм шүү дээ, та энэ тухай мэдэх үү?» гэв. Ландон толгойгоо дохьсон боловч хөтчийн нэг ч үгийг сонссонгүй, дараагийн хүнхэгийг ажиглахаар зэхнэ. Гэнэт, хэн нэг нь түүнийг араас нь бариад авлаа. Тэр Витториа байв. Тэр амьсгалж ч чадахгүй, гарыг нь атган зогсоно. Нүүрэнд нь тодорсон хүйтэн айдсыг ажиглаад, Ландоны толгойд ганц л бодол орж ирлээ. *Кардиналын хүүрийг олоо юм болов уу.* Сэрвээнийх нь үс босоод явчих шиг болов. «Аа ха, таны гэргий юу» гэж хөтөч налиганан, дахин нэг үйлчлүүлэгчтэй боллоо гэж баясна. Тэр Витториагийн шорт руу заагаад: «Одоо харин, та хоёрыг америк гэж хэлж болохоор байна шүү» гэлээ. Витториагийн харц нь жартайснаа: «Би Итали хүн» гэв. Хөтчийн инээмсэглэл нүүрэнд нь огцом царцсаж: «Өөх, бурхан минь» гэв. «Роберт» гэж Витториа шивнээд, нуруугаа хөтөч рүү харуулан: «Галилейн Диаграмма-г харах хэрэгтэй байна» гэлээ. «Диаграмма?» гэж хөтөч аль хэдийн сонсчихсон: «Та хоёр ч түүхийг сайн мэддэг бололтой шүү. даан ч тэр бичгийг олж үзэх хэцүү. Ватиканы нууц архивд хадгалж байдаг юм шүү дээ» гэлээ. «Биднийг өршөөгөөрэй!» гэж Ландон хэлээд, зайдуу очив. Тэр Витториагийн мэгдсэн

царайг хараад, гайхаж орхилоо. Диаграммын хуудсыг гаргаж ирэнгээ: «Яасан? Юу болоо вэ?» гэлээ. «Энийг хэзээ бичсэн юм бэ?» гэж Витториа хуудсыг барин ширтэнгээ асуув. Хөтөч дахиад л тэр хоёр дээр ирчихсэн, тэр хуудсыг гайхан харснаа: «наадах чинь ... юу биш байлгүй дээ ...» гэлээ. «Жуулчдад зориулсан хэвлэл байгаа юм» гэж Ландон хэлээд: «Тусалсанд гялайлаа. Гэхдээ, би эхнэртэйгээ хоёулхнаа баймаар байна» гэлээ. Хөтөч холдсон боловч нүд нь нөгөө цааснаас салахгүй байв. «Огноо, огноо. Энэ номыг хэзээ хэвлэсэн юм бэ?» гэж Витториа давтан давтан асуув. Ландон хуудасны доод хэсэгт байгаа ром тоог заагаад: «Хэвлэсэн огноо нь энэ байна. Юу болоо вэ?» гэлээ. Витториа ром тоог: «1939 он уу?» гэж тайлж уншлаа. «Тийм байна, яасан?» Витториагийн нүд нь айдсаар дүүрээд явчихлаа. «Болохоо байлаа шүү, Роберт. Бид баларлаа. Он нь зөрчихлөө» гэлээ. «Он нь яаж зөрчихлөө гэж?» «Рафаэлийн булш. Тэр булш 1759 оных юм байна. Диаграмма-г бичсэнээс хойш зуун жилийн дараа» гэлээ. Ландон Витториагийн хэлсэн үгийг ойлгох гэж хэсэг мэлрэн зогссоноо: «Үгүй ээ, Рафаэль 1520 онд, Диаграммаг бичихээс өмнө нас барсан юм» гэлээ. «Тийм л дээ. Гэхдээ энд сүүлд нь зөөж авчирсан юм байна». Ландон ойлгосонгүй. «Чи юу яриад байгаа юм бэ, ойлгосонгүй» гэлээ. «Би дөнгөж сая уншлаа. Рафаэлийн булшийг 1758 онд Пантеонд зөөж байрлуулсан юм байна. Италичууд нэртэй хүмүүстээ хүндэтгэл үзүүлж ийм хүндтэй газар байрлуулжээ». Энэ үгийг сонсмогцоо, Ландоны сүнс нь хийсээд явчих шиг хүйт даалаа. «Энэ шүлгийг бичиж байх үед» хэмээн Витториа үргэлжлүүлэн: «Рафаэлийн булш өөр газар байжээ. Тэр үед, Пантеонд Рафаэлийн булш байгаагүй юм байна» гэлээ. Ландон амьсгаа нь тагларчхав. «Энэ чинь тэгэхээр ...» «Энэ чинь тэгэхээр бид буруу газар байна гэсэн үг». Ландоны хөл гуйваад явчихлаа. *Үгүй . . . ийм байж болохгүй. . . Битгэлтэй байсан юм сан.* Витториа гүйн очиж, хөтчийн гарыг атгаад: «Синьеор, биднийг өршөөгөөрэй. Рафаэлийн булш 1600-аад оны үед хаана байсан юм бэ?» «Урбинод» гэж хөтөч түгдчин өгүүллээ. Тэр одоо сандарч мэгдэж эхэлсэн бололтой. «Төрсөн газар нь» гэлээ. «Тийм байж болохгүй» гэж Ландон өөрийгөө хараагаад: «Иллюминатигийн эрдмийн тахил нь энд Ромд байх ёстой. Энэ үнэн шүү!» гэв. «Иллюминати гэнэ ээ?» гэж хөтөч гайхан асууснаа Ландоны гартаа барьж байсан хуудсыг харж: «Та нар ингэхэд юун хүмүүс вэ?» гэлээ. Витториа хөтчийг шалгааж эхлэв. «Бид Сантигийн шороон булш гэдэг юм хайж байна. Ромд. Та тийм юм мэдэх үү?» Хөтөч мөрөө хавчин, толгой нь эргэсэн бололтой: «Энэ бол Ромд байгаа Рафаэлийн цор ганц булш шүү дээ» гэв. Ландон бодлоо цэгцлэх гэж оролдоно, даан ч олон юм эргэлдээд чадахгүй байв. Хэрэв Рафаэлийн булш энд 1655 онд байгаагүй юм бол энэ шүлэг юун тухай хэлээд байгаа юм бэ? *Чөтгөрийн цооногт Сантигийн шороон булш? Юу юм болоо? Бодооч!* «Санти гэдэг өөр уран бүтээлч байсан юм болов уу?» гэж Витториа асуув. Хөтөч мөрөө хавчин: «Би л лав мэдэхгүй юм байна» гэв. «Тэгвэл өөр хүн? Санти гэдэг нэртэй эрдэмтэн, яруу найрагч, одон орон судлаач байсан юм болов уу?» Хөтөч одоо тэр хоёроос салахын түүс болж байгаа бололтой. «Үгүй дээ, авхай. Миний сонссон цорын ганц Санти бол архитектор Рафаэль л юм даа». «Архитектор оо? Би зураач байсан гэж бодсон шүү дээ» гэж Витториа асуув. «Аль алийг нь л хийдэг байсан юм. Ер нь Микланжелло, да Винчи, Рафаэль бүгд л аль алийг нь хийдэг байсан юм». Ландонд гэнэт санаа төрөв. Хөтчийн ярианаас уу, эсвэл тойроод байгаа булшны үгнээс санаа авав уу, мэдсэнгүй. Гэхдээ л сонин санаа төрлөө. *Санти архитектор байсан.* Үүний хойноос, бодол ар араасаа цуварч гарав. Сэргэн мандлын үед архитекторууд хоёр л юм хийдэг байжээ. Нэг нь бурхныг алдаршуулахын тулд аугаа том сүм барих, нөгөө нь хүндтэнийг алдаршуулахын тулд гоёмсог булш барих явдал байв. *Сантигийн булш.* Тэгэхээр нэгэн бодол гялс хийн буув. Да Винчигийн *Мона Лиза*. Монетын *Усан лил цэцэг*. Микланжелогийн *Давид*. Сантигийн *шороон булш* ... «Санти булш

бунхан барьсан юм байна» гэж Ландон хэлэв. Витториа гайхан: «Юу гэнэ ээ?» гэв. «Энэ чинь Рафаэлийг оршуулсан газрыг биш, харин түүний барьсан булш бунхныг хэлээд байгаа юм байна». «Чи юу яриад байгаа юм бэ?» «Бид буруу тайлбарлачихсан байна. Энэ чинь бидний эрээд байгаа Рафаэлийг оршуулсан газрыг хэлээгүй, харин Рафаэль өөрөө хэн нэгэнд зориулан барьж өгсөн булш бунхны тухай яриад байгаа юм байна. Би энийг ойлгоогүйдээ итгэж чадахгүй нь. Сэргэн мандал, Барокийн үеийн Ромын уран баримлын хагас нь шахуу дандаа л булш бунханд зориулагдсан байдаг юм» хэмээн хүүрнэв. Тэгснээ, Ландон гашуунаар инээмсэглэв. *Рафаэль ч зуу зуун булш бунхан барьсан байх даа.* Витториа ч баярласан шинжгүй байв. «Бүр зуу зуугаар нь уу?» Ландоны инээмсэглэл ч царцаж орхив. «Тэдний тэгээд хэд нь шороон билээ, профессор оо?» Ландон тун эвгүй байдалд орлоо. Тэр Рафаэлийн бүтээлийн тухай сайн мэдэхгүй байв. Микланжелогийн бүтээлийн тухай тэр юу л бол юу ярьж чадах ч, Рафаэлийн бүтээлийг харин нэг их сонирхож байсангүй. Ландон Рафаэлийн алдартай хэдэн булшийг нэрлэж чадах ч, тэр нь ямархуу байдалтай байдгийг мэдэхгүй ажээ. Ландоны царай эвгүйцэн мушийхийг хараад, Витториа эргэн хөтөч рүү хандлаа. Тэр гэдрэгээ алхан холдохоор зэхэж байлаа. Бүсгүй түүний гарыг атгаад, татаж ойртуулснаа: «Бид булш хайж байна. Рафаэлийн барьсан булш. Тэгээд тэрийг шороон гэж тодорхойлж болохоор байх ёстой» гэв. Хөтөч балмагдан: «Рафаэлийн барьсан булш гэж би мэдэхгүй юм аа. Тэр маш олныг барьсан шүү дээ. Та хоёр магадгүй сүм хайж байгаа байх. Архитекторууд ихэнхдээ булшийг сүмтэй нь хамт зурдаг байсан юм шүү дээ.» Ландон хөтчийн зөв гэдгийг шууд ухаарав. «Тэгвэл, Рафаэлийн барьсан булш, сүмээс шороон гэхээр зүйл бий юу?» Хөтөч мөрөө хавчаад: «Уучлаарай. Та хоёр юу яриад байгааг би үнэндээ ойлгохгүй байна. Шороон гэдэгт тохирох ямар ч зүйл би санахгүй байна. Би ер нь явсан нь дээр байх» гэлээ. Витториа түүний гараас нь тавилгүй атгасаар, нөгөө гараараа тавдугаар хуудсыг барьчихсан уншина. «Чөтгөрийн цооногт Сантигийн шороон булшнаас. Танд энэ ямар нэг юм хэлж байна уу?» «Мэдэхгүй ээ». Ландон гэнэт энэ мөрийн эхний тодотголыг санах. *Чөтгөрийн цооног.* Тэгээд, хөтөч рүү хандан: «Рафаэлийн барьсан сүмүүдээс аль нэг нь дээр ийм задгай өрхтэй юү, үгүй юү?» гэв. Хөтөч толгойгоо сэгсрэн: «Миний мэдэхээр ганц Пантеон л ийм» гэснээ тэр зогтусан: «Гэхдээ ...» «Гэхдээ юу гэж?» гэж Ландон, Витториа хоёр зэрэг асуув. Хөтөч тэр хоёр руу толгой сэгсрэн дөхөж ирлээ. «Чөтгөрийн цооног гэсэн үү?» Тэгснээ, эрүүгээ маажин, мушилзаад: «Чөтгөрийн цооног гэдэг чинь *viso diavolo* юү?» гэлээ. Витториа толгой дохин: «Махчилж орчуулбал ч мөн л дөө» гэв. Хөтөч муухан мушилзан инээвхийлээд: «За, тэгэхээр ойрмогхон огт хэрэглээгүй нэг ийм нэр томьёо байдаг юм. Хэрэв эндүүрээгүй бол *viso diavolo* гэж бөөнөөр оршуулсан нүхийг хэлдэг юм» гэлээ. «Бөөнөөр оршуулсан нүх ээ?» гэж Ландоныг лавлав. «Тийм. Эндүүрээгүй бол чөтгөрийн цооног гэдэг нь сүмийн дэргэд нэг булшны хөлд дэвсэн, бөөн хүн оршуулсан нүхийг хэлдэг санагдана». «Дэвсэг булш гэж үү?» гэж Ландон асуув. Энэ юу гэсэн үг болохыг тэр сайн мэдэж байв. «Ай даа. Би наад үгийг чинь бодоод олохгүй байсан юм» гэж хөтөч хэллээ. Ландон уул нь энэ тухай бас бодож үзсэн байлаа. Дэвсэг булш гэдэг бол оршуулах асуудлыг хямдхан шийдсэн балай арга байв. Гэрийн аль нэг гишүүнийг сүм хийд хүндэтгэн, угалзаг чулуун авсанд хийж, сүмийн газар оршуулсны дараа, үлдсэн гишүүн нь өөрсдийгөө түүнтэй хамт мөн л сүмийн газар оршуулахыг шаарддаг байжээ. Сүмд гэрийнх нь тэр олон хүнийг оршуулах газар, мөнгө байхгүй болохоор, тэд дэвсэг булш буюу хүндтэй гишүүнийх нь булшны хажуугийн шалыг авч газрыг нь ухаад, тэнд нь бусдыг нь дэвсэг болгоод оршуулчихдаг байжээ. Гэхдээ, дэвсэг булш удалгүй түгээмэл хэрэглэгдэхээ больсон бөгөөд учир нь өмхий самхай сүмээр дүүрэн үнэртдэг болсон байна. Чөтгөрийн цооног хэмээн

Ландон дахин шивнэв. Энэ нэр томъёог тэр өмнө сонсож байгаагүй ч их л онож өгсөн байлаа. Ландоны зүрх хүчтэй түг түг цохилж эхлэв. *Чөтгөрийн цооногт Сантигийн бушинаас эхлэн.* Одоо ганц л асуулт үлдлээ. «Рафаэль тийм чөтгөрийн цооногт булш бунхан барьж байсан юм болов уу?» Хөтөч толгойгоо маажлан «Ер нь бол. . . Учлаарай. . . Би ганцыг л мэдэх юм байна». *Цор ганцыг уу?* хэмээн Ландон асуув. Үүнээс сайхан хариултыг бодоод ч олохгүй байлаа. «Хаана байдаг юм бэ?» гэж Витториа бараг л хашхирах шахав. Хөтөч тэр хоёр руу гайхсан байртай харснаа «Чиги сүм гэдэг юм. Августино Чиги, ах дүү нарынх нь булшинд зориулсан сүм л дээ. Тэд урлаг, эрдмийг тэтгэдэг хүмүүс байсан юм». *Эрдмийг үү?* гэж Ландон асуунгаа, Витториатай харилцан харц тулгаад авав. «Хаана байдаг юм бэ?» гэж Витториа асуув. Хөтөч асуултыг хайхралгүй, мэргэжлийн өвчин нь хөдөлсөн бололтой, ярьж эхлэв. «Би тэр сүмийг шороон гэж хэлж болохыг мэдэхгүй л дээ. Гэхдээ л ямартай ч гэсэн өөр гэж тодорхойлж болно шүү». *Өөр өө? Яагаад?* гэж Ландон лавлав. «Архитектурын хувьд нэг өөр гэх үү дээ. Рафаэль бүгдийг нь ганцаараа хийсэн юм. Өөр зарим хүн дотор чимэглэлийг нь хийсэн. Нэрийг нь санахгүй байна». Ландон түүний үгийг нэг бүрчлэн сонсож байв. *Нэр нь тодорхойгүй Иллюминатигийн урлаач байх л даа.* «Дотоод заслыг нь хийсэн тэр этгээд ямар ч гоо зүйн мэдрэмжгүй этгээд байсан байж таарна. Dio mio! Atrocita! Ер нь ямар амьтан хүний булшин дээр пирамид барих вэ дээ» гэлээ. Ландон чихэндээ итгэсэнгүй. «Пирамид аа? Тэр сүмд тэгээд пирамид байдаг юм уу?» «Харин тийм ээ. Аймаар байгаа биз?» гэж хөтөч үргэлжлүүлнэ. Витториа хөтчийн гарыг шүүрч аваад: «Сеньиор, Чиги сүм хаана байдаг юм бэ?» гэж тулгаж асуулаа. «Хойшоогоо нэг бээр орчим зайд. Санта Мариа дэл Пополо сүмийн дотор» гэв. Витториа гүнзгий амьсгаа аваад: «Баярлалаа. Явъя даа» гээд ухасхийв. Хөтөч: «Хүүе байзаарай. Би яасан мангар юм бэ?» гэв. Витториа зогтусан эргэснээ: «Алдаа хийчихжээ гэж битгий л хэлээрэй дээ» гэв. Хөтөч толгой сэгсрээд: «Үгүй ээ. Гэхдээ арай өмнө нь миний санаанд буух ёстой байсан юм. Чиги сүмийг дандаа Чиги гэж нэрлэдэг байгаагүй юм. Өмнө нь түүнийг Capella della Terra гэдэг байсан юм» гэлээ. «Газрын сүм гэж үү?» гэж Ландон асуув. Витториа тосч аваад: «Үгүй. Шороон сүм гэж» гэлээ. Витториа Ветра Пантеоноос гарч Ротунда талбайгаар гуйж явахдаа, утсаа залгалаа. «Оливетти захирагч аа. Энэ буруу газар байна!» гэлээ. Оливетти: «Буруу гэнэ ээ? Юу гэсэн үг юм бэ?» хэмээн хашхична. «Эрдмийн анхны тахил гэдэг нь Чиги сүмд байдаг юм байна». «Хаана гэнэ э?» гэж Оливетти хашхирахад нь уурлаж байгаа нь мэдрэгдэнэ. «Ландон гуай хэлэхдээ ...» «Санта Мариа дэл Пополо! Умарш нэг бээр. Хүмүүсээ тийш нь аваачаарай. Дөрвөн минут дугуу байна шүү». «Хүмүүс маань энд байрлачихсан шүү дээ, би зүгээр л...» «Хөдлөөрэй!» гэж хэлээд Витториа утсаа таслав. Түүний араас, Ландон Пантеоны үүдэнд гарч ирлээ. Бүсгүй түүнийг шууд л гараас татан, замын хажууд зорчигч хүлээн зогсоо таксины цуваа өөд гүйлээ. Тэгээд, эхний таксины дэргэд ирж, дээрээс нь пад пад хийтэл цохилоход, унтаж байсан жолооч нь цочин сэрж, нойрмог нүдээр дүрлийлгэн гайхан ширтэнэ. Витториа хаалгыг нь тас хийтэл татаж онгойлгоод, Ландоныг дотор нь чихэж оруулаад, араас нь өөрөө үсрэн суулаа. «Санта Мариа дэл Пополо! Presto (Түргэлээрэй. ита)!» гэж хашхичлаа. Нойрмог дээрээ, бас цочиж айсан жолооч хаазан дээрээ хүчтэй жийхэд машин гудамж дагуу хурдлан одов.

Хэсэг 63

ВВС-ийн давчуухан машин дотор Чинита Макрийг цааш нь түлхэж суулгаад, Гунтер Глик компьютер дээрээ сууж, харин Чинита мөрөн дээрээс нь харан байв. «Би хэлээ биз дээ?» гэж Глик үглэн, хэдэн түлхүүр нэмж хайлтын зурвас дээр бичлээ. «Британ хов энэ

залуусын хойноос ганцаараа хөөцөлддөггүй байгаа биз?» Макри ойртож очоод, өнгийв. Гликийн зөв байлаа. ВВС-ийн алдарт сүлжээ сүүлийн арван жилд зургаан удаа Иллюминати хэмээн нууцлаг шашинлаг нийгэмлэгийн тухай мэдээ цацжээ. За, за, тэгвэл намайг нил өнгөөр будахгүй юу гэж Макри бодлоо. «Хэн гэж сэтгүүлчид энэ тухай бичсэн байна?» гэж асуугаад «Бодвол, яльтай яльгүй юмнууд л биз?» гэлээ. «ВВС яльтай яльгүй юмнууд авдаггүй л юм даа». «Тэр чамайг аваа биз дээ?» Глик хөмсгөө зангидсанаа: «Чи яагаад ойшоохгүй байгааг ойлгохгүй юм. Түүхийн туршид Иллюминатигийн тухай баримт зөндөө л байдаг даа» гэлээ. «Чөтгөр, Үл мэдэгдэх нисдэг биет, Лохнэсс нуурын мангасын тухай ч олон баримт байдаг юм». Глик мэдээнүүд уншиж сууснаа: «Чи Уинстон Черчилль гэж сонссон уу?» «Сонссон л юм шиг байна». «ВВС Черчиллийн тухай түүхэн теле-нэвтрүүлэг хийжээ. Чин сүсэгт католик хүн байж дээ. 1920 онд Черчилль Иллюминатиг шүүмжлэн, Британийн ард түмэнд түүний аюул заналаас сэрэмжилж явахыг сануулж байжээ.» Макри нэг л итгэж өгсөнгүй. «Хаанаас энэ тухай мэдээ вэ? Британи хов-оос уу?» Глик инээснээ: «Лондон Хэральд, 1920 оны 2 сарын 8» гэлээ. «Үгүй байлгүй дээ». «Тэгвэл нүдээ нээгээд харахгүй юу». Макри өлийн, компьютер рүү ойртлоо. *Лондон Хэральд, 1920 оны 2 сарын 8. Ойлгох юм алга даа.* «Черчилль параной байсан юм байлгүй дээ». «Ганцаараа биш юм аа» гэж Глик цааш нь уншингаа хэлэв. «Вудро Вильсон 1920 онд АНУ-ын банкны салбарт Иллюминатигийн нөлөө бэхжиж байгааг анхааруулсан гурван радио сурвалжлага өгсөн байна. Чи эхээр нь сонсох уу?» «Больё доо, чи минь». Тэгсэн ч, гэсэн Глик нэгийг нь тавьж сонсгов. Вудро Вильсон: «Тийм зохион байгуулалттай, тийм хорлонтой, тийм бүрэн төгс, тийм түлхэнгүй, өөрийг нь гүтгэж байхад нь өөдөөс нь няцааж чадахгүй тийм хүч, түүнээс өөр үгүй биз ээ» гэж байв. «Би энэ яриаг огт сонсож байгаа юм байна шүү». «Магадгүй чи 1921 онд дөнгөж хүүхэд байсан биз?» «Бас хөөрхөн гээч» гээд Макри Гликийг нудрав. Тэр хөгширч байгаагаа мэдэж байлаа. Дөчин гуравтай түүний өтгөн хар буржгар үс нь сааралтаж байлаа. Нүүрээ будахгүй гэх омголон хүүхэн билээ. Өмнөдийн Баптист эх нь Чинитаг өөрийгөө хүндэтгэн, даруу байхыг сургажээ. *Чи нэгэнт хар арьст хүүхэн учраас өөрийгөө хэн бэ гэдгийг нуух хэрэг огт байхгүй. Чи үхсэнийхээ дараа л өөрийгөө хүнээс нуугаарай. Цэх зогс, тод инээмсэглэ, ямар нууц чамайг инээлгээд байгаа юм бол гэтэл нь хүмүүсийг гайхуул* гэж ээж нь хэлдэг байсан нь санагдана. «Сэсиль Род гэж дуулсан уу?» гэж Глик асуув. «Британийн санхүүч үү?» гэсээр Макри толгой өндийлгөв. «Мөн, мөн. Родын сургалтын тэтгэлгийн санг байгуулсан». «Чи арай юу гэх гээгүй биз дээ». «Ай даа. Иллюминатус байжээ». «BS» «ВВС шүү. 1984 оны 11 сарын 16». «Манайхан тэрийг тэгээд Иллюминатус байсан гэж бичээд байгаа юм уу?» «Тэгж л байна даа. Тэгээд манайхан Родын сургалтын тэтгэлгийн санг хэдэн зуун жилийн өмнө байгуулагдсан ба дэлхийн хамгийн ухаалаг залуусыг Иллюминатигийн эгнээнд элсүүлэх зорилготой юм гэсэн байна даа» гэлээ. «Шал инээдтэй юм. Ах маань Родын сургалтын тэтгэлэг авч байсан юм чинь». Глик инээснээ: «Билл Клинтон ч гэсэн» гэлээ. Макри одоо уурлаж эхэллээ. Тэр ийм аахар шаахар сурвалжлагыг үзэж чаддаггүй байв. Тэр ВВС агентлаг бүх мэдээгээ нарийн хянуур судалж, шалгадаг гэж боддог байлаа. «Энд бас нэг юм байна» гэж Глик хэлэв. «ВВС, 1998 оны 3 сарын 5, Парламентын хорооны дарга Крис Муллин Британий парламентын гишүүдээс Масоны гишүүн хүн байвал, тэр тухайгаа зарлахыг шаардсан байна». Макри энэ тухай санаж байлаа. Энэ шаардлага бас цагдаа, шүүгч нарт бас хамаарч байлаа. «Яагаад дахин давтан ингээд байгаа юм бол?» Глик уншсаар л: «Масоны доторх нууц фракц манай улс төр, санхүүгийн системд ихээхэн нөлөөтэй болжээ». «Тэр үнэн шүү»: «Нэлээн үймээн тарьжээ. Парламент дахь масонууд үймээн гаргажээ. Тэгэхээс ч өөр аргагүй байж. Дийлэнхи

парламентын гишүүн Масоны сүлжээ, хандивын ажилд нь татагдаж элссэн, гэмгүй хүмүүс байжээ. Тэд тэр нөхөрлөлийн өмнөх түүхийг огт гадарладаггүй байсан байна». «Түүх гэгчийг нь». «За, за» гээд Глик цааш нь өгүүллээ уншив. «Энийг хар даа. Иллюминати хөвөрсөөр яваад бүр Галилей, Францын Гэрнэт, Испанийн Алумбрадос хүрч байна шүү дээ. Бүр Карл Маркс, Оросын хувьсгал хүртэл хамаатай болох нь». «Түүхийг байн байн шинээр бичдэг шүү дээ». «За тэгвэл, чи шинэ мэдээ хүсээ юм биз дээ? Энийг нэр хар даа. Уолл Стрийт Жоорнал-ын Иллюминатигийн тухай сүүлийн үеийн мэдээ». Макригийн анхаарлыг аргагүй татав. «Нөгөө алдарт сэтгүүл үү?» «Өнөөдөр ямар интернет тоглоом Америкт хамгийн их түгэж байна гээч?» «Памела Андерсоны сүүлийг хатга гэдэг тоглоом уу?» «Их л дөхлөө. Иллюминати: Дэлхийн шинэ дэг журам гэдэг гэнэ дээ». Макри итгэсэнгүй Гликийн мөрөн дээр нь тэгнэх шахуу, өлийн харвал «Стив Жаксон Тоглоом саяхан . . . түүхэн сэдэвт адал явдалт тоглоом гаргасан бөгөөд... Баварид үүссэн эртний сатаанлаг нөхөрлөл дэлхийг эзлэх гэж оролддог байна. Та энэ тоглоомыг онлайн аар ... аас авч болно...» Макри уншаад, өвчтэй юм шиг болчхов. «Энэ Иллюминати чинь христийн шашны эсрэг юу хийгээд байдаг юм бэ?» «Ганц христийн шашин биш бололтой. Бүх шашны эсрэг л юм шиг байна» гэж Глик хэлэв. «Гэхдээ утсаар ярьсан хүний яриаг бодоход тэд тухайлан Ватикантай ямар нэг тооцоотой юм шиг л байна даа». «За, боль доо. Чамтай утсаар ярьсан тэр залуу өөрийгөө танилцуулсан зоргоор нь чи үнэмшээд байгаа юм биш биз дээ?» «Иллюминатигийн элч гэж үү? Дөрвөн кардиналыг алах гэж байна гэж үү?» гэж Глик асууснаа, санаа алдан инээмсэглээд «Үнэмшээд л байгаа юм шиг байна» гэв.

Хэсэг 64

Ландон, Витториа хоёрын суусан такси Скрофа гудамжны өргөн замаар нэг бээр газрыг ганц минутын дотор л туулан ирлээ. Тэд дэл Попол буюу Ардын талбайн урд хэсэгт найман цаг болохоос арай өмнөхөн буулаа. Ландонд лийр байгаагүй болохоор жолоочид америк доллараар илэрхий давуу төлчхөөд, Витториатай хамт үсрэн гарав. Талбай нам гүм, зөвхөн Розати кафед суух хэдэн хүн инээн суухаас өөр чимээгүй байлаа. Агаарт гоймон, эспрессо кофе үнэртэнэ. Ландон Пантеоны талаар хийсэн алдааныхаа цочролоос гараагүй л байлаа. Гэхдээ, энэ талбайг зэрвэс ажигламагц зургаа дахь мэдрэхүй нь түүнд зөв газраа иржээ гэж хэлээд байв. Тэр чигтээ Иллюминатигийн бэлгэдлээр дүүрэн ч юм шиг. Талбай зууван хэлбэртэй, яг голд нь Египет гэрэлт хөшөөг санагдуулам дөрвөлжин чулуун хөшөөтэй, тэр нь яг пирамидыг тиг болгосон янзтай. Ромын эзэнт гүрний үед, Египетийг тоносны үр дүнд, пирамид энд тэндгүй тарсан бөгөөд пирамидын дээд хэсгийг дуурайлган тэнгэр рүү сүлбэсэн Ромын үеийн хөшөөг бэлгэдэл судлаачид «эрхэмсэг пирамид» гэдэг бөлгөө. Ландоны харц огт өөрчлөгдөлгүй гүйн явсан ч эцэстээ илүү ноцтой сонин зүйл дээр тогтов. Тэр тун өвөрмөц онцгой байлаа. «Бид зөв газраа ирчихжээ» гэж тэр намуухан дуугаар эргэлзээгүй хэллээ. «Тэрийг хар даа» гээд талбайн алс нөгөө захад байгаа Ардын хаалга гэх том чулуун гулдан хаалга руу заалаа. Сүрлэг гайхалтай энэ хаалга - энэ талбайг зуун зуун жилийн турш тэр өндрөөс ажигласаар ирсэн нь лавтай. Дааман хаалганы яг голд нь хамгийн дээд талд нэгэн бэлгэдэл дүрс байлаа. «Танил харагдаж байна уу?» Витториа тэр том сийлбэрийг өлийн хараад: «Гурван талт чулуун дээр од гэрэлтэж байгаа юм уу даа?» Ландон толгойгоо сэгсрэн: «Пирамидын дээр Иллюминатигийн тэмдэг байгаа юм» гэлээ. Витториа

эргэж харснаа, нүдээ томруулан: «АНУ-ын Төрийн их тамга шиг үү?» «Яг тийм. Нэг долларын дэвсгэрт дээрх масоны бэлгэдэл». Витториа гүнзгий амьсгаа аваад, талбайг бүхэлд нь ажиглангаа: «Тэр сүм нь тэгээд хаана байна аа?» гэв. Дэль Пополо талбай дахь Санта Мариагийн сүм яг л байрлалаа буруу эзэлчихсэн байлдааны усан онгоц шиг санагдах агаад талбайн зүүн өмнөд хэсгийн толгодыг нөмөрлөн хазгай байрласан ажээ. Арван нэгдүгээр зууны чулуун барилгын нүүрэн хэсэг өмнө нь угсарсан барилгын тавцангийн цаанаас улам ч болхи харагдана. Сүмийн зүг алхаж явахдаа, Ландоны толгойд элдэв бодол төрнө. Тэр сүмийг гайхан мэлэрнэ. Аллага, тэгээд, энэ дотор болох юм байх даа? Оливетти түргэн л ирээсэй. Хармаан дахь буу нь эвгүй санагдана. Сүмийн гол хаалгын шат их л найрсгаар урин дуудах авч, урд нь барилгын тавцан шат, багаж хэрэгсэл, **CONSTRUZIONE. NON ENTRARE** (Барилгын ажил, Орохыг хориглоно. Ита.) анхааруулга тэмдэг тавьчихсан болохоор нэг л нийцгүй харагдана. Энд барилгын ажил явагдаад, сүм хаагдсан нь илэрхий байлаа. Тэгэхээр, алуурчин ганцаараа ажиллахад тун саадгүй боломж нээжээ. Пантеонтой зүйрлэх ч юм биш. Ямар ч зальжин арга бодож олох шаардлага алга. Харин яаж ийгээд дотогшоо нэвтрэх хэрэгтэй л байлаа. Витториа хашааны завсраар юу ч бодолгүй шууд л гарч, шат өөр өгсөв. «Витториа» гэж Ландон дуудаад: «Тэр тэндээ байвал яах юм бэ?» гэлээ. Витториа сонссонгүй бололтой. Бүсгүй сүмийн цорын ганц үүдний өмнөх шатаар өгсөнө. Ландон араас нь яаран алхална. Түүнийг үг хэлж амжихаас нь өмнө бүсгүй хаалганы бариулд хүрээд татлаа. Ландон амьсгалаа даран зогсов. Хаалга онгойсонгүй. «Өөр газраар орж болдог л байж таарна даа» гэж Витториа үглэв. «Магадгүй» гэж Ландон хэлээд: «Гэхдээ, Оливетти удахгүй ирнэ шүү дээ. Ийшээ орно гэдэг тун аюултай. Хоёулаа сүмийг гадна талаас нь ажиглаад байж байя...» Витториа түүн рүү нүдээ эргэлдүүлэн харлаа. «Энд орж болох өөр газар байгаа бол гарч болж л таарна. Хэрэв нөгөө этгээд алга болчих юм бол, бид *fungito* шүү дээ». Итали хэлэндээ тааруу ч гэсэн Ландон түүний юу ярьж байгааг ойлгож байлаа. Сүмийн баруун талын нарийн зөрөг харанхуй, жижиг, хоёр талд нь өндөр ханатай ажээ. Тэндээс шээс үнэртэх агаад баар зоогийн газрын тоо нь нийтийн жорлонгийн тооноосоо хорь нэгийн харьцаатай олширчихсон хотод байдаг ерийн л үнэр билээ. Ландон, Витториа хоёр өмхий харанхуй руу яаран буулаа. Арван тав орчим дэлэм явсны дараа Витториа, Ландоны гарыг татаад, нэг зүг рүү заав. Ландон ч түүнийг харсан байлаа. Өмнө нь хүнд төмөр нугастай модон хаалга байлаа. Энэ бол стандарт *porta sacra* (ариун хаалга. Ита.) буюу лам нарын орж гардаг хувь хаалга байлаа. Үүгээр нь хулгай ордог, мөн таагүй гудамж руу харсан илүү хаалга үл хөдлөх хөрөнгийнх нь үнийг унагадаг болохоор ийм хаалгыг одоо нэгэнт шаардлагагүйд тооцдог болжээ. Витториа хаалга руу түргэн дөхлөө. Тэгээд, хаалганы бариул хайн харж зогсохдоо илэрхий мэгдсэн байв. Ландон ард нь ирээд, бариул байх ёстой газар нь дугуй төмөр цагираг байхыг харлаа. «Анулус гэдэг юм» гэж тэр шивнэв. Ландон цагиргийг гартаа бариад, аажуухан өргөж, татав. Хаалга чад гээд онгойсонгүй. Тэгэхээр, цагиргаа нар дагуулан зөөлхөн эргүүлэв. Цагираг саадгүй эргэсээр 360 хэм бүтэн эргэлээ. Гэхдээ, цоож мултрах чимээ гарсангүй. Ландон гайхаад, дахин нөгөө тал руу нь эргүүлсэн ч бас нэмэргүй. Витториа гудамжны нөгөө өнцөг рүү хараад: «Өөр газраар орж гардаг юм болов уу?» гэв. Ландон үгүй л байх даа хэмээн бодно. Сэргэн мандлын үеийн дийлэнх сүм хотыг эзэлсэн тохиолдолд, бэхлэлт болгон ашиглахаар баригдсан байдаг. Тиймээс, аль болохоор цөөн хаалгатай байдаг ажээ. «Хэрэв өөр хаалга байгаа бол байшингийн ар талд, ханан хөндийн дагуу зугтах гарц маягийн зүйл байх ёстой» гэлээ. Витториа аль хэдийн явж одсон байв. Ландон түүнийг даган, харанхуй нарийн гудамжаар алхлаа. Хоёр талд нь өндөр босоо хана байх ажээ. Гэнэт найман цаг болсныг мэдэгдэн, дохио дуугарав. Роберт Ландон Витториаг

анх дуудахад нь сонссонгүй. Тэр төмөр саравчтай цонхоор сүмийн доторхыг харах гэж оролдон шагайсаар хоцорчээ. «Роберт» гэж Витториа арай чангахан дуудлаа. Ландон түүн рүү харав. Витториа гудамжны үзүүрт зогсчихсон, нэг гараа даллан, нөгөө гараараа доошоо зааж байв. Ландон түүн рүү дурамжхан гүйсээр очив. Арын хананы суурь хэсэг, том гэгч чулууны ард байшингийн суурь руу ордог жижиг хаалгыг халхлан байлаа. «Үүд юм уу даа?» гэж Витториа асуув. Ландон толгойгоо дохив. *Уул нь ч гарц л даа, гэхдээ техникийн хувьд ялгаагүй.* Витториа өвдөглөж суугаад, завсраар нь шагайна. «Хаалгыг нь шалгая, онгорхой байна уу, үгүй юү?» Ландон орох гэтэл Витториа түүний гарыг нь татаад, урдуур нь ухасхийв. «Байз!» гэж Ландон хэлэв. Бүсгүй түүнийг байн байн болгоомжлоод байгаад унтууцсан байртай, эргэн харлаа. Ландон шүүрс алдаад: «Би эхэлж оръё» гэв. Витториа гайхан хараад: «Хөлөг баатрын ёс уу?» гэж асуулаа. «Хөөрхнөөрөө биш нас намбаараа эхэлье» гэлээ. «Найр тавьж байгаа хэрэг юм уу?» Ландон инээвхийлээд, хажуугаар нь гарч, харанхуйд уусан одов. «Шатаар болгоомжтой буугаарай» гэх сонсогдоно. Тэр нэг гараа хананд наагаад, харанхуйд ямх ямхаар урагшилж байлаа. Хурууных нь үзүүрт хатуу чулуун ирмэг мэдрэгдэнэ. Тэр эгшинд тэр Дэдэлусийн домгийг саналаа. Минотаврын төөрдөг байшингаас гарахын тулд гараа хананаас салгахгүй явахыг залуу хүүд сануулсан, агаад тэр ёсоор явсаар хаалганд нь хүрсэн гэдэг. Ландон аажимхан урагшилж байсан боловч эцэст нь хүрмээр байгаа эсэхээ мэдэхгүй л байлаа. Хонгил яльгүй нарийхан болж, Ландон улам ч аажуухан алхана. Витториа яг ард нь явааг нуруугаараа мэдэрч байлаа. Хана зүүнш тохойрон эргэж, хагас дугуй хэлбэртэй болжээ. Тэрүүхэнд жигтэй бүгээн гэгээ тусна. Тэр гэгээнд Ландон хүнд модон хаалга олж харлаа. «Хөөх!» гэж Ландон хэлэв. «Цоожтой байна уу?» «Тийм байсан юм шиг байна аа». «Байсан юм шиг гэнэ ээ» гэснээ, Витториа дэргэд нь зэрэгцээд ирлээ. Ландон цоож руу заав. Хаалга хагас онгорхой, дотроос нь бүгээн гэгээ гарна. Цоожийг эвдсэн лоомын ором хаалганы модонд шинээрээ байх. Тэр хоёр хэсэг чимээгүй байлаа. Хормын дараа, Ландон Витториагийн гар цээж рүү нь зөөлөн дөхөж, пиджакийнх нь дотоод энгэрт ирэхийг мэдрэв. «Тайвшир, профессор оо. Би зүгээр л буу авах гэж байна» гэж тэр хэлэв. Тэр үед Ватиканы музей дотор, Швейцар жардын томилгоот баг бүх чиглэлд тарж одлоо. Музей харанхуй, харуулууд АНУ-ын тэнгисийн явган цэргийн шөнийн харааны шил зүүжээ. Тэр шил бүх юмыг ногоон туяатай харагдуулна. Бүх харуул урдаа антен мэт зүйл барьж, түүнийгээ сурмаг гэгч нь байн байн дохилзуулах бөгөөд чихэндээ тэр антен мэт зүйлтэйгээ холбоотой жижиг чихэвч зүүжээ. Тэд хөшөө, ханан хөндий, шүүгээ, тавилгын доогуур дадамгай гэгч шалгана. Бага ч атугай соронзон талбай олмогцоо, антен дуугарч дохио өгөх бөлгөө. Гэхдээ, энэ шөнө тийм дохио сонсогдохгүй бололтой байв.

Хэсэг 65

Санта Мариа дель Попологийн дотоод байдал - бүдэгхэн сүүмийх гэрэлд барьж эхлээд хаячихсан метроны буудал шиг л харагдана. Гол танхимд нь есөн жорын хог хөглөрч, ховхорсон шал, тоосгоны овоолго, шороон овоо, түрдэг тэрэг, бүр зэвэнд идэгдсэн зээтүү хүртэл хэвтэнэ. Аварга том баганууд шалнаас эгц дээш босч асар том дээврийг нь бат нот тулна. Хуруу зузаан тоос болсон шилний цаанаас бүдэгхэн ёлтойх гэрэлд шавар, шорооны хуурай үнэр агаарт ханхийнэ. Ландон хана туургыг нилд нь бүрхсэн Пинтуричиогийн зүмбэрийн өмнө Витториатай зогсоод, тахилын гол ширээ рүү мэлрэн байв. Юу ч эс хөдөлнө. Үхмэл аниргүй. Витториа буугаа хоёр гараараа бариад өмнөө зэхжээ. Ландон цагаа харвал 8:04 болж байна. *Энд зогсч байдаг бид ч солиотой хүмүүс юм аа. Аюултай шүү дээ.* Хэрэв алуурчин энэ дотор байгаа хэвээрээ бол тэр дуртай хаалгаараа гарч ирнэ: харин өөдөөс

нь ганц буутай зогсож байна гэдэг тийм ч их үр дүнтэй байж чадахгүй байлаа. Түүнийг дотор байхад нь барьж авах бол цорын ганц боломж: гэхдээ тэр энд байсаар байгаа эсэхийг мэдэхгүй билээ. Ландон - хүмүүсийг Пантеонд аваачаад, алуурчныг зогсоох цорын ганц боломжийг алдагдуулсан, бүх хүнийг төөрөлдүүлж орхисон - ганц гэмтэн болоод байлаа. Витториа сүмийг бүхэлд нь зэрвэс ажиглаад: «За тэгэхээр Чиги сүм гэдэг нь хаана байна вэ?» гэлээ. Ландон бүгээн саарал гэрэл дунд, сүмийн гадна ханыг тойруулан харав. Сэргэн мандлын үед нэг том дуган дотор, хэдэн хэдэн сүм байсан агаад Нотре Дам мэт том сүм дуганд бүр арав гаруй жижиг сүм оршдог байв. Тийм жижиг сүм том дуганыхаа дотор өрөө, булан, хүнхэг, гонхонд нь байрлаж, хана, ханын хөндийгөө дагуулан булш бунхнаа байрлуулдаг байжээ. Ландон ханын дагуу дөрвөн өрөө маягийн гонхон байх, тэнд нийт найман сүм багтаж болохыг хараад *муу л мэдээ байна даа* гэж бодлоо. Найм гэдэг тийм ч их тоо биш. Гэхдээ барилгын ажил хийж байгаа болохоор: дотор нь байгаа булшийг тоос шорооноос хамгаалах гэж бүх гонхонг зузаан тунгалаг хулдаасан хөшгөөр хааж - хаана юу байгааг нь мэдэхийн тулд нэг нэгээр нь шалгахаас өөр аргагүй болжээ. «Хөшиг татсан энэ гонхонуудын аль нь ч байж магадгүй» гэж Ландон бувтнана. «Аль нь Чиги сүм бэ гэдгийг мэдэхийн тулд бүгдийг нь шагайж харах л хэрэгтэй болно доо. Тэгэхээр Оливеттийг хүлээвэл...» «Хоёр дахь зүүн хагас нь аль вэ?» гэж Витториа асуув. Ландон түүнийг хүн бүр мэдээд байдаггүй архитектурын тодорхой нэр томъёог их л итгэл төгс хэлэхээр нь гайхан харлаа. «Хоёр дахь зүүн хагас нь аа?» Витториа ард нь байгаа ханыг заав. Угалзалсан зүмбэртэй тэр ханан дээр сүмийн гадаа хаалган дээр харсан гэрэлт одтой пирамидын дүрс байлаа. Хажууд нь байх пайз дээр: Александр Чигигийн сүлд Түүний булш Энэ сүмийн хоёр дахь зүүн хагаст буй гэж бичсэн байв. Ландон толгой дохив. Чигигийн сүлд нь одот пирамид байсан байх даа. Гэнэт, тэр Чиги гэгч баян тэтгэгч хүн өөрөө Иллюминатус байсныг ухаарлаа. Тэгээд, Витториа руу харж толгой дохиод: «Сайн байна шүү, Нанси Дрю» гэлээ. «Юу?» «За, за. Зүгээр л...» Гэнэт . . . төмрийн жижиг хэлтэрхий тэднээс дэлэм зайтай тан хийн унахад, бүх сүм даяар цуурайтан царгив. Дуу гарсан зүг Витториа бугаа онилох зуур Ландон түүнийг тэврэн ойролцоох баганын цаагуур татан орууллаа. Цуурай алслан одоход, дахиад л анир чимээгүй болов. Тэд хоёр амьсгаа даран түр хүлээв. Дахин чимээ гарлаа, гэхдээ юм чирэх мэт чимээ гарав. *Энд ирдэггүй л байж* гэж Ландон бодно. Чимээ ойртсоор, гэхдээ, пад пад гэх чимээг нь сонсвол энэ хүн доголлон болтой. Гэнэт баганын доод хэсгээр нэгэн зүйл гарч ирлээ. Figlio di puttana! гэж Витториа хараасаар багана руу нуруугаараа наалдахад, Ландон ч бас биеэ шахан наалаа. Баганын цаанаас, хачиртай талхны хаягдал цаасан дээр чирсэн аймаар том харх гараад ирэв. Харх тэр хоёрыг гэнэт анзаарч, тэдэн рүү, ялангуяа Витториагийн барьсан бууны гол төмөр рүү баахан харж байснаа, нэг их тоосон шинжгүй нөгөө талхаа чирсээр одов. «Чөтгөр авмар!» хэмээн Ландон хараал тавихад, зүрх нь байдгаараа дэлсэж байлаа. Витториа бугаа буулгаад, хэвийн байдалдаа оров. Ландон баганын цаанаас шагайн, ажилчин залуугийн идээд хаясан хоолны үлдэгдэл шалан дээгүүр тарж орхисныг харлаа. Ландон, сүмд өөр ямар нэг хөдөлгөөн байгаа эсэхийг хянаад: «Хэрэв энд алуурчин байгаа бол энэ чимээг сонссон л байж таарна. Тэгэхээр, Оливеттийг хүлээсэн нь дээргүй юу? Чи нээрэн өөрсдөө явья гээд байна уу?» гэж асуув. «Хоёр дахь зүүн хагас гэж хаана байдаг юм бэ?» гэж Витториа тулгаж асуулаа. Ландон эргэж ажилдаа орлоо. Сүмийн нэр томъёо гэж яг л тайзных шиг дандаа урвугаараа ойлгогддог ажээ. Тэр гол тахилын өмнө очиж, тийш нь нүүрээ харуулан зогсов. Тайзны гол. Тэгээд, эрхий хуруугаа мөрөө давуулан заалаа. Тэгээд, хоёулаа зэрэг эргэж хараад, хаашаа зааснаа ажиглав. Чиги сүм, баруун талын дөрвөн гонхоны гурав дахид нь байсан бололтой. Тэр хоёр сүм дотроо зөв талдаа, гэхдээ өөр үзүүрт нь зогсож байлаа.

Тийшээ очихын тулд, сүмийг хөндлөн гулд туулж, гурван гонхон өнгөрөн, яг л Чиги сүм шиг хулдаасан хөшгөөр халхалсан талбайгаар явах хэрэгтэй байв. «Байзаарай!» гэж Ландон хэлээд: «Би түрүүлээд явья» гэлээ. «Боль доо». «Би Пантеон руу үймүүлж дагуулсан хүн шүү дээ». Бүсгүй эргэж хараад: «Гэхдээ надад буу байна шүү дээ» гэлээ. Түүний нүднээс Ландон юу бодож байгааг нь харж байлаа.

Би аавыгаа алдсан. Би үй олноор хөнөөх энэ зэвсгийг хийлцсэн. Энэ этгээдийн булаасан юм болгон минийх байсан юм... Ландон түүнийг зогсоох нь нэмэргүй юм гэдгийг мэдээд, араас нь дагав. Бүсгүй болгоомжтой зөөлөн алхлан, сүмийн зүүн талаар алхаж явлаа. Хөшиг татсан эхний хөндийг өнгөрсний дараа, Ландон тэмцээнт тоглоом тоглож байгаа юм шиг хөвчрөөд явчлав. *Гурав дахь гонхонд би эхэлж очно доо* гэж бодлоо. Сүм дотор аниргүй, зузаан чулуун хана гаднах дуу чимээг огт үл нэвтрүүлнэ. Тэд нэг сүмээс нөгөө рүү шилжин өнгөрөх зуур, тэдний дүрс гялгар хөшгөн дээр тусч, хумирахад нь яг л хий үзэгдэл шиг дэрвэгнэх ажээ. Цаг 8:06 болж байлаа. Алуурчин цагийнхаа хуваарийг ягштал баримтлан, Ландон, Витториа хоёрыг ирэхээс өмнө ажлаа амжуулчихаад, арилаад өгөө болов уу? Эсвэл тэндээ байсаар байгаа болов уу? Ландонд аль нь таалагдахыг мэдэхгүй л байлаа. Тэр хоёр дахь хагасыг туулан явах зуур, сүмийг муу ёрын харанхуй дарж эхлэв. Тоос шороо дарж хөгцөрсөн цонхны цаана наран шингэж, шөнө юу юугүй нөмрөн авлаа. Тэднийг урагш зүтгэх зуур, ард нь том хүнд хулдаасан хөшиг гэнэт намиран хөдлөх шиг болов. Ландонд, хэн нэгэн хаа нэгтээ хаалгаар гараад явчлав уу даа гэж санагдлаа. Витториа гурав дахь хонгилын өмнө очлоо. Тэр буугаа өмнөө бариад, толгойгоо хандуулсан зүг рүүгээ онилон явна. Боржин чулуун ханан дээр Чиги Сүм гэсэн хоёр үг сийлжээ. Ландон толгой дохив. Тэр хоёр том гэгч баганын цаагуур орж биеэ далдлан, онгорхой булан руу дөхөв. Витториа буугаа бэлэн бариад, хулдаасан хөшигний наана зогсжээ. Тэгээд Ландон руу хандан: «Хөшгийг өргө!» гэж дохив. Бурхан минь гэж Ландон дотроо залбирна. Тэгээд, аажуухан бүсгүйн хажууд ирээд, мөрөн дээгүүр нь хөшгөнд хүрэв. Хүнд хулдаасан хөшгийг хэрээрээ л аяархан нээх гэсэн боловч хөшиг ганц хуруу хэртэй онгойхдоо сүрхийн чахран дуугарлаа. Тэр чимээнд нь, тэр хоёр хөшиж орхив. Дахин анир чимээгүй болов. Хормын дараа Витториа болгоомжтой ёо урагшлан, хөшгөн завсраар шагайлаа. Ландон ч мөрөн дээгүүр нь бас өнгийнө. Хором хэртэй, тэр хоёр амьсгаа даран анав. «Хоосон байна» гэж Витториа хэлээд буугаа буулган: «Хоцорчихлоо» гэв. Ландоны ухаан санаа огт өөр ертөнц рүү эгшин зуур арилж одсон болохоор бүсгүйн хэлснийг сонссонгүй. Сүм ийм байж болох юм гэж тэр төсөөлж ч байсангүй. Бор боржингоор өнгөлсөн Чиги сүм гоц содон байлаа. Ландон юм мэддэг хүний нүдээр бүхнийг ажиглана. Галилей ч юм уу, ер нь иллиуминатигийнхан өөрсдөө энэ сүмийн зургийг гаргасан болов уу гэмээр тийм шороон харагдаж байлаа. Таазан дээр гэгээрлийн зүг чиглүүлэх оддыг дүрсэлж, одон зурхайн долоон гаригийг бас зуржээ. Доогуур нь одон зурхайгаас үүссэн шороон тэмдэг гэх арван хоёр ордны бэлгэ байна. Тэдгээр орд шороо, хий, гал, ус дөрвөн махбодод шүтэлцэх агаад махбод тус бүр чадал, оюун, сэтгэл, догдлолыг илэрхийлнэ. Шороо бол чадал юм хэмээн Ландон саналаа. Хананы тэртээ, Ландон шороон бэлгийн дөрвөн улирал *primavera, estate, autumn, inverno (uma, Хавар, зун, намар, өвөл)* - ыг дүрсэлжээ. Тэр сүмийн зайг бүхэлд нь дүүргэсэн хоёр баримлыг бүр гайхавч баршгүй байлаа. Ландон тэр хоёрыг удаан мэлрэв. *Үгүй байлгүй дээ! Ийм юм бас байдаг аа?* Гэхдээ байж л байлаа. Сүмийн хоёр талд харилцан тэгш хэмтэй арван тохой өндөр боржин пирамид байв. «Кардинал байхгүй л байна даа» гэж Витториа шивнэв. «Алуурчин ч бас алга» гээд тэр хулдаасан хөшгийг яран, дотогш оров. Ландоны нүд тэнд байгаа хоёр пирамидаас салж чадсангүй. *Христийн сүмд пирамид юу хийж байгаа юм бол оо?* Гайхалтай юм үүгээр зогссонгүй. Пирамид тус бүрийн яг зүрхэн тушаа нүүрэн талд зууван хэлбэртэй алтан зүмбэр байлаа. Ландон тийм юм цөөхөн үзсэн билээ. Тэр зүлгэж өнгөлсөн зууван дээр шингэж буй нарны улаан туяа ойж таазан дээгүүр цацарна. *Галилейн зууван? Пирамид? Одот тааз?* Ландон үүнээс илүү «иллюминативаг» байх сүм төсөөлж ч чадахгүй байв. «Роберт!» гэж гэнэт Витториа дуудаад: «Хар даа» гээд нэг тийшээ заав. Ландоны оюун санаа арай л гэж

бодит байдалдаа эргэн ирж, Витториагийн заагаад байгаа зүг харав. «Цуст там!» гэж тэр цочин хашхираад, арагш ухрав. Шалан дээр гайхалтай нарийн дүрсэлсэн араг ясны зураг байх ба нүдгүй хоосон ухархай нь тэр хоёрыг нэвт ширтэнэ. Гантиг шигтгэж хийсэн тэр шигтгэмэл «нисэн яваа үхэл»-ийг бэлгэддэг ажээ. Араг яс том хавтан тэвэрч, тэр хавтан дээр яг гадаа байсан шиг пирамид, од хоёрыг зурсан байлаа. Гэхдээ, энэ зургаас Ландон айсангүй. Тэр зургийг том дугуй чулуун дээр шигтгэсэн: харин тэр дугуй чулууг шалнаас нь ховхлоод өргөөд тавьчихсан, доор нь том харанхуй нүх ёрлон харагдана. «Чөтгөрийн цооног» гэдэг нь хэнд ч ойлгомжтой байв. Ландон таазыг нь мэлрээд байснаас, тэр нүхийг анзаараагүй ажээ. Тэр нүх рүү нэг алхав. Тэндээс тэвчихийн аргагүй өмхий ханхална. Витториа алгаараа хамраа дарна. «Che puzza!» «Effluvium» гэж Ландон хэлэв. «Илжирсэн яс үснээс ялгарсан уур савсаж байгаа нь энэ». Тэр ханцуйгаараа хамраа таглан амьсгалаад, нүхэн дээгүүр өнгийн харав. Түнэр харанхуй нүх. «Юу ч харагдахгүй байна». «Тэнд хүн байгаа болов уу?» «Мэдэх аргагүй юм аа». Витториа нүхний нөгөө тал руу дөхвөл, тэр доор модон шат байхыг олж харав. Ландон толгойгоо сэгсрээд: «Там л гэсэн үг шүү дээ» гэв. «Гадаа байгаа багаж дунд гар чийдэн байгаа болов уу?» Бүсгүй тэр нүхнээс ханхлах өмхий үнэрээс халшрах шинжгүй ажээ. «Би хараадахъя». «Болгоомжтой» гэж Ландон сэрэмжлүүлэв. «Алуурчин энэ доор байгаа гэж бид хоёр ...» Витториа түүнийг сонсолгүй алхална. Зориг төгс хүүхэн шүү гэж Ландон бодлоо. Ландон нүх рүү эргэж хартал, толгой нь эргэх шиг болов. Тэгээд, амьсгалаа түгжээд толгойгоо бөхийлгөн, нүхний гүн рүү ширтлээ. Аажимдаа нүд нь харанхуйд дасч, тэр доор ямар нэг юм байгаа бүүдгэр дүрс олж харлаа. Цооног жижигхэн өрөөний хаалга маягтай эд ажээ. Чөтгөрийн цооног. Чигигийнхний хэдэн үеийг энэ дор ямар ч ёслол хүндэтгэлгүй хаяж орхио бол доо? Ландон нүдээ аниад, бүрэлзэхээ болихыг нь хүлээн азнав. Нүдээ дахин нээхэд, түнэр харанхуй дунд нэгэн бүүдгэр дүрс бүртийн үзэгдэнэ. *Би юм хараад байх шиг байх юм. Энэ тэгээд хүүр нь юм болов уу?* Дүрс их бүүдгэр байлаа. Ландон нүдээ дахин аниад, арай илүү удаан азнаж, харанхуйд ямар нэг юм олж харахыг зорино. Нүд нь эрээлжилж, бодол нь тэр харанхуйд юу байгааг олоод харчих юм сан хэмээн хичээнэ. Дахиад хэдхэн секунд. Энэ өмхий уураар амьсгалснаас болоод юм уу, эсвэл толгойгоо хэт их бөхийлгөснөөс болов уу ямартай ч дотор нь муухай оргиж, бөөлжис нь цутгаж байлаа. Эцэст нь нүдээ нээж, аймаар зүйл олж харав. Тэр харанхуй дотроос өмхий нүхний байр байдлыг олж харлаа. Бүдэгхэн исгэрээ чихэнд нь сонсогдоно. Бүүдгэр гэгээ нүхний ханыг бүртийлгэн харагдуулна. Гэнэт, дээр нь том хар сүүдэр гараад ирэв. «Хар даа» гэж ард нь хүн хэлэв. Ландоныг эргэж харж амжаагүй байтал хүзүү нь шархийтэл түлэгдээд явчихлаа. Витториа хүзүүн дээр нь унасан цогийг гөвөх гэж оролдон, гартаа байгаа бамбараа ийш тийш савлах тоолон сүмийн дотор талыг цэнхэр өнгө цэлэлзүүлнэ. Ландон хүзүүгээ дарснаа: «Яаж байгаа юм бэ, чи?» гэв. «Чамд л гэрэлтүүлж өгөх гэж байсан шүү дээ. Тэгсэн чинь, чи өөдөөс өндийгөөд ирсэн» гэв. Ландон бүсгүйн гартаа барьсан бамбарыг нь харна. «Гар чийдэн алга. Байгаа нь л энэ байна». Ландон хүзүүгээ үрээд: «Чамайг ирж явахыг чинь сонссонгүй». Витториа түүнд бамбараа өгөөд, нөгөө өмхий нүх рүү өнгийснөө: «Экэ савсаад байгаа уур нь шатдаг юм биш байгаа даа» гэлээ. «Үгүй л гэж найдахаас». Ландон бамбараа бариад: нүх рүү аажим дөхөв. Амсар дээр нь очоод бамбараа тонгойлгон, нүхний дотор талыг зэрвэс ажиглалаа. Нүх дугуй хэлбэртэй, хорин тохой орчим өргөн ажээ. Гучин тохой орчим доор шаварлаг ёроолоос уур савсана. Шороон махбод. Удалгүй Ландон нэг хүүр олж харлаа. «Хүүе, тэнд байна» гэж Ландон зөнгөөрөө хэлээд ухасхийв. Харанхуйд хүний бололтой дүрс сүүмийх агаад нүцгэн харагдана. «Нүцгэлчихсэн юм шиг байх юм» гэж Ландон хэлэв. «Нөгөө кардиналуудын нэг үү?» Өөр хэн л байх аж дээ гэж Ландон бодлоо. Лаг шаварт шигдсэн тэр

дүрс рүү улам бүр өнгийнө. Дүрс огт хөдлөхгүй, амьгүй үзэгдэнэ. Гэхдээ бас л хачирхалтай санагдана. Ландон: «Хүүе!» гэж дуудлаа. «Амьд байгаа юм шиг байна уу?» Доороос хариу огт өгсөнгүй. «Хөдлөхгүй байна аа. Гэхдээ ... сонин юм даа» Витториа араас нь өндөлзөн: «Яасан бэ?» гэв. Ландон тогтоож харахыг оролдон: «Зогсож байгаа юм шиг харагдаад байх юм» гэв. Витториа бүр сонирхон, нүхний амсраас өнгийн байж харах гэж оролдлоо. Тэгснээ, өндийж суугаад: «Тийм байна. Зогсоогоороо байна. Амьд, тусламж хэрэгтэй байж магадгүй байх аа» гэлээ. Тэгснээ, дахиж тонгойгоод «Хүүе! Mi puo sentire?» Өмхий самхай ханхалсан том нүх аниргүй хонхойно. Витториа хөлөө шат руу буулган: «Би орлоо» гэхэд нь Ландон гараас шүүрээд: «Аюултай шүү дээ. Би орьё» гэлээ. Витториа татгалзсангүй.

Хэсэг 66

Виа Томачеллигийн буланд зогсоо ВВС-ийн мухлаг тэргийн хажуугийн суудалд шигдэн суусан Чинита Марчи солиорох шахаад байв. Гунтер Глик юм хайгаад олохгүй байгаа бололтой, Ром хотын газрын зургийг эргүүлж тойруулан сууна. Гэтэл, утас дуугарч нөгөө хүн Гунтерт чухал мэдээ хэлж байгаа бололтой. Глик утсаа тавингаа эргэж хараад: «дель Пополо талбайд нэг сүм байгаа гэнэ. Тэнд л нөгөө хайгаад байгаа нотолгоо маань байгаа гэнэ дээ». «Нотолгоо гэнэ ээ?» гээд Чинита камерынхаа линзийг зүлгэж байснаа больж, биеэрээ Глик рүү эргэж хараад: «Кардиналыг цааш нь харуулсан тухай нотолгоо юу?» гэж тохуурхангуй хэлэв. «Тэгж л сая надад хэллээ шүү дээ». «Сонссон болгондоо итгэдэг юм уу, чи хөөрхий» гэж Чинита зэмлэнгүй хэллээ. Чинита өөрөө бараг л сонссон болгондоо итгэдэг гэж зэмлүүлдэг нэгэн боловч энэ удаа өөр нэгнийг ингэж зэмлэх завшаан тохиосонд баярлаж орхилоо. Зураглаач гэдэг хүн сурвалжлагчийнхаа тэнэг юм ярьж байгааг үг дуугүй бичиж зогсдог нэгэн болохоор хэрэгтэй хэрэггүй утасны дуудлага хөөцөлдөн гүйх Гунтер Гликийг Марчи уяатай нохой шиг л дагаж гүйх ёстой байлаа. Глик жолооны ард суухдаа, зөнгөөрөө шүдээ зуурчихсан байв. «Энэ залууд Гунтер Глик гэдэг нэр өгсөн тэр шооч хүнд эцэг эх нь лав уурласан байх даа. Ийм тэнэг нэртэй болохоороо өөрийгөө мундаг гэдгийг нотлох хэрэгтэй болдог байж таарна. Шалихгүй байж, мундаг шуугиан тарьчих санаатай үхэн хатан гүйгээд байдаг болохоос, уул нь Глик гайгүй залуу байлаа. Яг л Хью Грантын гэрэлтдэг самбар шиг. Адал явдал хөөж гүйдэг мангар банди. » «Хоёулаа Гэгээн Петерийн талбай руугаа буцсан нь дээргүй юу» гэж Марчи эелдэг байх аядан асуув. «Хоёулаа тэр хэргийг чинь дараа хөөцөлдөж болон шүү дээ. Цуурган цагийн өмнө эхэлсэн юм чинь **бид хоёрыг байхгүй үед кардиналууд шийдвэрээ гаргачихвал яах юм бэ»** гэлээ. «Хоёулаа энд барууншаа эргэх ёстой байх аа» хэмээн Глик огт сонссон царайгүй, газрынхаа зургийг эргүүлж тойруулан сууна. «Одоо баруунш эргэх юм бол, яг одоо зүүншээ эргэх ёстой юм байна» гээд нарийхан гудамж руу заалаа. Марчи: «Хүүе, чи аан гэж бай!» гэж бараг л хашхирах шахахад, нүд нь уурандаа улангасан, заамдаж авах шахлаа. Энэ зуур, Глик гэнэт хөлөө жийн тоормос дээр гишгэмэгц, урдуур нь Альфа Ромео маркийн дөрвөн машин шуртхийн гарч ирээд бараг л шүргэчих шахлаа. Тэгснээ, хавчиг гудамж дундуур огцом эргээд, Гликийн явах гэж байсан тэр замаар сүлжин алга болов. «Мэдрэл муут!» гэж Марчи хашхирна. Глик тоосон ч үгүй: «Саяынхыг харав уу» гэлээ. «Тэглээ, харлаа. Бид хоёрыг алчих шахлаа». «Үгүй ээ, тэр машинуудыг харав уу. Бүгдээрээ адилхан байгаа биз?» «Мэдрэл муутай юмнууд л байна». «Пиг дүүрэн чихсэн байсан, тийм үү?» «Тэгээд юу гэж?» «Дөрөв дөрвөн хүнтэй дөрвөн ижилхэн машин?» «Дүүрэн явж болдог гэж

мэддэггүй юм уу, чи?» «Италид уу?» гэж Глик хэлэнгээ, замын хоёр талыг болгоомжлонгуй хараад: «Тэд чинь өндөр фракцтай бензин гэдгийг ч мэддэггүй хүмүүс шүү дээ» гэснээ хурдаа, гэнэт, гэдрэг унатар нэмлээ. Макри суудлынхаа ар руу гэдэгсхийнгээ: «Яаж байна аа, чи чинь» гэсэнд Глик нөгөө дөрвөн Альфа Ромеогийн араас хурдлах зуураа: «Тэр сүм рүү зөвхөн чи бид хоёр явж байгаа биш бололтой шүү» хэмээн улангасан инээж явлаа.

Хэсэг 67

Ландон аяархан доошилно. Гишгүүр гишгүүрээр доошлоход шат чахран, Чиги сүмийн харанхуй, өмхий ёроол руу алхам алхам ойртоно. Чөтгөрийн цооног ... Нүхний хана руу харан аажим доошлоход, ямар гүнзгий нүх вэ хэмээн бодогдоно. Шат чахран доошлох тусам илжирсэн хүний мах, өмхий самхай ханхлан, бөглөрч үхмээр санагдаж, Оливетти хаана байгаа золиг вэ гэж эрхгүй бодогдоно. Витториа бамбараа доошлуулан, Ландоны замыг гэрэлтүүлэх гэж оролдож байгаа нь дээр харагдана. Доошилж явахад, дээрээс тусах цэнхэр гэрэл сааралтан, өмхий самхай нь бөглөрч үхмээр болж байлаа. Арван хоёр дахь гишгүүртээ хүрмэгцээ, Ландон гэнэт халтирч орхилоо. Шингэн шавар наалдсан тэр гишгүүрээс хөл нь халтирмагц, шатнаас гараараа зуурч, шуугаараа тулан арай гэж тогтов. Тэгээд, хөлөө буцааж гишгүүр дээр бат нот тавьж, шатаа хараасаар дахин доошиллоо. Гурван гишгүүр яваад, Ландон дахиад л унах шахлаа. Гэхдээ, энэ удаад халтирч биш, харин цочиж хэлмэсэндээ унах шахав. Нэг гараараа шатнаас барьж, нөгөөгөөрөө хана түшин явсан түүнд гэнэт тавиур дүүрэн гавлын яс тэмтрэгдэх нь тэр. Ландон зогтусан, орчноо сайтар ажвал, түшиж байсан хана нь энэ төвшнөөс доошоогоо нас барагсдыг эгнүүлэн оршуулсан гонх байхыг ухаарав. Дээр гэрэлтэх туяанд, хувхай араг ясны бөөн эгнээг харвал муу ёр даллах мэт зэвхий даах ажээ. *Араг яс, зулын гэрэл.* Сарын өмнө, Ландон иймэрхүү газар очсоноо гэнэт санав. *Яс, галын үдэш.* Нью Йоркийн Археологийн музейд сан арвижуулах хүлээн авалт зохион байгуулахад тэр тэнд оролцжээ. Бронтозаврын том том ясан дунд жижигхэн лаа асаасан байсан нь санагдах бөгөөд тэнд өмнө нь загварын шоунд хувцас өмсдөг байсан, одоо Таймс сэтгүүлд урлагийн шүүмж бичдэг Ребека Страус гэх эмэгтэйтэй танилцаж байлаа. Аятайхан цээжтэй, хар торон эмжээртэй палааж өмсөж, тамхи зуусан тэр авхай танилцсаныхаа дараа Ландон руу хоёр ч удаа утсаар ярих гэж залгасан боловч Ландон утсыг нь аваагүй ажээ. Ребека Страус энэ өмхий самхай дунд надтай ингээд байж байсан бол хэр удаан тэвчих байсан бол гэж Ландон бодлоо. Ландон доошилсоор ёроолд нь буулаа. Шаварлаг газар доор палбалзан, гутал тэр өмхий шаварт зоогдоно. Энэ нүх таглагдаад, эндээ амьдаараа булшлагадхгүй нь лав юм даг гэж өөрийгөө зоригжуулаад, шатнаасаа салж эргэлээ. Хорин тохой орчим өргөнтэй, дугуй хэлбэртэй нүх байна. Ханцуйгаараа хамраа даран, нэг амьсгалаад, нөгөө хүн дүрс рүү ойртов. Цаашаага харсан тэр дүрс бүдэг гэрэлд бүүдгэр, суунагласан цэгээн, амьгүй харагдана. Булшны гүн нүхэн дотор, Ландон юу харж байгаагаа ухаарах гэж оролдоно. Тэр хүн дүрс нуруугаараа Ландон руу харах бөгөөд нүүрийг нь харж чадахгүй байгаа боловч, тэр лавтай яа зогсож байгаа юм шиг үзэгдэнэ. «Хүүе!» гэж Ландон хамраа ханцуйгаараа даран байж дуудсанд, хариу өгсөнгүй. Ганц хоёр урагш алхаж ойртох үед, тэр хүн хэтэрхий намхан харагдлаа. *Хэтэрхий намхан ...* «Яаж байна?» хэмээн тэртээ дээрээс Витториа бамбараа савчин хашхирна. Ландон тэр хүн дүрсийг нэгд нэгэнгүй харж

болохоор ойртсон байсан ч хариу өгсөнгүй. Ар нуруугаар хүйт даагаад явангуут, нүхний хана нураад хавчаад авчих шиг боллоо. Газрын гаваас өндийж байгаа албин шиг тэр хүн Ландоноос хоёр дахин намхан, их настай хүн байлаа. Бүсэлхийг нь хүртэл газар булж булшилж орхисон тул ***** гадас шиг босоо зогсох ажээ. Кардиналын улаан шар туузаар гарыг нь ард нь хүлсэн байв. Жаахан урагш нь харуулж булсан ч нуруу нь арагшаа гэдийгээд, толгой нь ч арагшаа унжжээ. Нүд нь эгц дээшээ амьгүй гөлийх нь бурхнаас аврал эрэх шиг. «Өнгөрчихөж үү?» гэж Витториа дээрээс асууна. Ландон хүүр рүү дөхөөд, *ингэж амьд тарчилснаас өнгөрчихсөн нь дээр дээ, зайлуул* гэж бодлоо. Хэдэн алхам дөхөөд, нүд рүү нь харвал хөхөрч, хавджээ. Амьсгаатай эсэхийг нь сонсох санаатай доош тонгойсноо, гэнэт сарвага хийн ухарлаа. «Ээ, бурхан минь». «Юу гэнэ ээ?» Ландон чахарсан хоолойгоор: «Өнгөрчихжээ. Би дөнгөж сая үхлийн шалтгааныг нь харлаа» гэв. Тэр хүний ам нь ангайсан байх агаад амаар нь дүүрэн шороо чихчихсэн байлаа. «Аманд нь шороо чихэж, хахаачихсан байна». «Шороо? Шороон махбод!» хэмээн Витториа хэлэх нь сонсогдов. Ландоны толгойд давхар давхар бодол зэрэг зэрэг хөвөрч эхлэв. *Шороо. Тамга. Шороо, хий, гал, ус.* Алуурчин кардинал тус бүрийг эртний эрдмийн дөрвөн махбодоор тамгална гэж байсан билээ. Эхний махбод нь шороо. *Сантигийн шороон булш.* Өмхий ууранд утуулж, ухаан алдах шахсан хирнээ Ландон хүүрийг тойрон, нөгөө алдартай амбиграмм тамга нь ямар байдаг юм бол хэмээн урлаг судлаач хүний сонирхлоор шохоорхон харж - хайснаа ч олов. Иллюминатигийн зуун зуун дамжсан домог толгойд зурсхийн тодорно. Кардиналын цээжинд сийлсэн тамга гайхалтай зүйл байлаа. *La lingua pura...* Ландон толгойгоо тонгойлгон бичгийг өөд уруу нь харуулан уншлаа. Газар «Газар» гэж нэг уншаад уруу харуулан унших санаатай толгойгоо гилжийлгэв. «Газар». Гэнэт айдаст автан, хойшоо лагхийн ухрав. *Цаана нь бас гурав байгаа шүү дээ.*

Хэсэг 68

Систин цогчны дотор, лааны зөөлөн гэрэл сүүмэлзэвч кардинал Мортатигийн сэтгэл түгшин байв. Цуурган албан ёсоор, гэхдээ их л ёозгүй эхэллээ. Хагас цагийн өмнө тогтсон хугацаандаа, Карло Вентреско камерлинго ирээд, заншил ёсоор гол шүтээний өмнө сөхрөн залбирч, нээлтийн уншлагаа уншжээ. Тэгээд эргэж хараад, алга хавсарсан гараа буулган, Мортатигийн энэ насандаа Систин цогчны хоймрын шүтээний өмнө сонсож байгаагүй шулуун шударгаар ярьж гарав. «Энэ мөчид манай цуурганд дөрвөн дэвшигч маань байхгүй байгааг та бүхэн бэлхнээ мэдэх билээ. Саяхан таалал төгссөн Дээрхийн гэгээнтний нэрийн өмнөөс, та бүхнийг сүсэг бишрэлээ даган хийх ёстой бүхнээ ёсчлон гүйцэтгэхийг хичээнгүйлэн гуйя. Та бүхний мэлмийд гагц Бурхан залрах болтугай» гэлээ. Тэр ингэж хэлчхээд, үүд рүү алхлав. Нэг кардинал босч ирээд: «Гэхдээ, ингэхэд тэд маань хаана байгаа хэрэг вэ?» гэв. Камерлинго зогтуссанаа: «Хэлж эс мэднэм» гэлээ. «Тэд хэзээ ирэх вэ?» «Хэлж эс мэднэм». «Тэд сайн биз?» «Хэлж эс мэднэм». «Тэд эргэж ирнэ биз дээ?» «Сүсэглэж л сууя даа» гэж камерлинго хэлээд, гараад явчихлаа. Систин цогчны дааман хаалга хаагдаж, уламжлал ёсоор хоёр том гинжээр цуургалав. Швейцар жардын дөрвөн харуул даамны өмнөх гудмыг ажиглан харуулд зогсоно. Энэ хаалга нэг бол, дуган дотор байгаа нэг өвгөн кардинал үхэтхийн унах юм уу, эсвэл нөгөө дэвшигч нар эргэж ирвэл л онгойно гэдгийг Мортати мэднэ. Дэвшигч нар нь ирээсэй гэж тэр хүсэвч, ирэхгүй гэх совин татна. Камерлингогийн хэлснээр, хийх ёстой зүйлээ хийхээс дээ хэмээн Мортати шийдэв. Тэгээд, санал хураалт зарлав. Өөр яах ч билээ? Санал хураалтад бэлдэх ёслол гучин минут орчим үргэлжиллээ. Кардинал бүр насныхаа эрэмбээр гол шүтээний өмнө очиж, саналаа өгч тусгай ёс үйлдэнэ.

Ингэсээр, хамгийн сүүлийн кардинал өмнө нь дөхөж ирээд, сөгдөн мөргөв. «Христийн нэрийг барин би саналаа Бурхны тааллаар сонгогдох ёстой гэсэн түүндээ өглөө» хэмээн өмнөх кардиналуудын хэлснийг үг бүрчлэн давтлаа. Тэгээд босч саналаа толгой дээрээ өргөн, бүгдэд харуулаад гараа аажим буулган гол шүтээний өмнөх том бумбаны дээр байгаа цар таваг дээр тавив. Дараа нь тавгаа өргөн дээр нь, байгаа саналыг бумбанд юүллээ. Ингэж саналаа таваг дээр тавьж, бумбанд юүлэх нь нэг хүн олон санал сэм өгөхөөс сэргийлсэн эртний уламжлал юм. Саналаа бумбанд хийсний дараа, тэр тавгаа бумбан дээр эргүүлж тавиад, загалмай тэмдэгт нэг мөргөөд, эргэж байрандаа суулаа. Сүүлийн хүн саналаа өгч дуусав. Одоо Мортати ажилдаа орох цаг боллоо. Дээр нь байгаа цар тавгийг авахгүйгээр бумбыг сэгсэрч, дотор нь байгаа саналыг холив. Тэгээд, тавгийг авч бумбанд гараа хийн дайралдсан саналаа гаргаж ирнэ. Илүү ч үгүй, дутуу ч үгүй хоёр хуруу урттай тэр саналын хуудсын хуйлаасыг дэлгээд, хүн бүр сонсог гэж чанга дуугаар тэнд бичсэн нэрийг уншина. *Eligo in summum pontificem* (Дээрхийн гэгээнээр би сонгон)... хэмээн хуудас болгоны дээр бичсэн толгой үгийг их дуугаар уншаад, дараа нь доор нь бичсэн нэрийг ёслол төгөлдөр дуудна. Тэгээд, шавгыг өндөр гэгч өргөөд, *Eligo* гэх үгийг нь дайруулан том гэцэнд хатгаж хэлхээд, дуудсан нэрээ бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ. Энэ үйлийг дахин давтан хийнэ. Бумбаас нэр авч, чангаар дуудаад, гэцэнд хэлхэн, тэмдэглэл хөтөлнө. Мортати эхний санал хураалт үр дүнгүй болох нь гэдгийг шууд л мэдлээ. Долоон хуудас дэлгэхэд, долоон өөр хүний нэр бичжээ. Санал нийлэх шинжгүй болоод явчихлаа. Хүн бүр дармалаар буюу бичмэлээр янз янзаар л бичгийнхээ хэвийг өөрчлөх гэж оролдсон байвч, өөрийнхөө нэрийг бичсэн нь тодорхой байв. Бүгд л хувь ашгийн үүднээс, өөрийнхөө нэрийг бичиж, эцэст нь санал хураалт дахин явуулах хэрэгтэй боллоо. Кардиналууд дэвшигч нараа хүлээсээр ... Хамгийн сүүлийн саналыг дэлгэж уншаад, гэцлэж, бүртгэлдээ хөтөлсний дараа, Мортати санал хураалт «хүчингүй болсныг» зарлалаа. Шавга хэлэхсэн гэцийнхээ хоёр үзүүрийг холбож зангидаад, тэр хэлхээгээ мөнгөн цар таваг дээр тавьж, дээр нь химийн бодис асгаад, ардаа байгаа жижиг зуух руу хийлээ. Шавга дүрхийтэл асч шатав. Шавга дээр асгасан химийн бодис шатахдаа хар утаа гаргаж, утаа нь яндангаар дамжин дээш хөөрч гадна байгаа хүмүүст дохио өгнө. Ийнхүү, кардинал Мортати анх удаагаа гадна ертөнцөд дохио өглөө. Нэг удаа санал хураасан ч Пап тодорсонгүй.

Хэсэг 69

Бүтэж үхдэгийн даваан дээр, Ландон шатаар дээшээ өгсөн, харанхуй нүхний дээр бадамлах гэрэл өөд зүтгэнэ. Дээр хүмүүс ярилцах нь сонсогдох авч, юу яриад байгаа нь ойлгомжгүй байв. Түүний толгойд кардиналын цээжин дээр сийлсэн тамга л эргэлдэнэ. *Шороо... шороо ...* Шатны дээд гишгүүр рүү өгсөж явахад нь нүд нь бүрэлзээд, ухаан нь балартаад явчихлаа. Хоёр гишгүүр дутуу байхад ... шатнаас гулган тэнцвэр алдлаа. Уруул нь татвага хийн эхэр татаад, тохойнх нь доогуур янгинах тэр эгшинд, Ландон хөл нь шатнаас салаад, агаарт хөвөх шиг болов. Гэнэт, хоёр Швейцар жардын чанга гар булчингаас нь шүүрэн аваад, дээш өргөв. Тун удалгүй, Ландоныг чөтгөрийн цооногоос гаргаж ирэх агшинд, эхэр татан, уушги руугаа цэвэр агаар шунан соров. Татаж гаргаж ирсэн хоёр цэрэг, түүнийг хүйтэн гантиг шалан дээр нуруугаар нь зөөлөн тавилаа. Ландоны ухаан балраад дэн дун, хаана байгаагаа ч мэдэхгүй гиюүрнэ. Дээр одот тэнгэр, эрхэс гариг эргэлдэнэ. Нэг харанхуй дүрс

дээгүүр нь сүүмэлзэнэ. Хүмүүс ярилцана. Ландон чулуун пирамидын суурь түшин хэвтэж байснаа, босох гэж оролдов. Нэг их дуугаар хараал тавих хүний дуу сонсогдох үеэс, Ландоны ухаан санаа эргэн орж, хэн болохыг нь төвөггүй танилаа. Оливетти - Витториа руу: «Яагаад та нар энэ газрыг эхэлж олсонгүй вэ» хэмээн халаглан хашхична. Витториа тайлбарлах гэсэн боловч Оливетти огт тоомсорлосон шинжгүй, цаашаагаа эргэж: «Цогцсыг тэндээс гарга! Байшинг нэгж!» хэмээн цаад хүмүүс рүүгээ зандрав. Ландон дахиад л суух гэж оролдов. Чиги сүм Швейцар жардаар дүүрч, тэд сүмийн нуман хаалгыг хааж байсан хулдаасан хөшгийг хуу татан авахад, уушги нь цэвэр агаараар цэлийтэл дүүрлээ. Аажмаар ухаан мэдрэл нь эргэн эрж, өөр рүү нь дөхөж яваа Витториаг олж харлаа. Бүсгүй өмнө нь сөхрөөд, өөдөөс нь харж байгаа нь яг л сахиулсан дагина шиг байв. «Зүгээр үү?» гэж Витториа гарыг нь барьж, судасных нь лугшилтыг чагнахад, зөөлөн цагаан гар нь дотно сайхан санагдана. «Гялайлаа» гэж хэлэнгээ Ландон өндийж суугаад: «Оливетти галзуурах гэж байна уу» гэлээ. Витториа толгой дохиж: «Аргагүй шүү дээ. Хоёулаа уурлуулчихсан юм чинь». «Би уурлуулчихсан юм чинь гээч». «Дараагийн удаа, өрсөж очоод, гэмээ цайруул даа». «*Дараагийн удаа?*» Ландон гутрангуй: «*Дараагийн удаа гэж байхгүй ээ. Ганц боломжоо алдчихлаа.*» Витториа Ландоны цагийг харав. «Дөчин минут байна гэж цаган дээр чинь байгаа Микки хэлээд байна шүү дээ. Толгойгоо дайчлаад, дараагийн тэмдгийг олоход туслаач» гэв. «Витториа, би хэлээд байна шүү дээ. Баримлууд алга болчихсон. Гэгээрлийн мөр чинь» гэснээ Ландон зог тусав. Витториа зөөлөн мишээнэ. Ландон хөл дээрээ үсэрч босоод, хүрээлэн байгаа уран баримлуудыг сонжиж эхлэв. *Пирамид, од, эрхэс, тойрог зам.* Гэнэт бүх юм байр байрандаа байх мэт санагдаад явчихлаа. *Энэ чинь эрдмийн эхний шүтээн шүү дээ! Пантеон биш!* Гэгээрлийн сүм ямар их нууцлаг, далд байсныг одоо тэр гайхаж эхлэв. Чиги сүм хэний ч үл ажиглам дуганы хажуу тасалгаанд - бараг л хананд гаргасан нүх шиг юман дотор байсан бөгөөд шороон махбодлог бэлгэдлээр дүүрсэн байлаа. Төгс гэж энэ дээ. Ландон асар том пирамид баримлыг ширтэн, хана руу дөхөв. Витториагийн зөв байжээ. Энэ сүм эрдмийн анхны шүтээн юм чинь анхны тэмдэг болсон Иллюминатигийн баримлыг одоо болтол хадгалж байж магадгүй. Боломж байгаа юм байна шүү гэсэн сайхан бодол Ландоны толгойд гялсхийн орж, найдлагын дөл дүрсхийн бадамлав. Тэмдэг энд байгаа л бол тэр тэмдгийг дагаад, эрдмийн дараагийн шүтээн рүү очиж, алуурчныг барьж болно. Витториа дэргэд дөхөж очоод: «Би Иллюминатигийн урлаач хэн байсныг мэдээд авсан шүү» гэв. Ландон гайхан: «Юу гэнэ ээ?» хэмээн эргэж харав. «Бид одоо энд байгаа аль баримал нь» «Байзаарай, байзаарай. Чи Иллюминатигийн урлаач хэн байсныг мэдээд авчихсан гэсэн үү?» Ландон түүнийг олох гэж олон жил хичээсэн билээ. Витториа инээмсэглэн: «Бернини л байсан юм биш үү?» гэв. Бүсгүй буруу бодож байна гэж Ландонд бодлоо. Бернини байх боломжгүй юм. Жанлоренцо Бернини бол Микланжелогийн дараа л орох хоёр дахь гайхамшигт барималч байлаа. 1600-аад оны үед, Бернини хэн хэнээс илүү олон баримал барьжээ. Харамсалтай нь, хайж байгаа хүн нь тэр биш, нэр усгүй, алга болсон урлаач байлаа. Витториа хөмсгөө зангидан: «Чи нэг л гайхсан шинжгүй байх чинь» гэв. «Бернини биш ээ». «Яагаад? Бернини чинь Галилеотой нэг үед амьдарч байсан гайхалтай бүтээлч шүү дээ». «Тэр гайхалтай хүн маань католик байсан юм шүү дээ». «Тэгээд юу гэж? Галилео ч бас католик л байсан шүү дээ». «Үгүй дээ» гэж Ландон арцаад: «Галилеотой адил ч биш шүү. Галилео Ватиканы талд аргагүй болоод л орсон юм. Харин Бернини бол Ватиканы асарсан хүү нь. Орон хийдийнхэн Берниниг хайрлан хүндэлдэг байсан болохоор, Ватиканы урлагийн захирагчаар хүртэл сонгож байсан юм. Бараг л бүх амьдралынхаа турш Ватиканд амьдарсан хүн шүү дээ». «Гайхалтай халхавч. Иллюминатигийн халхавч». Ландон залхсан байртай:

«Витториа, аан гэж бай. Иллюминати нууц барималчаа il maestro ignito буюу нууц урлаач гэдэг байсан юм». «Тэд өөрснөө ч мэддэггүй л байсан байхгүй юу даа. Масонуудыг бод л доо, зөвхөн дээд төвшний гишүүд нь л бүх нууцаа мэддэг шүү дээ. Галилео жишээ нь Берниниг мэддэг байсан ч өөрийнх нь төлөө бусад гишүүндээ хэлээгүй ч юм билүү. Тэгвэл, Ватикан ч бас юу ч мэдэхгүй л өнгөрнө шүү дээ». Витториагийн ярьж байгаа зүйтэй байсан ч гэсэн Ландоныг л лав үнэмшүүлж чадсангүй. Иллюминати нууц хадгалахдаа сүрхий, тал тал мэдээллийг энд тэнд хадгалдаг, гагц дээд төвшнийхөн л бүх нууцаа мэддэг байлаа. Ингэж л тэд нууцлаг үлдэж чадсан агаад ... бүх юмыг мэддэг хүн үнэндээ хуруу дарам байдаг байжээ. Витториа цааш нь үргэлжлүүлэн: «Тийм ч учраас Бернини тэр хоёр том пирамидыг энд барьсан байхгүй юу» гэж хэлээд жоготой ёо инээмсэглэв. Ландон пирамид руу эргэж харан толгой сэгсэрснээ: «Бернини шүтлэгтэй хүн байсан, энэ хоёр пирамидыг барьсан байх учиргүй» гэлээ. Витториа мөрөө хавчсанаа: «Наадахаа цаанаа байгаа хавгандаа хэл» гэлээ. Ландон эргэж хавтан дээр байгаа бичгийг уншив. *ЧИГИ СҮМИЙН БАРИМАЛ Сүмийн архитектурыг Рафаэль, харин дотоод бүх заслыг Жанлоренцо Бернини урлав.* Ландон хавтанг хоёронтоо уншсан ч бас л үнэмшихгүй байлаа. Жанлоренцо Бернини бүтээлээ Онгон Мариа, сахиулсан тэнгэр, бошигот найдангууд, Папад л зориулж байснаас юугаа хийж энд, пирамид барьж байх билээ? Ландон сүндэрлэн буй аугаа том пирамидыг мэлийн зогсоно. Тус бүр гялалзсан зууван медалионтой хоёр том пирамид байх ба одод, одон зурхайн ордны тэмдгүүд гээд л огт христийн бус тэмдэг дүүрэн. *Дотоод бүх заслыг Жанлоренцо Бернини урлав.* Хэрэв энэ бичиг үнэн бол Витториагийн зөв байлаа. Хэрэв Бернини Иллюминатигийн нууцлаг урлаач байсан бол түүнээс өөр хэн ч энэ сүм дотор байгаа баримлуудыг урлаагүй байж таарна. Хэрэв тийм бол юу болох байсныг Ландон бодохоос бэрхшээв. *Бернини Иллюминатус байжээ. Бернини Иллюминатигийн амбиграмм тамгуудыг урлажээ. Бернини Иллюминатигийн Гэгээрлийн мөрийг засжээ.* Ландон ярих ч завгүй бодно. Энэ өчүүхэн Чиги сүмд дэлхийд алдартай Бернини ирээд, эрдмийн дараагийн тахил руу Ромыг хөндлөн гулд заасан баримал барьсан гэж үү дээ? «Бернини гэж би л лав зүүдэлж ч чадахгүй юм байна» гэлээ. «Ватиканы алдарт барималчаас өөр хэн Ром даяар хэрсэн Гэгээрлийн мөрийг засах гээд католик сүмүүдээр хэсч явах юм бэ? Энгийн нэгэн бол яав ч чадахгүй шүү дээ». Ландон тэр тухай бас л бодож байлаа. Тэгээд нөгөө хоёр пирамид руу харж аль нэг нь тэмдэг байж болох уу гэж бодно. *Хоёулаа ч юм уу?* «Хоёр пирамид өөд өөдөөсөө харчихсан байх» гэж Ландон бувтнан яахаа мэдэхгүй ажна. «Хоёулаа яг ижилхэн юм, ёстой мэдэхгүй юм даа» гэв. «Бидний хайж байгаа юм пирамид биш байх аа». «Байгаа ганц баримал нь л энэ хоёр байна шүү дээ». Витториа - Оливетти туслахуудтайгаа үймэлдэн буй чөтгөрийн цооног тийш зааж байна. Ландон Витториагийн гарыг дагуулан ажсан боловч эхэндээ юу ч харсангүй. Гэтэл үймэлдэх цэргүүдийн нэг нь хөдлөх тэр агшинд, араас нь цагаан гантиг гялсхийн бултайв. Араас нь гар, цээж, баримлын нүүр цухуйсаар — хүний галбиртай хоёр дүрс тодроод ирлээ. Ландоныгийн зүрх нь огшоод явчхав. Тэр пирамид, чөтгөрийн цооног хоёрыг л ажаад цаана нь байсан тэр хөшөөг анзаарсан ч үгүй. Тэгээд, гүйхээрээ алхлан тасалгааг хөндлөн гулд туулаад, үймэлдэх хүмүүсийн дэргэдүүр өнгөрч, хөшөө рүү ойртохдоо, гайхалтай нарийн дүрсэлсэн нүүр, уран зохиомж, салхинд дэрвэх мэт хувцас гэх мэт Бернинигийн бүтээлийн хэв шинжийг тодорхой ажиглаж эхлэв. Тулж очсоныхоо дараа мань хүн хөшөөнд дүрсэлсэн хоёр этгээдийг таньж, аяархан дуу алдав. Витториа ард нь ирмэгцээ: «Энэ хоёр чинь хэн юм бэ?» гэв. Ландон баримлыг биширсэн хэвээр Хабаккук, ангель хоёр хэмээн сонсогдох төдий бувтнав. Энэ бол Бернинигийн нэлээн алдартай бүтээлүүдийн нэг, урлагийн түүхийн зарим номд хүртэл орсон байдаг ажээ.

Ландон энэ баримал энд байдгийг мартчихсан байв. «Хабаккук гэнэ ээ?» «Ертөнц мөхөхийг зөгнөсөн хамба». «Энэ - нөгөө тэмдэг мөн үү?» Ландон бишрэнгүй толгой дохино. Амьдралдаа хэзээ ч ийм итгэл төгс байсангүй. Энэ Иллюминатигийн анхны тэмдэг байлаа. Эргэлзэх зүйл алга. Эрдмийн дараагийн тахилыг зүг чиглүүлэх баримлыг ямар нэгэн байдлаар «заасан» байх ёстой гэж Ландон бодож байсан ч бүр ийм илт байх юм гэж бодсонгүй. Ангель, Хабаккук хоёр хоёулаа гараа сунган, алсад чиглүүлсэн байв. Ландон инээвхийлэн: «Тийм ч бэрх биш юм байна шүү» гэлээ. Витториа нэлээн эргэлзэнгүй: «Энэ хоёр чинь өөр өөр зүг рүү заагаад байна шүү дээ. Ангель нэг зүг рүү, харин нөгөөх нь нөгөө зүг рүү нь» гэв. Ландон хөхрөв. Хоёр баримал хоёулаа яг эсрэг зүг рүүгээ зааж байлаа. Гэхдээ Ландон үүнийг ойлгочихсон, зөв зүгээ олчихсон байсан болохоор, хаалга руу хурдан хурдан алхаллаа. «Хаачихна вэ?» гэж Витториа хойноос хашхирав. «Байшингийн гадаа гарья» гэж Ландон хэлээд, хөл нь хөнгөрөн, хаалга руу гүйн одлоо. «Баримал хаашаа зааж байгааг очиж харья» гэв. «Хүлээ л дээ! Чи аль хурууг нь дагахаа яаж мэдээд байгаа юм бэ?» «Шүлэгээ сана л даа» хэмээн явуут дундаа хашхирав. «Сүүлийнх нь мөрийг!» «Ангель бүр ариун эрлийг чинь заана?» Бүсгүй эргэн харж ангелийн зааж байгаа зүг рүү харснаа: «Өө, нээрэн тийм шүү дээ, би гэж тэнэг, санасангүй шүү» гэж бувтналаа.

Хэсэг 70

Гунтер Глик, Чинита Макри хоёр дэль Пополо талбайн харанхуй буланд, ВВС-ийн мухлаг тэргээ зогсоожээ. Дөрвөн Альфа Ромео ирсний дөнгөж дараахан, үйл явдлын халуун мөрөөр мөшгөхөөр амжиж иржээ. Чинита юу болоод байгааг ойлгоогүй боловч камераа бариад, бичлэгээ хийж байв. Глик, Чинита хоёр дөнгөж ирмэгцээ л дөрвөн Альфа Ромеогоос хүдэр залуус үсрэн гарч ирээд, сүмийг тойрон хамгаалалтад авахыг харлаа. Зарим нь зэвсгээ бэлэн барьжээ. Арай ахимаг нэг нь нөгөө хэдээ удирдан, сүмийн урд хаалга руу давшлан очиж, дааман хаалганых нь цоожийг дэлбэлж орхив. Гэхдээ, Чинита юу ч сонсоогүйг бодоход, дуу намсгагч хэрэглэсэн бололтой. Нөгөө цэргүүд сүм рүү нэвтрэн орлоо. Чинита машиндаа суугаад, сүүдэрлэг газар нуугдсан хэвээрээ зурагаа авья гэлээ. Буу бол буу, дээрээс нь тэдний байгаа газраас болж байгаа бүх үйл явдал тов тод харагдаж байв. Глик ч төдийлөн арцсангүй. Тэгтэл, нөгөө залуус сүмийн үүдээр орж гаран үймэлдэж, бие бие рүүгээ хашхирч ярилцана. Тэр залуус ойр орчмоо нэгжиж эхлэхэд нь, Чинита камерынхаа линзийг тохируулан татав. Бүгд энгийн хувцастай ч гэсэн цэргийн хүмүүс гэдэг нь илт. «Тэд хэн юм болоо» гэж бүсгүй асуув. «Мэддэг сэн бол ч» гэж Глик хэлснээ: «Чи бичлэг хийж байна уу» гэв. «Нэгд нэгэнгүй». Глик: «Пап тодрохыг сахиж хүлээж суумаар л байна уу?» хэмээн тохуурхан асуув. Чинита юу хэлэхээ мэдсэнгүй. Ямар нэгэн юм энд болоод байгаа нь тодорхой ч, сонирхол татсан юм заримдаа энгийн, ямар ч ач холбогдолгүй байх тохиолдол байдгийг, олон жил сэтгүүлч дагаж явсан туршилгаараа мэдэж байлаа. «Юу ч биш байж магадгүй шүү дээ. Чиний сонссон юмыг сонсчхоод, шалгаж яваа ч юм билүү. Хуурмаг түгшүүр байж болно шүү дээ». Глик бүсгүйн гарыг татан: «Тийшээ тат даа» гээд сүмийн ар тал руу заав. Чинита камераа шатны дээгүүр чиглүүлэн, сүмээс гарч яваа эрийг: «Сайн уу, хө» хэмээн зураглаж гарав. «Хэн гэдэг дэгжин залуу вэ?» Чинита камераа татан дурандсанаа: «Өмнө нь хараагүй л хүн байна» гэв. Тэгээд камераараа бүр ойрхон татаж нүүрийг нь хараад: «Гэхдээ, энэ хүнтэй дахиад дайралдвал би л лав гайхахгүй дэг» гэлээ. Роберт Ландон сүмийн гаднах шатаар доош матиран, өмнөх талбайн гол руу алхална. Харуй бүрий болж, хаврын наран өмнөд Ромд оройхон шингэж байлаа. Нар байшингуудын цаагуур орж, сүүдэр нь талбай дээгүүр суналзан мөлхөж байв. «За, Бернини гуай. Ангель чинь, тэгээд, хаашаа заагаад байгаа юм бэ дээ?»

Дөнгөж гарч ирсэн сүмийнхээ байршлыг эргэж хараад, Чиги сүмийн дотор талыг санаандаа төсөөлөн, ангелийн зааж байгаа зүгийг олох гэж бодолхийлнэ. Огт эргэлзээгүйгээр, тэр наран шингэж буй өрнө зүг рүү хараа сунгав. Цаг урссаар. «Баруун өмнө» гэж өөртөө хэлээд, харааг нь хаагаад байгаа дэлгүүр, байшингуудын дээгүүр харах гэж өндөлзөнө. «Дараагийн тэмдэг тэр хавьд л байгаа даа». Тархиа дайчлан байж, Ландон Италийн урлагийн бүх түүхийг хуудас хуудсаар нь эргэн санах гэж оролдоно. Хэдийгээр, Бернини алдартай уран барималч ч гэсэн, бүтээсэн бүх баримлыг нь, мэргэжлийн хүн байсан ч, нэгд нэгэнгүй тоочин санахын аргагүй олон билээ. Гэхдээ, анхны тэмдэг Хабаккук, Ангель хоёр гэдэг баримал харьцангуй олонд танигдсан бүтээл байсан болохоор, хоёр дахь тэмдэг нь бас л санаанд тод байх нэгэн бүтээл байж магадгүй хэмээн найдна. Шороо, хий, гал, ус. Шороо-г нь - Шороон сүм дотор, ертөнцийн мөхлийг зөгнөсөн бошигот Хабаккукийг олчихсон байв. Хий дараагийнх нь. Ландон тархиа гашилгана. *Хийтэй холбоотой Бернинигийн ямар нэг бүтээл!* Бодоод бодоод олдохгүй байх авч, дотроо тун урамтай байв. *Би Гэгээрлийн мөрөөр явж байна! Одоо болтол байж л байгаа юм байна шүү дээ!* Ландон байшингуудын дээгүүр, баруун өмнөш өнгийн харвал сүмийн орой, цамхгаас өөр юм огт харагдахгүй ажээ. Газрын зураг хэрэгтэй. Эндээс баруун өмнөш ямар сүм дуган байгааг олж чадвал, аль нэг нь сэдэл өгч магадгүй гэж Ландон бодлоо. *Хий. Бернини. Баримал. Хий. Бодооч!* Ландон буцаж шатаар өгсөж явахдаа Витториа, Оливетти хоёртой дайралдав. «Баруун өмнөш. Дараагийн сүм эндээс баруун өмнөш байгаа» хэмээн Ландон үглэнэ. «Энэ удаад итгэлтэй байна уу, та?» гэж Оливетти их л хүйтэн асуув. Ландон тэрийг нь тоосонгүй: «Газрын зураг хэрэгтэй байна, Ромын бүх сүм хийдийн байршлыг харуулсан зураг хэрэгтэй байна» гэлээ. Захирагч хүрлийсэн царайгаа огт хувиргалгүй, Ландоныг хэсэг ажиглан зогсов. Ландон цагаа харснаа: «Хагас цаг л үлдээд байна шүү дээ» гэлээ. Оливетти, Ландоны хажуугаар нь гарч сүмийн өмнө зогсоосон машин руу алхахад нь, газрын зураг олж ирэх нь үү гэмээр байв. Витториа гайхан: «Ангель баруун урагшаа зааж байгаа юм уу? Баруун урд ямар ямар сүм байдгийг мэдэхгүй юу?» гэв. Ландон эргэж талбай руу харангаа: «Би байшин дээгүүр харж чадахгүй байна. Би Ром дахь сүм хийдийн тухай сайн мэдэхгүй» гэлээ. Витториагийн нүд нь том болон, гайхсан байртай: «Юу гэнэ ээ?» гэв. Ландон шатаар өгсөн, талбай руу эргэж харлаа. Нэлээн дээшилсэн болохоор, алсын бараа овоо гайгүй харагдах болов. Гэхдээ, л хотын бараа тун барагтай үзэгдэнэ. Аргаа баран, эргэн тойрноо нэг харснаа, хэрэгтэй юмаа оллоо. Тэнд дээшээ зургаан давхар өндөр, сарнай хээтэй гол цонхных нь дээгүүр, сүмд тулгаж барьсан барилгын шаталсан тавцан байх агаад тэнд гарвал, талбай тойроод байгаа байшингуудын дээгүүр харж болох байлаа. Чинита Макри, Гунтер Глик хоёр талбайн нөгөө захад, машиныхаа салхины шилэнд нүүрээ наачих шахан сууж байв. «Чи бичлэг хийж байна уу» гэж Гунтер асуулаа. Макри шатаар өгсөж яваа эрийн зүг камераа сунгана. «Хүн аалз гэхэд арай л гоё хувцас өмсчихсөн давхиж явна даа». «Доор нь байгаа Аалзхай авхай нь хэн бэ?» Чинита шатны доох нь байгаа шаавай хүүхнийг харснаа: «Чи мэдээд авмаар байгаа биз дээ?» гэв. «Чи редактор руу ярих юм биш үү?» «Болоогүй ээ. Жаахан харъя. Цуурганыг орхиод явчихсан хүмүүс чинь дуулгах сонинтой болсныхоо дараа ярихгүй бол болохгүй шүү дээ». «Нэг зөнөгийг тэнд тонилгочихсон гэж чи нээрэн бодоод байгаа юм уу» Чинита хөхрөн: «Чи ер нь тамд унах чинь тодорхой юм байна даа» гэв. «Гэхдээ, Пульцерийн шагналаа аваад л унана даа».

Барилгын шаталсан тавцангаар дээшээ авирах тусам улам дэнжигнэнэ. Гэхдээ, гишгүүр ахих тусам Ромын бараа улам тодорч байсан болохоор, Ландон авирсаар л байв. Хамгийн дээд талын тавцан дээр гарч ирэхэд, санаснаас илүү аахилж байв. Будаг цацагдсан тавцан дээр дэнжигнэн гарлаа. Их өндөр байсан ч, огт санаа зовсонгүй, харин ч урамтай байлаа. Алсын бараа гайхалтай харагдана. Ромын улаан вааран дээвэртэй байшингууд - жаргах нарны туяанд яг л гал далай дүрэлзэх шиг гялтайна. Ландон амьдралдаа анх удаа Бурхны хотыг Ромын агаарын бохирдол, замын бөглөрлөөс дээгүүр саравчлан харж зогслоо. Байшингийн дээвэр дээгүүр Ландон сүмийн ганжир, хонхны цамхаг хайна. Алслан алслан харавч, нэгийг ч олсонгүй. *Ромд зуу зуун сум бий. Эндээс баруун урагш ядаж ганц баймаар юм даа! Одоо болтол байгаа бол ядаж харагдмаар юм аа!* хэмээн бодолхийлнэ. Ландон тэнгэрийн хаяа хүртэл, дахин дахин нэгжин харна. Мэдээж, бүх сүм хийд, ялангуяа зам дагуу байх жижиг сүмийн ганжир эндээс харагдахгүй нь лав. 1600-аад оноос хойш Ром хот танихын аргагүй өөрчлөгдсөн байж таарна. Тэр үеийн хуулиар хамгийн өндөр байшин зөвхөн сүмийн барилга байх ёстой байсан бол одоо орон сууц, өндөр байшин, ТВ цамхаг л үзэгдэнэ. Ландон хоёр дахь удаагаа тэнгэрийн хаяа руу хараа сунгав. Нэг ч ганжир харагдсангүй. Тэртээ алсад, Ромын хаяанд, Микланжелогийн урласан том гэгч бөмбөгөр орой жаргах нарны гэрэлд гялалзана. Гэгээн Петерийн ордон. Ватикан хийд. Швейцар жард антиматерийг олчихвол кардиналууд хэрхэн баярлах бол хэмээн Ландон бодовч тэгж чадахгүй л байх аа даа гэх совин татав. Нөгөө шад шүлэг санаанд нь эргэлдэн, мөр бүрээр нь эргэн санана. *Чөтгөрийн цооногтой Сантигийн шороон булинаас. Сантигийн булшийг олчихсон. Ромыг хэрэн шидэт махбодууд хүрээлжээ.* Тэр шидийн махбод нь шороо, хий, гал, ус шүү дээ. *Ариун тэнслийн зүг гэрлийн мөр зурайж.* Бернинигийн барьсан Гэгээрлийн мөрийг хэлж байна. *Ангель бүр ариун эрлийг чинь заана.* Ангель ч баруун урагшаа л зааж байсан даа ... «Дааман шат руу» гэж Глик хашхираад, машиныхаа салхины шил рүү галзуу юм шиг чичин: «Нэг юм болоод байна шүү» гэв. Макри камераа эргүүлэн, дааман хаалганы урд талын гол шат руу чиглүүлэв. Үнэхээр, ямар нэг юм болоод байлаа. Цэрэг маягийн нэг залуу нэг Альфа Ромеог гол шатны эгц доор зогсоогоод, тээшийг онгойлгов. Тэгээд, талбай тойруулан хянаж байгаа хүн байгаа эсэхийг шалган, хянуур гэгч харлаа. Макрид тэр залуу тэр хоёрыг олоод харчих шиг санагдсан боловч нүд нь тэдэн дээр тогтолгүй өнгөрөөд, гар холбоогоороо цаашаагаа юм ярив. Тэгмэгц, сүмийн хаалга онгойн, хэдэн залуу гарч ирлээ. Тэд америк хөл бөмбөгийн хориглох эгнээ шиг зайгүй нягт зогсон, биеэрээ хана болж, ямар нэг юмыг халхлан, доошоогоо зэрэг буулаа. Тэр хүн-ханын цаана дөрвөн цэрэг маш хүнд зүйл өргөн явж байгаа нь, бараг л харагдахгүй шахам байв. «Сүмээс юм хулгайлж байгаа юм байх даа» хэмээн Глик цонхонд нүүрээ наах шахан хэлэв. Чинита камераа телефото дээр нь тавиад, байдаг чадлаар нь татан хүн-ханын хооронд завсар гарахыг анана. Секунд хүрэхгүй хурдан дарна даа хэмээн тэр бувгнана. Ганц л зураг даръя, тэгээд л боллоо хэмээн үглэнэ. Гэвч, хүн-хана нэг хүн мэт хөдлөн, доош алгуур буулаа. За л даа гэж Чинита дахин давган гонгинох тэр агшинд, боломж гэнэт гарч ирлээ. Өргөж явсан юмаа машины тээш рүү хийх тэр агшинд, Макрид зураг дарах боломж гарав. Хачирхалтай нь, тэр өргөж явсан юм нь настай хүн байлаа. Хоромхон зуур, Макри арав шахам зураг дарлаа. «Редакц руу утастаарай. Хоёулаа ямартай ч хүн амины хэрэг оллоо» гэж Чинита хэлэв. Алс хол СЭРН-д Максимлиан Колэр тэргэнцрээ Леонардо Ветрагийн өрөөн дотор жолоодон явна. Ветрагийн цаасан дундуур робот шиг сүлжинэ. Хайж байсан юмаа олоогүй Колэр унтлагынх нь өрөөнд орж орны хажуугийн шүүгээг татсанд цоожтой байлаа.

Тэгэхээр нь, гал тогооны өрөөнөөс хутга авчирч хөшөөд, шүүгээг онгойлгов. Дотроос нь, Колэр хайж байсан тэр зүйлээ оллоо.

Хэсэг 72

Ландон дэнжигнэн, барилгын шаталсан тавцангаас арай гэж бууж ирээд, тоос, шороо дарсан хувцсаа гөвөх зуур, Витториа түүн рүү дөхлөө. «Олз омог муутай юу?» Ландон толгой сэгсрэв. «Кардиналыг тээшинд хийчихлээ». Оливетти цэргүүдтэйгээ машиныхаа хамар дээр газрын зураг дэлгэчихсэн зогсож байгааг Ландон харлаа. «Тэд баруун өмнө зүгийг шалгаж байгаа нь тэр үү?» Бүсгүй толгой дохиод: «Тийм. Эндээс Гэгээн Петерийн ордон хүртэл ямар ч сүм алга» гэв. Ландон санаа алдав. Ядаж анх удаа, нэг юман дээр санаа нийлж байгаа нь энэ болохоор, тэр Оливетти руу очлоо. Цэргүүд зам тавин ярагдав. Оливетти толгойгоо өндийлгөн: «Юу ч алга. Гэхдээ, энэ зураг дээр сүм нэг бүрийг биш, зөвхөн томуудыг нь л тэмдэглэсэн байна. Нийтдээ тавь орчим байна даа» гэлээ. Ландон: «Бид хаана байна?» гэлээ. Оливетти дэл Пополо талбайг заагаад, яг баруун урагш дагуулан заалаа. Тэр шугам Ромын томоохон сүмүүдийг тэмдэглэсэн дөрвөлжин хар тэмдгүүдээс нэлээн хол зөрж байв. Харин Ромын томоохон сүм гэдэг нь 1600-аад оны үед байсан эртний сүмүүд байх ажээ. «Би шийдвэр гаргах хэрэгтэй байна. Та баруун урагш гэж зүгээ зөв тодорхойлсон биз?» хэмээн Оливетти тулгаж асуув. Ландон ангелийн сунгасан гарыг санаандаа төсөөлөнгөө: «Тийм. Эргэлзээгүй» гэлээ. Оливетти мөрөө хавчсанаа, нөгөө шугамыг дахин дагуулан харлаа. Тэр шугам Маргерита хатан хааны гүүр, Кола ди Рицео гудамжийг огтлон, Гэгээн Петерийн талбайн төв хүртэл нэг ч сүм хийдтэй дайралдалгүй үргэлжлэнэ. «Гэгээн Петерийн ордныг яагаад тооцохгүй байгаа юм бэ? Тэр чинь сүм шүү дээ» гэж, нүдэн доороо гүнзгий сорвитой нэг цэрэг өгүүлэв. Ландон толгой сэгсрээд: «Олны хөл үймсэн газар байх ёстой юм. Одоо бол тийм биш шүү дээ» гэлээ. Витториа Ландоны мөрөн дээгүүр өнгийн: «Энэ шугам чинь Гэгээн Петерийн талбай дээгүүр өнгөрч байна шүү дээ. Одоо энэ талбай дээр ч ёстой, олны хөл үймж байгаа шүү» гэлээ. Ландон тэр тухай бодож байсан болохоор шууд л: «Тэнд чинь нэг ч хөшөө баримал байхгүй шүү дээ» гэлээ. «Гэхдээ, яг төвд нь чулуун суварга байгаа шүү дээ». Тэр үнэхээр тийм байлаа. Гэгээн Петерийн талбайн яг голд нь Египетийн чулуун суварга байдаг билээ. Ландон тэр суваргыг санаандаа төсөөлөв. Ариун пирамид. Сонирхолтой л тохиолдол байна гэж бодсон ч тэр энэ бодлоосоо татгалзав. «Ватиканы гэрэлт хөшөө чинь Бернинигийнх биш, тэрийг чинь Калигула Египетээс авчирсан юм. Тэгээд ч хийтэй ямар ч холбоогүй байна» гэлээ. Түүнээс гадна бас нэг асуудал байв. «Шүлэгт өгүүлснээр махбод Ромыг хэрсэн байх учиртай. Гэгээн Петерийн талбай чинь Ромынх биш, Ватиканых» гэлээ. Нэг цэрэг дундуур нь орж ирээд: «Хэнээс асууснаас л шалтгаална даа» гэв. Ландон толгой өргөн: «Юу гэсэн үг вэ?» гэлээ. «Маргаад л байдаг шүү дээ. Ихэнх газрын зураг дээр Гэгээн Петерийн талбайг Ватиканы мэдэлд тэмдэглэсэн байдаг. Гэхдээ, талбай хэрмийн гадна байдаг болохоор Ром хотын захиргаа манайх гэдэг юм.» «Тоглож байгаа байлгүй дээ». Ландон энэ тухай огт мэддэггүй байлаа. «Оливетти захирагч, Ветра авхай хоёр хийтэй холбоотой баримлын тухай асуугаад байхаар нь л би энэ тухай хэлсэн юм» гэж тэр залуу хэлэв. «Тийм баримал, тэгээд, Гэгээн Петерийн талбайд байдаг юм уу?» «Яг ч тийм биш л дээ. Баримал ч биш. Магадгүй хамаагүй байх аа». «Ярь л даа» гэж Оливетти хүчлэв. Харуул мөрөө хавчаад: «Би талбай дээр харуулд гардаг, Гэгээн Петерийн талбайн булан нэг бүрийг гадарладаг болохоороо л, би энийг мэддэг юм». «Тэр баримал чинь, тэгээд, ямархуу эд юм бэ дээ?» гэж Ландон шавдуулав. Иллюминати бүр яг Ватиканы гадаа, Гэгээн Петерийн талбай дээр тэмдгээ тавих сүйхээтэй гэж үү хэмээн мань хүн гайхаж байлаа. «Би өдөр болгон

талбай дээр харуулд гардаг. Тэгээд, энэ шугам дайрч байгаа тэр газар талбайн голд байдаг юм. Тэгээд л, би бодлоо л доо. Гэхдээ, би сая хэлсэн шүү дээ, тэр чинь баримал биш... хавтан байхгүй юу» гэв. Оливетти галзуу юм шиг: «Хавтан ий?» гэж асуув. «Яг тийм, эрхэм ээ. Талбайд суулгасан хавтангууд шиг гантиг хавтан, чулуун суваргын доор байдаг юм. Гэхдээ тэр дөрвөлжин биш, зууван. Дээр нь салхи үлээж байгаа бололтой зураас зурчихсан байдаг юм» гэснээ зогтусаад: «тэр эрдмийн хэлээр яривал хийн урсгал гэх үү дээ» гэлээ. Ландон нөгөө цэрэг рүү хараа салгалгүй ширтэн: «Ашгүй дээ!» гэлээ. Бүгд л тэр цэрэг рүү харж байв. «Цоолбор гэдэг чинь уран баримлын нэг хэлбэр шүү дээ» гэж Ландон өгүүлэв. *Уран баримал гэдэг бол шуумал буюу цоолбор дүрс гаргах урлаг юм* гэсэн тодорхойлолтыг тэр олон жил самбарт бичиж байлаа. Цоолбор гэдэг бол зоосон дээр байдаг хүний дүрс шиг л хоёр хэмжээст орчин дахь уран баримал юм. Чиги сүм дэх Бернинигийн медалион бол нэг жишээ нь билээ. *Bassorelievo?* хэмээн нэг харуул италийн урлагийн нэр томъёо хэрэглэн асуув. «Яг тийм. *Bas-relief!*» хэмээн Ландон хариулаад, машины хамар дээр тулж зогсоод: «Би энэ тухай огт бодоогүй байжээ. Таны яриад байгаа Гэгээн Петерийн талбайн хэсгийг чинь *West Pontente* -Өрнийн салхи гэдэг юм. *Bac Respire di Dio* ч гэдэг». «Бурхны амьсгал гэдэг гэж үү?» «Тийм. Хий! Анх тэр талбайг барьж байсан хүмүүс тэр хавтанг сийлж, тавьсан байдаг юм.» Витториа гайхан: «Би Микланжело Гэгээн Петерийн талбайг анх зурж, сэдсэн гэж бодсон шүү дээ» гэлээ. «Үгүй ээ, зөвхөн ордонг нь!» гэж Ландон их л эр хонгор дуугаар ярьж эхлэв. «Гэхдээ, Гэгээн Петерийн талбайг бол Бернини зурсан юм». Альфа Ромеогийн цуваа дэл Пополо талбайг орхин хурдлахдаа, ард нь ВВС-ийн машин сүүлдэн дагахыг ч анзаарах сөхөөгүй яарч байлаа.

Хэсэг 73

Гунтер Глик ВВС-ийн машиныхаа хаазыг тултал гишгэн, Тибер гол дээрх Маргарита гүүр дээгүүр жирэлзэх дөрвөн Альфа Ромеогийн араас сүүлдэн шунгинана. Ердийн үед бол, Глик араас нь дагаж байгаагаа мэдэгдэхгүйн тулд тодорхой зай барьж явах байсан боловч яг одоо бол нисэх шахуу яваа тэр машинуудыг алдчихгүй дагах гэж л ядаж явлаа. Макри машины ард байрандаа суугаад, Лондонтой утсаар ярьж дууслаа. Харилцуураа тавьж дууссанаа, замын хөдөлгөөний шуугианыг даван: «Сайн, муу аль мэдээг нь сонсмоор байна даа?» гэв. Глик их таагүй байртай, редакцтайгаа ажиллах дандаа л амаргүй байдгийг санан: «Мууг нь» гэлээ. «Байрлалаа орхиж явлаа гэж редактор боож үхэх гээд л цамнаж байна гэнэ». «Нэг их гайхмаар мэдээ биш л байна». «Тэр чамайг хов хайж явдаг амьтан гэж байна гэнэ». «Мэдээж шүү дээ». «Тэгээд, босс маань чамайг овилгогүй амьтан шүү гэж надад санууллаа». Глик тоомжиргүй ярвайснаа: «За, тэгээд сайн нь юу вэ дээ?» гэв. «Сая бид хоёрын авсан зургийг үзье гэсэн». Гликийн тоомжиргүй ярвайсан царай мушилзан мишээх шинжтэй болов. *Хэн нь овилгогүй амьтан бэ гэдгээ үзье л дээ.* «Дамжуулчих цааш нь». «Чамайг зогсоод, сүлжээ ортол дамжуулж болохгүй шүү дээ». Глик Кола ди Риенцо гудамжаар харвасан сум шиг явж байлаа. «Одоо зогсож амжихгүй нь ээ». Тэр урдаа байгаа дөрвөн Альфа Ромеог сүүлдэн Ризоргинменто талбай рүү огцом эргэлээ. Гликийг машинаа огцом эргүүлэхэд, бүх юм машины урд тавцан дээр гулгахад нь Макри зүгээр суусангүй: «Дамжуулагчийг маань эвдчихэв! Тэгвэл, бид энэ мэдээгээ Лондон руу явган хүргэх болно шүү» гэлээ. «Суудалдаа чангахан суу, хонгор минь. Бид бараг л дөхөж яваа юм шиг байна». «Хаашаа?» гэж Макри гайхан асуув. Глик урдаа байгаа бөмбөгөр оройтой танил сүмийн зүг ширтэн: «Эхэлсэн газраа л эргээд ирэх шив» гэлээ. Дөрвөн Альфа Ромео хурдаа хассаар Гэгээн Петерийн талбай руу ирж, дөрвүүлээ таран талбайн захаар аажим явж, тодорхой цэгүүдэд цэргүүдээ

сэм буулгана. Энгийн хувцастай цэргүүд бужигнасан олон жуулчин, ТВ-ийн машинуудын дунд ороод, харагдахгүй алга болов. Зарим цэрэг талбайг хүрээлсэн багануудын дундуур ороод, үзэгдэхгүй болно. Ландон машины урд цонхоор талбай руу харвал, цаг мөч өнгөрөх тусам улам л олон хүн шавааралдаж байлаа. Оливетти Ватикандаа үлдсэн захирагч руугаа гар холбоогоор ярьж, энгийн хувцас өмссөн цэргүүдийг нэмэлт хүч болгон гаргаж, Бернинигийн Өрнийн салхи байгаа газар руу илгээсэн байлаа. Ландон Гэгээн Петерийн уудам талбайг харахдаа, нэг асуултыг дахин дахин тавьсаар байв. *Иллюминатигийн алуурчин эндээс гарна гэж яаж төлөвлөсөн юм бол? Энэ олон хүний дундуур кардиналыг авчраад олны нүдэн дээр хөнөөнө гэж яаж бодсон юм бол?* Ландон Микки Маустай цагаа харвал 8.54 болж байлаа. Зургаан минут дутуу байв. Оливетти урд суудлаас эргэж Ландон, Виттория хоёрын нүүр рүү эгцэлж хараад: «Та хоёр Бернинигийн ... туйпуу, хавтан, юу ч билээ ... тэр чөтгөрийнх нь юман дээр очоод зогсож бай. Халхавч нь урьдынх шигээ шүү. Та хоёр жуулчин, юм харвал гар утсаараа дохь!» гэв. Ландоныг юм хэлж амжаагүй байтал Виттория машинаас гарчихсан, гарыг нь татаж байлаа. Хаврын наран Гэгээн Петерийн ордны араар жаргаж, сүрлэг ордны сүүдэр талбайг бүхэлд нь хучжээ. Ландонд жихүүн санагдсан ч, Виттория сүүдэр нөмөрсөн талбай руу шууд л шургаад орчхов. Цугласан олны дунд ороод, Ландон зөрж өнгөрөх хүн бүрийн царайг түгшүүртэй еэ харан, алуурчин эдний дунд л байгаа даа гэж бодохоос улам жихүүцнэ. Тэгэхэд, ганц Витториагийн гар л дулаахан санагдаж байлаа. Ватиканы босго алхсан бүхэн бишрэн сүрдэх ёстой хэмээн Бернинигийн төсөөлж хийсэн зохиомж нээрэн л сүрдэж бахдам байлаа. Сүрдсэн, бас өлссөн хэмээн Ландон бодсоноо, яаж ийм тэнэг бодол ийм чухал мөчид орж ирснийг өөрөө гайхав. «Гэрэлт хөшөө рүү юу?» гэж Виттория асуув. Ландон толгой дохин, талбайн зүүн хэсэг рүү эргэлээ. Виттория хурдан атлаа, энгүүн алхахыг хичээн: «Цаг?» гэв. «Дөрвөн минут дутуу байна». Виттория юм хэлээгүй ч, Ландон гарыг нь атгаж байсан болохоор, гараа шийдмэг чивчирэхийг мэдрэв. Гар буу өвөрт нь байж л байлаа. Витториаг, арай ч буугаа гаргаад ир гэж хэлэхгүй болов уу гэж бодон, нүүр рүү нь харав. Дэлхий дээрх бараг бүх мэдээллийн агентлаг цуглачхаад байхад, Виттория буу бариад, алуурчны толгойг хага буудна гэж Ландон л лав төсөөлж чадахгүй байлаа. Гэхдээ л, кардиналыг хөнөөлгөөд, цээжин дээр нь тамгалуулж байснаас, тэгсэн нь дээр. *Хий. Эрдмийн хоёр дахь махбод.* Хийн тамга ямархуу хийцтэй бол, бас кардиналыг хэрхэн хөнөөх бол хэмээн төсөөлнө. Гэгээн Петерийн талбайг дахин нэг удаа хянавал, гантиг чулуун дэвсэг хөл доор нь нэлийж, эргэн тойрон Швейцар жард харуулдан байх ажээ. Хассассин кардиналыг хөнөөдөг юм аа гэхэд, эндээс хэрхэн зугтахыг бүү мэд дээ. Талбайн голд, Калигулагийн Египетээс авчирсан 350 тонн хүнд гэрэлт хөшөө байлаа. Тэнгэр рүү наян нэгэн метр өндөр шовх хатгасан, пирамид хэлбэртэй энэ хөшөөний дээр загалмай тогтоожээ. Нарны сүүлчийн туяаг ойлгох тэр загалмайд, Христийг хадсан загалмайн үлдэц байдаг гэнэ. Хоёр усан оргилуур гэрэлт хөшөөнөөс яг тэнцүү зайд, тэгш хэм үүсгэн байрлажээ. Урлаг судлаачид, энэ хоёр усан оргилуур яагаад зууван талбайн, захын хоёр тойргийн төвд баригдсан учрыг олдоггүй: Ландон ч саяхныг хүртэл мэддэггүй байлаа. Харин, өнөөдөр Ром хот тэр чигтээ пирамид, зууван, геометрийн тэгш хэмээр дүүрсэн мэт санагдана. Хөшөө ойртоод, Витториагийн алхаагаа удааширлаа. Бүсгүй нэлээн амьсгаадаж, Ландон ч аяыг нь даган мөрөө суллан, бөхийсгээд гүн амьсгаа аван, цээжээ түхийлгэлээ. Хөшөөний эргэн тойрон, хаа нэгтээ дэлхийн хамгийн том сүмийн дэргэд эрдмийн хоёр дахь тахил - Бернинигийн Өрнийн салхи, Гэгээн Петерийн талбай дахь зууван хавтан - байж байлаа. Гунтер Глик Гэгээн Петерийн талбайг тойрсон олон баганын сүүдэр даган, нэхмэл пиджактай эр, бор шорттой хүүхэн хоёрыг ажиглан, зогсож байв. Ерийн өдөр бол тэднийг анзаарахааргүй

байлаа. Тэр хоёр зүгээр л талбай тойрч яваа жуулчин шиг харагдана. Гэхдээ, өнөөдөр ерийн өдөр биш байлаа. Утасны дуудлага, хүүр, Ромоор давхилдах дугааргүй машин, юугаа хайсныг бурхан л мэдэх нэхмэл пиджактай эр гэх мэт адал явдал, оньсого дүүрэн өдөр байв. Глик тэднийг тасрахгүй дагана. Глик талбайн цаана яваа Макриг олж харав. Бүсгүй, талбайгаар зугаалах мэт яваа хосын эсрэг жигүүрт, Гликийн оч гэсэн газар нь оччихсон, явж байлаа. Макри камераа энгийн байдалтай авч явж, уйдсан сурвалжлагчийн дүрийг эсгэх гэж оролдовч, Гликтэй л адил шохоорхож байгаа нь илт байв. Түүнээс өөр нэг ч сурвалжлагч талбайн гүн рүү тийм хол ороогүй болохоор, ВВС гэх агентлагийн нэрийг камер дээр нь бичсэн хүүхэн, зарим жуулчны нүдийг эрхгүй татаж байв. Нас барсан нүцгэн өвгөнийг машины тээш рүү шидэж байгаа бичлэгийг, яг энэ эгшинд, машин дотроос нь VCR-аар төв рүүгээ дамжуулж байлаа. Бичлэг - хүн бүхний толгой дээгүүр, агаарын цэнхэр долгионоор Лондон рүү нисч байв. Редактор нь юу хэлэх бол? Энгийн хувцас өмссөн цэргүүд хүрэхээс өмнө, Макритай хамт хүүрт хүрч бичлэг хийхийг Глик хүснэ. Өмнө нь, сүмийн тэнд байсан цэргүүд талбайг аажим бүсэлсэн байлаа. Ямар нэг том юм болох нь ч болох шинжтэй. *Хэвлэл гэдэг үймээн тарих сайхан зэвсэг шүү дээ* гэж алуурчин хэлж билээ. Глик шуугиан тарих том боломж алдчих вий хэмээн үнэхээр их айна. Тэр - хэвлэлийн бусад машины байдлыг алсаас ажиг, Макриг нөгөө хачин хосыг талбайн цаанаас хэрхэн дагахыг харна. Шуугиан тарих үйл явдал удахгүй болох гээд байгаа санагдана.

Хэсэг 74

Ландон хайж яваа юмаа, элбэг арван алхмын цаанаас олж харлаа. Бернинигийн Өрнийн салхи гэх цагаан өнгийн зууван чулуун хавтан - талбайг бүрхсэн бусад саарал гантигаас илэрхий ялгаран байхыг Витториа ч бас харжээ. Бүсгүйн гар татавхийхийг Ландон мэдрэв. «Аажуухан гэм. Пиранха миранхагаа хий!» гэж Ландон шивнэв. Витториагийн атгасан гар суларлаа. Хавтан руу дөхөх тусам бүх юм гайхалтай хэвийн байх шиг санагдана. Талбайн хүрээ дотор жуулчид гайхдагаараа гайхацгааж, хандмаа нар хөөрөлдөж, нэг жаахан охин гэрэлт хөшөөний доор суусан тагтаанд будаа цацна. Ландон Миккитай цагаа харах гэснээ болив. Цаг тэртээ тэргүй бараг болчхоод байлаа. Ландон, Витториа хоёр алхаагаа удаашруулсаар, Бернинигийн Өрнийн салхи дээр очиж, ерийн жуулчид талбайг сонирхож яваа мэт энгийн байдалтай зогсов. Өрнийн салхи хэмээн Витториа хавтан дээрх бичгийг уншлаа. Ландон зууван хавтан дээр зогсож, доош харна. Энэ хавтанд ач холбогдол огт өгч байгаагүйгээ бодохоор: «Ямар гэнэн байсан юм бэ?» гэж бодогдоно. Урлагийн түүхийн нэг ч номдоо, Ромд хийсэн олон аяллынхаа нэгэнд нь ч Бернинигийн Өрнийн салхи-д, өнөөг хүртэл ач холбогдол өгч байсангүй ажээ. Гурван тохой орчим зууван, гантиг дээр Өрнийн салхийг ангель мэт төрхтэй болхидуухан дүрсэлсэн байв. Бернини тэр ангелийн амнаас бурхны амьсгаа - Ватиканаас гадагш хүчтэй салхи үлээж байгаа маягтай дүрсэлжээ. Энэ бол эрдмийн хоёр дахь махбод Хий-нд бүтээсэн Бернинигийн өргөл байжээ. Ландон харах тусам шинэ шинэ онцлог нээж байв. Ангелийн амнаас таван амьсгаа гарч байгаагаар зуржээ ... нөгөө л тав! Түүнээс гадна, хоёр ширхэг гялалзах од байлаа. Тэр Галилеогийн тухай санав. *Хоёр од, таван амьсгал, пирамидууд, зуувангууд, тэгш хэмүүд.* Толгой нь элдэв бодол, таамгаар дүүрнэ. Витториа Ландоныг хөтлөөд, нөгөө хавтангаас холдож орхив. «Нэг хүн бид хоёрыг дагаад байх шиг байна». Ландон гайхан: «Хаана?» гэв. Витториа хариу хэлэлгүй, гучин алхам орчим явангаа, Ватиканы ордны бөмбөгөр оройг заан, Ландонд юм хэлж байгаа юм шиг дүр үзүүллээ. «Талбай дээр ирснээс хойш л дагаад байгаа юм», гэснээ тун санамсаргүй мэт эргэж харснаа: «Байж л байна, яваад байгаарай» гэв. «Нөгөө хассассин уу?» Витториа толгой сэгсрэн: «Иллюминати арай ч ВВС-ийн камер барьсан хар хүүхэн хөлслөөгүй байлгүй дээ» гэлээ. Гэгээн Петерийн ордны сүмийн хонх чих дүлийртэл чанга цохилж эхлэхэд, Ландон, Витториа хоёр цочин түгшиж, царай нь хувьсхийнэ. Цаг болжээ. Тэр хоёр камер барьсан хүүхнээс алдуурах гэж хавтанг бараг нэг бүтэн тойрсноо, одоо харин хавтан руугаа эргээд чиглэв. Чанга чанга царгих сүмийн хонхыг эс тооцвол, бүх юм байдгаараа л байлаа. Жуулчид гайхдагаараа гайхацгаана. Орон гэргүй нэг согтуу гэрэлт хөшөөний зүг гэлдэрнэ. Нөгөө охин тагтаагаа тэжээсэн хэвээр. Нөгөө сурвалжлагч алуурчныг үргээж орхисон юм болов уу гэж Ландон бодлоо. *Үгүй байх аа,* гэж өмнөх бодлоо орхин, *танай кардиналуудыг хэвлэлийн баатар болгоод өгнө өө* гэж алуурчны хэлснийг санав. Сүмийн хонх есөн удаа цохилж дуусмагц, хүн бүрийн чихний хэнгэргийг чанга чанга балбаж байснаа гэнэт больчихсон болоод тэр үү, талбай гэнэт нам гүм боллоо. Гэтэл, анир чимээгүйг, жаал охин аймшигтай цочин хашхирах дуу эвдлээ.

Хэсэг 75

Охин дээр хамгийн түрүүнд Ландон гүйж очив. Хөөрхий охин айсандаа зэвхийж

хөшчихсөн, гэрэлт хөшөөний доорх одон дээр суусан навсар хар согтуу руу хуруугаараа зааж байлаа. Тэр хүн, харваас, Ромын орон гэргүй пөөнөгөрүүдийн нэг: нүүрнийх нь өмнүүр ширэлдсэн саарал үс нь унжсан, хир даг болсон цувны тамтаг эгэлдрэглэсэн байв. Хашхирч байсан охин олны дунд ороод, алга боллоо. Ландон тэр согтуугийн зүг ухасхийв. Харанхуй бүрийд, согтуу пөөнөгөрийн цувны тамтаг нойтон үзэгдвэл ... хүний халуун цус нэвчин, урсч байлаа. Бүх юм нүд ирмэхийн зуур болж өнгөрөв... Хөгшин салганан салганасаар, эгц урагшаа татганан унав. Ландон ухасхийсэн ч, амжсангүй... Хөөрхий өвгөн нүүрээрээ талбайн чулуун шалыг тасхийгэл мөргөн, үхэтхийн уналаа... Тэгээд, огт хөдөлсөнгүй. Ландон хажууд нь гүйн ирээд, сөхрөн суух агшинд Витториа ч гүйцэж ирлээ. Хэлмэн цочсон олон хүн тэднийг тойрон бужигнав. Витториа хуруугаа гүрээнийх нь судсан тавьж үзээд: «Судас нь цохилж байх шиг байна. Эргүүл дээ» гэв. Ландон өвгөний мөрөөс нь угзарч, биеийг нь эргүүлэхэд, эгэлдэрсэн хувцас нь сулбайн гулсав. Нурууг нь нүцгэлэн, цамцыг нь доош нь угз татваас, нурууных нь яг голд арьсыг нь цоо түлсэн мөр байлаа. Витториа түүнийг буцааж угзран, биеийг нь эргүүлэв. Ландоны, нуруу хүзүүнийх нь заагт зүүгээр хатгачхав уу гэмтэй, ухаан мэдрэл нь огшоод явчихлаа. Цээжин дээр сийлсэн тамга энгийн мөртөө, аймшигтай байв. Хий «Хий!» гэж Витториа уншаад: «Зайлуул, энэ нөгөөдөх чинь байна шүү дээ» хэмээн сулхан хэлэв. Хаанаас ч юм бэ Швейцар жардын цэргүүд цутган ирж, олон түмнийг хориглон, энд тэндгүй захирамжлан, харагдаж үзэгдэлгүй алга болсон алуурчны эрэлд гарав. Ойр байсан хүмүүсийнх нь яриагаар бол, харавтар арьстай нэгэн залуу энэ гуйлгачинд хичээнгүйлэн тусалж, талбайн нэг захаас түшиж ирээд, бүр дэргэд нь хэсэг суун, халамжилж байснаа, гэнэт олны дунд уусан алга болжээ. Витториа хөгшний хувцсыг хэвлийгээс доош тайчин үзвэл, тамганы хоёр хажууд, хавирганых нь доод талд, цоолсон шарх байна. Бүсгүй өвгөний толгойг гэдийлгэн, хиймэл амьсгаа хийлээ. Өвгөний ам руу дөнгөж үлээтэл, хоёр уушгинд нь гаргасан цоорхойгоор, яг л халим загас ус цацах мэт, цус цацран олгойдож, Ландоны нүүр рүү үсчлээ. Витториа хийсэн үйлдэлдээ өөрөө цочин, давхийж: «Яана аа? Уушгийг нь... цоолчихсон байна шүү дээ!» гээд суунтусав. Ландон нүдээ арчаад, цус гожигдох хоёр нүхийг элий балай юм шиг мэлийнэ. Кардиналын уушгийг хөнөөчихсөн байв. Швейцар жард ирэхэд, Витториа хүүрийг цувных нь тамтагаар хучиж байлаа. Ландон босох гэтэл газар дайвалзлаа. ВВС-ийн камер барьсан хүүхнийг дэн дун олж харав. Тэр камераа мөрөн дээрээ тавиад, тэдэн рүү чиглүүлэн, бүхнийг нэгд нэгэнгүй бичиж авч байлаа. Тэгснээ, Ландонтой харц тулгараад, муур шиг нэг мурилзаад, алга болчихлоо.

Хэсэг 76

Чинита Макри гүйхээрээ ирлээ. Насаараа хүлээгээд олдохгүй үнэтэй бичлэг хийжээ. Гэгээн Петерийн талбай дахь олны дундуур шурган гүйхэд, видео камер нь хүнд гэж жигтэйхэн санагдана. Хүн бүр л зам хөндөлсөн, эсрэг зүг рүү нь явах шиг ... зөрөөд ч байгаа юм шиг ... барьж авах гээд ч байгаа юм шиг. Макри аль болох хурдан, хэргийн газраас холдохыг хичээнэ. Нэхмэл пиджактай эртэй харц тулгарсан - удахгүй, хүмүүсээ хойноос нь илгээнэ .., нэхээд ирэх вий..., хар хувцастай баахан хүн ... олны дундаас ... энд тэндээс нь гэнэт гарч ирэх вий... гэж эмээнэ. Макри дөнгөж сая маш чухал баримт буулгаж авсан боловч яг юу бичээд авснаа сайн мэдэхгүй эмээж явлаа. Нас барсан тэр хүн нөгөө кардиналуудын нэг мөн болов уу? Гликийн яриад байсан, нөгөө учир нь олдохгүй утасны яриа бараг л үнэн болж байгаа хэрэг үү? ВВС-ийн машин руу эрчээрээ гүйж яваа бүсгүйн өмнө, гэнэт ... юу ч хийхэд бэлэн, шийдчихсэн байртай, цэрэг маягийн нэгэн залуу халз гараад ирэв. Тэр хоёрын харц тулгараад, хоёулаа зогтусав. Эгшин зуур залуу гар холбоогоо өргөн, ямар нэг юм

ярилцаад авлаа. Тэгснээ, бүсгүйн зүг шийдэмгий алхахад, Макригийн зүрх амаараа гартал айж, олны зүг хойшоо алхлаа. Хүнд том хөл гар бүсгүйг нөмрөн авахын өмнөхөн, бичлэг хийсэн хуурцгаа камераас гаргаж, нурууныхаа орчим, бүсэндээ түргэхэн хавчуулаад, хувцсаараа хааж амжив. Махлаг болохоор, хүн анзаарсангүй бололтой, тарган гэдэгтээ амьдралдаа анх удаа, энэ эгшинд л баярлаж үзлээ. *Глик, чи муу хаана байна аа!* Өөр нэг цэрэг зүүн талаас нь нөмрөн ирэв. Макри хурсан олны зүг алхсаар, хоосон хуурцаг гаргаж ирээд, камертаа шургуулж орхив. Бусдыг нь бурхан мэдэх хэрэг ... ВВС-ийн мухлаг тэрэгнээс гучхан алхмын наана, элгээ эвхсэн хоёр залуу бүсгүйн замыг хөндөлсөн, давшилж явлаа. «Хуурцагаа өг! Өгөөч!» гэж араас нь нэг залуу зандрав. «Үгүй шүү» гэж Макри мөчөөгөө өгөлгүй, гараараа камераа халхлан зогсов. Нэг залуу пиджакийнхаа хажуу талыг дэлгэн, сугандаа зүүсэн буугаа харууллаа. «Тэгээд бууд л даа» гэж Макри хэлснээ, ямар зоригтой хэлчхэв ээ гэж өөрөө гайхав. «Хуурцаг аа!» гэж эхний залуу давтан шаардана. *Золигийн муу Глик хааччихав аа?* Макри байдаг чадлаараа: «Би ВВС-ийн зураглаач байна. Чөлөөт хэвлэлийн хуулийн 12 дугаар зүйлийн дагуу энэ бичлэг бол Британий өргөн нэвтрүүлгийн корпорацын (ВВС) өмч мөн!» хэмээн хашхирав. Хоёр залуу түүнийг огт ажрахгүй зогсож байснаа, буутай залуу нь урагш нэг алхан: «Би Швейцар жардын дэслэгч байна. Таны зогсож буй улсын өмчийн тухай Ариун лүндэнгээр таныг нэгжиж, шаардлагатай эд зүйлийг хураан авч болно» гэлээ. Хүмүүс тэднийг бүчин шавах шинжтэй болов. Макри мөчөөгөө өгөлгүй: «Би Лондонд байгаа редактортайгаа зөвлөхгүйгээр ямар ч тохиолдолд энэ бичлэгийг та нарт өгөхгүй. Та нар ...», гэтэл яриаг нь таслан, нөгөө хоёр цэргийн нэг нь бүсгүйн гараас камерыг шүүрч аваад, нөгөө нь хоёр гарыг нь ард нь мушгиж зөрүүлээд, Ватикан руу түлхэв. Солиотой юмнууд хэмээн нэг залуу нь бувтнан, хурсан олны дундуур тууж явлаа. Макри битгий л намайг нэгжиж, хуурцгийн минь олчхоосой гэж бодно. Редакц руу дамжуултлаа хуурцгаа хадгалж чадвал ч... Гэнэт санаанд оромгүй юм боллоо. Олны дундаас нэг эр гарч ирээд, нуруунд нь наалдангаа, цамцных нь ар хормойг сөхөн, хуурцгийг нь авчхав. Бүсгүй хашхирдгийн даваан дээр болилоо. Ард нь амьсгаагаа түгжиж улайсан Гунтер Глик зогсоод, нүдээ нэг ирмэснээ олны дунд уусан алга боллоо.

Хэсэг 77

Роберт Ландон Папын бичгийн өрөөтэй залгаа, угаалгынх нь өрөөнд нүүрээ угааж байв. Нүүр, уруул руугаа цацагдсан цусыг дахин дахин угаана. Тэр өөрийнх нь цус биш, харин хэдхэн хормын өмнө, Ватиканы өмнөх талбайд, олны нүдэн дээр зэрлэгээр хөнөөгдсөн кардинал Ламазэгийнх байлаа. *Эрдмийн шүтээний өмнөх онгон тахил.* Хассассин заналаа гүйцээсээр л байв. Ландон толинд нүүрээ харвал, шал арчаагүй харагдлаа. Нүд нь бүлцийж гархилаад, хацар нь хонхойн харлачихжээ. Алтан тоногтой хар гантиг ханатай, хөвөн даавуун алчуур, анхилуун саван цөм бүрэн тансаг сайхан өрөөнд ганцаараа зогсоно. Цусанд будагдаж, түлэгдсэн тамга ой тойноос нь гардаггүй. Хий гэх тамга нүдэнд нь харагдсаар. Өглөөнөөс хойш, Иллюминатигийн гурван тамгыг нүдээрээ үзлээ ... цаана нь бас хоёр байгаа. Хаалганы гадаа, Оливетти, Рошер занги, камерлинго гурав юу хийхээ ярилцах нь сонсогдоно. Антиматерийг хайх ажил ахицгүй байгаа шинжтэй: харуулууд хайж олсонгүй, эсвэл Иллюминатигийнхан Ватиканд Оливетти захирагчийн бодсоноос илүү гүнзгий нэвтэрсэн бололтой. Ландон гар нүүрээ арчаад, жорлон хайсанд, суултуур харагдсангүй, харин зүгээр л нэг суулга байх ажээ. Тагийг нь онгойлгоод, дэргэд нь зогсов. Сэтгэлийн гүнээс нь харуусал оргилон, ясанд янгинаж, чөмөг царцтал гансарна. Гэнэт гэнэт юм дараа дараагаар болж, тэр бүрт нь сэтгэл эмтэрсээр, зүрх нь байдгаараа тамирджээ. Нойр хоолгүй, нойтон зэлмүүн

гүйж, тамлуулж, тарчилж, алуулсан хүний хөрж амжаагүй хүүрийг харж цочин цочирдсоор, сэтгэл нь тартагтаа тултал туйлджээ. Гэхдээ л, энэ бүх үйл явдлын эцэст учирч магадгүй аюулыг бодохоор, тайван байж чадахгүй байлаа. Бод л доо гэж өөртөө тушаавч, бодоод бодоод бодийн шийр дөрөв гэдэг л болоод байлаа. Гиюүрч байснаа, гэнэт эргэн тойрноо харав. Байна гэж зүүдэлж ч байгаагүй газраа байх ажээ. *Хөөх, энэ чинь Папын жорлон! Тэгээд, би Папын жорлонд бие засч байна, хэхэхэ...* хэмээн бодсоноо хөхрөв. *Папын ариун ширээ.*

Хэсэг 78

Лондонд, ВВС-ийн техникч хиймэл дагуулаас дамжуулж авсан бичлэгээ хуулаад, хяналтын өрөөгөөр дамжиж, Ерөнхий редакторын өрөөнд ороод, VCR тоглуулагчид нь хийгээд, ажиллуулах товчийг дарлаа. Бичлэг гүйж эхлэхэд, техникч бүсгүй - Ватикан хийдээс Гунтер Глик энэ бичлэгийг явуулж, ВВС-ийн фото архив - Гэгээн Петерийн талбай дээр нөгчсөн тэр хүнийг зөв таньсан зэргийг хэг ёг тайлбарлав. Ерөнхий редактор өрөөнөөсөө, хар хурдаараа гүйн ирж, хүн болгоныг сандчуулж эхлэв. Редакцад урсгалаараа явж байсан бүх ажил гэнэт зогслоо. «Таван минутын дараа бичлэгийг шууд цац! Кординаторууд, та нар холбоогоо бэлэн барьж бай. Ёстой гоё сурвалжлага, дүрстэйгээ байна шүү!!!» Маркетингийн зохицуулагч нар ч гүйлдэж эхэллээ. «Бичлэгийн урт?» гэж нэг нь хашхирав. «Гучин секундийн бичлэг» гэж ерөнхий редактор хариулав. «Агуулга?» «Хүн амины хэргийн шууд сурвалжлага». Зохицуулагч жаахан гайхсан байдалтай: «Ашиглах, лицензийн үнэ?» «Нэг удаад сая ам.доллар». Зохицуулагч гайхсанаа: «Юу гэнэ ээ?» гэв. «Дүлий юм уу, чи! Би ч гуйлгамаар байна шүү. CNN, MSNBC, тэгээд нөгөө гурван том нь! Утастаад превьюг нь үзүүл. ВВС энэ бичлэгийг үзүүлэхээс өмнө таван минут бодох хугацаа өг!» «Юу болоо вэ, чөтгөр гэж? Манай ерөнхий сайдыг амьдаар өвччихөө юү?» гэж нэг нь тэсэлгүй асуув. «Түүнээс ч сонин юм болоод байна аа» гэж ерөнхий редактор хариуллаа. Яг энэ эгшинд, Ромын хаа нэгтээ хассассин тавлаг сайхан буйдан дээр жаргалдаа умбан лаглайна. Домогт энэ газрыг бахдан гайхна. *Би Гэгээрлийн сүмд сууж байна, Иллюминатигийн ноохой.* Олон зуун жилийн турш энэ ноохой эндээ байсаар л байж дээ. Тэгээд, өмнө нь холбогдож байсан ВВС-ийн сурвалжлагч руугаа залгав. Дэлхий даяар хамгийн цочром мэдээг сонсох цаг боллоо.

Хэсэг 79

Витториа Ветра аяга ус балгаад, дөнгөж сая Швейцар цэргүүдийн нэг нь өгсөн бялуунаас амссан болж суув. Идэх хэрэгтэй гэж мэдэж байсан ч дур алга. Папын бичгийн өрөөнд хүмүүс бужигнан, хоорондоо чанга чанга ярилцана. Рошер занги, Оливетти захирагч, бас өөр зургаан харуул хохирлыг тооцон, цагийн байдлыг үнэлж, дараагийнхаа алхмыг ярилцана. Роберт Ландон цонхны дэргэд зогсоод, Гэгээн Петерийн талбай руу таг чиг гөлөрнө. Витториа хажууд нь дөхөж очоод: «Яах вэ?» гэлээ. Тэр толгойгоо сэгсрэв. «Бялуу идэх үү?» Тэр хоол харснаа, гэнэт огцом хөдлөн: «Тэгье, золиг гэж» гэснээ, бялууг бүхлээр нь амандаа хийчхэв. Вентреска камерлинго хоёр харуул дагуулсаар хаалгаар орж ирэх үед, ард нь ярьж байсан хүмүүсийн дуу намсав. Гарын даа гуай түгшсэн байртай байсан бол, одоо

цөхөрсөн царайтай болжээ. «Юу болоо вэ?» гэж камерлинго Оливеттигээс асуув. Царайнаас нь харвал, захирагчийг хариулахаас өмнө юу болсныг дуулсан шинжтэй байлаа. Оливетти дайны талбарт хохирлын тухай мэдээлж байгаа юм шиг товч цэгцтэй илтгэв. «Эбнер кардиналыг найман цаг дөнгөж өнгөрсний дараа дэл Пополо дахь Санта Мариагийн сүмээс амь үрэгдсэн байхад нь оллоо. Хахааж алаад, цээжин дээр нь «Шороо» гэсэн амбиграм дүрс тамгалсан байсан. Ламазе кардиналыг Гэгээн Петерийн талбай дээр, арван минутын өмнө уушгинд нь цоолж хөнөөсөн байхыг оллоо. «Хий» гэсэн амбиргам дүрсээр тамгалсан байсан. Алуурчинг барьж чадсангүй». Камерлинго өрөөг хөндлөн гулд алхан, Папын ширээний ард очоод, лагхийтэл сууж, толгойгоо бөхийлгөв. «Гидера, Баггиа хоёр кардинал амьд байгаа байх аа». Камерлинго толгойгоо өргөн, хилэнтэй царайгаар: «Захирагчаа, та намайг тайтгаруулах гээ юү? Хоёр кардиналыг аль хэдийн цааш нь харуулчхаад байна. Таныг эрж олж чадахгүй бол, тэр хоёр ч гэсэн удахгүй өөд болох байх шүү» гэв. Оливетти цэрэг хүний ёсоор: «Тэр хоёрыг олно оо. Итгэлтэй байна» гэлээ. «Итгэлтэй байна аа..? Өнөөг хүртэл бид дандаа л алдаад байна шүү дээ». «Тийм биш ээ. Бид хоёр тулаанд ялагдсан боловч дайнд бол ялна шүү. Иллюминатигийнхэн энэ үдшийг хэвлэлээр дамжуулан үймүүлэх гэж оролдсон. Одоогоор, бид түүнээс нь сэргийлж амжлаа. Хоёр кардиналыг хоёуланг нь үймээн болголгүй олсон» гэж Оливетти хэлснээ: «Түүнээс гадна Рошер занги антимаатерийг хайх ажил амжилттай явж байгааг илтгэсэн» гэлээ. Улаан береттэй Рошер занги урагшаа нэг алхав. Яв тав атлаа хатуу биш тэр залуу бусад харуулаа бодоход, арай л илүү хүн шиг санагдав. Рошерийн хоолойд нь сэтгэл хөдөлсөн шинж илрэх авч, дуу нь яг л хийл шиг ажээ. «Эрхэм ээ. Нэг цагийн дотор, бид канистерыг олж чадна» гэлээ. «Занги аа!» гэж камерлинго Рошерт хандан: «Би их гутранга юм ярьж байж магадгүй. Гэхдээ Ватикан хийдийг бүрэн нэгжихэд, бидэнд байгаа цагаас илүү цаг зарцуулна гэж би ойлгосон юм сан» гэв. «Бүрэн хайлт бол тэгнэ, эрхэм ээ. Гэхдээ, бид байдлыг нягталж үзээд, антимаатерийн канистерыг манай цагаан бүст - Гэгээн Петерийн талбай ч юм уу, музей ч юм уу — жуулчид нэвтэрч болох газар тавьсан байх гэж итгэж байгаа юм. Тэр газруудад бид тог таслаад, хайлт хийж байна». «Та нар Ватикан хийдийн багахан хэсэгт хайлт хийж байгаа юм уу?» «Тийм, сениор. Нэвтэрсэн этгээд Ватикан хийдийн дотоод хэсэг рүү орсон байх боломж тун бага. Алга болсон хяналтын камер уул нь, нийтийн нэвтэрч болох хэсэгт, музейн шатуудын нэгийг нь хардаг байсан юм. Тэд нийтийн нэвтрэх хэсэгт орж хяналтын камерыг хулгайлсан болохоор нийтийн зөвшөөрөгдсөн аль нэг газар антимаатерийг нуусан байх. Чухам тийм газруудад бид эрлээ төвлөрүүлээд байна». «Гэхдээ, тэр этгээд манай дөрвөн кардиналыг хулгайлсан шүү дээ. Тэгэхээр, бидний бодож байснаас илүү гүнзгий байгаа биз?» «Заавал тэгж бодох хэрэггүй. Кардиналууд өнөөдрийн ихэнх хэсгийг Ватиканы музей, Гэгээн Петерийн ордонд гаднын хүмүүс байхгүй үед өнгөрөөсөн. Тэдгээр, газрын нэгнээс нь кардиналуудыг хулгайлсан байж магад». «Тэглээ гээд, тэднийг яаж энэ хэрмээс авч гарсан байх вэ?» «Бид тэр талаар бас л ажиллаж байна». «Мэдлээ, мэдлээ» гээд камерлинго өндийж Оливетти рүү ирээд: «Захирагч аа, би нүүлгэн шилжүүлэх таны төлөвлөгөөг сонсмоор байна» гэв. «Төлөвлөгөө боловсруулах ажил ид явагдаж байна, эрхэм ээ. Гэхдээ, яг одоо бол Рошер занги канистерыг олно гэдэгт би бүрэн итгэлтэй байна шүү». Рошер талтай үг хэлсэнд нь талархан, хөлөө тас хийтэл хавсран: «Хүмүүс маань шалгах ёстой газрынхаа гуравны хоёрыг шалгасан. Бид бүрэн итгэлтэй байна» гэлээ. Камерлинго тийм ч итгэлтэй биш байгаа бололтой. Энэ эгшинд нэг нүднийхээ доогуур сорвитой нэг харуул газрын зураг барьсаар орж ирээд: «Ландон гуай! Би *Өрнийн салхи* -ны тухай таны хүссэнийг олоод ирлээ» гэв. Ландон зажилж байснаа залгиад: «Сайн байна. Харья даа» гэв. Хүмүүс ярилцаж байх зуур, Витториа Ландон хоёр Папын ширээн

дээр дэлгэсэн газрын зураг руу харуултай хамт дөхөв. Цэрэг газрын зураг дээр Гэгээн Петерийн талбайг зааж: «Бид энд байна. *Өрнийн салхи* -ны амьсгал чанх дорно зүг Ватиканы эсрэг чиглэжээ» гээд хуруугаараа Гэгээн Петерийн талбайгаас зүүнш, Тибер голыг гатлуулан, эртний Ромын төв хүртэл дагуулан заалаа. «Энэ шугам бараг л Ромыг хөндлөн гулд явж байна. Шугамын дагуу хорь орчим католик сүм байгаа» гэлээ. Ландон тун таагүй ярвайн: «Хорь оо?» гэв. «Олон ч байж магадгүй». «Тэр олон сүмээс хэд нь яг энэ шугамын дагуу байна вэ?» «Мэдээж, зарим нь бусдаасаа илүү ойрхон байна. Гэхдээ *Өрнийн салхи* -ийн амьсгал яг хаашаа чиглээд байгааг газрын зураг дээр үзүүлэхэд, мэдээж, наанатай цаанатай алдаа гарна л даа». Ландон Гэгээн Петерийн талбайг хэсэг харлаа. Тэгээд, эрүүгээ хэсэг маажсанаа: «Гол. Эдгээрийн аль нэгэнд нь галтай холбоотой Бернинигийн баримал байхгүй биз?» Хэн ч хариулсангүй. «Гэрэлт хөшөө. Эдгээрийн аль нэгийнх нь урд гэрэлт хөшөө байхгүй биз?» Харуул газрын зургийг ширтэн, хайж эхлэв. Ландоны нүдэнд оч гэрэлтээд явчхыг Витториа анзаарч, юун тухай бодож байгааг нь ч гадарлав. Зөв шүү! Эхний хоёр тэмдэг урдаа талбайтай, гэрэлт хөшөөтэй байсан. Магадгүй, тэр гэрэлт хөшөөнүүд тэмдэг байгаа газрыг дохиолдог байж болох юм. Тэнгэр баганадах пирамидууд Иллюминатигийн замыг дохиолдог байх. Витториа энэ тухай бодох бүр зөв юм шиг санагдаад байв. Ромын дөрвөн өндөр гэрэлт хөшөө эрдмийн шүтээнийг дохиолон сүндэрлэнэ. «Энэ ч таамаглал л даа» гэж Ландон хэлээд: «Гэхдээ Ромын олон олон гэрэлт хөшөөг Бернинигийн үед босгож, зөөж байрлуулсан юм даг. Тэр ажилд Бернини оролцсон байх нь гарцаагүй». Витториа үг нэмж: «Эсвэл Бернини тэмдгээ өмнө байсан гэрэлт хөшөөний хажууд тавьж болох» гэлээ. «Үнэн шүү» гээд Ландон толгой дохив. «Муу мэдээ дуулгахад, энэ зураасыг дагуулаад нэг ч гэрэлт хөшөө алга» гэж харуул хэллээ. Хуруугаа зураас дагуулан чирсээр: «Бүр ойрхон ч юм алга» гэв. Ландон санаа алдав. Витториа мөрөө хавчлаа. Уул нь, энэ их дажгүй санаа байлаа. даан ч, тэр хоёрын бодож байсан шиг тийм амар эд биш ажээ. Гэхдээ, бүсгүй урам хугалахыг бодсонгүй. «Роберт, бод доо. Бернинигийн галтай холбоотой бүх баримлыг чи мэднэ шүү дээ. Ямар ч хамаагүй баримал» гэв. «Би бодож л байна. Бернини маш олон бүтээл хийсэн. Зуу зуугаар нь. Би *Өрнийн салхи* нэг сүмийг онцгойлон заах байх гэж бодсон юм. Ядаж санаа өгөх юм руу хөтлөх байх гэж бодсон юм» гэв. «Фуосо, Гал гэсэн үг. Бернинигийн аль нэг баримал иймэрхүү нэртэй юү?» Ландон мөрөө хавчин: «Бернинигийн Галын наадам гэдэг алдарт гар зураг бий. Гэхдээ, тэр баримал биш. Тэгээд ч Германы Лайпцигт байдаг юм». Витториа урвайн: «Чи тэр амьсгал чиг зааж байгаа гэдэгт итгэлтэй байна уу?» «Чи өөрөө тэр хавтанг харсан шүү дээ, Витториа. Бүгдийг нь тэгш хэмтэй хийсэн байсан. Ямар нэг чиг заасан зүйл гэвэл тэр амьсгал л байсан шүү дээ». Түүний зөв гэдэг нь мэдээж байлаа. «Түүнээс гадна» гээд Ландон үргэлжлүүлэн: «*Өрнийн салхи* өөрөө хийг бэлгэдэж байгаа болохоор, бэлгэдлийн хувьд, амьсгалаа дагаж явах нь зөв» гэлээ. Витториа толгой дохиод: «За тэгвэл амьсгалаа дагая, гэхдээ хаашаа?» гэв. Оливетти дундуур нь орж ирээд: «За юу байна даа?» гэв. «Хэтэрхий олон сүм байна» гэж цэрэг хэлэв. «Хорин дөрөв, түүнээс ч олон. Тэгэхээр хоёр хоёр хүн сүм бүрт тавиад ...» «Боль, боль» гэж Оливетти таслаад: «Алуурчин хоёр удаа хаашаа очих вэ гэдгийг нь бид мэдсэн боловч алдчихсан. Олон хүн дайчилна гэдэг чинь Ватикан хийдийг огт хамгаалалтгүй орхиод, хайлтаа зогсооно гэсэн үг» гэлээ. «Бидэнд лавлах хэрэгтэй байх» гэж Витториа хэлээд: «Бернинигийн бүтээлийн индекс. Тэгвэл, цөмөөрөө гарчгуудыг нь гүйлгэхэд, ямар нэг санаа орж ирэх нь лав» гэв. Ландон эргэлзэнгүй: «Мэдэхгүй юм даа. Бернини Иллюминатид зориулж хийсэн бол тэр нь лав бүрхэг нэртэй байгаа байх. Магадгүй огт индексэд ороогүй ч байж магад» гэлээ. Витториа түүнийг үгүйсгэн: «Эхний хоёр баримал нэрд гарсан бүтээлүүд байсан, чи тэрийг нь ч мэдэж байсан

шүү дээ». Ландон: «Тийм л дээ» гээд мөрөө хавчив. «Гал гэдэг үгээр хайлт хийгээд, тэндээсээ зөв чигт байгаа бүтээлүүдийг нь түүвэл олж болно доо». Энэ зөв санаа гэдгийг зөвшөөрөхөөс өөр арга байсангүй. Ландон Оливетти рүү эргэж: «Бернинигийн бүтээлийн бүрэн жагсаалт хэрэгтэй байна. Мэдээж, Бернинигийн бүтээлийн тухай явган ширээний цомог байхгүй л биз дээ» гэв. «Явган ширээний цомог оо?» гэж асуухыг харвал, Оливетти анх удаа сонсож байгаа бололтой. «За тэр яах вэ? Ямар ч хамаагүй цомог. Ватиканы музейд эрх биш Бернинигийн цомог байгаа биз дээ?» Нүдэндээ сорвитой харуул сандрангүй хэлэв. «Музейн тогийг тасалчихсан. Каталог нь нүсэр том шүү дээ. Туслах хүнгүйгээр ч явахгүй дээ» гэлээ. Оливетти дундуур нь таслан: «Бернинигийн бүтээл гэнэ ээ? Тэр энд Ватиканд ажиллаж байхдаа хийсэн бүтээлийн тухай та ярьж байна уу?» «Тийм шүү» гээд Ландон: «Тэр энд бүх насаараа суусан хүн. Тэгээд, яг Галилеотой шүүхдэлцэж байх үед шүү дээ» гэж тайлбарлав. Оливетти толгойгоо дохисноо: «Тэгвэл өөр нэг лавлах байж болох юм байна» гэв. Витториагийн нүдэнд оч гялалзаад явчхав. «Хаана тэр вэ?» Захирагч юм дуугарсангүй харуулаа авч эргээд, цаанаа хар хур хийн юм ярив. Харуулын нүд нь бүлтийж ирснээ, дуулгавартай яа толгой дохино. Оливетти даалгавар өгч дуусмагц, харуул Ландон руу эргэв. «Намайг дагаарай, Ландон гуай! Одоо ес, арван тав болж байна, яарахгүй горьгүй» гэлээ. Ландон харуулыг даган хаалгаар гарлаа. Витториа араас гарах гэтэл Оливетти гараас нь зуурч зогсоогоод: «Ветра авхай, тантай ярих юм байна» хэмээн тушаангуй хэлэв. Ландон харуул хоёр гарч одов. Оливетти модон мануухай шиг царай гарган Витториаг холдуулаад ярилцъя гэв. Тэр энэ тухай хэлэх гээд огт завдал гарсангүй байсаар өдийг хүрсэн бөгөөд одоо л нэг зай гарлаа гэж боджээ. Гэтэл, гар холбоогоор «Захирагч аа!» хэмээн хашхирав. Өрөөнд байсан бүх хүний анхаарлыг энэ дуу татлаа. Гар холбоогоор их л түгшингүй: «Та зурагтаа асаагаад өөрөө үзсэн нь дээр байх аа даа» гэлээ.

Хэсэг 80

Ландон хоёрхон цагийн өмнө Ватиканы нууц архиваас гарахдаа, хэзээ эргэж ирэх тухайгаа огт бодоогүй. Гэтэл одоо, тэр өөр нэг харуултай хамт дахиад л тийшээ яаран яаран гүйж явна. Түүнийг дагуулж яваа харуул өмнө нь шогшиж, замын хажуугаар шоо дөрвөлжин жижиг гэрэл хөхөлхийн, нарийн зам урд нь дурайх ажээ. Нууц архив өмнөхөөсөө ч илүү дүнсгэр, хүрлийн угтав. Зэгзийм хүйтэн байдлыг харуул л эвдэж, амь оруулж, Ландон түүнд талархаж байлаа. «Энд байдаг байх аа» хэмээн Ландоны дагуул хана дагуулан өрсөн хэдхэн хорготой хамгийн сүүлийн өрөө рүү дагуулан ирлээ. Шилний цаанаас өлийн товъёог нь уншиж байснаа: «Аа, энд байна. Яг л захирагчийн хэлсэн газар байна шүү» хэмээн бувтнав. Ландон гарчгийг нь уншив. *Attivi Vaticani*. Ватиканы хөрөнгө гэнэ үү? Товъёогоос нь гарчиг руу нь орж уншив. Үл хөдлөх хөрөнгө... Валют ... Ватиканы банк ... эртний эдлэл ... хэмээн жагсаалт үргэлжилнэ. «Ватиканы бүх хөрөнгийн бүртгэл» хэмээн харуул тайлбарлав. Ландон шоо дөрвөлжин нэг юм олж харлаа. Ээ гэгээн эзэн минь. Энд юу боосныг хэн ч хэлж чадахаар байлаа. «Ватиканы захиалгаар хийсэн Бернинигийн бүх бүтээлийн жагсаалт энд байгаа гэж захирагч хэлсэн» гэлээ. Захирагчийн зөн бараг л зөв байж таарлаа шүү гэж Ландон бодов. Бернинигийн үед Папын захиалгаар хийсэн бүх зүйл хуулийн дагуу Ватиканы өмч хэмээн бүртгэгддэг байв. Тийм харилцаа захиалгаар хийдэг бизнес гэхээс илүү феодалын харилцаа маягтай агаад хамгийн мундаг уран бүтээлчдийг Ватикан бараг л худалдаад авчихдаг, урчууд нь ч төдийлөн гомдоллодоггүй, харин ч сайрхдаг байлаа. «Ватиканы гадна байгаа баримлууд ч энд бас бүртгэлтэй байдаг хэрэг үү?» гэж Ландон асуув. Харуул толгой дохиод :«Мэдээж шүү дээ. Хууль ёсоор, Ромын бүх католик сүм, хийд

Ватиканы өмч байдаг юм» гэлээ. Ландон бүрэн жагсаалт гартаа барьж байлаа. Тэр жагсаалтад Өрнийн салхи-ны амьсгал үлээсэн зүг тэд хорь гаруй сүмийн нэрс, эд хөрөнгийнх нь бүртгэл байв. Эрдмийн гурав дахь шүтээн эдний л нэг байж таарна, тэрийг нь олно доо. Ерийн цагт сан бол, тэр сүм нэг бүрийг тухайлан сонирхох байсан ч одоо бол бүгдийг нь шүүгээд, Бернинигийн галд зориулсан бүтээлийг олоход, ердөө л хорин минут хэрэгтэй байв. Ландон эргэлддэг цахим хаалгаар дотогш орсонд харуул хөдөлсөнгүй. Ландон түүн рүү эргэж хараад : «Агаар нь бага боловч амьсгалж болохоор шүү» гэв. «Надад таныг энд хүргэж өгөөд, буцаад аюулгүйн төвд яаралтай ир гэж тушаасан» гэв. «Та буцах гэж байгаа юм уу?» «Тийм. Швейцар жард архивд орох эрхгүй. Би таныг энд хүргэж ирснээрээ тэр журмыг зөрчиж байгаа юм. Захирагч надад энэ тухай бас сануулсан». «Журам зөрчих өө?» Энэ шөнө энд юу болоод байгаа тухай ер нь ойлгож байна уу? «Тэр захирагч ер нь хэний талд ажиллаад байна вэ?» Үүнийг сонсоод, харуулын нүүрэн дээр байсан бүх уриалагхан шинжүүд гэнэт алга болон хувьсаад, нүд нь доорх сорви нь татганаад явчхав. Тэр залуу гэнэт, яг л Оливетти шиг харагдана. «Өршөөгөөрэй!» гэж Ландон сая хэлсэн үгэндээ үнэхээр гэмшин: «Надад тусламж хэрэг болж магадгүй гэж бодоод л ...» гэв. Харуул хөдөлсөн ч үгүй. «Би тушаал гүйцэтгэж сурсан. Түүнээс тушаалын зөв бурууг мэдэхгүй. Та хэрэгтэй юмаа олмогцоо, даруй захирагчтай холбоо бариарай!» Ландон: «Тэгээд тэр чинь хаана байж байх юм бэ?» хэмээн уцаарлав. Харуул гар холбоогоо тайлаад, ширээн дээр тавингаа: «Нэгдүгээр суваг шүү» гэгчхээд, харанхуйд далд орлоо.

Хэсэг 81

Папын ажлын ширээний яг өөдөөс харсан гоёмсог хананд том гэгч Хитахи зурагт байдаг ажээ. Ажлын өрөөний цонх онгорхой, хүн бүхэн тэр зурагтын өмнө цуглав. Дэлгэц халж ирмэгц бүлтгэр нүдтэй, хүрэн үстэй залуухан эмэгтэй сурвалжлагч гарч ирлээ. «MSNBC-ийн мэдээ» хэмээн бүсгүй хэлээд: «Кэлли Хоран-Жонс Ватиканаас шууд мэдээлж байна» гэв. Түүний цаана, Гэгээн Петерийн ордон цонхныхоо бүх гэрлээ гялтгануулан, харанхуйд бүрсийн харагдаж байх ажээ. «Шууд ч биш байна даа. Эвлүүлэг байна. Ордны бүх гэрэл унтраастай байгаа» гэж Рошер гоочилно. «Чшш!» гэж Оливетти түүнийг чимээгүй болгоодохов. Сурвалжлагч их л түгшүүртэй еэ өгүүлнэ. «Өнөө орой Ватиканд олон олон почирдом үйл явдал өрнөж байна. Цуурганд орж байх ёстой хоёр кардинал Ромд хэрцгийгээр хөнөөгджээ». Оливетти: «Хөөх!» гэж эхэр татан, уушгиныхаа гүнээс дуу алдав. Сурвалжлагчийг ярьж байх зуур, нэг харуул хаалган дээр гүйж ирээд: «Захирагч аа! Хяналтын өрөөний деспичерийн бүх утасны гэрэл асчихсан, болж байгаа явдлын талаар албан ёсны тайлбар өгөхийг..» Оливетти зурагтаас нүдээ салгалгүй ууртай яа: «Унтраа, тэр утасны самбарыг» гэлээ. Харуул гайхсанаа: «Гэхдээ, захирагчаа...» «Яв цаашаа!» Харуул явж одов. Камерлинго эргэж хараад, юм хэлэх гэснээ больж, Оливетти рүү муухай гэгч хэсэг харснаа, цаашаагаа зурагт руу харахыг Витториа анзаарав. MSNBC-ийн мэдээ цааш үргэлжилсээр. Швейцар жард кардинал Ебнерийн хүүрийг дэл Пополо талбай дахь Санта Мариагийн сүмээс гаргаж, Альфа Ромеогийн тээшинд хийх тэр эгшинд бичлэг зогсон, кардиналын нүцгэн биеийг татаж томруулан үзүүлэв. «Ямар золиг нь энэ зургийг авчхав аа?» гэж Оливетти тэвдэнэ. MSNBC-ийн сурвалжлагч үргэлжлүүлсээр. «Энэ бол Германы Франкфуртын кардинал Эбнер бололтой байна. Харин цогцсыг нь сүмээс гаргаж байгаа

хүмүүс бол Швейцар жард ажээ». Сурвалжлагч их л үнэмшилтэй ярьж байгаагаа үзүүлэх санаатай хөдөлж байв. Дараа нь, дэлгэц дээр дахиад л түүний нүүр томрон гарч ирлээ. «Одоо үзүүлэх гэж байгаа бичлэгийн өмнө, бид үзэгчдээ анхааруулах нь зүйтэй болов уу. Энэ бичлэг бодитой бөгөөд зарим үзэгчид маань зохимжгүй санагдаж магадгүй юм». Телевизийнхэн үзэгчиддээ санаа тавин ингэж анхааруулдаг ч энэ бол хүмүүсийг татах хуурмаг арга гэдгийг Витториа мэддэг тул дургүйцэн: «Хм!» гэв. Ингэж анхааруулсны дараа хэн ч сувгаа сольдоггүй билээ. Сурвалжлагч давтан: «Дахин анхааруулахад, энэ бичлэг манай зарим үзэгчид хэтэрхий цочроом байж магадгүй билээ». «Ямар бичлэг вэ? Та нар дөнгөж сая гаргачаа биз дээ» гэж хэлмэгцээ ... Оливеттигийн хэл нь гагцчихлаа. Зурагтаар хос хоёр Гэгээн Петерийн талбай дээгүүр явж байгааг үзүүлэв. Витториа, өөрийгөө Роберттой явж байгааг шууд л танилаа. Бичлэгийн хажуу бөөрөнд, ВВС-ийн өмч гэсэн бичиг гарч байв. Сүмийн хонх цохилно. «Үгүй байлгүй дээ» хэмээн Витториа дуу алдав. «Та чинь энэ бичлэгийг хураагаад авчихсан гээгүй билүү?» гэж Камерлинго Оливетти рүү хялайн асуув. Бичлэг дээр гэнэт нэг охин цочин хашхирлаа. Камер тэр охиныг хайж олох гэж, дүрс нь сарнин савчин байснаа, охины заасан цусанд автсан орон гэргүй гуйлгачин дээр тогтов. Роберт Ландон дундуур нь гүйн ирж, охинд туслахыг оролдоно. Дүрс улам тодров. Үйл явдлыг нэг нэгэнгүй үзүүлэх тусам, Папын бичгийн өргөөнд байгаа хүн болгоны царай улам барайн, дуугаа улам хураана. Кардинал нүүрээрээ талбайн хатуу шал тасхийтэл мөргөн уналаа. Витториа гүйж ирээд, тусламж үзүүлнэ. Цус, тамга. Хиймэл амьсгаа хийх гэж оролдоно, уушгинаас нь цус олгойдно. «Аймшигтай бичлэг» гэж сурвалжлагч хүч нэмэн: «Энэ бичлэгийг хэдхэн минутын өмнө Ватиканд хийсэн юм. Эх сурвалжийн мэдээлж байгаагаар бол, энэ хүн Францын кардинал Ламазе ажээ. Хөөрхий тэр кардинал цуурганд суухгүй, энд ийм хувцастай хэрхэн ирсэн нь оньсого хэвээр үлдлээ. Одоогоор, Ватикан энэ талаар тайлбар өгөхөөс татгалзаж байна» гэв. Тэгээд, бичлэгийг давтан үзүүллээ. «Тайлбар өгөхөөс татгалзсан гэнэ ээ» гэж Рошер эгдүүцэн хэлээд: «Ганц минут өгчих л дөө» гэв. Сурвалжлагч хөмсгөө атируулан ярьсаар л. «MSNBC энэ аллагын шалтгааныг тогтоохоор ажиллаж байна. Одоогоор энэ хэргийн хариуцлагыг өөрсдийгөө Иллюминати хэмээн нэрлэсэн бүлэглэл хүлээнэ гэдгээ мэдэгдээд байгаа юм». «Юу гэнэ ээ?» хэмээн Оливетти тэсэрчхэв үү гэлтэй, писхийтэл дуу алдав. «... Иллюминатигийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг манай вебсайтад зочилж..» «Non e possibile (Огт боломжгүй шүү дээ. ита.)» хэмээн Оливетти гайхна. Тэр сувгаа солив. Нэгэн испани бололтой залуу: «Иллюминати хэмээх сатаанлаг бүлэглэлийг зарим түүхч үзэхдээ ...» хэмээн гарна. Оливетти зурагтын удирдлагыг галзуу юм шиг даран, бараг бүх сувгийг сольж үзлээ. Суваг болгон шууд нэвтрүүлэг хийж, дийлэнх нь англи хэлээр ярьдаг суваг ажээ. « - Швейцар жард энэ орой нэгэн сүмээс нэг хүүр дамнан гаргаж ирсэн нь кардинал...» « - ордны болоод музейн гэрлийг унтраасан байгаа нь зарим талаар сэжиг төрүүлж байна ...» « -удахгүй сэрдэх онолч Тайлэр Тинглитэй уулзаж, болоод байгаа цочирдом үйл явдлын талаар ярилц ...» « - энэ үдэш дахин хоёр аллага үйлдэхээр төлөвлөсөн тухай жиг жуг ярьж байна...» « - Пап болж магадгүй байсан кардинал Баггиа бас алга болсон эсэхийг тодруулах...» Витториа зурагтаас холдов. Бүх юм хэтэрхий хурдан өрнөнө. Цонхны цаана харанхуй болж, хүний мууг сонсгосон эмгэнэлт мэдээ Ватиканы зүг улам олон хүнийг татан дуудаж байна. Агшин бүрт олон олон хүн нэмэгдэнэ. Явган хүмүүс талбайн зүг алхалж, сурвалжлагын багаар дүүргэсэн хэвлэлийн мухлаг тэргүүд ар араасаа цуварна. Оливетти зурагтын удирдлагыг тавиад, камерлингогийн өөдөөс харан: «Сениор. Энэ бүхэн яаж болсныг би мэдэхгүй байна. Бид тэр камерт нь байсан касетийг л авсан» гэв. Камерлинго үг дуугарч чадахааргүй болтлоо цөхөрсөн байлаа. Хэн ч

юу ч ярьсангүй. Швейцар жардын харуулууд анхаарлаа хөвчлөн, таг дуугүй зогсоно. Эцэст нь камерлинго ам нээж: «Энэ үйл явцыг бид хүссэнээрээ хянаж чадалгүй алдуурчээ» гэж уурлах ч сөхөөгүй, цөхөрсөн байдалтай хэлэв. Тэгснээ, хурсан олныг цонхоор хараад: «Би мэдэгдэл хийх хэрэгтэй юм байна» гэлээ. Оливетти толгойгоо сэгсрэн: «Үгүй, эрхэм ээ. Чухам үүнийг л Иллюминати хүсч байгаа. Мэдэгдэл хийвэл бид тэднийг нотолж, бэхжүүлж орхино. Чимээгүй байх хэрэгтэй». «Энэ хүмүүсийг тэгээд яах вэ?» гэж камерлинго цонхоор зааж: «Хормын дараа, хүмүүс арав, арван мянгаараа цуглана. Дараа нь, зуу зуун мянгаараа цуглана. Энэ үйл явдал олон олон хүнийг аюул руу дуудна. Хүмүүсийг анхааруулах хэрэгтэй. Тэгээд, кардиналуудыг нүүлгэх хэрэгтэй» гэв. «Цаг бас ч байна. Рошер зангид антимаатерийг олох боломж өгөөч». Камерлинго ууртай эргэн хараад: «Чи надад тушаах гээ юу?» гэв. «Үгүй, танд зөвлөж байна. Гадаа байгаа хүмүүсийг тараая гэвэл хий алдлаа гэж зарлаад, талбайг цэвэрлэж болно. Харин, Ватиканыг барьцаанд аваад байгаа тухай зарлавал бүр ч их аюултай». «Захирагч аа, би танд дахиад хэлье. Дэлхий дахинд, би энэ ариун өргөөнөөс худал хэлж чадахгүй. Ямар нэг юм би хэлбэл, тэр үнэн байх болно». «Үнэнийг үү? Ватиканыг сатаанлаг бүлэглэл заналхийлээд байна гэж үү? Ингэвэл, байдлыг улам дордуулна шүү дээ». Камерлинго мэлийн: «Бидний байдал хэр зэрэг дордоно гэж?» гэв. Энэ зуур Рошер занги зурагтын удирдлага авч дууг нь чангалав. Хүн бүхэн зурагт руу харлаа. MSNBC-ийн нэвтрүүлэгч хүүхэн дахин дэлгэцнээ гарч ирэхэд, дэлгэцийн хажууд талийгаач Паптны зургийг томоор тавьсан байв. «Шуурхай мэдээ. ВВС-ээс дөнгөж сая дамжууллаа» гээд, тэр хүүхэн камерын цаана байгаа найруулагчаасаа энэ тухай үнэхээр ярих хэрэгтэй эсэхэд тээнэгэлзэн, нүдээрээ асуув. Тэгснээ, нотолсон дохио авсан бололтой, царай нь их л төлөв болж: «Иллюминати дөнгөж сая» гэснээ түгдчин: «... Дөнгөж сая арван таван хоногийн өмнө талийгаач Паптныг хөнөөсөн гэдгээ хүлээлээ» гэв. Камерлинго амаа ангайн гайхжээ. Рошер зурагтын удирдлагыг байранд нь тавив. Витториа сая юу хэлчхэв ээ гэж гайхан, ухаарч ядан байв. «Ватиканы хуулиар бол Папын биед задлан шинжилгээ хийж байгаагүй, тиймээс Иллюминати аллага хийсэн тухай мэдээ нотлогдохгүй байж магадгүй юм. Гэлээ ч, Иллюминати талийгаач Папын үхлийн шалтгаан бол харвалт биш, хордолт хэмээн мэдэгдэж байна». Өргөө дахиад л огт чимээгүй болчхов. Оливетти хагартлаа уурлан: «Галзуу юмнууд ширэн нүүрлээд, худлаа ярих юм!» гэлээ. Рошер дахин дахин суваг солино. Мэдээ, яг л халдварт өвчин шиг, сувгаас сувагт давтагдаж, бүгд яг ижил мэдээ цацна. Гэхдээ, толгой гарчиг нь шуугиан тарих хамгийн ончтой томьёоллууд байж ажээ. Ватикан дахь аллага Хорлогдсон Пап Сатаан Бурхны асрыг ганхуулав Камерлинго харцаа буруулан: «Бурхан минь, аварч тэтгээч!» гэв. Рошер дахин нэг суваг тогтоон үзэв. ВВС-ийн мэдээний ширээн дээр төлөв царайтай нэг эр сууна. Улаан сахалтай, гажиг царайтай хүний зургийг дэлгэцийн дээд буланд тавиад, зургийнх нь доор Гунтер Глик - Ватиканаас шууд гэж бичжээ. Глик утсаар холбогдсон бололтой, яриа нь тасалдаж байв. «Зураглаач бид хоёр кардиналын цогцсыг Чиги сүмээс гаргаж байхад нь бичлэг хийсэн юм» гэлээ. «Үзэгчиддээ дахин сануулахад ВВС-ийн сурвалжлагч Гунтер Глик энэ үйл явдлыг хамгийн түрүүнд сурвалжилсан хүн юм. Иллюминатигийн алуурчин гэх хүнтэй тэрээр хоёр удаа утсаар холбогджээ. Гунтер, алуурчин хэдхэн хормын өмнө тань руу утастаж, Иллюминатигаас мэдээ дамжуулсан гэв үү?» «Тэгсэн». «Тэр, Иллюминати - талийгаач Паптны үхэлтэй ямар нэг хэмжээгээр холбоотой гэдгээ хүлээсэн гэв үү?» гэж нэвтрүүлэгч асуухдаа, нэг л итгэл муутай сонсогдоно. «Тийм, тийм. Тэр надад хэлэхдээ, Пап Ватиканыхны бодож байгаачлан, харвалт бол өнгөрөөгүй, харин Иллюминати түүнийг хорлосон юм гэсэн». Өргөөнд байсан хүн бүхэн амьсгаа даран чагнана. «Хорлосон гэнэ ээ?» хэмээн нэвтрүүлэгч түгдчин: «Яаж?» гэв. «Тодорхой юм огт

хэлээгүй» гэж Глик хэлснээ: «Гэхдээ тэр ...» гээд утасны цаанаас цаас шажигнах чимээ сонсогдсоноо: «Херапин гэх бодисоор хордуулсан гэсэн» гэлээ. Камерлинг, Оливетти, Рошер гурав бие бие рүүгээ айх гайхах зэрэгцсэн харцаар харцгаав. «Херапин?» гэж Рошер асууснаа: «Энэ чинь нөгөө ...» Камерлинг хүрлийн: «Паптын эм шүү дээ» гэв. Виттория гайхан: «Пап херапин хийлгэж байсан юм уу?» гэв. «Цус бүлэгнэх өвчтэй байсан юм» гэж камерлинг хэлээд: «Өдөрт нэг удаа тариа хийлгэдэг байсан юм» гэв. Рошер гайхаш тасран: «Гэхдээ херапин чинь хор биш биз дээ. Яагаад Иллюминати» «Херапины тунг нь ихдүүлбэл үхлийн аюултай» гэж Виттория хэлэв. «Энэ чинь хүчтэй антикоагулянт. Их тунгаар хэрэглэвэл дотуур цус алдаж, тархи цусны дутагдалд ордог юм». Оливетти их л сэжиглэнгүй: «Ингэхэд, та яаж энэ тухай мэддэг юм бэ?» гэв. «Далайн биологичид тэнгисийн сүүн тэжээлтнийг хашихдаа, хөдөлгөөний дутагдлаас болж цусны blood clotting үүсэхээс сэргийлж, херапин хэрэглэдэг юм. Тунг нь буруу хэрэглэснээс болж амьтан үхэх тохиолдол бий» гэснээ: «Херапинийг их тунгаар хүнд хэрэглэвэл, харвалттай андуурах симптом өгч болох юм, ялангуяа, задлан хийхгүй бол» гэлээ. Камерлинг түгшсэн байртай харав. «Эрхэм ээ, энэ бол илэрхий Иллюминатигийн нийтэд зориулсан худал яриа! Папад тунг нь хэтрүүлж өгнө гэдэг байж болшгүй хэрэг. Хэн ч ингэж чадахгүй. Тэдний зөв байя гэхэд, түүнийг нь нотолж хэзээ ч чадахгүй. Папын хуулиар задлан хийхийг хориглодог шүү дээ. Тэртээ тэргүй херапинийг өдөр болгон хэрэглэж байсан болохоор задлах хийсэн ч гэсэн херапиний ул мөр олдож л таарна, тэр нь юу ч нотлож чадахгүй» гэлээ. «Үнэн шүү» гэж камерлингогийн хоолой чангарч эхэлснээ: «Гэхдээ өөр юм намайг зовоож байна. Дээрхийн гэгээнтэн ийм эмчилгээ хийлгэж байгаа гэж хэн ч мэдээгүй шүү дээ». Өргөөнд чимээгүй болов. «Үнэхээр херапиний тунг нь хэтрүүлсэн бол биед нь шинж тэмдэг илрэх ёстой» гэж Виттория хэлэв. Оливетти Виттория руу хандан: «Ветра авхай, та намайг сонсоогүй бололтой. Папын хуулиар Ватиканд задлан шинжилгээ хийхийг хориглодог юм. Дайснууд маань тийм ийм гэж хэлсний төлөө, бид Дээрхийн гэгээнтний ариун цогцсыг мэсээр эсгэж болохгүй» гэв. Виттория жаахан эвгүйцэн: «Би тэгье гээгүй ээ». Бүсгүй буруу зүйл ярьмааргүй, эвгүй сэтгэгдэл төрүүлмээргүй байлаа. «Мэдээж би Папын ариун биеийг хөндөх гээгүй» гэснээ дахин түгдчив. Чиги сүмд байхад, Робертын хэлж байсан санаанд орлоо. Папын авс ямагт газар дээр байдаг, цементээр огт хучдаггүй, эртний фараонуудын адил газар доор булшилбал сүнс нь түгжигдэж үлддэг гэж итгэдэг уламжлалтай ажээ. Зуу зуун фунтийн жинтэй тагийг зүгээр л авсан дээр нь тавьдаг, гравитацын хүчнээс өөр юм тэр тагийг хаадаггүй байна. Техникийн хувьд бол боломжтой л юм хэмээн бүсгүй бувгнав. «Ямар ямар шинж тэмдэг үзүүлдэг юм бэ?» гэж камерлинг гэнэт асуув. Виттория цочсондоо зүрх нь амаар гарчих шахав.»Тунг нь хэтрүүлбэл амны мукоса цус алддаг юм» гэлээ. «Амны юу гэнэ ээ?» «Хохирогчийн ам нь цус алддаг. Үхсэний хойно цус нь өтгөрч бөглөрөөд, амных нь дотор тал хар өнгөтэй болно» гэв. Виттория - Лондонгийн усан санд, нэг сургагч тунг нь санамсаргүй хэтрүүлээд, үхүүлчихсэн хоёр халим загасны зургийг харснаа санах. Хоёр халим усан дээр хөвчихсөн, ам нь ангархай, хэл нь тас хар болчихсон байлаа. Камерлинг юм хэлсэнгүй, босч цонхоор харав. Рошерийн итгэл төгс байдал замхарсан шинжтэй: «Сениор, хэрэв энэ мэдээ үнэн бол ...» «Худлаа!» гэж Оливетти тасалж хэлээд: «Гаднын хүн Паптан ойлгоно гэдэг уулаасаа боломжгүй» гэв. «Хэрвээ энэ үнэн бол, хэрвээ ариун эцгийг маань үнэхээр хордуулсан бол энэ антимаатерийг хайх ажиллагаанд шууд нөлөөлнө шүү» хэмээн Рошер хэлэв. «Хэрэв үнэхээр амь насыг хорлосон бол тэд бидний бодож байгаагаас ч илүү гүнзгий нэвтэрсэн байж таарна. Тэгвэл, цагаан бүсийг нэгжээд ч нэмэргүй. Хэрэв дотоод бүсийг бүхэлд нь нэгжье гэвэл, бид канистерыг олохгүй ч байж магадгүй нь» гэлээ. Оливетти занги руу тун муухай хяламхийн: «Занги аа, юу

болохыг би танд хэлж өгнө» гэж санууллаа. «Үгүй шүү» гэж камерлинго эргэж харснаа шууд Оливетти рүү эргэж: «Би танд юу болохыг хэлж өгнө шүү» гэлээ. «Энэ бүхэн хэтэрхий газар аваад байна. Би хорин минутын дараа цуурганыг завсарлуулах эсэх, кардиналуудыг нүүлгэн шилжүүлэх эсэх талаар шийдвэр гаргана. Шийдвэр эцсийнх. Ойлгомжтой юу?» гэв. Оливетти хөдөлсөнгүй. Дуугарсан ч үгүй. Камерлинго эргээд, чанга дуугарч эхэлсэн нь нөөцөд байсан эцсийнхээ хүчийг шавхаа юу гэлтэй. «Рошер занги, та цагаан бүсийг нэгжиж дуусмагцаа надад шууд илтгэ!» гэв. Рошер толгой дохингоо, Оливетти руу санаа зовсон байртай хяламхийв. Дараа нь камерлинго дагуул хоёр харуулдаа хандан: «BBC-ийн сурвалжлагч Гликийг энд авчир. Хэрэв Иллюминатигийн алуурчин түүнтэй холбоо барьж байгаа бол тэр залуу бидэнд туслах магад. Яв!» хэмээн илгээв. Хоёр харуул эгшин зуур алга болов. Тэгээд, бусад харуул руу эргэн: «Эрхэмүүд ээ. Өнөө орой дахиж хэн нэгэн амиа алдахыг би хармааргүй байна. Та бүхэн нөгөө хоёр кардиналыг арван цагийн дотор олж, эдгээр аллагыг үйлдсэн тэр мангасыг барьж ир. Ойлгомжтой юу?» гэв. «Гэвч, эрхэм ээ!» гэж Оливетти арцан: «Бид тэдний хаана байгааг мэдэхгүй байгаа шүү дээ» гэв. «Ландон гуай энэ талаар ажиллаж байгаа. Тэр чадах байх. Би сүсэглэж байгаа шүү» гэлээ. Тэгээд, тэрээр дахин эрс шийдмэгээр хаалга руу гарахдаа, гурван харуул руу дохин: «Та гурав надтай хамт яв!» гэж тушаав. Харуулууд дагав. Хаалгаар гарахынхаа өмнө камерлинго эргэж, Витториа руу хандан: «Ветра авхай, та ч бас надтай хамт явна уу» гэлээ. Витториа эргэлзэнгүй: «Та хаачихна вэ?» гэвэл, тэрээр хаалгаар гарангаа: «Сайн нөхрөө нэг эргэе дээ» гэв.

Хэсэг 82

СЭРН-д нарийн бичиг Силвий Боделок авхай гэдэс нь өлсөөд, гэртээ харихын түүс болж байв. Аз дутахад, Колэр захирал эмнэлэгт оччихоод, амьд гараад ирсэн төдийгүй түүнийг оройтож ажиллахыг гуйж биш, тушааж утастжээ. Тэгэхдээ, нэг ч тайлбар тавьсангүй. Энэ олон жилийн турш Силвиа өөрийгөө Колэрын хувьсгануур муухай ааш, дуугүй мөртөө хөгийн дарамттай зан, уулзалтаа сэмхэн тэргэнцрийнхээ гар дор байрлуулсан видео камераар бичиж авдаг зуршлыг нь тоохгүй байхаар програмчилсан билээ. Колэр, СЭРН дэх буудлагын тийрт өдөр болгон очдог, тэгэхдээ нэг өдөр өөрийгөө буудчихаасай гэж сэмхэн боддог ажээ. даан ч, Колэр бас ч тийм муу бууддаг хүн биш байв. Силвий одоо ажлынхаа ширээний ард, гав ганцаараа гэдэс нь хоржигнохыг сонсож сууна. Колэр ирээгүй хэвээр, тэгсэн мөртөө ийм тийм ажил хий гэж ч утастсангүй. *Золиг шиг энд өлөн, ажилгүй сууж байснаас* гэж бодмогцоо, цаас авч, Колэрт зурвас үлдээгээд, ажилчдын гуанз орж голоо зогоохоор гарав. Урьд нь бүсгүй хэзээ ч ингэдэггүй байлаа. Бүсгүй СЭРН-ийн ажилчдын гуанзны урт танхимаар явж байхдаа, бүх ажилчин хоолоо идэлгүй, гуанзны танхимын том зурагт дээр шавсныг анзаарав. Нэг их том юм болоод байгаа бололтой. Хүмүүсийн ард нь очиж зогсвол, «бит-толгойтнууд» гэдэг компьютерын залуу шазруун мэргэжилтнүүд тэнд сууж байлаа. Бүсгүй дээгүүр нь зурагтаар гарч байгаа мэдээний тэргүүн гарчгийг уншаад, ухаан алдах шахав. Ватикан дахь аллага Силвий сонссон зүйлдээ итгэсэнгүй. Эртний нэг нөхөрлөл Папыг хорлолоо гэнэ үү? Юугаар баталсан юм бэ? Үзэн ядалт нь уу? Эсвэл хайнга байдал нь уу? Гэхдээ л гуанзанд байгаа ерөнхий уур амьсгал их түгшүүртэй байв. Хоёр залуу мэргэжилтэн - Билл Гейтсийн зурагтай, доор нь Газар дэлхийг техникийнхэн өвлөнө гэсэн бичигтэй футболкоо дэврүүлэн гүйлдэнэ. «Иллюминати одоо ч байгаа гэж би та нарт хэлээгүй юу» гэж нэг нь хэлэв. «Би энэ чинь компьютер тоглоомын нэр л гэж бодсон шүү дээ» гэсэнд, «Хөөе мал аа, тэд чинь Папыг хөнөөчхөөд байна, нөгөө Папыг чинь!» гэлээ. «Папыг хөнөөсний төлөө хэдэн оноо авах бол?» гэж нэг нь хэлээд, бүгдээрээ маасайтал инээлдэнэ. Силвий

гайхан хачирхана. Эрдэмтдийн дунд ажилладаг католик бүсгүй заримдаа шашны эсрэг жиг жуг сонсдог боловч, бүх юманд ингэж ханддаг энэ овилгогүй хүүхдүүд - шашны жин нөлөө буурсны үр дүн биз ээ гэж бодож суув. Юу нь тийм хөгжилтэй байгаа юм бол? Яагаад тэд ингэж үзэн ядна вэ? Силвийгийн хувьд сүм гэдэг ямагт хэрүүл маргаанаас ангид тайван газар, найрсаг дулаан хүмүүсийн цуглаан, заримдаа зүгээр л хүмүүсийн нүдэнд олзлогдохгүйгээр чанга дуулах боломжтой сайхан газар байлаа. Сүмд -оршуулга, хурим, баптизм, баяр - гээд л хүний амьдралын гол гол үйл явдал өрнөдөг мөртлөө хэнээс ч, хэзээ ч хариу нэхэж байгаагүй билээ. Мөнгөн хандив өргөсөн ч болно, өргөхгүй байсан ч болно. Хүүхдүүд нь ч Наран гаригийн сургуульд сурч, тусламтгай.найрсаг байхыг заалгадаг ажээ. Энд, тэгээд, юу нь буруу байх вэ дээ? СЭРН дотор байгаа ийм олон «сэргэлэн толгой», яагаад сүм хийдийн үзүүлдэг ийм энгийн ач холбогдлыг ойлгодоггүй юм бол гэж бүсгүй заримдаа гайхдаг байлаа. quarks and mesons дундаж хүнийг сайн сайханд хөтөлж үнэхээр чадах уу? Тэгшитгэл гэгч хүний ариун нандин зүйлд итгэх итгэлийг сэргээж чадна гэж үү? Силвий жаахан уцаарлангуй хонгилоор алхаж явахдаа, зурагтгай бүх өрөө пиг дүүрэн хүнтэй байхыг харлаа. Ватиканаас өнөө өглөө Колэр рүү залгаад байсан нь - болоод байгаа жигтэй явдалтай холбоотой юм биш байгаа? Магадгүй л юм. Ватикан - СЭРН-ийн хийсэн судалгааг эсэргүүцсэн мэдэгдэл гаргах болгоныхоо өмнө «хүндэтгэн сануулж» утастдаг: хамгийн сүүлд нанотехнологийн салбарт хийсэн СЭРН-ийн нээлт генийн инженерчлэлийн салбарт нөлөөлж магадгүй гэж сүм хийдийн зүгээс буруушааж утастсан билээ. СЭРН тэрийг нь тоодоггүй байв. Ватиканыг дөнгөж эсэргүүцэж дуусмагц, Колэрын утас дахин дуугарч, технологид хөрөнгө оруулдаг компаниуд шинэ нээлтийнх нь лицензийг сонирхон ярьдаг байлаа. Колэр тэдэнд Ватиканы мэдэгдлийн тухай «хэвлэлийн муухан шуугиан шүү дээ» л гэж хэлдэг байв. Силвий Колэр рүү пэйжэрдэж, хаана ч, юу ч хийж байсан бай зурагтаа асааж, мэдээ үз гэдэг юм уу гэж бодлоо. Тэр тоох болов уу? Тэр ер нь болж байгаа үйл явдлын талаар сонссон болов уу? Мэдээж сонссон л байх. Тэгээд, тэр бүх мэдээг сандлынхаа гар доорх нууц камераар доогтойхон бичиж авч байгаа биз. Силвий хонгилоор явсаар тоглоом тохуу хийж, хөөрч баясаагүй бараг л меланхолик гэмээр хэдэн хүн сууж байхыг харлаа. Тэд бол СЭРН-ийн хамгийн хөгшин, хамгийн нэр хүндтэй хүмүүс, Силвий орж ирээд суухыг анзаарсан ч шинжгүй мэдээ үзэж байв. СЭРН-ийн өөр нэг хэсэгт, Леонардо Ветрагийн хүйтэн байранд Максимлиан Колэр орных нь хажуугийн шүүгээнээс авсан ширэн хавтастай тэмдэглэлийн дэвтрийг уншиж дуусгаад, зурагтаар мэдээ үзэж байв. Хэдэн минутын дараа Ветрагийн тэмдэглэлийг буцааж тавиад, зурагтаа унтраан, өрөөнөөс гарлаа. Алсын алсад, Ватикан хийдэд, кардинал Мортати бумба дүүрэн саналын хуудсыг Систин цогчны зууханд дахин хийлээ. Тэр цаасан хэц дүрсхийн шатахад, яндангаас хар утаа олгойдов. Хоёр удаа санал хураалаа. Пап тодорсонгүй.

Хэсэг 83

Гар чийдэн барьж яваа ч, Гэгээн Петерийн ордны түнэр харанхуйг бүрэн гэрэлтүүлж яагаад ч чадахгүй ажээ. Толгой дээр, тэртээ хол, том бөмбөгөр адар хүнхийх агаад Витториад одгүй шөнө далайд хөвөх шиг хов хоосон санагдана. Бүсгүй - Швейцар жардын харуулууд, камерлинг нарыг даган алхана. Тээр дээр тагтаа дуугарч, сар сүр хийх сонсогдоно. Бүсгүйн жихүүдсийг мэдсэн юм шиг, камерлинг гараа сунган, мөрөн дээр нь тавихад, хүчтэй чадал

дамжаад ирэх шиг боллоо. Камерлинго - одоо хийх гэж байгаа ажилд нь чухал хэрэгтэй урам зориг өгөх шиг болов. *Яах гээд байгаа юм болоо* гэж бүсгүй бодсон оо, *солиотой юм* гэж өөртөө үглэв. Гэхдээ л, хэчнээн айж бэмбэгнэж байсан ч, хийхээс өөр арга байхгүй гэдгийг ойлгож байв. Камерлингог шийдвэр гаргах хэрэгтэй, харин шийдвэр гаргахад - Ватиканы доод хонгилд байгаа авсанд булшлагдсан мэдээлэл хэрэгтэй байлаа. Юу болох бол гэж бүсгүй эмээнэ. *Иллюминати Папыг хөнөөсөн гэж үү? Тэд үнэхээр тийм чадалтай гэж үү? Би Папын биед задлан шинжилгээ хийх гэж байна гэж үү?* Витториа энэ том харанхуй байшинд явж байхдаа, шөнө далайд сэлэхээс илүү эвгүйцэж байгаагаа мэдрэн, гайхасхийж явав. Байгаль - сайхан. Бүсгүй байгалийг мэддэг байв. Гэвч, энэ бол хүний ертөнц - ойлгоно гэдэг хэтэрхий төвөгтэй. Махчин загас улай үзэн цуглах шиг, хэвлэлийнхэн олз горьдон, гадаа шавжээ. Зурагтаар гаргаж байсан тамгалуулсан хүний хүүр аавыг нь санагдуулж, алуурчны жихүүдэс хүрэм инээдийг амилуулна. Айдас төрөхөөс илүү уур хилэн дүрэлзэнэ. Тэд - Витториагийн мэдэх хамгийн том хар модноос ч илүү бүдүүн модон баганыг тойроход, өмнө нь нэг оч алтран байлаа. Тэр гэрэл ордны яг төв хэсэгт шалан доороос сүүмийх мэт санагдана. Ойртож явахдаа, Витториа юу харснаа ухаарлаа. Энэ бол Ватиканы хамгийн нандин зүйлсийг агуулдаг, хоймрын шүтээний эгц доор орших нууцлаг өрөө байв. Тэнд тосон дэнлүүгээр хүрээлсэн алтан гүнгэрваа байлаа. «Гэгээн Петерийн яс уу?» гэж Витториа мэдэхийн цаагуур мэдэж байгаа атлаа асуув. Энэ ордныг мэддэг хүн болгон л үүнийг мэддэг билээ. «Үгүй ээ. Хүмүүс дандаа тэгж андуурдаг юм» гэж камерлинго эрс үгүйсгээд: «Энэ дурсгал төдий эд биш. Энэ гүнгэрваанд шинэ сонгогдсон кардиналд Папаас өгдөг шаш тууз байдаг юм» хэмээн тайлбарлав. «Гэхдээ би бодохдоо...» «Бүгд л тэгж боддог юм. Танилцуулга номд үүнийг дандаа Гэгээн Петерийн авс хэмээн бичсэн байдаг, гэхдээ жинхэнэ булш нь эндээс хоёр давхар доош, газар доор байдаг юм. Дөчөөд оны үед түүнийг ухаж гаргасан, одоо тийшээ хэнийг ч оруулдаггүй юм» гэв. Витториа мэл гайхав. Тэр олон мянган бээрийг бадарчлан туулж, Ватиканд ирж, энэ алтан гүнгэрвааны дэргэд ирж мөргөөд, буцаж ирмэгцээ, би Гэгээн Петерийн авсанд мөргөсөн хэмээн сайрхан ярьж байсан хүнтэй уулзаж байсан билээ. «Ватикан яагаад энэ тухайгаа хүмүүст хэлдэггүй юм бэ?» «Бид ариун зүйлээс дандаа л увдис хүртэж байдаг. Тэр нь хоосон байсан ч ялгаагүй» гэлээ. Витториа, эрдэмтэн хүний хувьд, энэ логикийг зөвшөөрөхөөс өөр аргагүй байв. Тэр, плацебо нөлөөний тухай олонтаа уншиж байлаа. Шидэт эм хэмээн итгэсэн эгэл нэгэнд жирийн нэгэн аспирын өгөхөд хорт хавдар эдгэж байсан гэдэг. Ингэхэд сүсэг гэж юу билээ? «Өөрчлөх гэдэг л Ватиканд харин байдаггүй юм. Хуучин алдаагаа хүлээн зөвшөөрөх, модернизац гэх мэт зүйлээс бид түүхийн турш зайлсхийсээр ирсэн. Дээрхийн гэгээн харин үүнийг өөрчлөх гэж оролдсон юм» гэснээ хэсэг түгдчин: «Тэр орчин үеийн ертөнц рүү гарч, бурханд хүрэх шинэ зам хайж байсан юм» гэлээ. Витториа түнэр харанхуйд толгой дохин: «Эрдэм шиг үү?» гэв. «Үнэнийг хэлэхэд эрдэм үүнд хамаагүй». «Хамаагүй ээ ..?» Витториа эрдмийн тухай олон зүйл ярьж болох ч гэсэн, «хамаагүй» гэх үг л лав огт тохирохгүй санагдана. «Эрдмээр хүнийг анагааж болно. Эрдмээр хүнийг алж болно. Аль нь ч гэсэн эрдмийг хэрэглэж буй хүний сүнснээс хамаарна. Тэр сүнснийг нь, харин, би сонирхдог юм» гэв. «Та бурхны дуудлагыг* хэзээ сонссон бэ?» «Төрөхөөсөө өмнө». Витториа түүн рүү гайхан харав. «Уучлаарай, хачин хариулт байна гэж бодож магадгүй. Би бурханд зүтгэх ёстой гэдгээ дандаа л мэддэг байсан. Гэхдээ, залуу зандан цагтаа цэрэгт алба хаах үедээ л зорилгоо сая ухамсарласан юм» гэв. «Та цэрэгт байсан юм уу?» «Хоёр жил. Би буу барихгүй гэсэн болохоор, намайг эмнэлгийн нисдэг тэрэгний нисэгч болгосон юм. Би одоо ч хааяа хааяа нисдэг». Витториа камерлингог нисдэг тэрэг жолоодож байгаагаар төсөөлж үзэв. Тэгсэн харин ч гайхмаар санагдсангүй.

Камерлинго Вентреска жолооны ард сууж байгаа нь түүний тэнгэрлэг дүрийг бүр ч тодотгож байх шиг санагдав. «Та Паптай хамт нисч байсан уу?» «Үгүй ээ. Бид зөвхөн мэргэжлийн хүмүүст тэр тэнгэрлэг хүнд үйлчлэхийг л зөвшөөрдөг юм. Харин, Пап хааяа намайг нисдэг тэргээ унаад, Гондолфо нутагтаа харихыг зөвшөөрдөг байсан» гэлээ. Тэгснээ чимээгүй болж, харанхуй дунд Витториа руу эргэн хараад: «Ветра авхай, та ийшээ бидэнд туслахаар ирсэнд би чин зүрхнээсээ талархаж байна. Таны эцгийн төлөө эмгэнэл илэрхийлье, үнэн сэтгэлээсээ» гэлээ. «Гялайлаа». «Би аавыгаа хэзээ ч харж байгаагүй. Тэр маань намайг төрөхийн өмнө өөд болчихсон. Харин, ээж минь намайг аравтай байхад өнгөрсөн дөө». Витториа гайхан, адилхан хувь заяатай юм болов уу гэж бодсоноо: «Та өнчдийг асрахад өссөн юм уу?» гэлээ. «Би ослоос амь гарсан юм. Харин, тэр осол ээжийг минь авч одсон». «Хэн таныг өсгөсөн юм бэ?» «Бурхан» хэмээн камерлинго хэлээд: «Бурхан надад өөр аав хайрласан юм. Палермогийн хамба намайг эмнэлгийн орон дээр байхад ирээд авч явж билээ. Тэгэхэд, би огт гайхаагүй. Би бурхны энэрэнгүй хайрыг, бүр бага байхаасаа л, ингэж мэдэрсэн хүн. Хамба гуайн тэр сайхан царай, миний бодож байснаар, бурхан намайг сонгосон юм байна гэдгийг нотолж өгсөн юм даа». «Таныг бурхан сонгосон гэж та боддог юм уу?» «Тэгдэг шүү». Камерлингогийн хоолой итгэл төгс гэхээсээ, талархангуй өнгө сонсогдоно. «Би хамба гуайн доор олон жил ажилласан. Дараа нь, тэр маань кардинал болсон ч намайг мартаагүй юм. Тэр бол миний санаж явдаг аав минь юм шүү дээ» гэлээ. Гар чийдэнгийн гэрэл савчин, камерлингогийн нүүрэн дээр зэрвэс тусахад, нүдэнд нь гансрал үзэгдэнэ. Тэр хэд явсаар, нэг гулдан хаалганы дэргэд ирж онгойлгоход, гар чийдэн савчин гэрэл нь ийш тийш тусч байв. Хаалганы цаана, доошоо буусан том өргөн шат байх агаад, яагаад ч юм бэ, Витториад буцмаар санагдав. Харуулууд камерлингог хаалгаар гаргаад, дараа нь бүсгүйд туслав. «Тэр тэгээд яасан бэ?» гэж Витториа цааш нь ухаж асуугаад: «Таныг тэр энд авчирсан уу?» гэв. «Тийм. Тэгээд, тэр өөр албанд тохоогдон, кардиналын цуглааныг орхисон юм». Витториа гайхаж орхив. «Тэгээд, яасан гэж? Ингэж асууж байгаад уучлаарай. Нас барчихсан уу?» «*Le mie condoglianze*. Саяхан уу?» гэж Витториа асуув. Камерлинго эргэж харахад, цаана нь тусах гар чийдэнгийн гэрэлд нүүр нь сүүдэртэн байлаа. «Яг арван таван хоногийн өмнө. Бид одоо түүн дээр очиж явна» гэлээ. * Бурхны дуудлага гэдэг нь христийн шашинт хүний хувьд бурхныг шүтэх тухай сайн зарыг сонсож мэдээд, бурханд итгэх христийн зөв шүтлэгт орох тухай ойлголт юм.

Хэсэг 84

Архивын хорго дотор гэрэл муутай чийдэн хөхийнө. Энэ хорго өмнө нь байснаас илүү жижиг ажээ. Бага байх тусам бага цаг, бага агаар хэмээн Ландон бувтнаад, Оливеттиг агааржуулагч ажиллуулж өгөөч гэж гуймаар санагдана. Ландон Belle Arti (Уран бүтээл) гэсэн товъёогтой шүүгээг зоволгүй олов. Андуурах ч арга байсангүй. Тэр хэсэг бүхэл бүтэн найман тавиур дүүрэн байлаа. Католик сүм хийд дэлхий даяар сая сая урлагийн бүтээлийг эзэмшдэг билээ. Ландон тавиурууд дээрх каталогийг гүйлгэн, Жанлоренцо Бернинигийн бүтээлийн жагсаалтыг хайна. Шүүгээний дунд хавиас Б үсгийн каталог эхлэх байх гэж таамаглан, дээж доош хэд гүйлгэж харснаа «Б» үсгийн каталог байхгүй юм байх даа хэмээн гайхлаа. Тэгснээ, энэ каталог үсэг дарааллаар хийгдээгүй юм байна гэдгийг гэнэт ухаарав. Тэр каталогийн учрыг нь олох гэж зөөдөг шатыг нааш цааш татан, дээр доор нь гарна. Нэлээн гайхширсны эцэст шүүгээний хамгийн дээд эгнээнд, хамгийн зузаан хавтас олсон нь сэргэн мандлын үеийн буюу Микланжело, Рафаэло, да Винчи, Ботичелли нарын бүтээлийн жагсаалт байв. Одоо л Ландон «Ватиканы хөрөнгө» хоргоны учрыг оллоо. Тэр жагсаалтыг уран бүтээлчийн

мөнгөн дүнгээрээ хамгийн үнэтэй бүтээлээс нь эхэлж дараалуулсныг ухаарлаа. Микланжело, Рафаэл хоёрын завсар Бернини гэсэн товёог олсон нь таван хуруу зузаан байлаа. Амьсгал нь давхацсаар, түнтийсэн зузаан хавгастай юм барьсан Ландон шатаар арай хийж буув. Тэгээд л, зурагтай ном үзэж байгаа хүүхэд шиг хавгсаа шалан дээр тавьж байгаад, хуудсыг нь эргүүлж гарлаа. Даавуун хавгастай тэр хүнд номын хуудаснуудыг Итали хэлээр, гараар бичсэн байв. Хуудас бүр нэг л бүтээлийг бүртгэж, тэр бүтээлийн тухай товч тайлбар, бүтээсэн огноо, байрлал, материалын үнэ, заримдаа ерөнхий дүрсийг нь хавсаргасан байлаа. Ландон найман зуун хуудастай бүртгэлийн хуудас бүрийг нь эргүүлж гарав. Бернини зүгээр сууж тун чаддаггүй хүн байсан бололтой. Оюутан ахуй цагтаа, тэр — нэг хүн богинохон амьдралынхаа турш яаж ийм олон бүтээл туурвиж чадсаныг гайхдаг байлаа. Дараа нь, тэр -аугаа уран бүтээлч нар өөрийнхөө гараар тун цөөхөн зүйл урласныг нь мэдээд, уур нь хүрдэг байжээ. Тэд том том урлантай, тэндээ өөрөө эх загвараа гаргачхаад, залуу уран бүтээлчдийг хөлсөлж томруулдаг байсан байна. Бернини мэтийн барималчид эх загвараа шавраар урлаад, олон хүн хөлсөлж гантиг болгон, томруулдаг байжээ. Хэрэв энэ олон бүтээлээ Бернини ганцаараа хийсэн сэн бол өнөөдрийг хүртэл дуусалгүй, нухаж суух сан билээ. «Индекс» гэж Ландон, тархиныхаа холбоосуудыг чангалах санаатай, чанга гэгч хэлээд, номоо арагш нь эргүүлж, F үсгээр эхэлсэн, fuoco буюу гал гэсэн үгийг хайж эхлэв. даан ч тэр F-үүд нэг дор байсангүй, энд тэнд өөр үгтэй хоршин оржээ. *Энэ хүмүүс цагаан толгойн үсгийн дарааллыг яагаад аваад хэрэглэжээ чаддаггүй байна аа, золиг гэж.* Бүтээлийг он дарааллаар жагсааж, Бернини шинэ бүтээл хийх тоолон, тэр өдөр нь бүртгэж орхидог байжээ. Бүртгэлийг огноогоор нь хийжээ. Ямар ч тус алга. Ландон жагсаалтыг харж байснаа, дахиад нэг бэрхшээл байгааг ухаарав. Хайж байгаа бүтээлийнх нь нэрэнд гал гэсэн үг заавал орсон байх албагүй билээ. *Хабаккук, Ангель хоёр, Өрнийн салхи* гэх хоёр нэрэнд *Шороо, Хий* гэдэгтэй холбоотой үг санаа огт байхгүй. Ландон аргаа бараад, нэг хоёр минут хуудсыг нь эргүүлж, тойруулан харж, санаа өгчих зураг тааралдах болов уу хэмээн шүүрдэв. Мэдэхгүй ч бүтээл тааралдах, мэдэх ч бүтээл тааралдах. *Даниэль, Арслан хоёр: Аполло, Дафни* хоёр гэх мэт үргэлжилсээр. Нэлээн хэдэн усан оргилуур үзэгдэнэ. Усан оргилуур хармагц, бодол нь түр сарнив. Ус. Эрдмийн дөрөв дэх шүтээн усан оргилуур байж болох юм. Тэгвэл, усанд зориулсан хамгийн оновчтой өргөл болно доо. Гэхдээ, алуурчныг усанд зориулсан бүтээл хайхаас өмнө барьчих биз дээ. Бернини, гэхдээ, хэд хэдэн оргилуур барьсан, бараг бүгдээрээ сүмийн өмнө байдаг билээ. Ландон эргээд, асуудал руугаа орлоо. Гал. Номоо ширтсээр сууна. Витториагийн үг түүнд урам өгч байв. *Чи эхний хоёр баримлыг нь мэддэг байсан ... тэгэхээр, чи лав энийг нь ч гэсэн мэддэг байх.* Индекс рүү эргэж, мэддэг бүтээлийнхээ нэрсийг хайвал, нэг нь ч олигтой санаа төрүүлсэнгүй. Ландон, ухаан алдахаасаа өмнө энэ каталогийг дуусгаж чадахгүй юм байна гэдгээ гэнэт ухаарч, хоргоноос гарч каталогоо үзвэл дээр юм байна гэж бодлоо. *Энэ чинь зүгээр л бүртгэлийн дэвтэр шүү дээ* гэж өөртөө хэлэв. *Энэ чинь Галилеогийн эх номын хуудсыг авч гарахтай адил биш шүү дээ.* Цээжнийхээ хармаанд хийсэн нөгөө хуудсаа санан, эндээс гарахаасаа өмнө, тэр хуудсыг буцааж тавих ёстойгоо өөртөө сануулав. Номоо өргөөд, хаах гэснээ гэнэт зогтусав. Индекс дотор зөндөө тайлбар байсан боловч тэр нэг тайлбар арай л өөр байлаа. Тэр бол *Гэгээн Терезагийн баясал* хэмээх Бернинигийн баримал агаад Ватикан доторх анхны байрнаас нь удалгүй зөөжээ. Гэхдээ, энэ баримал өөрөө анхаарал татсангүй. Энэ баримлын түүхийг нэлээд сайн мэднэ. Дийлэнх хүн үүнийг гайхалтай бүтээл гэж үнэлдэг ч, Урбан VIII Пап энэ баримлыг хэтэрхий завхай хийцтэй, Ватиканд байж болохгүй хэмээн үзээд, Ромын бөглүү мухрын нэг жижиг сүм рүү илгээжээ. Тэр сүм - Ватиканаас дорнош орших таван сүмийн нэг байлаа. Түүнээс гадна,

тэнд *per suggerimento del artista* гэсэн тайлбар байв. *Бүтээлчийнх нь саналаар?* Ландон хэсэг бодолхийлэв. Бернини бүтээлээ бөглүү мухрын нэг жижиг сүм рүү явуулахыг санал болгосон гэдэг нэг л жоготой байв. Хэн ч байсан өөрийнхөө бүтээлийг, мэдээж, том сүмүүдийн өмнө байлгахыг эрх биш хүсэх билээ. Гэхдээ хэрэв... Тэр санаагаа улам лавшруулах ухав. Энэ боломжтой юу? Бернини энэ баримлыг Ватиканаас гаргахын тулд уулаасаа хэтэрхий завхай гэмээр хийцтэй хийсэн юм болов уу? Бернинигээс хаана байрлуулахыг асууна гэж тэр мэдээ болов уу? Тэгээд, тэр бөглүү мухрын сүм нь Өрнийн салхины амьсгал зүгт байхаар сонгосон гэж үү? Ландон энэ барималтай төдийлөн танил биш болохоор, сонирхол нь улам дүрэлзэх авч энэ баримал гал-тай ямар ч холбоогүй ажээ. Баримлыг харсан хэн ч байсан, энэ бол эрдмийнх бус, порнограф төрлийн байж магадгүй, ямартай ч эрдмийн шинжгүй гэхсэн билээ. Нэг английн шүүмжлэгч *«Гэгээн Терезагийн баясал Христийн сүмд баймааргүй ганц баримал юм»* хэмээн тодорхойлсон байлаа. Үүнийг ойлгож болно. Гэгээн Тереза - нуруугаараа налж хэвтээд, хөлийн хуруунуудаа жимбийлгэн, дүрсэлсэн нь яавч Ватиканд байх эд биш ажээ. Ландон хурдан гэгч тэр бүтээлийн тайлбарыг татаж үзлээ. Тойм зургийг нь харвал, найдварын оч гэнэт гялсхийв. Тэр тойм зурагт Гэгээн Тереза үнэхээр л өөрөөсөө таашаал авсан байртай байх боловч ... хажууд нь өөр нэг дүрс байх агаад тийм дүрс байдгийг Ландон ор тас мартсан байв. Ангель! Ангелийн араас домгийг нь саналаа. Гэгээн Тереза зүүдэнд нь ангель ирж, түүнтэй уулзсан гэж нотолсныхоо дараа гэгээн хэмээн цоллогдсон гэлэнмаа байлаа. Шүүмжлэгчид тэр уулзалтыг шашинлаг биш, янаг байсан болов уу гэдэг. Хуудасны доор, Тереза өөрийгөө өмгөөлөн өгүүлсэн гайхамшигт мөртүүдийг ишлэсэн байлаа. *Гантайсан алтан жад ... гал бадарсан, сүрдэм жад ... биеийг минь бүлэн бүлэн ... хэвлийг минь нэвт нэвт бүлэн ... болиулмааргүй, тачаадам сайхан таашаал өгч байлаа...* Ландон инээмсэглэнэ. *Энэ дур тавьсан хурьцлын тухай биш бол, өөр юуны тухай байх билээ.* Түүнээс гадна, тэр тайлбарыг уншин инээмсэглэж байв. Тайлбарыг итали хэлээр бичсэн ч гэсэн *fuoco* буюу гал гэдэг үг хэд хэдэн удаа давтагджээ. ... ангелийн жадны үзүүрт *гал* бадарч байв. ... ангелийн тэргүүнд *галын* дөл цацарч байв. ... бүсгүй тачаалын *галд* шатаж байв. Ландон тойм зургийг дахин харснаа, улам итгэлтэй болов. Ангель жадаа зүг чиг заах мэт өргөжээ. *Ангель бүр ариун эрлийг чинь заана.* Тэр бүү хэл, Бернинигийн сонгож авсан ангелийн төрөл ч няхуур байлаа. *Энэ бол серафим байлаа. Сераф гэдэг «галт нэгэн» гэсэн үг билээ.* Ландон юмыг нягтлан нягтлан шалгадаг ч, нэрэнд төдийлөн ач холбогдол өгдөггүй нэгэн: гэхдээ, баримал байгаа сүмийн нэрийг уншаад, бүр ач холбогдол өгч байв. *Санта Мариагийн дэлла Витториа сүм. Ялалт.* Ландон бодов. *Төгс.* Ландон өндийхөд, толгой нь хэсэг эргэв. Энэ номыг эргүүлж байранд нь тавих уу, яах вэ гэж, шат харан, хэсэг бодолхийллээ. *Золиг гэж, Жакуй эцэг өөрөө тавина биз гэж тэр бодоод, номыг доод тавиурт нь нямбай гэгч тавиад орхилоо.* Эргэдэг цахилгаан хаалга руу, товчийг нь дарахаар очихдоо, Ландон амьсгаадаж байсан ч их л урам зоригтой байв. Даан ч, тэр аз нь хаалга руу очихоос өмнө хийсчхэв. Ямар ч анхааруулга өгөлгүй, хоргын гэрэл унтарчхав. Хаалганы тог ч бас тасраад, ажиллахгүй байв. Удалгүй пад пад гээд, архивын гэрэл тэр чигтээ унтраад, тас харанхуй болчихлоо. Нэг хүн гэрэл унтраачихжээ.

Хэсэг 85

Ватиканы ариун гүдин* гээч нь Гэгээн Петерийн сүмийн гол талбайн эгц доор орших агаад тэнд талийгаач болсон Пап нарыг нутаглуулдаг ажээ. Витториа спираль шатаар доошилсоор бунхан руу орлоо. Тэнд, СЭРН-ийн Хадрон бутлууртай адил хүйтэн харанхуй, Швейцар жардын барьсан гар чийдэн л зам гэрэлтүүлж байлаа. Хоёр талын хананд, тасалгаа

гаргаж ухсан гонхон байх агаад чийдэнгийн гэрэлд, урд байгаа чулуун авс л дэгэн догон гэрэлтэнэ. Бүсгүйн жихүүдэс хүрнэ. *Хүйтэн байна шүү* гэж амандаа бувтнах ч, энэ тэндээс хараад байгаа юм шиг санагдах нь бүр ч жихүүдэс хүрмээр ажээ. Авс болгоны дээр Пап болгоны царай, биеийг бодит хэмжээ нь ямбаныхаа хувцсыг бүрэн жагсааж, гараа зөрүүлэн хэвтсэн шуумлыг нас барсан дүрээр дүрсэлжээ. Түүнийг хармагц, тэд авсныхаа хүнд боржин тагийг өргөн зайлуулаад, дотроос гарах гэж зүтгэх мэт аймшигтай санагдана. Тэдгээр авсны дунд гар чийдэнгийн гэрэл савлан, урагш зүтгэж, босоо хэвтээ янз бүрийн Папын дүрс зурсхийн орж ирээд л харанхуйдаа эргээд уусч, сүг мэт мэт сүүмэлзэнэ. Талийгаачдыг хүндлээ юу, сүнсээс нь айгаа юу, тэд хоорондоо ган хийлгүй, чимээгүй алхална. Камерлинго алхам бүрээ мэддэг юм шиг, нүдээ аниатай явах ажээ. Витториа түүнийг, талийгаач Папыг өнгөрснийх нь дараа бунхан руу нь олонтаа ирсэн бололтой гэж сэжиглэн бодсоноо: магадгүй энд ирж, арилаачид мөргөн, юу хийж, яах ёстойг зурж, зааж өгөөч гэж залбирдаг байсан биз гэж цагаатган бодлоо. *Би кардиналын ивээл дор олон жил ажилласан* хэмээн камерлинго ярьж байсан билээ. *Надад яг л аав минь юм шиг ханддаг байж билээ.* Витториа өөрийг нь армиас аварсан тэр кардиналын тухай ярьж байсан камерлингогийн үг, аяс болгоныг тодхон санана. Хожим болсон явдлууд ч түүнд ойлгомжтой байлаа. Камерлингод тийм халуун дулаан хандаж байсан тэр хамба, Пап болон өргөмжлөгдөөд, хажуудаа залууг татан, гарын даа болгосон ажээ. *Энэ ч олны юмны учрыг тайлж байна шүү* гэж Витториа бодно. Витториа хүний дотоод сэтгэлийн учгийг үргэлж л мэдэрдэг бөгөөд камерлингогийн сэтгэлийн учиг ч анхаарлыг нь өдөржин татсан билээ. Уулзсанаасаа хойш, камерлинго болж байгаа үйл явдлаас тэс өөр, нэг л бишрэл төрүүлсэн атлаа цаанаа санаа зовнисон шинжтэй байгаад байлаа. Амарлингуй царайных нь цаана, дотроо цамнах чөтгөртэй асхин буй эр харагдана. Бүсгүйн зөн зөв байжээ. Ватиканы түүхэнд байгаагүй заналтай тулж, ачааны хүндийг үүрч буй энэ хүн тулж түшдэг хамгийн дотнын багшаа алдчихаад, ганцаардан аргагүйдэж байгаа нь энэ ажээ. Жардууд хаашаа явахаа мэдэхгүй, энэ хавьд л байх ёстой хэмээн тээнэгэлзэх шиг зогсосхийв. Харин камерлинго итгэл төгс урагшилсаар, бусдаасаа илүү тод гэрэлтэх мэт харагдах нэгэн чулуун авсны дэргэд хүрч зогслоо. Дээр нь сүүлчийн Папыг дүрсэлсэн шуумал байна. Телевизээр талийгаач Папыг олонтаа харсан болохоор, Витториа шуумлыг хармагцаа танив. Одоо яах бол? Бор зүрх нь бомболзон чичирнэ. «Бидэнд цаг бага ч гэсэн, та бүхэн бурхныг бодож, залбирал үйлдэнэ үү» гэж камерлинго хэлэв. Швейцар жардууд зогссон газраа мэхийн ёслов. Витториа ч тэднийг дуурайн мэхийхэд, зүрх нь лүг лүг хийн цохилно. Камерлинго авсны өмнө сөгдөн, Итали хэлээр уншлага уншлаа. Витториа тэр уншлагыг сонсон ахуйд эцэг нь..., ариун багш нь санагдаж, өөрийн эрхгүй нулимс дуслуулав. Камерлингогийн уншлага Папад төдийгүй эцэгт нь зориулагдсан мэт санагдана. «Оройн дээд эцэг, зөвлөгч, нөхөр минү» хэмээн камерлинго сүрлэг тод хэлэхэд, эргэн тойрон хүнгэнэн цуурайтлаа. Витториагийн сэтгэлд үг нэг бүр нь царгин цоргилно. «Дотроос чинь сонстох дуу хоолой болгон бурхных шүү гэж, хүүхэд ахуйд минь та сургадаг байж билээ. Ямар ч аймшиг руу хөтөлж байсан тэр л дуу хоолойг сонсож, дагаж бай гэж сургадаг байж билээ. Миний бие өнөөдөр тэр л дуу хоолойг даган, цээрт үйлийг аймшиггүй үйлдэхээр энд ирлээ. Хүч чадал хайрла. Өршөөл энэрлээ соёрх. Таныхаа сүсэглэж явсан тэр бүхний төлөө, үүнийг би зүрхлэн үйлдсү. Амен». «Амен» гэж, Жардууд даган өгүүлэв. «Амен, эцэг минь» хэмээн, Витториа хоолой зангируулан хэлээд, нулимсаа арчлаа. Камерлинго алгуур босч, авснаас алхам холдоод: «Тагийг нь ав!» гэлээ. Жардууд тээнэгэлзэн зогсож, нэг нь зүрхлэн: «Эрхэм ээ! Хууль ёсоор, бид таны мэдэлд. Хий гэснийг чинь л хийнэ л дээ...» Камерлинго тэр жардын бодлыг унших мэт яриаг нь таслан өгүүллүүн:

«Би ийм юм хийлгэснийхээ төлөө, нэг л өдөр танаас өршөөл хүснэ. Харин одоо би танаас дуулгавартай яа гүйцэтгэхийг хүсье. Ватиканы бүх хууль католик шашныг хамгаалах цор ганц зорилготой байдаг. Чухам тэр ариун зорилгын төлөө өнөөдөр тэр хуулиудыг зөрч гэж би тушааж байна». Жардын гавуу** тээнэгэлзэхээ больж тушаал өгөв. Гурван залуу гар чийдэнгээ газар тавьж, ханцуй шамлан авс руу очиход, сүүдэр нь толгой дээгүүр сүүтгэнэнэ. Цэргүүд гараа зэрэгцүүлэн, тагийн толгой хавьд тавиад, хөлөө арагш жийж, түлхээр зэхэв. Нэгэн командаар, том боржин тагийг бүх хүчээрээ нэгэн зэрэг амьсгаа аван, хүчлэн түлхлээ. Таг хөдөлсөнгүй. Дэндүү хүнд ажээ. Витториа дотор нь юу байх бол гэхээс жихүүдэс хүрнэ. Гурван эр дахин түлхэвч таг бас л хөдөлсөнгүй. «Ancora!» хэмээн камерлинго хэлээд ханцуйгаа шамлан тэдэнтэй зэрэгцэн хамт түлхэхээр зогсов. «Ora!» Бүгд зэрэг түлхлээ. Витториа тэдэнд туслаар сэтгэн, ухасхийсэн боловч том хар таг хяхтнан, аажуухан онгойж эхэллээ. Эрчүүд дахин уухайлан түлхвэл, чулуу чулуутай үрэлдэн хяхарч, авсны таг хайрцаг дээрээ тэгнэн эргэв. Авсны тагийн толгой цаашаагаа, хөл нь наашаагаа хөндөлдөн завсар гарлаа. Бүгд аниргүй болж, амьсгаадан ухрав. Тэгснээ, нэг жард бөхийж, гар чийдэнгээ аваад, авсны дотор тал руу гүйлгэн тусгалаа. Гэрлээ нэлээн тогтоож байснаа, дахин тойруулан харна. Бусад жард нэг нэгээрээ хойноос нь очиж, авс руу өнгийнө. Тэдний мэгдэж байгаа нь харанхуйд ч гэсэн мэдэгдэхээр байлаа. Тэвдэж сандарсан тэд биеэ загалмайлан залбирна. Камерлинго ч авс руу тонгойн харснаа, гилмэн балмагдав бололтой, мөр нь унжаад явчихлаа. Тэгж хэсэг зогссоноо, эргэж харлаа. Rigor mortis гэх шинж илэрч, Паптан шүдээ зуурчихсан байвал эрүүг нь зааж, амыг нь ангайлгаж байж л, хэлийг нь харах хэрэгтэй болно доо гэж Витториа эмээж байлаа. Гэтэл, тэгэх хэрэг байсангүй. Эрүү нь сулраад, ам нь том гэгч ангайсан байв. Харин хэл нь тас хар өнгөтэй байлаа.

Хэсэг 86

Гэрэл ч үгүй, анир ч үгүй. Нууц архив тас харанхуй. Айдас Ландоныг хөтлөн, хүч өгч байх ажээ. Амьсгаа нь давхацсан тэр хаалга руу гүйн очиж, товчийг нь алгаараа цохилгов. Нэмэргүй. Дахин цохилгов. Хаалга ажиллахаасаа өнгөрчээ. Харанхуйд тэмтчин хашхирсан боловч, хоолой нь хүржигнээд, дуу ч гарсангүй. Бүх юм түүнийг тойроод, бөглүү оргиод авчихлаа. Уушги нь хүчилтөрөгч нэхэн татваганаж, татваганах тусам зүрх нь хоёр дахин их цохилно. Яг л элгэндээ эвхэртэл цохиулсан мэт санагдана. Бүх биеэрээ хаалга руу мөргөж үзсэн чинь хаалга эргэлдэж байгаа юм шиг санагдав. Мөргөх бүр нүдэнд нь оч үсчинэ. Нүдээ нээсний дараа л ганц хаалга эргээд байгаа биш, харин бүхэл бүтэн өрөө түүнийг тойрон эргэлдэж байгааг ухаарлаа. Толгой нь эргэсэн Ландон гүйдэг шат тулах гэтэл шалан дээр падхийн унав. Өвдөг дээрээ сөхрөн, номын тавиур руу тэмтэчлээ. Хөлрөн байж арай гэж шатаа барьж авлаа. Шат уул нь хүнд мод юм уу, төмөр байх болов уу гэж бодсон чинь хөнгөн цагаанаар хийсэн эд ажээ. Ландон голсонгүй, шатаа хана мөргөдөг туухай шиг бариад, түнэр харанхуй дунд хоргоны шилэн ханыг баримжаалан, хар эрчээрээ гүйв. Хана бодсоноос ойрхон байж таарч, шат ханыг байдаг эрчээрээ мөргөсөн боловч шилэн дээр зөөлхөн түнхийгээд, ойж орхив. Энэ шилийг зүгээр нэг хөнгөн цагаан шатаар цохиод хагалж чадахгүй ажээ. Талбай дээр буутай явж байснаа гэнэт санасан боловч Оливетти захирагч Папын өрөөнд орохын өмнөхөн, камерлингогийн аюулгүй байдлыг хангах үүднээс хураагаад авчихсаныг саналаа. Буутайгаа байсан бол ч... Ландон дахин хашхирсан боловч хоолойн чадал барагджээ. Харуул - гар холбоогоо хоргын гадна байгаа ширээн дээр тавьсныг санах. *Би аваад орчихгүй*

яав даа! Цээжин дээр нь хүнд юм дарчихсан юм шиг санагдаж, нүдэнд нь хөхөлбөр оч гэрэлтэнэ. Өмнө нь ийм тэг дөрвөлжин юман дотор түгжигдээд үхэх гэж л байсан шүү дээ. Түүнтэй харьцуулахад одоо байгаа маань ч гайгүй л байна. Тэр үед чи жаахан хүүхэд байсан мөртөө л, яах ёстойгоо бодоод олчихсон шүү дээ, тэгэхээр одоо бол чадаж л таарна. Ойр тойр, улам бүр түнэр харанхуй болно. Ландон шалан дээр хэвтээд, нуруугаараа өнхөрч, дээш харан хэвтэв. Гараа хоёр талаараа сул унжууллаа. Тэгээд, биеэ хянах гэж оролдоно. Тайван, тайван. Босоо зогсоогүй болохоор зүрхэнд ирэх ачаалал багасч, галзуурсан юм шиг лугшиж байсан цохилт нь овоо зөөлрөв. Усанд сэлэлтийн тамирчид тэмцээний хооронд ингэж амардаг ажээ. Энд агаар хангалттай, сайхан байна. За одоо харин яавал дээр вэ, хөө. Тог ирчих болов уу гэж горьдосхийн бодолхийлж хэвтэнэ. Даан ч тог ирсэнгүй. Гэхдээ амьсгаа нь арай уужирч, толгой нь эргэхээ болив. Гарна шүү, эндээс, хө гэж өөртөө хэлсэн боловч, яаж гэдгээ мэдэхгүй л байлаа. Бугуйд нь Микки Маустай цаг харанхуйд хөхөлзөн инээвхийлэх шиг 9.33 зааж байв. Гал болоход хагас цаг дугуу байдаг. Нэгэнт өнгөрөх шив дээ гэж санагдана. Тэгснээ цухалдаж, хэн энэ тогийг тасалж орхидог байна аа. Рошер занги эрлийнхээ хүрээг тэлж байгаа нь энэ юм болов уу? Оливетти намайг энд байгаа гэж Рошерт хэлээгүй юм байх даа? Тэглээ гээд, одоохондоо ямар нэмэр байх вэ дээ. Толгойгоо дагзаар нь шал руу тулж, амаа том гэгч ангайлгаад, чадах чинээгээрээ уужим амьсгаа авах гэж хичээнэ. Амьсгалах бүр хүчилтөрөгчийнх нь хэмжээ буурна. Гэхдээ л, толгой эргэхээ болив. Тэгээд, бүх бодлоо хураагаад төвлөрүүлээ. Шилэн мөртөө, даан ч зузаан эд юм даа, чөтгөр гэж.

Энэ дотор хүнд, төмөр, галд тэсвэртэй хавгас байдаггүй юм байх даа. Уул нь бусад архивд байдаг л юм сан. Гэхдээ, энд тийм юм харагдаагүй санагдана. Байсан ч гэсэн тэрийг тас харанхуйд хайж олно гэдэг цаг үрсэн ажил. Оллоо гээд өргөж даахгүй хүнд, ялангуяа, ингэж сульдсан үедээ. *Уншлагын ширээ!!!* Номын тавиуруудын голд уншлагын жижиг ширээ байсныг Ландон саналаа. Ер нь бүх л архив тийм байдаг. *Тэгээд юу гэж?* Тэртээ тэргүй өргөж дийлэхгүй байж. Хөдлөглөө ч гэсэн тийм хол авчирч чадахгүй, номын тавиурууд хооронд тэр ширээг багтаагаад, аваад гарчих зай ч байхгүй. *Тавиурууд хоорондын зай хэтэрхий нарийхан...* Гэнэт, сайхан санаа зурсхийв. Тэр год үсрэн бослоо. Хэт хурдан өндийснөөс болоод, толгой нь янхийтэл өвдөөд, харанхуйд тэмтчин байж, хажуугийнхаа номын тавиур түшив. Тэгээд хэсэг зогсож, амсхийлээ. Санаагаа хэрэгжүүлэхийн тулд бүх хүчээ шавхах хэрэгтэй болохоор, амсхийх хэрэгтэй. Америк хөл бөмбөгийн тамирчин сургуулилалтын тэрэг түрж байгаа юм шиг номын тавиурыг мөрөөрөө тулаад, хөлөө шал руу жийгээд, байдаг хүчээрээ түлхлээ. *Тавиурыг унагааж чадвал ч...* Номын тавиур хөдөлсөнгүй. Ландон байрлалаа засаад, дахин түлхэв. Хөл нь шалан дээр гулсана. Тавиур хяхарсан ч хөдөлсөнгүй. Хөшүүрэг хэрэгтэй болох нь. Ландон нэг гараараа хоргын шилэн ханыг тулж баримжаалаад, хоргын ар талын хана руу байдаг хурдаараа гүйв. Арын хана бас л бодож байснаас ойрхон байж таарч, бас л мөргөж орхив. Хараал тавиад, Ландон сүүлийн эгнээний номын тавиураас зуурлаа. Нэг хөлөөрөө арын хана руу тийрч, нөгөө хөлөөрөө номын тавиурын доод тавцан дээр тавимагцаа дээшээ авирч эхэллээ. Тавцанг гишгүүр хийн, дээр нь байсан ном дээр гишгэчин, дээшээ авирна. Амь гарах зөн нь архив, бичиг хэргийн ямар ч журам дүрмээс илүү хүчтэй түүнийг адгуулж байв. Харанхуй болохоор тэнцвэрээ олох хэцүү, дээрээс нь олон олон оч гэрэлтээд байхаар нь нүдээ аньчихсан, авирч явлаа. Ландон шалмаг хөдөлж байлаа. Дээшлэх тусам агаар сийрэгжиж, амьсгалах улам хэцүү болно. Эцэстээ уулын оргилд гарсан уулчин шиг, хамгийн дээр талын тавцан дээр гарлаа. Тэгээд, нөгөө хөлөө шил рүү жийж, бараг л хана, номын тавиур хоёрын хооронд тэгнэж зогслоо. *Одоо биш бол хэзээ ч биш шүү, Роберт* гэж өөртөө үглээд, *яг л сургуульдаа хөл жийх, дасгал хийдэг шиг ээ* гэж шавдууллаа. Толгой нь эргэж байсан ч гэсэн цээжээрээ номын тавиурыг тулж, гараараа зуураад, хоёр хөлөө хана руу тулж жийлээ. Болсонгүй. Номын тавиур хөдөлсөнгүй. Байрлалаа засаад, дахин түлхэв. Номын тавиур энэ удаа бага зэрэг хөдөллөө. Тэгмэгц, дахин хүчлэн түлхсэнд, тавиурын дээд тал хөдөллөө. Ганц хуруу орчим цаашаагаа хазайснаа, ганхаж, наашаагаа буцан хазайна. Ландон номын тавиурыг цаашаа хазайхад нь түлхэн, наашаа хазайхад нь тулан ганхуулж эхэллээ. *Ингэж ганхуулаад л байя. Гэхдээ, цаашаа хазайхад нь нэмж түлхье.* Номын тавиур одоо бүр хүчтэй ганхаж эхэллээ. Цаашаагаа хазайх болгонд нь Ландон хөлөө улам хүчтэй жийнэ. Дөрвөн мөч нь янгинан өвдөвч тэр хайхарсангүй. *Дахиад гурвантаа түлхээд л ...* Гурав хүрсэнгүй, хоёрхон л түлхүүллээ. Гэнэт жингүй ч юм шиг, нисээд байгаа ч юм шиг болов. Баахан ном тавиураас сарр хийтэл асгарч, Ландоны зүүгдсэн номын тавиур цаашаагаа уналаа. Номын тавиур газар хүрэлгүй, цаанаа байсан өөр нэг тавиурыг хүчтэй гэгч дэрлэн цохиж, ганхууллаа. Ландон ухасхийн, цаад тавиурын орой руу үсрэн цааш нь түлхэж, дэм үзүүлнэ. Тэр тавиур удалгүй чахран дуугарч, бас л унав. Номын аварга том тавиурууд бие биеэ яг л эгнээ даалуу шиг дэрлэн унана. Төмөр төмрөө түнхийтэл цохилон, ном сарр хийн асгарч, аймшигтай нүргэлэнэ. Нэг тавиур унахад, Ландоны зүүгдэж байсан тавиур сэг хийн нэгэнтээ доошлох агаад энд ер нь номын хэдэн тавиур байсан юм бол, хэр их жинтэй юм бол гэж хүртэл бодоод амжив. Цаана байгаа шилэн хана ч зузаан даа... Ландоны зүүгдсэн тавиур доошилсоор бараг л газар хүрэхийн даваан дээр, тэр хүлээж байсан чимээ нь сонсогдов. Тэртээ цаад талд, хаалганы тэнд, төмрөөр шил

цохих чимээ гарлаа. Хамгийн сүүлийн номын тавиур хүнд том шилэн ханыг хүчтэй еэ мөргөхөд, хоргын хана тэр чигтээ доргин жингэнэв. Гэхдээ, удалгүй хамгийн муухай юм болж, горь тасраад явчихлаа. Чив чимээгүй. Шил хагарч бутарсан чимээ сонсогдсонгүй, зүгээр л номын хүнд тавиураар хүчтэй цохиулсан шил цохилтын жинг шингээн, түнннннн хийн удаан доргих л сонсогдлоо. Гэтэл, удалгүй тэртээд, жингэнэн хяхтнах чимээ гарах шиг болов. Ландон номон овоолгыг ширтэн, тэр чимээг амьсгаа даран чагнах гэсэн ч амьсгалаа түгжихээр ч агаар тэнд үлдээгүй байлаа. Нэг хором, хоёр хором ... Ухаан балартан унахын даваан дээр, Ландон шил зад үсрэн гадагш цацагдах чимээ сонслоо. Шилэн хорго яг л их бууны сум шиг дэлбэрчихэв. Ландоны зүүгдсэн номын тавиур ч шалан дээр уналаа. Бороо орох мэт шил жингэнэн шалан дээр буух тэр эгшинд, агаарын урсгал сэнгэнэн цутгалаа. Ватиканы хонгилд талийгаачийн дэргэд зогсож байсан Витториагийн бодлыг гар холбоогоор аахилан, давчидсан хүний дуу тасалж орхив. «Роберт Ландон байна. Намайг сонсож байгаа хүн байна уу?» *Роберт!* Витториа түүнийг хажуудаа байсан болоосой гэж ямар их хүсч байснаа гэнэт ухаарав. Жардууд бие биеэ гайхан харсхийснээ, нэг нь гар холбоогоо сугалж аваад: «Ландон гуай! Та гуравдугаар суваг дээр байна. Захирагч таныг нэгдүгээр суваг дээр хүлээж байгаа» гэв. «Тэрийг нэгдүгээр суваг дээр байгаа гэж мэдэж байна, гэхдээ би түүнтэй биш, камерлинготой яримаар байна. Намайг холбоод өгөх хүн байна уу?» гэв. Нууц Архивын гүн харанхуйд хагархай шилэн дунд Ландон амьсгаадан зогсоно. Зүүн гарыг нь даган бүлээхэн юм урсаж байгааг харвал, цус гарчээ. Камерлингогийн хоолой гэнэт цаанаас сонсогдов. «Би Вентреска камерлинго байна. Юу болоо вэ?» Ландон харилцуурын товчийг даран, лугших зүрхээ даран: «Нэг хүн намайг цааш нь харуулах гэж оролдох шиг боллоо!» гэв. Шугам чимээгүй болов. Ландон нэг гүнзгий амьсгаа аваад: «Би бас дараагийн аллага болох газрыг олчих шиг боллоо» гэлээ. Түүнд хариулсан хүний хоолой камерлинго биш, харин Оливетти захирагч байлаа. «Ландон гуай. Юу ч битгий яриарай».

Хэсэг 87

Ландоныг Бэлведэрэ гудмыг өгсөн, Швейцар жардын командын байр руу гүйж явахад, цус болсон цаг нь 9.41 болж байв. Гараас нь цус гоожихоо больсон ч харагдаж байгаагаасаа илүү өвдөж байлаа. Тэр дөнгөж ирмэгцээ Оливетти, Рошер, камерлинго, Витториа, өөр бас хэдэн цэрэг ирсэн байхыг харав. Витториа түүн рүү ирээд: «Роберт! Чи шархадчихсан байна шүү дээ» гэлээ. Ландоныг хариу хэлэхээс өмнө Оливетти өрсөн: «Ландон гуай, та харин ч дажгүй байх шив дээ. Сэтгэл амарлаа. Би сануулахаа мартчихаж. Өршөөгөөрэй» гэв. «Мартчихаж ээ?» гэж Ландон уурлан хашхичив. «Тэнд намайг байгаа гэдгийг мэдсээр байж...» Рошер: «Миний буруу, эрхэм ээ» хэмээн урагш алхан хэлээд: «Би таныг архивд байгаа гэж огт мэдээгүй юм. Бидний шалгаж байгаа цагаан бүсийн нэг хэсэг нь таны байсан байшинтай цуваа холбогдсон байдаг юм. Бид эрлээ тэлж байсан болохоор тог таслах тушаалыг би өгсөн юм. Би мэдсэн сэн бол...» «Роберт» гэж Витториа таслан хэлээд, Ландоны шархтай гарыг харж, эргүүлж тойруулан үзэнгээ: «Паптанд хор өгсөн юм байна. Иллюминати түүнийг хөнөөжээ» гэлээ. Ландон тэр үгийг сонссон боловч ойшоох сөхөөгүй шахуу байсан болохоор шууд ухаарсангүй. Тэр зүгээр л бүсгүйн дулаан зөөлөн гарыг мэдэрч байв. Камерлинго дээлнээсээ торгомсог даавуу гаргаж ирээд, гараа арчиг хэмээн Ландонд өглөө. Гэхдээ юу ч хэлсэнгүй. Ногоон нүдэнд нь гал дүрэлзэнэ. Витториа: «Роберт, чи дараагийн кардиналыг хаана хөнөөхийг мэдэж чадсан гэл үү?» гэв. Ландон: «Тийм шүү. Түүнийг нөгөө юунд...» «Байз» гэж Оливетти дундуур нь орж ирээд: «Ландон гуай. Таныг нэг ч үг бүү дуугар гэж гар холбоогоор хэлэхдээ, зүгээр хэлээгүй юм шүү» гэлээ. Тэгээд эргэж Швейцарь

жардууд руу хандан: «Эрхэмүүд, өршөөх ажаам уу» гэлээ. Харуулууд командын төв рүү алга болов. Хэн нь ч гомдоллосонгүй. Тэднийг явуулаад, Оливетти эргэж харан өгүүлэв. «Хэлэхэд эвгүй ч гэсэн, Папыг зөвхөн энэ ханан дотор байгаа хүмүүсээс л хөнөөж чадна гэдгийг санах хэрэгтэй. Тиймээс буяныг бодож нэг ч хүнд итгэж болохгүй, манай жардуудад ч гэсэн» гэлээ. Энэ үгийг их л гаслантай яа, гэхдээ шударга хэлж байв. Рошер арсан: «Энэ дотор» «Тиймээ тийм» гэж Оливетти таслаад: «Таны хайлт оновчтой гэдэгт эргэлзмээр болоод байна. Гэхдээ л, бид тэгэхээс өөр аргагүй. Хайгаад бай» гэлээ. Рошер юм хэлэх гэснээ болиод, явж одов. Камерлинго гүнзгий амьсгаа авлаа. Тэр үг хэлээгүй байсан боловч Ландон энэ хүний зориг дахин хатуужиж байгааг мэдэрлээ. «Захирагч аа» гэж камерлинго шийдсэн байртай хэлээд: «Би цуурганыг завсарлууллаа» гэв. Оливетти ширүүн харсан хэвээр: «Бүү тэгээсэй гэмээр байна. Цаана нь бас хоёр цаг хорин минут байна шүү дээ» гэлээ. «Бага хугацаа шүү дээ». Оливетти нэлээн арцан: «Та юу хийх гээ вэ? Бүх кардиналыг хамгаалалтгүй нүүлгэн шилжүүлэх гээ юү?» гэв. «Бурхан надад хайрласан чадлын хирээр би энэ шашныг аварч үлдэхийг л хичээж байна. Яаж хийх вэ гэдэгт минь сэтгэлээ чилээх хэрэггүй» гэлээ. Оливетти адарч эхлэв. «Та юу ч хийх гэж байсан» гэснээ түр түгдэрээд: «Би таны хэлснийг буруушаах эрхгүй. Ялангуяа энэ сүмийг хамгаалах, аюулгүй байлгах үүргээ хөсөрдүүлсэн надад тийм эрх үгүй. Гэхдээ, би таныг хүлээгээч гэж гуйя. Хорьхон минут... арван цаг хүртэл. Ландон гуайн мэдээ зөв байх юм бол бидэнд алуурчныг барих боломж байсаар байна. Бидэнд горим, зохисоо сахих боломж байсаар байна». «Зохис оо?» камерлинго хүйтэн хөхрөн: «Зохисоо бид алдаад удаж байна шүү дээ, захирагч гуай. Та дайн болж байгааг анзаарахгүй байгаа юм гэж үү?» гэв. Нэг жард командын байрнаас гарч ирмэгцээ камерлингод хандав. «Эрхэм ээ, ВВС-ийн сурвалжлагч Гунтер Гликийг саатууллаа гэж илтгэж байна» гэлээ. Камерлинго толгой дохиод: «Түүнийг зураглаач хүүхэнтэй нь хамт Систин цогчны гадаа байлгаж бай. Би уулзая» гэлээ. Оливеттигийн нүд нь бүлтийгээд ирэв. «Та яах гэж байгаа юм бэ?» «Хорин минут шүү, захирагч аа. Би танд үүнээс илүүг өгч чадахгүй» гээд камерлинго явж одов. Оливетти Альфа Ромеогийнхоо суудалд суун, Ватикан хийдээс ямар ч илүү дутуу дагуулгүй шунгинан гарч одлоо. Арын суудалд, Витториа хаалганы хажуугийн хайрцгаас авсан боолтоороо Ландоны гарыг боож суув. Оливетти урагш харсан хэвээр: «За Ландон гуай минь. Хаашаа явах билээ?» гэв.

Хэсэг 88

Оливеттигийн Альфа Ромео гэрэл дохиогоо гялалзуулан байсан ч гэсэн хуучин Ромын зүг гүүр гаран давхих түүнийг хэн ч анзаарахгүй байгаа мэт. Бүх машин түүний эсрэг зүг Ватикан руу хөвөрч, Ариун ширээтийн хийд гэнэт Ромын хамгийн сонирхолтой хэсэг болчихсон мэт байв. Арын суудалд суугаа Ландоны толгойг олон бодол зовооно. Алуурчныг барьж амжих болов уу? Хэрэгтэй юмыг нь тэр хэлж өгч чадах болов уу? Эсвэл оройтчихоогүй байгаа даа? Камерлинго - Гэгээн Петерийн талбайд хурсан олонд та нар аюулд өртөөд байна гэж хэр өмнө нь хэлэх бол? Архивд болсон явдал үнэхээр алдаа байсан гэж үү? Оливетти зүтгэсээр Санта Мариа дэлла Витториа сүм хүртэл Альфа Ромеогийнхоо тоормос дээр огт гишгэсэнгүй. Өөр үед сэн бол, Ландоны тохой цайрч байх байсан ч одоо бүр мэдээгүй болчихсон шиг л байлаа. Толгой дээр гэрэл дохио гялалзах нь бид очиж явна шүү гэж хашхичих мэт санагдана. Гэхдээ, цаг хожихын тухайд үнэхээр гайхалтай байлаа. Дөхөж очингуугаа, Оливеттиг гэрэл дохиогоо унтраах болов уу гэж найдна. Машин дотор сууж явахуй, Ландонд юмыг эргэцүүлэх зуурхан завшаан гарч байлаа. Тэр Паптныг хороосон тухай ярьсныг гэнэт саналаа. Нэг бодлын утгагүй мэт санагдавч, нөгөө бодлын харин ч бүр

боломжийн ажээ. Хаашаа л бол хаашаа шургалдаг нь Иллюминатигийн ид чадал байсаар ирсэн: тэд тэндээ шургалж, үүрлэж, төлжиж, тэлж, улмаар уусгаж, шингээж орхидог байв. Папыг хороож чаддаггүй байсан гэвэл худлаа. Талийгаач Папын биед задлан хийхийг хориглодог байсан болохоор, Папын үхэлтэй холбоотой элдэв хов сэжгийн нэг нь ч саяхныг хүртэл батлагддаггүй байв. Эрдэмтдийн хүсэлтээр VIII Бонифачи (Сайн явдалт) нэрт залгамжлагч нь, сэнтийг нь булаахын тулд хороочихсон гэгддэг, V Сэлистин (Төвшин амгалант) Папын булшийг рентген туяагаар судлах хүсэлт тавьсан юм. Эрдэмтэд, ясны хэлтэрхий зэрэг хүч хэрэглэсэн ул мөр хайж байгаад, Папын гавал руу арван хуруу урт хадаас шаачихсан байсныг олж билээ. Хэдэн жилийн өмнө, Иллюминати гэгдэгчээс хэд хэдэн мэдээ түүн рүү явуулж байсныг Ландон дурсав. Тэр худал цуурхал хэмээн санаад, Харвардын микрофишийн цомгийг шүүж үнэн эсэхийг нь шалгасан билээ. Гайхалтай нь, тэр мэдээ үнэн байв. Тэгээд, тэр мэдээг нэр хүндтэй хэвлэлүүд Иллюминатигийн хий цуурхалд хэрхэн автдагийн жишээ болгон, ангийнхаа самбарт хадаж орхисон билээ. Харин одоо, хэвлэлийн тэдгээр сэжиг цуурхал байгаагүй мэт санагдана. Ландон тэдгээр өгүүллийг санаандаа тодхон санаж байв... Британийн өргөн нэвтрүүлгийн корпорац 1998 оны 7 дугаар сарын 14 I Жон Пол Пап 1978 онд Пи 2 гэдэг Масоны ложийн хорлолд өртөж, өөд болжээ... I Жон Пол Пап бээр Америкийн Арххамба Пол Марчинкусыг Ватиканы банкны захирлын албан тушаалаас зайлуулахаар шийдсэн нь Пи 2 гэх энэ нууц бүлгэм түүнийг хөнөөх шалтгаан болжээ. Энэ банк масоны ложийн луйврын мөнгийг хаацайлдаг байсан байна. Нью Йорк таймс 1998 оны 8 дугаар сарын 24 Яагаад I Жон Пол гадуур хувцастайгаа орондоо хэвтэж байв? Яагаад тэр хувцас нь урагдсан байв? Энэ мэт асуулт хөвөрсөөр л байна. Түүнд эмнэлгийн ямар нэг шинжилгээ хийгээгүй байна. Нэг ч Папад задлан шинжилгээ хийж байгаагүй гэдэг үндэслэлээр Кардинал Виллот задлан хийхийг хоригложээ. Жон Полын нүдний шил, шаахай, гэрээслэл нь хэрэглэж байсан эмтэй нь хамт орных нь дэргэдээс хачирхалтай яа алга болжээ. Лондоны Өдрийн Шуудан 1998 оны 8 сарын 27 ... хүчирхэг, өршөөлгүй, хууль бус Масоны ложийн хорон гар Ватиканд нэвтэрлээ. Витториагийн хармаанд байсан гар утас жингэнэж, Лондоны бодлыг арчиж орхив. Өдийд хэн утастаж байдаг билээ хэмээн гайхан, Витториа утсаа авлаа. Хурц хахир хоолойгоор нь хэн утастаж байгааг Ландон мэдэж орхив. Энэ хоолойг сонссон хэн бүхэн хэдэн алхмын цаанаас ч төвөггүй таньж болох билээ. «Витториа юу? Максимилиан Колэр байна. Антиматери олоогүй л байна уу?» «Макс? Чи зүгээр үү?» «Би мэдээ үзлээ. СЭРН, антиматери хоёрын тухай юу ч ярьсангүй. Энэ ч сайн л хэрэг. Наагуур чинь юу болж байна вэ?» «Бид канистераа олоогүй л байна. Байдал жаахан төвөгтэй, Роберт Ландон л нэлээн тусалж байна даа. Одоо бид кардиналуудыг хөнөөсөн хүний хойноос л хөөцөлдөж байна. Яг одоо бол ...» гэтэл дундуур нь Оливетти тасалж: «Ветра авхай, та дэндүү их юм яриад өгчихлөө» гэв. Бүсгүй их л дурамжхан гар утсаа буулгаад: «Захирагч аа. Энэ хүн бол СЭРН-ийн захирал. Тэр юу болж байгааг мэдэх ёстой шүү дээ». «Тэр энд л энэ асуудалтай зууралдах эрхтэй, гэтэл, та гар утасны нээлттэй шугамаар яриад байна. Та бүр зөндөө их бурчихлаа.» Витториа шүүрс алдан утсаа өргөж: «Макс, байна уу» гэв. «Надад чамд хэлэх юм байна л даа» гэснээ Макс: «Аавын чинь тухай юм... Аав чинь антиматерийн тухай хэнд ярьсныг би олж мэдлээ» гэв. Витториа барайгаад явчхав. «Макс, аав хэнд ч л хэлээгүй гэж надад ярьж байсан юм шүү». «Хэлсэн байх вий гэж эмээж байна шүү. Би аюулгүйн албанаас зарим нэг юм тодруулчхаад, эргээд ярья» гэснээ Макс утсаа тавилаа. Витториагийн царай барайсан хэвээр, гар утсаа хармаандаа хийлээ. «Чи зүгээр үү» гэж Ландон асуув. Бүсгүй мишвэлзэн толгой дохисон боловч хуруу нь чичгэнэнэ. Зүгээр ч биш байлаа. Оливетти: «Сүм Пиаца Барберинигийн тэнд байгаа» гэж хэлээд, дуут дохиогоо

унтраан цагаа харав. «Есөн минут л байна шүү». Ландон эхний тэмдгийг шууд олж харсан боловч сүмийн хонх нэлээн хол царгилах сонсогдов. Пиаца Барбени. Их л сонссон нэр санагдавч, яг юу билээ гэдгийг нь ололгүй, бодлыг зовоосоор ... гэнэт саналаа. Энэ талбайн хажууд, метроны буудал барихтай холбоотой нэлээн шуугиан болсон билээ. Хорин жилийн өмнө, тэр хавьд метроны буудал барьж, талбайн доогуур ухах болж, урлагийн түүхчид, тэгж ухвал талбайн голд байгаа гэрэлт хөшөө нурна гэж эсэргүүцэж байжээ. Хот байгуулалтын мэргэжилтнүүд аргаа барж, сүүлдээ тэр гэрэлт хөшөөг нүүлгэн, оронд нь Тритон гэх усан оргилуур барьж өгчээ. *Тэгэхээр Бернинигийн үед энэ талбай дээр гэрэлт хөшөө байсан хэрэг* гэж Ландон олзуурхан бодов. Одоо харин гурав дахь тэмдэг алга болчхоогүй байгаа даа л гэж Ландон эмээж байлаа. Талбайгаас нэг гудамжны наана, Оливетти машинаа хажуу гудам руу нь эргүүлж зогсоолоо. Тэгээд хүрмээ товчилж, захыг нь босгоод, буугаа цэнэглэв. «Та хоёр зурагтаар гарчихсан болохоор хүмүүс таньчихаж магадгүй. Тэгэхээр, сэмхэн шиг урд гол хаалгыг нь ажиглахаар талбайн нөгөө талд гар. Би ар талаас орьё» гэлээ. Нэг буу гаргаж Ландон өгөөд: «Юмыг яаж мэдэх вэ» гэв. Ландон өнөөдөртөө хоёр дахь удаагаа буу барьж байгаа нь энэ. Буугаа энгэрийнхээ хармаанд хийхдээ, нөгөө Диаграм-ынхаа хуудсан дээр нь хийчихсэнээ гэнэт санах. Орхиод гарахгүй яав даа гэж бодлоо. Үнэлж баршгүй номынх нь хуудас, ингээд хэн нэг хүний хармаанд жуулчинд зориулсан Ром хотын зураг шиг явж байгааг мэдвэл, Ватиканы номын санч гуай галзуурах байх даа. Архиваас гарахдаа шилэн ханыг хагалж, ном бичгийг нь талаар нэг цацаж орхисноо санавал голоор нь могой гүйх шиг эвгүй болов. *Гэхдээ, архив маань өөрөө энэ шөнө дэлбэрч цацагдчихгүй бол ч...* Оливетти машинаасаа гараад, нарийн гудамж руу зааж: «Талбай тэр зүгт бий. Нүдээ онгойлгоод, хүн амьтанд харагдчихгүй шиг яваарай даа» гэв. Тэгээд, гар утсаа бүсэндээ бэхэлсэн гэрэнд нь хийгээд: «Ветра авхай. Хоёулаа утсаа автоматаар дууддаг дээр нь тохируулъя» гэлээ. Витториа утсаа гаргаж ирээд, Пантеоны дэргэд очихдоо тохиргоо хийсэн товч дээр дарж, Оливетти руу залгахад, бүсэнд нь байсан утас чимээгүйхэн чичирхийлэв. «Болж байна. Ямар нэг юм харвал надад мэдэгдээрэй» гээд буун дээрээ зөөлөн цохилон: «Би дотор хүлээж байя. Тэгээд, тэр муу тэрсүүдийг ч цусыг нь холиод өгнө дөө» гэлээ. Яг тэр үед, тэднээс тун холгүй өөр нэгэн гар утас дуугарч байлаа. Хассассин: «Байна уу» гэв. «Би Янус байна» гэлээ. Хассассин инээмсэглэн: «Эзэн минь, та сайн л биз дээ» гэв. «Хаана байгааг чинь мэдчихээд, зарим хүн чам руу хөдөлж байгаа шүү». «Тэгвэл тэд арай л оройтчихож дээ. Би энд аль хэдийн амжуулчхаад байж байна». «Сайн л байна. Наанаасаа мэнд л зайлаарай даа. Хийх ажил дуусаагүй л байна шүү». «Миний өмнө хөндөлдсөн бүхэн хүүр болдог юм». «Чиний өмнө хөндөлдсөн хүн ч их юм мэддэг бололтой билээ шүү». «Та тэр Америк залууг хэлээд байна уу?» «Чи түүнийг мэддэг юм уу?» Хассассин хөхрөн: «Ухаантай мөртөө гэнэн юм билээ. Надтай утсаар яриад байсан шүү дээ. Хажууд нь байгаа хүүхэн харин яг эсрэгээрээ.» Леонардо Ветрагийн охины тухай ярихад, хуял тачаал нь сэрнэ. Утасны цаана хэсэг чимээгүй болоход, хассассин анх удаа эзэн нь тээнэглэсэнгүй байдалд орохыг мэдрэв. Эцэст нь: «Хэрэгтэй бол тэр хоёрыг нухчихна биз дээ» гэлээ. Алуурчин инээвхийлэн: «Тэгчихье» гэв. Бүх биеэр нь янагийн нялуун мэдрэмж жирсхийн гүйж: «*Хүүхнийг харин би алчуур болгоод авчихъя*» гэлээ.

Гэгээн Петерийн талбайд дайн болж байгаа юм шиг л байв. Энд тэндгүй шуугилдан, үймэлдэнэ. Тэмдэгт өндөрлөгийг эзэлж байгаа хуягт шиг хэвлэлийнхний машин талбай руу зүтгэж, буу барьсан цэрэг шиг сэтгүүлчид камер, микрофоноо барин давшилна. Талбайг хүрээлэн хэвлэлийн тулааны хамгийн сүүлийн үеийн шилдэг зэвсэг - хавтгай дэлгэцээ байрлуулах гэж үймэлдэнэ. Хавтгай дэлгэц гэж ачааны машин юм уу, эвхдэг шат дамнуулан тавьчихдаг баймгай том зурагт ажээ. Байшингийн дээвэр дээр байрлуулдаг зарлал, рекламн том зурагт шиг телевизийнхээ нэвтрүүлэг, компанийнхаа логог байнга цацна. Хэрэв дэлгэцээ зөв байрлуулж чадвал, үйл явдлыг сурвалжилж байгаа бусад телевиз тэр дэлгэцийг нь харуулахгүйгээр зураг авах боломжгүй болохоор ашигтай байдаг ажээ. Талбайд зөвхөн хэвлэлийнхэн ирээд зогссонгүй, цочирдсон олон бас цуглаж байлаа. Тал бүрээс гайхаж, сонирхсон хүмүүс бөөн бөөнөөрөө ирнэ. Ердийн үед чөлөөтэй байдаг тэр талбайн ямх зай болгонд хүн бүчин зогсжээ. Болж байгаа үйл явдлыг дор бүр нь мэдээлж байгаа том том зурагтуудад наалдах шахуу зогсон, мэдээ бүрийг сэтгэл дэнслэн сонсоно. Талбайгаас зуухан алхмын цаана Гэгээн Петерийн ордны зузаан хэрмэн дотор байдал бүр ч ноцтой байлаа. Шартрон дэслэгч, гурван харуултайгаа харанхуйд хөлхөнө. Харанхуйд хардаг хэт туяаны шил зүүсэн тэд урдаа металл илрүүлэгч бариад, хоёр тийш ширвэн ширвэн алхана. Ватиканы нийтэд нээлттэй хэсгийг самнаж үзэхэд, одоохондоо л лав юу ч илэрсэнгүй. «Шилээ авсан нь дээр юм шиг байна» гэж нэг гавуу хэллээ. Шартрон аль хэдийн хэт туяаны шилээ тайлж байв. Тэд Паллиум хонхор буюу ордны яг төв дунд зогсоно. Ерэн есөн зулын гэрэлд хэт туяаны шил гялбаж байв. Шартрон нүсэр шилээ авч, санаа амран, хүзүүгээ шилгээн, чилээгээ гаргалаа. Тэгээд, нөхдийн хамт шатаар аажуухан доошлов. Доор байгаа алтан зүмбэрт танхим шаргалтан гялалзана. Тэр өмнө нь ийшээ ирж үзээгүй ажээ. Шартрон Ватиканд ирснээсээ хойш ямар нэг муу юм болох тоолон, эндхийн гайхалтай сонин нэг зүйлийг өөртөө нээдэг байлаа. Энд байгаа олон зулыг анх удаа л харж байгаа нь энэ ажгуу. Илүү ч үгүй, дутуу ч үгүй яг ерэн есөн зул энд ямагт асч байдаг уламжлалтай ажээ. Эндхийг хариуцсан нэгэн аль нэгийг нь унтраачихгүй байхын тулд хянамгай нь аргагүй нэг нэгээр нь ариун тос нэмж, харгалзан суудаг байв. *Дандаа биш гэхэд шөнө дунд хүртэл л лав харгалздаг байх даа* гэж Шартрон бодлоо. Шартрон металл илрүүлэгчээ зулын дээгүүр нэг ширвэчхээд, цаашаа явав. Юу ч илэрсэнгүй, илрээгүйд нь ч гайхсангүй. Учир нь дэлгэц дээр канистер харанхуйд байсан билээ. Цааш явсаар, том хар нүхийг хаасан нүсэр хаалтын дэргэд ирэв. Нүхэнд эгц доошоо буусан давчуу чулуун шат байх ажээ. Энэ нүхний тухай олон домог бий. Гэхдээ, тэд доошоо буусангүй. Рошер занги зөвхөн нийтэд нээлттэй хэсгийг л шалга, цагаан бүсийг орхи гэж тов тодорхой тушаажээ. «Энэ юун үнэр вэ?» хэмээн, нүхний амсраас эргэхдээ асуулаа. Нүхнээс хортой гэмээргүй анхилуун үнэр гарч байв. «Зулын тос байх» гэж нэг нь хариулав. Шартрон гайхан: «Керосин гэхээсээ үнэртэй ус гэмээр юм». «Керосин биш ээ. Энэ зул Папын тахилын ширээний дэргэд байдаг болохоор этанол, чихэр, парфюм, бутаны тусгай холимог хийдэг юм». «Бутан аа?» Харуул толгой дохин: «Тийм. Асгах юм бол ч баларна шүү. Тэнгэр шиг анхилам үнэртэж байгаа ч там шиг галзуу шатна шүү» гэлээ. Харуулууд Паллиумын хонхрыг шалгаж дуусаад гар холбоо тасардаг өөр нэг хэсэг рүү алхаж явтал, гар холбоо хяхтнан аслаа. Тэд холбоогоор дамжуулсныг сонсоод, цочин хэлмэв. Камерлинго уламжлалыг зөрчиж, цуурганыг таслан, кардиналууд руу очих гэж байгаа тухай сонсжээ. Ийм юм түүхэнд байгаагүй. Түүнээс гадна, Ватикан хэзээ ч өмнө нь шинэ төрлийн цөмийн цэнэгт бөмбөг дээр сууж байсангүй билээ. Гэхдээ, асуудлыг камерлинго биеэрээ шийдэж байгааг сонсоод, Шартрон жаахан тайвширлаа. Түүний хувьд, камерлинго Ватикан хийдийн дотор хамгийн их хүндэлж явдаг хүн байлаа. Камерлинго зарим нь бурханд өгсөн хайр нь өөрийг

нь үгүй хийчих шахсан шашны гэнэн мухар сүсэгтэн гэж шоолдог байсан ч бурхны дайснуудтай учрахын цагт хамгийн хатуу тулалдах хүн бол энэ гэдгийг зөвшөөрдөг билээ. Швейцар жардууд камерлинго цуурганд бэлдэн явахыг энэ долоо хоногт олонтаа харсан бөгөөд тэд түүнийг жаахан цухалдангуй, зөөлөн харц нь нэлээн шаардангуй болсон тухай ярилцаж байлаа. Зөвхөн цуурганд бэлдээд зогсохгүй, багш нь байсан Папыг алдсаныхаа дараа ийм чухал ажлыг тийм яаруу хийх хэрэгтэй болсон гэдгийг ч тэд бас шивнэлдэж байв. Шартрон Ватиканд ирээд удаагүй байхдаа, камерлингогийн нүдэн дээр ээж нь бөмбөгөнд тэсэрч үрэгдсэнийг сонссон билээ. *Сүмд бөмбөг тэсэлдэг... одоо бүр газар сайгүй тэсэлж эхлэх нь дээ.* Засгийн газрынхан бөмбөг тэсэлсэн этгээдийг олоогүй, христийн эсрэг этгээдүүд л байх гэсхийгээд, чимээгүй өнгөрөөсөн билээ. Тиймээс, камерлинго амьдралын гашууныг амссан гэдэг нь тов тодорхой. Хоёрхон сарын өмнө, нэг сайхан орой Шартрон Ватиканы цэцэрлэгт явж байгаад, камерлинготой санамсаргүй мөргөлдөж орхисон билээ. Камерлинго түүнийг шинэ харуулуудын нэг гэдгийг төвөггүй таньж, хамт жаахан алхья гэж билээ. Тэр хоёр онц зүйл яриагүй боловч камерлинго Шартронд гүн дотно сэтгэгдэл үлдээжээ. Шартрон: «Эцэг минь, та болгоож өршөөвөл танаас болчимгүй юм асууж болох уу?» гэвэл, Камерлинго инээмсэглэн: «Танд би бас болчимгүй хариулт өгч магадгүй л юм даа» гэжээ. Шартрон цайлган гэгч хөхрөөд: «Би тааралдсан бүх гэлэнгээс асуудаг ч гэсэн одоо болтол ухаарахгүй яваа юм» гэлээ. «Чамайг тэгээд ямар гэгч асуулт зовоогоод байгаа хэрэг вэ?» гэж камерлинго нарийн жимээр хар дээлийнхээ хормойг намируулан, жавхалзтал алхангаа асуув. Хар арьсан гутал нь гялс гялсхийн газар товчлох бөгөөд орчин үеийн атлаа эгэл, эрэлхэг атлаа даруу эзнийхээ чанарыг илтгэх шиг санагдана. Шартрон гүнзгий шүүрс алдан: «Би тэр бүхнийг чадагч, нигүүлсэнгүй сэтгэлт гэдгийг л ухаарахгүй яваа хүн л дээ» гэв. Камерлинго инээвхийлээд: «Чи Бичвэрийг уншсан биз дээ?» «Хичээсэн». «Тэгээд чи бүхнийг чадах, нигүүлсэнгүй сэтгэл хоёр хэрхэн нэгэн биед цогцолсныг ойлгохгүй байгаа юм биз дээ?» «Яг тийм». «Бүхнийг чадагч, нигүүлсэнгүй сэтгэлт гэдэг бол бурхан бүхнээс хүчтэй атлаа нэн энэрэнгүй гэсэн үг шүү дээ». «Гадарлаж л байна л даа. Гэхдээ энэ хоёр чинь ... зөрчилдөөд байгаа юм шиг ээ». «Тийм шүү. Зөрчилдөөд байгаа. Хүний зовлон, дайн, өвчин гээд л...» «Харин тийм» гэж Шартрон тосч аваад камерлингод асуултаа тайлбарлах гэж оролдон: «Энэ орчлонд аймшигтай зүйл их л болох юм. Хүний зовлонг харвал, бурхан бүхнээс хүчтэй атлаа нэн энэрэнгүй хоёрыг зэрэг цогцлоох аргагүй юм шиг? Хэрэв бурхан бидэнд хайртай байсан бол, тэгээд энэ зовлонг өөрчлөх чадалтай байсан бол биднийг энэ зовлонгоос гэтэлгэж дөнгөх байсан биш үү?» Камерлинго хөмсгөө зангидан: «Тэгэх байсан гэж үү?» Шартрон хэлмэж орхив. Би дэндүү эрээ цээргүй аашлаагүй байгаа? Асуух ёсгүй асуучихсан болов уу? «Хэрэв бурхан бидэнд хайртай, биднийг хамгаалдаг байсан бол тэгэх л байх байсан байх даа. Тэгэхээр, нэг бол тэр бүхнийг чадагч, гэхдээ тоомжиргүй: эсвэл нигүүлсэнгүй, гэхдээ туслах чадалгүй болж таарч байгаа биш үү?» «Та хүүхэдтэй юу, дэслэгч ээ?» Шартрон гайхасхийн: «Үгүй ээ, эрхэм ээ». «Та найман настай хүүтэй байжээ гэж бодъё. Та хүүдээ хайртай байх байсан уу?» «Мэдээж шүү дээ». «Түүнийг зовоохгүй байхын тулд та чадах бүхнээ хийх байсан уу?» «Тэгэлгүй яах вэ?» «Та түүнд ролик авч өгөх байсан уу?» Шартрон эргэцэв. Камерлинго дандаа л түүнд хачирхалтай цэцэн санагддаг байв. «Тэгэх л байсан байх даа» гэж Шартрон хэлээд: «Тэгнэ ээ, тэгнэ. Ролик авч өгөлгүй яах вэ, гэхдээ болгоомжтой байгаарай гэж захих байсан». «Та тэгээд эцгийн хувьд түүнд үндсэн хэдэн сайн зөвлөгөө өгөөд явуулж, алдаагаа өөрөө хийж, өөрөө түүнээсээ сураг гээд явуулах байсан уу?» «Би ард нь гүйж, үглэж яншихгүй л байсан даа. Та энэ тухай л асуугаад байна уу?» «Гэхдээ хүү чинь унаад, өвдгөө шалбалчихвал яах вэ?» «Дараа жаахан болгоомжтой явах биз л гэж

бодно доо». Камерлинг инээвхийлэн: «Тэгэхээр, та хүүгээ өвтгөхгүй байлгаж болох чадалтай аглаа хүүгээ хайрласандаа алдаан дээрээ сураасай гэж бодно гэсэн үг үү?» «Тийм шүү. Өсч том болохдоо, өвдөлтийг мэдрэх л ёстой шүү дээ. Тэгж л байж бид сурдаг шүү дээ». Камерлинг толгой дохин: «Харин тийм л байхгүй юу даа» гэв.

Хэсэг 90

Ландон, Витториа хоёр Пиаца Барберинигийн баруун талд байх жижиг гудамжны сүүдрээс ажиглаж байв. Талбайн цаана, бүрэнхийн дунд, сүмийн байшингийн дээрх цомбон орой ёрдойх мэт сүүмийнэ. Шөнө болмогц, өдрийн халуун арилад байхад, яагаад талбай дээр нэг ч хүн байхгүй байгааг Ландон гайхсан боловч дээр нь онгорхой цонхоор хашхичих зурагтын дууг сонсвол, бүх хүн хаа одсоныг төвөггүй мэдэж болох байв. «...Ватиканаас одоо болтол тайлбар өгөөгүй байна ... хоёр кардиналыг хорсолтой ёо хөнөөжээ ... Ромд сатаан шүгэлсэн нийгэмлэг... илүү гүнзгий нэвтэрсэн байж ч магадгүй ...» Нерогийн тавьсан гал* л энэ мэдээ шиг түргэн тархаж байсан байх даа. Бүх дэлхий Ром хотыг цөхрөн харж байлаа. Энэ болж байгаа бүхнийг зогсоож чадах болов уу гэж Ландон бодолхийлэв. Сүм рүү хяламхийн хүлээн зуураа, Ландон талбайг ажвал хэдэн захаас нь сүүлийн үеийн байшингууд шавж эхэлсэн боловч зууван хэвээрээ байгааг харж гайхлаа. Хажуугийн тансаг зочид буудлын орой тэртээ дээр том гэгч неон гэрэл цацран байхыг Витториа хараад, Ландонд дохиж заав. Гайхалтай тохиол гэдэг энэ л байх. Бернини Зочид буудал «Аравт тав дугуу байна» гэж Витториа хэлээд мууран нүдээрээ талбайг нэгэнтээ ширвэв. Төд удалгүй бүсгүй Ландоны гарыг татаж, сүүдэр рүү оруулаад, талбайн төв рүү дохилоо. Ландон бүсгүйн ширтээ зүг хараад, загзасхийв. Тэдний өмнө, гудамжны гэрэлд, хоёр том хар дүрс бүртэлзэнэ. Хоёулаа нэвсгэр хувцас өмсч, хувцасныхаа юүдэнгээр нүүрээ хаажээ. Энэ бол католик бэлэвсэн эхнэрүүдийн уламжлалт хувцас билээ. Тэгэхээр, эмэгтэй хүн болов уу гэж харагдсан ч харанхуйд тодорхой мэдэгдсэнгүй. Нэг нь арай настай, өвчтэй болов уу гэлтэй хазганах агаад залуухан, хүчтэй нөгөө нь түүндээ тусалсан янзтай. «Буугаа өгөөдөх» гэж Витториа хэлэв. «Болохгүй шүү дээ». Хэлж дуусаагүй байхад нь, Витториа шуртхийн хармаанд нь байсан бууг авчихлаа. Тэгээд, бүсгүй тэр хоёрыг араар нь тойрох санаатай, сүүдэрт зүүн талаас нь сэмхэн гэтэв. Чимээ огт гаргалгүй, агаарт хөвж байгаа юм шиг алхана. Ландон түүнийг хараад, ***** гадас шиг гацчихав. Хормын дараа амандаа хараал үглэсээр, хойноос хөдөллөө. Нөгөө хоёр их л удаан майрганана. Ердөө хагас минутын дотор Ландон, Витториа хоёр яг хойно нь гарчхаад, араас нь дөхөж явлаа. Витториа элгээ эвхэн буугаа нуужээ. Харахад гэмгүй мэт боловч хэрэгтэй бол хормын зуур буудахад бэлэн зэхжээ. Бүсгүй нөгөө хоёр руу хөвөх мэт хурдан ойртож, араас Ландон гүйцэх санаатай алхаж явахдаа, хазгай гишгэж чулуу үсэргээдэхлээ. Витториа түүн рүү муухай гэгч хялайв. Аз болж, нөгөө хоёр сонссонгүй, хоорондоо ярилцаж явлаа. Гучаад тохой зайнаас, Ландон тэдний яриаг дуулж эхлэв. Гэхдээ, нэг ч үг тогтоож сонссонгүй, зүгээр л шулганалдах ажээ. Хажууд нь Витториа улам л хурдан алхах агаад элгээ эвхсэн гар нь жаахан суларч, буу нь цухуйчихсан явж байлаа. Хорин тохой дөхөв. Нэгнийх нь дуу их л цээл агаад нөгөө нь чанга, ууртай, хар ярхийнэ. Настай хүүхний хоолой шиг сонсогдов. Юу вэ? Манин хүн юм болов уу? Яг юу хэлж байгааг нь сонсох санаатай чих тавьтал, өөр нэг эмэгтэйн чанга яриа саад боллоо. «Mi scusi! (Уучлаарай. Ита.)» гэж Витториа найрсгаар хэлсэн ч час хийсэн чанга сонсогдов. Тэр хоёр нэвсгэр хүн гэнэт зогсоод, эргэж харах зуур, Ландоны зүрх зогсчих шиг боллоо. Харин Витториа тэр хоёр руу шууд чиглээд, улам хурдан алхана. Тэр хоёр яаж ч амжхааргүй байлаа. Ландоны хөл хөшчихөв. Витториа элгэндээ эвхсэн гараа сул тавьж, буугаа урагш сунгах шиг санагдав.

Тэгтэл удалгүй нөгөө хоёр хүний нүүр гудамжны дэнд тодорч, бүсгүйн мөрөн дээгүүр харагдлаа. «Ээ, юу болох нь вэ» гэсэн бодол гэнэт зурсхийн: «Витториа, битгий» гэж хашхиран хойноос нь гүйлээ. Витториа ч хормын төдийд байдлыг ухаарч, гараа ердийнхөөрөө хаялан яваа юм шиг нэгэнтээ алхалснаа, харанхуй шөнө даарч бэгцийсэн мэт сугаа хавчин гараа урдаа зөрүүлэхдээ, бугаа нууж амжив. Ландон гүйцэж ирэхдээ, нөгөө хоёртой золтой л мөргөлдчихсөнгүй. «Buona sera (Үдшийн мэнд. ита)» гэж Витториа бувтнахад, дуу нь их л зөөлөрчээ. Ландоны санаа уужран, урт амьсгаа авав. Уламжлалт нэвсгэр хувцас өмссөн хоёр настай авгай өмнө нь зогсоно. Нэг нь хөл дээрээ тогтож чадахгүй шахуу хөгшин хүн, арай танагтай нь түүндээ тусалж байжээ. Хоёулаа хүзүүгээрээ эрхи зүүжээ. Тэр хоёр юун хүмүүс гэнэт гараад ирэв хэмээн балмагдсан янзтай байлаа. Витториа бээрсэн мэт зогсоод, мишилзэн: «Dov'è la chiesa Santa Maria della Vittoria? Санта Мариа дэлла Витториа сүм хаана байдаг вэ?» Хоёр хөгшин гарч ирсэн байшингийнхаа зүг зэрэг шахуу заан: «E la (тэр байна. ита)» гэв. «Grazie (Баярлалаа. ита)» гэж Ландон хэлээд, гараа Витториагийн мөрөн дээр зөөлөн тавьж, арагш нь эелдгээр татав. Зүв зүгээр явсан хоёр гэмгүй авгайг буудах шахсандаа халширч байв. «Non si può entrare (Одоо орж болохгүй. ита)» гэж нэг авгай нь хэлээд: «E chiusa temrano (Эрт хаачихсан. ита)» гэлээ. «Эрт хаачихсан гэнэ ээ» гэж Витториа дуу алдаад: «Perche (Яагаад. ита)?» гэж асуув. Хоёр авгай хоёулаа зэрэг тайлбарлаж гарлаа. Уур унтуугаа гаргах боломж гарлаа гэсэн шиг л бурж өглөө. Ландон итали хэлэндээ сайн биш ч гэсэн заримыг нь ойлгочихлоо. Арван тавхан минутын өмнө тэр хоёр хөгшин сүм дотор Ватиканыг авран хамгаалахыг бурхнаас гуйн мөргөж байсанд нэг хүн гарч ирээд, өнөөдөр сүм эрт хааж байгаа гээд тэр хоёрыг гаргажээ. «Hanno conosciuto i' uomo?» гэж Витториа их л шаргуу шалгаав. «Тэр таньдаг хүн чинь байсан уу?» Хоёр авгай толгой сэгсрэв. Тэр хүн straniero crudo (хэтэрхий бүдүүлэг. ита), тэнд байсан бүх хүнийг бараг л хүчээр хөөсөн ажээ. Цэвэрлэгч, залуу мөргөлчид цагдаа дуудна шүү гэсэн боловч, тэр инээгээд, цагдаа дуудахдаа, камертай ир гээрэй гэж тохуурхаж байжээ. Камертай ир гэнэ ээ гэж Ландон амаа ангайн асуув. Хоёр хөгшин ууртай яа мөрөө хавчин, нөгөө залууг «bar- arabo» хэмээн зүхэв. Тэгээд, цаашаа эргээд, явж одов. «Bar-arabo гэж юу гэсэн үг вэ» гэсэн байртай Ландон Витториа руу харвал «Зэрлэг гэж байгаа юм» гэлээ. Тэгснээ: «Үгүй ээ. Bar-arabo гэдэг чинь Араб гэдгийн доромж нэр шүү дээ. Тэгэхээр, араб байх нь» гэлээ. Ландоны нуруу арзасхийн сүм рүү харахад, сүмийн өнгөт шилэн хээтэй цонх цаанаасаа туяарч байв. Бие нь хөшиж орхилоо. Витториа түүнийг анзааралгүй гар утсаа гарган, автомат товчоо даран: «Оливеттид хэлэх хэрэгтэй» хэмээн үглэнэ. Ландон дуугүй л бүсгүйн гарт хүрч, салганасан гараараа сүм рүү заалаа. Витториа сая л анзаарав. Чөтгөр нүдээ анивчин, дооглох шиг галын дөл цонхны цаанаас өрвөлзөж байлаа. * Эртний Ромын хаан Неро- Ром хотын төвд, ордон барих гэсэнд, хотын төвд газар олдохгүй байжээ. Тэгэхээр нь, нэг шөнө сэм гал тавьж, Ромын төвийг бүхэлд нь түймэрдээд, нурмыг нь зайлуулж ордноо барьсан гэдэг домог бий. Үүнээс болоод Нерогийн түймэр гэдэг нь хорон санаатны тэвчишгүй үйлдлийг нэрлэдэг зүйр үг болжээ.

явч бүрийн оньсон төхөөрөмж овоорон хэвтэнэ. Хэрмийн зарим хэсгийг сэргээн засварлаад, жуулчдад сонирхуулдаг ажээ. Ландон гадна хэрмээс төв цайз руу харлаа. Тойрог хэлбэртэй цайз илд барьсан хүрэл ангель хүртлээ 107 тохой орчим өндөр ажээ. Тагттай өрөө дотроосоо гэрэлтсэн хэвээр. Ландон тийшээ хашхирмаар санагдсан ч тийшээ очих өөр зам хайсан нь дээр байлаа. Цагаа харвал 11:12 болж байна. Хэрмийн дотогшоогоо нурсан чулуун нуранги дамжин доошоо буулаа. Тэгээд, хэрмийн хананы сүүдэр даган нар зөв тойрон гүйлээ. Гурван жижиг хаалга тааралдсан боловч бүгдийг нь бүр мөсөн хаачихжээ. *Хассассин яаж дотогшоо ордог юм бол?* Түлхэж үзээд л цааш явна. Шинэ зассан хоёр хаалга олсон ч гадна талаас нь түгжсэн байлаа. *Үүгээр л лав ордоггүй бололтой.* Цаашаагаа бөгтөлзөн гүйнэ. Ландон бараг л хэрмийг бүхэлд нь тойрчих шахлаа. Гэнэт өмнө нь хайрган зам гарч ирлээ. Нэг үзүүр нь гадна хэрмийн хана руу, гүүр татсан дааман хаалга руу оджээ. Харин нөгөө үзүүр нь төв цайз руу оржээ. Зам явсаар цайзын гол руу хонгил руу орсон харагдана. *Il traforo!* Цайзын трафоро гэж хонгилын тухай Ландон өмнө нь уншиж байсан санагдана. Энэ нь цайзыг дотуур нь ороосон том нүхэн хонгил бөгөөд цайзын хамгаалалтын захирагч хоромхон зуур морьтойгоо цайзан дээрээс доошоо бууж байх зориулалттай байдаг ажээ. Хассассин дээшээ гарсан байж таарна. Зам дагаад очвол, том гэгч хонгил угтлаа. Ландон баярлан гүйсэн боловч хонгил руу ормогцоо зогтуулаа. Хонгил доошоо ороосон буусан байлаа. Буруу тийшээгээ явжээ. Трафорогийн энэ хэсэг дээшээ биш, доошоогоо зоорь руу ордог бололтой. Хонгил газрын гүн рүү нэлээн гүн орсон санагдана. Ландон эргэлзэн дээшээ тагт руу нэг харлаа. Тэнд хүн хөдлөхийг харсандаа итгэлтэй байлаа. *Шийдэх хэрэгтэй.* Нэгэнт өөр зам хараагүй болохоор тийшээгээ орохоос өөр арга байсангүй. Тэртээ дээр хассассин олзныхоо дээр зогсоод харж байлаа. Алгаараа гарыг нь илбэл ёстой л торго шиг зөөлөн сайхан арьстай ажээ. Хувцсыг нь тайлан, бүх биеийг нь шохорхох хүслэн төрнө. Энэ хүүхнийг хэдэн янзаар эдлэн жаргах билээ дээ. Хассассин энэ хүүхнийг эдлэх эрхтэй ажээ. Януст хангалттай зүтгэсэн. Энэ бүсгүй бол дайны олз. Эдэлж дуусаад, буйдан дээрээс нь суга татан өвдөг сөхрүүлэн суулгана. Тэгээд суугаагаараа түүнд бас таашаал өгөх ёстой. *Үүнээс илүү шан гэж үгүй.* Хуял тавих яг тэр эгшинд, хассассин хүүхний хоолойг хэрчинэ. *Ghayat assa' adaha.* *Үүнээс илүү таашаал гэж үгүй.* Дараа нь тагтан дээрээ гарч зогсоод, тамхиа татсан шигээ олон хүн олон зууны турш хадгалж байсан хонзонг... өөрийнх нь зүтгэлийн эцсийн үр шим - Иллюминатигийн ялалтыг сэтгэл бахдан харах билээ. Ландоныг буух зуур хонгил улам ч харанхуй болно. Яг нэг тойрон, доошоо буусны дараа гишгэдэл тэгширлээ. Хөлийнхөө чимээ цуурайтахыг сонсвол том танхимд орж ирснээ мэдлээ. Харанхуй дотор ямар нэг зүйл бүртийнэ. Урагш алхан гараараа тэмтэрлээ. Гарт нь хром, шил бүхий өөгүй тэгш хүйтэн гадарга баригдав. Машин бололтой. Тэмтэрч явсаар хаалгыг нь олоод бариулаас татан онгойлголоо. Машины бүхээгийн доторх гэрэл нэлсхийн асав. Арагш нэг алхан хараад, энэ хар мухлаг машиныг танив. Хоолой руу нь огшоод явчихлаа. Тэгснээ дотор нь үсэрч олоод, оргилуур дотор гээчихсэн бууныхаа оронд барьчихмаар зэвсэг хайв. Юу ч олсонгүй. Харин Витториагийн гар утас харагдав. Бяц дарагдан, хэмхэрчээ. Үүнийг хараад, Ландон хирдхийв. Хожимдоогүй байгаасай билээ. Урагш тонгойн машины урд гэрлийн товчийг дарвал гэрэл аслаа. Жирийн л нэг өрөө. Өмнө нь морины жүчээ юм уу, зэвсэг хадгалдаг байсан байх. Тэгээд, энэ өрөө мухар байлаа. Гарц байхгүй. Буруу газар ирчхэж. Ландон машинаасаа үсрэн гарч ханыг тойруулан харлаа. Хаалга үүдгүй өрөө байх. Хонгилын үүдэн дээр байсан ангелийг бодвол, ийм баймгүй юм даа гэж бодогдоно. Үгүй дээ! Оргилуурын дэргэд алуурчны хэлсэн үг санаанд оров. *Тэр Гэгээрлийн сүмд ... намайг ирэхийг хүлээгээд л байж байгаа даа.* Одоо алдаа хийе гэхэд, дэндүү харамсмаар ихийг амжуулчихсан байлаа. Зүрх нь

дэнсэлнэ. Уур уцаар, үзэн ядалт түүнийг галзууруулах шахаж байна. Шалан дээр цус байхыг хараад Витториагийнх юм болов уу гэж эмээв. Гэхдээ мөрийг нь харвал гутлын улны мөр байна. Алхам нь хол, цусан дуслыг үзвэл зөвхөн зүүн хөлийнх ажээ. Хассассин! Ландон мөрийг нь даган өрөөний мухар руу очиход сүүдэр нь улам томрон, нүүгэлтэнэ. Урагш алхах тусмаа гайхаж баршгүй. Цус татсан мөрийг нь харвал тэр шууд л өрөөний булан руу гараад явчихсан байлаа. Булан руу очмогцоо тэр нүдэндээ итгэсэнгүй. Тэнд байсан боржин чулуунууд бусадтайгаа адил дөрвөлжин биш байлаа. Бас л нэг тэмдэг бололтой. Тэр чулуу өөгүй тавалж хэлбэртэй, өнцөг нь булан руугаа харсан байх ажээ. Давхар чулуун ханан дунд огт анзаарагдахгүйгээр тэнд байгаа нарийн завсар гарц болдог байна. Ландон завсраар нь шургав. Тэр гудам руу ороод явчихлаа. Өмнө нь, нэгэн цагт энэ гудмыг түгжиж байсан модон цуурганы хэмхэрхий байна. Хонгилын цаана харин гэрэл байлаа. Ландон гүйлээ. Модон цуурган дээгүүр үсрэн, гэрэл өөд зүтгэв. Гудам удалгүй илүү нэг танхим руу хөтлөн аваачлаа. Жижиг хонгилын цаана нэлээн том өрөө байв. Ганц бамбар л тэр өрөөг гэрэлтүүлнэ. Ландон энэ том цайзын цахилгаангүй хэсэгт, магадгүй жуулчид хэзээ ч ирж байгаагүй, ирэх ч үгүй тийм хэсэгт орчихжээ. Өдрийн гэрэлд энэ өрөө аймаар харагдах байсан байх, харин шөнө, бамбарын гэрэлд их дүнсгэр үзэгдэнэ. *Il prigionie (Шорон. ума)* Элэгдэж муудсан төмөр сараалжтай арваад хорих өрөө байна. Нэг нь овоо дориун ашиглаж болохоор агаад шалан дээр хаясан улаан шаш тууз, хар дээлийг хараад, Ландоны зүрх зогсох шахав. *Кардиналуудыг энд хорьж байжээ!* Тэр торны цаана хүнд төмөр хаалга байна. Хаалга хагас онгорхой, завсраар нь урт гудам маягтай зүйл харагдана. Ландон тийшээ их л шийдмэг алхсанаа болилоо. Цус дусаасан мөр тийшээ ороогүй байв. Хаалганы тотго дээр үг сийлжээ. *Il Passeto (Хонгил)*. Энэ хонгилын тухай уншиж байсан ч үүд нь хаана байдгийг хэн ч мэддэггүй байлаа. *Il Passeto* - хонгил бол Гэгээн Ангелийн цайз, Ватикан хоёрыг холбосон хагас километр хэртэй нүхэн гарц ажээ. Ватиканыг бүсэлсэн үед зарим Пап энэ хонгилоор ийшээ зугтаж ирдэг байсан бол зарим нь нууц амрагтайгаа уулзах гэж, зарим нь олзолсон өшөөтнөө тамлах гэж үүгээр ирдэг байжээ. Харин одоо бол хонгилын хоёр талыг хоёуланг цоожилчихсон, түлхүүр нь Ватиканы аль нэг шүүгээнд байдаг гэж Ландон бодож байлаа. Иллюминатигийнхан хэрхэн Ватикан руу орж гарч байсныг мэдээд, голоор нь хүйт оргих шиг. Ватикан дотроос хэн шашнаа тэрслэн энэ түлхүүрүүдийг дайсандаа гардуулсныг гайхна. *Оливетти юу? Швейцар жардаас нэг нь үү?* Гэхдээ одоо хамаагүй болжээ. Шалан дээр туссан цус эсрэг чигтээ явжээ. Тэнд зэвэнд идэгдсэн төмөр хаалган дээр хүнд гинж тохсон харагдана. Цоожийг нь мулталчихсан, хаалга нь хагас онгорхой ажээ. Цаана нь шат хана тойрон өгссөн үзэгдэнэ. Хаалганы довжоон дээр тавалж хавган суулгажээ. Бернини өөрөө цүүц бариад энэ хавтанг хадаа юм болов уу гэж Ландон бодлоо. Хаалганы нуман тотго дээр нялх ангелийн дүрс сийлжээ. Цусан толбо шат өөд өгсөнө. Дээш өгсөхийн өмнө Ландон зэвсэг хайв. Ямар ч хамаагүй зэвсэг гартаа барих хэрэгтэй. Хайж хайж сараалж торны дөрвөн тохой урт төмөр оллоо. Нэг тал нь жад шиг хурц ажээ. Барьж явахад хүнд боловч байгаа ганц зэвсэг болгочихмоор юм нь л энэ. Гэнэдүүлж дайрвал, хассассины хөл нь шархтай байгаа болохоор дийлж болмоор санагдана. Хамгийн гол нь хоцрохгүй л байх хэрэгтэй. Шат хана даган тойрч, огцом өгсөх ажээ. Ландон дээшээгээ аль болох хурдан, гэхдээ чимээ гарах вий хэмээн чих тавин гүйлээ. Аниргүй. Дээшээ өгсөх тусам шоронгийн хаалгаар гарах гэрэл бүдгэрсээр алга болов. Тас харанхуй. Нэг гараараа хана түшин өгсөнө. Галилео дурангаар харсан бүхнээ, түүнээс ургуулан дүгнэсэн нээлтээ ярихаар яг энэ шатаар тэр дээшээ, нөхөдтэйгөө уулзахаар яарч явсан болов уу. Ландон Иллюминатигийн ноохой Ватиканы өмч, яг хажууд нь байсныг гайхаад барахгүй байв. Тэд Ватиканы өмчлөлийн газар хурдаг байжээ. Швейцар жардууд Ромыг нэгжин, бүх зоорийг

шалгаж, алдартай бүх эрдэмтдийн гэрийг ажиглаж байх зуур... Иллюминати энд... Ватиканы яг хамар дор нь уулзалдаж байх ч гэж. Ёстой төгс мэх гэдэг энэ дээ. Бернини эндхийг засварласан гол архитектор нь байсан болохоор хэнээс ч асуулгүй бүхнийг өөрийнхөө бодсоноор шинэчлэн зассан байж таарна. Хэдэн нууц орц, гарц, өрөө нэмж хийгээ бол? *Гэгээрлийн сүм.* Ландон их л ойрхон байлаа. Шат улам нарийсаж, хана хоёр талаас нь хавчих гээд байх шиг. Түүхийн сүүдэр зогсоо зайгүй түүнд ямар нэг юм шивнэнэ. Харанхуйд өмнө нь зурвас шар гэрэл тодров. Хаалганы доогуур гялтайх бамбарын тэр гэрлийг хараад Ландон хэдхэн гишгүүрийн дараа зорьсон газраа очих нь гэдгээ мэдлээ. Чимээгүйхэн урагш алхлаа. Ландон харанхуйд өгссөн болохоор өөрийгөө цайзын аль хэсэгт яваагаа мэдсэнгүй, гэхдээ орой руу нь их л ойртсон гэдгээ гадарлаж байв. Нөгөө асар том ангель одоо яг дээр нь байгаа байх даа. *Ангель минь, авран тэтгээрэй* хэмээн залбираад гартаа барьсан төмөр саваагаа урдаа бэлдээд, хаалга руу аяархан дөхөв. Витториагийн гар өвдөнө. Сэрээд гараа хүлээстэйг мэдсний дараа, суллагчаж болох байлгүй гэж бодоод, тайвширсан авч амжсангүй. Араатан эргээд иржээ. Одоо тэр цээжээ нүцгэлчхээд дээр нь зогсож байв. Алаан тулааны сорви биед нь илхэн харагдана. Хорт могойнх шиг хоёр нүд нь биеийг нь цоо ширтэх ажээ. Үйлдэх гэж байгаа булай үйлээ төсөөлж байгаа нь илт. Тэгээд, өмднийхөө тэлээг яаралгүй тайлаад, газар шидчихлээ. Витториа айдаст авган, нүдээ анилаа. Нүдээ дахин нээхэд, алуурчин том хурц хутга барьчихсан байв. Тэгээд, хацрыг нь хутгаараа алгадан, шалиг шалиг инээвхийлнэ. Бүсгүй айж мэгдсэн царайгаа хутганы гялбаанд харах шиг боллоо. Хассассин хутгаа мөрөөр нь хүүхний бүсэлхий дээгүүр гүйлгэхэд, хүйтэн төмрийн үзүүр зэвүүн байлаа. Алуурчин доогтой шалиг харцаа дальдчилгүй, хутгаа шортных нь бүсэлхий рүү огцом шургууллаа. Бүсгүй эхэр татав. Хутга өмдөн дотуур нь нааш цааш аажуухан гүйж, алгуурхан доошлох нь аймаар санагдана. Алуурчин хажууд нь хэвтэхэд, амьсгал нь чихэн дээр мэдрэгдэнэ. «Энэ хутгаар аавын чинь нүдийг ухсан юм шүү дээ!» Витториа эгшин зуур хүн алж ч чадахаар өширч байгаагаа мэдэрлээ. Хассассин хутгаа өмднөөс нь сугалж авснаа, дээш нь ногоон шарга цамцан дээгүүр нь гүйлгэж эхлэв. Тэгснээ гэнэт больсноо, толгойгоо өргөлөө. Нэг хүн өрөөнд ороод иржээ. «Наад хүүхнээсээ холд!» гэж жигшин зандрах дуу үүдний тэндээс сонсогдлоо. Хэн ингэж хэлснийг нь хараагүй боловч дуугаар нь танилаа. *Роберт! Амьд байгаа юм байна!* Алуурчны царай хувьсхийж, сүнс харсан юм шиг болчихжээ. «Ландон гуай. Чамайг ангель өөрөө хамгаалдаг байх аа» гэлээ.

Хэсэг 108

Ландон хормын зуур ариун газар ирснээ ухаарлаа. Хуучирч муудсан энэ өрөөнд байгаа дүрс бүгд л таньдаг мэддэг бэлгэдлүүд байлаа. Тавалж, пирамид, гариг эрхэс, тагтаа... *Гэгээрлийн сүм.* Энгийн, гэхдээ ариун. Хүрээд ирчихлээ. Яг өмнө нь, онгорхой тагтны наана, хассасин зогсоно. Цээж нь нүцгэн тэрээр Витториагийн хажууд байлаа. Бүсгүй хөдөлж чадахгүй авч амьд ажээ. Түүнийг хараад, Ландоны сэтгэл сая л нэг уужрав. Хормын зуур тэр хоёрын харц тулгаран - талархал, цөхрөл, гуниг -бүх догдлол хурсан харц солилцлоо. «За ингээд дахиад уулзах шив дээ» гэж хассассин хэлэв. Тэгээд, гартаа барьсан төмрийг нь хараад: «Энэ удаа чи ийм юмтай ирээ юү?» хэмээн чанга дуугаар хөхөрлөө. «Хүлээсийг нь тайл!» Хассассин хутгаа Витториагийн хоолойд тулгаад: «Би зүгээр л алчихдаг юм уу?» гэв. Энэ хүн тэгж чадна гэдгийг Ландон мэдэж байлаа. Тэгээд аль болохоор дуугаа зөөллөн өгүүлэв. «Чиний яах гэж байсныг чинь бодвол ... наад бүсгүй чинь үхэхийг илүүд үзэх биз дээ» гэлээ. Хассассин их л доромж инээвхийлээд: «Тийм шүү. Энийг зүгээр ингээд алчихвал хайран юм даа» гэлээ. Ландон урагш алхаад, зэвгэй төмөр савааныхаа хурд үзүүрийг

хассассин руу чичлэв. Гарыг нь урчих нь тэр. «Бүсгүйг явуулчих» гэлээ. Хассассин санаа алдан, мөрөө буулгахыг харвал, бууж өгч байгаа аятай. Гэнэт гараа дээшээ өргөж, Ландоны нүдний өмнө бөөн хар булчин оволзон үзэгдсэнээ, даруй хутга нисэх мэт цээж рүү нь тэмүүлэн ирж яваа үзэгдэв. Зөнгөөрөө юм уу, цөхөрсөндөө юм уу Ландоны хөл нь нугаран сөхрөхөд, хутга чихнийх нь хажуугаар салхи зүсэн өнгөрч, ард нь байгаа хананд хангинан тусах сонсогдов. Хассассин сөхөө өгсөнгүй. Гартаа төмөр саваа барин сөхөрсөн Ландонйг тохуурхсан мэт инээвхийлэн, Витториагаас холдон, Ландон руу арслан барс шиг үсэрч байх ажээ. Ландон өвдгөө өргөн, саваагаа үзүүрээр нь чиглүүлэн өргөх үед хоолойтой цамц, норсон хувцас нь хөдөлгөөнийг нь хориод байх шиг санагдлаа. Харин хагас нүцгэн хассассин гайхалтай хурдан хөдөлж, хөлийнх нь шарх огт байхгүй мэт хөдөлгөөнийг нь огтхон ч удаашруулсангүй. Энэ хүн өвчин дааж сурсан хүн ажээ. Амьдралдаа анх удаа Ландон буутай ч байсан болоосой гэж бодов. Хассассин Ландоныг аажуухан тойрч, хутга руугаа дөхөх гэсэн боловч Ландон саваагаа чичлэн хорив. Тэгтэл, тэр буцаад Витториа руу хөдлөх гэлээ, Ландон дахиад л саваагаа чичлэн болиулав. «Цаг байна шүү» гэж Ландон хэлээд: «Канистер хаана байгааг хэлчих. Ватикан Иллюминатигаас ч илүүг төлөх байх шүү» гэлээ. «Чи ямар гэнэн тэнэг юм бэ?» Ландон жадаа чичилнэ. Хассассин бултана. Ландон бандан сандал дагуулан, төмөр саваагаа урдаа барин чичилж, алуурчныг зууван өрөөний буланд шахах санаатай залж байв. *Өө, энэ чинь нэг ч булангүй өрөө байна шүү дээ.* Жигтэй нь, хассассин түүн рүү довголсон ч үгүй, зугатсан ч үгүй, хөлөө сэлгэн, хөнгөн хөнгөн үсчиж, хөдөлгөөнийг нь гярхай ажин байв. Ландоноор тоглоод ч байгаа юм шиг. Хүйтэн хүлээцтэй байлаа. Юугаа хүлээгээ юм болоо? Алуурчин дороо эргэлдэн, биеэ үсчин, займчина. Яах гээд байгааг нь ойлгоно гэдэг ёстой л шатар тоглож байгаа юм шиг байлаа. Гартаа барьсан саваа нь хүнд болж ирэхэд, Ландон хассассин юу хүлээгээд байгааг нь гэнэт мэдлээ. *Намайг л цуцаах гээд байгаа вий.* Гэхдээ, нээрэн цуцаж байлаа. Гар хөл нь бадайрч, адреналин түүнийг босоогоор нь барьж дийлэхгүй шинжтэй болж байв. Хөдлөхгүй бол болохоо байлаа. Хассассин бодлыг нь уншсан мэт зүгээ өөрчлөн хөдлөв. Өрөөний голд байгаа ширээ рүү түүнийг аваачих гээд байгаа мэт санагдана. Ширээн дээр бамбарын гэрэлт гялтганасан нэг юм байлаа. *Буу юм болов уу?* Ландон хассассин руу ширтсээр, ширээ рүү аажуухан ойртов. Хассассиныг ухасхийх эгшинд Ландон ширээ рүү хяламхийгээд, дагуулаад байсан өгөөш рүү нь орчихгүйг хичээлээ. Гэхдээ л, сониуч зан нь өгөөш рүү татагдчихлаа. Ширээ рүү харав. Тэнд ямар ч зэвсэг байсангүй. Гэхдээ, тэнд байсан юмыг анзаарахгүй байж чадсангүй. Ширээн дээр зэвэнд идэгдсэн тавалж хэлбэртэй төмөр хайрцаг байлаа. Тагийг нь хажууд нь түшүүлж тавьжээ. Дотуур нь тусгаарласан таван хоногт таван тэмдэг байлаа. Бүгд төмөр, иш нь мод байв. Юун тэмдэг болохыг нь Ландон асуултгүй мэдэж байлаа. Шороо, Хий, Гал, Ус. Хассассин дайрах вий гэсэндээ, Ландон арагш татвагахийн ухрав. Тэр тэгсэнгүй, харин ч Ландонд тэмдгүүдийг үзүүлсэндээ баярласан мэт байлаа. Ландон нүдээ дайсан дээрээ онилон, урагшаа цээж рүү нь дүрэхээр зэхэж байв. Гэхдээ л нөгөө хайрцаг санаанаас нь гардаггүй. Хэдийгээр тэмдгүүд нууцлаг - зарим иллюминатигийнхан ийм юм байдаг гэдгийг гадарладаг ч үгүй байсан ч гэсэн - Ландон тэр хайрцагт өөр нэг нууцлаг юм байх шиг санагдаад байлаа. Хассассин хөлөө сэлгэн үсчих зуур, Ландон дахиад нэг хяламхийгээд авав. *Бурхан минь!* Хайрцагт таван тэмдэг хайрцгийн захаар байрлуулсан тавуулаа хоногтоо байлаа. Голд нь бас нэг хоног байх ажээ. Тэр нь хоосон байсан ч гэсэн бүр ч том өөр ямар нэгэн, дөрвөлжин тэмдэгт зориулсан нь мэдээжийн харагдаж байлаа. Хассассин цахилгаан цахих шиг гялсхийн дайрлаа. Олз руугаа шумбах бүргэд шиг л хассассин нисэн ирлээ. Ландоны анхаарал нь сарнин, ухаарч амжаагүй байтал, бүрхээд ирлээ. Хамгаалах гэдэг

хэтэрхий оройтжээ. Саваагаа өргөх гэж оролдсон ч, хассассин хоёр гараараа савааг аль хэдийн зуурчихсан байлаа. Гар нь урагдсан ч гэсэн атгалт нь аймшигтай чанга ажээ. Хоёр эр алалдан тэмцэж эхлэв. Ландоны гарт байсан саваа гулсан мултарч, алга нь шазран өвдсөөр хоцорно. Хором хүрэхгүйн дараа савааных нь хурц үзүүр өөдөөс нь чиглэн ирэх нь тэр. Анчин өөрөө ан болжээ. Ландон хүнд юманд цохиулан салбайн унав. Хассассин мушилзан тойрч, Ландоны ард нь гарч хананд тулгалаа. «Америкаар «төгсгөл» гэдгийг юу гэх вэ?» Ландон төвлөрч чадахгүй байв. Хассассин дайрах үед нь өөр юм хараад, ангайж байснаа бодон өөрийгөө зүхнэ. Юу ч ойлгогдохгүй байв. *Иллюминатигийн зургаа дахь тэмдэг?* «Зургаа дахь тэмдгийн тухай би юу ч уншаагүй дээ» хэмээн өөрийгөө зүхэх зуур бодон бувгнана. «Уншаа байлгүй дээ» гэж хассассин хөхрөн, Ландоныг дугуй хана дагуулан хөөж байлаа. Ландон төөрөлдөж орхилоо. Харин алуурчин үгүй бололтой. Уул нь Иллюминати таван тэмдэгтэй. Тэр нуруугаараа хана налаад, гартаа барьчихмаар зэвсэг хайж байлаа. «Эртний махбодуудын төгс нэгдэл» гэж хассассин хэлээд: «Сүүлийн тэмдэг нь хамгийн гайхалтай шүү. Даан ч чи тэрийг харж амжихгүй байх л даа» гэв. Ландон одоогоор юм харахтай манатай байлаа. Нуруугаараа хана руу хараад, өрөөн дотор хэрэг болчихмоор юм хайна. «Чи тэгээд тэр сүүлийнх нь тэмдгийг харсан юм уу?» гэж цаг хожих санаатай асуув. «Нэг л өдөр тэд намайг үнэлж шагнана даа. Би ч өөрийгөө харуулна» . Хассассин түүн рүү жадаа чичлэн, их л зугаатай байлаа. Ландон хана налав. Хассассин түүнийг хаа нэг булан руу аваачих гээд байгаа юм шиг санагдана. *Хаашаа тэр вэ?* Ландон ар тал руугаа эргэж харж чадахгүй байв. «Тэр тэмдэг чинь тэгээд хаана байгаа юм бэ?» «Энд л лав биш. Януст л ганцааранд нь байдаг юм». «Янус гэнэ ээ?» хэмээн Ландон асуув. Огт сонсож байгаагүй нэр байлаа. «Иллюминатигийн удирдагч. Удахгүй наашаа ирнэ гэсэн». «Иллюминатигийн удирдагч нь наашаа ирж яваа юм уу?» «Яах вэ хамгийн сүүлийн тэмдгийг дарж тамгалахгүй юу». Ландон зарсхийн, Витториа руу харлаа. Бүсгүй гайхалтай амгалан... дэлхий ертөнцийг үл тоомсорлон нүдээ аниад ... уушги нь зөөлөн зөөлөн гүн амьсгална. Энэ бүсгүй хамгийн сүүлийн хохирогч нь гэж үү? Ингэхэд тэр нь тэр гэж үү? Хассассин Ландоны нүдийг хараад, юу бодсоныг нь гадарлав бололтой. «Та хоёр тэрний дэргэд юу ч биш. Чи одоо ингээд талийж одно, мэдээж. Харин миний яриад байгаа тэр сүүлийн хохирогч бол хамгийн аюултай дайсан маань юм шүү дээ» гэлээ. Ландон хассассины ярьсныг ухаарах гэж оролдоно. Хамгийн аюултай дайсан гэнэ ээ? Хамгийн чухал кардиналууд аль хэдийн талийж одсон. Пап өнгөрчихсөн. Иллюминати бүгдийг нь цааш нь харуулчихсан шүү дээ. Ландон хассассины доогтой зэвүүн нүднээс хараад сая л ухаарав. *Камерлинго*. Вентреска камерлинго энэ бүх үймээн дунд, энэ дэлхийн бүх хүний ганц найдлага болсон хүн байлаа. Хэдэн арван жилийн турш сэрдэх онолчдын хийснээс илүүгээр энэ шөнө камерлинго Иллюминатигийг ялласан ажээ. Хийсэн хэргийнхээ төлөөсийг, хөөрхий камерлинго төлөх хэрэгтэй боллоо. Сүүлчийн бай. «Чи түүнд хүрч чадахгүй шүү дээ» гэж Ландон өднө. «Би очихгүй ээ» гэж хассассин Ландоныг булан руу улам шахангаа: «Тийм нэр хүндтэй ажлыг Янус л өөрөө хийнэ шүү дээ» гэв. «Иллюминатигийн удирдагч нь өөрөө очиж камерлингог тамгалах гэж үү?» «Эрх мэдэлд чинь бас ямба гэж бий». «Гэхдээ одоо бол хэн ч Ватикан хийд руу орж чадахгүй байх аа». Хассассин хөмсгөө өргөн инээвхийлээд: «Мэдээж хэрэг. Гэхдээ уулзалт товлосон бол ч өөр хэрэг шүү» гэлээ. Ландон гайхширсаар. Ватиканы хүлээж байгаа цорын ганц хүн бол хэвлэлийнхний 11 цагийн Самари хүн гээд байгаа, Рошерийн хэлснээр шашныг аврах мэдээлэл бүхий тэр ... Ландон таг мэлрэв. *Ээ, бурхан минь*. Ландон цочирдохыг хараад, хассассин их л баясан: «Янус яаж Ватикан руу нэвтрэх юм бол гэж би ч гэсэн гайхаж байсан юм. Тэгээд, би мухлаг тэргээ жолоодоод явж байгаад, радиогоор - 11 цагийн Самари хүний

тухай сонссон» гэснээ додигонон инээмсэглээд: «Ватикан Янусыг алгаа дэлгэн угтана даа» гэлээ. Ландон савж унахаа шахав. Тэр Самар хүн чинь тэгээд Янус болж таарав уу? Хүний санаанд оромгүй хуурмаг явдал гэж энэ дээ. Иллюминатигийн удирдагчийг Швейцар жард шадарлан, шууд л камерлингогийн өрөө рүү аваачих нь байна шүү дээ. Гэхдээ, *Иллюминатигийн удирдагч Рошерийг хэрхэн дөнгөө юм бол? Эсвэл Рошер үүнд хамаатай юм болов уу?* Нуруугаар нь хүйт даав. Архивд түгжигдсэнээс хойш, Ландон Рошерт огт итгэж өгөхгүй байлаа. Хассассин гэнэт чичиж, Ландоны мөрийг сүлбэж орхив. Ландон гэдрэгээ саван, уурандаа: «Янус тэндээсээ амьд гарч чадахгүй шүү дээ» гэлээ. Хассассин мөрөө хавчаад: «Зарим үйлийн төлөө амь хайрангүй шүү дээ» гэв. Хассассин үнэн хэлж байгаа бололтой. Янус амь золин тийшээ очиж байгаа ажээ. Эгшин зуур, Ландон Иллюминатигийн хорлонт ажиллагааны бүрэн учгийг тайллаа. Папыг цааш нь харуулсны дараа, оронд нь гарч ирсэн тэр дорой гэлэн харин ч хүчтэй дайсан болон хувирчээ. Тиймээс сүүлийн мөчид түүнийг устгахаас өөр аргагүй болсон нь энэ аж. Ландоны тулж байсан хана гэнэт алга болчхов. Араас нь голын жихүүн салхи үлээж, харанхуй шөнө дүнсийнэ. Тагт! Хассассин юу бодож байсныг мань хүн одоо л ухаарлаа. Ландон ард зуун тохой өндөр хана баганадаж байгааг мэдэрч байлаа. Наашаа ирж явахдаа, тэр нүдээрээ харсан билээ. Хассассин ч цаг алдалгүй дайрав. Жад цээжийг нь онилон ирлээ. Арай гэж арагшаа ухарч, жадны үзүүр цамцыг нь сэглээд өнгөрөв. Жад дахин цээжийг нь онилон ирэв. Арагш ухрах гэсэн боловч ард нь тагтны хашлага тулахыг мэдрэв. Дараагийн удаа жадлахад, би үхнэ дээ гэж Ландон бодож амжлаа. Гэхдээ цээжээрээ хажуулдасхийн эргээд, гараараа төмөр савааг шүүрч авахад, алга нь тэсвэрлэшгүй их өвдөн шаналав. Хассассин сэхээ өгөлгүй чичилнэ. Тэр хоёр хүч тэнцэн, нүүр нүүрээ тулан хэсэг дэнжгэнэхэд алуурчны амьсгаа Ландоны нүүр рүү үлээж байлаа. Саваа мултарч эхэллээ. Хассассин хэтэрхий хүчтэй байв. Аргаа барахдаа, Ландон тэнцвэрээ алдан байж, хөлөө жийн алуурчны шархтай хөлийг өшиглөх гэж оролдов. Гэхдээ, алуурчин, аргагүй мэргэжлийн хүн тулдаа, эмзэг газраа хамгаалж дөнгөв. Ландон сүүлийнхээ мэхийг хийчихлээ. Төмөр савааг гараараа тогтоон барьж дийлэхээ болив. Хассассин дахин хүчтэй дугтран, Ландоныг арагш нь хашлага руу түлхэв. Ард нь бүсэлхийнийх нь дор юу ч үгүй хоосон агаар л мэдрэгдэж, нуруугаар нь зарсхийн, хүйт даав. Хассассин төмөр саваагаараа Ландоны цээжин дээр нь дарж, арагш нь дугтран түлхэнэ. Ландон нуруугаараа хашлага дээр нумран тогтох гэж оролдох. Ma'assalamah хэмээн хассассин хамраараа гуншина. Үүрд баяртай. Хассассин улангассан харцаа салгалгүй, сүүлийн удаа дугтран түлхлээ. Ландоны хүндийн төв нь шилжиж, хөл нь шалнаас хөндийрөөд явчхав. Ганц найдлага бий. Унахдаа, Ландон гараараа тагтны доод ирмэгээс зуурлаа. Зүүн гар нь гулсаж мултраад, харин баруун гар нь тогтов. Ландон нэг гараараа тагтны доод ирмэгээс зуурчихсан, хоёр хөл нь хашлага арай давалгүй толгойгоороо доошоо харчихсан дүүжигнэнэ. Хассассин түүний дээрээс төмөр саваагаа далайн нэг мөсөн зүйл дуусгахаар зэхнэ. Саваагаа дээшээ өргөх агшинд, Ландон гайхмаар зүйл харлаа. Үхлийн өмнөх зэрэглээ юм уу, эсвэл зүгээр л айдас байв уу, Хассассиныг тойрон гэгээ цацрах шиг боллоо. Араас нь юу ч үгүй хоосноос гал бадамлах шиг боллоо. Далайсан төмрөө алдан, хассассин өр өмөртөл дуу тавин ориллоо. Төмөр саваа Ландон нүүрийг нь шүргэн, харанхуй руу унан шингэв. Хассассин эргэж харахад, нуруунд нь гал дүрэлзэн байхыг харлаа. Ландон биеэ татан хашлага дээгүүр харвал, Витториа хорсол дүүрэн нүдээ жартайлган, хассассиныг хэрж зогссон байлаа. Витториа урдаа бамбар барьчихсан зангаж, нүүрэнд нь шийдэмгий байдал тодрох нь галын дөлөнд хослон үзэгдэнэ. Тэр яаж хүлээснээсээ мултарсныг Ландон ухаарсангүй, анзаарсан ч үгүй, хашлага дээгүүрээ буцаад, давж орох гэж сарвалзана. Тэмцэлдээд удсангүй. Хассассин орь дуу тавин, бүсгүй рүү

дайрлаа. Витториа бултах гэж оролдсон ч чадсангүй, алуурчин бамбарыг нь барьчихсан булаах гэж ноцолдоно. Ландон хашлага давангуутаа, урагш давшиж гараа атган, алуурчны түлэгдсэн нуруу руу байдаг чадлаараа буулгав. Орь дуу тавих нь Ватиканд хүртэл сонсогдохоор ажээ. Нуруу нь өвдсөндөө, хассассин хөдөлж чадалгүй, бамбараа Витториад алдмагц, бүсгүй бамбараа дахин далайж: «Нүдийг нүдээр» хэмээн хашхирч, нүүр рүү нь цоргив. Нүүрнийх нь арьс шархийн түлэгдэж, зовхи нь атираад явчихлаа. Үхэж байгаа юм шиг дахин нэг хашхирч, гараараа нүүрээ дарлаа. «Амийг амиар» гэж Витториа дахин хашхираад, бамбараа бэйсболын цохиур шиг бариад, тас хийтэл цохиход, хассассин савж унахдаа, тагтны хашлага руу ойчив. Энэ эгшинд Ландон, Витториа хоёр зэрэг очиж хамаг хүчээрээ хассассиныг түлхлээ. Хассассин хашлага даван ойчиж, шөнийн харанхуй руу нисэн одов. Ямар ч орь дуу тавих чимээ сонсогдсонгүй. Харин тэртээ доор хураасан их бууны чулуун бөмбөгөн сум дээр далавчаа дэлгэсэн элээ шиг ойчих тэр эгшинд нуруу нь хугарах битүү чимээ гарлаа. Ландон Витториа руу галзуу хүн шиг цоо ширтэнэ. Бүсгүйн бие, мөрөн дээгүүр нь олсны тасархай харагдана. Нүд нь гал шиг дүрэлзэнэ. «Хүдини* ёог мэддэг байсан юм шүү дээ» гэв.

Хэсэг109

Энэ үеэр Гэгээн Петерийн талбай дээр Швейцар жард эгнэн жагсаад, захирагчийнхаа тушаалаар нэгэн зэрэг ярсхийтэл урагшлан, цугласан олныг аюулгүй зайд түлхэн гаргахаар шахаж байв. Шавсан олон өөрийнхөө аюулгүй байдалд зовнихоосоо илүү Ватиканд болж байгаа явдлыг шохоорхох ажээ. Талбайд босгосон том том дэлгэцүүд камерлингогийн зөвшөөрсний дагуу антимаатерийн цаг урвуу тоолж байгаа дүрсийг Швейцар жардын хяналтын камераас шууд дамжуулна. Харамсалтай нь урвуу тоолж байгаа тэр дэлгэц хүмүүст болгоомжлол төрүүлж чадахгүй байв. Тэд дэлгэц дээр канистер дотор агаарт дүүжигнэн байгаа жижиг дуслыг ширтэж, санаснаас аймаар биш харагдахыг гайхна. Урвуу тоолох цаг дөчин тав хүрэхгүй минутын дараа дэлбэрэх гэж байгааг харуулна. Хараад ажиглан суух хангалттай их цаг байлаа. Швейцар жард - камерлинго дэлхий нийтэд хандан үнэнийг илчилснийг, мөн Иллюминатигийн энэ заналыг хэвлэлийнхнээр дамжуулан нийтэд үзүүлж байгааг зөв гэж дуу нэгтэй зөвшөөрч байлаа. Иллюминати Ватиканыг дайсныхаа өмнө чимээгүй, гөлийсөн зангаараа байх вий хэмээн хүлээж байсан нь тодорхой. Гэтэл тэгсэнгүй. Карло Вентреска камерлинго шаггүй дайсан гэдгээ харууллаа. Систин цогчин дотор Мортати кардинал түгшин байна. 11:15 болж байлаа. Зарим кардинал залбирал уншин, зарим нь цаг дөхөж байгааг мэдсэн бололтой гарах гарц хайн сэлгүүцнэ. Зарим нь бүр хаалга балбаж байлаа. Гадна талд нь Шартрон дэслэгч хаалга нүдэх чимээг сонсох авч юу хийхээ мэдэхгүй алмайна. Цагаа харав. Рошер занги тушаал өгөхөөс нааш кардиналуудыг тэндээс гаргаж болохгүй гэж хатуу тушаасан билээ. Хаалга улам чанга нүдэж, тэгэх тусам Шартрон улам л тэвдэнэ. Занги мартчихсан юм биш биз дээ. Утсаар ярьснаасаа хойш, занги нэг л жигтэй аашлах болжээ. Шартрон гар холбоогоо сугалан: «Занги аа? Шартрон ярьж байна. Цаг болчхоод, өнгөрч байх юм. Систин цогчныг онгойлгох уу?» гэв. «Цогчныг хаалттай байлгаж бай. Би чамд тэгж тушаасан биз дээ». «Тийм ээ, эрхэм ээ. Би зүгээр л ...» «Зочин удахгүй ирнэ. Хэдэн хүн аваад дээшээ гарч, Папын өргөөний үүдийг хамгаал. Камерлингог гадагш нь гаргаж болохгүй шүү!» «Өршөөгөөрэй, эрхэм ээ?» «Та юу ойлгосонгүй вэ, дэслэгч ээ?» «Зүгээр ээ, эрхэм ээ. Гүйцэтгэе!» Папын өргөөнд камерлинго задгай гал ширтэн бясалгана.

Надад чадал хайрла, бурхан минь! Гайхамшигт шидийг үзүүлээч. Тэгээд, гал дотроос юм ухан, энэ шөнө амьд үлдэж чадах болов уу хэмээн гайхна.

Хэсэг 110

Арван нэгэн цаг хорин гурван минут. Витториа Гэгээн Ангелийн цайзын тагт дээр зогсон, Ром дээгүүр ширтэж, нүдэнд нь нулимс цэлэлзэнэ. Роберт Ландонд тэврүүлмээр санагдавч чадсангүй, хамаг бие нь хөдөлж ч чадахгүй, хөшчихсөн байлаа. Аавыг нь хөнөөсөн этгээд тэртээ дор үхдэл болоод хэвтэж байлаа, гэхдээ өөрөө бас хохирогч болох шахлаа. Ландоны гар мөрөнд нь хүрэх үеэс, дулаахан амьсгал нь сэтгэлд байсан хүйтэн мөсөн цамхгийг эгшин зуур хайлуулан урсгах шиг санагдав. Халуун сэтгэл нь таатай нөмөрлөж, амин урсгал царцсан биеийг дулаацуулан эргэлдэж эхлэв. Нүднийх нь бүрэлзээ арилж, эргэж харлаа. Роберт байдгаараа нороод шолбойчихсон, өөрийг нь аврахын тулд бишгүй зовлон үзсэн шинжтэй, үхэх гэж байгаа юм шиг харагдаж байлаа. «Баярлалаа, чамд ...» хэмээн шивнэв. Ландон ядрангуй инээвхийлээд, чамд л ёстой талархах ёстой шүү хэмээн хариуллаа. Мөрөө мултлах чадвар нь хоёуланг нь аварчээ. Витториа нүдээ арчив. Бүсгүй түүнтэй хамт, яг тэндээ мөнх зогссон ч чадах байлаа. Даан ч амсхийх зав алга. «Хоёулаа явах хэрэгтэй» гэж Ландон хэлэв. Витториагийн санаа сэтгэл хаа хол байлаа. Тэр Ватикан руу ширтэнэ. Дэлхийн хамгийн жижиг улс хэтэрхий гэмээр ойрхон, хэвлэлийнхний гэрэлд цайран харагдана. Гайхалтай нь, Гэгээн Петерийн талбай дээр хүн пиг шавчихсан байлаа. Швейцар жард яг ордны өмнөх талбайд дөнгөж зуун тавь гаруйхан тохой газар -бүх талбайн гуравны нэг хүрэхгүй газраас л хүмүүсийг холдуулжээ. Аюулгүй гэгдэх газар нь бүр ч олон хүн шавж, дотор талдаа байгаа хүмүүсийг түгжиж орхино. *Хэтэрхий ойрхон байлаа. Бүр хэтэрхий ойрхон.* «Би буцаад очлоо» гэж Ландон хэлэв. Витториа эргэж хараад: «Ватикан руу юу?» гэв. Ландон Самар хүний тухай түүнд хэлж, ямар башир арга сэдэж байгааг ч бас ярив. Өөрийгөө Янус гэж нэрлэсэн Иллюминатигийн тэргүүн камерлингог тамгалахаар биеэрээ ирж явав. Иллюминатигийн сүүлийн эгшин. «Ватиканд хэн ч энийг мэдээгүй байгаа. Тийшээ холбогдох ямар ч арга байдаггүй, гэтэл тэр нөхөр хэзээ хэзээгүй ирэх гэж байна. Тэрийг орж ирэхээс нь өмнө, харуулуудад хэл хүргэх хэрэгтэй байна» гэж Ландон өгүүлэв. «Чи энэ хүмүүсийн дундуур гарч чадахгүй шүү дээ». Ландоны хоолой итгэл төгс сонсогдоно. «Гарц бий. Итгэж болно шүү». Энэ түүхч гуай мэдэхгүй зүйлийг нь мэдэж байгаа юм байна гэдгийг Витториа ойлголоо. «Хамт явъя». «Хэрэггүй. Хоёул хоёулаа эрсдэл рүү ...» «Тэнд байгаа хүмүүсийг холдуулах арга бодох хэрэгтэй шүү дээ. Хэтэрхий аюултай газар байна». Гэнэт зогсож байсан тагт нь чичирхийлж эхлэв. Чих дөжиртөл дүнгэнэн, цайз тэр чигтээ савлан ганхах шиг боллоо. Гэгээн Петерийн ордны зүгээс хурц цагаан гэрэл гялсхийн цацрав. Витториад ганц л бодол төрлөө. *Бурхан минь! Антиматери цагаасаа өмнө дэлбэрчихлээ.* Гэтэл, дэлбэрэлтийн оронд талбай дээрх хүмүүс бүтд баясан уухайлав. Витториа гэрэл рүү харлаа. Талбай дээр байсан хэвлэлийнхний бүх гэрэл тэр хоёр руу чиглэнэ. Тэнд байгаа бүх хүн тэр хоёр руу харан, гараараа даллан байв. Чичирхийлсэн дуу улам чангарна. Талбай дээрх хүмүүс их л баясацгаах ажээ. Ландон гайхан: «Юун чөтгөр нь ...» Толгой дээгүүр нь гэнэт чих дүлийртэл дүнгэнэв. Цамхгийн дээгүүр Папын нисдэг тэрэг дүнгэнэн гарч ирлээ. Тэр хоёрын толгой дээгүүр, тавин тохой өндөрт, Ватикан хийд рүү гэрэл даган ниснэ. Нисдэг тэрэг яг дээгүүр нь өнгөрөх эгшинд, цайз тэр чигтээ дэнжигнэн чичирлээ. Талбай дахь гэрлүүд нисдэг тэргийг даган одоход, Ландон, Витториа хоёр дахиад л харанхуйд үлдэв. Гэгээн Петерийн талбай дээгүүр дүнгэнэн нисэхийг хараад, Витториа хоцорчхов уу даа хэмээн гэнэт айдаст автав. Багширсан олон, ордон хоёрын зайд баахан тоос бужигнуулан, нисдэг тэрэг ордны

өмнөх шатны доод ирмэгт буулаа. «Тэр гарц чинь хаана байдаг юм бэ?» гэж Витториа асуув. Ватиканаас хүний жижиг дүрс гарч ирээд, нисдэг тэрэг рүү дөхөж ирэв. Тэр хүний улаан бэрэт малгайг хараагүй бол Витториа танихааргүй байлаа. «Улаан хивсний мэндчилгээ. Рошер байна» гэв. Ландон нударга зангидан, тагтны хашлага руу шаагаад: «Тэднийг сануулах хэрэгтэй» гээд эргэлээ. Витториа гарыг нь татан саатуулав. «Байз даа!» Бүсгүй нүдэндээ итгэхгүй байлаа. Хуруу нь чичрэн, нисдэг тэрэг рүү заана. Хэчнээн хол байсан ч танигдахаар байлаа. Хаалга бууж өөр нэг хүн үзэгдсэн нь андуурах аргагүй ажээ. Тэр хүн суугаа байсан ч талбай дээгүүр ямар ч саадгүй, хурдан гэгч сүнгэнэн одов. Цахим тэргэнцэртэй хаан. Максимлиан Колэр!

Хэсэг 111

Бэлведэрагийн гудмын тансаг чимэглэлийг Колэр гайхан явна. Тэртээ унжиж байгаа алтан навч л гэхэд хорт хавдар анагаах судалгааг нэлээн хэдэн жил санхүүжүүлж чадах ажээ. Доголон хүнд зориулсан тойрог замаар Рошер - Колэрыг дагуулан, Апостоль асар рүү явлаа. «Цахилгаан шат байхгүй юм уу?» гэж Колэр асуув. «Цахилгааныг нь тасалчихсан юм» гэж Рошер хариулаад, харанхуй өргөөн дэх лааг заалаа. «Манай эрлийн тактикийн нэг хэсэг» гэв. «Тэр тактик чинь ч бүтсэнгүй дээ» гэлээ. Рошер толгой дохино. Колэр дахин нэг удаа бүгшин ханиав. Энэ насных нь сүүлчийн ханиалга ч байж магадгүй. Гэхдээ тийм ч эвгүй бодол санагдсангүй. Тэд хамгийн дээд давхарт гараад, Папын өргөө чиглэн явах үед, өөдөөс нь дөрвөн харуул гарч ирээд, мэгдэн харцгаана. «Занги аа. Та энд юу хийж байгаа юм бэ? Энэ хүнд байгаа мэдээлэл» «Энэ хүн зөвхөн камерлинготой л ярьна». Харуул гайхширч, сэжиглэнгүй харлаа. «СЭРН-ийн захирал Максимлиан Колэр гэж хүн ирээд, уулзая гэж байна гэж камерлингод дуулга» гэж Рошер шаардангуй тушаалаа. «Мэдлээ, эрхэм ээ!» Нэг харуул камерлингогийн өргөө рүү гүйв. Бусад нь байрандаа үлдээд Рошерийг сэжиглэнгүй ажна. «Түр хүлээнэ үү, занги аа. Таны зочинд мэдэгдэнэ ээ». Колэр зогссонгүй. Гэнэт огцом эргээд, тэргэнцрээ жолоодон, харуулын хажуугаар гарах гэж оролдов. Харуулууд дагаж эргээд, түүнийг даган гүйв. «Fermati! Эрхэм ээ! Зогс!» Колэр тэднийг төвөгшөөв. Дэлхийн хамгийн шилмэл аюулгүйн хүчин хүртэл энэ тахир дутуу хүнийг хөндөлдөж чадахгүй байлаа. Колэр эрүүл хүн байсан бол харуулууд түүнийг нухаад хаячих байв. *Тахир дутуу хүмүүс чадалгүй гэж эд боддог юм, тэгж бодож байвал надад л сайн биз.* Колэр, ажлаа дуусгахад нь хэтэрхий бага хугацаа үлдээд байгааг мэдэж байлаа. Энэ шөнө энд үхэж магадгүйгээ ч мэдэж байлаа. Тэр ямар анзааргагүй байснаа өөрөө ч гайхаж байв. Үхэл гэдэг үүнийхээ төлөө төлж болох л үнэ ажээ. Вентреска камерлинго мэтээр хийсэн ажлаа устгуулья гэхэд харамсмаар ихийг бүтээжээ. «Эрхэм ээ!» гэж харуулууд хашхиралдан гүйцэж ирмэгцээ, өмнүүр нь хөндөлдөн жагсаад: «Та зогс!» гэлээ. Нэг нь бугаа шүүрэн, Колэр рүү онилов. Колэр зогслоо. Рошер араас нь гүйцэж ирээд: «Колэр гуай, та тогтож айлд. Хэдхэн л хором болох байх. Папын өргөөнд хэн ч дайрч орж болдоггүй юм» гэлээ. Колэр Рошерийн харцаас хүлээхээс өөр арга үгүй юм байна гэдгийг ухаарлаа. За, за, хүлээхээс дээ. Хана дүүрэн урт гэгч толины өмнө ширүүн дүртэй харуулууд Колэрийг зогсоожээ. Өөрийнх нь толинд сарнисан дүрс түүнийг цочоов. Эртний хонзон санагдан оргилно. Энэ хонзон түүнд эрч хүч өгнө. Тэр дайснуудынхаа дунд байлаа. Энэ хүмүүс нэр төрийг нь дээрэмдсэн. Энэ л хүмүүс шүү дээ. Энэ хүмүүсийн л гайгаар эм хүний амтыг тэр хэзээ ч үзээгүй, дурыг нь татахаар өндөр зогсож үзсэнгүй. *Ямар үнэнийг эд мэддэг гэж? Ямар нотолгоо тэрэнд нь байгаа юм бэ? Үлгэр дүүрэн хуучны ном л биз. Ид шид эргэж ирнэ гэж ярьдаг билүү? Гэтэл эрдмийн шимээр ид шидийг өдөр бүр бүтээж байна шүү дээ.* Колэр хэсэг өөрийнхөө хүйтэн нүд рүү

ширтлээ. *Шашны гарт өнөө шөнө үхэж магадгүй л юм* хэмээн бодолхийлнэ. *Гэхдээ ямар эхний удаа нь ч энэ биш дээ.* Колэр хүүхэд насныхаа хамгийн хүнд үе рүү хэсэг зуур уусан одов. Франкфурт дахь том байшиндаа арван нэгтэй жаал хүү өвчиндөө шаналан хэвтэж, эцэг эх хоёр нь хажууд нь сууна. Дэвсгэр даавуу нь Европын хамгийн шилдэг бүтээгдэхүүн боловч хүүгийн хөлсөн дэвтжээ. Өвчин Макс хүүгийн биеийг галаар төөнөж байгаа мэт хэмлэнэ. Хүүгийн орны хажууд, аав ээж хоёр нь яг хоёр дахь хоногтоо хөдлөлгүй, сөхрөн суужээ. Тэр хоёр бурханд мөргөж байлаа. Франкфуртын хамгийн сайн гэх гурван эмч сүүдэрт сүүмэлзэнэ. «Дахин бодож үзээч, та хоёр!» гэж нэг нь тэсэлгүй зандран: «Хүүгээ хараач! Халуун нь нэмэгдээд байна. Өвдөж шаналж байна. Үхэх нь байна шүү дээ!» гэв. Ээж нь дуугарахаас өмнө юу гэж хэлэхийг нь Макс хүү гадарлаж байлаа. «Gott wird ihn beschuetzen (Бурхан түүнийг минь хамгаална. Гер.)». *Тийм ээ. Бурхан намайг хамгаална* хэмээн Макс бодно. Ээжийнх нь үг улам ч бат нот сонсогдоно. *Бурхан намайг хамгаална.* Цагийн дараа, Макс хүүгийн бие хүнд даацын машинд дайруулчихсан юм шиг үе мөч болгоноороо шархирч өвдлөө. Уйлж ч чадахгүй, амьсгалж ч чадахгүй байв. «Хүү чинь шаналж байна шүү дээ» гэж өөр нэг эмч үглэн: «Ядаж өвдөлтийг нь намжаая л даа. Надад тариа байна, ганц л удаа...» гэтэл «Ruhe, bitte! (Чимээгүй бай, гуйя. Гер.)» хэмээн аав нь нүдээ ч нээлгүй хэлэн тэр эмчийн үгийг таслав. Тэгээд мөргөлөө үргэлжлүүлнэ. «Аав аа, гуйя л даа» гэж Макс уйлан: «Эмч энэ өвдөлтийг л дараад өгчхөг л дөө» гэж гуймаар санагдсан ч ханиалга нь тэр үгийг амнаас нь унагасангүй. Цагийн дараа өвдөлт бүр нэмэгдлээ. «Хүү чинь тахир дутуу ч болж магадгүй» гэж нэг эмч хэлээд «Эсвэл үхэж ч магадгүй. Эм өгвөл нэмэр болно шүү дээ» гэж эмч нарын нэг нь бувгнав. Колэрын аав ээж хоёр зөвшөөрсөнгүй. Тэд эмнэлэгт итгэдэггүй байлаа. Эмч гэдэг бурхны төлөвлөгөөг тасалдуулах хэн юм бэ? Тэд улам хичээн мөргөнө. Бурхан энэ хүүг тэдэнд хайрласан мөртөө яалаа гэж буцаагаад аваад явах билээ дээ. Ээж нь Максыг хүчтэй байгаарай гэж захиана. Авраамын итгэлийг бурхан шалгасан тухай Библьд бичсэн байдаг шүү дээ, яг л тэрэн шиг чамайг бас шалгаж байгаа юм шүү гэнэ. Макс сүсэгтэй байх гэж хичээсэн ч бие нь тэсэхийн аргагүй өвдөж байлаа. «Би ингэж байж чадахгүй нь» хэмээн нэг эмч нь хэлээд, өрөөнөөс гарч гүйлээ. Үүр гэгээрэхийн үед, Макс ухаангүй шахуу байлаа. Булчин шөрмөс нэг бүр нь задрах мэт өвдөнө. *Намайг ингэж зовж байхад, Есүс хаана байна вэ? Есүс надад хайргүй юм болов уу?* хэмээн хүү бодно. Ээж нь гараа хүүгийнхээ хөнжил дээр тавиад, суугаагаараа дугхийчихжээ. Аав нь өрөөний цаана цонхоор тусах үүрийн гэгээнд бясалгаж зогсоно. Аврал гуйсан залбирал нь дүнгэнэн сонсогдоно. Максын дээр ямар нэг юм нисч явахыг харав. Ангель уу даа? Макс тодорхой харж чадахгүй байлаа. Нүд нь аниатай байв. Тэр дүрс чихэнд нь юм хэлэхийг чагнавал ангель лав биш ажээ. Энэ бол дэргэдээс салалгүй хоёр өдөр сахиж суусан, Англиас ирсэн шинэ тариа хэрэглэе гэж аав ээж хоёрыг нь цөхөртлөө гуйсан тэр эмч байлаа. «Би одоо энийг л хийхгүй бол өөрийгөө л лав хэзээ ч уучлахгүй» гэж тэр шивнээд, Максын туниагүй гарыг эвлэг зөөлөн татлаа. «Хурдхан л хийчихье». Макс багахан хатгахыг мэдэрсэн ч өвдөж байгаатай нь харьцуулахад юу ч биш байлаа. Эмч тариагаа сэмхэн хураагаад, гарахынхаа өмнө Максын духан дээр нь гараа тавиад: «Энэ чамайг аварна. Би Анагаах ухаанд итгэдэг» гэлээ. Хэдхэн хормын дараа ямар нэг шидэт шингэн венийх нь судсыг даган гүйхийг Макс мэдэрлээ. Тэр дулаахан, зөөлхөн гүйдэл өвчнийг намнан, бүх биеэр нь таатайхан тарж байв. Тэгээд, хэд хэдэн өдрийн турш сэхээгүй өвдсөн Макс анх удаагаа тавтай сайхан нойрслоо. Халуун буух үед, аав ээж хоёр нь бурхны ач хэмээн баясацгаасан сан. Гэвч хүү нь өрөөл татуу болсныг мэдээд, тэд үнэхээр гутарч, хүүгээ тэргэнцэртэй нь түрээд сүм рүү очиж, гэлэнтэй уулзсан билээ. Гэлэн тэдэнд: «Бурхан авралаар л танай хүү амь гарчээ» гэж билээ. Макс

сонсож байсан ч дуугүй л байлаа. «Гэхдээ хүү минь алхаж явж чадахгүй шүү дээ» гэж Колэр авгай хэлэхэд нь гэлэн толгой дохиод: «Хүүг хангалттай сүсэглэж чадсангүй гэж бурхан гэсгээсэн нь энэ юм байлгүй дээ» гэж билээ. «Колэр гуай» хэмээн нэгэн харуул гүйн ирж: «Камерлинго таныг бараалхахыг зөвшөөрч байна» гэлээ. Колэр тэргэнцрээ эргүүлэн гудмаар хурдална. «Таныг ирсэн гэсэн чинь их л гайхаж байна лээ» гэж залуу үглэн дагав. «Тэгэх ч байх гэж бодсон юм. Залуу минь, би камерлинготой ганцаараа уулзмаар байна» гэж Колэр хэлэв. «Болохгүй шүү дээ, хэн ч өмнө нь ...» хэмээн харуулыг хэлтэл, Рошер үгийг нь таслан: «Дэслэгч ээ! Колэр гуай хүссэнээрээ л бараалхах болно» хэмээн зандарлаа. Харуул үл итгэсэн байртай харсаар үлдэв. Рошерийн зөвшөөрснөөр харуулууд Папын өргөөний хаалган дээр жишиг болсон аюулгүйн үзлэгээ хийлээ. Тэд металл илрүүлэгч бариад, цахим тоногоор дүүрсэн Колэрын тэргэнцэрт ёс төдий дэмий хайлт хийлээ. Тахир дутуу хүнийг зохих ёсоор шалгаж тэртээ тэргүй болохгүй байв. Тэргэнцрээс нь буу зэвсэг олсонгүй. Колэр энэ оройн бүх хэргийг нэг тийш нь шийдэх санаатай авч явсан тэр зэвсгийг нь ч салгаж авсангүй. Колэрыг Папын өргөөнд ороход, Вентреска камерлинго бөхөж буй галын дэргэдэх залбирлын буланд сөхрөн сууж байлаа. Нүдээ ч нээсэнгүй. «Колэр гуай! Та намайг золигт гаргахаар ирэв үү?» гэлээ.

Хэсэг 112

Ватикан хийд рүү яаран яваа Ландон, Витториа хоёрын өмнө Il Passeto гэх хонгил сунан үргэлжилнэ. Ландоны гартаа барьсан бамбар өмнөх хэдхэн алхмыг л гийгүүлэх ажээ. Хонгилын хоёр талаасаа, бас дээрээсээ тун давчуу. Хүйтэн, бас эвгүй үнэртэнэ. Ландон түнэр харанхуй руу тэмүүлэн, Витториа мөр даран, ард нь гүйнэ. Ландоны толгойд нь Колэр, Янус, хассассин, Рошерийн царай... бас зургаа дах тэмдэг ээлжлэн солигдоно.

Чи зургаа дахь тэмдгийн тухай сонссон нь лавтай. Энэ бол хамгийн гайхалтай нь шүү хэмээн хассассин хэлж байсан нь цуурайтна. Үгүй гэдгээ Ландон маш сайн мэдэж байлаа. Бүр сэрдэх онолууд ч зургаа дахь тэмдгийн тухай дурдаагүй билээ. Алтан гулдмай, Иллюминатигийн Очирын тухай ярьдгаас биш, зургаа дахь тэмдгийн тухай огт дурддаггүй дэг. «Колэр Янус байж таарахгүй. Ёстой тийм байж болохгүй» гэж Витториа харанхуйд гүйж явснаа хэлэв. *Тийм байж болохгүй* гэдэг үгийг хэлж болдоггүй юм байна гэдгийг Ландон энэ шөнө голдоо ортол ухаарчээ. «Мэдэхгүй юм даа» гэж гүйт дундуур хашхиран: «Колэр ч жаахан дурамжхан байсан, бас түүнд шалтгаан байж болох л юм». «Энэ бүхэн СЭРН-ийг мангас шиг болгож байна. Колэр хэзээ ч СЭРН-ий нэрэнд сэв суулгах юм хийхгүй дээ». Иллюминати энэ самууныг хүмүүсийн нүдэнд дэлгэх гэж оролдохдоо, СЭРН-ийг татан, хүн бүхэн СЭРН-ийг харааж байлаа. Гэхдээ СЭРН хэр хохирсон бол? Шашныхан СЭРН-ийг шүүмжлэх бол байдаг л зүйл. Ландон бодох тусам энэ үймээнээс хамгийн их хожиж байгаа нь СЭРН л байлаа. Хэрвээ шуугиант мэдээг тоглоом гэвэл хожлын хөзөр нь антиматери мөн. Бүх ертөнц энэ тухай л ярьж байлаа. «Барнум гэгч шоу зохион байгуулагч юу гэж хэлснийг мэдэх үү?» гэж Ландон мөрөн дээгүүрээ Витториа руу харан хэлснээ: «Миний тухай юу ярих чинь хамаагүй, харин нэрийг минь л зөв хэлж бай гэсэн юм» гэлээ. Хүмүүс антиматерийн лицензэд оочирлоод зогсож байгаа байх шүү. Ялангуяа энэ шөнө ямар чадалтайг нь харсны дараа ч... «Үгүй дээ» гэж Витториа хэлэв. «Эрдмийн нээлтийг сурталчилна гэдэг чинь устгах чадлыг нь гайхуулна гэсэн үг биш. Энэ бол харин ч болохгүй зүйл. Нээрэн шүү!» Ландоны бамбар бөхөж эхлэв. «Тэгвэл бүр энгийн байж болох юм. Колэр магадгүй буруу тооцоолоод — Иллюминатигийн сүр хүчийг харуулахгүйн тулд Ватикан амаа хамхиад, ийм зэвсэг байгааг зөвшөөрөхгүй гэж бодсон биз. Гэтэл камерлинго гарч ирээд, хамаг юмыг өөрчилж орхихгүй юу.» Витториа чимээгүй гүйсээр. Энэ сценарь бүр ч боломжтой санагдаад явчхав. Ландон өгүүлрүүн: «Тийм шүү! Колэр камерлингог тэгнэ гэж огт бодоогүй байж таарна. Тэгсэн, камерлинго Ватиканы юмыг хав дардаг уламжлалыг эвдээд, олонд дэлгэчихсэн. Бүр бүгдийг нь дэлгэчихсэн. Тэгээд бүр антиматерийг зурагтын дэлгэцээр цацчихдаг. Ийм гайхалтай хариу барина гэж Колэр зүүдлээ ч үгүй байж л дээ. Хамгийн хачирхалтай нь, Иллюминатигийн энэ дайралт, эргээд өөрсдийг нь эвгүй байдалд оруулчихжээ. Тэгээд бүр очиж очиж камерлингог шашны шинэ тэргүүн болгож орхихгүй юу. Аргаа барсан Колэр одоо түүнийг цааш нь харуулах хэрэгтэй болчихлоо». «Макс новшийн амьтан, гэхдээ алуурчин биш» гэж Витториа хэлэв. «Тэгээд, хэзээ ч аавыг минь хөнөөх хэрэгт оролцохгүй байсан» гэлээ. Колэр өөрөө энэ асуултад нь хариулж байгаа мэт Ландонд санагдав. *Леонардог СЭРН-ий олон хүн аюултай гэж боддог байсан. Шашин, эрдэм хоёрыг нийлүүлэх нь дэндүү утгагүй хэрэг.* «Колэр нэлээн өмнө нь антиматерийн тухай олж мэдээд, түүний шашны үр нөлөөг нь таашаагаагүй байж болох л юм». «Аавыг минь үүний төлөө л хөнөөсөн гэж үү? Утгагүй юм. Тэгээд ч, Колэр ийм төсөл байгаа гэдгийг хэзээ ч мэдэж чадахгүй байсан». «Чамайг байхгүй хойгуур аав чинь Колэртай яах тухай зөвлөх гэж энэ нууцаа задалсан ч юм билүү. Чи өөрөө аав чинь ийм аймшигтай зэвсэг хийснийхээ ёс суртахууны үр нөлөөнд эргэлзэж байсан гээ биз дээ?» «Очиж очиж Колэртой ёс суртахууны үр нөлөөний тухай ярина гэнэ ээ? Үгүй байлгүй дээ» гэж Витториа унтууцав. Хонгил барууншаа бага зэрэг хазайв. Хурдан гүйх тусам бамбар бөхнө. Энэ унтарчихвал яана гэж Ландон бодов. Тас харанхуй л болно доо. «Түүнээс гадна, Колэр энэ бүхний ард байсан юм бол өнөө өглөө чам руу утастаж яах юм бэ?» гэж Витториа асуулаа. Ландон энэ тухай бодсон байжээ. «Намайг дуудсанаараа, өөрийгөө гэмгүй гэдгийг л харуулахгүй юу. Ийм юм болж байхад зүгээр сууж байсан гэж түүнийг хэн ч зэмлэж чадахгүй шүү дээ. Гэхдээ, энэ хүртэл явахын чинээ санаагүй байх л даа». Колэрт

ашиглуулсан гэж бодоход, Ландонд эвгүй байлаа. Ландон энэ явдалд оролцсоноороо Иллюминатийг улам бодитой болгожээ. Түүний ном, өгүүлэл нь өнөө шөнөжингөө хэвлэлээр яригдаж, инээдтэй ч гэсэн, Харвардын энэ багш энд гүйж явсан нь дэлхийн бүх сэрдэх онолчдын сэжиг, таамгийг өрдөн, Иллюминати нөхөрлөл түүхийн дурсгал биш, амьд хүч гэдгийн нотолгоо болж байлаа. «ВВС-ийн тэр сурвалжлагч СЭРН-ийг Иллюминатигийн шинэ ноохой гэсэн гэнэ» гэж Ландон хэлэв. «Юу гэнэ ээ?» гэж Витториа хашхирав. Ард нь зогтусах шиг болж гар нь суларсан ч дахин гүйж байгаа бололтой.»Тэгж хэлээ юу?» «Зурагтаар шүү. Тэр эртний аймшигт нөхөрлөлийг өөрөө ч мэдэлгүй орогнуулсан гэмгүй байгууллага, яг л масоны лож шиг гэсэн гэнэ». «Бурхан минь. Энэ ч СЭРН-ийг үгүй хийнэ шүү». Ландон харин тэгж бодсонгүй. Ямартай ч гэсэн энэ хэтэрхий худлаа биш байлаа. СЭРН бол эрдэм, судалгааны өлгий болсон газар. Дэлхийн хамгийн том судлаачдын орон гэр. Мөнгө булаг шиг л ундарна. Тэгээд ч Максимлиан Колэр захирал нь билээ». *Колэр бол Янус.* «Хэрвээ Колэр үүнд хамаагүй юм бол энд юугаа хийж яваа юм бэ?» гэж Ландон лавшруулав. «Энэ самуурлыг зогсоох гэж л яваа байх. Дэмжлэг үзүүлэх гэж. Нээрэнгээсээ Самар хүн болох гэж. Антиматери төслийн тухай хэн мэдэж байсныг мэдээд, мэдээллээ хуваалцах гэж ирсэн ч байж болно шүү дээ». «Тэрийг камерлингог тамгалах гэж ирж яваа гэж алуурчин хэлсэн шүү». «Бодооч дээ! Энэ чинь амиа хорлохтой адил шүү дээ. Макс эндээс амьд гарч чадахгүй шүү дээ». *Чухам үүнийг л тэр хүссэн ч юм билүү* гэж Ландон бодно. Төмөр хаалга тэртээ дүнсийнэ. Ландоны зүрх зогсох шахав. Тэр хоёрыг дөхөж ирэхэд цоож нь уначихсан байж таарч, хаалга нь ч амархан онгойж орхилоо. Ландон санаа амран, яг л бодож байснаараа энэ хонгилыг ашигладаг юм байна гэдгийг харлаа. Тун саяхан, дөнгөж өнөөдөр ашигласан бололтой. Чухам энэ хонгилоор л дөрвөн кардиналыг хулгайлан авч явсан гэдэг бараг л эргэлзээгүй байлаа. Тэд гүйсээр. Ландон баруун талд нь үймэн шуугих чимээ сонсов. Гэгээн Петерийн талбайд байгаа хүмүүс бололтой. Нэлээн дөхжээ. Дахиад нэг хаалга тааралдав. Бас л цоожгүй ажээ. Гэгээн Петерийн талбай дээрх шуугиан ард нь алслахын үеэс, Ландон Ватиканы хэрмэн дотор орсноо гадарлав. Ватиканы яг хаана нь энэ хонгил хүрдэг юм бол гэж дотроо гайхна. *Цэцэрлэг үү? Ордонд юм болов уу? Папын өргөөнд юм болов уу?* Гэнэт хонгил дуусчхав. Төмөр ширээж хийсэн хүнд том хана өмнө нь лаглайна. Бөхөж буй бамбарын гэрэлд тэр хана бариул ч үгүй, товч ч үгүй, түлхүүрийн ч нүхгүй, нугас ч үгүй, юу ч үгүй харагдана. Тэр гэнэт сандарлаа. Архитектурчид ийм ханыг *senza chiave*- ганц талын гарц гэдэг агаад нууц зам, хонгилд хэрэглэж, зөвхөн гадна талаасаа, цаад талаасаа онгойхоор хийдэг байна. Ландоны найдвар нь гарт нь байсан бамбартай хамт унтарчхав. Цагаа харвал, Микки инээмсэглэн, 11:29 хэмээн зааж байв. Унтууцсан Ландон бамбараа шидчихээд, гараараа хаалгыг нүдэж эхэллээ.

Хэсэг 113

Нэг юм болохгүй байгаа нь илт. Шартрон дэслэгч Папын өргөөний хаалган дээр зогсоод, хамт байгаа дайчдынхаа эвгүйцэж байгааг бас мэдрэн жихүүцнэ. Рошерийн хэлснээр тэдний хамгаалж байгаа энэ нууцлаг уулзалт Ватиканыг сүйрлээс аврах ажээ. Гэхдээ л Шартроны совин татаад байв. Рошер яагаад муухай аашлаад байгаа юм бол? Нэг юм болохгүй байгаа нь илт байлаа. Шартроны баруун талд зогсох Рошер яг урагшаа алсын алс руу гөлөрнө. Занги ерөөсөө ийм байдаггүй болохоор танихгүй хүн шиг санагдана. Цагийн өмнөөс Рошер Рошер биш болчихсон байв. Ярьсан, хэлсэн нь утгагүй байлаа. *Энэ уулзалтад хажууд нь нэг хүн заавал байх ёстой доо!* Максимлиан Колэр ороод хаалгаа дотроос нь түгжихийг тэр сонссон билээ. *Рошер яагаад ингэхийг зөвшөөрсөн юм бол?* Шартроны санааг зовоосон өөр олон

зүйл байлаа. Кардиналууд. Тэд цогчин дотор цоожтой хэвээрээ байгаа. Солиотой юм. Камерлингогийн тушааснаар бол арван таван минутын өмнө тэднийг тэндээс гаргах ёстой байсан шүү дээ. Рошер камерлингод мэдэгдэлгүй тушаалыг нь зөрчжээ. Шартрон сануулсан боловч Рошер золтой л толгойг нь авчхаагүй. Шатлан захирах дарааллыг Швейцар жард зөрчиж байсан удаагүй, Рошер одоо хамгийн том захирагч байлаа. Хагас цаг үлдлээ хэмээн, Рошер яаран танхимыг бүдэгхэн гийгүүлэх лааны гэрэлд цагаа шалгав. *За хурдлаач дээ.* Энэ хаалганы цаана юу ярьж байгааг сонсох сон гэж Шартрон бодно. Энэ самуурлын үед камерлингогоос өөр зохион байгуулж байгаа этгээд байхгүй байлаа. Энэ хүн өнөө шөнө том шалгууртай тулж байгаа ч нугарсангүй. Асуудал бүхэнтэй итгэлтэй, шаргуу, бүхэнд үлгэр болохуйц гялалзан тулж байв. Шартрон католик шүтлэгээрээ бахдаж байв. Вентреска камерлинготой тулснаараа Иллюминати алдаа хийжээ. Шартроны бодлыг нэгэн жигтэй чимээ тасалдуулав. Түн түн хийнэ. Чимээ энэ гудмын доороос гарч байв. Цохих чимээ чанга, гэхдээ бөглүү сонсогдоно. Рошер эргэж харав. Занги Шартрон руу дохиж, доошоогоо очихыг зангав. Залуу гар чийдэнгээ барьсаар юу дуугараад байгааг шалгахаар одлоо. Маш хүчтэй цохилж байв. Шартрон доош уулзвар руу гүйн очлоо. Чимээ булангийн цаана Сала Клентинагийн араас гарах шиг. Тэнд ганцхан Папын хувийн номын сан л байдаг билээ. Дээрхийн гэгээний номын санг таалал төгссөнөөс нь хойш түгжсэн сэн. Тэнд хэн ч байх учиргүй. Шартрон урагш гүйж, нэг удам хонгил өнгөрөөд, дахин нэг булан тойрч, номын сангийн хаалга дээр ирлээ. Том модон хаалганы дэргэд хүн бараг жижиг харагдах агаад, хаалга эгээ л харуул шиг дүнсийнэ. Дотор талаас нь, нэлээн бөглүү алсад нүдэж байв. Шартрон тээнэгэлзсэн зогсоно. Тэр энд орж үзээгүй байв. Ер нь тоотой хэдэн хүн ордог, гэхдээ Папыг дагаж л ордог байлаа. Шартрон тээнэглээнгүй хаалгын бариулыг атган дарав. Бодсончилон, цоожтой байлаа. Чихээ түлхүүрийн нүхэн дээр тавив. Ямар нэг юм нүдэх чимээ илүү тод сонсогдоно. Бас өөр юм ч сонсов. *Хүний дуу. Хэн нэг нь хашгирч байлаа.* Тэр юу гэж байгааг нь сонсоогүй ч тэвдсэн дуу байгааг гарцаагүй сонслоо. Нэг хүн энэ дотор түгжигдчихсэн юм болов уу? Швейцар жард хариуцлага алдсан байх нь дээ. Шартрон эргэж очоод, Рошерт илтгэдэг юм уу гэж нэг бодсоноо: «За тэгж ч яах билээ дээ» гээд шийдлээ. Шартрон шийдвэр гаргаж сурсан нэгэн бөгөөд шийдвэрээ ч гаргалаа. Буугаа гаргаж ирээд, цоож руу онилон, гохоо дарав. Хаалганы түгжээ зад үсэрч, саван онгойв. Босгоны цаана пад харанхуй. Тэр гар чийдэнгээрээ гэрэлтүүлэв. Дөрвөлжин өрөө байх агаад дорнын хивс, өндөр гэгч царсан тавиур дээр ном дүүртэл өржээ. Арьсан буйдангийн хажууд гантиг ил зуух байна. Гурван мянган эртний судар эгнэн, орчин үеийн сонин, сэтгүүлийн нэн шинэ дугаар, Дээрхийн гэгээний хүссэн бүхэн энд байдаг гэж тэр сонсож байсан билээ. Эрдмийн төдийгүй улс төрийн сэтгүүлээр цайны намхан ширээ дүүрчээ. Нүдэх чимээ илүү тод сонсогдож байлаа. Тэр чимээний зүг Шартрон гэрлээ тусган өрөөний алс булан руу харав. Эсрэг хананд нь, явган ширээний цаана, том төмөр хаалга байх ажээ. Ёстой л хана шиг бат нот дүнсийнэ. Том гэгч дөрвөн цоож өлгөжээ. Тотго дээр жижигхэн бичиг байлаа. Il Passeto Шартрон алмайрна. *Пан оргоход зориулсан гарц!* Шартрон il pas-seto-ийн тухай сонсож байсан, бүр энд хувийн номын санд нь үүд нь байдаг гэж ч сонсож байсан боловч зуун зууны туршид хэн ч ашиглаж байгаагүйг мэдэх билээ. *Цаад талаас нь хэн нүдэж байдаг билээ?* Шартрон гэрэл тусган, хаалга ойртлоо. Цаад талд цөхөрсөн бололтой чимээгүй болов. Тэгснээ, цохихоо болиод, хашхирч байгаа нь сонсогдоно. Энэ том төмрийн араас үгийг нь арай гэж дуулав. ... Колэр ... худлаа хэлж... камерлинго ... «Хэн бэ?» гэж Шартрон зандрав. «..эрт Ландон, Виттория Ве...» Шартрон сонсоод, мэлрэн гайхав. Та нарыг чинь үхсэн л гэж бодсон шүү дээ! «... хаалга» гэж бөглүү хоолой «онгойл... ээ» гэж хашхирлаа. Шартрон нүсэр

том хаалгыг харвал онгойлгохын тулд тэсрэх бөмбөг хэрэгтэйг ухаарлаа. «Болохгүй нь ээ! Хэтэрхий зузаан юм байна.» «... уулзалт... боль ... эрлинг ... аюул...» Шартрон олон аюулыг тайван туулж байсан туршлагатай ч сүүлийн хэдэн үгийг сонсоод тэвдэхгүй байж чадсангүй. Зөв сонссон байгаа даа? Зүрх нь дэлссээр Шартрон өргөө рүү эргэлээ. Тэгснээ гэнэт зогтусан эргэж харав. Харц нь хаалган дээр ... тусч, хүмүүсийн хэлсэн тэр үгээс илүү жигтэй юм тэр харлаа... Хаалгыг түгжсэн цоож болгоны нүхнээс түлхүүр нь цухуйх ажээ. Түлхүүр нь эндээ байсан юм уу? Итгэж чадахгүй нүдээ завчлан мэлэрнэ. Энэ түлхүүрүүд аль нэг шүүгээнд байх ёстой! Энэ хаалгыг хэдэн зууны турш огт онгойлгоогүй шүү дээ! Шартрон гар чийдэнгээ газар тавиад нэг түлхүүрийг нь барин эргүүлэв. Гацангуй янзтай, их л хатуу байлаа, гэхдээ л эргэж байв. Энийг саяхан онгойлгосон бололтой. Дараагийнх нь түлхүүрийг эргүүлэв. Сүүлийн цоожийг эргүүлсний дараа Шартрон хүчлэн татлаа. Нүсэр хүнд хаалга хяхран онгойв. Залуу гар чийдэнгээ дотогш нь тусгалаа. Роберт Ландон, Виттория Ветра хоёр номын сан руу ороход, ёстой сүнс сүг шиг харагдаж байв. Ядарч, туйлдаад цонхийчихсон, амьтай голтой хоёр юм байлаа. «Юу вэ? Юу болоод байгаа юм бэ? Та хоёр хаанаас ирээ вэ?» хэмээн Шартрон хэлмэн асуув. «Макс Колэр хаана байна?» гэж Ландон хариу асууна. Шартрон дээшээ зааж: «Камерлинготой хоёулханаа уулз...» гэтэл Ландон, Виттория хоёр түүнийг түлхчхээд, харанхуй руу гүйн одлоо. Шартрон зөнгөөрөө буугаа сугалан араас нь онилонгуутаа больж, араас нь шогшив. Рошер тэднийг гүйн ирэхийг сонссон бололтой, хөлөө алцайж зогсоод, буугаа шагайн «Alt! (Зогс. ита)» хэмээн зандрав. «Камерлинго аюулд ороод байна» хэмээн Ландон гараа өргөн, хурдаа хасан очихдоо хашхирлаа. «Хаалгаа онгойлго! Макс Колэр камерлингог алах гэж байна» гэв. Рошер ууртай яа ширвэв. «Хаалгаа онгойлгооч ээ! Бушуулаач» гэж Виттория хэллээ. Хожимджээ. Дотор нэг хүн орь дуу тавин хашхирлаа. Камерлингогийн дуу байв.

Хэсэг 114

Ирүүл тулаан удсангүй. Шартрон Рошерийн хажуугаар дайрч, Папын өргөөний хаалгыг буудан, савж ороход, Вентреска камерлинго ёолон орилсон хэвээр байлаа. Харуулуудын араас Ландон, Виттория хоёр ч орлоо. Байдал нүд далдирам байв. Лааны гэрэл, бөхөж буй галын цог л өрөөг гэрэлтүүлж байлаа. Колэр ил зуухын өмнө тэргэнцрээсээ босоод хачин зогсчихсон, гартаа буу бариад, өвчиндөө тарчлан хөл доор нь хэвтэх камерлинго руу чиглүүлчихсэн байх ажээ. Камерлингогийн хар дээлийн энгэр нь урагдчихсан, нүцгэн цагаан цээжин дээр нь нэг юм харлана. Ландон өрөөний нөгөө захаас тэр тэмдгийг тодорхой харсангүй, харин Колэрын дэргэд том, дөрвөлжин тамга хэвтэж байв. Тамга улайсан хэвээрээ байлаа. Швейцар хоёр харуул шууд л буугаа шүүрч аваад гал нээв. Сум Колэрын цээжийг нэвлэн орж, хүчинд нь хөөрхий тахир дутуу эр тэргэнцэр дээрээ савж унана. Хэнхдэг нь хүржигнэн цусанд будагдав. Гарт нь байсан буу шалан дээгүүр гулсан одлоо. Ландон үүдэн дээр мэлэрнэ. Виттория алмайран: «Макс ...» гэж дуудах гэсэн ч, нэр нь хоолой дээр нь ирээд гацчихав. Камерлинго шалан дээр тэлчлэн, нэг хөрвөөд, Рошер руу долоовор хуруугаараа заан «Иллюминатус!» хэмээн чөтгөр харсан мэт загзайтал хашхирлаа. «Чи муу гөлөг! Гэгээн дүр эсгэсэн зулбасга!» хэмээн Рошер ханцуй шамлан, давшлав. Шартрон зөнгөөрөө буугаа сугалан, Рошерийн араас нуруунд нь гурван сум зоолоо. Занги нүүрээрээ газар шаан унангаа, эрчиндээ шалан дээгүүр цусаа гоожуулан хэсэг гулсаад зогслоо. Шартрон харуулуудаа дагуулан өвчиндөө гингэнэх камерлингогийн зүг туслаар гүйн очив. Хоёр харуул очоод, камерлингогийн цээжийг сөхөн хармагцаа дуу алдав. Нэг нь тамгыг хармагцаа урвуу харуулан дахиж уншаад, агдганан хашхирч, арагш нэг алхам ухарлаа. Шартрон ч тэр түлэгдсэн тамгыг

хараад жихүүцэн, цээжийг нь хар дээлийнх нь уранхайгаар зөөлөн халхаллаа. Ландон өрөөгөөр алхан, аллага таллага, хүүр цогцсон дундуур зүтгэн юу болоод байгааг ухаарах гэж оролдон алхална. Тахир дутуу эрдэмтэн Ватикан руу нисч ирээд, шашны хамгийн том эрхтэнг тамгалж, зорьсон хэргээ гүйцээжээ. *Зарим үйлсийн төлөө амь хайрангүй байдаг* юм гэж хассассин хэлж байж билээ. Ийм зэрэмдэг хүн яаж эрүүл чийрэг камерлингог дийлж чадав аа? Колэр гартаа буутай байсан л даа. *Яаж хийсэн нь хамаагүй, ямартай ч Колэр санаснаа гүйцээлээ.* Харуулууд камерлингод тусалж байх зуур Ландон Колэрын тэргэнцрийн хажууд угаа савсуулан хэвтээ тэмдэг рүү очив. *Зургаа дахь тэмдэг?* Урагшлах тусмаа Ландон гайхна. Тэр тэмдэг дөв дөрвөлжин, томоос том, Иллюминатигийн ноохойд харсан тэр хайрцгийн гол хоногт байсан нь илэрхий байлаа. *Сүүлчийн зургаа дахь тэмдэг. Хамгийн гайхалтай нь* хэмээн хассассин хэлж байсан нь нүдэнд нь үзэгдэнэ. Ландон Колэрын хажууд сөхөрнө. Нөгөө том тэмдэг халуунаараа цогшин, харанхуйд хөхрөн үзэгдэнэ. Тэр модон ишнээс нь бариад харлаа. Юу байгааг нь мэдэхгүй байсан ч тийм юм байна гэж зүүдэлсэн ч үгүй. Шороо, Хий, Гал, Ус Ландон дүрсийг хараад эхэндээ сайн ойлгосонгүй мэлийнэ. Ямар ч ойлгомжгүй дүрс байв. Харуул энийг хараад, яагаад хашхирсан юм бол? Олон тууш шугамтай замбараагүй дүрс. Хамгийн гайхалтай нь гэл үү? Эргүүлж тойруулан харвал ямартай ч тэгш хэмтэй байх, гэхдээ тууш мөртөө замбараагүй дүрстэй байлаа. Нэг хүн мөрөн дээр нь гараа тавихаар нь Ландон Витториа болов уу гэж бодоод эргэж харав. Гэтэл тэр гар цусанд будагджээ. Цочин эргэж харвал, Максимилиан Колэр тэргэнцрээсээ өндийн, сарвайж байлаа. Ландоны сэрвээнийх нь үс өрвийн босч, гартаа барьсан тэмдгээ алдчихлаа. Колэр амьд байлаа. Үхэж буй хөөрхий захирал тэргэнцрээ тулан өндийж, амьсгалах аядан аахилна. Колэрын саарал нүд Ландонтой харц тулгарахад, өнөө өглөө түүнтэй СЭРН-д уулзаж байсан тэр л хөшүүн, хүйтэн янзаараа байв. Тэгснээ зэвүүцэл, өширхлөөр дүүрсэн юм шиг бүр ч хэрцгий харагдах шиг. Эрдэмтэн гуай татваганах агаад хөдлөх гэж оролдоод байх шиг. Бүх хүн камерлингод туслан анзааргагүй байх, Ландон хүн дуудах гэсэн ч чадсангүй. Үхэж байгаа хүний нүдэн дэх сүүлийн оч түүнийг хөдлөх тэнхээгүй болгож орхилоо. Захирал гараа өргөн сүүлийнхээ тамирыг шавхан байж тэргэнцрийнхээ гар дороос нэг төхөөрөмж мултлав. Шүдэнзний хайрцгийн чинээ тэр юмаа гартаа барин татваганахыг Ландон хараад, буу барьчихсан байгаа юм уу гэж гэнэт айлаа. Гэхдээ биш байлаа. «Энийг ...» гээд Колэр аахилна. «Энийг ... хэвлэлийнхэнд ... өгөөрэй ...» гэж хэлж дуусмагцаа нөгөө юмаа Ландоны алган дээр унагаад, эвхрэн унав. Ландон чичрэн гартаа байгаа юмыг харав. Тэр цахим төхөөрөмж дээр SONY RUVI гээд хөндлөн бичсэн байлаа. Нөгөө олон бичил цахим төхөөрөмжүүдийн нэг видео камер байлаа. Колэр амиа золиосолсон энэ үйлсээ камерт бичээд, хэвлэлийнхэнд өгч шашны увайгүйг, эрдмийн ариуныг харуулах гэж оролдсон биз ээ. Энэ хүний төлөө хангалттай ихийг өнөө шөнө хийлээ. Шартрон Колэрын камерыг үзэхээс өмнө, Ландон түүнийг пиджакийнхаа хамгийн гүн халаасанд хийгээд тэр бичлэг эндээ мартагдвал таарна гэж бодов. Камерлингогийн хоолой нам гүмийг эвдэв. Суух гэж оролдон, Шартроноос зуурангаа: «Кардиналууд хаана байна?» гэж асууна. «Систин цогчиндоо л байгаа. Рошер тэгж тушаасан юм» гэж Шартрон хариулав. «Бүгдийг нь ... одоо даруй гарга». Шартрон кардиналуудыг гаргахаар нэг харуулаа гүйлгэв. Камерлинго өвчиндөө шаналан өгүүллрүүн: «Нисдэг тэрэг ... дууд ... намайг эмнэлэгт аваачаач!»

Хэсэг 115

Гэгээн Петерийн талбай дээр буусан Ватиканы нисдэг тэрэгний нисэгч бүхээгтээ суугаад, чамархайгаа маажиж байлаа. Талбай дээрх шуугиан хэтэрхий чанга, моторынх нь

нүргээн хүртэл сонсогдохгүй ажээ. Энэ хүмүүс хамгаалалтыг удахгүй давах байх даа хэмээн гайхна. Шөнө дунд болоход, хорин тавхан минут дутуу байхад хүмүүс тэндээс явахгүй, зарим нь залбирч, зарим нь уйлж, зарим нь шашныг зүхэн харааж, зарим нь Библийн галав юүлдэг хэсгийг уншина. Хэвлэлийнхний прожектор бүхээгийн шилэн дээр тусч гялбуулахад нисэгч нүдээ гараараа хаана. Гэрэл өнгөрсөн хойно, хүмүүс рүү дахин харлаа. Тэнд олон олон даавуун лоозон барин зогсжээ. Антиматери - Антихрист! Эрдэмтэд - Эвэрт чөтгөр! ТЭР БУРХАН ЧИНЬ ОДОО ТЭГЭЭД ХААНА БАЙНА ВЭ? Нисэгч унтууцна. Толгой нь өвдөнө. Бүхээгийнхээ салхины шилний хаалтыг буулгаад, хэрэгтэй хэрэггүй тэр олны самууныг харахгүй суудаг юм уу гэж бодсон ч, хэзээ мөдгүй нисэх хэрэг гарч магадгүй болохоор тэгж чадсангүй. Шартрон дэслэгч дөнгөж сая гар холбоогоор аймшигт мэдээ дамжуулсан билээ. Максимлиан Колэр камерлинго руу дайрч, хүнд гэмтээжээ. Шартрон, америк эр, нөгөө хүүхэн гурав камерлингог эмнэлэг рүү аваачих гээд авч яваа. Камерлинго гэмтсэнд нисэгч өөрөө буруутай юм шиг санагдана. Хэлж сануулдаг л байж. Түрүүхэн Максимлиан Колэрыг онгоц буудлаас авах үед, нүдэнд нь үхлийн гэмээр занал тодорч байсныг анзаарчээ. Таалагдаагүй боловч аваад явахаас өөр арга байсангүй. Гэхдээ, энэ хамаагүй л дээ. Рошер энэ шоуг зохион байгуулж, Рошер энэ нөхрийг хамгийн чухал этгээд гэж итгүүлсэн билээ. Рошерийн алдаа байжээ. Удалгүй дахиад нэг бүлэг хүн талбайд үзэгдэв. Кардиналууд өргөн эгнээгээр жагсан, Ватиканаас Гэгээн Петерийн талбайд байгаа олонтой нэгдэхээр ёс төртэй гарч ирлээ. Тэсрэх бөмбөг дээрээс дөнгөж өндийгөөд, санаа нь амарсан бололтой байсан тэдний нүдэнд сүмийн гадаа, талбай дээр болж байгаа явдлыг хараад, дахин эмээж байгаа нь илт. Хурсан олон дахин уухайлан шуугив. Нисэгчийн толгойг тас хийтэл цохиод авах шиг болов. Аспирин хэрэгтэй. Хэдийг ч уусан яах вэ. Эм авах гээд нисэх нь хаашаа юм гэхэд, түүнд яалт ч үгүй хэдэн аспирин уучихвал, энэ олны улангасан хашхичих чимээнд дүнгэнээд байгаа толгойд нь нэмэр болохоор санагдана. Урд хоёрын суудлын хооронд байх газрын зураг, нисдэг тэрэгний схемтэй хамт байгаа анхны тусламжийн хайрцаг руу сарвайлаа. Хайрцага аваад онгойлгох гэсэн чинь түгжээтэй байв. Түлхүүрийг нь хайгаад олсонгүй. Өнөөдөр азгүй өдөр ажээ. Тэгээд, аргаа баран чамархайгаа үрэн суув. Түнэр харанхуй ордонд, Ландон, Витториа хоёр, хоёр харуултай дөрвүүлээ амьсгаа авах завдалгүй тэвдэн гүйлдэнэ. Өөр юм олоогүй болохоор камерлингог ширээн дээр хэвтүүлээд, дөрвөн талаас нь өргөн, холбируулж унагаачихгүй санаатай шогшино. Хаалганы цаана, хурсан олны самууран хашхирах сонсогдоно. Камерлинго ухаангүй шахуу татганана. *Цаг дуусаж байлаа.*

Хэсэг 116

Ландон тэр хэд Гэгээн Петерийн ордноос гарах эгшинд 11:39 болж байлаа. Гадаа аймаар юм болж байхыг цочирдон харлаа. Хэвлэлийнхний прожектор ордны цагаан гантигт ойх нь яг л нарны туяа цасанд ойх шиг санагдана. Ландон нүдээ онийлгон, ордны том том багануудын араар орж нуугдах гэж бодсон ч гэрэл бүх талаас тусч байлаа. Өмнө нь, хүмүүсийн араас том гэгч дэлгэцүүд нэлийнэ. Ордноос талбай руу буусан өргөн том шатны дээр зогсоо Ландон яг л дэлхийн хамгийн том тайзны голд зогсох мануухай шиг санагдана. Энд тэндгүй гялбах цагаан гэрлийн хаа нэгтээ нэг нисдэг тэрэг мотороо унтрааж байгаа нь мянга мянган хүний шуугиан дотроос сонсогдлоо. Зүүн талд нь ордноос аюулгүй газар руу нүүлгэх гэж байгаа кардиналууд эгнэн зогсоно. Тэд бүгд тэртээ доор талбай дээр бужигнасан олны үймээнийг хараад, цочирдон зогтусжээ. «Болгоомжтой байгаарай!» гэж Шартрон хашхиран, кардиналуудыг доош нь нисдэг тэрэгний зүг шатаар дагуулан хөдлөв. Усан доогуур явж байга». юм шиг Ландонд санагдлаа. Камерлинго, ширээ хоёрын хүнд жинд гар нь

тохойгоороо янгинан өвдлөө. Цагаа тулахаар ийм нэр төргүй байж болно гэж үү хэмээн бодно. Хариулт ойлгомжтой. ВВС-ийн хоёр сурвалжлагч нээлттэй талбайг хөндлөн гарч, хэвлэлийнхний байгаа газар руу явж байхыг харав. Тэгээд, үймсэн олон руу эргэн харлаа. Макри, Глик хоёр буцаад, тэдэн рүү ирж явна. Макри камераа өргөжээ. *Махчин тас эргээд ирлээ* гэж Ландон тэр хоёрыг хараад бодлоо. «Alt!» гэж Шартрон хашхираад «Гэдэргээ!» гэж хорив. Хоёр сурвалжлагч үгэнд нь орсонгүй, харин ч урагшаа давшилсаар. Энэ хоёрын хийж байгаа ВВС-ийн бичлэгийг бусад телевиз зургаахан хормын дараа л нэлийтэл цацаж эхэлнэ дээ гэж бодов. Гэхдээ, Ландон буруу тооцжээ. Хоёрхон хором л болов. Бүгд нэг сүлжээнд холбогдсон аятай, талбай дээр байсан бүх дэлгэц урвуу тоолж байгаа антиматери, Ватиканыг сурвалжилж байгаа нэвтрүүлэгчээ орхиод, нэгэн зэрэг дүрсээ сольж, Ватиканы ордны өргөн гантиг шатыг үзүүлээ. Бүх дэлгэц дээр Ландон хөөрхий камерлингогийн өвчиндөө шаналсан биеийг өргөн яваа нь Техникolorын өнгөний гайхамшигтай нарийвчлалтай гарна. Ингэж болохгүй шүү дээ! гэж Ландон бодно. Доошоо гүйж очоод, хажуугаас нь болиулмаар санагдана. Даан ч чадсангүй. Чадсан ч гэсэн нэмэр болохгүй байв. Хүмүүсийн уухайлах дуунаас болсон уу, далайн хүйтэн амьсгалаас болов уу, Ландон л лав хэзээ ч төсөөлж чадхааргүйгээр, санаанд оромгүй гайхалтай зүйл боллоо. Хар дараад, сэрж байгаа хүн шиг камерлинго гэнэт нүдээ нээгээд, босоод суучхав. Гайхаж цочсондоо, бас ширээн дээрх хүндийн төв өөрчлөгдмөгц өргөж байсан дөрөв тэссэнгүй, ширээний урд хоёр хөл газар унав. Камерлинго гулсаж эхэллээ. Ширээнийхээ урд хэсгийг тэвдэн өргөсөн боловч амжсангүй, камерлинго гулссаар хөл дээрээ буучхав. Гайхалтай нь камерлинго ойчсонгүй, хоёр хөл дээрээ бат зогсоно. Толгой нь эргэсэн бололтой хэсэг дуугүй зогссоноо, хэн ч хорьж амжихаас өмнө гэнэт Макри руу тэмүүлэн очлоо. «Болиоч ээ!» хэмээн Ландон хашхирав. Шартрон урагшлан камерлингогийн замыг хаах гэж оролдлоо. Камерлинго эргэж галзуу юм шиг харцаар ширтээд: «Намайг орхи!» гэлээ. Шартрон давхийн ухрав. Байдал бүр ч муухай боллоо. Цээжин дээгүүр нь Шартроны нөмөргөсөн дээлийн уранхай нь биеийг нь даган гулсана. Хувцас нь тогтох болов уу гэж бодсон ч тэгсэнгүй. Уранхай энгэр нь навсран гулсч, цээжнээсээ бүсэлхий хүртэл нүцгэрч орхилоо. Дуу дуугаа авалцсан хүмүүсийн дуу дэлхийг эгшин зуур тойроод, буцаад хүрээд ирэх шиг л байн байн үелзэн хашхиралдана. Камерууд энд тэдгүй гозолзон, гэрэл зургийн аппарат гялсхийнэ. Зурагтын том дэлгэцүүд дээр камерлингогийн тамгалуулсан цээж дэлгэц дүүрэн гарч, бүр нэг нэгэнгүй үзүүлнэ. Зарим телевиз дүрсийг тогтоогоод, 180 хэм эргүүлж шинжлэн тайлбарлаж буй бололтой.

Иллюминатигийн үнэмлэхүй ялалт. Ландон камерлингогийн шархыг дэлгэц дээрээс харлаа. Тэр бол хэдхэн хормын өмнө гартаа барьж байсан тэр тэмдгийн дардас байсан агаад тэмдгийг харж суухдаа юу болохыг нь төдийлөн ухаараагүй билээ. Харин одоо бол өөр байлаа. Энэ тэмдэг төгс утгатай зүйл байв. Ландоны сэтгэлд хүмүүсийн шуугилдах их чимээг даван Иллюминатигийн эртний домог аянга мэт чанга нүргэлнэ. Харсан хүн гагцхүү алмайран гацахаар эртний махбодоос бүрдсэн сэвгүй очир эрдэнэ! Энэ домог үнэн байсныг одоо л мэдлээ. **Шороо, хий, гал, ус. Иллюминатигийн очир. Шороо, Хий, Гал, Ус**

Хэсэг 117

Гэгээн Петерийн талбайд оволзон буй хүмүүсийн тэвдэж шуугих нь хэрээс хэтэрч, Ватиканы түүхэнд байгаагүй зүйл болж байх шиг. Энэ хийд байгуулагдсанаас хойших 2000 жилийн турш ямар ч дайн, ямар ч загалмайд хадах шийтгэл, ямар ч эргэл мөргөл одоо болж байгаа шиг ийм их аймшигтай, далайцтай байгаагүй биз ээ. Энэ бүх үймээн самууныг Ландон агаарт жингүйдэн, Витториатай хамт гол шатны дээд тавцангийн тэртээ нисэн,

хөндлөнгөөс ажиглаж байгаа мэт санагдана. Үйл явдал их хол өрнөн, дуу шуугиан хананы цаана байгаа мэт сонсогдон, цаг хугацаа зунгааралдсан юм шиг... *Тамгалуулсан камерлинго ... нүүцэн цээжээ ... дэлхий нийтэд харуулах гэж... Иллюминатигийн очир... нууцаа хорлонтой ёо дэлгэлээ... Антиматерийн урвуу тоолох цаг Ватиканы түүхийн сүүлчийн хорин минутыг тоолж байна.* Гэхдээ, үйл явдал дөнгөж эхэлж байжээ. Камерлинго ослын дараах ухаан самууралд орчихсон юм уу, чөтгөрт эзэмдүүлж орхив уу гэлтэй гэнэт солиотой юм шиг аашилж эхлэв. Үл үзэгдэгч сүнстэй яриад байгаа юм уу гэлтэй ганцаараа шивнэн, бурхантай яриа юу гэлтэй гараа тэнгэр рүү сарвайжээ. «Надад хэлээч! Би таныг сонсож байна!» хэмээн камерлинго хоосон тэнгэр рүү харан ориллоо. Зүрх нь шимшрээд, солиорч байгаа юм болов уу гэж Ландон бодов. Витториа бас тэгж боджээ. «Тэр шоконд орчхож. Тэгээд хий юм хараад байх шиг байна. Өөрийгөө бурхантай ярьж байна гэж бодоод байх шиг». *Энийг зогсоохгүй бол болохгүй нь* гэж Ландон бодлоо. Энэ хэтэрхий утгагүй, шившигтэй төгсгөл болох нь байна. *Энэ хүнийг эмнэлэгт аваачъя.* Шатны доор Чинита Макри хамгийн аятайхан байрлалаа эзэлчхээд, зураг авч зогсоно. Ард нь байгаа том дэлгэцүүд гэнэт хийж байгаа бичлэгийг нь шууд нэвтрүүлж эхэллээ. Хүмүүс бүгд л машин дотроосоо кино үздэг том дэлгэц харж байгаа юм шиг санагдана. Эртний тууль шиг дүрс гарч байна. Уранхай дээлээ унжуулж, цээжээ тамгалуулж шархадсан камерлинго зовон туулан, бэрхийг давсан баатар мэт үзэгдэнэ. Тэнгэрээс заяатай зайран бөө шиг л тэнгэртэй ярьж байлаа. «77 sento, Dio. Бурхан минь, таныг сонсож байна». Шартрон биширсэн дүртэй камерлингог ширтэн зогсоно. Хурсан олон гэнэт чимээгүй болов. Эгшин зуур бүх ертөнц чимээгүй болсон мэт... сүмд байгаа, зурагтаа үзэж суугаа хүн бүр амьсгаа даран хүлээв. Камерлинго бүх дэлхийн өмнө гараа өргөөд, шатны дээд тавцан дээр зогсч байна. Яг л Христ шиг нүүцэн, тамлуулж зовсныхоо тэмдгийг цээжин дээрээ харуулан зогсоно. Гараа дээшээ тэнгэр рүү өргөн: «Grazie! Grazie, Dio (Баярлалаа, баярлалаа, бурхан минь. ита)» хэмээн хашхирлаа. Бүх дэлхий нам гүм хэвээр. «Grazie, Dio!» хэмээн бүрхэг тэнгэрийг нарны туяа хүү татан гийгүүлэх мэт камерлингогийн нүүрэнд баярын цог тодрон хашхирна. Баярлалаа, бурхан минь. Баярлалаа, бурхан минь гэнэ үү хэмээн Ландон алмайрна. Камерлинго бараг л гэрэлтэж байлаа. Хачин жигтэй байсан царай нь баясгалан төгөлдөр болов хувирна. Тэнгэр рүү гараа сунгаад, толгой дохисоор. Тэгээд дээшээгээ: «Энэ хадан дээр би сүмээ босгоно!» хэмээн хашхирлаа. Ландон энэ үгийг мэддэг боловч яагаад камерлинго хашхираад байгааг ухаарсангүй. Камерлинго хүмүүс рүү эргээд, дахиад л шөнийн харанхуйд хашхирлаа. «Энэ хадан дээр би сүмээ босгоно!» Тэгээд, гараа дахин тэнгэр рүү сунгаад, чанга дуугаар инээд алдан: «Grazie, Dio. Grazie» гэлээ. Энэ хүн солиорчихжээ. Бүх дэлхий харж байв. Гэхдээ үйл явдлын оргилыг хэн ч төсөөлөөгүй байлаа. Нүүрэндээ баясал тодруулсаар, камерлинго эргээд, Гэгээн Петерийн ордон руу орчихлоо.

Хэсэг 118

Арван нэгэн цаг дөчин хоёр минут. Камерлингог эргүүлэх гэж баахан хүн эргээд, ордон руу зүтгэв. Ландон ийм юман дунд орооцолдоно чинээ санасангүй. Гэхдээ, тэр хаалганд хамгийн ойрхон байсан болохоор зөнгөөрөө хөдлөв. *Энэ хүн энд үхэхээр шийдсэн бололтой* хэмээн бодмогцоо Ландон харанхуй хоосон хаалга руу эрчээрээ гүйлээ. «Камерлинго, зогс!» Ордон руу гүйн ормогц тас харанхуй нөмрөн авч, сохор юм шиг болчхов. Гадаа гэрэлд дассан

байсан хүүхэн хараа нь гэнэт нарийсаж хамраасаа урагшаа хэдхэн тохой газрыг л мэдэрнэ. Гүйж байснаа гэнэт больж зогсохоос өөр аргагүй боллоо. Харанхуй ордон дотор камерлинго урд нь хаа нэгтээ гүйж яваа нь дээлийнх нь намирах дуугаар баримжаалагдана. Витториа, харуулуудтай хамт араас орж ирлээ. Гар чийдэнгийн гэрэл гарсан боловч ордны том хүйтэн хонгилд бараг л ямар ч хэрэггүй шахуу санагдав. Гэрэл нааш цааш тусах авч хоосон шал, аварга том баганууд дээр л ойно. Харин камерлинго алга. 'Камерлинго! Эрхэм ээ. Хүлээгээч!» хэмээн Шартрон орилоход, дуунд нь айдас сонсогдов. Хаалган дээр нэг юм гэрэл гялбуулан, сүр сар хийн орж ирэхэд, хүн болгон эргэж харлаа. Үүдэн дээр Чинита Макри зогсож байлаа. Камераа мөрөн дээрээ барьчихсан, тэнд анивчих улаан гэрэл шууд бичлэг хийж байгааг харуулна. Глик ард нь микрофоноо барьчихсан, аажуухан яваач гэсээр орж ирлээ. Энэ хоёрыг хараад, Ландон нүдэндээ итгэсэнгүй. Цагаа олж дээ. «Гар! Энэ та нарт хүртээлтэй зүйл биш!» хэмээн Шартрон зандрав. Макри, Глик хоёр гарсангүй. «Чинита. Амиа хорлох гээ юү? Би очихгүй шүү» хэмээн Глик шивнэнэ. Макри түүнийг тоосонгүй. Камерынхаа тохируулгыг тавилаа. Гэтэл гэрлийнх нь хурц туяа хүмүүсийг гялбуулан, ордны тэр хавийг бүхэлд нь гэрэлтүүллээ. Ландон нүд нь гялбахад, гараараа нүүрээ халхлав. Чөтгөр гэж. Нүд нь гэрэлд дасахад харвал, одоо ойр тойрны гуч орчим тохой газар тодорхой харагдаж байлаа. Яг энэ үед камерлингогийн хашхирах сонсогдов. «Энэ хадан дээр би сүмээ босгоно». Макри дуу гарсан зүг камераа чиглүүлэв. Тэртээ хол камерын хурц гэрэл сарних саарал үзүүрт, танил дүрс бүхий хар дээлийн өөдөс үзэгдээд, алга болов. Ордны гол шатаар доошоо бууж байгаа бололтой. Хүн бүрийн нүдэнд хойноос явах эсэхдээ эргэлзсэн байртай харц зурсхийн тодров. Хамгийн түрүүнд Шартрон Ландоны хажуугаар шийдсэн бололтой сүрхийн камерлингогийн хойноос чавхдав. Ландон хойноос гүйж, араас нь харуулууд, Витториа дагалаа. Хамгийн сүүлд Макри араас нь хүн бүрийн замыг гийгүүлэн, үхлээ эрсэн хүмүүсийг дэлхий даяар харуулан хөдөллөө. Глик хараал тавин араас нь их л дурамжхан, чичирхийлсэн хоолойгоор амьсгаадан тайлбар хийх аядан бувтнасаар гүйлээ. Гэгээн Петерийн ордны гол танхим хөл бөмбөгийн талбайгаас том юм байна гэж нэг удаа Шартрон тоймлож байжээ. Харин одоо бүр хоёр дахин том болчихсон санагдана. Камерлинго ер нь хаашаагаа яваад байгаа юм бол хэмээн Шартрон цэргүүдтэйгээ хамт гүйнгээ гайхаад барахгүй байв. Камерлинго яах аргагүй шоконд орчихсон байсан, дээрээс нь Папын өргөөнд болсон аллага таллагыг харсан, тэнд тамлуулсан өвчиндөө дэмийрчихсэн яваа бололтой. ВВС-ийн камерын гэрлийн тусгалын тэртээ захад, камерлинго: «Энэ хадан дээр би сүмээ босгоно» хэмээн их л баясгалантай хашхиран гүйх нь сонсогдоно. Шартрон эндүүрээгүй бол Матайн 16:18-нд байдаг шадьг камерлинго хашхиран явна. Энэ хадан дээр би сүмээ босгоно. Энэ сүм замхарч алга болох гэж байхад энэ шадьг үглэн яваа нь хэтэрхий гаслантай сонсогдоно. Камерлинго солиорсноос зайлахгүй. Үгүй ч байж магадгүй юм даа? Шартрон энэ тухай бодмогц сүнс нь дэвээд явчих шиг болов. Бурхныг харсан, сонссон гэдэг дандаа л хүсэлдээ хууртсан хэрэг -хэт их мөрөөдсөнөөсөө болоод хүссэнээ л сонссон хэрэг байдаг билээ. Бурхан шууд ярьдаггүй сэн. Хормын дараа ариун сүнс өөрөө бууж ирээд, чадлаа гайхуулах шиг болж, Шартрон билэг үзэв. Тавин тохой тэртээ сүмийн яг голд гэнэт... тунгалаг, гэрэлт сүнс гарч ирлээ. Дүрс нь яг л хагас нүцгэн камерлинго шиг харагдах боловч гэрэл нь нэвт туяарах ажээ. Шартрон бараг л зогсож, цээж нь зангираад ирэв. *Камерлинго нэвт гэрэлтэж байна!* Бие нь улам бүр тунгалагшин гэрэлтэнэ. Тэгэнгүүтээ сүмийн харанхуй руу шингэн шингэсээр алга болчхов. Ландон ч бас гэрэлт сүнсийг харжээ. Тэр ч бас гайхамшиг харж байгаа нь энэ үү хэмээн хэсэг боджээ. Гэвч Шартроныг гүйцэн, камерлингог харанхуй руу ууссан тэр зүгт гүйсээр, тэр газар руу очмогцоо юу харснаа сая л ухаарлаа. Камерлинго Паллиумын хонхор руу, ерэн

есөн зул мөнхөд асах нүхэн танхимд ирсэн байжээ. Доороос гэрэлтэж байсан тосон зул, дээр нь байсан камерлингогийн сүүдрийг уусган, яг л гэрэлт сүнс мэт харагдуулжээ. Камерлинго шатаар бумагц, тэр харанхуй дунд уусах мэт санагджээ. Ландон амьсгаадан, нүхэн танхимын ирмэг дээр нь ирж дээрээс харлаа. Тэгээд, шатаар ухаан мадаггүй доошоо буув. Тэр доор тосон зулаар алтран гэрэлтэх гантиг танхим дундуур камерлинго гүйж алдарт алтан хайрцаг хадгалдаг өрөө рүү хөтөлсөн шилэн хаалган зүг зорьжээ. *Юу хийгээд байгаа юм бол доо. Алтан хайрцаг тус болно гэж л бодоогүй байлтай билээ* хэмээн Ландон бодов. Камерлинго шилэн хаалгыг савж онгойлгоод, дотор нь оров. Алтан хайрцгийг тоосонгүй баруунтайгаар нь шурдхийн өнгөрлөө. Хайрцгаас цааш таван тохой хэртээ цаана сөхрөн сууж, газарт шигтгэсэн төмөр сараалжийг ховхлох гэж хүчилнэ. Ландон камерлингог хаашаа гүйж явсныг нь одоо л гадарлан бүр ч тэвдэв. Өө, бурхан минь. Шатаар хар эрчээрээ буун: «Эцэг минь, боль!» хэмээн хашхирлаа. Ландоныг шилэн хаалгаар орж ирэх эгшинд камерлинго хүнд төмөр сараалжийг өргөж аваад, хажуу тийш нь шалан дээр чихний хэнгэрэг дөжиртөл, тэсхийтэл жингэнүүлэн шидлээ. Цаана нь бүр ч доошоо хөтөлсөн нарийн шаттай цооног байлаа. Камерлинго тэр нүх рүү зүтгэх тэр эгшинд Ландон мөрнөөс нь татав. Мөр нь хөлсөндөө нэвтэрсэн болохоор, гар нь халтирсан боловч тогтоож чадлаа. Камерлинго давхийн цочиж: «Яаж байна аа?» гэв. Ландон нүдийг нь хармагцаа бараг л цочив. Камерлинго донгиотсон, бясалгасан биш харин ч хурц, шийдэмгий харагдана. Цээжин дээр нь байгаа шарх аймаар байлаа. «Эцэг минь! Та энэ доошоо ороод хэрэггүй. Бид эндээс гарах хэрэгтэй байна» гэж Ландон аль болох тайван хэлэх гэж оролдов. «Хүү минь!» гэж камерлинго жигтэй тайван хэлээд: «Би дөнгөж сая билэг үзлээ. Би мэдэж байна» гэв. «Камерлинго!» хэмээн Шартрон баахан хүмүүстэй хашхиралдан ирлээ. Тэд шатаар буун, өрөөний шилэн хаалгаар түлхэлдэн ирж, Макригийн камерын гэрэл өрөөг нилсхийтэл гийгүүлэн ирлээ. Шартрон газар байсан төмөр сараалжийг сугалаад авчихсаныг хараад, хирдхийн цочив. Өөрийгөө загалмайлан адислаад, Ландон руу камерлингог зогсоосонд нь талархан харлаа. Ландон ойлгож байв. Тэр сараалжийн цаана юу байдгийг мэдэх бөгөөд ер нь Ватиканы хаана нь юу байдгийг мэддэг болтлоо хангалттай уншсан билээ. Тэнд Христ шашны хамгийн дагшин газар байдаг. Terra Santa. Дагшин орон. Заримдаа Некрополис (үхлийн хот. Грек.), заримдаа Катакомбс гэнэ. Цөөн хэдэн гэлэнгийн үе улируулан үлдээсэн тэмдэглэлээс үзвэл, Некрополис гэдэг төөрсөн хүнийг залгиж орхидог газар доорх аймшигт цооног байлаа. Камерлингогийн араас хэн ч ийшээ орохооргүй билээ. «Эрхэм ээ» хэмээн Шартрон камерлингод хандан: «Та одоо шоконд орчихсон байна. Цөмөөрөө эндээс гарах хэрэгтэй. Та тийшээ орж болохгүй. Энэ чинь амиа хорлосон хэрэг шүү дээ» хэмээн учирлана. Камерлинго гэнэт амарлингуй дүртэй болчхов. Тэгээд, гараа аажуухан өргөж, Шартроны мөрөн дээр тавиад, өгүүлрүүн: «Чиний зовнил, зүтгэлд чинь гялайлаа. Яаж гэдгээ чамд хэлж чадахгүй. Ухаарч байгаа эсэхээ ч би өөрөө мэдэхгүй. Гэхдээ, би билэг үзсэн. Антиматери хаана байгааг би мэдсэн» гэлээ. Бүгд мэлэрч орхив. Камерлинго хүмүүс рүү эргэж хараад: «Энэ хадан дээр би сүмээ босгоно. Ингэж л хэлсэн. Ойлгомжтой байгаа биз дээ?» гэлээ. Ландон камерлингог бурхантай ярьсан гэдгийг ойлгосонгүй, бас яагаад тэр үг тийм ойлгомжтой байгааг ч ойлгосонгүй. *Энэ хадан дээр би сүмээ босгоно.* Есүс анх Петерийг шавиа болгохдоо, энэ үгийг хэлжээ. Энэ ер нь ямар хамаатай юм бэ? Макри улам ойртов. Глик шоконд орчихсон, чимээгүй зогсоно. Камерлинго маш хурдан тайлбарлав. «Иллюминати зэвсгээ энэ шашны тулгын нь чулуун дээр нуужээ. Сууринд гэсэн үг» гээд доошоо заав. «Энэ сүм, энэ шашин боссон тэр хадан дээр шүү дээ. Тэр хад хаана байгааг би мэднэ» гэлээ. Ландон камерлингог хүчээр дээш нь авч явах хэрэгтэй болжээ гэж бодов. Шийдэмгий мөртлөө ярьж байгаа нь утгагүй байлаа. *Хад?*

Шашин боссон тулгын чулуу? Өмнө байгаа цооног суурь руу биш, харин Некрополис руу аваачина. «Тэр үг чинь зүгээр л хэлц шүү дээ, эцэг минь. Ямар ч хад байхгүй». Камерлинго тун урамгүйхэн харлаа.»Хад бий, хүү минь, бий» гээд нүх рүү дахин зааж: «Pietro e la pietra» гэв. Ландон гялсхийн ухаарав. Ямар энгийн байгаа вэ гэж бодохоос голоос нь хүйт даана. Ландон тэр цооног руу харан зогсохдоо, энэ сүмийн доор гүнд булшилсан нэгэн зүйл хад байгааг ухаарлаа. Pietro e la pietra. Петер бол хад юм шүү дээ. Бурханд шүтсэн Петерийн сүсэг гүн бат бөгөөд Есүс Петерийг «хад» хэмээн нэрлэж, тэр хадны мөрөн дээр шашнаа мандуулна хэмээн өгүүлж байжээ. Энэ хадан дээр, Ватикан дов дээр Петерийг загалмайд хадаж, булшилсныг Ландон санав. Петерийн булшин дээр эртний христүүд жижиг сүм барьсан. Он цаг удаан, шашин түгэх хэрээр тэр сүмийн дээр сүм давхарлан барьсаар өнөөгийн энэ аугаа гайхамшигт ордон боссон билээ. Бүх шашин яг үнэхээр Гэгээн Петер дээр, хадан дээр босжээ. «Антиматерийг Петерийн булшин дээр тавьжээ» гэж камерлинго тод хурц хэллээ. Хэдийгээр бурхнаас авсан мэдээлэл гэх боловч бат нот логиктой байлаа. Гэгээн Петерийн булшин дээр антиматерийг тавьсан гэдэг илэрхий ажээ. Иллюмати дайснаа дарсны тэмдэг болгож, христийн шашны амин судас дээр бэлгэдлийн хувьд ч, бодитойгоор антиматерийг байрлуулжээ. Төгс нэвтрэлт. «Хэрэв та нарт нотолгоо хэрэгтэй байгаа бол» хэмээн камерлингогийн хоолой их л бачимдсан янзтай болж: «Би энэ сараалжийг түгжээгүй байхыг олсон юм» гэлээ. «Энэ сараалжийн цоожийг хэзээ ч тайлж байгаагүй юм. Нэг хүн энийг тун ойрмогхон онгойлгосон байна даа» гэлээ. Бүгд нүх рүү харлаа. Хормын дараа камерлинго гартаа тосон зул бариад, нээлхий рүү зүтгэж байв.

Хэсэг 119

Чулуун шат газрын гүн рүү огцом доошилж байв. *Би энэ доор үхэх юм байна л даа* хэмээн Витториа бодон бусдынхаа араас нарийн хонгил дагуулан тавьсан хүнд олс гартаа барин бууна. Ландон камерлингог доош буулгахгүй хорих гэсэн боловч Шартрон гарыг нь татан болиулжээ. Залуу харуул камерлинго юу хийж байгаагаа мэдэж байгаа гэдэгт итгэсэн байлаа. Ландон хэсэг зогссоноо камерлинго, Шартрон хоёрын араас мөр даран нүх рүү орлоо. Витториа зөнгөөрөө дагав. Тэд эгц доошилсон, олсон бариултай чулуун шатаар доошилно. Хазгай гишгэвэл, хальж үхэх нь лавтай. Тэртээ доор камерлингогийн барьсан тосон зул алтран харанхуйд гэрэлт цох шиг харагдана. Ард нь ВВС-ийн хоёр сурвалжлагч чихэлдэн орохыг сонсов. Камерын гэрэл ард нь нэлсхийсэн авч чанх урд нь яваа Витториагийн сүүдэр цооногийг халхлан, нүд гялбам гэрэл түнэр харанхуй сүүдэртэй сүлэлдэнэ. Гэхдээ, доор яваа Шартрон, Ландон хоёр харагдаж байлаа. Витториа энэ хоёр сурвалжлагчийг гайхна. Ийм мөчид, ийм дагшин, нууцлаг газар хүртэл камераа чирэн, бүхнийг ил задгай үзүүлж явах ийм увайгүй хүмүүс байх гэж. *Камераа унтраагаасай.* Гэхдээ, энэ камерын гэрэлд л хүн бүхэн хаана яваагаа харж байгаа гэдгийг саналаа. Хүмүүс ар араасаа гүйлдэн явах зуур, Витториагийн тархинд олон олон бодол солигдон явлаа. Камерлинго энэ доор юу хийх гээ юм бол? Антиматерийг оллоо гээд одоо яах билээ? Цаг үлдсэнгүй шүү дээ. Камерлинго зөв юм хийж байгаа байх гэсэн совин татаад байгаад Витториа өөрөө ч гайхна. Антиматерийг газрын гүнд гурван давхар доор тавьсан нь тун шударга, нигүүлсэнгүй явдал мэт. Z лаборатори шиг гүнд антиматери дэлбэрвэл аюул харьцангуй бага. Дулааны долгион, хэлтэрхийн үсрэлт гэж байхгүй, гадна байгаа хүмүүст

аюул бага: зүгээр л библьд өгүүлдэг шиг газар цөмрөн, цөмөрсөн газар руу нь ордон тэр чигтээ нурж унана. Колэр үүнийг тооцож энд тавьсан байх. Гэмгүй хүмүүсийг хохироохгүй гэж. Витториа захирлыгаа энэ хэрэгт оролцсон гэж итгэж өгөхгүй байлаа. Тэр шашныг жигшдэг, гэхдээ арай ч ийм аугаа хуйвалдааныг зохион байгуулах хүн биш. Колэр шашныг ингэтлээ зэвүүцдэг байсан гэж үү? Бүр Ватиканыг мөхөөж, алуурчин хөлсөлж, аавыг нь, дөрвөн кардинал, Паптай хамт хөнөөхөөр тийм их өширсөн байсан гэж үү? Санаанд багтахгүй юм. Тэгээд ч Колэр Ватикан хэрмэн дотор болж байгаа бүхнийг яаж зохицуулах билээ? *Рошер Колэрын Ватикан дахь тагнуул байсан* гэж Витториа өөртөө тайлбарлав. *Рошер Иллюминатус байсан.* Эргэлзээгүй. Рошер зангид бүх өрөөний түлхүүр, бүр Папын өргөө, Гэгээн Петерийн булш, il Passeto, Некрополисын, бүгдийнх нь түлхүүр байдаг байсан. Тэр өөрөө Гэгээн Петерийн булшин дээр антматерийг тавьчаад, Ватиканы хориотой хэсгүүдэд эрэл хийгээд хэрэггүй гэж тушаасан. Рошер хэн ч канистерыг олж чадахгүй гэж боджээ. *Гэхдээ, Рошер хэзээ ч бурхан камерлингод билэг үзүүлэх юм гэж тооцож чадахгүй.* Бурхны билэг. Энэ л Витториагийн дотор эргэлзээ, сүсэг хоёрыг тэмцэлдүүлж орхисон билээ. Бурхан нээрэн камерлинготой ярьсан гэж үү? Витториа үгүй гэдэгт итгэж байсан ч өөрөө хамааралт зөнг судалдаг физикчийн хувьд гайхамшиг гэдгийг шууд үгүйсгэж чадахгүй байлаа. Тэр өдөр болгон гайхамшигтай тааралддаг. Хоорондоо мянган бээрийн алсад байгаа хоёр лабораторьт тус тусдаа байгаа нэг далайн мэлхийн ихэр хоёр өндөг яг нэг эгшинд зэрэг хагардаг ... бүтэн нэг га талбайд тархсан далайн залхаг яг л нэг ухамсарт захирагдах мэт нэг хэмнэлээр хөдөлдгийг өдөр бүр хардаг билээ. *Нүднээ үл үзэгдэх хамаарлын хэлхээ энд тэндгүй байдаг* гэж бодно. Бурхан хүн хоёрын хооронд тэгвэл ..? Аав минь, надтай сүсгээ нэгтгэн хажууд байсан ч болоосой. Аав нь ариун хамаарал гэдгийг нэг удаа охиндоо эрдмийн хэлээр тайлбарлаж өгч, түүнд нь охин нь гүн бат итгэж билээ. Аавыгаа мөргөж байхыг хараад: «Аав аа, та яагаад дандаа ингэж мөргөдөг юм бэ? Бурхан танд хариу хэлдэггүй шүү дээ» гэж нэг удаа асууснаа, одоо ч тодхон санана. Леонардо Ветра бясалгаж сууснаа больж, охин руугаа эцэг ёсоор инээмсэглэн харна. «Охин минь өөнтөгч юм гээч! Чи бурхан хүнтэй ярьдаг гэдэгт итгэдэггүй юм уу? Тэгвэл би чиний хэлээр тайлбарлаж өгье дөө». Аав нь шүүгээн дээрээсээ хүний тархины загварыг авч, өмнө нь суугаад, өгүүлрүүн: «Хүн тархиныхаа чадавхын тун цөөн хувийг л ашигладаг гэж чи мэдэх байх. Гэхдээ, хүн бэрх нөхцөлд ормогц, жишээлбэл бэртэх, хэт их айх, хэт их баясах, гүнзгий бясалгах ч юм уу, тэгэхэд хүний мэдрэл гэнэт бүгдээрээ цочирдон, оюун ухаан нь хөвчирч бүхнийг гэв гэнэт ухаараад ирдэг». «Тэгээд юу гэж?» гэж Витториа өөнтөглөн: «Оюун хөвчирч, юмыг сайтар ойлгоно гэдэг чинь бурхантай ярьж байгаа хэрэг биш шүү дээ» гэв. «Пээх» гэж аав нь дуу алдсанаа: «Ингэж оюун нь хөвчирч, бүх юм тодорхой болоход л бэрх асуудлын зөв хариулт дандаа олдоод байдаг. Үүнийг Буддын лам нар дээд ухаарал гэдэг. Биологичид ондоошсон төлөв гэдэг. Сэтгэлзүйчид болохоор хэт мэдрэмж гэдэг. Харин христүүд үүнийг хариу авсан мөргөл гэдэг» гээд нүүр дүүрэн инээмсэглээд: «Тэгэхээр ариун илчлэл гэдэг заримдаа зүгээр л зүрх чинь мэдэж байгаа тэр зүйлийг олж сонсохын тулд тархиа тохируулах төдий зүйл байх нь ч бий» гэжээ. Газрын гүн рүү алхаж явахдаа, аав зөв ярьж байсан юм болов уу гэж Витториа бодно. Биеийнх нь өвдөлт, цочролын улмаас камерлинго гэнэт антматерийг хаана тавьсан байж болох тухай оньсогыг тайлчихсан байж болох л юм. *Хүн нэг бүр бурхан байдаг* гэж Будда сургажээ. *Бид бүхнийг мэднэ. Тиймээс зөвхөн оюун ухаанаа сонсохын тулд сэтгэлээ нээх хэрэгтэй.* Витториа газрын гүн рүү алхаж явах тэр эгшинд оюун нь хөвчрөн, оюун ухаан нь хөвөн гарч ирж, бүх юмыг нэгэн эгшинд ухаарлаа. Камерлинго юу хийх гэж байгааг тэр гэнэт мэдрэв. Тэгмэгцээ урьд нь айж байгаагүй ихээр айлаа. «Камерлинго боль!»

гэж Виттория цооног нэг орилов. Ватикан хийдийг тойроод зогсож байгаа олныг санамагц, хамаг бие нь хөшчих шиг боллоо. «Та антиматерийг дээш нь гаргачихвал тэнд байгаа бүх хүн үрэгдэнэ шүү дээ!» гэлээ. Ландон нэг алхахдаа гурван шат алгасан бууж байлаа. Цооног давчуу байсан ч кластрофоб нь хөдөлсөнгүй. Кластрофобын айдсаас илүү айдас нүүрлэн байв. «Камерлинго, та антиматерийг тэнд нь орхи. Өөр арга байхгүй» гэж Ландон туяарах гэрлийг зүглэн доошилсоор хэлэв. Энэ үгийг хэлж байхдаа тэр үүндээ бас төдий л итгэхгүй байв. Ингэж хэлснээрээ тэр камерлинго бурхантай ярьсныг зөвшөөгөөд зогсохгүй, хүн төрөлхтний уран барилгын дурсгал болсон Гэгээн Петерийн ордон, дотор нь байгаа мянга, мянган гайхамшигт урлагийн бүтээлийг устгаж болно гэж зөвшөөрч байгаа хэрэг байлаа. *Гэхдээ гадаа байгаа хүмүүсийн төлөө бол ... өөр арга үгүй.* Хүмүүсийн амийг аврах цорын ганц зам бол энэ гайхамшигт барилгыг устгах явдал болжээ. Иллюминатигийнхан энэ бэлгэдлийг устгасандаа ямар их додигор байх бол. Цооног дотор өмхий үнэртсэн, хүйтэн байлаа. Тэртээ дор Гэгээн Петерээс эхлээд эртний олон христүүдийг оршуулсан некрополис байв. Ийшээ очиж яваа нь амиа хорлосон хэрэг биш байгаасай гэж Ландон залбирна. Гэнэт камерлинго зул барьсаар зогсов. Араас нь Ландон бараг л мөргөх шахлаа. Шатны доод хэсэг сүглийн харагдана. Гурван гавал товойлгон дүрсэлсэн давгмал төмөр хаалга шатны доор зам хаан, сүндэрлэнэ. Камерлинго тэнд хаалга онгойлгох гэж татаж байлаа. Ландон араас нь гүйж ирээд түлхэн хааж, замыг нь хаан зогсов. Бусад нь ар араасаа түрхрэлдэн ирж, бүгдээрээ ВВС-ийн камерын гэрэлд цонхийсон цагаан харагдаж байв. Ялангуяа, Глик ард нь дурамжхан байсныг хэлэх ҮҮ бүр ч илүү цонхийсон үзэгдэнэ. Шартрон Ландоны гарыг зуурч: «Камерлингог оруул» гэлээ. «Үгүй шүү!» хэмээн тэр дээрээс Виттория хашхиран бууж ирэв. «Цөмөөрөө эндээс шалавхан гарах хэрэгтэй. Та антиматерийг эндээс авч гарч болохгүй. Тэгвэл, гадаа байгаа бүх хүн үрэгдэнэ шүү дээ» гэлээ. Камерлинго гайхалтай амарлингуй хэлэв. «Та нар бүгд... бид бүгдээрээ сүсэглэх хэрэгтэй. Цаг бага үлдээд байна шүү». «Ойлгохгүй байна. Газар дээр дэлбэрэх нь энд дэлбэрэхээс хэдэн мянга дахин аюултай шүү дээ» гэж Виттория асуув. Камерлинго амгалан ногоон нүдээрээ бүсгүйн сэтгэлийг нэвт уяраан харав. «Газар дээр дэлбэрэлт болно гэж хэн хэлээ вэ?» гэв. Виттория алмайрч орхив. «Та энийг энд нь үлдээх гэж байгаа юм уу?» Камерлинго бүр гайхмаар итгэл төгс байв. «Өнөө шөнө дахиад хэн ч үхэхгүй». «Эцэг минь, гэхдээ» «Гуйя... сүсэглэгтүн!» гээд камерлинго гүнзгий амьсгаа аваад өгүүлрүүн: «Би та бүхнийг надтай хамт бай гээгүй. Та бүхэн чөлөөтэй явж болно. Би зүгээр л бурхныг заасныг бүү зөрчүүлээч гэж гуйж байна. Намайг хий гэж тушаасныг нь гүйцэлдүүлэхийг болгооно уу». Тэгээд их л шийдэмгий байртай: «Би энэ шашныг аврах гэж байна. Би чадна. Утсан чинээ улаан амиараа андгайлъя». Аниргүй мэт боловч сэтгэлд аянга буух шиг санагдав.

Хэсэг 120

Арван нэгэн цаг тавин нэгэн минут. Некрополис гэж үнэхээр Үхлийн хот ажээ. Ландон энэ тухай олон уншсан ч бодсоноос шал өөр, санаа алдмаар байлаа. Агуйн шалан дээр барьсан гэмээр байшин шиг жижиг бунхнаар газар доорх энэ уудам хөндий дүүрчээ. Үхширсэн агаар үнэртэнэ. Тоосго өрж, гантиг хавтангаар хучсан бунхан, шарил элэгдэн нуржээ. Дундуур нь жигтэй нарийн жим зурайна. Элэгдэж нурсан энэ тосгоны шороон саарал харанхуй тэнгэрийг тулан овоолсон шороо шиг багана сүндэрлэнэ. *Үхлийн хот* хэмээн Ландон бувтнан, эрдмийн хүний сонь, ерийн хүний айдас хоёртоо автана. Бусадтайгаа хамт сул шороо пургисан жимээр хамт явлаа. *Би буруу газраа ирсэн юм болов уу.* Шартрон камерлингод сүсэглэж явдгаа илтгэн, хамгийн түрүүнд урагшлан, төмөр хаалгыг түүнд нээж

өглөө. Глик, Макри хоёр гэрэл гаргаж өгөхийг хүссэн камерлингод нэр төртэй ээ зөвшөөрсөн боловч хэрэв энэ дотроос амьд гарч ирвэл зүй ёсоор оногдох сайшаалд горьдсон - зөвшөөрсөн сэдэл нь сайхан сэтгэлийнх гэхэд хэцүү л байлаа. Витториа хамт явахдаа хамгийн дурамжхан байсан агаад нүдэнд нь жинхэнэ эмэгтэй хүний тэвдэж балмагдсан зөн харагдахыг Ландон анзаарлаа. *Тэртээ тэргүй оройтсон* гэж Ландон бодоод, Витториагийн гараас хөтлөн, бусадтайгаа хамт алхлаа. *Бид шийдчихсэн хүмүүс ажээ.* Витториа чимээгүй байсан ч яг ижил юм бодож яваагаа Ландон мэдэж байлаа. *Камерлингогийн буруу байвал есөн минут гэдэг Ватиканаас зугтан одоход хэтэрхий бага хугацаа.* Ландон гүйж явахад хөл нь цуцаж, бусад нь харин өөдөө нэлээн урагштай явж байхыг гайхасхийн харлаа. Учрыг нь олмогц дотор зарсхийв. Хөл доор нь Есүс Христ аж төрж байх үеийн газар тэр чигтээ байлаа. Тэд жинхэнэ Ватикан дов руу өгсөж байв! Ватиканы судлаачид дандаа Гэгээн Петерийн булш Ватикан довны орой дээр байдаг гэж ярихыг олонтаа сонсож байсан ч тэд яаж мэдээд байгааг нь гайхдаг байв. Одоо л ойлголоо. *Тэр Ватикан дов гэдэг чинь эндээ байж л байгаа юм байна шүү дээ.* Ландонд түүхийн номын хуудсан дундуур гүйж явах шиг санагдана. Тэр довны дээр хаа нэгтээ Гэгээн Петерийн булш - Христийн шашны цөм бий. Булш нь эхэндээ жижиг бунхан төдийхөн байжээ. Петерийн сүр нөлөө дэвжихийн хэрээр гадуур нь том сүм барин барьсаар одоо дээшээ 440 тохой болж, Микланжелогийн барьсан хүнхэр орой, алтан ганжир нь булшнаас эгц дээшээ хуруу хүрэхгүй зөрүүтэй сүндэрлэнэ. Тэд нарийн мурилзсан жимээр дээшээ өгссөөр. Ландон цагаа харав. Найман минут. Витториа тэр хоёр энэ хөндийд л дуусах нь дээ хэмээн бодов. «Болгоомжтой! Могойн үүр байна шүү!» хэмээн Глик хашхирлаа. Ландон амжиж харвал, жижиг жижиг нүх замыг нь тойрон хаа нэгтээ онгойн харагдана. Нэгэн дээгүүр нь үсрэн гарлаа. Витториа ч бас үсрэн гарахдаа, нэгэн дээр нь бараг гишгэх шахлаа. Бүсгүй ойр тойрноо тэвдэнгүй харж: «Могойн үүр юм уу?» гэлээ. «Уул нь ч хүнсний гуурс л даа» гэж Ландон хэлээд: «Гэхдээ чи мэдээд хэрэггүй, итгэж үз» гэлээ. Тийм нүхийг хооллох сүв гэдэг ажээ. Эртний христүүд хүний махан бие амилдаг гэж итгэдэг байсан болохоор тэр нүхээр үхсэн хүнийг тэжээх гэж сүү, зөгийн бал дусаадаг байжээ. Камерлинго ядарч байлаа. Бурхан хийгээд хүн төрөлхтний өмнө хүлээсэн үүргээ ухамсарламагц хөл нь гуйвахаа болин, шинэ эрчээр хурдална. Бараг л хүрлээ. Бие нь аймаар өвдөнө. Хүний сэтгэл биеэсээ илүү өвчин даадаг гэдэг дээ. Гэхдээ л ядарч байв. Цаг тун бага үлдлээ. «Би таны шашныг аварна. Эцэг минь. Тангараглая!» ВВС-ийн камерын гэрэл араас нь тусч байгаад баярлаж байсан ч тэр тосон зулаа өндөр өргөн явна. *Би харанхуйг гийгүүлэх зулын гэрэл. Би гэрэл.* Гүйж явахад нь зулын тос цалгих бөгөөд тос асгарч, өөрийг нь түлж орхих вий хэмээн эмээнэ. Энэ шөнө арьс махаа түлж хаширчхаад байлаа. Довны оройд гарах үедээ камерлинго хөлсөндөө нэвчиж, арай гэж амьсгалж байлаа. Тэгээд, хяр дээр гармагцаа, дахин төрсөн мэт болов. Довны хяр дээрх дэвсэг дээр өмнө нь хэдэнтээ ирж байсан газраа дахин ирлээ. Зам энд дуусжээ. Некрополис гэнэт шороон хананд хүрээд дууслаа. Тэнд Mausoleum S. гэсэн жижиг үсэг байлаа. La tomba di San Pietro (Гэгээн Петерийн булш. ита). Шороон хананд бүсэлхий тушаа газар нэг нүх байлаа. Ямар ч пайзгүй, зул ч үгүй, зүгээр л нэг нүх, цаана нь өмхөрсөн ганц авс л байлаа. Тэр нүх рүү камерлинго шагайж хараад, баясан инээвхийлнэ. Араас нь бусад нь гүйцэж ирэхийг тэр сонсов. Хажуудаа тосон зулаа тавиад, бурханд дахин мөргөлөө. *Баярлалаа, бурхан минь! Бараг л дууслаа.* Гадаа хүн дүүрэн талбайд, кардиналуудын дунд Мортати кардинал тэртээ газрын гүнд болж байгаа явдлыг нэгд нэгэнгүй харуулах дэлгэцийг ширтэнэ. Юунд итгэхээ мэдэхгүй болчихсон байлаа. Түүний харж байгааг энэ дэлхий цөмөөрөө харж байгаа гэж үү? Бурхан үнэхээр камерлинготой ярилаа гэж үү? Үнэхээр тэр антиматери Гэгээн Петерийн шарилын дэргэд «Хар даа!» хэмээн

олон түмэн шуугилдлаа. «Тэнд байна!» хэмээн хүн болгон дэлгэц рүү заана. «Энэ бол гайхамшиг!» Мортати дээшээ харав. Камер савж хөдлөөд, дүрс нь тогтохгүй байсан ч юу харуулж байгаа нь тодорхой байлаа. Насандаа мартахгүй мөч. Камерлинго шороон дээр суучихсан мөргөж байгааг араас нь харуулж байлаа. Өмнө нь байгаа ханан дээр нэг нүх байх ажээ. Тэр нүхэн дотор эртний нуранги чулуун дунд өгөрсөн авс харагдана. Тэр авсыг Мортати энэ насандаа ганц л удаа харсан боловч хэнийх болохыг нь лавгай мэдэж байлаа. San Pietro. Христийн шашны хамгийн нандин зүйлийг олж харсандаа энэ олон түмэн бишрэн, баясч давалгаа нүргэлэх мэт шуугисан гэвэл эндүүрэл билээ. Мортати тийм ч гэнэн биш. Гэгээн Петерийн шарил энэ олон хүний сөхөрч мөргөх зүйл биш байлаа. Шуугиулаад байгаа зүйл шарилын дээр нь тавиастай байв. Антиматерийн канистер тэнд байлаа. Тэр бүхэл өдөржин байсан газартаа... некрополисын харанхуй дунд нуугдан байлаа. Урвуу тоолон, үхэл дуудсан хэвээр гөлийнө. Камерлингогийн зөв байжээ. Мортати тэр тунгалаг цилиндрийг мэлрэн зогсоно. Өнгөгүй цагаан бөмбөлөг голд нь хөвсөн хэвээр. Канистер байгаа тэр нүх үхэл айсуу сүүлийн таван минутыг тоолох бүрт улаан өнгөөр анивчина. Шарилын дээр канистерын хажууд, Швейцар жардын хяналтын камер хэвтэж канистерыг чиглэн, дүрсээ нэвтрүүлсээр. Мортати өөрийгөө загалмайлан адислав. Энэ насандаа үзсэн хамгийн аймшигт дүрс энэ байлаа. Гэхдээ хормын дараа энэ байдал бүр ч муудлаа. Камерлинго гэнэт бослоо. Тэгээд, антиматерийг аваад бусдынхаа зүг гүйв. Нүүрийг нь дэлгэц дүүрэн харуулж байлаа. Тэр бусдыгаа холдуулаад, некрополисыг уруудан, ирсэн зүг рүүгээ буцаад гүйлээ. Камер Витториа Ветра дээр тусав. Бүсгүй тэвдсэн янзтай харагдана. «Та хаачихна вэ, камерлинго? Та хэлэхдээ ...» «Сүсэглэгтүн!» хэмээн камерлинго гүйнгээ хашхирлаа. Витториа Ландон руу эргэн: «Одоо яах вэ?» гэв. Ландон камерлингог зогсоох гэж оролдсон боловч, Шартрон дундуур нь орж саатууллаа. Залуу эр камерлингод бүрэн итгэжээ. ВВС-ийн камераас ирж байгаа дүрс бартаат замаар явж байгаа бололтой, эргэлдэн, доргин хөдөлнө. Оршуулгын цуваа шиг явж байсан тэр хүмүүс тэвдэн сандарч, харанхуй сүүдэр дундуур эргээд, некрополисын үүд рүү гүйлдэв. Талбай дээр Мортати айх гайхах зэрэгцэн зогсоно. «Тэр одоо тэрийгээ нааш нь авчрах нь ээ?» Бүх дэлхийн зурагтаар шууд гэхэд дэндүү шууд нэвтрүүлгээр камерлинго антиматерийг гартаа барьчаад, некрополисоос амьд ертөнц рүү чиглэн, өгсөж явлаа. «Өнөө шөнө дахиад хэн ч үхэхгүй». Камерлинго худлаа хэлж байгаа юм шиг байлаа.

Хэсэг 121

Камерлинго Гэгээн Петерийн ордны гулдан хаалгаар яг 11:56-д гарч ирлээ. Тэрээр бүх дэлхийн гайхшруулан, антиматерийг бурханд өргөх ариун тахил шиг урдаа барьчаад, бүхний нүдний өмнө гүйж явна. Хагас нүцгэн, цээжиндээ шархтай тэрээр хар эрчээрээ гүйж яваагаа талбайд босгосон аварга том дэлгэцүүд дээр харж болох байлаа. Гэгээн Петерийн талбайд хурсан олны чимээ - уйлсан, хашхирсан, залбирсан, мөргөсөн - зүсэн зүйлийн чимээ баясал, айдас хоёрыг зэрэг илэрхийлсэн жигтэй сонсогдоно. *Биднийгээ нүглээс тонилгож хайрла* хэмээн залбиран гүйсээр. Некрополисоос ирэх замдаа, камерлинго дэмийрчихсэн юм шиг байв. Одоо сүйрэх нь тодорхой боллоо. Роберт Ландон, Витториа Ветра хоёр түүнийг зогсоож, антиматерийг газрын гүнд нь хаяад, дээшээ гаргахыг оролдсон ч бүтсэнгүй. *Сохор тэнэгүүд!* Камерлинго өөр өдөр сөн бол хэзээ ч ингэж чавхдан гүйж чадахгүй сэн билээ. Гэхдээ, өнөө шөнө бурхан түүнтэй хамт байлаа. Роберт Ландон камерлингог хориглох гэж оролдсон ч камерлингод чин сүсгээрээ хэзээд үнэнч, итгэлт Шартрон Ландоныг хориглосон. Сурвалжлагч нар саад болж чадахааргүй их ачаатай явж байв. *Бурхан шидээрээ өршөөдөг билээ.* Араас нь нөгөө хэд нь гарч ирэхийг камерлинго дэлгэц дээрээс харлаа. Сүүлийнхээ

хүчийг шавхан байж антиматерийг толгой дээрээ өргөн гүйнэ. Тэгээд, Иллюминатид тамгалуулсныхаа хариуг авахаар гараа савлан, шатны уруу улам ч хурдан чавхадлаа. Одоо хийх юм ганц л байна. *Шидийн юм шиг л хурдан байх хэрэгтэй. Дөрвөн минут...* Ландон цуцаж ядарсандаа ордноос яаж гарснаа санахгүй шахуу байв. Хэвлэлийнхний хурц гэрэл дахин нүдийг нь гялбуулна. Камерлингогийн дүрс чанх урд нь хар эрчээрээ гүйж явахыг л харж байв. Хэвлэлийнхний прожекторын гялбам гэрэлд камерлинго дахиад л тунгалаг болж, гэрэлтэх мэт. Урагдсан дээл нь яг л нөмрөг шиг, банзал шиг харагдана. Дайсандаа тамлуулсан ч тэссээр явна. Камерлинго чигээрээ гүйсээр, хүмүүсийг сүсэгтэй байхыг уриалсаар, гартаа үхлийн зэвсэг барьчаад олны зүг гүйнэ. Ландон араас нь гүйсээр. *Энэ юу хийгээд байгаа юм бол? Тэр хүмүүсийг бүгдийг нь хороох гээ юу?* «Сатааны бүтээлд бурхны сүмд байх газар үгүй!» хэмээн хашхирсаар, олныг түйвээн гүйнэ. «Эцэг минь! Явах газар байхгүй шүү дээ» гэж Ландон араас нь хашхирлаа. «Тэнгэр рүү хар! Бид дандаа тэнгэрээ мартчих юм». Тэр эгшинд Ландон камерлинго хаашаа явж байсныг ухаарч, ариун дээд үнэн түүнийг бүчин авлаа. Тэр яг яасныг тодорхой хараагүй авч гадарлаж, аврал тэнгэрт байгааг мэдэв. Од дүүрэн Италийн тэнгэр. *Аврах гарц.* Камерлингог эмнэлэгт хүргэхээр дуудсан нисдэг тэрэг урд нь зогсч, дотор нь нисэгч нь суучихсан, харин сэнс нь зогсож байлаа. Камерлингог тийшээ гүйж очиход, Ландоны сэтгэл гэнэт догдлов. Дотор нь элдэв бодол үерийн ус шиг түрэн ирэв. Эхлээд Газар дундын өргөн удам тэнгис санаанд нь буув. Ингэхэд, хэр хол билээ, тэр чинь? Таван бээр үү, арван бээр рүү? *Fuimosino* эрэг хүртэл галт тэргээр долоо орчим минут явдаг сан. Нисдэг тэргээр хэр удаан явах бол? Цагт 200 км-ийн хурдтай, зогсохгүй явахад яах бол? ... Хангалттай хол очиж шидчихээд, наашаа буцаж ирнэ гэхээр ... Гэхдээ өөр бас хувилбар байгааг санах. Урагшаа бараг л жингүй юм шиг гүйлээ. *La Cava Romatia!* Гантиг хадаар дүүрсэн энэ газар Ромын хойхно гуравхан бээрийн зайд бий. Хэр том билээ? Хоёр ам дөрвөлжин бээр байх. Гэхдээ, яг одоо бол хүнгүй байгаа нь лавтай. Тэнд канистерыг хаявал ... «Бүгд гэдрэгээ!» хэмээн камерлинго хашхирна. Гүйж явахад нь цээж нь өвдөнө. «Холд! Холдоорой!» Камерлинго тэднийг чиглэн ирэхэд нь нисдэг тэрэгний хажууд зогсч байсан Швейцар жардууд мэлэрч орхив. «Гэдэргээ!» хэмээн дахин хашхирлаа. Харуулууд тал тал тийшээ холдов. Камерлинго нисэгчийн бүхээг рүү гүйн очиж, хаалгыг нь онгойлгоод: «Хүү минь, буу! Бушуул!» гэхийг бүх дэлхий харан гайхаж байлаа. Нисэгч үсрэн буулаа. Камерлинго бүхээг нэлээн дээр, тийшээ гарахын тулд хоёр гараараа зуурч өгсөх хэрэгтэйг харж байснаа, ард нь чичрэн зогсоо нисэгч рүү эргэж хараад, канистераа бариуллаа. «Барьж бай. Намайг орохоор өгөөрэй!» гэв. Камерлинго бүхээгт үсрэн орох зуур Роберт Ландон хойноос нь хашхичин гүйж явааг харав. *Одоо чи ойлгов уу? Одоо чи бишрэв үү?* Камерлинго нисэгчийн суудалд сууж, зарим нэг төхөөрөмжөө тохируулаад салхивчаар шагайж канистер руугаа сарвайлаа. Нисэгч гар хоосон зогсч байв. «Тэр авчихлаа». Камерлинго гэнэт түгшин: «Хэн?» гэж асуув. «Тэр» гээд нисэгч гараараа заалаа. Роберт Ландон канистер ямар хүнд байсныг гайхна. Ландон гүйж нисдэг тэрэгний нөгөө талд гараад, хэдхэн цагийн өмнө Витториатай хамт сууж байсан арын суудал дээр үсрэн гарлаа. Хаалгаа онгорхой орхиод, бүсээ бүслэв. Тэгээд өмнөө нисэгчийн суудал суугаа камерлинго руу хашхирлаа. «Нисээрэй, эцэг минь!» Камерлинго Ландон руу эргэж харвал царай нь байдгаараа цонхийчихсон байв. «Чи яаж байгаа нь энэ вэ?» «Та нис! Би хаяя!» гэж Ландон хэлээд «Цаг алга аа! Зүгээр л энэ ариун нисдэг тэргээ бариад нис!» гэлээ. Камерлинго хэсэг зогтусахад ард нь гялбалзах хэвлэлийнхний гэрэлд нүүр нь сүүдэртэнэ. «Би энийг ганцаараа хийж дөнгөнө. Би энийг ганцаараа хийх ёстой юм». Ландон сонсохгүй байв. «Нис ээ, нис!» хэмээн хашхирлаа. *Би танд туслах гэж байна аа* гэснээ цагаа харснаа гацасхийлээ. *Эцэг минь, гурван минут.*

Гурван минут дутуу байна. Гурван минут дутуу байна гэдгийг сонсоод, камерлинг эргээд ухаанаа олох шиг болов. Эргэж хараад, нисдэг тэргээ жолоодлоо. Сэнс нь хүрхэрсээр дээшээ хөөрөв. Эргэлдэх тоосон дотор Витториа гүйж явааг Ландон харлаа. Тэр хоёрын харц тулгарсны дараа бүсгүй яг л чулуу шиг шалан дээр туялганан уналаа.

Хэсэг 122

Нисдэг тэрэг дотор моторынх нь дүнгэнээ, хаалгаар шуурах салхины улианд Ландон чих дүлийрэх шахав. Камерлинг машинаа дээш огцом хөөргөхөд, Ландоныг татах хүч өгзгөөс нь хавтгай болтол татах шиг боллоо. Гэгээн Петерийн талбай дахь гэрэл нэг хэсэг орчин тойрныг нь нэвт гэрэлтүүлж байснаа Ромын олон гэрэл дунд аажим шингэв. Ландон антимаатерийн канистерыг гараараа тас атгасан байлаа. Атгах тусам алга нь хөлс, цусанд нэвчин халтирамтгай болох шиг. Канистер дотор антимаатерийн бөмбөлөг дусал тайван гэгч байрандаа эргэлдсээр, шингэн дэлгэц дээрх цаг урвуу тоолох үед, тод улаан гэрэл бүхээгийг нэлс хийлгэн гэрэлтүүлнэ. «Хоёр минут үлдлээ!» хэмээн Ландон камерлинг руу хашхирахдаа, ингэж дээшээ хөөрөөд, хаана антимаатерийг хаях гэж байгаа юм бол хэмээн гайхаж байлаа. Хотын гэрэл доор нь дөрвөн зүг найман зовхист нэлэнхий гэрэлтэнэ. Өрнө зүгт Газар дундын тэнгисийн хаяа үзэгдэв бололтой хотын нэлэнхий гэрлийг тас хярган хав харанхуй, хоосон нүүгэлтэн үзэгдэв. Тэнгис Ландоны бодож байснаас хол ажээ. Эргийн дагуу нягтарсан гэрлийг харвал, тэнгист хаясан бөмбөгний арван килотонн тэсрэлтээс үүссэн аймшигт том цунами энэ хотыг баруун хатавчнаас нь үерлэн урсгах тухай бодсонгүй. Ландон бүхээгийн цонхоор урагшаа харвал, гэнэт найдлага төрлөө. Чанх урд нь шөнийн тэнгэрт Ром хотын дунд орших нэгэн уул аниргүйхэн дүнсийнэ. Тэр уулын бэлээр цэг шиг жижиг гэрлүүд энд тэнд анивалзах нь баячуудын дүүрэг байлаа, харин бэлээсээ цааш нэг бээрийн цаана түнэр харанхуй ноёлох ажээ. Тэртээд нэг ч гэрэл үгүй - тас харанхуй. *Чулуун уурхай* хэмээн Ландон бодов. *La Cava Romana!* Хотын дунд дүнсийх тэр харанхуй уулыг харвал боломжийн талбайтай, бас ойрхон санагдлаа. Тэнгисээс ч ойрхон. Баясал огшоод явчихлаа. Камерлинг антимаатерийг тийшээ л аваачъя гэж бодсон юм байна л даа! Нисдэг тэр тийшээ чиглэнэ. Гэтэл сэнс хүрчигнэн, онгоц хөөрөх хирээр тэр уул ойртох биш харин ч жигтэй еэ холдох ажээ. Ландон гайхаад, доошоо хяламхийн харлаа - айх гайхах хоёр нь бүр ч нэмэгдэв. Мянга мянган тохой доор, яг эгц доор нь хэвлэлийнхний гэрэлд нэлийх Гэгээн Петерийн талбай гялтайна. *Бид хоёр чинь Ватиканы дээр хэвээрээ байна шүү дээ!* «Камерлинг! Урагшаа яв. Бид хоёр хангалттай өндөр авчихлаа. Урагшаа явах хэрэгтэй. Энэ канистерыг Ватикан дээр хаяж болохгүй шүү дээ!» гэж Ландон камерлинг руу хашхирлаа. Камерлинг дуугарсангүй, нисдэг тэргээ жолоодоход л хамар анхаарлаа хандуулсан харагдав. «Хоёр хүрэхгүй минут үлдээд байна» хэмээн Ландон хашхираад: «Харж байна уу? Урд *La Cava Romana* байна. Хойшоогоо хэдхэн бээрийн зайд. Хоёулаа...» «Үгүй шүү!» гэж камерлинг хэлэв. «Хэтэрхий аюултай юм байна. Уучлаарай!» гэлээ. Нисдэг тэрэг дээшээ хөөрнө. Камерлинг Ландон руу эргэж харж, эмгэнэнгүй инээмсэглээд: «Анд минь, чи ийшээ орж ирээгүй байсан бол дээр байсан юм. Би бүх юмаа зольсон юм шүү дээ» гэлээ. Ландон камерлингогийн шийдсэн шинжтэй, ядрангүй харцыг ширтэн ... гэнэт ухаарлаа. Цус нь царцаад, эргэхээ больчих шиг болов. «Гэхдээ нэг тийшээ явж болно шүү дээ!» «Дээшээ!» гэж камерлинг хэлээд, дуу нь чангаран: «Ганц гарц тийшээ л байна» гэв. Ландон алмайрч орхив. Камерлингогийн санааг

мань хүн буруу ойлгожээ. Тэнгэр рүү л хар! «Тэнгэр рүү л явж байж шүү дээ» гэж Ландон ухаарав. Камерлинг антиматерийг доошоо хаях гэж огт бодоогүй ажээ. Нисдэг тэрэг хөөрч болох хамгийн дээд өндөр рүү Ватиканаас аль болох холдохыг бодож байжээ. Энэ бол буцах замгүй аян байжээ.

Хэсэг 123

Гэгээн Петерийн талбайд Витториа дээшээ гөлийн зогсоно. Нисдэг тэрэг хөөрсөөр харанхуйд уусав - хэвлэлийнхний прожектор гүйцэж гэрэлтүүлэхээ ч болилоо. Хүрчигнэсэн моторынх нь чимээ хүртэл сонсогдохтой, үгүйтэй алсад дүнгэнэнэ. Бүх дэлхий даяар ... хүн бүхэн ... сүсэг бүхэн ... зүрх бүхэн ... нэгэн зүгт - дээшээ тэнгэр рүү ширтэн, хүзүүгээ хугалчих вий гэлтэй өлийн ав аниргүй амьсгаа даран хүлээнэ. Витториагийн сэтгэл өмрөн өвдөж, гансралын туйлд хүрчээ. Нисдэг тэрэг хөөрч алга болоход, тэнгэрт Ландоны царай тодроно. *Тэр юу бодоо юм бол? Ухаараагүй юм байх даа?* Талбай дээрх зурагтын бүх камер дээшээ харанхуй руу онилжээ. Далай мэт олон хүн дээшээ хараад хором мөч бүрийг чив чимээгүй тоолон хүлээнэ. Бүх зурагт ... Ром хотын одот тэнгэрийг үзүүлнэ. Витториагийн нүд нулимсаар дүүрлээ. Бүсгүйн ард гантиг шатны хажууд 161 кардинал тэнгэр рүү дуу чимээгүй мэлрэн зогсоно. Зарим нь алга хавсарчээ. Дийлэнх нь хөшсөн мэт хөдөлгөөнгүй. Зарим нь уйлна. Чаг чагхийн хором бүр элс шиг асгаран урсана. Гэр, бар, ажил, онгоц буудал, эмнэлэг - хаа сайгүй сүнс бүр дэлхий даяар нэгдэн аугаа их үйлийн гэрч болно аниргүй хүлээнэ. Эр эм хос гар гараа атгалцжээ. Зарим нь үр хүүхдээ энгэртээ наажээ. Time seemed to hover in limbo, souls suspended in unison. Цаг хугацаа хаа байгаа нь мэдэгдэхгүй, сүнс далайд Гэнэт, Гэгээн Петерийн ордны хонх дайны харанга шиг аймшигтай яа донгинов. Витториагийн хадар даган нулимс гүйнэ. Тэгээд л, бүх дэлхий харж байтал, цаг дууслаа. Хамгийн аймшигтай нь бүх зүйл огт аниргүй болж өнгөрөв. Ватикан хийдийн эгц дээр тэртээ холд цэг шиг гэрэл гялбана. Хормын дараа хэн ч хэзээ ч үзээгүй цэв цэвэрхэн, цав цагаан гэрэл нэлсхийв. Айж байсан, хүлээж байсан юм боллоо. Жижиг цагаан од шиг гэрэл гэнэт тэлж томрон томорсоор, ойртон ойртсоор, тархан тархсаар хормын төдий орчлонг тэр чигт бүрхэн авлаа. Нэлийсэн цагаан гэрэл аянгын хурдаар шөнийн харанхуй тэнгэрийг өдөр мэт саруул гэгээгээр гийгүүлсээр, тэртээ дээрээс хүмүүсийн зүг айсуу. Олны царай аймшигт автан цонхийж, нэлийсэн гэрэлд үхсэн мэт цайран харагдах агаад гялбасан хурц туяанаас нүдээ халхлан, сүүлийнхээ амьсгалын нэгэн зэрэг авах шиг эхэр татацгаав. Гэрэл энэ хорвоог хучин авах тэр эгшинд бурхны хүслээр болов уу гэлтэй хэний ч хэзээ ч бодож байгаагүй зүйл боллоо. Нэлийсэн гэрэл урсан ирснээ гэнэт хана мөргөсөн мэт зогсчхов. Тэсрэлт шилэн цонхны цаана болж байгаа гэлтэй. Цацраг нь хүрэх ёстой тэр газраа хүрээд цаашаагаа гүйх эсэхээ тээнэгэлзэн зогсох шиг. Сар дэлхийд ороод ирчих шиг нэлийсэн цагаан гэрэлт бөмбөлөг Ромын тэнгэрт хөвөлзөнө. Шөнө өдөр мэт гэрэлтэнэ. Тэгээд цохилтын долгион ирлээ. Цохилт хүчтэй, гүнзгий, сүнс зайлмаар аймшигтай. Чөтгөр тамаас тургих шиг хавь ойрыг сэгсчин, тоос шороо босгон, хуй май болж Ватикан хийдийн боржин суурийг хүртэл чичрүүлнэ. Хүмүүсийн уушгинаас эхэр татсан сүүлчийнх нь амьсгааг элэгдэн гаргаж, газар нэвсийтэл унагана. Сүмийн багана дэнжигнэнэ. Зөөлөн дулаахан салхи эрчээрээ талбайг бүхэлд нь тойрч, хээ хуартай баганыг тойрон исгэрч, хэрмийн ханыг мөргөн сарнина. Ертөнцийг сүйрлийг харахаар хурсан олны дээгүүр шороон манан татаж, дээрээс урсах долгионд цохигдон газраар нэг пургина. Нэлийсэн гэрэл гэнэт эгшин зуур тэнгэрийг бүрхсэн шигээ эргээд хураагдав. Цацраг болгон ирсэн замаараа буцаж гүйн эхэлж тодорсон жижиг цагаан од шиг гэрэл болсноо... замхрав.

Ийм олон хүн хэзээ ч ийм аниргүй байж үзээгүй биз ээ. Гэгээн Петерийн талбайд тэнгэр рүү өлийн хөшсөн хүмүүс нэг нэгээрээ сэрэх мэт ухаан орж бие бие рүүгээ харах агаад гайхаж бахдаж дуусаагүй хэвээрээ. Хэвлэлийнхний гэрэл ч дээр дүнсийх шөнийн түнэр харанхуйгаас салж, эргээд газар дээрээ бууж ирлээ. Нэг хэсэг бүх дэлхий тэр чигтээ ухаан орж, амь орох мэт армаг тармагхан хөдөлгөөнд орж эхлэв. Мортати кардинал өвдөг сөхрөн унаж залбирна. Бусад кардинал ч ар араасаа залбирч эхэллээ. Швейцар жард жадаа буулган, хүлцэнгүй номхон зогсоно. Чив чимээгүй. Хөв хөдөлгөөнгүй. Хүн нэг бүрийн зүрхэн дэх хоосон гайхшрал хайлан, дулаахан зөөлөн догдлол урсан ирлээ. Эмгэнэл. Айдас. Гайхал. Итгэл. Сүсэг. Саяхан ухаарсан, мэдэрсэн тэр аугаа хүчний өмнө биширсэн сэтгэл төрнө. Хөөрхий Витториа гав ганцаараа дааман хаалганы өмнөх том цагаан шатан дээр хөл дээрээ тогтож чадахгүй эмгэнэн чичирнэ. Нүдээ аньжээ. Хээр талд холоос холд цохилох сүмийн хонх шиг нэг нэр сэтгэлийн угаас хамаг биеэр нь урсан урсан сонсогдоно. Ав ариун, гэхдээ аймшигтай хэрцгий сонсогдоно. Тэр сонсохыг хүсэлгүй бодлоосоо арчиж хаях гэж оролдов. Гэхдээ тэр нэр цуурайтан цуурайтан сонсогдоно. Бодлоосоо салгаж хаях гэж оролдох тусам сэтгэл өөрөө улам улам өвдөнө. Хүмүүсийн гайхал бахдалыг даган хуваалцах гэж хичээн ... антиматерийн аймаар хүч ... Ватиканы сүсэг ... камерлинго ... эр зориг ... гайхамшиг ... биеэ золиослох зориг ... бүхнийг санаандаа төсөөлөх гэж хичээнэ. Гэхдээ л тэр нэр амин голынх нь гүний гүнээс цуурайтан, сэтгэлийг нь орь ганцаар орхино. *Роберт*. Гэгээн Ангелийн сүмд түүний л төлөө ирсэн. Түүний амийг нь аварсан. Харин түүний бүтээлд өртөн хорвоог орхих нь тэр. Мортати кардинал мөргөж байхдаа камерлинго шиг бурхны хоолойг сонсох сон гэж хүснэ. *Гайхамшигийг үзэхийн тулд байдаг гэдэгт нь итгэх хэрэгтэй юм болов уу?* Мортати шүтлэг ихтэй ч орчин үеийн хүн байлаа. Шүтлэгтэй ч гэсэн гайхамшиг байдаг гэдэгт итгэдэггүй хүн байв. Шүтлэг нь дандаа гайхамшигийн тухай... үхээд амилсан тухай*... хүний сүүдэр нь үлдсэн бүтээлгийн тухай** ... өгүүлдэг ч энэ бол байдаг л нэг домог гэж боддог байлаа. Яагаад гэвэл ингэсэн гэж итгэхэд дэндүү бэрх, ямар ч нотолгоогүй ажээ. Гайхамшиг гэдэг бидний үнэн байгаасай гэж хүсдэг үлгэр төдий л зүйл шүү дээ. Гэтэл сая... Дөнгөж сая харсан зүйлдээ итгэхгүй байхаар тийм их орчин үежсэн хүн юм гэж үү, би? Сая болсон явдал гайхамшиг байгаагүй гэж үү? Тийм шүү дээ! Камерлингод бурхны шивнэсэн хэдхэн үг бүх үйл явцыг эргүүлж, энэ шашин, энэ сүмийг аварлаа шүү дээ. Итгэхэд юу нь тийм хэцүү байгаа юм бэ? Бурхан юу ч хийгээгүй байсан бол бид юу гэж ярих ёстой байсан юм бэ? Ялгуусан эзэн минь хайхраагүй гэж хэлэх байсан юм уу? Энэ бүхнийг зогсоох чадалгүй байсан гэж хэлэх байсан юм уу? *Гайхамшиг гэдэг л цорын ганц ил хариулт байгаа биз дээ?* Мортати кардинал сөхрөн мөргөхдөө, камерлингогийн сүнсийг бас даатган залбирч байлаа. Энэ залуухан гарын даа бурхнаас нотолгоо шаардахгүй итгэх ёстой гэдгийг өтөл насанд нь нүд үзтэл нотолж өгсөнд талархаж байлаа. Сүсгийг нь ингэж шалгах юм гэж Мортати өмнө нь зүүдэлж ч байсангүй. Гэгээн Петерийн талбайд чив чимээгүй байсан хүмүүс хэсэг бусаг шивнэлдэж байлаа. Удалгүй тэд шуугилдаж эхлэв. Тэгснээ талбай даяар хашхиралдаж эхэллээ. «Хараач! Хараач!» Мортати нүдээ нээн хурсан олны зүг харав. Бүгдээрэнгийнх нь царай цов цонхийж түүний ард байгаа Гэгээн Петерийн ордон руу чичлэн зааж байлаа. Зарим нь сөхөрч, зарим нь муужран, зарим нь эхэр татан уйлж байлаа. Чичрэн мэгдэн хашхиралдах олны гар сунган заах тэр зүгт Мортати эргэн харлаа. Тэд Гэгээн Петрийн ордны дээвэр рүү, Есүс арван хоёр шавийнхаа хамт талбайг ширтэн байдаг тэр зүг зааж байв. Тэнд Есүсийн баруун талд хурсан олны зүг гараараа даллан ... Карло Вентреска

камерлинго зогсч байлаа. * Библьд өгүүлснээр Есүс загалмайд хадуулан, тэнгэр болсныхоо дараа дахин амилсан гэдэг. ** Турины бүтээлгийн тухай энд өгүүлжээ. Өлмийд эшлэсэн тайлбар 1-ийг үзнэ үү.

Хэсэг 125

Роберт Ландон унахаа больжээ. Айдас алга. Өвдөхөө ч больжээ. Салхи шуугих чимээ ч алга. Ус руу зөөлөн цүлхийн орсноо санавч одоо эрэг дээр тавтай яа унтаж байх ажээ. Ухаан орж байгаага мэдсэн ч Ландон өөрийгөө үхчихсэн байгаа нь энэ үү хэмээн бодлоо. Тун сайхан байв. Бүх бие нь зөөлөн аажим мэдээ алдрах нь нэн таатай. Ингээд хаачсан ч яах вэ. Айдас, өвдөлт хоёрыг мэдрэхгүй нь аятайхан, амьдрал амласан ч тэр айдас, өвдөлт хоёр руу дахиж зүглэхгүй дээ гэж бодно. Хамгийн сүүлд үхэлтэй, тамтай учирсан мэт санагдаж байлаа. *Намайг аваад яв л даа...* Нэг хүн хацар руу нь алгадаж, амар амгалан сайхан мэдрэмжээс нь бүр холоос буцааж татаад байлаа. Амттай сайхан зүүднээс нь сэрээх гээд байв. *Зүгээр байлга л даа.* Сэрмээргүй байв. Баяр баясгаланг нь тойрон чөтгөрүүд цуглаад, тэр сайн сайхныг нь эвдэх гэж нүдэж байлаа. Нүүгэлтсэн дүрсүүд сүүмэлзэнэ. Хашхиралдана. Салхи шуугина. *Боль л доо!* Дургүйцэх тусам улам хүчтэй чаргууцалдацгаана. Тэгээд, нөгөө зүг рүү эргүүлээд, аваад явчихлаа. Нисдэг тэрэг дээд өндөртөө тулан хүрчигнэнэ. Ландон гарах газаргүй балмагдана. Хором өнгөрөх тусам хаалганы цаана байгаа Ром хотын гэрэл гэгээ холдон холдсоор. Гартаа байгаа канистераа шидчихвэл, хорь хүрэхгүй хормын дотор хагас бээр унах байлаа. Гэхдээ доор байгаа хүмүүсийн дээр нь унана. *Дээшээ! Дээшээ!* Ландон дээшээ хэр өндөрт байгаага мэдсэнгүй. Ердийн жижиг сэнст онгоц дөрвөн бээр өндөрт хөөрдөг. Энэ нисдэг тэрэг өдийд төдий орчим өндөр авсан байх аа. *Хоёр бээр үү, гурван бээр үү?* Боломж байж л байна. Цагаа зөв тооцож чадвал канистер унахдаа доор байгаа хүмүүст хүрэхгүй, дээрээ байгаа нисдэг тэрэгт хүрэхгүй аль алинд нь аюулгүй зайд дэлбэрнэ. Ландон доор гэрэлтэн эргэлдэх хот руу өнгийн харлаа. «Тэгээд чи зөв тооцоолж чадвал ч ...» гэж камерлинго хэлэв. Ландон давхийн цочиж, түүн рүү харлаа. Камерлинго түүн рүү хараа ч үгүй байж, бодол нь цонхны шилэн дээр ойсныг уншаа юм уу гэлтэй байв. Тэр нисдэг тэрэгнийхээ жолоог бариагүй, гараа жолооныхоо хүрднээс авчихсан байлаа. Нисдэг тэргээ авто удирдлага дээр нь ямагт дээшээ хөөрч байхаар тохируулаад тавьчихсан бололтой. Гараа дээшээ өргөөд, бүхээгийн дээд таазанд байгаа баахан цахилгаан утаснуудыг ухан, цаана нь хүний нүднээс нууж скочоор наасан түлхүүр гаргаж авлаа. Тэгээд, урд хоёр суудлын хоорондох хайрцгийг хурдан гэгч онгойлгов. Тэндээс нийлэг эдээр хийсэн хар өнгийн том үүргэвч гаргаад өөрийнхөө хажуугийн суудал дээр тавилаа. Ландон учрыг нь ололгүй, дэмий л мэлэрнэ. Камерлинго маш дадмаг хөдлөх ажээ. «Канистераа өг!» гэж камерлинго хатуу хахир хэллээ. Ландон юу бодохоо ч мэдэлгүй канистераа камерлинго руу чулуудав. «Ерэн секунд дутуу шүү!» Камерлинго антимаатерийн канистерыг нямбай гэгч бариад, суудлын хоорондох нөгөө хайрцагт хийгээд, хүнд тагийг нь тавиад, түлхүүрээрээ түгжиж орхив. Ландон гайхан мэлэрсээр. «Та юу хийгээд байгаа юм бэ?» гэж Ландон асуув. «Хорхойгоо дарж байна» гэж камерлинго хэлээд хайрцгийн түлхүүрийг цонхоор шидчихлээ. Цонхоор гараад, түнэр харанхуйд уусч одох түлхүүртэй хамт Ландоны сүнс нь зайлчихлаа. Камерлинго нөгөө үүргэвчээ авч үүрээд, хоёр мөрөвчийг нь холбож урдаа бүслэн бэхэллээ. Тэгээд, гайхаж мэлэрсэн Ландон руу эргэн харав. «Уучлаарай! Уул нь чи энд орж ирээд, ингэж үлдэх ёсгүй байсан юм» гэж хэлээд, бүхээгийн хаалгыг онгойлгон түнэр харанхуй шөнө рүү үсэрч одов. Ландоны нүднээ сүүмэлзэх дүрсүүд овоо тодорч эхлэхдээ аймшигтай өвдлөө. Жинхэнэ

өвдөлт! Яс мах нь аймаар өвдөнө. Чинэрч, бас янгинаж өвдөнө. Ингэж байснаас хурдан үхэх сэн. Чих нь усаар дүүрэн шуугиж, шинэ дүрс гараад ирлээ. Тарчлаа дөнгөж эхэлж байгаа нь энэ ажээ. Өөдөс сөөдөс үзэгдэнэ. Айдас хүйдсийн сүг. Хар дарсан зүүд, үхэл хоёрын хооронд гацчихаад, нэг мөсөн үхэх юм сан гэвч ухаан санаа нь улам тодрон, юу болсноо санаж эхлэв.

Антиматерийн канистерыг авч болохооргүй түгжчихсэн. Нисдэг тэрэг хөөрөх хэрээр цаг урссаар. Тавин секунд. Дээшээ, бүр дээшээ. Ландон бүхээг дотор галзуу юм шиг дүүлэн, дөнгөж сая юу болсныг ухаарах гэж оролдоно. Шүхэр хайн суудлын доодохыг ухсан ч олсонгүй. Дөчин секунд. Ямар нэг гарц байх л ёстой доо. Гучин таван секунд. Нисдэг тэрэгний онгорхой нээлхийгээр мань хүн цээжээ гаргаад, салхины шуугианд доор гэрэлтэх Ром хотыг харлаа. Гучин хоёр секунд. Тэгээд шийдлээ. Хэний ч санаанд оромгүй шийдэл... Шүхэр байхгүй болохоор, Ландон шууд л үсэрчхэв. Түнэр харанхуй шөнө түүнийг нөмрөн авч дээр хүрчигнэх мотор, сэнсний дуу бүдгэрэн, чөлөөт уналтаар чулуу шиг ойчиж яваа түүний чихийг нь үрэх салхины шуугианд сонсогдохгүй боллоо. Газар руу унаж явахдаа, тэрээр усанд үсрэлтээр хичээллэхээ больсноос хойш анх удаа бүх жингээрээ татах хүчний төв рүү шунгинаж яваагаа мэдэрлээ. Хурдан унах тусам, газар улам хүчтэй татаж, доош нь сүпхийтэл сорох шиг. Энэ удаа даан ч тавин тохой өндрөөс усан сан рүү үсэрсэнгүй, харин ... мянга мянган тохой өндрөөс төөлж хэмжээлшгүй урт цардмал хатуу зам, байшин барилга руу унаж явлаа. Чих үрэн шунгинах салхины чимээн дунд, Колэрын сүнс авсан дотроосоо шивнэх шиг ... өнөө өглөө СЭРН-д чөлөөт уналтын хоолойн дэргэд ярьж байсан нь санаанд буулаа. *Хааш хаашаа нэг мухар дэлэм талбай, унаж яваа биеийн хурдыг бараг хорин хувь бууруулдаг юм.* Хорин хувь гэдэг ч ингэж унаж яваа хүн амь гарахад хангалттай биш л юм. Тэгээд, нисдэг тэрэгний хаалгаар үсрэхдээ, гартаа шүүрч авсан тэр юмаа бараг л зөнгөөрөө дэлгэв. Хэрэгтэй гэхээргүй зүйл байсан ч, ядаж л амьд үлдэх найдлага хэсэг зуур төрүүлжээ. Нисдэг тэрэгний урд шилний халхавч бэрзээнт хойд хаалганы хажууд хэвтэж байлаа. Дөрвөлжин хэлбэртэй, дөрвийг харьцах хоёр дэлэм орчим, том гэгч тэр даавууг шүхэр гэхэд хэтэрхий бүдүүлэг эд байлаа. Нисдэг тэрэгний урд шилний араамд тохох зорилгоор хоёр талд нь нэг нэг гархи хадсанаас өөр тоноггүй ажээ. Ландон хоёр гархинаас нь атгаад, гөвөх мэт хөдөлгөөн агаарт хийлээ. Хамгийн сүүлийн боломжоо алдахгүй ашиглах гэж махарна. Амьд гарах ямар ч найдлага байхгүй шахуу... Ландон чулуу шиг л унаж байлаа. Хөлөө доош жийж, гараа дээш өргөж гархинаас атгажээ. Халхавч сүрхийн дэлгэгдэж, дээр нь яг л мөөг шиг бөмбийв. Хурд огцом багасахдаа, Ландоныг бараг л ураад хаячих шахав. Дээр нь нэг юм дэлбэрч байгаа бөглүү чимээ сонсогдов. Бодож байснаас хол дэлбэрчээ. Гэвч тэсрэлтийн долгионд даруй цохиуллаа. Ар өвөр хоёр талаас нь зэрэг хүчтэй цохих шиг болоход уушги няцарчхав уу гэлтэй. Дээрээс нь доошоо дулаан салхи төөнөн одов. Гархиа алдахгүйг хичээнэ. Бэрзээнт сүрхий далбалзан сүр сар хийсэн ч ашгүй тогтлоо. Гэрэл сүүдрийн хязгаарт Ландон чулуу шиг унаж яваа нь яг л мянган тохой давлагаанаас зайлан, ирмэг даган, далайн эрэгт хөвөх сурфер шиг. Гэнэт нөгөө дулаан алга болчихлоо. Дахиад л хүйтэн харанхуй дунд унаж явна. Ландонд найдвар төрөв. Даан ч тэр найдвар удсангүй алга болчихлоо. Бэрзээнт унах хурдыг нь сааруулж байгаа гэж найдан гараа өргөсөөр, гэхдээ чихийг нь үрэх салхины чимээ хэнгэргийг нь хагалах шахуу чанга хэвээрээ байв. Ийм хурдан унаж байхад амь гарах магадлал тун бага юм байна даа. Газар мөргөж, няцарч үхэх нь дээ. Толгой дотор тоо тооцоо эргэлдэвч ухаарах сөхөөгүй байлаа. ... *Ам дөрвөлжин нэг дэлэм талбай ... унах хурдыг хорин хувь бууруулна...* Дээрээ барьсан бэрзээнтний багцааг харвал, унах хурдыг хориос илүү хувь сааруулах ёстой сон. Гэхдээ л доошоо унаж байгаа хурд, хэнгэрэг хагалам салхины чимээг бодвол бэрзээнт хэдий их сааруулсан ч гэсэн амьд үлдэх боломжгүй байлаа. Ийм хурдан унаж байхад доор цардмал талбай таарвал, ямар ч найдвар үгүй. Ром хотын гэрэл доор нь нэлийн харагдана. Яг л харанхуй тэнгэрээс гэрэлт судал сүлжилдсэн, хэтэрхий нягт одтой хар нүх рүү унаж яваа санагдана. Гэрэлт одон хээ дундуур бүдүүн хар могой гулсах мэт харанхуй хар зурвас хотыг хоёр хэсэгт хуваана. Ландон тэр

бүдүүн хар зурвас руу хялам хялам хийн харна. Дахиад л сэтгэлийн угаас төрсөн найдвар хамаг биеийг нь бүлээцүүлэн тэврэв. Баруун гар талынхаа гархийг байдаг хүчээрээ татлаа. Бэрзээнт барууншаа-хамгийн бага эсэргүүцэлтэй тал уруугаа хазайн улам илүү сэрчигэнэн дуугарна. Хажуу тал руугаа эргэж байх шиг Ландонд санагдав. Алга нь зүсэн өвдөхийг үл хайхран дахин баруун тал руугаа татлаа. Бие нь хажуу руугаа хазайж байгааг мэдэрнэ. Гэхдээ, хангалттай хазайсангүй. Дахин нөгөө хот дундуур мурилзах гэрэлгүй хар могой шиг зурвас руу доошоо өнгийн харлаа. Баруун талд л харагдана, би хангалттай өндөр байгаа болов уу? Хэтэрхий удаан хүлээсэн юм болов уу? Баруун тал руугаа байдаг хүчээрээ татан бурхнаас аврал эрлээ. Нөгөө мурилзах могойн хамгийн бүдүүн хэсгийг нь чиглүүлэн, бэрзээнтээ даялуулан залахыг хичээн ... насандаа анх удаагаа гайхамшиг гуйн бурханд залбирлаа. Хормын зуур бүх юм болж өнгөрлөө. Нөгөө хар зурвас руу ойртмогц ... шумбаж сурсан төрөлх зөн нь сэрж ... нуруугаа цэхлэн, хөлийнхөө өлмийг нугалан ... дотоод эрхтнээ хамгаалан уушгиа агаараар дүүргэж ... хөлөө цэхлэн хана мөргөдөг гуалин шиг болгоод ... тэгтэл ... Тибер мөрний зөөлөн ... агаарт сийрэгжин, хөөсөрсөн урсгал ... тогтмол уснаас гурав дахин сийрэг ус... цүлхийлээ. Тэгээд л ... түнэр харанхуй. Ус хүчтэй балбан цүлхийх чимээ тэнгэрт бөмбийх гэрлийг харж байсан хүмүүсийг давхийтэл цочоов. Энэ шөнө Ромын тэнгэрт харууштай юм их байлаа... эхлээд тэнгэр рүү эгц хөөрсөн нисдэг тэрэг ... дараа нь аймшигтай нэлийсэн их гэрэл, дэлбэрэлт ... одоо Тибер голын урсгал дунд Тиберина арлын хажууд тэнгэрээс юм нэвсийн уналаа. 1656 оны хар тахлын үед халдварт нэрвэгдсэн олныг энэ арал дээр тусгаарлаж байснаас хойш хүмүүс Тиберина арлыг анагаах шидтэй гэж итгэдэг болжээ. Тэгээд ч, Ромын эмнэлгийг энд байгуулж, арлынхаа нэрээр алдаршуулжээ. Биеийг нь уснаас татаж гаргах үед, байдгаараа няцарсан байлаа. Гайхалтай нь тэр амьд, судас нь зөөлөн ч атугай цохилж байлаа. Тиберинагийн анагаах шид л энэ эрийн зүрхийг цохилуулаад байх шиг байна гэж тэр хүмүүс хоорондоо гайхан ярилцана. Хэдэн минутын дараа, нөгөө эр бүгшин ханиалгаад, ухаан орох тэр эгшинд, Тиберина арал үнэхээр анагаах шидтэй юм байна гэдэгт бүрэн итгэж биширлээ.

Хэсэг 126

Энэ дэлхий дээр энд болж байгаа гайхамшигийг дүрслэн хэлэх үг байхгүй дээ хэмээн Мортати кардинал бодно. Гэгээн Петерийн талбай дээрх нам гүм ямар ч ангелийн найрал дуунаас илүү чанга сүрлэг байлаа. Мортати кардинал Вентреска камерлинго руу харах эгшинд сэтгэл зүрх хоёр нь түсхийтэл мөргөлдөв. Тэр бодитой, үнэн зүйл харж байлаа. Гэхдээ ... ийм байх учиргүй санагдана? Камерлинго нисдэг тэрэгт суухыг хүн болгон харсан. Нисдэг тэрэг дэлбэрч, тэнгэрт гэрлэн бөмбөлөг үүсэхийг ч харсан. Харин одоо, энд, камерлинго ордны дээвэр дээр, хүн олны дээр зогсож байдаг. Ангель тусалсан юм уу? Бурхан өөрөө дахин амилуулсан юм уу? *Ийм юм байж болохгүй шүү дээ...* Зүрх нь үүнд итгэх гээд байсан ч оюун нь шалтгаан хайгаад байлаа. Тойроод зогсох кардиналууд бүгд л Мортатигийн харж байгааг харж, гайхаж байгааг гайхаж байлаа. Тэнд үнэхээр камерлинго зогсож байлаа. Эргэлзээгүй мөн байлаа. Гэхдээ жаахан өөр ... гэгээн харагдаж байлаа. Ариусаад ирсэн юм уу? Ингэхэд хүн үү, сүнс үү? Цагаан царай нь хэвлэлийнхний хурц прожекторын гэрэлд эгээ л агаарт хөвөх шиг үзэгдэнэ. Талбайд хүмүүс уйлан, хашхиран, баясан шуугилдана. Хэдэн гэлэнмаа сөхрөөд суучихсан мөргөж байлаа. Хурсан олон шагшин давлагаална. Гэнэт талбай даяараа камерлингогийн нэрийг дуудаж эхлэв. Зарим кардиналын нулимс нүүрийг нь даган урсаж, хүмүүстэй хамт камерлингог дуудна. Мортати эргэн тойрноо мэлэрнэ. Энэ ер нь юу болоод байна вэ? Карло Вентреска камерлинго Гэгээн Петерийн ордны дээвэр дээр зогсоод

өөрийг нь ширтээ хурсан олны зүг харна. Зүүдлээгүй байгаа даа, би? Нэг л гэгээлэг сайхан байлаа. Тэнгэрээс Ватикан хийдийн цэцэрлэгт, Гэгээн Петерийн сүрлэг ордны сүглийх сүүдэрт, шүхрээ дэлгэн, зүлгэн дээр зөөлөн буусан тэр зүйл өөрийнх нь бие байв уу, сүнс байв уу? Одоо зогсож байгаа ордны энэ дээвэр дээр Медаллионы өргөн шатаар гүйн өгсөх тэр их чадлыг агуулсан зүйл өөрийнх нь бие байв уу, сүнс байв уу? Бие нь сүнс шиг л хөнгөн санагдана. Хурсан олон нэрийг нь дуудаж байсан ч тэд түүнийг шагшаагүй гэдгийг мэдэж байлаа. Амьдралынхаа өдөр болгон бурханд мөргөдөг камерлингогийн тэр их сүсэг шиг тийм их сүсгийг хүмүүс мэдрэн шагшиж байгаа нь тэр ажээ. Хөөрхий энэ хүмүүс, бурхны аугаа чадалд эргэлзэн, нотлохыг ямагт шаарддаг байсан хөөрхий энэ хүмүүс өнөөдөр тэр нотолгоог биеэрээ мэдэрч шагшин байгаа нь энэ. Энэ эгшинг өгөөч гэж Вентреска камерлинго бүх насаараа бурхнаас гуйсан авч бурхан үнэхээр гуйсныг нь өгчихлөө гэдэгт өөрөө ч итгэж чадахгүй байв. Баяссандаа хүмүүс рүү хашхирмаар санагдана. Бурхан чинь амьд шүү! Ойр тойрондоо байгаа гайхамшгийг мэдэр! Камерлинго олны зүг харан, хэзээ ч байгаагүй сайхныг мэдрэн, хэсэг зогслоо. Тэгээд, шагших түмний зүг мэхийн ёслоод, арагш ухран дээврээс холдов. Тэгээд, ганцаараа үлдээд, сөхөрч суугаад, наманчлан мөргөлөө.

Тойроод байгаа бүүдгэр дүрс холдон ойртоно. Нүд нь аажимдаа дасч эхэллээ. Хөл нь янгинан, ачааны машинаар дайруулчихсан юм шиг бүх бие нь булран өвдөнө. Хажуугаараа хэвтчихсэн байв. Өмхий үнэртэнэ. Тасралтгүй ус цалгилах шиг сонсогдоно. Гэхдээ, аятайхан санагдахгүй байлаа. Хажууд нь бас хүмүүс ярьж байгаа сонсогдоно. Бүүдгэр цагаан юм үзэгдэнэ. Бүгдээрээ цагаан юм өмсдөг юм байх даа? Диваажинд юм уу, тэнгэрт байгаа байх нь! Хоолой нь шатах мэт өвдөхийг бодоход, тэнгэр л лав биш юм шиг байна. «Бөөлжихөө больчихлоо. Эргүүлье» гэж нэг хүн Италиар хэлэх нь шийдмэг, мэргэжлийн сонсогдоно. Ландоныг дээш нь харуулан аажуухан хэвтүүлнэ. Толгой нь гулжийчхав. Суух гэж өндийсөнд нэг гар хорьж, аажуухан хэвтүүллээ. Нэг хүн түүнийг нэгжиж, хармаанд нь байсан юмыг авч байх. Тэгээд, дахиад л ухаан алдлаа. Жакобус эмч шүтлэггүй хүн байлаа. Анагаах ухаан шүтлэгийг нь аль хэдийн аваад хаячихсан байв. Гэхдээ, өнөө шөнө Ватикан хийдэд болсон зүйл эрдмийнхээ логикт хэр итгэдгийг дахин нэг шалгаад авлаа. *Одоо бүр тэнгэрээс хүмүүс унадаг болох нь ээ?* Тибер мөрнөөс татаж гаргасан хүнийхээ судасны цохилтыг шалгав. Бурхан л түүнийг аврах гэж мэрийсэн байх. Унахдаа ус хүчтэй мөргөснөөс болоод, ухаан алджээ, хэрэв Жакобус голын эрэг дээр нөхөдтэйгөө зогсоод, Ватиканы тэнгэрт болж байсан зүйлийг ажиглаж байгаад хараагүй бол мань хүнийг хэн ч анзаарахгүй, живэх байлаа. «E Americano (Нөгөө америк хүн чинь байна. ита)» гэж түүнийг уснаас татаж, хуурай газар гаргалцсан нэг сувилагч хэлжээ. Нөгөө америк хүн! Америкчууд Ромд хэсүүчлэх нь дэндэж, сандвич гэх хачиртай талх италийн үндэсний хоол болох нь гэж ромчууд хошигнодог билээ. *Гэхдээ америкчууд тэнгэрээс унадаг болбол ч арай дэндэнэ ээ.* Жакобус үзгэн гэрлээ нүдэнд нь тусган, хүүхэн харааных нь хөдөлгөөнийг шалгаад: «Эрхэм ээ! Сонсож байна уу? Та хаана байгаагаа мэдэж байна уу?» гэлээ. Нөгөө хүн дахиад л ухаан алдлаа. Жакобус гайхсангүй. Хиймэл амьсгаа хийсний дараа, тэр хүн нэлээн бөөлжсөн билээ. «Si chiama Robert London (Роберт Ландон гэдэг юм байна. ита)» хэмээн сувилагч жолооных нь үнэмлэхийг уншина. Нөгөө хэд шалан дээр гаргаж ирээд, хэсэг амсхийв. *Байж боломгүй юм* хэмээн Жакобус шагширна. Роберт Ландоныг Ватиканд туслан гүйж яваа америк профессор хэмээн зурагтаар гаргаж байсан билээ. Жакобус дөнгөж хэдхэн минутын өмнө Ландоныг антиматерийг аваад, Гэгээн Петерийн талбай дээрээс нисдэг тэргээр дээшээ хөөрч байхыг шууд сурвалжлагаар харсан сан. Жакобус нөхөдтэйгөө хамт эмнэлгийнхээ талбай дээр гүйн гарч антиматери гэрлэн бөмбөлөг үүсгэн, дэлбэрч байхыг харсан билээ. *Яаж тэр хүн энд байж болох вэ дээ?* «Энэ чинь тэр хүн мөн» гэж нэг сувилагч үсээ арагш нь илбэн хэлээд: «Өмссөн пиджак нь мөн байна» гэлээ. Гэнэт нэг хүн эмнэлгээс хашхичин гарч ирлээ. Өвчтөнүүдийнх нь нэг байв. Хөөрхий тэр бүсгүй галзуу юм шиг гүйн, гартаа радио барьчихсан, тэнгэр рүү занган, бурханд үнэн голоосоо мөргөн айсуй. Вентреска камерлинго Ватиканы ордны орой дээр шидийн мэт хүчээр дахин гарч ирлээ гэжээ. Жакобус маргааш өглөө найман цагт ээлж нь буухаар, шууд сүм рүү очъё гэж шийдэв. Ландоны толгой дээр маш хурц гэрэл асав. Тэр үзлэгийн ширээн дээр хэвтэнэ. Астригент юм уу, нэг химийн бодис үнэртэнэ. Нэг хүн түүнд тариа тариад, хувцсыг нь тайллаа. Цыганууд л лав биш байна гэж хагас ухаандаа бодно. Харь гаригийнхан юм болов уу? Тийм юм ч байдаг гэсэн шүү. Аз болж нэг их тарчлаахгүй юм шиг байна. Юу хүсээ юм бол? «Юу болоод байна?» гээд Ландон босоод суучхав. Гэхдээ, нүд нь гиюүрэн эргэлдэнэ. «Attento! (Болгоомжтой. ита)» хэмээн нэг амьтан гүйгээд ирлээ. «Жакобус эмч» гэсэн пайз зүүсэн харагдана. Тэр яг л хүн шиг харагдаж байв. Ландон гиюүрсээр «Би... бодохдоо ...» «Аажуухан, Ландон гуай! Та эмнэлэгт байна». Бүрэлзээд байсан нь аажимдаа гайгүй боллоо. Сэтгэл амрах шиг болов. Эмнэлэгт дургүй боловч харь гаригийнхны туршилтын туулай болсноос, энд байх нь хамаагүй дээр билээ. «Намайг

Жакобус эмч гэдэг» гэж тэр эр өөрийгөө танилцуулаад, юу болсныг тайлбарлав. «Та ч амьд үлдэх азтай хүн юм аа». Гэхдээ нэг ч их азтай санагдахгүй байв. Нисдэг тэрэг ... камерлинг ... гээд л санаанд нь олон юм эргэлдэнэ. Бүх бие нь өвдөн тарчилна. Ус өгөхөд нь балгаад, амаа зайлав. Алган дээр нь шархны лент тавьж өгнө. «Хувцас хаана байна?» гэж Ландон асуув. Түүнд цаасан даавуугаар хийсэн нөмрөг хөнтрүүлсэн байлаа. Нэг сувилагч хэсэг хэсэг хэрчээд хаячихсан шаргал цамц, нэхмэл пиджакийг нь тавиур дээр овоолчихсон заана. «Усанд шалба норчихсон байсан. Таны хувцсыг тайлах хэрэгтэй байсан юм» гэлээ. Харрис нэхмэл пиджакийг нь хэрчээд хаячихсан байхыг хараад, урвайж орхив. «Таны хармаанд байсан самбай цаас норчихсон байхаар нь хаячихсан шүү» гэлээ. Тэгж хэлэхэд нь, ууссан самбай цаас хамаг хувцсаар нь тарчихсан юм шиг жижиг жижиг цаасан бөөсөөр хучигдсан байхыг анзаарлаа. Галилеогийн Диаграмма-гаас энэ дэлхий дээр үлдсэн байсан сүүлчийн ганц хувь уусаад, алга болчихжээ. Дүйрч гиюүрсэн тэр яахаа мэдэхгүй, дэмий л мэлэрнэ. «Таны хувийн эд зүйлийг хадгалсан шүү» гээд сувилагч бүсгүй хуванцар сагс руу дохив. «Түрийвч, камер, үзэг. Камерыг чинь чадлаараа л хатаах гэж оролдлоо». «Надад камер байхгүй». Сувилагч гайхасхийн, хуванцар сагсаа аваад, доторхийг нь харууллаа. Түрийвч, үзэг хоёртой нь хамт Sony RUVI камер байлаа. Одоо л саналаа. Колэр үүнийг түүнд өгөөд, хэвлэлийнхэнд дамжуулаарай гэсэн билээ. «Таны хармаанаас олсон юм. Гэхдээ бараг л шинийг авах нь дээр байх аа даа» гэлээ. Сувилагч камерыг эргүүлж, хоёр хуруу дэлгэцийг нь харуулав. «Дэлгэц нь хагарчихсан байна» гэв. Гэнэт нүүр нь мишээснээ: «Гэхдээ дуу нь ажиллаж байгаа юм шиг байна, жаахан хэцүү юм» гэлээ. Тэгээд, чихэндээ наан чагнаснаа: «Нэг юмыг л дахин дахин давтаад байх шиг байна. Хоёр хүн хэрэлдээд байгаа юм уу даа» гээд Ландонд өгөв. Ландон камер аваад чихэндээ наан сонсов. Дуу нь тасалдсан, төмөр шиг хяхарсан байсан ч ойлгож болохоор байлаа. Нэг нь ойрхон, нөгөө нь хол ярина. Хоёуланг нь танилаа. Ландон цаасан даавуун нөмрөг хэлтрээд, тэр хоёрын яриаг шимтэн сонсоно. Тэр юу болж байгааг харж чадахгүй байсан ч ярианых нь аймшигт төгсгөлийг сонсоод, энэ камерыг хадгалж байсандаа баярлалаа. Ээ, бурхан минь. Нөгөө яриа дахиад л давтагдлаа. Ландон камерыг чихнээсээ буулгаад, дэмий л мэлрэн сууна. Антиматери ... нисдэг тэрэг ... болсон явдал эхнээсээ түүний толгойд эргэлдэнэ. Тэгэхээр энэ чинь... Дахиад бөөлжмөөр болов. Сэтгэлд нь төрсөн айдсаас болоод, Ландон ухасхийн үзлэгийн ширээнээс өндийж, хоёр хөл дээрээ чичрэн бослоо. «Ландон гуай!» хэмээн эмч хэлээд, хорьж хэвтүүлэх гэлээ. «Хувцас хэрэгтэй байна» гэж Ландон хэллээ. Араараа задгай нөмрөг нь нуруугаар нь сэвнэ. «Гэхдээ та амрах хэрэгтэй». «Би гарлаа. Хувцас хэрэгтэй байна». «Үгүй ээ, гэхдээ та...» «Гарлаа, гарлаа». Өрөөнд байсан эмч сувилагч нар бие бие рүүгээ гайхан харцгаав. «Манайд хувцас байхгүй шүү дээ. Маргааш танай нөхдөөс нэг нь хувцас авчрах биз». Ландон амьсгаагаа дараад, эмч рүүгээ цоо ширтэн: «Жакобус эмч ээ! Би одоо энэ хаалгаар гараад явна. Надад хувцас хэрэгтэй байна. Би Ватикан руу явна. Хэн ч өмнө нь Ватикан руу бөгсөө гялалзуулаад, шалдан орж байгаагүй шүү дээ. Та ойлгов уу?» гэлээ. Жакобус эмч алмайран, шүлсээ залгиад: «Энэ хүнд нэг өмсчихмөөр юм олоод өг!» гэлээ. Ландонд Тиберина эмнэлгээс гарахад яг л эргээд скаут, болчихсон юм шиг санагдана. Мэргэжилдээ гарамгайг нь илтгэсэн олон зураас чимэгтэй түргэн тусламжийн эмчийн хүрмийн энгэрийн цахилгааныг нь татаад өмсчихсөн байлаа. Хамт яваа хүүхэн нь махлаг агаад ижилхэн хүрэм өмсжээ. Эмч тэр хүүхэнд Ландоныг даатгаж, хамаг хурдаараа Ватикан руу хүргэж өгөхийг даалгажээ. «Molto traffico (Түгжрэл ихтэй байгаа даа. Ита.)» гэж Ландон хүүхэнд Ватикан хавийн зам машинаар дүүрчихсэн тухай сануулан хэллээ. Хүүхэн тоосон шинжгүй хүрмэн дээрх нэг тэмдэг рүүгээ заагаад «Sono conducente di ambulanza (Түргэний машиныг гарамгай жолоодсоны төлөө.

Ита.)» гэлээ. «Ambulanza?(Түргэний машин аа? ита)» Ойлгомжтой. Ландон түргэний машинаар явах нь. Бүсгүй Ландоныг дагуулан байшингийн булан тойрлоо. Урсгал усан дээр тавьсан гүүргэн дээр хөлөг нь зогсч байлаа. Түүнийг хараад, Ландоны бие нь хөшөөд, царцаж орхив. Нэлээн хуучирсан нисдэг тэрэг, дээр нь Aero-Ambulanza (Аэро-түргэн тусламж) гэж бичжээ. Ландон толгойгоо сэгсрэв. Бүсгүй инээвхийлэн: «Ниснэ, Ватикан руу. Хурдан очно» гэлээ.

Хэсэг 128

Гайхаж бахадсан кардиналын чуулга Систин цогчны зүг гэрэл цахилгаан дунд эргээд орлоо. Харин Мортати кардинал эргэлзсэн хэвээр. Энэ эргэлзээ нь улам гүнзгийрч хуйлран, түүнийг газар дэлхийгээс аваад явчих вий гэмээр. Тэр гайхамшгийн тухай эртний гэрчлэлд итгэдэг ч саяхан харсан бүхэн нь ойлгож ухаарахын аргагүй байлаа. Насан туршдаа, далан есөн жилийн турш амьдралаа зориулсны дараа л, сая болж өнгөрсөн бүхэн түүний сүсгийг амьд, бадрангүй болгож байлаа. Гэхдээ л ... бодох тусам итгэхэд улам хэцүү ажээ. Ямар нэг юм биш байлаа. «Мортати эрхэм ээ!» хэмээн хашхирсаар Швейцар жардын нэг харуул айсуй. «Таны хэлснээр бид дээшээ дээвэр рүү гарч үзлээ. Камерлинго ... махан биетэн мөн байна! Тэр үнэхээр амьд хүн байна! Сүнс биш! Бидний мэддэг тэр хүн мөн байна» гэлээ. «Тэр тэгээд чамтай ярьсан уу?» «Тэр сөхрөөд, чимээгүй мөргөж байсан. Бид саад болж түвдсэнгүй». Мортати гайхсан хэвээр: «Очоод ... кардиналууд хүлээж байна гээ» гэв. «Эрхэм ээ! Нэгэнт тэр чинь хүн юм болохоор...» гээд харуул түгдчив. «Тэгээд юу гэж?» «Нөгөө цээж нь ... түлэгдсэн шархтай шүү дээ. Шархыг нь сувилах уу? Их л өвдөж байгаа байх даа». Мортати энэ тухай бодсон байлаа. Шашинд насаараа зүтгэсэн боловч ийм зүйл түүнд хэзээ ч тохиолдож байгаагүй билээ. «Тэр хүн мөн юм бол хүнд үйлчилдэг шиг л үйлчил. Усанд оруул. Шархыг нь сувил. Шинэ дээл өмсөг. Бид түүнийг Систин цогчиндоо хүлээж л байя». Харуул гүйн одов. Мортати цогчин руу алхана. Бусад кардинал аль хэдийн цогчин руу орчихсон хүлээж байлаа. Дээшээ өгсөж явахдаа, тэр Хаан шатны өлмий дэх бандан сандал дээр Витториа Ветра ганцаараа сууж байхыг харлаа. Харцнаас нь ганцаардал, гансрал үзэгдсэнд очмоор санагдсан боловч одоохондоо завдахгүй байлаа. Ажилтай байв ... гэхдээ ямар ажил вэ гэдгээ өөрөө ч мэдэхгүй л явлаа. Мортати цогчин руу оров. Тэнд хүмүүс гайхал бишрэлдээ авган шуугилдана. Дааман хаалга хаагдлаа. *Бурхан өршөөх болтугай!* Тиберина эмнэлгийн давхар сэнст Аэро-түргэн тусламж Ватикан хийдийн ард эргэлдэн, дотор нь Ландон шүдээ хавиран чичирч, энэ амьдралдаа унах хамгийн сүүлийн нисдэг тэрэг минь энэ байгаасай хэмээн бурхнаас гуйна. Яг одоо Ватиканы санаа хамгийн бага зовж байгаа асуудал бол Ватиканы агаарын зайн хууль гэж ятгасны хүчинд, Ландон нисэгч хүүхнийг хэрмийн араас оруулж харанхуй дунд, Ватиканы нисдэг тэрэгний буудалд газардууллаа. «Grazie (Баярлалаа. ита)» хэмээн хашхирч, газар буулаа. Нисэгч хүүхэн түүн рүү уруулаа цорвойлгон үнсэлт үлээгээд, хөөрч, хэрмийн хана даван түнэр харанхуй руу нисч одлоо. Ландон гүнзгий амьсгаа аваад хийх гэж байгаа зүйлээ дахин тунгаан, бодлоо цэгцэллээ. Камераа гартаа барьсаар, тэр өдөр унаж явсан гольфийн картаа уналаа. Өдөржин цахилгаан тасарсан болохоор цэнэг унаж байгааг дэлгэц дээр зааж байв. Цэнэгийг нь дэмий үрэхгүйн тулд гэрлийг нь асаалгүй унаад явлаа. Түүнээс гадна, Ватиканд ирснээ хэнд ч мэдэгдэхийг хүссэнгүй. Мортати кардинал Систин цогчин дотор үймсэн олныг харж гайхан зогсоно. «Энэ бол үнэхээр гайхалтай! Бурхан л ийм гайхамшиг бүтээж чадна!» гэж нэг нь хашхирав. «Тийм шүү! Бурхан түүний чин хүслийг ивээсэн байж таарна» гэж нөгөө нь дэмжинэ. «Камерлингог Пап болгоё! Хэдийгээр тэр кардинал биш ч гэсэн бурхан бидэнд гайхалтай сайхан билэг

үзүүллээ шүү дээ» гэв. «Тэгье! Цуурганы хууль бол хүний хууль, харин бурхны зарлиг бол юу юунаас ч дээгүүр байх ёстой. Одоо даруй саналаа хураая!» гэж нэг нь дэмжин хашхирлаа. «Санал хураах аа? Тэр чинь ч миний ажил байх шүү!» гэж Мортати явуут дундаа хэлэхэд, хүн бүхэн түүн рүү гайхан харлаа. Кардиналууд түүн рүү ширтэж байгаа нь мэдрэгдэнэ. Түүний үг тэдэнд доромжлол юм шиг сонсогдож байх шиг. Тэнд байгаа хүмүүсийн нүүрийг харвал, гайхамшгийг харж биширсэн, түүндээ ухаан зулаггүй итгэсэн харагдана. Мортати тэгсэнгүй. Зүрхэнд нь нэг л гансрал төрөн өвдөж, яагаад гэдгийг нь тайлбарлаж чадахгүй шанална. Энэ ариун ёслолыг ариунаар нь явуулахаар тангарагласан түүний дотор эсэргүүцэж чадашгүй нэгэн сэжиг төрөөд байлаа. «Нөхөд минь!» хэмээн тахилын ширээний өмнө очоод Мортати кардиналуудад хандав. Өөрийнх нь дуу хоолой биш юм шиг санагдана. «Би өнөө шөнө харсан зүйлийнхээ учир утгыг тайлах гэж энэ насныхаа үлдсэн амьдралыг зориулах биз ээ. Гэхдээ камерлингогийн тухай та бүхний санал болгож байгаа зүйл ... яавч бурхны хүсэл биш байлтай!» Танхим тэр чигтээ аниргүй болчхов. «Та ... та яаж ингэж хэлж чадаж байна вэ?» гэж эцэст нь нэг кардинал хашхирлаа. «Камерлинго шашныг аварлаа! Бурхан камерлинготой шууд ярилаа! Үхлийг даван тууллаа! Өөр ямар бэлгэ танд хэрэгтэй юм бэ?» «Камерлинго наашаа ирж яваа. Хүлээе. Саналаа хураахаас өмнө юу гэхийг нь сонсьё. Тэр ямартай ч тайлбарлах биз» гэж Мортати өгүүлэв. «Тайлбарлах аа?» «Би Их сонгогчийн хувиар цуурганы хуулийг мөрдүүлэх тангараг тавьсан хүн. Эрдэнийн хуулиар бол камерлинго Пап болоход нийцгүй хүн. Тэр бол гэлэн ... гарын даа төдий хүн. Нас нь ч бас нийцгүй байна». Кардиналууд түүнийг жигшин харж байгааг мэдэрлээ. «Санал хураахыг зөвшөөрнө гэдэг би та бүхнийг Ватиканы хуулиар бол нийцгүй хэмээн тооцогдох хүнийг сонго хэмээн зөвшөөрсөн болно. Ариун тангаргаа зөрч гэж би та бүхнийг ятгасан болно шүү дээ!» «Гэхдээ энэ шөнө болсон зүйл манай хуулиас хэтийдсэн зүйл шүү дээ!» гэж нэг нь уцаарлав. «Тийм үү?» гэж Мортати сөргөж асуугаад: «Шашны дүрмээ зөрч гэж байгаа нь бурхны хүсэл хэрэг үү? Жигтэй бүхэнд хөтлөгдөн учир шалтгааныг умарт гээд байгаа нь бурхны хүсэл хэрэг үү?» Энэ үгс өөрийнх нь хаанаас хөврөн гарсныг Мортати өөрөө ч мэдсэнгүй. «Гэхдээ чи сая бидний харсныг хараагүй хэрэг үү?» гэж нэг нь илэрхий уурсан хашхирав. «Ийм гайхалтай чадлыг чи яаж өөнтөглөж чадаж байна вэ?» Мортати дуугаа намсган, ямар доогуур хөгөөр ярьж байгаагаа өөрөө ч гайхна. «Би бурхны чадлыг өөнтөглөөгүй! Бурхан л биднийг учир шалтгааныг хайж, шүү гэсэн! Бурханд л эрүүл ухааныг барин зүтгэж байна!» гэлээ.

Хэсэг 129

Систин цогчны гадаа Хаан шатны доод дэвсгийн дэргэд урт бандан сандал дээр Витториа Ветра гиюүрэн сууна. Арын хаалганы тэндээс нэг хүн гүйж явахыг хармагцаа сүнс үзсэн юм шиг загзайв. Эмнэлгийн түргэн тусламжийн хувцастай хүн өөрөө боолттой, тэгээд бас хазганан явж байлаа. Бүсгүй нүдэндээ ч итгэсэнгүй. «Ро ... бэрт?» Тэр дуугарсангүй, шууд ирээд л тэврээд авлаа. Уруул дээр нь уруулаараа чанга гэгч дарсан нь баярлаж, сэтгэл догдолсон үнсэлт байв. Витториагийн нулимс өөрийн эрхгүй бөмбөрөн, хоолой нь зангирна. «Ээ, бурхан минь ... баярлалаа». Тэр дахин нэг удаа шунан үнсэхэд, Витториа урагш тэмүүлэн, түүнд биеэ бүрэн тушаалаа. Бие биедээ олон жил ээнэгшсэн хос шиг тэврэлдэнэ. Бүсгүй айдас, гансралыг агшин зуур мартав. Нүдээ аньжээ. Яг л жингүй хөвж яваа шиг санагдана. «Тийм шүү!» хэмээн нэг нь хашхирахад, Систин цогчны дотор цуурайтаж байв.

«Бурхан ивээлийг хүртээгүй хэн ийм аймшигт тэсрэлтийг тойрч амь гарах билээ?» хэмээн асуув. «Би чадна» гэж нэг хүн цогчны үүд хавиас чанга хашхирлаа. Мортати, кардиналууд бүгдээрээ цогчны голоор алхах хүнийг сая л таньж, мэлэрнэ. «Ландон гуай юу даа?» Ландон чимээгүйхэн цогчин руу хазганан орж ирлээ. Виттория Ветра хамт орж ирэв. Ард нь хоёр харуул асар том зурагт ачсан чиргүүл түрж явна. Зурагтаа залгуурт залгаж бэлдэхийг хүлээн, Ландон чимээгүй номхон зогсоно. Зэхэж дуусмагц, Ландон дохиж, харуулууд гараад, дуганы үүдийг хаав. Ландон, Виттория хоёр кардиналуудтай хамт үлдлээ. Ландон Sony RUVI камераа зурагтад холбоод, удирдлагынх нь товчийг нь дарав. Зурагт амь орон жирэлзэв. Зурагтаар Папын ажлын өргөө гарч байна. Нууц камераар бичсэн бололтой бичлэг нь жигтэй хачин чичирхийлж байлаа. Дэлгэцийн голд камерлинго ил зуухны өмнө зогсжээ. Тэр шууд камер руу харж яриад байгаа юм шиг байсан ч удалгүй энэ бичлэгийг хийсэн тэр хүнтэй ярьж байгаа нь ойлгомжтой болов. Энэ бичлэгийг СЭРН-ий захирал Максимлиан Колэр хийсэн гэдгийг Ландон кардиналуудад тайлбарлалаа. Цаг орчмын өмнө Колэр тэргэнцрийнхээ гар дор харагдахааргүй байрлуулсан камераар камерлинготой хийсэн энэ уулзалтынхаа бичлэгийг нууцаар хийсэн ажээ. Кардиналууд бичлэгийг галзуу юм шиг шимтэн үзнэ. Тэр хоёр ярилцаж эхэлмэгц Ландон чимээгүй болов. Тэдэнд үзүүлэх гэсэн зүйл одоо удахгүй гарна даа... «Леонарда Ветра өдрийн тэмдэглэл хөтөлж байсан юм уу? Тэгвэл энэ чинь СЭРН-д л сайн юм биш үү? Ялангуяа, антиматерийг хэрхэн гаргаж авсан тухай бичсэн бол ч ...» хэмээн камерлинго өгүүлнэ. «Үгүй дээ. Яаж гаргаж авсан нь Леонардотой хамт алга болсон. Гэхдээ тэр тэмдэглэлд бас өөр хүний тухай дурджээ. Таны тухай» гэж Колэр цохов. Камерлинго балмагдан: «Ойлгосонгүй» гэлээ. «Тэнд Леонардо өнгөрсөн сард тантай уулзсан тухайгаа тэмдэглэжээ». Камерлинго нэлээн тэвдэнгүй хаалга руу харснаа: «Рошер надаас асуулгүй таныг ийш нь нэвтрүүлэх ёсгүй сэн. Та яаж ирээ вэ?» гэв. «Рошер юу болсныг мэдэж байгаа. Би утастаж таны юу хийгээд байгааг хэлсэн юм». «Намайг юу хийгээд байгааг уу? Та юу ч ярьсан гэсэн Рошер бол Швейцар жард. Шашиндаа итгэдэг болохоор нэг муу эрдэмтнээс илүү камерлингодоо итгэдэг юм». «Тэр шашиндаа итгэдэг болохоор танд итгэхгүй байгаа юм. Цэргүүдийнх нэг нь шашнаасаа урвасан гэдэгт тэр итгэж чадахгүй байсан юм. Тиймээс өөр ямар шалтгаан байх вэ гэж эрэлхийлж байсан хэрэг». «Тэгээд та тэр шалтгааныг нь тайлбарлаж өгөө юү?» «Үнэнийг хэлж өгсөн юм. Аймшигт үнэнийг». «Рошер танд итгэсэн юм бол яагаад намайг баривчлаагүй юм бэ?» «Би битгий тэгээрэй гэсэн юм. Би чимээгүй үлдье, харин чи намайг камерлинготой уулзуул гэж тохирсон юм л даа». Камерлинго хүйтэн зэвүүн хөхөрнө. «Чи тэгээд хэн ч итгэхгүй юм яриад шашныг буруутгая гэж бодоо юу?» «Хэнийг ч буруутгах гээгүй байна. Би зүгээр л үнэнийг таны амнаас сонсьё гэсэн юм. Леонардо Ветра чинь миний найз байсан юм шүү дээ». Камерлинго юм ярих шинжгүй, Колэр рүү ширтэнэ. «За тэгвэл би эхлээд ярья» гээд Колэр өгүүллрүүн: «Сар гаруйн өмнө Леонардо Ветра тантай ярьж Паптантай яаралтай уулзах хэрэгтэй байна гэжээ. Паптан Леонардогийн ажлыг биширдэг байсан болохоор, бас Леонардо онц чухал гэж хэлсэн болохоор та тэр хоёрыг уулзуулжээ.» Камерлинго уцаарлангуй царайлан, ил гал руу харж зогслоо. Юу ч хэлсэнгүй. «Леонардо Ватиканд маш нууц байдалд иржээ. Учир нь тэр охиндоо өгсөн тангаргаа эвдэж, түүндээ их л гэмшиж байсан ч өөр арга байхгүй гэж шийдэж л дээ. Судалгааныхаа үр дүнд хөөрхий тэр их л цочирдож, шашнаас ёс зүйн заавар авья л гэж бодож. Тэгээд л Пап та хоёртой хийсэн нууц уулзалтынхаа үеэр шашинд гүнзгий нөлөө үзүүлж болохуйц нээлтийнхээ тухай ярьж өгчээ. Тэр нээлт нь Үүтгэл физикийн хувьд бодитой байж болох тухай, энергийн хэт хуралдал, Леонардогийн үүнийг л бурхан гэж боддог байсан юм, бүтээлийн тухай домгийг давтаж болох тухай ярьжээ.» Тэгснээ хоёулаа хэсэг

чимээгүй болов. «Паптан гайхаж биширсэн байна» гэж Колэр өгүүллрүүн: «Тэгээд, Леонардог бүтээлээ нийтлүүлэхийг хүсжээ. Дээрхийн Гэгээн эрдэм, шашин хоёрын сөргөлдөөнийг эцэслэж, энэ хоёрыг холбохыг насаараа мөрөөдсөн нэгэн билээ. Тэгээд, Леонардо эргэлзээд байсан зүйлийнхээ тухай, ёс зүйн заавар хүссэн тэр зүйлийнхээ тухай ярьжээ. Библид өгүүлсэн шиг бүтээлийг давтсан туршилт бүх зүйлийг хос хосоор нь үүтгэжээ. Эсрэг тэсрэгээр нь. Гэрэл, сүүдэр гэдэг шиг. Ветра материйг бий болгоод зогсоогүй антиматерийг бий болгожээ. Цааш нь ярих уу?» Камерлинго чимээгүй л байлаа. Доошоо бөхийгөөд, нүүрс авч гал руу шидэв. «Леонардо ийшээ ирсний дараа та түүний ажлыг нь харахаар СЭРН рүү очжээ. Леонардогийн тэмдэглэлд таныг биеэрээ лабораторьт нь ирсэн гэжээ» хэмээн Колэр өгүүлэв. Камерлинго толгойгоо өргөн түүн рүү харлаа. Колэр цааш нь өгүүлсээр. «Паптан өөрөө айлчилсан бол хэвлэлийнхний анхаарлыг татах байж л дээ. Тэгээд тэр таныг тийш нь явуулжээ. Леонардо таныг нууц лабораторьтоо дагуулан явж, антиматерийн аннигиляц, Их тэсрэлт, Бүтээлийг үзүүлжээ. Тэгээд, зогсолгүй түүний нээсэн аргаар антиматерийг их хэмжээгээр гаргаж авч болно гэдгийг харуулах гэж нэлээн их хэмжээгээр гаргаж аваад, нууцаар нөөцөлсөн байснаа ч харуулжээ. Та ч бас гайхаж биширсэн байна. Тэгээд, та Ватикан хийд рүү буцаж, Паптан юу харснаа илтгэжээ». Камерлинго санаа алдан: «Тэгээд таны санааг юу зовоогоод байгаа юм бэ? Би антиматерийн тухай юу ч мэдэхгүй царайлж Леонардогийн надтай хуваалцсан нууцыг задлахгүй байгаа нь таныг зовоогоод байгаа юм уу?» гэлээ. «Үгүй ээ. Леонардо Ветра танай тэр бурхныг чинь оршин байдгийг бараг л баталчхаад байхад, та түүнийг хөнөөсөн чинь л намайг зовоогоод байна!» гэлээ. Камерлинго түүн рүү эргэж хараад, жишим ч үгүй зогсоно. Гал чад пад хийн шатна. Гэнэт камер чичирхийлж, өмнүүр нь Колэрын гар харагдав. Тэр тэргэнцрийнхээ доор бэхэлсэн юмыг авах гэж бөхөлзөөд байгаа бололтой. Тэгээд арагшаа суухдаа, гартаа буу барьчихсан байлаа. Гарын тохой сунан, буу барьчихсан, тэр нь камерлингог шууд чиглэсэн байгааг камерын дурангийн өнцөг тодорхой харуулна. Колэр: «Нүглээ наманчил, эцэг минь!» гэлээ. Камерлинго давхийн цочиж: «Чи эндээс амьд гарч чадахгүй шүү дээ!» гэв. «Танай шашин чинь намайг бага байхад минь зэрэмдэглэж орхисон юм, үхчихвэл харин ч сайхан амсхийх биз». Колэр буугаа хоёр гараараа бариад: «Чи өөрөө сонго. Нүглээ наманчил, эсвэл одоо үх!» гэлээ. Камерлинго үүд рүү хяламхийв. «Гадаа Рошер байгаа. Тэр ч гэсэн таныг цааш нь харуулмаар байгаа байх шүү» гэж Колэр хэлэв. «Рошер бол энэ шашныг хамгаалахаар тангараг өргөсөн хүн...» «Намайг энд Рошер оруулсан шүү. Буутай минь хамт. Чиний хуурамч царайд чинь дур нь гутаад байгаа. Чамд ганц л зам байна. Наманчил. Чиний амнаас үнэнийг сонсмоор байна». Камерлинго гөлөлзөөд эхлэв. Колэр буугаа өргөөд: «Чамайг алж чадахгүй гэж бодоод байна уу?» гэлээ. «Би юу ч хэллээ гэсэн чам шиг юмнууд ойлгохгүй шүү дээ!» гэж камерлинго зэвүүцэн хэлэв. «Хэлээд үз л дээ». Харанхуйн дунд ил галын өмнө камерлинго хэсэг зогслоо. Түүнийг ярьж эхлэхэд, дуу хоолой нь наманчилж байгаа гэхээсээ илүү бусдын төлөө өөрийгөө золиосолсон сүртэй сонсогдоно. «Үүсэхээсээ эхлээд л энэ шашин бурхны дайснуудтай тэмцэж эхэлсэн. Заримдаа үгээр, заримдаа илдээр тэмцсэн. Гэхдээ дандаа л ялж байсан». Камерлинго яриад эхлэхээрээ хүнийг итгэж биширтэл татдаг тэр төрхөндөө орж эхлэв. «Гэхдээ түүхэнд байсан албингууд үзэн ядалт, уур хилэнгийн албингууд байсан юм. Байлдаж болохуйц, ялж болохуйц, айдас төрүүлсэн дайсан байсан. Цаг хугацаа өнгөрөх тусам ялагдсан дайсан минь дүрсээ хувилгасаар ... цэвэр шалтгаан болон хувирсан юм. Ил тод, ойлгомжтой шалтгаан хайх явдал. Гэхдээ сүнс сүсэггүй нь хэвээрээ». Камерлинго ярьж байгаа зүйлдээ уурлаж, ширүүн догшин болчихлоо. «Колэр гуай, та хэл дээ! Шашин хүний толгой логикоор бодоод нотолчихсон юмыг няцааж чадах уу? Энэ нийгмийн суурь болчихсон байгаа эрүүл ухаан гэгч тэр сүсэг

бишрэлгүй зүйлийг бид ганхуулж чадах уу? Шашин сануулан хашхирах тоолонд, та нар жишим ч үгүй, бидний тоомжиргүйг дуудаж байна. Параноид! Хяналаа гэж, захиргаадлаа гэж! Тэгээд л нүгэл чинь зузаараад байна. Оюун сэхээлэг гээд өөртөө итгэчихсэн. Энэ хэв маяг чинь яг л хорт хавдар шиг үсэрхийлэн халдварлаж байна. Технологийн гайхамшиг гэгчээ гэгээн зүйл болгочихно. Өөрсдийгөө ариун гэж зарлана. Бид одоо эрдэм гэгчээс зөвхөн сайн сайхныг нь л хараад сурчхаж. Тэр эрдэм өвчин, өлсгөлөн, зовуурийг илааршуулдаг гэнэ! Эрдэм -шинэ бурхан дандаа гайхамшиг, бүхнийг чадагч, нигүүлсэнгүй! Үй олноор устгаж байгаа зэвсгийг битгий анзаар. Хүн бүрийн ганцаардал, мөхлийг март. Эрдэм энд байна!» Камерлинго буу руу алхангаа: «Тэр эрдэм чинь Сагааны дүртэй ... мөхөл зөгнөж байгааг харж байна» гэлээ. «Чи юу дэмийрээд байгаа юм бэ? Ветрагийн нээлт тэр бурхны чинь оршин байгааг бараг л нотолчихсон шүү дээ! Тэр чинь танай талын хүн байсан шүү дээ!» «Манай тал аа? Эрдэм, шашин хоёр хэзээ ч хамт байгаагүй! Чи бид хоёр нэг бурхныг хайгаагүй! Чиний бурхан чинь хэн юм бэ? Протон, масс, цэнэгт эгэл бөөмс үү? Тэр бурхан чинь яаж та нарт эрмэлзэл төрүүлдэг юм бэ? Тэр бурхан чинь хүний зүрхэнд хэрхэн хүрч, түүнийг өөрөөсөө илүү чадалд хариуцлагатай байхыг сургадаг юм бэ? Яаж түүнийг бусадтайгаа эвтэй байхыг сургадаг юм бэ? Ветра буруу бодож байсан юм. Тэрний ажил шашных биш, шашны дүртэй л эд! Хүн бурхны бүтээснийг туршилтын хоолойд давтаж чадахгүй, тэгээд тэрийгээ бүх дэлхийд харуулж бүр болохгүй. Энэ чинь бурхныг алдаршуулж байгаа хэрэг үү, эсвэл шалгаж байгаа хэрэг үү?» Камерлинго биеэ маажин, дуу хоолой нь улам бүр солиотой юм шиг болж байлаа. «Чи тэгээд үүний л төлөө Леонардо Ветраг алсан хэрэг үү?» «Шашны төлөө! Хүн төрөлхтний төлөө! Энэ солиорлыг зогсоохын төлөө! Хүн бүхнийг бүтээгч бурхны чадлыг гартаа авах ёсгүй. Бурхныг туршилтын хоолойд илрүүлэх гэнэ ээ. Ганц дусал шингэн бүхэл бүтэн хотыг үгүй хийх юм гэнэ. Түүнийг зогсоох хэрэгтэй байсан юм!» Камерлинго гэнэт чимээгүй болчхов. Тэр эргээд, цаашаагаа гал руу ширтэнэ. Бодлоо дахин цэгцлэх шиг зогсоно. Колэр буугаа өргөн шагайв. «Чи наманчилж дуусав уу? Чи зугтаж чадахгүй шүү!» Камерлинго гутрангуй инээнэ. «Наманчилна гэдэг чинь сэтгэлээсээ зугтаж байгаа хэрэг шүү дээ.» Тэр хаалга руу харав. «Бурхан чиний талд байгаа бол чам шиг хүн ухаарахгүй олон боломж ямагт байдаг юм». Тэгээд, гараараа дээлийнхээ захаас зуурч байснаа огцом татаж ураад, цээжээ нүцгэлэв. Колэр цочиж: «Чи яагаад байгаа юм бэ?» гэв. Камерлинго юм хэлсэнгүй. Тэр ил зуух руу очоод цогших гал дотроос нэг юм гаргаад ирэв. «Болиоч! Чи яах гээд байгаа юм бэ?» гэж Колэр хашхирав. Камерлинго эргэж харвал тэр улайссан тэмдэг барьчихсан зогсож байлаа. Иллюминатигийн очир. Нүд нь араатан шиг гялалзана. «Би уул нь үүнийг ганцаараа хийх гэж бодож байсан юм». Түүний дуу нь хөвчирч, чангарна. «Гэхдээ ... Бурхан чамайг надтай хамт бай гэсэн юм байлгүй дээ. Чи миний аврал». Колэрыг хөдлөхөөс өмнө камерлинго нүдээ аниад, гэдэсхиймэгцээ, улайссан тэмдгээрээ цээжнийхээ яг голд өөрийгөө тамгалчхав. Мах шархийн түлэгдэнэ. «Мариа эх минь! Ивээлт эх минь... Хүүгээ тэврээч!» Өр өвдтөл ориллоо. Колэр тэвдэн, мэдээгүй хөл дээрээ эв хавгүй босчихсон зогсоно. Буугаа дэмий л савчина. Камерлинго бүр ч чанга хашхирлаа. Тэгээд нөгөө тэмдгээ Колэрын хөл рүү шидчихээд, өвдсөндөө эвхрэн, шалан дээр уналаа. Дараа нь юу болсон нь мэдэгдсэнгүй, жирэлзлээ. Дэлгэц дээр нэг юм пижигнэж жирэлзээд, Швейцар жард хаалга эвдэн орж ирлээ. Буу дуугарав. Колэрын цээж нь цусанд будагдан, тэргэнцэр рүүгээ савж уналаа. «Боль!» хэмээн Рошер харуулуудыг Колэр руу буудахыг зогсоох санаатай хашхирч харагдана. Камерлинго шалан дээр тэлчилэн, эргээд Рошер рүү зааж: «Иллюминатус!» гэлээ. «Муу гөлөг, Гэгээн дүр эсгэсэн зулбасга» хэмээн Рошер түүн рүү давшлав. Шартрон гурвантаа буудаж, түүнийг замд нь унагалаа. Рошер үхлүүт шалан дээр гулсана. Харуулууд

шархадсан камерлинго руу гүйлдэнэ. Тэр зуур Роберт Ландон тэргэнцрийн хажууд сөхрөн сууж, нөгөө тэмдгийг гайхан харна. Тэгтэл, бүх дүрс бүхэлдээ дайвалзав. Колэр ухаан орж камераа тэргэнцрийнхээ гар доорх сууринаас нь салгалаа. Тэгээд Ландонд өгөв. «Энийг ...» гээд Колэр аахилна. «Энийг ... хэвлэлийнхэнд ... өгөөрэй...» Ингээд дэлгэц харанхуйлав.

Хэсэг 130

Камерлинго баяр бахдалдаа умбана. Швейцар жард түүнийг Хаан шатаар дагалдан бууж, Систин цогчны зүг удирдан явах зуур гадаа Гэгээн Петерийн талбай дээр хүмүүс түүний нэрийг дуудахыг сонсон, бул хар уулыг нүүлгэж чадлаа даа хэмээн бодож явлаа. Grazie Dio. Тэр тэнхээ суулгасан бурхандаа баярлан явлаа. Эргэлзэж явах үед нь бурханд түүнтэй ярьсан билээ. Чиний үйл бол Ариун явдал хэмээн бурхан хэлжээ. Би чамд тэнхээ өгнө. Бурхны тэнхээ өгсөн ч гэсэн түүний арга зам зөв эсэхэд тээнэгэлзэн, айж байлаа. *Чи биш бол ХЭН гэж? Одоо биш бол ХЭЗЭЭ гэж? Ингэж биш бол ЯАЖ?* хэмээн бурхан түүнд шивнэнэ. Есүс биднийг өөрсдийн минь үйлийн үрээс аварсан шүү гэж бурхан сануулна. Загалмайд хатуулан, үхлээс сэрж айдас, найдвар гэдэг хоёр догдлолыг зэрэг төрүүлэн биднийг аварсан. Тэгж л дэлхийг аварсан шүү дээ. Гэхдээ мянган жилийн өмнө. Даан ч цаг хугацаа энэ гайхамшигийг элээн, хүмүүс мартжээ. Тэд хуурмаг шүтээн - техно-гайхамшиг, оюуны гайхамшигт бишрэх болжээ. *Харин сэтгэлийн гайхамшигийг яах билээ?* Камерлинго бурханд хүмүүсийн сүсгийг хэрхэн дахин сэрээх вэ гэдгийг зааж өгөөч хэмээн мөргөдөг байлаа. Гэвч бурхан чимээгүй л байдаг байв. Камерлингогийн сүсгийн хамгийн түнэр харанхуй үед бурхан түүнд бошго үзүүлжээ. *Тэр шөнийн айдас!* Дөнгөж үнэнээ хүлээсний дараа шалан дээр унтлагынхаа хувцастай тэлчилэн, махан биендээ хоргодох нүгэлт сүнс нь гарч ядан зууралдах, тарчлант тэр хүний царай одоо болтол нүдэнд нь үзэгдэнэ. Ингэж болохгүй шүү дээ гэж тэр хашхирч байлаа. Гэхдээ л, болдог юм байна гэдгийг амссан билээ. Худал хуурмаг түүнийг тамын гал тасар татна. Сүмд түүнийг дагуулж ирсэн тэр хамба, түүнд хүү шигээ ханддаг байсан тэр хүн, камерлингогийн зүтгэн Пап болтол нь шадарласан тэр хувраг ... хуурамч дүртэй байжээ. Энгийн нэгэн нүгэлтэн байжээ. Өдий болтол нууж явсан тэр хуурмаг дүрийг нь мэдсэний дараа, бурхан түүнийг өршөөх эсэхэд эргэлзэж байлаа. «Таны тангараг!» хэмээн камерлинго тэр Паптан руу байдгаараа уурсан хашхираад, гарч одлоо. «Та бурхны өмнө өргөсөн тангаргаа няцсан байна. Ерийн л нэг нүгэлтэн». Пап түүнд тайлбарлах гэсэн боловч камерлинго сонсохыг ч хүссэнгүй. Тэр замын турш уйлан, бөөлжин, өөрийгөө урж маажин, галзуу юм шиг явсаар Гэгээн Петерийн булшны өмнө цусандаа холилдон, ганцаараа хүйтэн шороон дээр хэвтэж байлаа. Мариа эх минь, би яах вэ? Биширч явсан тэр хүнийхээ хуурмаг царайд гутан, сүсэггүй энэ ертөнцөөс намайг салгаж өгөөч хэмээн бурхнаас гуйн некрополисын хүйтэн шороон дээр арчаагүй хэвтэж байх тэр эгшинд бурхан түүнтэй ярьжээ. Толгойд нь аянга мэт цуурайтах хоолойгоо *Чи бурханд зүтгэхээр андгайлсан билүү?* Гэж асуув. «Тийм, тэгсэн!» гэж камерлинго хашхирлаа. «Бурхныхаа төлөө үхэхээс шантрахгүй юу?» «Шантрахгүй. Тэгээд намайг аваад яваач!» «Шашны төлөө үхэхээс шантрахгүй юу?» «Шантрахгүй». «Тэгвэл ... хүн төрөлхтний төлөө үхэхээс шантрахгүй юу?» Камерлинго гэнэт чимээгүй болох агшинд тэр ёроолгүй гүн ангал руу унаж байв. Тэр улам хурдан хурдан унана. Гэхдээ тэр хариултаа мэдэж байлаа. Дандаа л мэддэг байв. «Тэгнэ!» гэж байдаг чадлаараа хашхирлаа. «Би хүний төлөө үхнэ! Яг таны хүү шиг би тэдний төлөө үхнэ!» Цагийн дараа, камерлинго шороон дээр эвхрэн хэвтсэн хэвээрээ л байлаа. Ээжийнх нь царай үзэгдэв. *Бурхан чамайг хайрласан. Чи учиртай төрсөн юм шүү* хэмээн хэлнэ. Камерлинго дахин галзуурч эхлэх шиг болов. Гэтэл бурхан түүнтэй дахин ярилаа. Гэхдээ энэ удаа аниргүй

хэлжээ. Камерлинг түүнийг маш сайн ойлголоо. Сүсгийг сэрээ! *Чи биш бол ... хэн? Одоо л биш бол ... хэзээ?* Харуулууд Систин цогчны хаалгыг онгойлгож, Карло Вентреска камерлинг судсаар нь эрх сүр гүйхийг мэдрэн, урагш шийдэмгий алхан орлоо. Бурхан түүнийг сонгосон. Бүр анхнаасаа... *Түүний хүслийг гүйцээнэ ээ.* Камерлинг дахин төрсөн юм шиг л мэдэрч байлаа. Швейцар жард түүний шархыг сувилж, усанд оруулаад, шинэ цагаан дээл өмсгөжээ. Түлэгдсэн шарханд нь морфин тариад, дараа нь өвчин намдаагч хийх гэхэд нь хэрэггүй хэмээн татгалзжээ. *Есүс тэнгэрт халихын өмнө, өвчин зовлонгоо гурван хоног амссан билээ!* Тэр бүр хөлийнхөө улаас дээшээ өвчнөө мэдрэхээ больж эхэлсэн байлаа. Цогчинд орж ирэхэд нь, кардиналууд түүнийг мэлрэн харж байхыг хараад, тэр огт гайхсангүй. *Тэд одоо л бурхныг мэдэрч байна. Надад биш, надаар дамжин илрэх бурханд тэд биширч байгаа юм* хэмээн өөртөө сануулна. Цогчны дундуур хөндлөн гарахдаа ... уурссан царай олж харав. Хажуугаар өнгөрөх хүн болгоны царайнаас ямар нэг өөр зүйл болоод байгааг харлаа. Юу байдаг билээ? Тэд түүнийг өнөө шөнө хэрхэн хүлээж авах бол гэж нэг бус удаа бодсон билээ. Баясч уу, биширч үү? Тэр хүмүүсийн нүдийг нь харвал аль нь ч алга байлаа. Тэгээд, тахилын гол ширээ рүү очих агшинд ... Роберт Ландоныг олж харлаа.

Хэсэг 131

Карло Вентреска камерлинг Систин цогчин дотор зогсч байлаа. Бүх кардинал босоод зогсчихсон, түүн рүү харж байв. Ландон хоймрын тахилын өмнө зурагтын хажууд зогсчихсон, тэр зурагтаар камерлингогийн мэдэх үйл явдал дахин дахин өрнөх ба тэр үйл явдлыг хэн бичээд, хэн энд үзүүлснийг ухаарч ч чадахгүй байлаа. Витториа Ветра хажууд нь хүрлийн зогсоно. Камерлинг нүдээ аниад, нөгөө морфин нь хий юм харагдуулж байна, одоо нүдээ нээхэд өөр байдал харагдах вий хэмээн найдна. Даан ч тэгсэнгүй. Тэд мэдчихжээ. Жигтэй нь, тэр ердөө айсангүй. *Бурхан минь, таны надад захисныг эд нарт ухааруулах үг хайрлаач.* Хэн ч юу ч хариулсангүй. *Эцэг минь, одоо бүтэлгүйтэхэд хэтэрхий оройтсон байна шүү дээ.* Аниргүй хэвээр. *Бид хоёрын хийснийг тэд ойлгохгүй шүү дээ, эцэг тэнгэр минь.* Камерлинг хэний дуу сонссоноо мэдсэнгүй, гэхдээ маш тодорхой ухаарлаа. *Үнэн чамайг чөлөөлнө ...* Карло Вентреска камерлинг толгой дээш өргөн, Систин цогчны гол тахилын өмнө ихэмсэг алхан очлоо. Бүдэг лааны гэрэл ч кардиналуудын хүрлийсэн царайг зөөллөхгүй байв. Тайлбарлаад өгөөч гэж тэр царайнууд шаардана. Ямар солиотой юм хийснээ тайлбарла. Бидний буруу гэдгийг сэнхрүүлээд аль. *Үнэнийг, гагцхүү үнэнийг* хэмээн камерлинг өөртөө шивнэв. Энэ хэрмийн дотор хэтэрхий олон нууц бий ... нэг нь түүнийг солиоруулж орхисон билээ. *Гэхдээ солиорлоос л үнэн төрсөн юм чинь.* «Сая сая хүнийг аврахын төлөө өөрийнхөө өчүүхэн сүнснийг өг гэвэл та нар өгөх үү?» гэж камерлинг тэдний дундуур явангаа асуулаа. Цогчин дотор хэн ч юу ч ярьсангүй, хөдөлсөн ч үгүй, зүгээр л түүнийг ширтэнэ. Харин гадаа талбай дээр хүмүүс түүний нэрийг дуудан дуудан дуулна. Камерлинг гол тахилын өмнө очоод: «Дайснаа егүүтгэх, үнэн хайрыг чинь доромжилж байхад зүгээр суух хоёрын аль нь илүү аймшигтай нүгэл вэ?» *Хүмүүс Гэгээн Петерийн талбай дээр дуулж байна.* Камерлинг Систин цогчны тааз руу ширтэн хэсэг чимээгүй зогслоо. Микланжелогийн урласан том бурхан түүн рүү хараад ... сайшааж байх шиг. «Би цаашид тэвчихээ больсон юм» гэж камерлинг өгүүлээд, кардиналууд руу харвал тэдний нүдэнд ойлгож байгаа шинж огт тодорсонгүй. Тэд ийм амархан юм ухаарахгүй байна гэж үү? Ийм тулгуу шаардлага байгааг

ухаарахгүй байна гэж үү? Тун энгийн, мэдээжийн шүү дээ. Иллюминати. Эрдэм, Сатаан хоёр чинь нэг зүйл. Эртний айдсыг сэрээ. Тэгээд няц дар. *Айдас, найдвар хоёр. Тэдний сүсгийг сэрээ.* Энэ шөнө Иллюминати чадлаа дахин шинээр нээн харуулж, гайхалтай жүжиг шиг өндөрлөлөө. Айдас энэ дэлхийг нэгэн эгшинд хүрхэрэн эгшээж, хүн бүрийг хооронд нь дахин нягтрууллаа. Тэгээд бурхны хүч тэр хар хүчийг няц дарлаа. *Би зүгээр сууж чадаагүй юм.* Бурхан энэ эрмэлзлийг камерлинг сэтгэлийн гансралдаа авган байх тэр үед өгсөн билээ. *Энэ сүсэггүй ертөнцийг ээ! Хэн нэг нь сүсэг өгөх ёстой шүү дээ. Чи. Чи биш бол өөр хэн гэж? Чамд учиртай төрсөн. Тэдэнд хуучин албинг үзүүлж, хуучин айдсыг нь сөх.* *Тоомжиргүй байна гэдэг үхэл. Сүүдэр байхгүй бол гэрэл үгүй. Муу байхгүй бол сайн үгүй. Гэрэл сүүдрийн аль нэгийг нь сонгуул, тэднээр. Айдас хаана байна? Айдсыг дарах баатар хаана байна? Одоо биш бол хэзээ гэж?* Камерлинг алхсаар дуганы танхимын голд кардиналуудын дунд очлоо. Кардиналууд гэдрэгээ ухран зай гаргахад нь өөрийгөө улаан тэнгисийг хоёр хувааж байгаа Моша шиг төсөөлнө." Гол тахилын өмнө Роберт Ландон зурагтаа унтраагаад, Витториагийн гараас барьж, хажуу тийшээ зайдуу зогслоо. Ландон амь гарсан нь гагцхүү бурхны хүсэл биз ээ. Бурхан Ландоныг аварчээ. Гэхдээ яагаад гэдгийг нь гайхна. Анир чимээгүйг эвдэн дуганд, байсан цорын ганц эм хүн Витториа Ветра тасхийтэл хашхиран, урагш давшлав. «Чи аавыг минь алсан уу?» гэв. Камерлинг - Витториа Ветра руу эргэж, харцыг нь хараад ойлгосонгүй. Гансрал харагдана, гэхдээ бас уурлаа юу? Гэхдээ, бүсгүй ойлгох ёстой шүү дээ. Аавынх авьяас билэг өөрийг нь үхэлд хүргэсэн. Түүнийг зогсоох ёстой байсан. Бүх хүн төрөлхтний тусын тулд шүү дээ. «Аав маань бурхны төлөө ажиллаж байсан» гэж Витториагийн хоолой нь зангиран хэлэв. «Бурхны төлөө лабораторьт ажилладаггүй юм. Бурхны төлөө хүмүүсийн сэтгэлд ажилладаг юм». «Аавын минь сэтгэл ариун байсан. Түүний судалгаа...» «Түүний судалгаа хүний тархи, сүнснээсээ илүү хурдан хөгжиж байгааг л нотолсон!» Камерлинггийн хоолой хутга шиг хурц байлаа. Хэн ч тийм дуу хоолой түүнээс гарна гэж бодсонгүй. «Аав шиг чинь шүтлэгтэй хүн өнөө шөнө бидний харсан тийм зэвсэг хийж байгаа юм чинь ерийн хүн тийм технологиор юу хийх байсныг төсөөлөөд үз!» «Чам шиг хүн үү?» Камерлинг гүнзгий амьсгаа авлаа. Энэ хүүхэн ухаарахгүй байна гэж үү? Хүний ёс суртахуун эрдэм мэдлэгээс илүү хурдан хөгжиж чадахгүй байна. Хүн төрөлхтөн ёс суртахууны хувьд одоо байгаа зэвсгээ эзэмших хэмжээнд хүртэл хангалттай хөгжөөгүй байна. Бид хийсэн зэвсгээ хэрэглэхгүй байж үзээгүй! Тэгээд ч Леонардо өөрөө хийсэн бүтээсэн нь хүн төрөлхтөнд шинэ төрлийн зэвсэг нэмж байгааг мэдэж байсан. Гэхдээ, түүнийгээ үгүй хийж чадаагүй. Хүн бие биеэ алж сураад удаж байна. *Ээжийнх нь хэлсэн санаанд буув.* Леонардо Ветра өөр бас нэгэн шалтгаанаар аюултай байлаа. «Зуун зууны турш эрдэм шашныг бага багаар эмтэлж байхад, сүм хийд зүв зүгээр сууж байсан. Тэгсээр гайхамшиг элэгдлээ. Оюунаа сэтгэлээсээ илүү дасгалжууллаа. Хүмүүс олноороо шашныг буруутгадаг болсон. Бурхан гэдэг бол амьдрал утгагүй гэдгийг зөвшөөрөх чадалгүй дорой хүмүүсийн зохиосон хий үзэгдэл, галлюцинац болж хувирсан. Эрдэм бурхны чадлыг ингэж мохоож байгааг би тэвчиж чадаагүй. Нотол гэж та нар хэлдэг билүү? Эрдмийн тоомжиргүй байдлыг нотлох хэрэг үү? Бидний ухаарлын хүрээнээс гадна нэг юм оршдог гэдгийг зөвшөөрөх, юу нь буруу байгаа юм бэ? Бурхны үйлийг лабораторьт давган хийх тэр өдөр л хүмүүст сүсэг хэрэггүй болно!» «Хүмүүст сүм хэрэггүй болно гээч!» гэж Витториа түүн рүү давшлан өгүүлэв. «Та нар хүмүүсийг эргэлзээнд байлгаж байж хянах гээ юу? Эргэлзээ чамд сүнс өгдөг хэрэг үү? Бид амьдрал учир утгатай гэдгийг мэдэх хэрэгтэй. Хүн айх тусам, гэгээрсэн сүнсийг хайдаг болохоор л бид бурхныг дотроо хайрладаг. Гэхдээ сүм гэдэг энэ хорвоо байгаа цор ганц гэгээрсэн сүнс биш. Бид тус бүрдээ бурхныг өөр өөрийнхөө замаар

хайдаг. Чи юунаас нь айгаа вэ? Бурхан энэ хэрмээс өөр газар гараад ирнэ гэж айгаа юу? Хүмүүс бурхныг өөр өөрийнхөө амьдралаас олж, эцэстээ эртний энэ зан үйл чинь хаягдана гэж айгаа юу? Шашин хөгжих ёстой! Оюун асуултад хариулж, сэтгэл шинэ үнэнийг шингээдэг юм. Аав чамтай л адил бурхныг өөрийнхөөрөө хайж явсан! Зэрэгцээ шугамаар л хайж явсан! Чи яагаад үүнийг олж хараагүй юм бэ? Бурхан гэдэг биднийг дээрээс хараад, дуулгаваргүй байвал гал руу шидчихдэг дарангуйлагч биш! Бурхан гэдэг бидний мэдрэлийн судлуудаар гүйж, зүрхэн дотор минь байдаг энерги юм шүү дээ! Бурхан хаа сайгүй бий!»

«Эрдмээс бусдад нь» гэж камерлинго өрөвч зөөлөн нүд гарган хэллээ. «Эрдэм гэдэг уулаасаа сүнсгүй эд. Сэтгэлээс ангид зүйл. Антиматери шиг оюуны ололтууд энэ дэлхийд ямар нэг ёс суртахууны зааваргүй бий болдог юм шүү дээ. Тийм болохоороо л аюултай. Тэгээд, эрдэм өөрийгөө бурхангүй зүтгэлээр бий болсон Гэгээрлийн мөр гэж зарлавал? Гоо сайхан гэж юу вэ гэдэг асуултад асуултаар хариулдаг бол?» гэснээ камелинго толгой сэгсрэн: «Үгүй дээ, тийм байж болохгүй» гэлээ. Танхим хэсэг чимээгүй болов. Камерлинго Витториагийн цоо ширтсэн харцтай тулгарснаа, гэнэт асар их ядарч цуцсанаа ухаарлаа. Уул нь ийм байх ёсгүй байсан юм. *Энэ тэгээд бурхны сүүлчийн сорилт уу?* Гэтэл Мортати аниргүйг эвдэв.

«Дэвшигч?» гэж айдаст автан шивнэж: «Баггиа нар. Чи тэднийг яагаагүй биз дээ?» гэв. Камерлинго түүний хоолойд нь гансрал тодрохыг ажиглан гайхлаа. Мортати ийм зэргийн юмыг ухаарах ёстой шүү дээ. Шуурхай мэдээ бүхэн өдөр болгон эрдмийн нээлтийн тухай л мэдээлдэг. Харин шашны тухай хэр мэдээлдэг вэ? Зуун жилд ганц уу? Шашинд гайхамшиг хэрэгтэй байна шүү дээ! Тэр гайхамшиг энэ ертөнцийг нойрноос нь сэрээх ёстой. Зөв замд нь эргүүлээд оруулах ёстой. Сүсгийг сэрээх ёстой. Дэвшигч нар тэртээ тэргүй удирдагчид байж чадахааргүй байсан, тэд бол хуучныг хаяж, шинэ ертөнцийг тэврэн авахад бэлэн олиггүй либералууд л байсан. Шашныг аврахын тулд шинэ удирдагч хэрэгтэй. Залуу. Эрчтэй. Чадалтай. Гайхалтай. Дэвшигч нар ингэж үхсэнээрээ амьд байснаасаа илүү том гавьяа шашинд байгуулсан. Айдас, найдвар хоёр. *Сая саяыг аврахын тулд дөрвөн сүнс л золигт гаргаа биз.* Ертөнц тэр дөрвийг шашны баатрууд гэж мөнхөлнө. Сүм хийдүүд тэр дөрөвт зориулж тахил өргөнө. *Хэдэн мянган хүн бурхныг алдаршуулахын тулд үрэгдэв? Гэтэл тэр чинь ердөө л дөрвүүлээ байсан шүү дээ!* «Дэвшигч?» гэж Мортати давган асуув. «Би та бүхнийг эмгэнэлийг хуваалцаж байна» гээд өөрийгөө өмгөөлөн, цээж рүүгээ зааж: «Би ч гэсэн бурхны төлөө үхэх байсан, гэхдээ миний ажил дөнгөж эхэлж байна. Тэд Гэгээн Петерийн талбай дээр дуулж байгааг сонсож байна уу?» гэв. Мортатигийн харцад айдас тодрохыг камерлинго хараад мэлэрч орхив. Морфиноос болоод байгаа юм уу? Камерлинго улаан гараараа тэр дөрвийг тонилгочихсон юм шиг Мортати харж байлаа. *Бурхны төлөө бол би тэгэхээс ч буцахгүй* гэж камерлинго бодов. Гэхдээ үйлийг бол хассассин, өөрийгөө Иллюминатигийн даалгаврыг гүйцэтгэж шашныг хорлож байна гэж бодсон хөөрхий тэр алуурчин үйлдсэн билээ. *Би Янус байна. Би чамд чадлаа харуулна* гэж камерлинго түүнд хэлж, хэлснээ ч гүйцээсэн билээ. Хассассины жигшил өөрийг нь бурхны шатрын хүү болгожээ. «Хүмүүс дуулахыг сонс доо» гэж камерлинго инээвхийлэн, дотроос нь баяр хөөр төрөн хэлэв. «Айдсаас өөр юу ч сэтгэлийг ингэж нэгтгэдэггүй юм. Сүмийг дахин барина. Өнөө шөнө тэр хүмүүс яаж эвлэснийг хар даа. Айдас тэднийг гэрт нь авчирчээ. Орчин үеийн албинг орчин үеийн хүн рүү туу. Тоомжиргүй байхаа болино. Нүглийн нүдийг харуул, Сатаан төр, банк, сургууль, тэр бүү хэл бурхных нь сүмд хүртэл нэвчиж, нээж олсон эрдмийг нь ашиглан сөнөөж байгааг харуул. Бүр их хорлонтой харуул. Хүн эсэргүүцнэ. Сайн сайхныг хайна. Хүн өөрөө сайн сайхан болно!» Аниргүй болов. Тэд одоо л нэг юм ухаарав бололтой. Иллюминати дахиж сэргээгүй. Иллюминати аль хэдийн мөхсөн. Харин домог нь амьд.

Камерлинго Иллюминатиг зүгээр л сэрүүлэг болгосон юм. Иллюминатигийн домгийг мэддэг бүхэн түүний айдсыг дахин мэдэрлээ. Мэддэггүй нэг нь мэдэж аваад, ямар сохор дүлий явж байж вэ гэдгээ мэдлээ. Эртний албингууд ирж нойрмог ертөнцийг сэрээлээ. «Гэхдээ ... тэр тэмдгүүд?» гэж Мортати хэлэхэд, хоолойд нь жигшил тодров. Камерлинго хариулсангүй. Ватикан тэдгээр тэмдгийг хэдэн зуун жилийн өмнө хурааж авсан гэдгийг Мортати хэрхэн мэдэх билээ. Тэднийг Боржа дахь Папын хувийн зооринд Папын хоргонд түгжээд, мартаж, шороо тоосонд дарагдан байжээ. Түүнийг Папаас өөр хүн харвал, хэтэрхий аюултай гэж шашин үзээд тийн даржээ. *Айдас төрүүлсэн тэр зүйлийг яагаад шашин тийм далд нуугаа вэ? Айдас хүмүүсийг бурхан руу улам ойртуулдаг шүү дээ.* Папын хоргоны түлхүүр Папаас Папт дамжин иржээ. Карло Вентреска камерлинго тэр түлхүүрийг сэмхэн аваад дотор нь орж үзжээ. Тэр дотор Апокрипа гэх Библид хэвлэдэггүй арван дөрвөн бүлгийнх нь гар бичмэл, Онгон Мариагийн булшны тодорхой байршил гээд л гайхалтай зүйлс дүүрэн байлаа. Түүнээс гадна, Иллюминатигийн цомгийг камерлинго олжээ. Ватикан Иллюминатиг Ромоос хөөн гаргасныхаа дараа, бүх нууцыг нь олж, ... Гэгээрлийн мөр ... Ватиканы хамгийн том урлаач Бернинигийн урвалт ... Ватиканы өөрийнх нь өмчийн Гэгээн Ангелийн цайзад Европын шилдэг эрдэмтэд хуран шашныг мөхөөхийг оролдож байсныг бүгдийг нь илрүүлжээ. Тэнд бас тавалж хайрцаг байх агаад дотор нь нөгөө алдарт Иллюминатигийн очир байлаа. Эртний аюулаа мартсан нь дээр гэдэг Ватиканы уламжлалын дагуу тэднийг тэнд нь мартжээ. Харин камерлинго үүнийг зөвшөөрсөнгүй. «Тэгвэл антимаатерийг юу гэх вэ? Чи Ватиканыг устгах эрсдэлийг тоосонгүй гэж үү?» гэж Витториа лавлав. «Бурхан чиний талд байхад эрсдэл гэж байдаггүй юм» гэж камерлинго хариулав. «Эцсийн эцэст энэ бол бурхны үйл байсан» гэлээ. «Чи чинь солиотой юм байна!» гэж бүсгүй гайхшрав. «Сая сая хүнийг аварсан шүү дээ». «Баахан хүнийг алаа биз дээ, чи?» «Сүнс нь аврагдсан байх шүү!» «Наадахаа чи өөрөө очиж аав, Максимлиан Колэр хоёрт хэл!» «СЭРН-ийн мөн чанарыг илчлэх ёстой байсан юм. Чи өөрөө хагас бээрийг устгах чадалтай дусал хийчхээд, намайг солиотой гэнэ үү?» гэж камерлинго уурсан давшлав. Энийг ерийн л нэг цэнэг байсан гэх гээ юу? «Бурханд итгэдэг бүхэн түүний сорилыг туулдаг жамтай! Бурхан Авраамыг хүүгээ егүүтгэн тахил өргөхийг хүссэн! Бурхан Есүсийг загалмайд хадуулахыг тушаасан! Тэгээд бид өнөөдөр цуст, зовлонт, гаслант загалмайг өдөр болгон хар хүчний чадлыг бүү март хэмээн ханандаа зүүдэг! Тэрийг хараад, сэтгэл хатууждаг! Есүсийн цээжин дээрх шарх хар хүчний чадлыг сануулсан амьд сэрүүлэг! Миний цээжин дээрх шарх хар хүчний чадлыг сануулсан амьд сэрүүлэг! Хар хүч амьд, харин бурхны хүсэл тэднийг дийлдэг!» Түүний дуу Систин цогчинд цуурайтахад, үхээрийн аниргүй танхимыг ноёрхов. Цаг зогсчих шиг боллоо. Микланжелогийн Сүүлчийн шүүлт камерлингогийн араас тодорч, Есүс нүгэлтнүүдийг тамд илгээнэ. Мортатигийн нүдэнд нулимс цийлэлзэв. «Чи юу хийчхээ вэ, Карло минь?» гээд Мортати шивнэв. Нүдээ анихад нь том том нулимс бөмбөрөн унана. «Дээрхийн гэгээн?» Хүмүүс нэгэн зэрэг санаа алдах шиг болов. Бүх хүн түүнийг дөнгөж сая л санав уу гэлтэй. Паптан. Хорлогдсон гээ биз дээ? «Хорлонт худалч!» гэж камерлинго хөмхий зуун занав. Мортати цочин түүн рүү харж: «Чи юу гэнэ ээ? Тэр шударга хүн байсан... Тэр чамд үнэн голоосоо хайртай байсан шүү дээ» гэлээ. «Би ч түүнд хайртай байсан». *Би түүнд ямар хайртай байлаа? Гэвч хуурамч амьтан! Бурханд өргөсөн тангаргаа няцсан!* Камерлинго кардиналууд энэ тухай яривал одоохондоо ойлгохгүй гэдгийг мэдэж байлаа. Гэхдээ ойлгуулах л хэрэгтэй байв. Хэлбэл ч ухаарах байлгүй дээ! Дээрхийн гэгээнтэн энэ шашны түүхэнд байгаагүй худалч хүн байлаа. Тэр аймшигт шөнийг камерлинго одоо ч тод санана. Камерлинго СЭРН-ээс ирээд Ветрагийн Үүтгэл, антимаатерийн аймшигт чадлын тухай илтгэжээ. Паптан тэндээс аймшиг мэдрэх байх гэж

бодож байсанд, тэр харин ч Ветрагийн нээлтээс найдвар олж харжээ. Тэр бүр Ватикан Ветрагийн ажлыг санхүүжүүлж, шашны холбогдолтой эрдмийн судалгаанд нааштай хандах ёстой гэж ярьжээ. *Солиорол! Шашин өөрийгөө үгүйсгэх эрдмийн судалгааг санхүүжүүлнэ гэнэ ээ? Үй олноор хөнөөх зэвсгийн суурь болох ажлыг уу? Ээжийг нь хөнөөсөн бөмбөгийг хийсэн шиг тийм судалгааг уу...?* «Та тэгж болохгүй шүү дээ» гэж камерлинго хэлмэн хэлэв. «Би эрдэмд их өртэй хүн» гэж Паптан хэлэв. «Би нэг зүйлийг насаараа нууж ирсэн. Намайг залуу байхад эрдэм надад бэлэг өгсөн юм. Би тэр ачийг хэзээд санаж явах учиртай» гэлээ. «Мөхөс би ухаарсангүй. Бурханд зүтгээ хүнд эрдэм ямар бэлэг барьж чадах билээ?» «Энэ хэцүү» гэж Паптан хэллээ. «Чамд ойлгуулахын тулд цаг хэрэгтэй. Гэхдээ, чи миний тухай нэг жирийн зүйлийг мэдэж ав. Би үүнийг бүх насаараа нуусан юм. Одоо чиний мэдвэл зохих цаг нь болсон» гэлээ. Тэгээд, Паптан аймшигт нууцаа дэлгэлээ.

Хэсэг 132

Камерлинго Гэгээн Петерийн булшны өмнө шороон дээр эвхрэн хэвтэнэ. Некрополис хүйтэн байлаа, гэхдээ камерлингогийн сэтгэлд хурсан гомдол цусаар нь даган бүх биеийг нь бүр ч илүү царцааж байлаа. Дээрхийн гэгээн намайг эндээс олохгүй. Хэн ч олж чадахгүй... «Энэ хэцүү» гэж хэлэх Папын дуу сэтгэлд нь цуурайтна. «Чамд ойлгуулахын тулд цаг хэрэгтэй...» Хэчнээн их цаг орсон ч камерлинго түүнийг нь ойлгохгүй гэдгээ мэдэж байлаа. Муу худалч! Би итгэж байхад..! БУРХАН итгэж байхад..! Арай ч дээ! Пап ганц үг хэлээд л, камерлингогийн итгэж явсан бүх зүйлийг нураагаад хаячихжээ. Багшийнхаа тухайд итгэж явсан бүх зүйл нь эгшний дотор бутран алга боллоо. Камерлингогийн цээжинд хурсан тэр үнэн хамаг сэтгэлийг нь хутгаж, Папын өргөөнөөс гүйж явахдаа хүртэл бөөлжиж байлаа. «Байз! Би тайлбарлая!» гэж Пап араас нь босч зогсоод хоцорлоо. Камерлинго зугтаж одов. Дээрхийн гэгээн камерлингог юу гэж бодоод, үүнээс илүү адал балмадыг тэвчинэ гээ вэ? Өөр хүн мэдсэн бол яана? Энэ шашны ариун нь хаачлаа? Папын тангараг юу ч биш юм гэж үү? Солиорох шиг болж, ухаан зулаггүй гүйсээр камерлинго Гэгээн Петерийн булшны өмнө л сэхээ оржээ. Яг тэр үед бурхан түүн дээр ирж, түүнтэй ярьжээ. **ЧИНИЙ БУРХАН ӨРШӨӨЛГҮЙ!** Тэгээд, тэр хоёр хамтдаа төлөвлөгөө зохиолоо. Тэр хоёр шашныг хамтдаа хамгаална. Тэр хоёр хамтдаа сүсэггүй ертөнцийн сүсгийг сэрээнэ. Хар хүч энд тэндгүй байна. Одоохондоо энэ ертөнц дархлаатайгаа байна. Тэр хоёр хамтдаа энэ ертөнцөд хар хүчийг илчлэн харуулж ... тэгээд бурхан түүнийг аварна! Айдас, найдвар. Тэгээд ертөнц сүслэх нь лав! Бурхны эхний сорилт амархан байлаа. Папын унтлагын өрөөнд орж ... тариаг нь дүүргээд ... үхэж дуусах хүртэл нь худалчийн амыг дарах. Сарны гэрэлд, Папын нүд нь ямар нэг юм хэлэх гээд байхыг камерлинго харлаа. Гэвч оройтжээ. Паптан хангалттай ихийг хэлчихсэн.

Хэсэг 133

Паптан хүүхэдтэй байсан юм». Дуган дотор камерлинго энэ үгийг хэлэхэд, хүмүүс таг мэгдэн, тэдний гайхсан эргэлзсэн царайг хараад, тэр бардам зогсоно. Тавхан үг аймшигт нууц дэлгэлээ. Түүнийг жигшиж ялласан кардиналуудын харц тэвдэж бачимдсан байдалтай болж, камерлингогийн буруу байгаасай хэмээн залбирч байх шиг. *Паптан хүүхэдтэй байсан*

юм. Ландон ч бас гиюурч орхилоо. Алганд нь байсан Витториагийн гар чичирсхийв. Харин Ландоны толгойд түмэн асуулт хариулт нэхэн хуйларч, дэлхийн төв хаана байгааг ч олохоо болив. Камерлингогийн хэлсэн үг агаарт хуйлран тогтоод, эгээ л антиматерийн тэсрэлтээс үүссэн гэрлэн бөмбөлөг шиг доор байгаа хүмүүсийг балмагдуулж орхилоо. Солиотой юм шиг нүдэнд нь шударга бат зарчим тодрох шиг. Ландон энэ бол хар дарсан зүүд, удахгүй сэрнэ гэж өөртөө итгүүлэх гэж оролдов. «Битгий худал хэл!» гэж нэг кардинал хашхирлаа. «Итгэж чадашгүй нь! Дээрхийн гэгээн энэ хорвоо дээр амьдарч байсан бүх хүнээс хамгийн ариун хүн байсан юм» гэж нөгөө нь бувтнав. Гэтэл Мортати намуун зөөлөн хоолойгоор дуугарлаа. «Нөхөд минь! Камерлингогийн хэлдэг үнэн шүү.» Дуганд байсан кардиналуудын үстэй толгой нь арзайн, бүгд нэгэн зэрэг Мортати руу цочин ширтлээ. «Паптан үнэхээр хүүхэдтэй байсан юм уу?» Камерлинго гайхан, Мортати руу харж: «Та мэдэж байсан юм уу? Та ... яаж мэдсэн юм бэ?» гэв. Мортати уртаар санаа алдаад: «Дээрхийн гэгээн сонгогдох гэж байхад... би чөтгөрийн мөрч байсан юм» гэлээ. Бүх хүн нэгэн зэрэг дуу алдав. Тэгэхээр үнэн байх нь хэмээн Ландон бодлоо. «Чөтгөрийн мөрч» гэдэг нь Ватиканд ямар нэг ичгүүрт хэрэг гарвал, мөрдөн шалгадаг тушаалтан ажээ. Папаар хэн сонгогдов гэдэг чухал, бас аюул дагуулж болзошгүй асуудал, тиймээс сонгууль болохоос өмнө, Пап болохоор нэр дэвшсэн хүний булай булхайг илчлэхээр, нэг кардиналыг нууцаар томилдог ажээ. «Чөтгөрийн мөрч» гэгдэх тэр этгээд нэр -дэвшсэн хүнийг Пап болгож болохгүй бүх шалтгааныг уудлан дэлгэх үүрэг хүлээнэ. Насных нь тоо ойртсоноо мэдсэн Паптан амьд ахуйдаа дараагийнхаа Папыг тодруулах зорилгоор «Чөтгөрийн мөрч» томилдог ажээ. Чөтгөрийн мөрч хэзээ ч өөрийгөө илчлэх ёсгүй билээ. «Би Чөтгөрийн мөрч байсан юм. Тэгж л би мэдсэн хэрэг» хэмээн Мортати давтан өгүүлэв. Хүмүүс амаа ангайн алмайрна. Өнөө шөнө Ватиканд зөрчигдөөгүй хууль бараг үлдсэнгүй. Камерлингогийн дотор бачимдан: «Та тэгээд хэнд ч хэлээгүй юм уу?» хэмээн давшиллаа. «Би Дээрхийн гэгээнийг улайлгасан. Тэр наманчилж, бүх зүйлийг нэгд нэгэнгүй тайлбарлан өгүүлж, энэ нууцыг дэлгэх эсэхийг зөвхөн миний сэтгэлд даатган орхисон юм» хэмээн Мортати тайван өгүүлнэ. «Таны сэтгэл тэгээд энэ мэдээллийг дарж өнгөрүүлэхээр шийдээ юү?» «Тэр Пап болох магадлал хамгийн их хүн байсан. Хүмүүс түүнд хайртай байсан. Хэрэв илчилсэн бол шашны нэр хүнд асар их унах байсан юм». «Гэхдээ тэр чинь хүүхэдтэй хүн шүү дээ! Тэр биеэ зандан хадгалах ариун тангаргаа зөрчсөн байсан». Камерлинго одоо дахиад л солиотой юм шиг хашхичиж эхлэв. Сэтгэлд нь ээжийнх нь хэлсэн үг бууна. *Бурханд өргөсөн тангараг бол хамгийн дээд тангараг. Бурханд өргөсөн тангаргаа хэзээ ч битгий няцаарай!* «Паптан бурханд өргөсөн тангаргаа няцсан шүү дээ!» Мортати дүрсхийн уурлав. «Карло, түүний хайр ариун байсан. Тэр ямар ч тангараг зөрчөөгүй. Чамд тайлбарлаагүй юм уу?» «Юуг нь тайлбарлах юм бэ?» Камерлинго Папын өргөөнөөс ухаан зулаггүй гарч гүйхэд, Паптан араас нь *Би чамд тайлбарлая л даа* хэмээн дуудаж байсан нь санагдав. Мортати аажуухан, бас гунигтай яа, болсон явдлыг дэлгэлээ. Олон жилийн өмнө Паптан залуу гэлэн байхдаа үзэсгэлэнтэй нэгэн гэлэнмаад дурлажээ. Хоёулаа бурханд зандан байх тангараг өргөсөн болохоор тэр тангаргаа няцах зориг байсангүй. Тэр хоёрын дурлал улам улам цэцэглэжээ. Хэдийгээр тэр хоёр махан биеийн нойтон жаргалыг тэвчсэн ч, хоёул бурхны гайхалтай бэлэг - хүүхэдтэй болохыг хүсжээ. Тэр хоёрын хүүхэд. Бүсгүй илүү их тачаадаж байсан ч бурхандаа өргөсөн тангаргаа тууштай барьжээ. Нэг жилийн дараа тэр хоёрын тачаал тэсэхүй еэ бэрх болох үед нэг удаа бүсгүй жигтэй сонин мэдээтэй иржээ. Эрдмийн шинэ ололтын дүнд, эр эм хоёр бэлэг золгохгүйгээр хүүхэдтэй болж болох тухай нэгэн өгүүлэл уншжээ. Бүсгүй үүнийг бурхнаас илгээсэн бошго гэж үзсэн гэнэ. Гэлэнмаагийн нүдэнд төрсөн баяр бахдалыг гэлэн хараад, зөвшөөрчээ. Жилийн дараа гэхэд

бүсгүй хиймэл үр тогтоох замаар хүүхэдтэй болжээ... «Байж боломгүй юм» хэмээн камерлинго хашхирав. Тариулсан морфин нь хамаг мэдрэлээр нь тоглоод байгаа юм болов уу гэж бодовч, түүний сонссон бодитой байлаа. Мортати нулимсаа арчаад: «Карло! Тийм л учраас Дээрхийн гэгээн эрдэмд талархалтай ханддаг байсан юм. Тэр өөрийгөө эрдэмд их өртэй хүн гэж боддог байсан юм. Эрдмийн ачаар тэр бурханд өргөсөн зандан байх тангаргаа няцалгүй, эцэг байхын жаргалыг эдэлсэн билээ. Дээрхийн гэгээн шашны замаар ахиж дэвшихэд, хайртай бүсгүйтэйгээ хамт байж, хүүгээ хамт өсгөхийн жаргалыг мэдэрч чадаагүйдээ л жаахан сэтгэл дундуур байдаг хэмээн дурдсан билээ». Карло Вентреска камерлинго өөрийгөө солиорч байгааг одоо мэдэрлээ. Махан биеэсээ хагацан, зугтмаар санагдана. *Би яаж мэдэх юм бэ?* «Паптан ямар ч нүгэл үйлдээгүй, Карло. Тэр ариун байсан юм.» Камерлинго өөрийгөө цагаатгах шалтаг хайн, галзуу юм шиг цамнан: «Гэхдээ бод доо. Үйлийнх нь үрийг бод. Үйлийнх нь үр гараад ирвэл яах вэ? Бурхан өршөөг, тэр хүүхэд нь хүрээд ирвэл яах вэ? Энэ шашин ямар ичгүүрт автахыг төсөөл дөө!» хэмээн шүдээ хавиран давшлав. Мортати түгшиж эхлэв. «Түүний хүү нь энд хүрээд ирчихсэн шүү дээ!» Бүх хүн мэгдэн, галзуу юм шиг нүдээр Мортати руу төөнөв. Мортатигийн хоолой нь зангиран, чичирч: «Карло..? Дээрхийн гэгээний хүү нь ... чи шүү дээ!» гэлээ. Камерлингогийн зүрхэн дэх сүсгийн гал унтарчихлаа. Дээр нь Микланжелогийн Сүүлчийн шүүлт зураг заналтай яа сүглийн, гол тахилын өмнө чичрэн зогсоно. Тамаас чөтгөр гарч ирээд, түүн рүү зальтай яа ирмэн, тохуурхах шиг санагдана. Амаа ангайсан боловч үг дуугарч чадсангүй. «Чи ядаж гадарлаагүй юм уу?» гэж Мортати зандран: «Дээрхийн гэгээн яах гэж чамайг жаахан байхад чинь, Палермогийн эмнэлэгт чам дээр очсон гэж бодоо вэ? Чамайг яах гэж өөр дээрээ аваад, өсгөж хүмүүжүүлсэн гэж бодоо вэ? Түүний дурласан бүсгүй Мариа ... ээж чинь байсан юм. Тэр чамайг өсгөх гэж сүмээс гарсан, гэхдээ бурханд өргөсөн тангаргаа хэзээ ч зөрчөөгүй юм. Паптан дэлбэрэлтээс болж, эх чинь өнгөрөөд, чамайг гайхалтай яа амьд үлдсэнийг сонсоод ... чамайг дахиж ганцааранг чинь хэзээ ч орхихгүй гэж бурханд андгайлсан юм. Карло! Аав ээж хоёр чинь хоёулаа зандан байсан. Тэр хоёр бурханд өргөсөн тангаргаа сахисан. Тэгсэн мөртөө чамайг энэ ертөнцөд төрүүлэх арга олсон. Чи тэр гайхамшигт хүүхэд нь байхгүй юу!» Камерлинго чихээ даран, Мортатигийн үгийг сонсохгүйг хичээвч, сэтгэлээрээ сонсоод байлаа. Гол тахилын өмнө гиюүрэн балмагдан зогсоно. Ертөнц дайвалзан, ёгхийн сөхрөн уналаа. Секунд. Минут. Цаг өнгөрсөөр. Дуганы дөрвөн хананы дотор цаг хугацаа зогсчих шиг болов. Витториа бүх хүнийг эзэмдсэн ёрын гиюүрлээс салж, сэхээ ороод, Ландоны гараас гараа татаж аваад, хурсан олон кардиналын дундуур алхлаа. Дуганы хаалга тэртээ хол харагдаж, усан доогуур яваа юм шиг удаан хөдөлж, газар барагдахгүй байлаа. Кардиналуудын дундуур алхаж явахдаа, шүргэж өнгөрсөн хүн бүрд амь өгөх шиг бусдыгаа ёрын гиюүрлээс сэрээж явлаа. Зарим нь залбирна. Зарим нь мэгшин уйлна. Зарим нь түүний хойноос зүгээр л гиюүрэн ширтэнэ. Бүсгүй алхсаар дуганы хаалганд очих эгшинд, нэг гар араас нь түүнийг татан зогсоов. Эргэж харвал, нэг өвгөн кардинал хүрлийн ширтэж байлаа. Нүд нь айдсаар дүүрчээ. «Битгий. Битгий тэг л дээ» гэж тэр хэлэв. Витториа итгэж ядан мэлэрнэ. Өөр кардинал дөхөж ирээд: «Хийхээсээ өмнө бодоорой» гэлээ. Өөр бас нэг түүн рүү ирж явна. «Энэ гансрал ч ...» Кардиналууд Витториаг бүчин авлаа. Бүсгүй тэдэн рүү мэгдэн харна. «Гэхдээ өнөөдрийн явдлыг ... ертөнц даяараа үнэнийг мэдэх ёстой шүү дээ». «Сэтгэл минь зөвшөөрч байна» гэж өвгөн кардинал гарыг нь барьсан чигтээ хэлээд: «Гэхдээ буцах замгүй зам гэж бий. Хүмүүсийн найдвар хөсөр унана. Өөнтөглөнө. Хүмүүс дахиад хэрхэн сүслэх болж байна?» гэлээ. Улам олон кардинал түүний замыг хөндөлдөнө. Хар дээлэн хана өмнө нь босох шиг. «Талбай дээр байгаа хүмүүсийг сонс л доо. Энэ бүхэн тэр хүмүүсийн сэтгэлийг

аяж цочроох бол? Бид цөм эрүүл ухаанаар хандах ёстой шүү» гэж нэг нь учирлав. «Цөмөөрөө залбирья, бодох цаг хэрэгтэй байна» гэж нэг нь хэлэв. «Бид учиртай хөдлөх ёстой шүү. Ийм явдлын үр дагавар нь аймшигтай байж магадгүй» гэж нөгөө нь бувтнана. «Тэр миний аавыг хөнөөсөн! Тэр бүр өөрийнхөө аавыг ч хөнөөсөн шүү дээ!» гэж Витториа бачимдан хашхирна. «Тэр үүнийхээ төлөөсийг төлж л таараа» гэж гарыг нь барьсан кардинал гаслан өгүүлнэ. Витториа ч гэсэн тэгж бодож байлаа, гэхдээ бүр баталгаатай төлүүлэхийг хүсч байв. Тэр хаалга руу тэмүүлсэн боловч айдас хурсан царайтай хөгшин кардиналууд түүнийг бүчин авлаа. «Та нар яах гээд байгаа юм бэ? Намайг алмаар байна уу?» гэж Витториа хашхирав. Тойрон зогссон өвгөчүүл хувьсхийхэд, Витториа ингэж хэлсэндээ харамслаа. Тэд - өтөлж яваа махан бие дотроо оршсон ариун сүнснүүд байлаа. Хөөрхий тэд энэ шөнө хэтэрхий олон удаа хүчирхийлэлд өртжээ. Тэд огт заналхийлсэн янзгүй байв. Тэд зүгээр л айсан, аргаа барсан хүмүүс байв. «Би зүгээр л зөв юм хийх гэсэн юм» гэж өвгөн кардинал хэллээ. «Тэгвэл наад бүсгүйгээ тавьчих» гэж ард нь нэг хүн хэлэв. Тэр үг тайван, шийдмэг сонсогдоно. Роберт Ландон бүсгүйн хажууд ирээд, гараас нь барилаа. «Ветра авхай бид хоёр эндээс гарлаа» гэлээ. Гайхаж эргэлзсэн кардиналууд дурамжхан зай тавьж өгөв. «Азнаарай!» Мортати тэр хоёр руу хэлээд, хоймрын тахилын дэргэд сөхөрч, гиоүрч, гутсан камерлингог орхин айсуу. Тэр өмнөхөөс илүү өтөлсөн харагдана. Хөдөлгөөн нь саяын болсон ичгүүрт явдлыг туучих мэт хөшингө. Кардинал хүрч ирээд нэг гараа Ландоны, нөгөөг нь Витториагийн мөрөн дээр тавилаа. Витториад, тэр эгшинд, гүн хүндэтгэл төрөв. Өвгөний нүд гэмших мэт цийлэгнэж байлаа. «Мэдээж та хоёр явж бололгүй яах вэ» гэж Мортати хэлээд: «Мэдээж шүү дээ» гэснээ зогтусахад нь гэмшил харууслыг нь харж, бараг л барьж болмоор тод үзэгдэж байлаа. «Нэг л юм гуйя ...» гээд доошоо гэмшингүй харж, хэсэг зогссоноо, эргээд Ландон, Витториа хоёр руу эгцлэн харж: «Би үүнийг хэлье. Би одоо талбай дээр гараад хүмүүст наманчлан хэлье. Яаж хэлэхээ мэдэхгүй л байна... гэхдээ арга нь олдох биз. Шашин өөрөө наманчлах ёстой. Алдаагаа бид өөрсдөө хүлээх ёстой» гэлээ. Өвгөн эргэж, гол тахил руу харлаа. «Карло, чи энэ шашныг сүйрлийн ирмэгт аваачлаа» гэлээ. Тэгснээ зогтусав. Гол тахил хоосон байв. Дуганы хана даган, хувцас намиран ширхийх сонсогдоод, гэнэт хаалга дуугарлаа. Камерлинго гарч оджээ.

Хэсэг 134

Вентреска камерлингогийн цагаан дээл Систин цогчны шатаар намилзан, алга болов. Швейцар жард түүнийг гарч ирээд, ганцаараа баймаар байна гэхэд нь гайхаж орхилоо. Гэхдээ, дуулгавартай яа, хүндэтгэн дагажээ. Камерлинго булан тойрч, хүний нүднээс далд ормогцоо, хорьж дийлэхгүй байгаа сэтгэлээ тавилаа. Хүн тэсэхийн аргагүй гутрал, гансрал, гэмшил хуйлран, хамаг сэтгэлийг нь урж тастан байлаа. «Гэгээн эцэг минь» гэж өөрөө дууддаг, өөрийг нь «хүү минь» гэж дууддаг тэр хүндээ хор өгөөд алчихжээ. «Эцэг», «хүү» гэдэг үг зүгээр л шашны уламжлал юм гэж боддог байсан чинь, үнэхээр мах ясаараа холбоотой хоёр хүн бие биеэ тэгж дууддаг байсан юм санж. Хэдхэн долоо хоногийн өмнөх тэр шөнө шиг, камерлингогийн сэтгэл ёроолгүй ангал руу түнэр харанхуйд унаж явлаа. Ватиканы бороотой нэгэн өглөө тэндхийн ажилтнууд камерлингогийн хаалгыг нээн орж ирж, түүнийг амттай нойроос нь сэрээлээ. Дээрхийн гэгээн хаалга цохиход чимээгүй, утастахад хариу өгөхгүй байна гэнэ. Тэд голдоо ортол айсан байлаа. Папын өрөөнд зөвшөөрөл авалгүй орох эрхтэй цорын ганц хүн нь камерлинго билээ. Камерлинго Папын өрөөнд ганцаараа ороход, урд шөнө яаж үхсэн яг тэр чигтээ хэвтэж байлаа. Дээрхийн гэгээн яг л Сатаан шиг харагдаж байв. Үхэл л ийм өнгөтэй байдаг болов уу гэлтэй хэл нь тас хар байлаа. Папын

дугтам дээрээ албин шиг хэвтэнэ. Камерлинго эмгэнэсэнгүй. Бурхны зарлиг шүү дээ. Хэн ч түүний булайг мэдсэнгүй ... одоохондоо л лав мэдээгүй байгаа. Дараа нь л мэдэх биз. Камерлинго өрөөнөөс гарч ирээд, Дээрхийн гэгээнтэн зүрхний шигдээсээр таалал төгссөнийг зарлав. Тэгээд, цуурганд бэлдлээ. Мариа эхийн шивнээ чихэнд нь сонсогдоно. «Бурханд өргөсөн тангаргаа хэзээ ч битгий няцаарай!» «Ээж минь, би таныг сонсоод байна. Энэ сүсэггүй ертөнцийг эргүүлээд зөв замд нь оруулах хэрэгтэй байна. Айдас, аврал хоёр л ганц зам шүү дээ» хэмээн камерлинго хариулна. «Тийм ээ. Хэрэв чи биш бол ... хэн? Хэн энэ шашныг энэ харанхуйгаас авч гарах вэ?» Дэвшигч нарын нэг л лав биш. Тэд хөгшин ... амьдаараа үхчихсэн ...эртний ёсыг халж орчин үеийн хүмүүсийг даган хөл алдаж эрдмийг хөхин магтах либералууд. Цаг үеэсээ хоцрогдсон мөртөө, үгүй гэж долдгонох өвгөд. Мэдээж тэд эрх баривал сүйрч л таарна. Шашны тэнхээ нь уламжлал, огт үл хувирахад л байдаг. Бүх дэлхий хувьсана. Харин шашин хувьсах шаардлагагүй, зүгээр л хувьсан буй ертөнцөд өөрийнхөө чухлыг л сануулан байх үүрэгтэй. Хар зүгийн хүч оршсоор буй! Бурхан дийлж л таарна! Шашинд удирдагч хэрэгтэй. Хөгшчүүл хэзээ ч хүмүүсийг өөртөө татаж чаддаггүй! Есүс татаж байсан! Залуу, эрчтэй, чадалтай ... ГАЙХАЛТАЙ! «Цайгаа тавтай барь» гэж камерлинго хэлээд, дөрвөн дэвшигч-ийг Папын хувийн номын санд үлдээгээд гарлаа. Цуурган болох гэж байв. «Та бүхнийг энд хүн ирж дагуулна». Дэвшигч нар түүнд талархаад, алдарт Пассето хонгилд орж үзэхийг урьсанд гайхлаа. Гайхалтай! Камерлинго тэднийг орхихын өмнө хонгилын цоожийг нээж, харин яг цагтаа хаалга онгойн, араб царайтай нэгэн гэлэн бамбар барьсаар орж ирээд, хөөрхий дэвшигч нарыг хонгилоор авч одов. Хөөрхий тэд дахиж гарч ирсэнгүй. Тэгээд айдас, дараа нь аврал ирнэ. *Үгүй байлгүй дээ... би тэр албин чинь өөрөө байжээ.* Камерлинго Гэгээн Петерийн ордны сүүдэрт гүйнэ. Солиорол, гэмшиг хоёрын эрчээр ч юм уу, гансрал, ухаарал хоёрын эрчээр ч юм уу, эцгийнхээ царайг бодоод ч юм уу, морфины үйлчлэлээр ч юм уу оюун санаа нь цэлмэж орхив. Хувь заяаны ухаарал. Би юу хийхээ мэдэж байна. Эхнээсээ эхлээд л, энэ шөнө бүх юм түүний төлөвлөснөөр явсангүй. Таах аргагүй саад ямагт тулгарч, харин камерлинго нөхцөлд нь тохируулан зохицуулж байлаа. Гэхдээ л, энэ шөнө ингэж дуусна гэж бодсонгүй, гэхдээ л тэр энэ үйл явдлаас аятайхан мултрах аргаа олчихсон байлаа. Үүнээс өөрөөр төгсөх ёсгүй. Систин цогчинд ямар аймшигтай байсан бэ, бурхан намайг өршөөсөн эсэхэд хүртэл эргэлзлээ. *Ямар үйлтэй юм хийчих вэ?* Өвдөг дээрээ сөхрөн, эргэлзээнд умбан, бурхны өгүүлэхийг олж сонсохоор хичээсэн ч юу ч сонссонгүй. Бошго, заавар, чиглэл үзүүлэхийг гуйна. Шашин ичгүүрт явдлаа илчлэн мөхөөсэй гэж бурхны хүсэл байсан хэрэг үү? Үгүй байлтай! Бурхан л камерлингог ийм юм хий гэж зарлигдсан. *Тэгсэн биз дээ?* Тэр эгшинд бүхний учрыг ухаарав. Гол тахилын өмнө зогсоод, бошго харлаа. Ердийн зүйл гэнэт ер бусын харагдах нь яах аргагүй ариун зарлиг дамжуулсан хэрэг мөн. Загалмай. Энгийн, модон загалмайд Есүсийг хаджээ. Яг тэр мөчид бүх юм ойлгомжтой боллоо. Тэр хэзээ ч ганцаараа үлдэхгүй. Тэр бурхны хүсэл байлаа. Бурхан хамгийн хайртай хүнээсээ хамгийн их золиос шаарддаг билээ. Яагаад камерлинго үүнийг ойлгох гэж ингэж удав аа? Хэтэрхий аймхай эсвэл хэтэрхий ноомой байв уу? Ямар ч ялгаагүй, бурхан зам зааж байна. Одоо камерлинго бурхан яагаад Роберт Ландоныг аварсныг ч тодорхой ухаарч байв. Үнэнийг харуулахын тулд, ийм төгсгөлд хүргэхийн тулд байжээ. Энэ л шашныг аврах цор ганц зам байлаа! Паллиумын хонхор руу бууж явахдаа, яг л хөвж байгаа юм шиг санагдана. Морфин хамгийн хүчтэй үйлчилж байсан ч бурхан түүнийг хөтөлж яваа гэдгийг мэдэж байв. Кардиналууд цогчноос тээнэгэлзэн гарч, Швейцар жардад тушаал өгч байгаа нь алсаас сонсогдоно. Гэхдээ, тэд түүнийг олохгүй. Одоохондоо л олохгүй. Тэр нисэх мэт гүйсээр ерэн есөн тосон зул анивалзах нүхэн танхимын шатаар жирэлзтэл буулаа. Бурхан

түүнийг ариун газар руу хөтөлж байв. Камерлинго некрополис орох нүхэн замыг тагласан сараалж руу гүйнэ. Гэгээн харанхуйн дунд, тэнд л энэ шөнө төгсөх ёстой. Тэр тосон зул авч, доошоо буухаар зэхэв. Нүхэн танхимаар гүйж явахдаа, камерлинго гэнэт зогслоо. Нэг юм буруу санагдав. Бурханд яаж зүтгэхээрээ ингэж үхэх ёстой билээ? Ганцаараа үхлээ гээд гавьяа нь юу вэ? Есүс бүх дэлхий нүдээрээ харж байхад, зовлон туулсан. Тэгэхээр ингэж үхнэ гэдэг бурхны хүсэл яавч биш! Тэр өөрийнхөө бурхны хэлэхийг бүдэг бадаг сонсоно. *Карло, бурхан чамайг учиртай заяасан юм* гэж ээж нь хэлнэ. Гайхаж цочирдсон камерлинго урагшаа алхсаар. Гэтэл бурхан өөрөө түүн дээр ирлээ. Камерлинго түүн рүү ширтэн зогсоно. Ерэн есөн зулын гэрэл ард нь байгаа гантиг хананд сүүдрийг нь тусгах ажээ. Аймшигтай, том, бүүдгэр дүрс алтрах гэрлээр хүрээлүүлжээ. Тэр гэрлийн туяанд, камерлинго тэнгэр рүү хөөрөх ангель шиг л өөрийгөө бодож байлаа. Ангель шиг гараараа дэвэн сүүдрээ мэлрэн хэсэг зогсов. Тэгээд, шат руу эргэн харлаа. Бурхны захиас ойлгомжтой байв. Систин цогчны гадаа хүмүүс гурван минут хэртэй шуугилдсан боловч камерлингог олсонгүй. Шөнийн тэнгэр түүнийг залгичихсан юм уу гэлтэй сүнс сүүдэргүй алга болжээ. Мортати түүнийг хайхаар Ватиканыг бүрэн самнуулах гэж байсан ч, гадаа Гэгээн Петерийн талбай дээр хүмүүс түрхэрэн шуугихыг сонслоо. Тэд баясан хашхиралдаж байхыг сонсоод, кардиналууд бүгдээрээ цочсон байртай харц солилцоно. Мортати нүдээ аниад: «Бурхан өршөө!» гэв. Тэр шөнө хоёр дахь удаагаа кардиналын чуулган Гэгээн Петерийн талбай дээр цугтан гарч ирэв. Ландон, Витториа хоёр ч тэдний дунд урссаар, талбайд гарч ирлээ. Хэвлэлийнхний гэрэл бүгд ордны төв рүү чиглэжээ. Ордны нүүрэн талын голд байх Папын эрдэнийн тагт дээр Вентреска камерлинго гараад зогсчихсон, тэнгэр рүү сарвайж байлаа. Тэртээ холоос ч тэр дахин төрсөн мэт ариун үзэгдэнэ. Цагаан дээлтэйгээ гэрлийн төвд гялалзана. Талбайд хурсан олны эрч гэнэт давлагаалах мэт болж, Швейцар жард хорьж дийлсэнгүй сад тавилаа. Түмэн олон ордны зүг уулгалан давшина. Тэд уйлан, дуулан, хэвлэлийн гэрлүүд гялсхийн цугтан орж ирэхэд, энэ замбараагүй байдлыг юу ч зогсоож дийлэхгүй санагдана. Гэтэл жигтэй хачин юм боллоо. Тэртээ дээр камерлинго жижигхэн зан үйл хийв. Тэр хоёр гараа элгэндээ эвхээд, бөхийн залбирал. Хашгичин үймсэн олон нэг нэгээрээ, арав арваараа, зуу зуугаараа эгнэн, түүнийг даган толгой бөхийлгөлөө. Саяхан оволзон шуугиж байсан талбай, хормын төдий аниргүй мөргөлөөр дүүрэв. Алс тэртээ одсон сэтгэлдээ камерлинго найдвар, гансрал хослуулан мөргөнө. ... *Буян төгөлдөр ... эцэг, эх хоёр минь ... өршөө намайгаа ... та хоёрынхоо цор ганц хуу тань ... ингэж л тахил өргөө дөө. Ээ, Есүс минь ... биднийгээ тамын галаас аварч ... бүх сүнсийг ... таны аврал онц хэрэгтэй тэр сүнсийг ... тэнгэр рүү аваачаач ...* Камерлинго өөрийг нь ширтэж байгаа бүх дэлхий, доор нь байгаа түмэн олон, зурагтын камер руу нүдээ нээж харсангүй. Сүнсээрээ л мэдэрч байлаа. Хурсан олны залбирал түүний мэт зовлонт сүнсийг ч ариусгах мэт. Бүх хүнийг хэрсэн том гэгч сүсгийн тор дэлхий даяар татсан мэт. Гэртээ, машиндаа, энэ дэлхий тэр чигтээ зурагтынхаа өмнө нэгджээ. Зуу зуун улс оронд, түмэн янзын хэлээр хүн болгон нэг том зүрх болон нэгдэж бурханд хүрэх шиг. Тэдний мөргөлийн үгс шинэ атлаа эртний үнэнийг өөрийнхөө дуу хоолойгоор, өөрийнхөө сүнсэн дээр сийлсэн мэт танил дотно байв. Цаг мөнх, орон хязгааргүй мэдэрнэ. Аниргүй мөч өнгөрч, сүлд дуулан баясах чимээ алгуур нүргэлж эхлэв. Цаг болжээ. *Доромжлол, хуурмаг итгэл, мунхаглалын төлөө Ариун гурван эрдэнэдээ би өчүүхэн бие, цус, сүнс гурваараа өргөл барья...* Камерлинго бүх биеэрээ аль хэдийн өвдөлт мэдрээд эхэллээ. Өвчин арьсан дээгүүр нь дүрсхийтэл тарж, сүнс нь биеэсээ салж одохын түүс болов. Бурхантай анх удаа уулзахын өмнө сэтгэл нь яг ингэж өвдсөн билээ. Есүс ямар зовлон эдэлснийг бүү март. Утаа хоолойд нь зангирах шиг. Тариулсан морфин нь ч нэмэр болсонгүй. *За ингээд миний үйл дууслаа.*

Айдас нь минийх. Аврал нь тэднийх. Паллуимын хонхорт, камерлинго бурхны үгийг даган, өөрийгөө тосолсон байлаа. Үс, нүүр, дээл, биеэ бүхэлд нь тосолж, зулын ариун тосонд бүхэлдээ нэвчсэн байв. Яг л ээжийн минь үнэр шиг сайхан дотно үнэр гарах авч, чөтгөр шиг шатдаг тос билээ. Гайхалтай төгсгөл, түргэн ч төгсгөл болно доо. Ардаа ичгүүрт явдал бус ... харин тэнхээ, гайхамшиг үлдээлээ. Хармаандаа гараа шургуулан, Паллиумын incendiario-оос авсан жижиг алтан асаагуураа атгалаа. Амандаа Шүүлт бүлгийн шадьг уншина. *Галын дөл тэнгэр рүү одоход, Эзний ангель галын дөлтэй хамт нисэн одлоо.* Эрхий хуруугаа дарахад бэлтгэв. Гэгээн Петерийн талбай дээр хүмүүс дуулсаар ... Ертөнц хэзээ ч мартаггүй зүйл үзлээ. Тэртээ тагт дээр сүнс биеэсээ зугтан гарах мэт, камерлингогийн цээжинд ганц дөл улалзаад, гал дүрсхийн бүх биеийг нь хучин авлаа. Тэр хашгирсангүй, харин гараа өргөн тэнгэр рүү харав. Гал хөөрхий камерлингог тэр чигт нь нөмрөн, галт багана бослоо. Түүдэг мэт дүрэлзэх тэр галыг бүх дэлхий харж байв. Гэрэл нь улам тодрон тодорно. Тэгснээ аажмаар унтарлаа. Камерлинго алга. Тагтны хашлагын цаана унасан уу, агаарт замхран алга болов уу гэдгийг хэлэхэд бэрх. Утаан багана Ватикан хийдийн тэнгэрт уугиж байлаа.

Хэсэг 135

Үүр орой цайлаа. Өглөө орсон борооны дараа талбайд хурсан олон таржээ. Харин хэвлэлийнхний мухлаг тэргүүд үлдэж, машин дотроосоо шөнийн явдлыг гайхан ярьцгаана. Дэлхий даяар нэг ч сүм цурам хийсэнгүй. Бүх шашин, бүх сүм юу болж өнгөрсөн, яагаад ийм юм болсон, ямар сургамжтай талаар хүүрнэн хэлэлцэнэ. Олон олон асуулт байвч хариултууд нь улам олон асуулт авчрахаас хэтрэхгүй ажээ. Ватикан чимээгүй хэвээр, ямар ч мэдэгдэл гаргасангүй хэвээр. Гүнээс гүнд Ватиканы гүдинд, Мортати кардинал онгорхой авсны хажууд, гав ганцаараа сөхрөн суужээ. Хөөрхий хөгшний харласан хэлэнд хүрч, амыг нь хаалаа. Дээрхийн гэгээн амгалан харагдана. Мөнхрөх гэж л ийм байдаг биз ээ. Мортатигийн хөлний тэнд алтан бумбатай үнс байлаа. Өвгөн өөрийнхөө гараар тэр үнсийг цуглуулж, энд авчирчээ. «Өршөөх биз дээ» гэж өвгөн Дээрхийн гэгээнд хэлээд, алтан бумбыг Паптаны хажууд эвтэйхэн тавилаа. «Хүүгээ хайрлах эцгийн хайраас аугаа зүйл үгүй билээ». Тэгээд бумбаа Папын дээлний доор хүний нүднээс далд шургуулав. Энэ ариун бунхан гагцхүү нөгчсөн Папад зориулсан эд боловч, Мортатид ингэх нь зүйд нийцэм санагдана. «Дээдэс минь!» хэмээн нэг хүн бунханд орж ирээд хэлэв. Дэслэгч Шартрон гурван харуулаа дагуулан иржээ. «Тэд цуурганд цуглаад бэлэн байна» гэв. Мортати толгой дохиод: «Одоохон» гэлээ. Тэгээд, чулуун авс руу сүүлийн удаа хараад, хүчлэн бослоо. Тэгээд, харуулууд руу эргэн харж: «Дээрхийн гэгээн одоо л нэг амар амгалангаа оллоо доо» гэв. Харуулууд очоод, Папын авсны тагийг хүчлэн түлхэж, хуучин байранд нь тавилаа. Мортати ганцаараа Боржа цэцэрлэгийг өнгөрөн, Систин цогчин руу зөөлөн алхаж явна. Сэвшээ салхи дээлийнх нь хормойг үлээнэ. Апостолийн асраас нэг кардинал зэрэгцэн ирээд, хамт алхлаа. «Таныг дагалдан цуурган руу явахыг соёрхож хайрла, эрхэм ээ». «Үгүй дээ, та л надад соёрх». «Эрхэм ээ! Кардиналын чуулган урьд шөнийн явдлын төлөө, танаас өршөөл эрж байна. Бид үнэндээ сохорчихсон байжээ» хэмээн тэр түвдэнгүй өгүүллээ. «Бидний оюун заримдаа сэтгэл минь үнэн байгаасай гэж хүссэн зүйлийг л хардаг шүү дээ» гэж Мортати зөөллөн хариулав. Нөгөө кардинал хэсэг чимээгүй дагаж явснаа: «Танд хэлсэн үү? Та одоо Их сонгогч байхаа больсон шүү дээ» гэлээ. Мортати инээвхийлэн: «Хэлсэн. Түүний чинь төлөө би бурханд талархаад

байгаа юм» гэв. «Чуулган таныг нийцтэй хүн гэж үзэж байгаа». «Энэ шашинд сайхан сэтгэлтэн дүүрэн шүү дээ». «Та ухаантай хүн. Та биднийг сайн удирдах байх». «Би хөгшин хүн шүү дээ. Хэр удах билээ дээ?» Тэгээд хоёулаа инээлдэв. Тэд Боржа цэцэрлэгийн эцэст хүрэхэд, кардинал зогтосон, Мортати руу эргэж, сэжиглэж түвдэхгүй байгаа аятай хараад, энэ шөнийн аймшигт явдлуудаас сургамж авсан байртай, болгоомжтой асуув. «Тагт дээр ямар ч үлдэгдэл байгаагүй гэж та сонсов уу?» гэж бараг л шивнэлээ. Мортати гунигтай яа инээвхийлэн: «Борооны ус угаагаад арилгачхаа биз дээ» гэв. Нөгөө кардинал бүрхэг тэнгэр рүү ширтэн: «Магадгүй л юм» гэлээ.

Хэсэг 136

Өглөө дүл тэнгэр үүлэрхэг байсан хэдий ч, Систин цогчны яндангаас анх удаа цагаан утаа олгойдлоо. Сувдан утаа дээшээ гогцоорон олгойдоод, салхинд үлээгдэн сарнина. Тэртээ доор, Гунтер Глик сурвалжлагч тэр дүрсийг чимээгүйхэн ажиглаж байлаа. Сүүлийн бүлэг ... Чинита Макри ард нь ирээд, камераа мөрөн дээрээ тавьж: «Цаг боллоо» гэв. Глик толгойгоо дохив. Тэгээд, Чинита руу эргэж хараад, үсээ илэн, гүнзгий амьсгаа авав. *Сүүлчийн минь нэвтрүүлэг* хэмээн бодлоо. Тэднийг харах гээд хэсэг хүн цуглав. «Жаран секундйн дараа шууд» гээд Макри анхаарууллаа. Глик мөрөн дээгүүрээ Систин цогчны дээвэр рүү ширэв татаад: «Утааг авч байна уу?» гэлээ. Макри толгой дохино. «Би яаж авахаа мэднэ ээ, Гунтер». Мэдээж шүү дээ. Глик дэмий юм хэлжээ. Макригийн урд шөнө авсан зураг бараг л Пулцерийн шагнал авсан байх аа. Харин түүний ажил ... энэ тухай бодохыг хүссэнгүй. ВВС түүнийг халах байх, агентлаг маргаашаас эхлээд л СЭРН, Жорж Буш гээд л олон газраас шүүхэд зарга үүсгэсэн мэдэгдэл авна даа. «Чи дажгүй харагдаж байна» гэж Чинита хэлээд, камерын цаанаас жаахан санаа зовнингүй байртай: «Чамд нэг юм хэлэх үү ...» гэснээ хэлээ хазаад больчхов. «Зөвлөгөө юу?» Макри санаа алдаад: «Би зүгээр л гэнэтийн зүйл битгий хийгээрэй гэх гэсэн юм» гэлээ. «Мэдлээ, мэдлээ. Зүгээр л шууд сурвалжлага» гэв. «Шуудын шууд сурвалжлага шүү. Итгэлээ шүү» гэлээ. Глик инээвхийлэв. *Шууд сурвалжлага гэнэ ээ. Мангар юм уу?* Өнгөрсөн шөнийнх шиг сурвалжлага үнэтэй шүү. Эрсдэл хийх хэрэгтэй. Бөмбөгдөх хэрэгтэй. Хэн ч төсөөлөөгүй байсан үнэн гэнэт илэрнэ. Азаа эргүүлж авчрах төлөвлөгөө Гликт байлаа... «За эхэллээ... тав ... дөрөв ... гурав ...» Чинита Макри камерынхаа дурангаар Глик рүү харахад нүд нь зальжин инээвхийлж байв. *Би энэнд итгэдэг тэнэг юм аа. Юу бодож байсан юм бол оо?* Яах ч аргагүй цаг боллоо. Тэд дэлгэц дээр шууд гарч байна. «Гунтер Глик Ватикан хийдээс шууд сурвалжилж байна». Систин цогчноос олгойдон буй цагаан утааг харуулан, Глик камерын өөдөөс төгөлдөр харан зогсоно. «Ноёд, хадагтай нар аа! Одоо албан ёсны боллоо. Далан есөн настай дэвшилтэт үзэлтэн Саверио Мортати кардинал дөнгөж сая Ватикан хийдийн Папаар сонгогдлоо. Кардиналын чуулганы санал нэгтэй шийдвэрээр Мортатиг сонгожээ.» Макри одоо л нэг санаа амрав. Глик өнөөдөр жинхэнэ мэргэжлийн хүн шиг ажиллаж байв. Глик амьдралдаа анх удаа яг л сурвалжлагч хүн шиг харагдаж, сонсогдож байлаа. Гликийн дуу мэргэжлийн төвшинд аажим чангарч: «Өнгөрсөн шөнө болсон гайхамшигт явдлын тухай Ватикан өнөөг хүртэл тодорхой тайлбар өгөөгүй л байна» гэлээ. *Сайн байна.* Макри санаа уужирч байв. *Одоохондоо болж л байна.* Глик хоолойнхоо өнгөнд эмгэнэл тодруулан, дуугаа намсгав. «Өнгөрсөн шөнө гайхамшиг дагуулсантайгаа адил бас харуусал дагуулсан шөнө байлаа. Дөрвөн кардиналаас гадна Швейцар жардын Оливетти захирагч, Рошер занги хоёр үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдлээ. Түүнчлэн СЭРН-ийн суут физикч, антиматери технологийг нээсэн Леонардо Ветра, мөн Ватикан хийдэд нисч ирээд туслах гээд, явцын дунд үрэгдсэн СЭРН-ийн захирал

Максимлиан Колэр нар үрэгдэгсдийн дунд байна. Колэр гуай хэрхэн өнгөрсөн талаар албан ёсны тайлбар байхгүй байгаа ч ужиг өвчин нь сэдэрснээс болсон гэсэн яриа гараад байна».

Макри толгойгоо дохилоо. Сурвалжлага яг л тохирсон ёсоороо явж байлаа. «Урд шөнө Ватиканы тэнгэрт болсон тэсрэлттэй холбоотой СЭРН-ийн антиматерийн технологи эрдэмтдийн дунд бахдал зовнил зэрэг төрүүлсэн халуун сэдэв болоод байна. Колэр агсны туслах Силвиа Бодлок авхай Женевээс мэдэгдсэнээр бол СЭРН-ийн удирдах зөвлөл антиматерийн потенциалын талаар сонирхож байгаа ч аюулгүй байдлын тодорхой заавар боловсруулах хүртэл холбогдох судалгаа, лицензийг зогсоож байгаа юм байна.» *Онц* гэж Макри бодоод Одоо дуусгаарай. Гэхдээ Глик дуусгасангүй. Харин ч дуусгах дохио өгөхийн оронд камерын өөдөөс алхан, зальжин инээмсэглэн «Сурвалжлагаа дуусгахаас өмнө...» гэлээ. «Боль л доо!» «... Бид нэгэн хүнийг зочноор уриад байна». Чинитагийн гар нь камер дээрээ хөшчихөв. *Зочин? Ямар чөтгөрөө хийгээд байгаа юм бэ? Юун зочин? Дуусгаач!* Гэхдээ Глик яриад эхэлчихсэн болохоор нэгэнт хоцорсон байлаа. «Миний танилцуулах гэж байгаа хүн бол Америкаас ирсэн нэрт судлаач...» Чинита гайхав. Глик тойроод зогсоо хүмүүс рүүгээ дохин зочноо урьж, нэг хүн тэндээс урагш алхан гарах үед бүсгүй амьсгаа даран хүлээж дотроо залбирна. *Роберт Ландоныг олоод ирсэн байгаасай ... хоёрын хооронд сэрдэх онолч, дэл сул этгээд л биш шүү!* Гликийн зочин камерын дүрсэнд орж ирэх үед Макригийн зүрх зогсчих шиг болов. Роберт Ландон биш байлаа. Тэр жинс өмссөн, халзан толгойтой, зузаан нүдний шил зүүсэн хүн гартаа кока коланы лааз барьчихсан зогсож байлаа. Дэл сул этгээд! «Чикагогийн Дэ Полын их сургуулийн багш, Ватикан судлалаар мэргэжсэн эрдэмтэн Жозеф Ванек докторыг танилцууля» хэмээн Глик зарлалаа. Макригийн сэтгэл бага зэрэг амсхийв. Энэ хүн сэрдэх онолч биш, түүний тухай бүсгүй нэлээдгүй сонсож байжээ. «Ванек доктор, танд өнгөрсөн шөнийн цуурганы тухайд бидэнтэй хуваалцах сонин мэдээ бий юү?» гэж Глик асуув. «Байгаа шүү!» гэж Ванек америк маягаар сайрхаад: «Ийм олон гайхалтай зүйл тохиолдсон шөнийн дараа, өөр гайхалтай зүйл үлдсэн гэхэд хэцүү л дээ ... гэхдээ» гээд тэр хэсэг чимээгүй боллоо. Глик инээвхийлэн: «Гэхдээ, бас өөр ямар нэг гайхалтай зүйл энэ шөнийн олон явдлын дараа үлдсэн гэж үү?» гэж шавдуулав. Ванек толгойгоо дохиод: «Тийм шүү. Энэ жигтэй сонсогдож байж магадгүй ч гэсэн кардиналын энэ чуулган хоёр Пап сонгочихлоо». Макри камераа унагачих шахав. Глик цоргин инээмсэглэж: «Хоёр Пап гэнэ ээ?» гэлээ. Эрдэмтэн гуай толгойгоо дохиод: «Тийм. Эхлээд би насаараа Папын сонгуулийн тухай Ватиканы хуулийг судалсан хүн гэдгээ хэлмээр байна. Цуурганы хуулиуд хэтэрхий ээдрээтэй, зарим нь мартагдсан, заримыг нь хуучирсан гээд анзаарахаа больчихсон байдаг. Миний хэлэх зүйлийг бүр Их сонгогч өөрөө мэдэхгүй байж ч магадгүй. Гэхдээ л ... эртний мартагдсан хууль Romano Pontifici Eligendo, Numero 63 (Ромын хамбыг сонгох хууль, Дугаар 63)-т зааснаар санал хураана гэдэг Папыг тодруулах цорын ганц зам биш юм. Өөр «Шагшин тодруулах» гэх илүү ариун зам бас бий. Өнгөрсөн шөнө ийм явдал бас боллоо» гээд дуугүй болов. Глик зочин руугаа харж: «Тэгээд цааш нь?» гэв. «Өчигдөр шөнө Карло Вентреска камерлинго ордны дээвэр дээр байх үед, доор нь байсан бүх кардинал түүний нэрийг нэгэн дуугаар дуудаж байсныг санаж байна уу?» «Тэгэлгүй яах вэ?» «Түүнтэй холбоотой эртний нэгэн хуулийг би энд үгчлэн уншья» гээд хармаанаасаа хэсэг цааш гаргаж ирээд, хоолойгоо засаад уншлаа. «Шагшин тодруулах гэдэг нь Ариун сүнс заасан мэт бүх кардинал зоргоороо, хар аяндаа, нэгэн дуугаар, чангаар хэн нэгний нэрийг дуудахыг хэлнэ» «Тэгэхээр урд шөнө кардиналууд Карло Вентрескагийн нэрийг хамтдаа дуудахдаа, түүнийг кардиналаар сонгочихсон хэрэг үү?» «Тэгж таарч байгаа юм. Түүнээс гадна энэ хуулиар бол Шагшин тодруулахад тухайн хүн нийцтэй эсэх нь хамаагүй, жирийн гэлэн, хамба, кардинал хэнийг ч сонгож болдог юм. Тэгэхээр, энэ заалтаар бол камерлинго яах аргагүй Папаар сонгогдсон болж таарч байна даа» гэж Ванек доктор камер руу эгц харан хэлээд, цааш нь өгүүлэв.

«Тэгэхээр ийм болжээ гэж тоймлож болно. Карло Вентреска өчигдөр орой Пап болсон. Харамсалтай нь тэр арван долоохон минутын дараа больсон. Хэрэв тэр гайхалтай галт багана босгон алга болчхоогүй бол түүний шарил өдийд Ватиканы бунханд бусад Папын хамт байж байх байлаа». «Баярлалаа, доктор оо» гээд Глик Макри руу эргэн «Та мэлмий «гэгээрүүлсэн» тайлбар хийлээ» гэлээ.

Хэсэг 137

Ромын коллизиумын орой дээр Витториа зогсоод инээд, алдан залуугаа даллан дуудна. «Хүүе, Роберт, хурдлаач ээ. Би арай залуухан эртэй суудаг байж дээ». Бүсгүй адтай яа хөхрөх аж. Эрийнх нь хөл бул чулуу шиг бадайрч, бүсгүйнхээ алхааг гүйцэх гэж зүдрэн: «Хүлээгээрэй хө, хүлээ л дээ» хэмээн бувтнана. Зүрх нь амаар гарах гэж байгаа юм шиг дэлсэж байв. Роберт Ландон гэнэт сэрчихлээ. Харанхуй байв. Тэр хаана байгаагаа ухаарах гэж харь орны зөөлөн орон дээр удаан хэвглээ. Дэр нь том, гайхалтай зөөлөн ажээ. Агаарт аятайхан үнэр ханхална. Өрөөний нөгөө талд хоёр хавгастай шилэн хаалга онгорхой, цаана нь тансаг тагтаар сарны доогуур татсан үүлний тэртээгээс зөөлөн салхи сэвшинэ. Ландон хаана байгаагаа, яаж энд ирснээ санах гэж хичээнэ. Толгойд нь байж боломгүй олон үйл явдал эргэлдсээр... *Шидийн гал ноцож ... олны дундаас нэгэн ангель дээш хөөрөн одож ... бүсгүй зөөлөн гараараа гарыг нь атгаж, шөнийн харанхуй руу дагуулан ... ядарч, туйлдсан түүнийг гудамжаар хөтлөн гүйж... энд... энэ өрөөнд авчран ... хагас нойрмог түүнийг халуун шүршүүрт оруулж... оронд нь хэвтүүлээд... үхсэн мэт нам унттал нь сахиж сууна.* Харанхуй дунд Ландон хажуудаа байгаа өөр нэг ор олж харлаа. Унтахаар зассан боловч хоосон байлаа. Залгаа өрөөнд хүн шүршүүрт орж байгаа чимээ гарна. Витториагийн орыг харж байснаа, дэрэн дээр нь том үсгээр шивсэн үг олж харав. Бернини Зочид буудал. Ландон инээвхийлнэ. Витториа сайн сонгожээ. Хуучны тансаг засал Бернинигийн Тритон усан оргилуурын дээрээс өнгийнө... Ромд үүнээс илүү зохистой буудал байсангүй. Нойрмоглон хэвтээ Ландоныг хаалга нүдэх чимээ сэрээв. Нэг хүн чанга чанга нүдэж байлаа. Ландон гайхасхийн дурамжхан өндийв. *Бид хоёрыг энд байгаа гэж хүн мэдэхгүй дээ* гэж бодохоор сэтгэлд эвгүйцэв. Бернини зочид буудлын тансаг халаадыг эгэлдрэглээд, унтлагынхаа өрөөнөөс үүдний гонховч руу алхлаа. Том царсан хаалгаа харан, хэсэг зогссоноо, татаж онгойлгов. Хөх ягаан, шар өнгийн дүрэмт хувцастай хүчирхэг залуу өмнө нь зогсч байлаа. «Намайг Шартрон дэслэгч гэдэг. Швейцар жардаас явна» хэмээн өөрийгөө танилцуулав. Ландон тэрийг хэн гэдгийг мэдэхийн цаагуур мэдэж байлаа. «Та та нар биднийг яаж олоо вэ?» «Та хоёрыг талбайгаас явахыг хараад, бид дагасан юм л даа. Харин та хоёрыг эндээ байгааг мэдээд, санаа амарлаа» гэв. Кардиналууд Ландон, Витториа хоёрыг Ватикан хийд рүү буцаагаад аваад ир гэж Шартроныг явуулсан юм биш биз гэж бодоод гэнэт түвэгшээв. Кардиналуудаас гадна үнэнийг мэдэж байгаа хүн бол тэр хоёр билээ. «Дээрхийн гэгээнтэн танд үүнийг дамжуулаарай гэсэн юм» гэж Шартрон хэлээд, Ватиканы сүлдээр лацадсан дугтуй өглөө. Ландон дугтуйгаа онгойлгож, гараар бичсэн зурвасыг уншив. *Ландон гуай, Ветра авхай нарт, Та бүхний нэгэнт гаргасан хичээл зүтгэлд тань талархан, сүүлийн хорин дөрвөн цагт болсон явдлыг нууцлан үлдээрэй хэмээн би нэмэн хүсмээр байвч түвдэхгүй ажсаам. Тиймээс энэ тухайд гаргах шийдвэрийг та бүхний сэтгэлд даатган орхису. Өнөөдөр энэ дэлхий амгалан харагдана. Гэвч заримдаа асуулт нь хариултаасаа хүчтэй байдаг билээ. Миний хаалга та бүхэнд ямагт нээлттэй шүү. Дээрхийн гэгээн Саверио Мортати* Ландон захиаг хоёронтаа уншив. Кардиналын чуулган үнэхээр шударга зөв хүнээ сонгожээ. Ландоныг ам нээхээс өмнө, Шартрон боодолтой юм гаргаад ирлээ. «Дээрхийн гэгээний жижиг бэлэг».

Бор цаасанд боодолтой хүнд юм байлаа. «Дээрхийн гэгээний зарлигаар үүнийг танд Папын хоргоноос тодорхойгүй хугацаагаар зээлдүүлж байгаа юм. Таныг сүүлчийнхээ мөчид энэ зүйлийг буцааж өгөхөөр баталгаажуулан гэрээслэхийг Дээдэс танаас хүссэн билээ» хэмээн Шартрон өгүүлэв. Ландон боодлыг онгойлгож үзээд, амаа ангайн алмайрав. Тэмдэг!

Иллюминатигийн очир. Шартрон инээвхийлэн: «Энх тунхыг ерөөе» гээд эргээд явлаа. «Гялай ... гялайлаа» гэж Ландон арайхийн хэлж амжив. Гартаа үнэлж баршгүй бэлгээ барин, салганан зогсоно. Шартрон алхаж явснаа, гэнэт зогсон: «Ландон гуай, танаас юм асууж болох уу?» гэв. «Болохгүй яах вэ?» «Би харуулуудтайгаа хамт гайхацгаагаад байгаа юм л даа. Хамгийн сүүлийн мөчид ... нисдэг тэрэг дотор юу болсон юм бэ?» Дур гутан, унтууцал төрөөд явчихлаа. Ингэж үнэнийг шалгаах мөч ирнэ гэдгийг Ландон мэдэж байлаа. Витториа тэр хоёр Гэгээн Петерийн талбайгаас ирж явахдаа, энэ тухай яриад, Папыг хүсэхээс өмнө шийдвэрээ аль хэдийн гаргачихсан байлаа. Витториагийн аав антиматерийн нээлт хүмүүсийн сүсгийг сэрээнэ гэж найдаж байлаа. Урд шөнө түүний хүслийн яг эсрэг зүйл болсон билээ. Гэхдээ, бүх дэлхий даяар хүмүүс бурхныг өмнөхөөсөө өөрөөр хардаг болсон байв. Энэ гайхамшиг хэр удаан үргэлжлэхийг Ландон ч, Витториа ч мэдэхгүй, гэхдээ тэр хоёр л лав хүмүүсийн дотор сэрсэн сүсгийг эргэлзээ, ичгүүрт шалдлан, үгүй хийхийг хүсэхгүй байлаа. *Бурхан жигтэй аашилдаг шүү* гэж Ландон өөртөө өгүүлэн, урд шөнө болсон явдалд магадгүй ..., бурхан бага зэрэг ... оролцсон байж ... магадгүй л юм гэж бодно. «Ландон гуай! Нөгөө нисдэг тэрэгний тухай л ...» гэж Шартрон бодлыг нь эвтэйхэн сарниулан санууллаа. Ландон гунигтай яа инээвхийлэн. «Аа, тийм. Унаснаасаа болоод, шоконд орчхоод тэр үү... нэг л ... бүх юм нэг л ... орон гаран байгаа юм» гэлээ. Гэхдээ энэ үгийг зохиож биш, үнэн сэтгэлээсээ хэлэв. Шартрон нүдээ бүлтийлгэн: «Та тэгээд юу ч санахгүй байгаа юм уу?» гэв. Ландон санаа алдаад: «Тэр явдал надад ч гэсэн жигтэй хэвээрээ л үлдэх байх даа» гэлээ. Роберт Ландон унтлагынхаа өрөө рүү ормогцоо, өмнөө байгааг хараад, мэлрэн зогтусав. Витториа тагтны бариулыг нуруугаараа түшин зогсоод, түүн рүү цоо ширтэж байлаа. Ард нь байгаа сарны гэрэлд, тэр тэнгэрлэг яруу туяаран үзэгдэнэ. Халаадаа бүсэлсэн болохоор биеийнх нь адтай галбир тодрон, Ромын охин тэнгэр шиг л харагдана. Бернинигийн Тритон усан оргилуураас үсэрсэн сийрэг мананцар ард нь сэвсийнэ. Ямар ч хүүхэнд хэзээ ч татагдаж байгаагүй ихээр Ландон түүн рүү тэмүүлж байлаа. Тэр мэлэрсэн чигээрээ Иллюминатигийн очир, Папын захидал хоёрыг орны хажуугийн шүгээн дээр зөөлөн тавилаа, тэр тухай ярих цаг зөндөө олдоно. Тэгээд, тагтан дээр зогсоо бүсгүй рүү дөхлөө. Витториа түүн рүү баясан харж: «Ашгүй чи сэрчхээ юү» гэж эрхлэнгүй хэлнэ. Ландон инээвхийлэн: «Урт өдөр байлаа шүү» гэв. Бүсгүй үсээ сэвсийлгэн, халаадны захны гадуур буулгахад, зах нь жаахан задарч, янзаган цагаан цээж нь үл ялиг ил гарлаа. «Тэгээд одоо ... чи олзоо амталмаар байгаа биз дээ?» Ландон мэлэрч орхив. «Юу гэнэ ээ?» «Бид хоёр чинь насанд хүрсэн хүмүүс шүү дээ, Роберт. Юундаа ёсорхоо вэ? Юу бодоод байгааг чинь би харцнаас чинь мэдээд байна шүү дээ. Өлөн хүсэл чинь төрөөд байгаа биз дээ?» гэж зөөлөн хэлснээ: «Үнэндээ би ч гэсэн тэгмээр байна. Хоёулаа өлөн хүслээ дарвал яасан юм бэ?» гэлээ. «Тэгэлгүй яах вэ?» хэмээн Роберт зоригжин ухасхийв. «Зүйтэй» гэснээ, Витториа өрөөний үйлчилгээний цэсийг аваад: «Би энд байгаа бүгдийг нь захьчихсан» гэв. Сарны гэрэл доор тансаг тагтан дээр, гайхалтай сайхан зоог барилаа. Жинхэнэ итали маягийн гоймон идэж, Долчетто дарс шимэн, удаан ярилцав. Витториагийн юу хүсээд байгааг гадарлахын тулд Ландонд бэлгэдэл судлалын мэргэжлийн боловсрол хэрэггүй байлаа. Савоиа-тай жимсний мөхөөлдөс идэж, Ромкафе уух зуураа Витториа нүцгэн өлмийгөөрөө хөлийг нь зөөлөн шүргээд, түүн рүү эгц ширтлээ. Бүсгүй түүнийг сэрээгээ тавиад, тэвэрч ор руугаа аваачаасай гэх шиг. Гэхдээ, Ландон

тэгсэнгүй. Тэр жентлемен хэвээрээ үлдэхээр шийдэв. Хэнэггүй инээмсэглэл тодруулан, *хоёулаа жаахан ингэж тоглоё* гэж бодлоо. Бүх хоолоо идэж дууссаны дараа Ландон орныхоо хажууд суугаад, Иллюминатигийн Очирын эргүүлж тойруулан, тэгш хэм, амбиграмынх нь гайхамшигтай чанарын тухай эцэс төгсгөлгүй ярьж гарав. Витториа түүн рүү гайхан ширтэж байснаа, унтууцаж эхлэх шиг болов. «Чамд наад амбиграм чинь аймаар сонирхолтой байна, тийм үү?» гэж бүсгүй шахамдуулав. Ландон толгой дохин: «Тийм шүү. Бүр шагшмаар эд байгаа юм» гэлээ. «Энэ өрөөнд наадахаас чинь илүү сонин юм байхгүй байна гэж үү?» Ландон толгойгоо маажсанаа: «Энд ч илүү сонирхолтой юм нэг байна л даа» гэлээ. Бүсгүй инээмсэглэн хажууд нь очиж суугаад: «Тэгээд тэр чинь юу билээ?» гэв. «Чи Эйнштейний онолыг туна загасан дээр яаж няцаасан юм бэ?» Витториа тэвчээр алдан, гараа саваад: «Өө, бурхан минь. Туна загас л дугаж гэнэ. Надаар битгий тоглоод бай л даа. Санууллаа шүү» гэлээ. Ландон улам цаашлуулан: «Чи ер нь далайн замаг судлаад дэлхий хавтгай гэдгийг батлавал яасан юм бэ?» гэлээ. Витториагийн дотор тачаадаж байсан ч гэсэн, энийг сонсоод, нүүрэнд нь инээвхийлэл мэлсхийн тодорлоо. «Танд гэж мэдэгдэхэд, багш гуай, би дараагийнхаа туршилтаар түүхийг өөрчлөх гэж байгаа. Н ... жин хуралдуулдаг гэдгийг батлах гэж байгаа юм». «Н ... хуралдуулдаг гэнэ ээ?» гэж Ландон гайхсан царай гарган: «Би тэрийг чинь католик гэж мэдээгүй юм байна шүү дээ» гэв. Витториа ганцхан хөдлөөд, Ландоны дээр гарчхав. Тэгээд, инээд алдан: «Ландон гуай, та үхсэний дараа амьдрал байдаг гэж итгэдэг байлгүй дээ». Гарыг нь тэлж дараад, дээр нь мордов. «Үнэндээ бол би энэ ертөнцөөс өөр ертөнцийг төсөөлөхдөө муу л даа» хэмээн хөхөрнө. «Тийм үү? Та тэгээд шашны ямар нэг гайхамшигийг харж байгаагүй юу? Тэгээд бурхныг шүтэн, таашаалтай амтыг мэдэрч байгаагүй юу?» Ландон толгойгоо сэгсрэн: «Үгүй шүү. Би ер нь шашинд итгэж чаддаггүй өөдгүй хүмүүсийн нэг л дээ» гэв. Витториа халаадаа аажуухан тайлж: «Чи бас иога мастертай нэг оронд орж үзээгүй байх, тийм үү?» гэлээ.

~ТӨГСӨВ~